Арван гурав.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.06.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Гаалийн ерөнхий газрын Барааны ангиллын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Чимгэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Сангийн сайд З.Мэндсайхан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Б.Пүрэвдорж, Б.Түвшин, Б.Жаргалан, О.Номинчимэг нарын тавьсан асуултад Сангийн сайд З.Мэндсайхан хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг 17:00 цагт явуулахаар хойшлуулав./15:18/

Арван дөрөв.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нарын 71 гишүүн 2025.09.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, мөн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Б.Цэцэгсайхан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн

яамны Хяналт-шинжилгээ, дотоод аудитын газрын дарга Б.Батшагай, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Анар, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын мэргэжилтэн Ж.Төрболд, Санхүү, төсвийн судалгааны газрын мэргэжилтэн Д.Долгорсүрэн, Гаалийн ерөнхий газрын Барааны ангиллын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Чимгэрэл, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, мөн газрын Татварын улсын байцаагч Б.Отгонбаяр, Боловсролын яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч Э.Чойсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, референт Н.Монголмаа нар байлцав.

Төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай, Д.Пүрэвдаваа, М.Нарантуяа-Нара, П.Наранбаяр, Ө.Шижир, А.Ариунзаяа, А.Ганбаатар, М.Мандхай, О.Номинчимэг нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Х.Баасанжаргал, О.Номинчимэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан, Х.Баасанжаргал, М.Мандхай нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг 17:00 цагт явуулахаар хойшлуулав./16:47/

Арван тав.Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, мөн яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын газрын дарга Ц.Уранчимэг, мөн газрын ахлах шинжээч Ц.Мөнхбат, Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Х.Мөнхзул, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга С.Пүрэвсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Байгаль орчин, хүнс,

хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Энхгэрэл нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай, Л.Соронзонболд, Р.Сэддорж нарын тавьсан асуултад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир, Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./17:25/

Арван зургаа. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, мөн яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын газрын дарга Ц.Уранчимэг, мөн газрын ахлах шинжээч Ц.Мөнхбат, Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Х.Мөнхзул, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга С.Пүрэвсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Энхгэрэл нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./17:29/

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 17 цаг 30 минутаас хуралдааныг даргалав.

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	64
Татгалзсан:	35
Бүгд:	99

64.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

1.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	63
Татгалзсан:	36
Бүгд:	99

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	68
Татгалзсан:	31
Бүгд:	99

68.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	70
Татгалзсан:	29
Бүгд:	99

70.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	67
-------------	----

Татгалзсан: 32
Бүгд: 99
67.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 30
Бүгд: 99
69.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгасан санал:

Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Төслийн нэрийн “бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах” гэснийг “засаглалын” гэж, 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “хяналт, ил тод байдал, засаглалыг сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэхтэй” гэснийг “засаглалыг сайжруулах, хяналтыг хэрэгжүүлэх, ил тод байдлыг хангахтай” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 27
Бүгд: 99
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 2.1 дэх хэсгийн “бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах” гэснийг “засаглалын” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 26
Бүгд: 99
73.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Дээрх 1, 2 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан энэ хууль болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийн “бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах” гэснийг “засаглалын” гэж тухай бүрд өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	73
Татгалзсан:	26
Бүгд:	99

73.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай “Тайлбар” хэсэг нэмэх:

“Тайлбар:- Энэ хуульд заасан “үр ашигтай байх” гэж арилжааны зорилго бүхий төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьд оруулсан капиталын өгөөжийг капиталын жигнэсэн дундаж өртгөөс өндөр түвшинд байхаар үйл ажиллагаа явуулж, компанийн урт хугацааны үнэ цэнийг нэмэгдүүлэхийг ойлгоно. Нийтийн үйлчилгээний төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьд нийтийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай, тасралтгүй, боломжит бага зардлаар үзүүлэхийг ойлгоно.

Тайлбар:- Энэ хуульд заасан “зах зээлд шударга өрсөлдөх, аливаа хэлбэрээр давуу эрх эдлэхгүй байх” гэж хуульд зааснаас бусад тохиолдолд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхгүй, төрийн болон орон нутгийн өмчийг зах зээлийн үнэ, нөхцөлөөс доогуур ашиглахгүй, зөвшөөрөл, эрх олгох болон төрийн худалдан авах ажиллагаанд давуу эрх эдлэхгүй, дампуурал, төлбөрийн чадваргүйдлийн нийтлэг журмаас үндэслэлгүй чөлөөлөгдөхгүй байхыг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	69
Татгалзсан:	30
Бүгд:	99

69.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 6 дугаар зүйлийн гарчгийн “, хэлбэр” гэснийг хасаж, 6.1.2, 6.2.2 дахь хэсгийн “34-өөс” гэснийг “гуравны нэгээс” гэж тус тус өөрчилж, 6.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.3.Төрийн болон орон нутгийн өмчит компанийг үйл ажиллагааны зорилго, чиг үүргээс нь хамааруулан арилжааны, эсхүл нийтийн үйлчилгээ гэж ангилах бөгөөд энэ талаар тухайн компанийн дүрэмд тусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	69
Татгалзсан:	30
Бүгд:	99

69.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.1.Төрийн өмчит компанийг дараах үндэслэлээр үүсгэн байгуулж болно:

8.1.1.хувийн хэвшил дангаараа гүйцэтгэх боломжгүй, санхүүгийн үр ашиггүй нөхцөл нийтийн үйлчилгээний үүргийг хэрэгжүүлэх;

8.1.2.үндэсний эдийн засгийн ашиг сонирхлыг хангах зорилгоор төрийн нийтийн өмчид хамаарах байгалийн баялгийг ашиглах;

8.1.3.зүй ёсны монопол үйл ажиллагаа эрхлэх;

8.1.4.үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой батлан хамгаалах, хил хамгаалах, харилцаа холбоо, хууль сахиулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг дэмжих, холбогдох аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх;

8.1.5.хуульд тусгайлан заасан бол.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	68
Татгалзсан:	31
Бүгд:	99

68.7 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Төслийн 16 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16 дугаар зүйл.Ногдол ашгийн бодлого

16.1.Төрийн болон орон нутгийн өмчит компани нь Компанийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйлд заасан ногдол ашгийн бодлоготой байх бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ батална.

16.2.Ногдол ашгийн бодлогод тухайн компанийн үйл ажиллагааны зорилго, хөрөнгө оруулалтын бүтэц, мөнгөн урсгалын онцлогоос хамааруулан дараах хэлбэрийн аль нэг, эсхүл хосолсон хэлбэрийг тусгана:

16.2.1.аудитлагдсан санхүүгийн тайланд туссан татвар төлсний дараах цэвэр ашгийн тодорхой хувиар;

16.2.2.жил бүр хөрөнгө оруулагчид тогтвортой хуваарилахаар урьдчилан тогтоосон ногдол ашгийн зорилтот хэмжээ болон түүнд тооцох өсөлтийн хувиар;

16.2.3.аудитлагдсан санхүүгийн тайланд туссан хувь нийлүүлсэн хөрөнгө, чөлөөт мөнгөн урсгал, хүү, татвар, элэгдэл, хорогдлын өмнөх ашиг, эсхүл хүү, татварын өмнөх ашиг зэрэг санхүү үзүүлэлтээр урьдчилан тогтоосон хувь хэмжээгээр;

16.2.4.бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлтөөс шалтгаалж урьдчилан тооцоолоогүй орлого бий болсон тохиолдолд түүний урьдчилан тогтоосон тодорхой хувиар.

16.3.Төрийн болон орон нутгийн өмчит компани, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компанийн ногдол ашгийн бодлогод дараах зарчим, шаардлагыг тусгана.

16.3.1.ногдол ашгийг аудитлагдсан санхүүгийн тайланг үндэслэн тогтоох;

16.3.2.компанийн батлагдсан бизнес болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, их засварын хэрэгцээ, нөөц сан бүрдүүлэх шаардлага, санхүүгийн тогтвортой байдлыг харгалзан үзэх;

16.3.3.нийтийн үйлчилгээний үүрэг хүлээсэн бол тухайн үүргийн санхүүжилт, нөхөн төлбөр, татаас, тарифын зохицуулалт, зориулалтын хөрөнгийг ногдол ашиг тооцох сууринаас тусад нь авч үзэх;

16.3.4.компанийн урт хугацааны үнэ цэн, хэвийн үйл ажиллагааг дордуулахгүй байх;

16.3.5.бусад хувьцаа эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх.

16.4.Арилжааны зорилготой төрийн болон орон нутгийн өмчийн компани, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компани нь ногдол ашгийн бодлогод заасны дагуу ногдол ашиг хуваарилах үүрэгтэй.

16.5.Энэ хуулийн 16.4-т заасан компанийн тухайд тухайн жилд хуваарилах ногдол ашгийн зорилтот хувь хэмжээ, ногдол ашиг тооцох хэлбэрийг Засгийн газар, орон нутгийн өмчит компанийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал жил бүрийн төсвийн төсөл боловсруулах үе шатанд компанийн ангилал, салбарын онцлог, хөрөнгө оруулалтын хэрэгцээ, өр төлбөрийн хэмжээ, мөнгөн урсгал, өөрийн хөрөнгийн өгөөж, нөөц сангийн шаардлагыг харгалзан тогтооно.

16.6.Энэ хуулийн 16.5-д заасан зорилтот хувь хэмжээ нь арилжааны зорилготой компанийн хувьд хуваарилж болох цэвэр ашгийн 30 хувиас доошгүй байх зарчмыг баримтална. Харин компанийн санхүүгийн байдал, хөрөнгө оруулалтын хэрэгцээ, өр төлбөрийн хэмжээ, эсхүл энэ хуулийн 16.8-д заасан үндэслэл байгаа бол уг хувь хэмжээг бууруулж болно.

16.7.Нийтийн үйлчилгээний төрийн болон орон нутгийн өмчит компанид энэ хуулийн 16.6-д заасан доод хувь хэмжээ хамаарахгүй. Компани нь цэвэр ашигтай ажилласан тохиолдолд төлбөрийн чадвар, мөнгөн урсгал, нийтийн үйлчилгээний үүргийн санхүүжилт, үйлчилгээний хүртээмж, чанар, тасралтгүй байдлыг харгалзан ногдол ашиг хуваарилж болно.

16.8.Дараах үндэслэл байгаа бол энэ хуулийн 16.5, 16.6-д заасан зорилтот буюу доод хувь хэмжээнээс бага хэмжээгээр ногдол ашиг хуваарилж болно:

16.8.1.компанийн хэвийн үйл ажиллагааг хангах хүрээнд цэвэр ашгаас дахин хөрөнгө оруулалт хийх зайлшгүй шаардлага үүссэн;

16.8.2.компанийн ногдол ашгийн бодлогод тусгасны дагуу хуримтлагдсан алдагдлыг нөхөх шаардлага үүссэн;

16.8.3.эрх бүхий байгууллагаас тогтоосон өөрийн хөрөнгийн хүрэлцээний шалгуур үзүүлэлтийг хангуулж, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах шаардлага үүссэн.

16.9.Энэ хуулийн 16.8-д заасан үндэслэлээр ногдол ашгийг зорилтот хувь хэмжээнээс бага тогтоох саналыг төлөөлөн удирдах зөвлөл гаргана. Саналд дараах бичиг баримтыг хавсаргана:

16.9.1.аудитлагдсан санхүүгийн тайлан;

16.9.2.төлбөрийн чадварын болон мөнгөн урсгалын дүгнэлт;

16.9.3.зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалтын тооцоолол.

16.10.Энэ хуулийн 16.9-д заасан саналыг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч хянаж, зөвшөөрөх, өөрчлөх, эсхүл татгалзах тухай үндэслэл бүхий шийдвэр гаргана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	72
Татгалзсан:	27
Бүгд:	99

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төслийн 23 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 23.4 дэх хэсэг нэмэх:

“23.4.Төлөөлөн удирдах зөвлөлгүй төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьд түүний бүрэн эрхийг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	69
Татгалзсан:	30
Бүгд:	99

69.7 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалтын “авлигын,” гэсний дараа “нийтийн албаны ашиг сонирхлын,” гэж нэмж, 24.1.2 дахь заалтын “тухайн салбарт 5-аас доошгүй жил удирдах албан тушаалд” гэснийг “төрийн өмчит компанийн хувьд удирдах албан тушаалд таваас доошгүй, орон нутгийн өмчит компанийн хувьд удирдах албан тушаалд хоёроос доошгүй жил” гэж, “хууль” гэснийг “эрх зүй” гэж өөрчилж, 24.1.6.а. дэд заалтын “өөрөө” гэснийг “дангаараа” гэж өөрчилж, “дангаараа болон” гэснийг хасах,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	70
Татгалзсан:	29
Бүгд:	99

70.7 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.4, 24.5, 24.6 дахь хэсгийг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулах:

“24.4.Арилжааны зорилго бүхий төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь сондгой тооны таваас ес хүртэлх гишүүнтэй байна.

24.5.Энэ хуулийн 24.4-т заасан төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний төрийн болон орон нутгийн төлөөллийн нэг гишүүн нь хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээс санал болгож, томилогдсон этгээд байна.

24.6.Энэ хуулийн 24.4-т заасан төлөөлөн удирдах зөвлөл нь 5 гишүүнтэй бол хоёроос, 7 гишүүнтэй бол гурваас, 9 гишүүнтэй бол дөрвөөс доошгүй нь хараат бус гишүүн байна. Хараат бус гишүүнийг Компанийн тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	71
Татгалзсан:	28
Бүгд:	99

71.7 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн “нийтийн зориулалттай дэд бүтэц,” гэснийг хасаж, “таваас илүүгүй сондгой тооны” гэснийг “таван” гэж, “хоёр хүртэлх гишүүн нь төрийн захиргааны албан хаагч, хоёроос доошгүй нь мэргэжлийн хараат бус гишүүн байж болно” гэснийг “хоёроос доошгүй нь хараат бус гишүүн байна” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	70
Татгалзсан:	29
Бүгд:	99

70.7 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24.8.Энэ хуулийн 24.5-д зааснаас бусад төрийн болон орон нутгийн төлөөллийн гишүүдийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилох бөгөөд төрийн захиргааны албан хаагч нэрээ дэвшүүлж, сонгон шалгаруулалтад оролцож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	67
Татгалзсан:	32
Бүгд:	99

67.7 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсгийг доор дурдсан өөрчлөн найруулах:

“29.6.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний санал өгөх, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч доор дурдсанаас бусад тохиолдолд оролцож, удирдамж, чиглэл өгөхийг хориглоно:

29.6.1.ногдол ашгийн бодлого батлах, хэрэгжүүлэх;
29.6.2.төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогыг хэрэгжүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	71
Татгалзсан:	28
Бүгд:	99

71.7 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Дээрх 13 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 29 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 29.7, 29.8, 29.9 дэх хэсэг нэмэх:

“29.7.Төрийн болон орон нутгийн өмчийн төлөөлөл нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ компанийн ашиг сонирхол, хуульд заасан үүрэг, хариуцлагыг тэргүүн ээлжид баримтлах бөгөөд энэ хуулийн 29.6-д заасан удирдамж, чиглэлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн баримтлах эсэхийг бие даан шийдвэрлэнэ.

29.8.Төрийн болон орон нутгийн өмчийн төлөөлөл нь энэ хуулийн 29.6-д заасан удирдамж, чиглэлийг баримталсан, эсхүл баримтлаагүй нь түүнийг Компанийн тухай хууль болон бусад хуульд заасан үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

29.9.Энэ хуулийн 29.6-д заасан удирдамж, чиглэлийг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч бүртгэж хадгална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	70
Татгалзсан:	29
Бүгд:	99

70.7 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Төслийн 36 дугаар зүйлийн 36.1.1, 36.1.2 дахь заалтын “3” гэснийг “2” гэж, 36.1.3 дахь заалтын “өргөдөл” гэснийг “хүсэлт” гэж, 36.1.13 дахь заалтын “3 жил дараалан хангалтгүй” гэснийг “2 жил дараалан өөрчлөлттэй” гэж тус тус өөрчилж, 36.1.4 дэх заалтын “ноцтой” гэсний өмнө “эсхүл” гэж нэмж, 36.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36.5.Энэ хуулийн 36.1.1-д заасан тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчит нийтийн үйлчилгээний компани, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод төрийн эзэмшлийн хувьцаа эзэмших эрхийг хэрэгжүүлэгч болон төслийн санхүүжилттэй компанид хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	70
Татгалзсан:	29
Бүгд:	99

70.7 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Төслийн 37 дугаар зүйлийн 37.4, 37.5, 37.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“37.4.Төрийн болон орон нутгийн өмчийн компани жил бүрийн санхүүгийн тайлангаа баталгаажуулах, хараат бус мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж гаргуулах зорилгоор санхүүгийн тайлангийн аудит хийлгэнэ.

37.5.Төрийн аудитын байгууллага тайлант жилийн улсын хөгжлийн бодлого, тухайн жилийн санхүүгийн төлөв байдал, урьдчилсан судалгаа, эрсдэлийн үнэлгээг хийж, өмнөх оны гүйцэтгэсэн аудитын дүн, хүний нөөц, төсөв, санхүү бусад хүчин зүйлд үндэслэн санхүүгийн тайлангийн аудит хийх төрийн болон орон нутгийн өмчийн компанийг сонгон гүйцэтгэнэ.

37.6.Төрийн аудитын байгууллагаас энэ хуулийн 37.5-д зааснаас бусад төрийн болон орон нутгийн өмчит компанийн санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдэд тавигдах тусгай шаардлагыг Засгийн газарт хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	70
Татгалзсан:	29
Бүгд:	99

70.7 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Дээрх 16 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 37 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 37.7, 37.8 дахь хэсэг нэмэх:

“37.7.Энэ хуулийн 37.6-д заасан хөндлөнгийн аудит хийх хуулийн этгээдийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журмын дагуу аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээс төлөөлөн удирдах зөвлөл сонгон шалгаруулна.

37.8.Энэ хуулийн 37.1-д заасан өмчлөлийн бодлогод нийцүүлэн тухайн жилд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын хуулийн этгээдээр санхүүгийн аудит хийлгэх төрийн өмчит компанийн жагсаалт болон аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулах этгээдийг Засгийн газар тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	71
Татгалзсан:	36
Бүгд:	99

71.7 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Төслийн 41 дүгээр зүйлийн 41.3 дахь хэсгийг хасаж, 41.4 дэх хэсгийн “03 дугаар сарын 01-ний” гэснийг “04 дүгээр сарын 15-ны өдөр” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	65
Татгалзсан:	34
Бүгд:	99

65.7 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Төслийн 44 дүгээр зүйлийн дугаарыг 43 болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“43 дугаар зүйл.Энгийн хувьцаа нэмж гаргах, арилжих

43.1.Төрийн болон орон нутгийн өмчит компани нь энэ хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлэн энгийн хувьцаа нэмж гаргаж, дараах хэлбэрээр үнэт цаасны зах зээлд санал болгож хөрөнгө оруулалт татаж болно:

43.1.1.хуульд заасны дагуу нийтэд санал болгох, эсхүл хаалттай хүрээнд санал болгох;

43.1.2.хуульд заасны дагуу үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад давхар бүртгүүлэн санал болгох;

43.1.3.хуульд заасан бусад хэлбэрээр дотоодын болон гадаадын үнэт цаасны зах зээлд санал болгох.

43.2.Энэ хуулийн 43.1-д заасан шийдвэрийг төрийн өмчийн компанийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчит компанийн хувьд тухайн шатын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гаргана. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн хувьд Компанийн тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

43.3.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн энгийн хувьцааг нийтэд санал болгох ажиллагааг дараах зорилгоор хэрэгжүүлнэ:

43.3.1.компанийн үйлдвэрлэл, үйл ажиллагааг өргөжүүлэх, техник технологийн шинэчлэл хийх, өрсөлдөх чадвар, санхүүгийн чадавх, тогтвортой байдлыг дээшлүүлэх;

43.3.2.компанийн засаглал, ил тод байдал, хяналтыг сайжруулах, олон нийтийн оролцоог хангах;

43.3.3.Монгол Улсын иргэн, Үндэсний баялгийн сан, Тэтгэврийн сан болон хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх;

43.3.4.газрын хэвлийн баялгийн өгөөжийг Монгол Улсын иргэн бүрд хүртээмжтэй, ил тод, зах зээлийн зарчмаар хүргэх;

43.3.5.төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогыг хэрэгжүүлэх.

43.4.Энэ хуулийн 43.3.1-43.3.5-д заасан зорилго болон 43.6.2-т заасан зарчмыг хангах хүрээнд төрийн болон орон нутгийн өмчит компанийн энгийн хувьцааг нийтэд санал болгохдоо хөрөнгө оруулагчийн төрлийг дараах байдлаар дангаар болон хослуулан тогтоож болно:

43.4.1.Монгол Улсын иргэн;

43.4.2.мэргэжлийн хөрөнгө оруулагч;

43.4.3.стратегийн хөрөнгө оруулагч;

43.4.4.бусад хөрөнгө оруулагч.

43.5.Энэ хуулийн 43.4-д заасны дагуу хөрөнгө оруулагчдын төрөл, захиалгын доод болон дээд хэмжээ, хуваарилалтын аргачлал, төвлөрлөөс сэргийлэх арга хэмжээ болон шаардлагатай тохиолдолд нэг этгээдийн эзэмших дээд хэмжээг төрийн өмчит өмчийн компанийн хувьд Засгийн газар, Орон нутгийн өмчийн компанийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал мэргэжлийн оролцогчийн санал, дүгнэлтийг үндэслэн тогтооно. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн хувьд мэргэжлийн оролцогчдын санал, дүгнэлтийг үндэслэн Компанийн тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

43.6.Төрийн өмчит компанийн энгийн хувьцааг нийтэд санал болгоход дараах зарчмыг баримтална:

43.6.1.шударга, ил тод оролцох боломж олгох;

43.6.2.дангаар болон холбогдох этгээдэд хувьцаа эзэмшигчийн хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх;

43.6.3.хувьцааны үнэ, үнэлгээ, эрсдэл, ногдол ашиг, саналын эрх, хязгаарлалт, захиалгын нөхцөлийг нийтэд хүртээмжтэй мэдээлэх;

43.6.4.захиалга давсан тохиолдолд хувьцааг урьдчилан зарласан журмын дагуу хуваарилах;

43.6.5.Монгол Улсын иргэний хувьцааг богино хугацаанд төвлөрүүлэн худалдан авах, дамжуулан худалдах, зах зээлийн урвуулан ашиглах эрсдэлээс сэргийлэх зохицуулалт хийх;

43.6.6.Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан бусад энгийн хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хуульд өөрөөр заагаагүй бол хангах.

43.7.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааг дараах хэлбэрээр арилжиж худалдаж болно:

43.7.1.үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьд төрийн болон орон нутгийн эзэмшлийн энгийн хувьцааг хоёрдогч зах зээл дээр арилжих;

43.7.2.дуудлага худалдаа, уралдаант шалгаруулалт, хэлэлцээрийн аргаар стратегийн хөрөнгө оруулагчид худалдах;

43.7.3.өөр төрлийн үнэт цаас, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр солих;

43.7.4.хуульд заасан бусад.

43.8.Энэ хуулийн 43.7-д заасны дагуу төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцааг арилжих, худалдах шийдвэрийг Засгийн газар, орон нутгийн

өмчит компанийн орон нутгийн эзэмшлийн хувьцааг арилжих, худалдах шийдвэрийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хувьцаа эзэмшигчийн хувиар гаргана.

43.9.Энэ хуулийн 8.1.2-т заасан төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцааг худалдах, арилжих шийдвэрийг Улсын Их Хурал гаргана.

43.10.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмжийг нэмэгдүүлэх, ур чадвартай ажлыг тогтвортой ажиллуулах, дотоод хяналтыг сайжруулах зорилгоор Компанийн тухай хуульд заасны дагуу компанийн ажилтнууд опцион эзэмших хөтөлбөр хэрэгжүүлж болно.

43.11.Энэ хуулийн 43.10-т заасан хөтөлбөрийн нөхцөл, эзэмшлийн дээд хэмжээ, шилжүүлэх хязгаарлалт, хэрэгжүүлэх хугацаа, шалгуур үзүүлэлтийг төлөөлөн удирдах зөвлөлийн саналын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурал Засгийн газрын зөвшөөрлийг үндэслэн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70

Татгалзсан: 29

Бүгд: 99

70.7 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Төслийн 51 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 51.3, 51.4, 51.5 дахь хэсэг нэмэх:

“51.3.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийг энэ хуулийн 8.3-т заасан үндэслэлд нийцүүлэх арга хэмжээг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгуулна.

51.4.Энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан зохицуулалтыг 2028 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл хугацаанд үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

51.5.Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө үүсгэн байгуулагдсан уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн өмчит компанид энэ хуулийн 8.3-т заасан зөвшөөрөл хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70

Татгалзсан: 29

Бүгд: 99

70.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу хураалгасан санал:

С.Бямбацогт: 1.Төслийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.3.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн дүрэмд Компанийн тухай хуулийн 16.2-т зааснаас гадна компанийн үйл ажиллагаа, зорилго, хүрэх үр дүн, хувьцаа эзэмшигч, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн талаарх

мэдээлэл, нийтийн үйлчилгээний үүргийн бодлогыг тодорхой тусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	68
Татгалзсан:	31
Бүгд:	99

68.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	65
Татгалзсан:	34
Бүгд:	99

65.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 15 дугаар зүйлийн 15.5, 15.6 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	64
Татгалзсан:	35
Бүгд:	99

64.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32.4.Компанийн гүйцэтгэх удирдлагын хуульд заасан шаардлагыг хангасан хараат бус, мэргэжлийн багаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	65
Татгалзсан:	34
Бүгд:	99

65.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 37 дугаар зүйлийн 37.4, 37.5, 37.6 дахь хэсгийг өөрчлөн найруулах санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед дэмжигдсэн Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах саналыг хүчингүй болгох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	67
Татгалзсан:	32
Бүгд:	99

67.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль,

тогтоолын төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дуусав.

Уг асуудлыг 17 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: Байнгын хорооны саналаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69

Татгалзсан: 30

Бүгд: 99

69.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлэг батлах санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65

Татгалзсан: 34

Бүгд: 99

65.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 18 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Бизнесийн эрх чөлөөний тухай /Эдийн засгийн эрх чөлөөний тухай/ хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн нэгтгэсэн төслийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Нэг.Бизнесийн эрх чөлөөний тухай /Эдийн засгийн эрх чөлөөний тухай/ хуулийн төслийн талаар:

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар, С.Зулпхар, Б.Мөнхсоёл, Э.Одбаяр, Д.Пүрэвдаваа, Б.Пунсалмаа, П.Сайнзориг, Г.Уянгахишиг, Д.Үүрийнтуяа, С.Цэнгүүн, Д.Энхтүвшин /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, **БИЗНЕСИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ** болон **ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН** нэгтгэсэн төслийн нэрийг “**ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ**” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	67
Татгалзсан:	32
Бүгд:	99

67.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1, 1.2 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан өмчлөгчийн эрхийг хамгаалах, бизнесийн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх эрх, эдийн засгийн эрх чөлөөг баталгаажуулах, шударга өрсөлдөөн, бизнесийн орчны тогтвортой байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	69
Татгалзсан:	30
Бүгд:	99

69.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, нэгтгэсэн төслийн 2, 3 дугаар зүйлийг нэгтгэн 2 дугаар зүйл болгон доор дурдсан өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Эдийн засгийн эрх чөлөөний хууль тогтоомж

2.1.Эдийн засгийн эрх чөлөөний хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	63
Татгалзсан:	36
Бүгд:	99

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 35
Бүгд: 99
64.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, нэгтгэсэн төслийн 5 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 35
Бүгд: 99
64.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, нэгтгэсэн төслийн 6 дугаар зүйлийг 3 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Эдийн засгийн эрх чөлөөг хангах талаар баримтлах зарчим

3.1.Эдийн засгийн эрх чөлөөг хангахад дараах зарчмыг баримтална:

3.1.1.хуулиар хориглосноос бусад бизнесийн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх;

3.1.2.бизнесийн үйл ажиллагаанд хийх хязгаарлалтад зорилгодоо хүрэхэд тохирсон, боломжит хамгийн бага түвшинд байх;

3.1.3.төрийн зохицуулалт нь тогтвортой, урьдчилан таамаглах боломжтой байх;

3.1.4.шударгаар олж авсан өмчлөх эрхийг хамгаалах;

3.1.5.бизнесийн үйл ажиллагаанд хамаарах мэдээллийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, боловсруулж, ашиглах, хуульд зааснаас бусад тохиолдолд задруулахгүй байх;

3.1.6.хөдөлмөр, оюуны бүтээл, хөрөнгө оруулалтын үр шим, хууль, ёсны дагуу олсон орлогоо чөлөөтэй эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг баталгаажуулах;

3.1.7.хуулийн хүрээнд гэрээг чөлөөтэй байгуулах, түүний агуулгыг бие даан тодорхойлох эрхийг хангах;

3.1.8.хөдөлмөрлөх эрхийг бүрэн хангах, зохистой хөдөлмөрийг дэмжих;

3.1.9.ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний бодлого, зохицуулалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлттэй уялдуулах;

3.1.10.шударга өрсөлдөөнийг үндэслэлгүйгээр хязгаарлахгүй байх, өмчийн хэлбэр харгалзахгүй шударгаар өрсөлдөх боломжийг хангах;

3.1.11.хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчит компани байгуулахгүй байх;

3.1.12.төрийн үйлчилгээ цахим, ил тод, түргэн шуурхай, тэгш, хүртээмжтэй байх, бизнес эрхлэгчээс нэг мэдээллийг нэг удаа авах нөхцөлийг бүрдүүлэх;

3.1.13.нийтийн мэдээллийг хуульд заасны дагуу нээлттэй өгөгдөл болгож ашиглах боломжийг нэмэгдүүлэх;

3.1.14.бизнесийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээнд суурилсан, давхардалгүй, ил тод, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөвлөн туслахад чиглэсэн хяналт шалгалтыг тэргүүн ээлжид хэрэгжүүлэх;

3.1.15.хуульд зааснаас бусад тохиолдолд үнэ тогтоох үйл ажиллагаанд төр аливаа хэлбэрээр оролцохгүй байх.

3.2.Эдийн засгийн харилцааг зохицуулсан хууль тогтоомжийг боловсруулан батлахдаа энэ хуулийн 3.1-д заасан эдийн засгийн эрх чөлөөний зарчмыг баримтална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	66
Татгалзсан:	33
Бүгд:	99

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төсөлд доор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл. Эдийн засгийн эрх чөлөөг хангах төрийн бодлого, зохицуулалт

4.1.Төрийн байгууллага, албан тушаалтан бизнесийн үйл ажиллагаанд хийх төрийн зохицуулалтыг боловсруулахдаа бизнес эрхлэгчид үзүүлэх ачаалал, шударга өрсөлдөөний хязгаарлалт, хөрөнгө оруулалтын орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлж, бизнес эрхлэгч, мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн байгууллага, олон нийтийн оролцоог хангана.

4.2.Өмчлөх эрхийг хязгаарлах шийдвэр, үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу хууль, хуулиар эрх олгосон байх шаардлагыг хангасан байна.

4.3.Төрөөс үнэ тогтоох, нийлүүлэлтийг хязгаарлах шийдвэр гаргахдаа энэ хуулийн 3.1.2-т заасныг баримтлах бөгөөд аливаа хязгаарлалтыг зөвхөн хугацаатай тогтооно.

4.4.Тухайн жилийн төсвийн тухай хууль болон түүнийг дагаж боловсруулсан хууль тогтоомжоос бусад хууль тогтоомж нь бизнес эрхлэгчийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, зардлыг нэмэгдүүлэх бол хууль тогтоомжийн дагаж мөрдөж эхлэх хугацаа нь батлагдсанаас хойш 6-аас доошгүй сарын хугацаатай байна.

4.5.Бизнесийн үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль тогтоомж, захиргааны шийдвэрийн үр дагаварт жил тутам шинжилгээ хийж шаардлагагүй, давхардсан, үр ашиггүй зохицуулалтыг багасгана.

4.6.Бизнес эрхлэгчийн ашиг, орлого хөрөнгөд ноогдуулах татварыг хуулиар тогтооно.

4.7.Төр нь бизнесийн үйл ажиллагаанаас үүссэн маргааныг эвлэрүүлэн зуучлал, арбитрын болон бусад шүүхийн бус журмаар шуурхай, шударга, хараат бусаар шийдвэрлэх боломжийг дэмжинэ.

4.8.Төрийн аливаа сонгон шалгаруулах үйл ажиллагаа, төсвийн болон төсвийн бус хөрөнгийн захиран зарцуулалт, худалдан авалт нь бизнес эрхлэгчийн зах зээлд чөлөөтэй, шударга өрсөлдөх боломжийг хангасан байна.

4.9.Мэргэжил эзэмших, дээд болон мэргэжлийн боловсрол, сургалт, ажиллах хүчний шилжилт хөдөлгөөнийг хөдөлмөрийн зах зээл, эдийн засгийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн зохицуулна.

4.10.Төсвийн сахилга батыг сахиж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагуудыг хангаж ажиллана.

4.11.Төр бизнес эрхлэгчийн зөвшөөрөлтэй эрхэлж байгаа үйл ажиллагааг хэвийн, саадгүй явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	66
Татгалзсан:	33
Бүгд:	99

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, нэгтгэсэн төслийн 7 дугаар зүйлийг 8 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8 дугаар зүйл.Төрийн бодлого, үйл ажиллагаанд хориглох зүйл

8.1.Эдийн засгийн эрх чөлөөг хангах төрийн бодлого, үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:

8.1.1.үндэсний аюулгүй байдал, хүний үндсэн эрх, эрх чөлөө, хүн амын эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах зорилгоор нийтийн ашиг сонирхол, шударга өрсөлдөөнийг хамгаалахаас бусад тохиолдолд эдийн засгийн эрх чөлөөг хязгаарласан, хориглосон хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, дүрэм, журам, норм, стандартын баримт бичиг батлан гаргах;

8.1.2.бизнес эрхлэгчийн ажил хэргийн нэр хүндэд халдах, үндэслэлгүй хуурамч мэдээлэл түгээх;

8.1.3.бизнес эрхлэгчийг нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд албадан оролцуулах;

8.1.4.хуульд зааснаас бусад тохиолдолд зарим бизнес эрхлэгчид давуу эрх олгосон захиргааны хэм хэмжээний акт, дүрэм, журам батлах, үйл ажиллагаа явуулах, эс үйлдэхүй гаргах;

8.1.5.энэ хуульд заасан зарчмыг зөрчиж эдийн засгийн эрх чөлөөг хязгаарласан хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт батлах, эс үйлдэхүй гаргах;

8.1.6.бизнесийн үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөх, оролцох, үндэслэлгүй хяналт шалгалт хийх, өмч хөрөнгийг нь хууль бусаар хураан авах, дайчлах;

8.1.7.бизнес эрхлэгчид төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хууль, захиргааны хэм хэмжээний актад зааснаас бусад баримт бичиг, түүний бүрдлийг шаардах;

8.1.8.бизнес эрхлэгчийн үйл ажиллагаанд хуульд заагаагүй хяналт шалгалт хийх, хяналт шалгалтын тогтоосон хугацааг хэтрүүлэх.

8.2.Хувийн өмчийг нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хураах, дайчлан авах төрийн шийдвэр нь зөвхөн зах зээлийн бодит үнэлгээнд үндэслэсэн нөхөх олговор бүрэн төлөгдсөн тохиолдолд хэрэгжинэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	65
Татгалзсан:	34
Бүгд:	99

65.7 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, нэгтгэсэн төслийн 2 дугаар бүлгийн нэрийг **“ХОЁРДУГААР БҮЛЭГ” “ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА”** гэж өөрчилж, төслийн 4 дүгээр зүйлийн өмнө шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	63
Татгалзсан:	36
Бүгд:	99

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, нэгтгэсэн төслийн 8 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	64
Татгалзсан:	35
Бүгд:	99

64.6 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, нэгтгэсэн төслийн 3 дугаар бүлгийн нэрийг **“ГУРАВДУГААР БҮЛЭГ” “ХАРИУЦЛАГА, ИЛ ТОД БАЙДАЛ, ХЯНАЛТ”** гэж өөрчилж, төслийн 5 дугаар зүйлийн өмнө шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 35
Бүгд: 99
64.6 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, нэгтгэсэн төслийн 9 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 37
Бүгд: 99
62.6 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, нэгтгэсэн төслийн 10 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 40
Бүгд: 99
59.6 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, нэгтгэсэн төслийн 11 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 38
Бүгд: 99
61.6 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, нэгтгэсэн төслийн 12 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 37
Бүгд: 99
62.6 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, нэгтгэсэн төслийн 13 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 36
Бүгд: 99
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, нэгтгэсэн төслийн 14 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 35
Бүгд: 99

64.6 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, нэгтгэсэн төслийн 15 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65

Татгалзсан: 34

Бүгд: 99

65.7 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, нэгтгэсэн төслийн 16 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62

Татгалзсан: 37

Бүгд: 99

62.6 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, нэгтгэсэн төслийн **“ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ”**
“ХАРИУЦЛАГА, ШҮҮХИЙН ХАМГААЛАЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ, ХЯНАЛТ” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63

Татгалзсан: 36

Бүгд: 99

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, нэгтгэсэн төслийн 17 дугаар зүйлийг 5 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Хариуцлага.

5.1.Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэр, үйл ажиллагаа, үйлдэл, эс үйлдэхүйгээс бизнес эрхлэгчид учирсан хохирлыг төрөөс хуульд заасны дагуу нөхөн төлнө.

5.2.Энэ хуулийг зөрчсөн төрийн байгууллага, албан тушаалтан, хүн, хуулийн этгээд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64

Татгалзсан: 35

Бүгд: 99

64.6 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, нэгтгэсэн төслийн 18 дугаар зүйлийг 7 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7 дугаар зүйл.Гомдол гаргах эрх

7.1.Аж ахуй эрхлэгч төрийн хууль бус шийдвэр, үйл ажиллагаанд гомдол гаргах эрхтэй бөгөөд төрийн байгууллага гомдлыг хуульд заасан хугацаанд шуурхай шийдвэрлэх, эрхийг сэргээх, нөхөн төлбөрийг барагдуулах үүрэгтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	66
Татгалзсан:	33
Бүгд:	99

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, нэгтгэсэн төслийн 19 дүгээр зүйлийг 6 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6 дугаар зүйл.Ил тод байдал, хяналт

6.1.Төрийн байгууллага, албан тушаалтан бизнесийн үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа төрийн зохицуулалтын үндэслэл, зорилго, үр нөлөө, шийдвэр гаргах үйл явцын талаарх мэдээллийг нийтэд ил тод мэдээлж ажиллана.

6.2.Төр бизнесийн үйл ажиллагаатай холбоотой өөрт байгаа мэдээллийг нийтэд тэгш, шударга, хүртээмжтэйгээр хүргэнэ.

6.3.Засгийн газар эдийн засгийн эрх чөлөөг хангах талаарх энэ хуулийн хэрэгжилтийн тайланг жил бүр Улсын Их Хуралд танилцуулж, хэлэлцүүлнэ.

6.4.Тайланд дараах мэдээллийг тусгана:

6.4.1.эдийн засгийн зохицуулалт хийсэн хүрээ, арга хэлбэр, үр нөлөөний тоон үзүүлэлт;

6.4.2.эдийн засгийн эрх чөлөө зөрчигдсөн, нөхөн төлбөр олгосон тохиолдлын тоо, хэмжээ;

6.4.3.ил тод байдал, шударга өрсөлдөөний орчны талаарх дүн шинжилгээ;

6.4.4.энэ хуулийн 3.1.12-т заасны дагуу үнэ тарифын зохицуулалттай бизнесийн үйл ажиллагааны жагсаалт, тэдгээрт төрөөс олгосон татаас, дэмжлэгийн хэмжээ, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, үнэ тарифын зохицуулалтын үргэлжлэх хугацаа;

6.4.5.энэ хуулийн 6.4.4-т зааснаас бусад төрөөс бизнесийн үйл ажиллагаанд олгосон татаас, дэмжлэгийн хэмжээ;

6.4.6.эдийн засгийн эрх чөлөөний төлөв байдлын талаарх хөндлөнгийн мэргэжлийн байгууллагын санал.”

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Д.Энхтүвшин үг хэлж, хуралдаан даргалагч гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

24.Ажлын хэсгийн гаргасан, нэгтгэсэн төслийн 20 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	64
Татгалзсан:	35
Бүгд:	99

64.6 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, нэгтгэсэн төслийн **“ТАВДУГААР БҮЛЭГ” “БУСАД”** гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	62
Татгалзсан:	37
Бүгд:	99

62.6 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, нэгтгэсэн төслийн 21 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	58
Татгалзсан:	41
Бүгд:	99

58.6 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, нэгтгэсэн төслийн **“ЗУРГАДУГААР БҮЛЭГ” “БУСАД ЗҮЙЛ”** гэснийг **“ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ” “БУСАД”** гэж өөрчилж, төслийн 9 дүгээр зүйлийн өмнө шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	63
Татгалзсан:	36
Бүгд:	99

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, нэгтгэсэн төслийн 22 дугаар зүйлийг 9 дүгээр зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

9.1.Энэ хуулийг зөрчсөн төрийн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

9.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	66
Татгалзсан:	33
Бүгд:	99

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин үг хэлэв.

Хоёр.Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар:

Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал:

Нэг.Авто замын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	67
Татгалзсан:	32
Бүгд:	99

67.7 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 40
Бүгд: 100
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Наян ес.Шилэн дансны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 37
Бүгд: 100
63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Ер.Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 42
Бүгд: 100
58.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Ерэн нэг.Шүүх шинжилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	59
Татгалзсан:	41
Бүгд:	100

59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Ерэн хоёр.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	59
Татгалзсан:	41
Бүгд:	100

59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Ерэн гурав.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	60
Татгалзсан:	40
Бүгд:	100

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Ерэн дөрөв.Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.20, 25.21 дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	61
Татгалзсан:	39
Бүгд:	100

61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	60
Татгалзсан:	40
Бүгд:	100

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Ерэн тав.Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	59
Татгалзсан:	41
Бүгд:	100

59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Ерэн зургаа.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.17 дахь заалтын “тэсэрч дэлбэрэхээс бусад” гэснийг, мөн заалтын “100-” гэснийг, 6 дахь хэсгийн 6.15 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	62
Татгалзсан:	38
Бүгд:	100

62.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	59
Татгалзсан:	41
Бүгд:	100

59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлээс “1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.7 дахь заалтыг” гэснийг хасаж, 1 дүгээр зүйлд шилжүүлэх, мөн зүйлийн 13 дахь хэсгийг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	61
Татгалзсан:	39
Бүгд:	100

61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.11 дэх заалтын “өвчний” гэсний дараа “судалгаа” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	63
Татгалзсан:	37
Бүгд:	100

63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “зөвшөөрөл олгох, сунгах болон зөвшөөрөлтэй холбогдох бусад” гэснийг, мөн зүйлийн “8.1” гэсний дараа “, 8.3” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	60
Татгалзсан:	40
Бүгд:	100

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн “3.1 дүгээр” гэснийг “3.2 дугаар” гэж, мөн зүйлийн 5.5 дугаар зүйлийн “14 дэх” гэснийг “15 дахь” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	61
Татгалзсан:	39
Бүгд:	100

61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 8.1 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийн “7.8”, мөн зүйлийн “, 1.12” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	62
Татгалзсан:	38
Бүгд:	100

62.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 7 дугаар зүйл нэмэх:

“7 дугаар зүйл.Энэ хуулийг Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	63
Татгалзсан:	37
Бүгд:	100

63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гаргасан, Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн зарчмын зөрүүтэй саналын томъёоллууд дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн зүйл, хэсэг, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх, агуулга зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, найруулгын шинжтэй засвар хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	59
Татгалзсан:	41
Бүгд:	100

59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дуусав.

Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Арбитрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Радио долгионы тухай хуульд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шинжилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг “Хууль санаачлагчид нь буцаах тухай” тогтоол баталсанд тооцов./20:12/

Уг асуудлыг 20 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	66
Татгалзсан:	34
Бүгд:	100

66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 20 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 32
Бүгд: 100
68.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

1.“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 31
Бүгд: 100
69.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 20 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Нэг.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Нэг.Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Б.Баярбаатар, Х.Баасанжаргал, Д.Бум-Очир, А.Ганбаатар, Б.Жаргалан, М.Нарантуяа-Нара, П.Сайнзориг, А.Ундраа, С.Цэнгүүн, Л.Энхнасан /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 3 дугаар зүйлийн 3.1.12 дахь заалтын “тоног” гэснийг хасаж, мөн зүйлийн 3.1,13, 3.1.14 дэх заалтыг нэгтгэн “3.1.13” дахь заалт болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.13.“татах төхөөрөмжийн эд анги” гэж татах төхөөрөмж дагнан хэрэглэдэг хэсгийг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 35
Бүгд: 100
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижирийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6 дугаар зүйлийн 6.7.16 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.7.16.тамхи, татах төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, татах төхөөрөмжийн эд ангид тамхинаас өөр төрлийн үнэр, амт оруулагч бодис, бэлдмэл нэмсэн байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	68
Татгалзсан:	32
Бүгд:	100

68.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6 дугаар зүйлийн 6.7.16 дахь заалтын, мөн зүйлийн 5 дахь заалтын 7² дугаар зүйлийн 7^{2.3} дахь хэсгийн “дагалдах хэрэгсэл, татах төхөөрөмжийн” гэснийг “түүний” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	69
Татгалзсан:	31
Бүгд:	100

69.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 6 дугаар зүйлийн 6.8.3 дахь заалтын “байрлуулж” гэснийг “байрлуулах бөгөөд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	69
Татгалзсан:	31
Бүгд:	100

69.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын “6.8¹” гэснийг “6.10” гэж өөрчилж, мөн хэсгийн “Үндэсний зөвлөл” гэснийг “төв байгууллага” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	68
Татгалзсан:	32
Бүгд:	100

68.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтын 11¹ дүгээр зүйлийн 11^{1.6} дахь хэсгийн “үйлдвэр, худалдааны асуудал” гэснийг “хүнсний асуудал” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	66
Татгалзсан:	34
Бүгд:	100

66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтыг бүхэлд нь доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.1.“тамхин бүтээгдэхүүн” /цаашид “тамхи” гэх/ гэж тамхины навч, ургамлыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түүхий эд болгон үйлдвэрлэсэн, никотин, бохь, эсхүл химийн бусад бодис агуулсан татах төхөөрөмж ашиглаж, эсхүл ашиглахгүйгээр хэрэглэх зориулалттай, эмийн бүртгэлд бүртгэгдсэн тамхинаас гаргах эмээс бусад дараах бүтээгдэхүүнийг:

3.1.1.а.тамхины түүхий эд, задгай тамхи, татаж хэрэглэх зориулалттай навчин, сигар, дүнсэн, янжуур тамхи болон тэдгээртэй адилтгах бусад тамхи;

3.1.1.б.цахилгаан халаагч болон бусад төхөөрөмжөөр шатаахгүйгээр сорж татах зориулалттай халаадаг тамхи;

3.1.1.в.никотин, амт, үнэр оруулагч болон химийн бусад бодис агуулсан, эсхүл агуулаагүй шингэнийг цахилгаан хэрэгслээр ууршуулан татах, эсхүл түүнтэй адилтгах аргаар хэрэглэх зориулалттай электрон тамхи;

3.1.1.г.усан хоолойгоор татах зориулалттай тамхи;

3.1.1.д.үнэрлэх, сорох, зажлах, аманд уусгах, биед наах болон татахаас бусад аргаар хэрэглэх зориулалттай, никотин агуулсан, эсхүл агуулаагүй тамхин бүтээгдэхүүн.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	64
Татгалзсан:	36
Бүгд:	100

64.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг бүхэлд нь доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.2.Тамхины хяналтыг хэрэгжүүлэх талаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах үүрэг хүлээнэ:

5.2.1.тамхины хэрэглээ болон түүнээс шалтгаалах өвчлөл, нас баралтыг бууруулах чиглэлээр үндэсний бодлого, стратеги, хөтөлбөр боловсруулах, хэрэгжилтийг хангах;

5.2.2.тамхины хяналтын бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд төрийн болон орон нутгийн байгууллага, эрүүл мэндийн байгууллага, бусад холбогдох байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

5.2.3.тамхин бүтээгдэхүүний хэрэглээ, тархалт, эрүүл мэндэд үзүүлэх нөлөө, өвчлөл, нас баралтын талаарх мэдээлэл, статистикийг цуглуулах, мэдээллийн сан бүрдүүлэх, дүн шинжилгээ хийх, тайлагнах;

5.2.4.тамхины хамаарлаас гарах зөвлөгөө, эмчилгээ, сэтгэлзүйн дэмжлэг, никотин орлуулах эмчилгээ болон бусад эрүүл мэндийн тусламж үйлчилгээний стандартыг батлах, хэрэгжилтийг зохион байгуулах;

5.2.5.тамхины хамаарлаас гарах эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

5.2.6.тамхины хэрэглээ болон тамхины хяналтын талаар хүн амд чиглэсэн сургалт, сурталчилгаа, эрүүл мэндийн боловсролын үйл ажиллагааг зохион байгуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	68
Татгалзсан:	32
Бүгд:	100

68.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5 дугаар зүйлийн 5.3.1 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	64
Татгалзсан:	36
Бүгд:	100

64.0 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5 дугаар зүйлийн 5.3.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.3.2.бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын орчин дахь тамхины хяналтыг боловсролын салбарын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээд хэрэгжүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	64
Татгалзсан:	36
Бүгд:	100

64.0 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5 дугаар зүйлийн 5.3.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.3.3.мэргэжлийн байгууллагын судалгаанд үндэслэн бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын орчин дахь тамхидалтыг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	63
Татгалзсан:	37
Бүгд:	100

63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалтын “бүх шатын боловсролын” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 17 дугаар зүйлд заасан боловсролын байгууллага болон бүх түвшний

боловсролын сургалтын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	64
Татгалзсан:	36
Бүгд:	100

64.0 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5 дугаар зүйлийн 5.4 дэх заалтын “үр дүнтэй” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	65
Татгалзсан:	35
Бүгд:	100

65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалтын 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсгийн “хүнс, хөдөө аж ахуйн” гэснийг “хүнсний” гэж, мөн зүйлийн 5.5,3, 5.6.2 дахь заалтын “заасныг хэрэгжүүлэх” гэснийг “заасан зарчмыг баримтлах” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	64
Татгалзсан:	36
Бүгд:	100

64.0 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалтын 6 дугаар зүйлийн 6.7.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.7.2.энэ хуулийн 3.1.1.а-д заасан янжуур тамхи болон түүнтэй адилтгах бусад тамхи, 3.1.1.б-д заасан тамхийг нэг хайрцагт 20 ширхгээс цөөн тоогоор, эсхүл дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхийг 200 граммаас багаар савлах, энэ хуулийн 3.1.1.в-д заасан электрон тамхины шингэний хэмжээг 10 миллилитрээс ихээр савлах, тамхины шингэнийг дахин цэнэглэх боломжтой байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	57
Татгалзсан:	43
Бүгд:	100

57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн “2026 оны 01 дүгээр сарын 01-ний” гэснийг “2027 оны 01 дүгээр сарын 01-ний” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	61
Татгалзсан:	39
Бүгд:	100

61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд зүйл, хэсэг, заалт хасах, нэмэх саналтай уялдуулан холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, төслийн үг хэллэг, дэс дараалал, нэр томьёог жигдлэх засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	65
Татгалзсан:	35
Бүгд:	100

65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	64
Татгалзсан:	36
Бүгд:	100

64.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй санал:

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасангийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6 дугаар зүйлийн 6.7.16 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.7.16.электрон никотин дамжуулах системд тамхи болон гаанаас өөр төрлийн үнэр, амт оруулах бодис, бэлдмэл нэмсэн байх;” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	60
Татгалзсан:	40
Бүгд:	100

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нарагийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6.7.16 дахь заалтыг бүхэлд нь хасах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	60
Татгалзсан:	40
Бүгд:	100

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6.7.16 дахь заалтад дараах агуулгыг нэмэх:

“Тамхин бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд орц найрлагад хэрэглэхийг хориглосон бодисыг холбогдох техникийн зохицуулалтын шаардлагаар тодорхойлно;” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 39
Бүгд: 100
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайханы гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6.7.17 дахь заалтад доор дурдсан агуулгатай өгүүлбэр нэмэх:

“2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болон түүнээс хойш төрсөн Монгол Улсын иргэнд тамхи, тамхин бүтээгдэхүүн, никотин агуулсан болон никотин хүргэх зориулалттай бүтээгдэхүүнийг худалдахыг хориглоно. Энэ хэсэгт заасан этгээдэд тамхи, тамхин бүтээгдэхүүн, никотин агуулсан болон никотин хүргэх зориулалттай бүтээгдэхүүн худалдсан, нийлүүлсэн, үнэ төлбөргүй олгосон этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайхан үг хэлэв.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 72
Бүгд: 100
28.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

5.Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 7².3 дахь хэсгийг бүхэлд нь хасах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 44
Бүгд: 100
56.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасангийн гаргасан, Төслийн 3 дугаар 3.1.1 дэх заалтыг бүхэлд нь доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.1."тамхин болон никотин агуулсан бүтээгдэхүүн" гэж тамхины навч, тамхинаас гарган авсан никотин, нийлэг никотин эсхүл никотин агуулсан бусад бодисыг ашиглан хүний биед никотин хүргэх, эсхүл тамхи хэрэглэхтэй адил зориулалтаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг:

3.1.1.а."утаат тамхи" гэж үйлдвэрийн болон гар аргаар ороож бэлтгэсэн, татах зориулалттай янжуур, навчин тамхи, дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхийг;

3.1.1.б."халаадаг тамхи" гэж цахилгаан халаагч болон бусад арга, хэрэгслээр асаахгүйгээр сорж татах зориулалттай бүх төрлийн халаадаг тамхи;

3.1.1.в."электрон никотин дамжуулах систем" гэж никотин, никотин давс, амт, үнэр оруулагч болон бусад химийн бодис агуулсан, эсхүл агуулаагүй

шингэнийг цахилгаан хэрэгслээр ууршуулан татах, эсхүл түүнтэй адилтгах аргаар хэрэглэх зориулалттай электрон никотин дамжуулах системийг.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 43
Бүгд: 100
57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нарагийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 3.1.1 дэх заалтыг бүхэлд нь доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.1.“тамхин бүтээгдэхүүн” /цаашид “тамхи” гэх/ гэж тамхины навч, ургамлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн түүхий эд болгон үйлдвэрлэсэн болон нийлэг аргаар гаргаж авсан никотин, түүний уламжлал дагавар бодис, бохь, химийн бодис агуулсан, амт, үнэр оруулагч нэмсэн, эсхүл нэмээгүй, татах, үнэрлэх, сорох, зажлах, аманд уусгах, биед наах, эсхүл бусад аргаар, дагалдах хэрэгсэл бүхий төхөөрөмжийг ашиглаж болон ашиглахгүйгээр хэрэглэх зориулалттай, хууль тогтоомжид заасны дагуу эмийн бүртгэлд бүртгэгдсэн тамхинаас гаргах эмээс бусад дараах бүтээгдэхүүнийг:

3.1.1.а.тамхины түүхий эд, задгай тамхи, татаж хэрэглэх зориулалттай навчин, дүнсэн, шүүлтүүртэй, шүүлтүүргүй янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи;

3.1.1.б.цахилгаан халаагч болон бусад арга, хэрэгслээр асаахгүйгээр сорж татах зориулалттай бүх төрлийн халаадаг тамхи;

3.1.1.в.никотин, никотин давс, амт, үнэр оруулагч болон бусад химийн бодис агуулсан, эсхүл агуулаагүй шингэнийг цахилгаан хэрэгслээр ууршуулан татах, эсхүл түүнтэй адилтгах аргаар хэрэглэх зориулалттай электрон тамхи.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 37
Бүгд: 100
63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.11.“тамхи татах зөвшөөрөгдсөн цэг” гэж энэ хуулийн 3.1.1.а-д заасан бүтээгдэхүүн хэрэглэх цэг болон энэ хуулийн 3.1.1.б болон 3.1.1.в-д заасан бүтээгдэхүүнийг хэрэглэх цэгээс бүрдэх бөгөөд эдгээрийг тусад нь, эсхүл хооронд нь тусгаарлан зохион байгуулсан, тамхи хэрэглэх зориулалтаар тусгайлан бэлтгэсэн талбай, агааржуулалтын тоног төхөөрөмжөөр тоноглогдсон өрөөг.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58

Татгалзсан: 42
Бүгд: 100
58.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтыг хасах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48
Татгалзсан: 52
Бүгд: 100
48.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.5 дахь заалтын 5 дугаар зүйлийн 5.5.1 дэх заалтыг хасах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 40
Бүгд: 100
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалтын 5 дугаар зүйлийн 5.8.4 дэх заалтын “барилга байгууламж” гэсний дараа “тус бүр” гэж нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 39
Бүгд: 100
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалтын 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.4.1.зурагт анхааруулга нь тамхи, тамхин бүтээгдэхүүний техникийн зохицуулалтад нийцсэн байх.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 44
Бүгд: 100
56.0 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасангийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалтын 6 дугаар зүйлийн 6.7.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.7.2.энэ хуулийн 3.1.1.а, 3.1.1.б-д заасан тамхийг нэг хайрцагт 20 ширхгээс цөөн тоогоор, эсхүл дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхийг 200

граммаас багаар савлах, энэ хуулийн 3.1.1.в-д заасан электрон никотин дамжуулах системийн шингэний хэмжээг 10 миллилитрээс ихээр савлах, шингэн дэх никотины агууламж 30 миллиграмм/миллилитрээс их байх;" гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	56
Татгалзсан:	44
Бүгд:	100

56.0 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалтын 6.4.1 дэх заалтыг доор дурдсанаас өөрчлөн найруулах:

“6.4.1.тамхин бүтээгдэхүүний хэрэглэгчийн савлагаа (хайрцаг)-ны нүүрэн талын доод хэсгийн үндсэн гадаргуугийн дор хаяж 70 хувийг, мөн ар талын доод хэсгийн үндсэн гадаргуугийн дор хаяж 70 хувийг эзэлсэн, тамхин бүтээгдэхүүн хэрэглэхээс үүдэлтэй өвчлөлийн үр дагаврыг дүрсэлсэн зураг болон эрүүл мэндийн анхааруулга бүхий бичвэр байрлуулсан байх ёстой. Тамхин бүтээгдэхүүний савлагаан дээрх анхааруулгын бичвэр, дүрслэлийг байрлуулах шаардлагыг холбогдох техникийн зохицуулалтаар тодорхойлно.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	61
Татгалзсан:	39
Бүгд:	100

61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасангийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг хасах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	56
Татгалзсан:	44
Бүгд:	100

56.0 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарын гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Энэхүү хууль 202_ оны сарын-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилнэ. Харин 6.4.1, 6.7.16. дэх заалт нь энэхүү хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 24 сарын дараа хэрэгжинэ.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	61
Татгалзсан:	39
Бүгд:	100

61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал:

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 35
Бүгд: 100
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал:

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 38
Бүгд: 100
62.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Нэг.Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Онцгой албан татварын тухай хууль доор дурдсан агуулгатай хэсэг заалт нэмсүгэй.

1/5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 8, 9 дэх заалт:

8.	Электрон тамхины шингэн	1 миллилитр
9.	Аманд уусгах, зажлах зориулалттай тамхи	1 грамм

2/6.1².энэ хуулийн 4.1.2-т заасан барааны тогтоосон биет нэгжид дараах хэмжээгээр онцгой албан татвар ногдуулна:

д/д	Онцгой албан татвар ногдуулах барааны нэр, төрөл	Биет хэмжээ	Ногдуулах онцгой албан татварын хэмжээ /төгрөгөөр/					
			2026 он	2027 он	2028 он	2029 он	2030 он	2031 он

1	Татаж хэрэглэх зориулалттай навчин, сигар, янжуур тамхи, тэдгээртэй адилтгах бусад тамхи	20 ширхэг	836	2,000	3,500	5,000	6,000	8,000
2	Халаадаг тамхи	20 ширхэг	836	1500	2625	3750	4875	6000
3	Дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхи, усан хоолойгоор татах зориулалттай тамхи	200 грамм	626	1500	2625	3750	4875	6000
4	Электрон тамхины шингэн	1 миллилитр	0	750	1312.5	1875	2437.5	3000
5	Аманд уусах, зажлах зориулалттай тамхи	1 грамм	0	125	220	315	410	500

гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 38
Бүгд: 100
62.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “, халаадаг, шүүлтүүртэй, шүүлтүүргүй янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи” гэснийг “болон янжуур тамхи, тэдгээртэй адилтгах бусад тамхи, халаадаг тамхи” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 42
Бүгд: 100
58.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй санал:

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, Л.Энхнасан нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:
“1/5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг:

д/д	Онцгой албан татвар ногдуулах барааны нэр, төрөл	Онцгой албан татвар ногдуулах биет нэгж
1	Бүх төрлийн тамхины шингэн	10 миллилитр
2	Татаж хэрэглэх зориулалттай навчин, шүүлтүүртэй, шүүлтүүргүй янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи	100 ширхэг
3	Халаадаг тамхин бүтээгдэхүүн	100 ширхэг

4	Ууталсан никотин	1 килограмм
---	------------------	-------------

2/6.1.энэ хуулийн 4.1.2-т заасан барааны тогтоосон биет нэгжид дараах хэмжээгээр онцгой албан татвар ноогдуулна:

д/д	Онцгой албан татвар ногдуулах барааны нэр, төрөл	Биет нэгж	Ногдуулах онцгой албан татварын хэмжээ /төгрөгөөр/					
			одоо	2026 он	2027 он	2028 он	2029 он	2030 он
1	Татаж хэрэглэх зориулалттай навчин, шүүлтүүртэй, шүүлтүүргүй янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи	100 ширхэг	4,180	6,270	6,897	7,587	8,345	9,180
2	Халаадаг тамхин бүтээгдэхүүнийг тусад нь оруулах саналтай байна: Халаадаг тамхин бүтээгдэхүүн	100 ширхэг	0	3,135	3,449	3,793	4,173	4,590
3	Дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхи	200 грамм	626	939	1,033	1,136	1,250	1,375
4	Бүх төрлийн тамхины шингэн	10 миллилитр	0	3,135	3,449	3,793	4,173	4,590
5	Электрон тамхи төхөөрөмжийн хамт	10 миллилитр	0	3,135	3,449	3,793	4,173	4,590
6	Ууталсан никотинд	1 килограмм		20,900	29,275	35,125	42,150	46,365

гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 40
Бүгд: 100
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасангийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Онцгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн хүснэгтийн 2 дахь мөрийн “Янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи” гэснийг “Татаж хэрэглэх зориулалттай навчин шүүлтүүртэй, шүүлтүүргүй янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи” гэж, “20 ширхэг” гэснийг “100 ширхэг”, мөн

хэсэг дэх хүснэгтийн 3 дахь мөрийн “1 килограмм” гэснийг “200 грамм” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	58
Татгалзсан:	42
Бүгд:	100

58.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Тав.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаар:

Нэг.Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 6.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтын “хоёр зуун” гэснийг “гурван зуун” гэж, мөн заалтын “хоёр мянган” гэснийг “гурван мянган” гэж тус тус өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	58
Татгалзсан:	42
Бүгд:	100

58.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зургаа.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй санал:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	60
Татгалзсан:	40
Бүгд:	100

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Долоо.“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ тогтоох тухай тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Нэг.Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал:

С.Бямбацогт: Төслийн 1 дэх заалтыг бүхэлд нь доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтад доор дурдсан агуулгатай дараах зүйл нэмсүгэй:

1/24 дүгээр бүлгийн 24.04 дүгээр зүйл:

24	24.04		Тамхи, дахин боловсруулах тамхи, никотин агуулсан эсвэл тамхи, никотин орлуулагч агуулсан, шатаахгүйгээр сорж татах зориулалттай бүтээгдэхүүн; хүний биед никотин өгөх зориулалттай, никотин агуулсан бусад бүтээгдэхүүн	30
			Шатаахгүйгээр сорж татах зориулалттай бүтээгдэхүүн;	
		2404.11	Тамхи эсвэл дахин боловсруулсан тамхи агуулсан:	0

2/85 дугаар бүлгийн 85.43 дугаар зүйл:

85	85.43		Энэ бүлгийн бусд газар заагдаагүй ганцаарчилсан зориулалтын цахилгаан машин болон аппарат.	
		8543.40.10	Олон удаагийн хэрэглээний электрон тамхи	30
		8543.40.20	Цахилгаанаар ажилладаг ууршуулж татах төхөөрөмж	30
			Эд анги:	
		8543.90.10	Электрон тамхи болон түүнтэй төстэй цахилгаанаар ажилладаг ууршуулж татах төхөөрөмжийн	30
		8543.90.90	Бусад	30

3/96. Дугаар бүлгийн 96.14 дүгээр зүйл:

96	96.14	9614.00.00	Тамхины гаанс /гаансны толгой орно/ болон сигар, янжуур тамхины соруул, тэдгээрийн ад анги	30
----	-------	------------	--	----

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн үг хэлж, хуралдаан даргалагч гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн үг хэлж, хуралдаан даргалагч гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

Хоёр.Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй санал:

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нарагийн гаргасан, Төслийн 1 дэх заалтыг бүхэлд нь доор дурдсан өөрчлөн найруулах:

“1. “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтын 24, 85, 96 дугаар бүлэгт доор дурдсан агуулгатай 24.04, 85.43, 96.14 дүгээр зүйл тус тус нэмсүгэй:

24	24.01		Түүхий тамхи; тамхины хаягдал.	30
	24.02		Тамхи эсвэл тамхи орлуулагч агуулсан сигар, үзүүрийг нь тайрсан сигар /cheroots/ болон нарийн ороосон сигар /сигарилл/ болон янжуур.	0
	24.03		Боловсруулсан бусад тамхи болон тамхи орлуулагч; “нэсэгн төрлийн болгосон” буюу “салбэгдсэн” тамхи; тамхины ханд болон охь.	0
	24.04		Тамхи, дахин боловсруулсан тамхи, никотин агуулсан эсвэл тамхи, никотин орлуулагч агуулсан, асаахгүйгээр сорж татах зориулалттай бүтээгдэхүүн; хүний биед никотин өгөх зориулалттай, никотин агуулсан бусад бүтээгдэхүүн.	5
		2404.11	Тамхи эсвэл дахин боловсруулсан тамхи агуулсан:	5
		2404.11.10	Цахилгаан халаагч хэрэгслээр татах тамхи /ЕНТР/	5
		2024.12	Никотин агуулсан бусад: -нэг удаагийн электрон тамхи -цэнэглэгч шингэн	5
		2404.91	Амаар хэрэглэх зориулалттай	5

гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 42
Бүгд: 100
58.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2. Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын хүснэгтийн 85 дугаар бүлгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

85	85.43	8543.40.00	Электрон тамхи болон татах хэрэгсэл, эд анги: -Электрон тамхины хэрэгсэл шингэний хамт -Бусад.	30 30
		8543.90.00	Дагалдах хэрэгсэл, эд анги	30

гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 41
Бүгд: 100
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Найм.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар:

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, 1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.2026 оны ... дугаар сарын ...-ны өдрийн Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд:

1.1.Тамхины хяналтын тухай хуулиар стандарт, хэм хэмжээний акт батлах эрх олгосон Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллагууд, Стандартчиллын төв байгууллага тус хуульд нийцүүлэн холбогдох дүрэм, журам, стандарт, загварыг Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө шинэчлэн баталж, мөрдүүлнэ.

1.2.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд заасан тамхин бүтээгдэхүүн, түүний орц найрлагыг таних, шалгах зориулалтын лабораторийн тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

1.3.Тамхины хамаарлаас гаргах эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах төлөвлөгөөг Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө боловсруулж, эмчилгээ үйлчилгээг хэвийн явуулах, хуулийн хэрэгжилтийг хангана.

1.4.Тамхи үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн талаарх Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд заасан мэдээллийн нэгдсэн санг бий болгох, уг мэдээллийн санг холбогдох бусад мэдээллийн сантай мэдээлэл солилцдог байх чиглэлд төрийн байгууллагууд хамтран ажиллана.

1.5.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө мөн хуулиар тамхин бүтээгдэхүүнд тооцсон шинэ төрлийн тамхийг Тамхины хяналтын тухай хуулиар хориглосон байдлаар сурталчилсан зар сурталчилгааг хуульд нийцүүлэх арга хэмжээ авах, тамхи үйлдвэрлэх, импортлох, худалдаалахад зүй ёсны монопол болон давамгайл байдалтай аж ахуй эрхлэгч байгаа эсэхийг тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 46
Бүгд: 100
54.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2, 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 45
Бүгд: 100
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дуусав.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 20 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгасан санал:

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтыг, 4.1.3 дахь заалтыг “нэг ижил” гэснийг, 4.1.5 дахь заалтын “, болон сайн дурын санаачилгыг хэрэгжүүлэх” гэснийг, 4.1.12 дахь заалтын “Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн дагуу” гэснийг, 4.1.13 дахь заалтыг, 4.1.15 дахь заалтын “зорилгоор ашигладаг” гэснийг, 4.1.16 дахь заалтыг, 4.1.21 дэх заалтын “замаар уур амьсгалын өөрчлөлтийг сөрөг нөлөөллийг бууруулах бодлого,” гэснийг, 4.1.25, 4.1.27 дахь заалтыг, 4.1.30 дахь заалтын “Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн хүрээнд” гэснийг, мөн заалтын “тохируулга хийж” гэснийг тус тус хасаж, 4.1.3 дахь заалтын “шингээлт эсхүл” гэснийг “шингээх үйл ажиллагаанаас үүссэн” гэж, 4.1.4 дэх заалтын “тогтвортой” гэснийг “арга хэмжээ” гэж, 4.1.6 дахь заалтын “зах зээлийн тогтолцоо” гэснийг “зах зээлийг” гэж, 4.1.14 дэх заалтын “шингээсэн” гэснийг “Хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлсэн” гэж, 4.1.15 дахь заалтын “шаардлагаас” гэснийг “үүргээс” гэж, 4.1.28 дахь заалтын “нэмэр” гэснийг “нэмрийн зорилт” гэж тус тус өөрчилж, 4.1.6 дахь заалтын “худалдах” гэсний дараа “арилжих, дүйцүүлэх” гэж, 4.1.20 дахь заалтын “үйлдвэрлэл” гэсний дараа “үйлчилгээ” гэж, 4.1.28 дахь заалтын “зохицох” гэсний дараа “даван туулах” гэж, 4.1.30 дахь заалтын “нэмж” гэсний дараа “, эсхүл хасаж” гэж, 4.1.32 дахь заалтын “бусад хийг” гэсний өмнө “олон улсын гэрээ, стандартаар хүлэмжийн хий” гэж хүлээн зөвшөөрөгдсөн” гэж, 4.1.33 дахь заалтын “ой,” гэснийг гэсний дараа “бэлчээр,” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 41
Бүгд: 100
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул хуралдааны тэмдэглэлд саналаа дэмжсэнээр тэмдэглүүлэх санал гаргаж, 60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 4.1.7, 4.1.8, 4.1.10, 4.1.11, 4.1.18, 4.1.19, 4.1.22, 4.1.24, 4.1.26, 4.1.31, 4.1.36, 4.1.37, 4.1.38, 4.1.39 дэх заалтыг доор дурдуулсан өөрчлөн найруулах:

“4.1.12.“даван туулах” гэж уур амьсгалын өөрчлөлт, аюултын үзэгдэл тулгарахад байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тогтолцоо, үндсэн чиг үүрэг, өвөрмөц чанар, бүтцээ хадгалан хариу үйлдэл үзүүлэх, сэргээн зохион байгуулагдах, дасан зохицох чадавхыг;

4.1.7.“карбон кредит” гэж эзэмших, ашиглах, захиран зарцуулах боломжтойгоор баталгаажсан, бүртгэгдсэн карбон нэгжийг;

4.1.8.“карбон нэгж” гэж сааруулалтын үр дүнг нэг тонн хүчилтөрөгчийн давхар ислийн тэнцэлд дүйцэх байдлаар илэрхийлсэн тооцоолол нэгжийг;

4.1.10.“ногоон таксономи” гэж байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн зорилтод хувь нэмэр оруулах эдийн засгийн үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтыг тодорхойлсон нэгдсэн шалгуур, ангиллыг;

4.1.11.“олон талт карбон зах зээл” гэж олон улсын гэрээ, шийдвэрийн хүрээнд төвлөрсөн зохицуулалтаар хэрэгжих, олон улсад хийж шилжүүлэн тооцох, сааруулалтын үр дүнг бий болгох, бүртгэх, шилжүүлэх, худалдах, арилжих, дүйцүүлэх, ашиглах үйл ажиллагааг зохицуулсан зах зээлийг;

4.1.18.“уур амьсгалын өөрчлөлт” гэж байгалийн хүчин зүйл, хүний үйл ажиллагааны улмаас дэлхийн агаар мандлын хийн бүрэлдэхүүн өөрчлөгдсөнөөс үүдэн уур амьсгалд урт хугацаанд гарч буй өөрчлөлтийг;

4.1.19.“уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртөмхий хүн амын бүлэг” гэж уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөлд өртөх эрсдэлтэй, нийгэм, эдийн засаг, эрүүл мэнд, газар зүйн байршлын улмаас түүнд дасан зохицох, даван туулах чадавх хязгаарлагдмал хүн амын бүлгийг;

4.1.22.“уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөл” гэж уур амьсгалын өөрчлөлтийн улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчин, нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаанд нөлөөл үзүүлэх сөрөг өөрчлөлтийг;

4.1.24.“уур амьсгалын санхүүжилт гэж” уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн олон улсын, үндэсний болон орон нутгийн түвшинд төр, хувийн хэвшил, бусад эх үүсвэрээс бүрдсэн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг;

4.1.26.“үндэсний карбон зах зээл” гэж үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хангах хүрээнд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ялгарлаас урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны үр дүнд үүссэн

карбон кредитийг бүртгэх, шилжүүлэх, худалдах, арилжих, дүйцүүлэх, ашиглах замаар зохицуулсан зах зээлийг;

4.1.31.“хоёр талт карбон зах зээл” гэж улс хоорондын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжих олон улсад шилжүүлэн тооцох сааруулалтын үр дүнг бий болгох, бүртгэх, шилжүүлэх, худалдах, арилжих, дүйцүүлэх ашиглах үйл ажиллагааг зохицуулсан зах зээлийг;

4.1.36.“хүлэмжийн хий ялгарлаас урьдчилан сэргийлэх” гэж тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх тохиолдолд үүсэх байсан хүлэмжийн хий ялгарлаас зайлсхийх чиглэсэн үйл ажиллагаа;

4.1.37.“хүлэмжийн хий ялгарлыг бууруулах” гэж хүлэмжийн хий ялгарлын хэмжээг багасгахад чиглэсэн үйл ажиллагааг;

4.1.38.“хүлэмжийн хий ялгарлын тэнцэл” гэж тайлант хугацаанд үүссэн хүлэмжийн хийн нийт ялгаралтаас бууруулалт, урьдчилан сэргийлсэн ялгарал болон шингээлтийг хасан гарах цэвэр дүнг;

4.1.39.“хэмжилт, тайлагнал, баталгаажуулалт” гэж хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны үр дүнг баталсан аргачлалын дагуу хэмжих, үр дүнг тайлагнах, тайлагнасан мэдээллийг хөндлөнгийн итгэмжлэгдсэн этгээдэд шалгуулан баталгаажих үйл ажиллагааг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	59
Татгалзсан:	41
Бүгд:	100

59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.1.5 дахь заалтын “хөтөлбөрийг тодорхойлсон” гэснийг “хөтөлбөрт зориулсан” гэж, 7.1.9 дэх заалтын “санхүүжилтийн орлогын урсгалыг” гэснийг “санхүүжилтийг” гэж, 7.1.10 дахь заалтын “үйл ажиллагааг удирдах, зохицуулах” гэснийг “ажиллагааны” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 7.1.3 дахь заалтын “энэ хуульд заасан асуудлаар” гэснийг, 7.1.8 дахь заалтын “хүлэмжийн хий ялгарлын бууралт, шингээлтийн үр дүнг тооцох, баталгаажуулах, тайлагналтай холбоотой” гэснийг, 7.1.9 дэх заалтын “ногоон болон уур амьсгалын санхүүжилтийн орлогын урсгал, үр ашиг, зарцуулалтыг бүртгэх, хянах, тайлагнах, цаашдын төлөвлөлтийг хангах, олон улсын тайлагнал болон ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбоотой” гэснийг, 7.1.10 дахь заалтын “энэ хуулийн 4.1.27-д заасан” гэснийг, 7.1.11 дэх заалтын “бүрэн эрх” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн 7.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 7.1,1, 7.1.2 дахь заалт заалт болгох:

“7.1.1.уур амьсгалын өөрчлөлтийн төлөвлөлт, хэрэгжилтийн салбар хоорондын уялдааг хангах зорилгоор Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний үндэсний хороог байгуулж, ажиллуулах;

7.1.2.Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний хорооны санал, зөвлөмжийг үндэслэн Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт, Уур амьсгалын

өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөгөөг батлах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	59
Татгалзсан:	41
Бүгд:	100

59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.7 дахь заалтын “уур амьсгалын” гэсний дараа “өөрчлөлтийн” гэж нэмж, мөн зүйлийн 11.1 дэх хэсгийн “байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүргийн хүрээнд” гэснийг “ус цаг уур, орчны шинжилгээний асуудал эрхэлсэн” гэж, 11.1.2 дахь заалтын “нэмэр” гэснийг “нэмрийн зорилт” гэж, мөн заалтын “хариуцан зохих байгууллагад” гэснийг “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулахаар” гэж, 11.1.3 дахь заалтын “удирдах” гэснийг “удирдлага, зохион байгуулалтыг хангах” гэж тус тус өөрчилж, 11.1.6 дахь заалтын “Парисын хэлэлцээрийн шаардлагад нийцүүлэн” гэснийг, 11.1.10 дахь заалтын “бүрэн эрх” гэснийг тус тус хасаж, 11.1.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.9.сааруулалтын үр дүнгийн урт хугацааны хадгалалт алдагдах, хэтрүүлэн тооцож шилжүүлэх, байгалийн болон бусад хүчин зүйлээс шалтгаалан буцаан алдагдах эрсдэлийг бууруулах зорилгоор төсөл, хөтөлбөрөөс үүссэн баталгаажсан сааруулалтын үр дүнгийн тодорхой хувийг эрсдэлийн санд нөөцлөн, энэ хуулийн 7.1.7-д заасан журмын дагуу буцаан олгох, удирдлага хяналтыг хэрэгжүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	61
Татгалзсан:	39
Бүгд:	100

61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх тохиолдолд холбогдох хуульд заасан хүлэмжийн хийн бууруулах арга хэмжээг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгана.” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	61
Татгалзсан:	39
Бүгд:	100

61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 16.1, 16.4, 16.6 дахь хэсгийг дор дороос өөрчлөн найруулах:

“16.1.Үндэсний зохицуулагч байгууллага энэ хуулийн 12.1, 12.2-т заасан үнэлгээний үр дүнд үндэслэн Үндэсний дасан зохицох төлөвлөгөөг Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтод нийцүүлэн тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулна.

16.4.Холбогдох төрийн захиргааны төв байгууллага, аймаг нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 4.1.19, 4.1.20-д заасан уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртөмтгий салбар, хүн амын бүлгийн дасан зохицох, даван туулах чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

16.6.Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг, ойлголтыг бүх шатны боловсролын түвшинд эзэмшүүлэх, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, хандлага, оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	60
Татгалзсан:	40
Бүгд:	100

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дуусав.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 21 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан/-ийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: Байнгын хорооноос Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	60
Татгалзсан:	40
Бүгд:	100

69.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 21 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Арван долоо.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, мөн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Геологийн бодлогын газрын дарга Х.Санчигдорж, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга П.Баянбаатар, мөн газрын Хайгуул ашиглалтын газрын дарга С.Ган-Очир, Кадастрын хэлтсийн дарга М.Энхтулга, Үндэсний геологийн албаны дарга Н.Мөнхбилэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Т.Билэг-Өрнөх нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Д.Энхтүвшин, Х.Баасанжаргал, Э.Болормаа, М.Бадамсүрэн, Г.Ганбаатар нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Б.Жавхлан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Үндэсний геологийн албаны дарга Н.Мөнхбилэг нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./22:09/

Арван найм.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж нарын 36 гишүүн 2026.06.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Боловсролын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Бадамжав, мөн яамны Ерөнхий боловсролын бодлогын газрын дарга Л.Ганбат, мөн газрын ахлах шинжээч А.Цолмон нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх А.Болортуяа, референт Н.Монголмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Сарнай нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Х.Баасанжаргал, Б.Бейсен, Д.Ганбат нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж, Г.Уянгахишиг, Боловсролын яамны Ерөнхий боловсролын бодлогын газрын дарга Л.Ганбат нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./23:00/

Арван ес.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан нэр дэвшигч Ж.Сүхбаатар, Г.Эрдэнэбат нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан нар байлцав.

Анх нэр дэвшүүлсэн Улсын Их Хурлын саналыг Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт, Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд нар танилцуулав.

Нэр дэвшигчдээс болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Д.Энхтүвшин, Х.Баасанжаргал, А.Ариунзаяа, Д.Ганбат, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад нэр дэвшигч Ж.Сүхбаатар, Г.Эрдэнэбат нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./24:00/

Бусад.Ховд аймгийн ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 1981 оны төгсөгчид, Хэнтий аймгийн Баян-Адарга сумын ерөнхий боловсролын сургуулийн 1981 оны төгсөгчид, Өмнөговь аймгийн Даланзадгад сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүүгийн урилгаар Чингэлтэй дүүргийн 8, 16, 17, 21 дүгээр хорооны иргэдийн төлөөлөл, Завхан аймгийн Тэс сумын ерөнхий боловсролын сургуулийн 2001 оны төгсөгчид, Дундговь аймгийн Сүмбэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 1986 оны 10^а, 10^б, 10^в, 10^г ангийн төгсөгчид, Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнийн урилгаар Булган аймгийн Дашинчилэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2006 оны төгсөгчид, Увс аймгийн ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2006 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, Г.Хосбаяр нарын урилгаар Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн

1981 оны 10^а, 10^б, 10^в, 10^г ангийн төгсөгчид, нийслэлийн ерөнхий боловсролын 72 дугаар сургуулийн 1996 оны төгсөгчид, Улсын Багшийн дээд сургуулийн Физик, математикийн ангийн 1986 оны төгсөгчид, Өвөрхангай аймгийн шинэ зууны залуучууд уулзалтад оролцогчид, Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн урилгаар Бүгд Найрамдах Солонгос Улсын Мирал зүрхний сангийн төлөөлөгчид, Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нарагийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын “Голомт” цогцолбор сургуулийн 7, 9 дүгээр ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын урилгаар Хөвсгөл аймгийн Галт сумын ерөнхий боловсролын сургуулийн 1986 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын урилгаар Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын Сэтгэл зүйн тэнхим төслийн хүрээнд ажиллаж байгаа Минжи их сургуулийн багш, оюутнууд, Өмнөговь аймгийн Баяндалай сумын ерөнхий боловсролын 8 жилийн сургуулийн 1981 оны төгсөгчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 19 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 13 цаг 23 минут үргэлжилж, 126 гишүүнээс 101 гишүүн хүрэлцэн ирж, 80.2 хувийн ирцтэйгээр 24 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.БЯМБАДУЛАМ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2026 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 00 минут.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Бямбацогт: Их Хурлын гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая. 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 70 гишүүн буюу 55.6 хувийн ирцтэйгээр ирц хүрсэн учраас чуулганы нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Гишүүддээ мэдээлэл өгье. 7 хоногийн тов дараалалд тусгагдсан хэлэлцэх асуудлын тухай.

1.Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч томилох тухай асуудал Эдийн засгийн байнгын хорооны 06 дугаар сарын 24-ны өдрийн хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэхийг хойшлуулсан тул нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлаас хасагдсан.

2.“Эрчим хүчний салбарын тогтвортой байдал, хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл Эдийн засгийн байнгын хорооны 06 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны явцад Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд, Уянгахишиг, Батчимэг нарын гаргасан горимын санал дэмжигдэж, хойшлуулсан тул нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлаас хасагдсан.

3.“Эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалах, үнийн өсөлтийг бууруулах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл Эдийн засгийн байнгын хорооны 06 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны явцад тогтоолын төслийг хэлэлцэхийг хойшлуулсан тул нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлаас хасагдсан.

4.Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан анхны хэлэлцүүлэг хийх ёстой байсан. Эдийн засгийн байнгын хорооны 06 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны явцад хуулийн төслийг хэлэлцэх асуудлаас хассан тул нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлаас хасагдсан.

5.Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал Төрийн байгуулалтын байнгын хорооны 06 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэхийг хойшлуулсан тул нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлаас хасагдсан.

7.Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд;

8.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

9.Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Энхтүвшин, Тэмүүжин, Баасанжаргал нарын гишүүд өргөн мэдүүлсэн. Төрийн байгуулалтын байнгын хорооны 06 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаас хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хойшлуулсан тул нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлаас хасагдсан.

Төрсөн өдөр нь тохиож буй гишүүдийн тухай. 06 дугаар сарын 25-нд Улсын Их Хурлын гишүүн Өлзийхүүгийн Шижир төрсөн байна. Улсын Их Хурлын гишүүн Өлзийхүүгийн Шижирт төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний илч болсон танд болон таны гэр бүлд Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэе.

Чуулганы нэгдсэн хуралдааны ирцийг та олон нийтэд ил тод, нээлттэй, шууд мэдээлдэг болсон байгаа. Өнөөдрийн хуралдааны ирцэд эхэнд бүртгүүлсэн 5 гишүүнийг танилцуулъя. Наранцэцэгийн Алтаншагай, Бөхчулууны Пүрэвдорж, Нацагдоржийн Батсүмбэрэл, Хажыкберийн Жангабыл, Сүхбаатарын Эрдэнэболд нар өглөө чуулганы хуралдаандаа хамгийн эртэч гишүүн болж хүрэлцэн иржээ.

Өчигдөр Эдийн засгийн байнгын хороо өдрийн 14 цагаас шөнийн 24 цаг өнгөртөл 10 гаруй цаг хуралдсан. Эдийн засгийн байнгын хорооны шөнийн 24 цаг өнгөртөл хуралдсан гишүүддээ баяр хүргэе. Мөн Хууль зүйн байнгын хороо бас орой 17 цаг өнгөрч эхлээд 24 цаг хүртэл хуралдсан. 8 цаг гаруй, 9 цаг орчим хуралдсан Хууль зүйн байнгын хорооныхоо гишүүддээ бас ажил хэрэгчээр хандсан гишүүддээ баяр хүргэе.

Зочин танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлутын урилгаар Хөвсгөл аймгийн Галт сумын ерөнхий боловсролын сургуулийн 1986 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа, төгсөлтийнхөө 40 жилийн ойн баярыг тэмдэглэж байгаа та бүхэнд Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Дараах 19 асуудлыг хэлэлцэнэ.

1.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг үргэлжилнэ. Улсын Их Хурлын гишүүн Ганмаа нарын 46 гишүүн өргөн мэдүүлсэн байгаа.

2.Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг үргэлжилнэ. Засгийн газар 2026.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн.

3.Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг үргэлжилнэ. Засгийн газар 2026.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх

4.Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг үргэлжилнэ. Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл нарын 18 гишүүн 2026.04.14-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

5.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна. Засгийн газар 2026.06.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх

6.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

7.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

8.“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. /Газар зүйн нэрийн жагсаалт батлах тухай тогтоол байгаа./

9.Бизнесийн эрх чөлөөний тухай, Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл нарын 3 гишүүн өргөн мэдүүлсэн. Нэгтгэсэн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Зарчмын зөрүүтэй 189 саналтай шүү гишүүд ээ.

10.Орон сууцжуулалтын хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна. Засгийн газар 2026.06.11-ний өдөр өргөн мэдүүлсэн.

11.Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэхийг явуулна.

12.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ. Улсын Их Хурлын гишүүн Түвшин нарын 41 гишүүн өргөн мэдүүлсэн.

13.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна.

14.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулна.

15.Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг явуулна.

16.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

17.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

18.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

19.Бусад асуудлын хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д “Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчдаас Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ.” гэж заасан. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

Асрах үйлчилгээний тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Доржзовдын Энхтуяа нарын 64 гишүүн 2026.06.22-ны өдөр өргөн мэдүүлснийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд хуваарилсан.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна.

Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлтгэнэ үү. Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. Гишүүд суудлаа эзэлнэ үү. Ирц бүртгэлийн санал хураалт.

Зочин танилцуулъя. Ховд аймгийн ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 1981 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа эрхэм зочдод Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Гишүүд санал хураалтдаа бэлтгэсэн байна. Сая татгалзан гарч байгаа гишүүдийг бас чуулганы танхимдаа хүрэлцэн ирж, санал хураалтад оролцохыг урьж байна. Их Хурлын гишүүдийн зөвлөх, туслахууд, бүлгийн ажлын алба, Улсын Их Хурлын Хуралдаан зохион байгуулах газар гишүүдийг, татгалзан гарч байгаа гишүүдийг бас чуулганы танхимдаа хүрэлцэн ирэх ажлыг зохион байгуулна уу. Санал хураалт явуулъя.

1.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 81 гишүүн оролцсоноос 54 гишүүн буюу 66 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн 5 хуулийн төсөл байгаа.

2.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 82 гишүүн оролцсоноос 57 гишүүн буюу 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 82 гишүүнээс 55 буюу 67 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 83-аас 58 буюу 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 83-аас 55 буюу 66 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 83-аас 58 буюу 69 хувийн санал дэмжигдлээ.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

Дараагийн асуудалдаа оръё.

Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримттай холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдье. Санал хураалт явуулъя.

Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 83-аас 57 буюу 68 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн 45 хуулийн төсөл байгаа.

2.Төрийн нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 83-аас 63-ын буюу 75 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 83-аас 62 буюу 74 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 83-аас 58 буюу 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Байгууллагын нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 83-аас 58 буюу 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 83-аас 61 буюу 73 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 83-аас 61 буюу 73 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 83-аас 57 буюу 68 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 83-аас 58 буюу 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Засгийн газрын хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 84-өөс 59 буюу 70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 84-өөс 58 буюу 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 84-өөс 59 буюу 70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 84-өөс 58 буюу 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Зөрчлийн шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 85-аас 65 буюу 76 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлал баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 85-аас 63 буюу 74 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Инновацын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 85-аас 65 буюу 76 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 85-аас 65 буюу 76 хувиар санал дэмжигдлээ.

Зочин танилцуулъя. Хэнтий аймгийн Баян-Адарга сумын ерөнхий боловсролын сургуулийн 1981 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа, төгсөлтийнхөө ойг тэмдэглэж байгаа та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

18.Кибер аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 85-аас 63 буюу 74 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 85-аас 61 буюу 71 хувийн саналаар санал дэмжигдлээ.

20.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 85-аас 67 буюу 78 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 85-аас 66 хувийн 77 хувийн саналаар санал дэмжигдлээ.

22.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 85-аас 65 буюу 76 хувийн саналаар санал дэмжигдлээ.

23.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 85-аас 63 буюу 74 хувийн саналаар санал дэмжигдлээ.

24.Орон нутгийн хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 85-аас 61 буюу 71 хувийн саналаар санал дэмжигдлээ.

25.Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 85-аас 63 буюу 74 хувийн саналаар санал дэмжигдлээ.

26.Патентын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 85-аас 61 буюу 71 хувийн саналаар санал дэмжигдлээ.

27.Тагнуулын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 85-аас 59 хувийн 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

28.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 85-аас 61 буюу 71 хувийн саналаар санал дэмжигдлээ.

29.Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. 85-аас 64 буюу 75 хувийн саналаар санал дэмжигдлээ.

30.Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 85-аас 63 буюу 74 хувийн саналаар санал дэмжигдлээ.

31.Төрийн бус байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 85-аас 60 буюу 70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

32.Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 85-аас 63 буюу 74 хувийн саналаар санал дэмжигдлээ.

33.Улсын бүртгэлийн ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 85-аас 64 буюу 75 хувийн саналаар санал дэмжигдлээ.

34.Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. 86-аас 61 буюу 70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

35.Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 87-оос 65 буюу 74 хувийн саналаар санал дэмжигдлээ.

36.Хувиргасан амьд организмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 87-оос 63 буюу 72 хувийн саналаар санал дэмжигдлээ.

37.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 87-оос 64 буюу 73 хувийн саналаар санал дэмжигдлээ.

38.Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 87-оос 67 буюу 77 хувийн саналаар санал дэмжигдлээ.

39.Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 87-оос 67 буюу 77 хувийн саналаар санал дэмжигдлээ.

40.Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд төслийг хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын

томъёоллоор санал хураалт явуулъя. 87-оос 66 буюу 75 хувийн саналаар санал дэмжигдлээ.

41.Шүүх шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 87-оос 65 буюу 74 саналаар санал дэмжигдлээ.

42.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 87-оос 63 буюу 72 хувийн саналаар санал дэмжигдлээ.

43.Эд хөрөнгийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 87-оос 66 буюу 75 хувийн саналаар санал дэмжигдлээ.

44.Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 87-оос 68 буюу 78 хувийн саналаар санал дэмжигдлээ.

45.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 87-оос 68 буюу 78- хувиар санал дэмжигдлээ.

46.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 87-оос 66 буюу 75 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төрийн нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

10.33 цаг.

Зочин танилцуулъя.

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа төрийн албан хаагч та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Дараагийн асуудалдаа оръё.

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг үргэлжлүүлнэ.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Санал хураалт явуулъя.

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалтад 87 гишүүн орсноос 60 гишүүн буюу 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

10.35 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Төрийн нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ.

Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл нарын гишүүд санаачилсан хууль байгаа.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Төрийн нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт явуулъя.

Төрийн нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 87 гишүүн орсноос 58 гишүүн буюу 66 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн 46 хуулийн төсөл байгаа.

1.Төрийн болон албаны нууцын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 87 гишүүнээс 61 буюу 70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 87-оос 62 буюу 71 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 87-оос 62 буюу 71 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 88-аас 64 буюу 72 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Байгууллагын нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 88-аас 62 буюу 70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 88-аас 61 буюу 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 88-аас 60 буюу 68 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 88-аас 63 буюу 71 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 88-аас 61 буюу 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 88-аас 61 буюу 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 88-аас 60 буюу 68 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 88-аас 61 буюу 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 88-аас 60 буюу 68 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 88-аас 57 буюу 64 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 88-аас 63 буюу 71 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Инновацын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. 89-өөс 59 буюу 66 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулна. 89-өөс 62 буюу 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Кибер аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 89-өөс 63 буюу 70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 89-өөс 63 буюу 70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

20.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 89-өөс 63 буюу 70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 89-өөс 63 буюу 70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

22.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 89-өөс 63 буюу 70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

23.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 89-өөс 60 буюу 67 хувийн саналаар санал дэмжигдлээ.

24.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 89-өөс 59 хувийн 66 хувийн саналаар санал дэмжигдлээ.

25.Орон нутгийн хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 89-өөс 62 буюу 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

26.Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналыг томьёоллоор санал хураалт явуулна. 89-өөс 58 буюу 65 хувийн саналаар санал дэмжигдлээ.

27.Патентын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 89-өөс 60 буюу 67 хувийн саналаар санал дэмжигдлээ.

28.Тагнуулын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 89-өөс 59 буюу 66 хувийн саналаар санал дэмжигдлээ.

29.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 90-өөс 60 буюу 66 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүүгийн урилгаар Чингэлтэй дүүргийн 8, 16, 17, 21 дүгээр хорооны иргэд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа иргэд та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

30.Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 90-өөс 60 буюу 66 хувийн саналаар санал дэмжигдлээ.

31.Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 90-өөс 61 буюу 67 хувийн саналаар санал дэмжигдлээ.

32.Төрийн бус байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлал хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 90-ээс 62 буюу 68 хувийн саналаар санал дэмжигдлээ.

33.Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын

томьёоллоор санал хураалт явуулъя. 90-ээс 58 буюу 64 хувийн саналаар санал дэмжигдлээ.

34.Улсын бүртгэлийн ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя 90-өөс 60 буюу 66 хувийн саналаар санал дэмжигдлээ.

35.Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя 90-өөс 63 буюу 70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

36.Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 90-өөс 61 буюу 67 хувийн саналаар санал дэмжигдлээ.

37.Хувиргасан амьд организмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 90-өөс 64 буюу 71 хувийн саналаар санал дэмжигдлээ.

38.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг төсөл үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 90-өөс 63 буюу 70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

39.Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 90-өөс 59 буюу 65 хувийн саналаар санал дэмжигдлээ.

40.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя 90-өөс 56 буюу 62 хувийн саналаар санал дэмжигдлээ.

41.Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. 90-өөс 65 буюу 72 хувийн саналаар санал дэмжигдлээ.

42.Шүүх шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 90-өөс 60 буюу 66 хувийн саналаар санал дэмжигдлээ.

43.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 90-өөс 62 буюу 68 хувийн саналаар санал дэмжигдлээ.

44.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 90-өөс 64 буюу 71 хувийн саналаар санал дэмжигдлээ.

45.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 90-өөс 65 буюу 72 хувийн саналаар санал дэмжигдлээ.

46.Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 90-ээс 64 буюу 71 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төрийн нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхэд санал хураалтад гишүүд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлээ.

10.51 цаг.

Дараагийн асуудалдаа оръё. Гишүүд ээ, байж байгаарай. Энэ чинь үгтэй юм байна.

Дараагийн асуудалдаа оръё.

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулъя.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Жадамбын Энхбаяр танилцуулна. Индэрт урьж байна.

Ж.Энхбаяр: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд газрын тосны бүтээгдэхүүний импортын хараат байдлыг бууруулах, дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулахаар тусгасан болно.

Монгол Улс газрын тос боловсруулах үйлдвэрийг 2028 онд ашиглалтад оруулахаар төлөвлөж, түүхий тос дамжуулах хоолойн барилга, угсралтын ажил дуусах шатдаа орж байна.

Иймд газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах зорилгоор газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэх, хайгуул судалгааны ажлыг эрчимжүүлэх, шинэ орд илрүүлэх, баталгаат нөөцийг өсгөх зэрэг эрх зүйн болон хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх шаардлагатай байна. Сүүлийн жилүүдэд

бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулалт олборлолт тасралтгүй буурч байгаа бөгөөд Бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой хууль тогтоомжийн зөрчил, эрх зүйн тогтворгүй байдал үүнд хүчтэй нөлөөлж байна.

Иймд 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр батлагдсан Газрын тосны тухай хуулийн хүрээнд байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтэд үүсээд буй олон жилийн маргааны асуудлыг шийдвэрлэх, өмнө байгуулсан гэрээний тогтвортой байдлыг хангах, газрын тосны хөрөнгө оруулалт олборлолтыг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газраас Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдуулан боловсруулсан хуулийн төслийг нэн яаралтай горимоор хэлэлцүүлэхээр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төсөл батлагдсанаар 1991 оны Газрын тосны тухай хуулийн хүрээнд байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний тогтвортой байдлыг хангаж, гэрээнд заасан татвар, шимтгэл, нөөц ашигласны төлбөрийн зохицуулалтыг гэрээний дагуу хэрэгжүүлэх эрх зүйн үндэс бүрдэх юм.

Асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Баярлалаа.

С.Бямбацогт: Төслүүдийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Нацагдоржийн Батсүмбэрэл танилцуулна. Индэрт урьж байна.

Н.Батсүмбэрэл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 06 дугаар сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд газрын тосны бүтээгдэхүүн импортын хараат байдлыг бууруулах, дотоодын түүхий эдэд тулгуурлан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулах зорилтын хүрээнд газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдээр хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэх Бүтээгдэхүүн хуваах гэрээний хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын эрх зүйн тодорхойгүй байдлыг арилгах, өмнө байгуулсан гэрээний нөхцөлийг хамгаалах, үүссэн татвар, шимтгэлийн маргааныг шийдвэрлэх, нөөц ашигласны төлбөр, татварын шимтгэлийг тухайн бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан нөхцөлийн дагуу шийдвэрлэх эрх зүйн үндсийг бий болгох, хөрөнгө оруулагчдыг эрх зүйн үндсийг бууруулж, хайгуул, олборлолтын нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, шинэ орд газар илрүүлэх, баталгаат нөөцийг өсгөх эрх зүйн болон хөрөнгө оруулалтын ач холбогдолтой хэмээн үзэж Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, уг хуулийн төслийг дагалдуулан Газрын тухай тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Нийгмийн даатгалын

ерөнхий хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг боловсруулан яаралтай дэгээр хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлжээ.

Хууль санаачлагч нь хуулийн төсөл батлагдсанаар Бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх зүйн тогтвортой байдал хангагдах, газрын тосны салбарын хөрөнгө оруулалтын орчин сайжрах, хайгуул, олборлолтын үйл ажиллагаа эрчимжих, төр болон хөрөнгө оруулагч хоорондын маргаан буурах, газрын тос олборлолт тасалдах эрсдэл буурч, боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдээр хангах нөхцөл сайжрах зэрэг эерэг үр дүнтэй болно гэж үзжээ.

Хуулийн төслийг D-Parliament.mn цахим сайтад байршуулж, иргэд, олон нийтийн саналыг авсан байна.

Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд Газрын тосны Тосон уул 19 талбай яагаад газрын тосны нөөц ашигласны төлбөрт хамрагдахгүй байгаа, ялгаатай зохицуулалт хийх болсон талаар, Улсын Их Хурлын гишүүн Очирбат Засгийн газар болон хөрөнгө оруулагчдын хооронд үүссэн их хэмжээний татвар, шимтгэлийн маргаа улсын эдийн засаг болон төсөвт ямар нөлөө үзүүлэх, Засгийн газар эрх ашгаа хангалттай хамгаалж ажилласан эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Түүнчлэн Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Сэддорж хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд өмнө байгуулсан гэрээний алдаа, дутагдлаа дүгнэн хойшид шинэ гэрээ байгуулахдаа алдаа сургамжаа давтахгүй байхыг санууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасныг үндэслэн хуулийн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих санал хураалт явуулахад Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 60,9 хувь, Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг 60,9 хувь, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 60,9 хувь, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг 65,2 хувь, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 65,2 хувь, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг 65,2 хувийн саналаар хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Батсүмбэрэл гишүүнд баярлалаа. Зочин танилцуулъя.

Завхан аймгийн Тэс сумын ерөнхий боловсролын сургуулийн 2001 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төгсөлтийнхөө 25 жилийн ойг тэмдэглэж байгаа, Төрийн ордонтой танилцаж байгаа та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Жадамбын Энхбаяр Монгол Улсын Тэргүүн шадар сайд буюу Эдийн засаг, хөгжлийн сайд, Гонгорын Дамдинням Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Батжаргалын Цогтнараран Татварын ерөнхий газрын дарга, Басангийн Батжаргал Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Чулууны Хишигдалай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Батжаргалын Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Шийрэвдамбын Маргад Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тосны ашиглалтын хэлтсийн дарга гэсэн ийм ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Ажлын хэсгийн гишүүдэд сануулахад Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандаж, Улсын Их Хурлын гишүүдийн асуусан асуултад бүрэн гүйцэд, үнэн зөв, бодитой хариулт өгөх ёстой. Хариулт дутуу, хариулт буруу, хариулахаас татгалзах юм бол Улсын Их Хуралд үл хүндэтгэлтэй хандсан гэж үзэж, зохих хуулийн дагуу хариуцлага хүлээлгэдэг болохыг бас анхааруулъя.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Сархадын Зулпхар гишүүн асуултаа асууя.

С.Зулпхар: Улсын Их Хурлын эрхэм дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд, Ажлын хэсгийнхний өдрийн амгаланг айлтгая.

Монгол Улсын хувьд стратегийн онцгой ач холбогдолтой зүйл бол эрчим хүчний бие даасан байдал, эрчим хүчний хараат бус байдал. Энийг та бид бүгдээрээ мэдэж байгаа. Энэ үүднээс эрчим хүчний гол үндсэн бүрэлдэхүүн хэсэг болсон газрын тосны үйлдвэр байгуулах энэ стратегийн зорилт бол манай улсын өөрийнх нь бие даасан байдлын эдийн засгийн өсөлт, хөгжлийн гол тулгуур нь гэдгийг та бүхэн эрх биш бүрэн ойлгож байгаа. Энэ ч үүднээс миний хувьд бол Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг бол бүрэн дэмжиж байна. Та бүхнийг бас дэмжиж саналаа өгнө гэдэгт эргэлзэхгүй байна.

Надад 3 асуулт байгаа юм. Энхбаяр сайдаас, бас Дамдинням сайдаас асууж байгаа юм. Манай дээр жишээ нь Петрочайна Дачин Тамсагийн газрын тос ямар нэгэн байдлаар бид олборлож байна. Гэхдээ сүүлийн жилүүдэд энэний олборлолт нь буурсан ийм нөхцөл байдалтай байгаад байна л даа. Тэгэхээр энэ бол биднийг цаашдаа үйлдвэрээ байгуулчихаад түүхий эдээ хангаж чадах уу гэсэн ийм бас эргэлзээнд хүргэж байгаа юм. Тэгэхээр энэ чиглэлээр бид цаашдаа жишээ нь ямар бодлого барьж, ямаршуу байдлаар энэ асуудлыг шийдэх гэж байгаа вэ гэсэн ийм

асуулт байгаа юм. Олон нийт бас энэ талаар зөв мэдээлэл аваасай гэж бодож байна. Наана цаанаа янз янзын мэдээлэлтэй байх шиг байгаа юм.

2 дахь асуудал бол Дамдинням сайдаас би зориуд асууж байгаа юм. Мэдээж хэрэг хайгуул хийхгүйгээр бид ямар нэгэн үр дүнд хүрэхгүй. Хайгуул өөрөө их чухал. Энэ геологийн хайгуул, энэ дотроо уул уурхай дотроо газрын тосны хайгуулын ажил ямар түвшинд байгаа юм. Бид энийг цаашдаа ямар бодлогоор авч явах юм. Бидний хүлээлт ер нь ямар байгаа юм гэдэг дээр та хэлээч. Яагаад гэвэл энэ шинээр байгуулагдах үйлдвэр маань цаашдаа түүхий эдээр бүрэн хангагдах ёстой. Шаардлагатай бол энэ үйлдвэр цаашдаа бүр өргөтгөөд ч болтугай томруулаад бид эрчим хүчнийхээ хэрэглээг бол бүрэн хангах чиглэл рүү явах ёстой учраас энэ чиглэлээр бас ямар үр дүн гарах вэ гэсэн ийм асуулт байгаа юм.

3 дахь зүйл. Би Энхбаяр сайдаас бас зориуд асууж байгаа юм. Үйлдвэр байгуулах бол 1 хэрэг, үйлдвэрийг ажиллуулна гэдэг бол бас жичдээ асуудал. Үйлдвэрийг ажиллуулахад гол зүйл бол хүний нөөц. Энэ технологийг мэддэг тэр техник, технологийн бүрэн чадвартай мэргэшсэн ажиллах хүчин, инженерүүд бэлтгэгдсэн байх ёстой. Энэ чиглэлээр бэлтгэл хангагдаж байна уу гэсэн асуулт байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Зулпхар гишүүний асуултад хариулъя.

1 дүгээрт газрын тосны үйлдвэрийн бүтээн байгуулалт бол маш эрчимтэй явж байгаа. Улсын Их Хурал маань бас ойлгож, гадаад зээлийн ашиглалтыг сайжруулах хууль баталж өгсөнтэй холбоотойгоор ажлын тоо хэмжээ эрс нэмэгдсэн. талбай дээр бол 3500 орчим ажилчид ажиллаж байна. Энэ жилдээ тоо нь нэмэгдэнэ. Саяхан Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гадаад хэргийн сайд ирж, бид бас очиж цуг үзээд ирлээ. Яг энэ үед бидний ярьсан 1 асуудал бол таны асууж байгаа асуулт. Өөрөөр хэлбэл энэ баригдаж байгаа үйлдвэр маань 2 жилийн дараанаас ашиглалтад ороод эхлэхээр хэн удирдаж авч явах вэ, удирдаж авч явах хүмүүсийг яаж бэлтгэх вэ гэдэг асуудал яригдаж байгаа. Тэгээд хамгийн 1 дүгээрт бид нар ШУТИС дотоодын мэргэжилтнүүдээ бэлдэх чиглэлээр 30 хүүхдийн квот гаргаад, тусгайлан сургаад ингээд явж байгаа. Тэтгэлэг өгөөд.

2 дугаарт ажиллаж байгаа инженер, техникийн ажилчид дотроосоо энэ үйлдвэрийг авч явах хүмүүсийг сонгон шалгаруулаад, бэлдээд явж байна. Удахгүй Бүгд Найрамдах Энэтхэг Улсын талтай ярилцаад, яг ажиллаж байгаа үйлдвэрүүд дээр аваачиж, туршлага судлуулж, ажиллуулахаар хөтөлбөр гаргаад явж байгаа. Тэгэхээр энэ бол аягүй чухал сэдэв.

2 дугаар асуудал бол газрын тосны бүтээгдэхүүний түүхий эдтэй холбоотой асуудал. Түүхий эдтэй холбоотой асуудал бол бид үйлдвэр маань 1,5 сая тонны хүчин чадалтай үйлдвэр. Бид бол оргил үедээ 1,4 саяыг олборлож байсан үе бий. 1,2-1,4. Тэгэхээр бид бол 380 орчим мянгыг олборлож байна. Энэ хуурай газрын эх газрын хайгуулд сонирхол илэрхийлж байгаа аж ахуйн нэгжүүд бас харьцангуй бага байгаад байдаг. Петрочайна компанитай бол манай төр засгийн бүх удирдлагууд уулзсан. Би бас уулзаж байсан. Энэ хүмүүс бол гэрээний үүргээс бусад асуудлаар

бид нартай үүсчхээд байгаа энэ асуудлаа тодорхой болгоод өгчих. Тэгвэл бид хайгуул судалгаагаа эрчимжүүлье гэсэн ийм байр суурийг илэрхийлдэг.

Одоогийн байдлаар бол газрын тосны хайгуулын 10 талбай уламжлалт бус газрын тос буюу занар гэж ярьдаг. Шатдаг занар. Энэ занарын 7 талбайд хайгуулын ажил явж байна. Энэ 2 компани 2026 онд нийт 410 мянган тонн газрын тос олборлохоор байна. Олборлолт бол 2007 онд 367 мянга, 2028 онд 331 гээд ингээд буураад явах гээд байгаа юм. Тэгэхээр бид бол эндээс юу харах ёстой вэ гэхээр энэ маргаанаа шийдвэрлээд, тэгээд манай улсад ажиллаад сурчихсан, дээрээс нь энэ дэлхийн хамгийн том газрын тосны олборлогч хайгуул эрхэлдэг Петрочайна компанитай хамт хамтарч ажиллах хамгийн гол зарчим нь зөв юм гэж. Бусад аж ахуйн нэгжүүд Энэтхэгийн талд бас бид санал тавиад ингээд явж байгаа. Ер нь одоогоор бол сонирхож байна гэсэн хариу ирэхгүй байгаад байгаа юм.

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Дундговь аймгийн Сүмбэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 1986 оны 10^а, 10^б ангийн төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Сархадын Зулпхар гишүүн тодруулж асууя.

С.Зулпхар: Баярлалаа. Би бас яах вэ Энхбаяр сайдыг их чухал бас тоонууд хэлэх ёстой гэж бодож байгаа юм. Олон нийт8 бид бас тодорхой мэдээлэлтэй байх ёстой. Үйлдвэр ашиглалтад орсноор дотоодынхоо хэрэгцээний хэдэн хувийг хангах вэ гэдэг ийм асуулт байнга тавигдаж байгаа. Бидэнд бас тодорхой төсөөллүүд байгаа. Зөвхөн ашиглалтад орсон үеийн бидний хэрэглээний хэдэн хувийг хангахаас гадна, ойрын 10 жилд манай эдийн засаг өсөхийн хэрээр ер нь эдийн засгаа өсгөхийн тулд эрчим хүчнийхээ хэрэглээг бид нэмэгдүүлэх ёстой. Энэ чиглэлээр манай энэ үйлдвэрийн цаашдын бас преспектив ер нь ямар байх юм бэ. Энийг цааш нь томруулах юм уу, өргөтгөх юм уу гэдэг ийм асуудал байгаа юм.

2 дахь асуудал мэдээж хэрэг аливаа үйлдвэр байхад бол орон нутгийнхаа иргэдийн санал бодол, дэмжлэгийг авах ёстой. Энэ чиглэлээр бас жоохон тодорхой бас сорилтууд байсан. Асуудлууд байсан. Энэ ер нь шийдэгдэж байгаа юу гэсэн бас ийм асуулт байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Энэ үйлдвэр маань бол бүрэн хүчин чадлаараа ажиллахад манай улсын нийт хэрэглээний 50 хувийг хангана. Яг одоогийн байдлаар. Манай улсын уул уурхай, үйлдвэрлэл, барилга, зам гүүрний ажлын бүтээн байгуулалтын идэвхжилээс шалтгаалаад хэрэглээ бол өснө. Тэгэхээр энэ үйлдвэрийнхээ хүчин чадлыг бид нар бол нэмж таарна.

2 дугаар асуудал бол орон нутагтаа ажиллах асуудал дээр бол Газрын тосны хууль дээр болохгүй асуудлууд байсан. Орон нутаг нь олборлуулаад байдаг, авдаг зүйл байхгүй байгаад байсан. Манай Бадамсүрэн нарын гишүүдийн санаачлаад явж байгаа хууль удахгүй батлагдаад гарахаар энэ асуудал шийдэгдэнэ. Орон нутагт АМНАТ-ийн тодорхой хувь очдог болно. Энэ нь бас Засгийн газар, яамны барьж

байгаа бодлоготой таарч байгаа. Намраас бид бас Газрын тосны хуулиа бол шинэчилж оруулж ирэхээр бэлтгээд явж байна.

С.Бямбацогт: Батын Батбаатар гишүүн асуултаа асууя. Алга байна. Нарантуяа-Нара гишүүн асуултаа асууя. Алга байна. Оюунсайханы Алтангэрэл гишүүн асуултаа асууя.

О.Алтангэрэл: Энэ хууль батлагдсанаар хайгуул олборлолтыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ гэж. Яаж нэмэгдүүлэх юм. Яг тодорхой энэ хуулийн зохицуулалт ийм юм орж байгаа учраас гээд. Яагаад энийг асууж байгаа юм гэхээр манай Дорнодын жишээ байна л даа. Хэчнээн олон жил тэр газрын тосны баялгаас орон нутаг нь авах ёстой юмаа авъя, ард иргэд нь өгөөжөө хүртье гэж хэчнээн олон жил тэмцэл хийв. Ард иргэд, нутаг орны удирдлагууд, 1 жишээ нь манай Бадамсүрэн гишүүн тэнд сууж байна шүү дээ. Ерөөсөө л энэ байгалийн баялагтай холбоотой юм, газрын тос, ашигт малтмалтай холбоотой зүйл ярихаар нэг тийм эмээлттэй, болгоомжлолтой болчихжээ. Энэ өнгөрсөн жилүүдийн үйл явдлын улмаас. Ингэж байгаад хэдэн ухсан нүхтэй үлдэх юм биш байгаа. Ингэж байгаад баахан зальдуулчихсан гэрээний хохирогчид болчих юм биш байгаа гэсэн ийм айдастай болчихжээ.

Тийм учраас ашигтын хууль ороод ирэхэд энэ хэнд ашигтай, ямар компанийн, ямар лобби юу хийх гээд байна гэж харддаг. Ингээд орж ирж байгаа хууль дээр хайгуул, олборлолтыг нэмэгдүүлнэ. Шинэ орд илрүүлнэ энэ тэр гээд бичихээр яаж илрүүлэх гэж байгаа гэж өөрийн эрхгүй харддаг болж. Бид ер нь хэрсүүжих ёстой юм билээ. Өнгөрсөн жилүүдэд уул уурхай тойрсон, байгалийн баялаг тойрсон олон гэрээн дээр Монголын ард түмэн зальдууллаа, хууртлаа. Одоо асуудалд нухацтай ханддаг болох ёстой. Бид бас харьцангуй мэдлэгтэй боллоо. Орчин үед дэлхий ертөнцтэй хөл нийлүүлж байна. Хууль, эрх зүй, дэлхийн дэг журмын талаар өөрсдийн гэсэн мэдлэг, мэдээлэлтэй боловсон хүчинтэй боллоо. Тийм учраас энэ байгалийн баялагтай холбоотой, байгалийн нөөц, ашигт малтмал, газрын тостой холбоотой зүйлүүд дээр Улсын Их Хурал маш анхааралтай, нухацтай хандах ёстой гэж бодож байгаа юм.

Тэгэхээр ерөөсөө тодорхой 3 асуулт.

1 дүгээрт, хайгуул, олборлолтын нэмэгдүүлэх нөхцөлийг яаж бүрдүүлэх юм. Яаж бүрдүүлэх юм.

2 дугаарт, шинэ орд илрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ гэнэ. Шинэ ордыг илрүүлэхэд энэ хуулийн зохицуулалт чинь ямар байдлаар, яаж дэм болох юм.

3 дугаарт, энэ бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх зүйн тогтвортой байдал хангагдана гэж байгаа. Одоо бол Бүтээгдэхүүн хуваах гэрээтэй явж байгаа. Маш их хуулийн маргаантай байгаа. Эрх зүйн тогтвортой байдлыг нь хангахад энэ хууль чинь яг яаж туслах юм бэ. Хамгийн гол нь энэ баялгийн өгөөж нь ард түмэндээ нутгийн иргэддээ хүрдэг энэ зүйл дээр ямар нэг ахиц дэвшил байгаа юм уу. Энэ танилцуулга дээрээс ийм зүйл олж харсангүй. Тэгээд эдгээр асуултууддаа тодорхой хариулт авъя.

С.Бямбацогт: Энхбаяр сайд хариулъя. Шадар сайд Ж.Энхбаяр.

Ж.Энхбаяр: Энэ маргаан үүссэн 2 аж ахуйн нэгж бол дэлхийн газрын тосны тэргүүлэгч ийм компаниуд. 1991 онд анх Монгол улс Бүтээгдэхүүн хуваах гэрээ, Газрын тосны хуулиа батлаад, газрын тосны геологи, хайгуулыг манай ахмад үе алсыг харж эхлүүлсэн. 30 жил болсон. 35 дахь жилдээ болж. Өнөөдөр бид импорт 100 хувь хараат хэвээрээ байна. Хууль, эрх зүйн орчин ойлгомжгүй байдал үүссэн. Улмаар хөрөнгө оруулагч нарт маргаан, татварын болон даатгалын маргаанууд үүссэн. Ингээд жилдээ 1 сая 400 мянган тонн буюу өнөөдрийн Алтан ширээгийн үйлдвэрийн хүчин чадлыг бүрэн ашиглах бололцоотой газрын тос олборлож байсан манай газрын тосны салбар өнөөдөр 200 мянган тонн руу унасан. Шалтгаан бол хууль, эрх зүйн орчин тодорхойгүй, татварын орчин тодорхойгүй. Монгол Улс, Засгийн газар анх байгуулсан хөрөнгө оруулалтыг урихдаа байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээгээ дагаж мөрдөөгүй.

Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр бол их тодорхой заасан байсан. Ашигт тосны 40 хувь Монгол Улс авна. 60 хувийг нь хөрөнгө оруулагч авна. Үндсэндээ газрын тосны салбар бол асар их эрсдэлтэй гэдэг нь энүүгээр их тод харагдаж байгаа. 30 гаруй жил 4 тэрбум долларын хөрөнгө оруулалт хийсэн. Эргэн буцаан нөхөлт нь 40 гаруй хувьтай л яваа юм байна лээ. Өнгөрсөн хугацаанд 12 сая тонн газрын тос олборлож, экспортолж, Монгол Улсын төсөвт 3 их наяд төгрөгийн татвар, шимтгэлийн орлого тушаасан байгаа юм. Хөрөнгө оруулалт 30 жил явахад нөхөөгүй. Ер нь газрын тосны салбар чинь ийм эрсдэлтэй байдаг юм байна гэдэг нь тодорхой. Манай хууль, эрх зүйн орчин бол ахиж газрын тосны салбарт хөрөнгө оруулагчийг бид нар татаж чадсангүй. 1990-ээд оны хууль бол их татаж. Анх бол Америкийн, Австралийн компаниуд орж ирсэн шүү дээ. Энэ Соко, Тамсаг компанид дандаа Америк, Австралийн компаниуд ажиллаж байгаад, Хятадын төрийн өмчит компаниуд руу шилжүүлээд, Монголоос гарцгаасан. Ингээд Хятадын хөрөнгө оруулалттай компаниуд 4 тэрбум долларын хөрөнгө оруулалт хийгээд, үйл ажиллагаа явсан. 2012 оноос хойш эрх зүйн орчныг манайх өөрчилж эхэлсэн. Татварын хууль баталж эхэлсэн. Шүүхийн маргаануудыг үүсгэсэн. Ингээд 1 сая 400 мянган тонн хүрсэн олборлолт тасралтгүй буурсаар байгаад өнөөгийн түвшинд хүрсэн.

Эсрэг талд нь бид нар зээл аваад, газрын тос боловсруулах том үйлдвэрийг бариад, 2028 онд дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Зүүн бүсээс түүхий нефтээ татах хоолойн асуудлыг бариад, энэ жил дуусаж байна. Гэтэл түүхий эдийн хангамжийн асуудал дээрээ бид иймэрхүү маргаантай байна. Энийг 1 мөр шийдвэрлэх нь өнөөгийн гадаад орчинд үүсээд байгаа асуудал бол Монгол улсын хамгийн эмзэг байдал бол газрын тос, нефть бүтээгдэхүүний хараат байдал гэдэг нь тодорхой байна. Иймд .../минут дуусав/

С.Бямбацогт: Алтангэрэл гишүүн тодруулж асууя.

О.Алтангэрэл: Миний асуугаад байгаа асуулт бол яг ямар зохицуулалтууд байгаа юм бэ. Зорилгыг бол ойлгож байна. Тэгээд манай Энхбаяр сайд бол түрүүнд нь хөдөө аж ахуйн салбарт Монгол Улсын экспортыг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүд үнэ цэнтэй байх энэ зүйл дээр бол нэлээн хувь нэмэр оруулж амжилт гаргаж ажиллаж байсан. Тэгээд энэ нь одоо бас энэ асуудал дээр амжилт гаргах болов уу гэж итгэж байна. Тэгэхдээ яг ямар зохицуулалт байна. Урьд өмнө байгаагүй ямар зохицуулалтууд энэ хуульд ороод, тэгээд та бүхний яриад байгаа энэ олборлолтыг нэмэгдүүлэх, шинэ орд илрүүлэх, тогтвортой байдлыг бий болгох

чинь яг ямар зохицуулалтаар ороод байгаа юм бэ гэсэн их тодорхой асуулт асуугаад байгаа.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ. Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Эдгээр төслүүд жилдээ 1 сая 400 мянган тонн хүртэл газрын тос олборлож байсан. Эрх зүйн орчинтой холбоотойгоор унагаачихсан. Үр ашиггүй байдал руу орсон. Тэгэхээр эд нар амлаж байгаа юм. Хэрвээ энэ хууль, эрх зүйн орчноо та нар ойлгомжтой, тодорхой болгоод, анх байгуулсан гэрээгээ дагаж мөрдөх юм бол бид одоо байгаа хуучин түвшиндээ хүрэх бүрэн бололцоо байна. Нөөц баталгаажсан. 40, 50 сая тонн газрын тос байна. Мөн Монголын Говь, Алтайн өвөр говь, Их нууруудын хотгор гээд ирээдүйд төлөв сайтай талбайнууд олон байна. Энэ зүүн бүсэд хийсэн хөрөнгө оруулалттай холбоотойгоор бусад бүс нутагт хөрөнгө оруулалтууд гацчихаад байна. Хүлээгээд байна. Монгол Улс хэрхэн гэрээгээ дагаж мөрдөхөөс юм шалтгаалаад байна. Тэгэхээр энэ гол асуудал бол Бүтээгдэхүүн хуваах гэрээнд зохицуулалт хийж, анх гэрээ байгуулж, хөрөнгө оруулалт хийсэн тэр гэрээгээ л Монгол Улс дагаж мөрдөнө гэдгээ л .../минут дуусав/

С.Бямбацогт: Алтангэрэл гишүүн тодруулъя.

О.Алтангэрэл: Тэгэхээр урьд нь байгуулсан гэрээнийхээ зохицуулалтыг хууль, эрх зүйн орчноороо баталгаажуулах явдал юм гэж ойлголоо. Тэгээд дээрээс нь бидэнд ийм төлөв сайтай талбайнууд байгаа юм байна. Тогтоогдчихсон, цаашид өөрийн газрын тосны үйлдвэрээ хангах нөөц бидэнд тогтоогдчихсон нөөц байгаа юм байна гэж ойлголоо. Баярлалаа.

С.Бямбацогт: Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Жилдээ бид нар бараг 3 тэрбум орчим долларыг гадагшаа өгч байгаа. Бензин, шатах тос, агаарын түлш, хий гээд. Тэр нөөц Монгол Улсад байгаа нь тодорхой. Батлагдаад, хөрөнгө оруулаад, олборлолт яваад, жилдээ 1 сая 400 тонн олборлож байсан. Гэтэл энэ хууль, эрх зүйн нэмэлт, өөрчлөлтөөр бид нар тодорхойгүй байдал үүсгээд, маргаан үүсгээд, ингээд асуудлыг нэлээн цаг алдчихлаа л даа. 30-аад жил алдчихлаа. Тэгэхээр энэ маань 1991, 1993, 1995, 1997 онд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдээ мөрдөөч ээ гэдгийг л хөрөнгө оруулагч тал хүсээд байгаа юм. Бид чинь 2012 онд засаг солигдоод, баахан хууль, эрх зүйн орчныг өөрчлөөд, нэмэлт татвар, акт тавиад явчихсан байхгүй юу. Тэгэхээр анхандаа байгаач ээ. Хөрөнгө оруулалт ийм урт хугацаанд нөхдөг ийм эрсдэлтэй салбар гээд, үнэхээр эрсдэлтэй салбар байна. Өөр нэмж хөрөнгө оруулалт Монгол Улсад орж ирсэнгүй. Тэгэхээр одоо байгаа аж ахуйн нэгжүүдийнхээ эрх зүйн орчныг нь засаад, энийгээ гадна талдаа сайн сурталчлаад хөрөнгө оруулалт орох урсгалаа нээх бололцоотой..../минут дуусав/

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Дорноговь аймгийн Сүмбэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 1986 оны 10^в, 10^г ангийн төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе.

Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууя. Алга байна. Жаргалсайхан гишүүн асуултаа асууя. Алга байна. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуултаа асууя.

М.Бадамсүрэн: Хуулийн төсөлтэй танилцлаа. Энэ акт гэж татвар, НДШ-ийн акт яг хэдэн төгрөг, хэдэн жилийн туршид тавигдсан байгаа вэ. 1.

2 дугаарт нь Засгийн газарт Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр ногдол ашиг жилд хэдэн төгрөг улсын төсөвт хуримтлагдаж байна.

3-д нь үүнээс тухайн нөлөөлөлд өртөж байгаа Дорнод аймгийн Халх гол, Матад сум, Дорнод аймагт хэдэн төгрөг хуваарилагдаж байгаа вэ. Жил бүрийн, сүүлийн 5 жилийн байдлаар бэлэн мэдээлэл байгаа байх. Энийг асууя.

2 дугаарт нь газрын тос гэдэг бол шавхагддаг баялаг. Энэ газрын гүнд 2-3км-т байгаа тос. Энийг ашиглахын тулд гүний усыг ашигладаг. 1 литр нефтийг олборлохын тулд бараг одоогийн технологиор 4-5 литр гүний ус ашиглаж байгаа. Тэгээд энэ технологийг ер нь хэр зөв гэж боддог вэ. Мэргэжлийн үүднээс. Энэ хэдэн тонн ус ашиглаж байна.

Энхбаяр сайд инээгээд хэрэггүй л дээ. Би бас мэтгэлцвэл тантай бол мэтгэлцэхэд бэлэн байна. Ж.Энхбаяр сайд. Тэгэхээр энэ бол инээдэм биш. Танд бол инээдэм, иргэдэд бол энэ бас ханиадам шүү. Тэгэхээр энэнд маань зөв зүйтэй хариулт өгөөч ээ. Яагаад гэвэл иргэдийн мэдэх эрхийг хангахын тулд энэ асуултыг би асууж байгаа юм гэдгийг бас таныг, Тэргүүн Шадар сайдыг ойлгоосой гэж бодож байна.

Ер нь Оюунтолгойн гэрээ, газрын тосны гэрээ бол маш муу гэрээ. Энэ бол ойлгомжтой. Тийм ч учраас өнөөдөр энэ гэрээний үр дагавраас үүссэн маргааныг арилгахын тулд хуульдаа өөрчлөлт оруулах энэ арга замыг сонгосон байна гэж би бол харж байгаа юм. Тийм учраас цаашдаа Монголын төр, Монголын төрөөс томилогдсон албан тушаалтнууд сайн гэрээ байгуулах хэрэгтэй. Энэ гэрээг сайн гэрээ гэж үзэж байгаа юу, муу гэрээ гэж үзэж байгаа юу гэдгийг би асууя.

Газрын тосны талаар цаашид технологийн дэвшлийг илүү нэвтрүүлэх талаар бас анхаараарай гэдгийг хэлье. Яагаад гэхээр энэ бол хамгийн эмзэг асуудал. Дотооддоо үйлдвэртэй болсон, түүхий эдээ хангах зорилтыг бол ойлгож байгаа. Гэхдээ Монголд ашигтай, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг стандартын түвшинд хийдэг байхыг л шаардаж байгаа. Тэгээд энэ дээр технологи мөрдөлттэй холбоотой, байгаль орчныг нөхөн сэргээхтэй холбоотой гарсан зөрчил акт асуудлуудыг яривал арвин зузаан баримт материал байна. Тэгээд энэ технологийг сайжруулах, байгаль орчныг нөхөн сэргээхэд чанд мөрдүүлэх талаар яг ямар ахиц дэвшил цаашид гаргах вэ.

Би яагаад энийг мэдэж байна гэхээр Дорнод аймгийн Засаг даргаар ажиллаж байхад, намайг анх Засаг даргаар томилогдоход байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь 40 хэдэн хувьтай энэ 2 талбай нь үнэлэгдсэн. Тэгээд энэ бол яг гарааны нөхцөл буюу байгаа нөхцөл байдлыг харуулсан л үзүүлэлт. Үүнээс хойш өнгөрсөн хугацаанд бүх технологийн тээврийг нь хатуу хучилттай авто замтай болголоо. Гүний усыг ашиглахад нь тоолуур тавилаа гээд олон дэвшилтэт зүйлүүд

орон нутгийн санал санаачилгаар гарсан. Гэхдээ та бүхэн цаашдаа энийг .../минут дуусав/

С.Бямбацогт: Хэн хариулах вэ. Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Монгол улс өөрийн шатах, тослох материалтай болох гэж 35 жилийн өмнө анх бодлого эхэлсэн. Өнөөдрийг хүртэл үр дүн гараагүй. Түүхий эдээ зараад олсон орлого, валютаа газрын тосонд, шатахуунд өгсөн хэвээр л байна. Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн хамгийн гол тулгамдсан шийдэх ёстой асуудал бол бензин, шатахуун. Дотоодын үйлдвэрлэл. Хөрөнгө оруулалтыг урьсан. 4 тэрбум долларын хөрөнгө оруулалт орсон. Тогтвортой байдлын гэрээ байгуулсан. Бүтээгдэхүүн авах гэрээ байгуулсан. Ингээд ажил явж байсан. Эрх зүйн орчноо өөрчилсөн. Хөрөнгө оруулагч дээр янз бүрийн болзол тулгалт тавьж эхэлсэн. Өнөөгийн байдлаар 700-аад тэрбум төгрөгийн акт тавигдсан. Петрожайна компанийн Улаанбаатар дахь оффисыг нь хаасан, хурааж авсан, лацадсан. Энэ аж ахуйн нэгжийг үйл ажиллагаа явуулах боломжгүй болгосон. Гадаад орчин хүндрээд байдаг. Үндэсний боловсруулах үйлдвэрийг яаралтай ашиглалтад оруулах нь чухал байдаг. Түүхий эдээр хангах хэрэгтэй байдаг. Газрын тосны геологи, хайгуулыг нэмэгдүүлэх хэрэгтэй байдаг.

Иймд энэ өнгөрсөн 30 жилийн хугацааныхаа хуулийн дүгнэлт хийгээд, хууль, эрх зүйн орчноо бид нар цэгцэлж янзалж, 1 мөр ойлголттой болохгүй бол Монгол Улсад газрын тосны салбарт ийм эрсдэлтэйгээр хөрөнгө оруулах, хөрөнгө оруулагч байхгүй байна. Нэмэгдсэнгүй. Ирээдүйн төлөв бүхий олон талбайнууд байгаа. Зарласан боловч хөрөнгө оруулагч орж ирэхгүй байна. Нийтдээ 3 их наяд төгрөгийг энэ 2 аж ахуйн нэгж Монгол улсын төсөвт өнгөрсөн хугацаанд тушаасан байна. 2025 онд гэхэд 231,9-ийг төлсөн байна. 2026 онд 231-ийг төвлөрүүлэхээр төлөвлөгөөтэй ажиллаж байсан.

Тэгээд ус болон технологитой холбоотой асуудлыг ажлын хэсэг, тэр мэргэжлийн хүмүүс нь хариулна биз. Энэ миний асуудал биш. Би бол хууль, эрх зүйн орчныг нэг мөр ойлгомжтой болъё. Монгол Улс хөрөнгө оруулагчтай байгуулсан гэрээгээ мөрддөг байгаасай гэж бодож байна. Хууль, эрх зүйн орчин тодорхой ойлгомжтой байдаг байгаасай гэж бодож байна.

Дахин хэлэхэд газрын тос, шатах, тослох материал, бензин тос бол Монгол Улсын стратеги. Манай хөгжлийн бодлого. Бензин нэмэгдэнэ, инфляц өснө. Инфляц өснө, тэтгэвэр, урсгал, цалин бүх урсгал зардлыг нэмэх ийм хуулийн зохицуулалттай. Нэмсээр байгаад улсын төсөв маань урсгал зардлын төсөв болоод дууслаа. 2027 онд бид нар шинэ хөрөнгө оруулалт хийж чадахгүй шүү дээ. Тэр суурь шалтгаан юу юм гэвэл шатахуун байна. Шатахуунаа дотооддоо хийдэг болъё. Тэгэхийн тулд түүхий эд, хөрөнгө оруулалт, олборлолтоо нэмэх хэрэгтэй л байна. Тийм бодлогоор энэ хууль, эрх зүйн орчныг өөрчилж оруулж ирж байгаа.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. Индрийн 4 дүгээр микрофон. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Газрын тосны бодлогын газрын дарга Хишигдалай. Өнгөрсөн 2025 онд газрын тосны нөөц ашигласны төлбөрөөс нийслэлд 36 тэрбум төгрөг улсын төсөвт орсон. Орон нутгийн хөгжлийг

дэмжих санд бол үүний 30 хувь нь очдог байгаа. Өөрөөр хэлбэл 10,9 тэрбум төгрөг. Нэгдсэн санд. Тэгэхээр нэгдсэн сангаас Дорнод аймаг руу хэрхэн хуваарилсан талаар мэдээллийг бол Сангийн яамнаас дэлгэрэнгүй мэдээлэл авч танд өгье.

Усны төлбөрт бол Тосон уул 19 талбайгаас 1,8 тэрбум төгрөг, Тамсаг 21 талбайгаас 1,8 тэрбум төгрөг, Бүтээгдэхүүн хуваах гэрээт 97 талбайгаас 442 сая төгрөг бол ус ашигласны төлбөрт улсын төсөвт орсон байна.

Орон нутагт түрүүн дурдсан нөөц ашигласны төлбөрөөс гадна бас орон нутгийг хөгжүүлэх урамшуулал гэж жил бүр Петрочайна компани 2 талбай дээр 50, 50 мянган доллар өгдөг байна. Тусгай зөвшөөрлийн төлбөр 19 дүгээр талбай дээр 32500 доллар, 21 дүгээр талбай дээр 10 мянган доллар. Өнгөрсөн 2020-2023 онд орон нутагтай байгуулсан 3 талт хэлэлцээрээр Халх гол, Матад сумдад 450 мянган доллар тус тус ажил үйлчилгээ хийх гэх мэтчилэн гэрээнүүдийг байгуулж ажилласан байна.

С.Бямбасүрэн: Бадамсүрэн гишүүн тодруулж асууя.

М.Бадамсүрэн: Дамдинням сайдын хувьд бас орон нутагт рояалти хувийг хуваарилах гэдгийг бас бодлогоор дэмжиж байгаад их баярлалаа. Тэгээд бидний зүүн бүс, говийн бүсийн гишүүд хамтарч санаачилсан орон нутагт өгөөжөөс хүргэх чиглэлийн хууль, эрх зүйн орчныг бол дэмжих нь зайлшгүй чухал. Яагаад гэхээр энэ өмнийн говь Мэнэн тамсагийн талд амьдран сууж ирсэн хэдэн малчдын ач буянаар өнөөдөр бид энэ Оюутолгой, Тавантолгой, газрын тос гээд энэ ордуудаас орлого олж байгаа гэдгийг бид нар маш сайн ойлгох хэрэгтэй.

2021 онд Ардын хувьсгал ялахад 500 хүрэхгүй мянган хүнтэй байсан. Нүүдэлчид энэ том, дэлгэсэн дэлгэсэн нутгийг бидэнд үлдээсэн шүү. Тийм учраас тэр хүмүүст өгөөж хуваарилах гээд байгаа болохоос энийг өөр юманд авах гээд байгаа юм байхгүй. Энийг маш хатуу ойлгох хэрэгтэй. Тэгээд 5-10 жилийн хугацаанд Засгийн газар бол бараг энэ тавьсан актаа тооцоод ингээд .../минут дуусав/

С.Бямбацогт: Үг хэлчих шиг боллоо. Гэхдээ Сангийн яамныхан бас тэр актуудтай холбоотой орж байгаа орлого, өгөөжтэй холбоотой асуудлуудаар тодорхой мэдээлэл бэлдэж өгөөрэй. Бадамсүрэн гишүүн асуултаа гүйцээгээд асуучихъя.

М.Бадамсүрэн: Тэгэхээр би нөгөө орон нутагт ямар хөрөнгө хуваарилагдаж байна гэхэд ингээд хариулахад аягүй боломжгүй л байгаад байгаа байхгүй юу. Үндсэндээ хариулахад аягүй хэцүү байгаа байхгүй юу. Яагаад гэвэл нөгөө хуваарилж байгаа юм байхгүй. Тийм учраас энэ ерөөсөө тэнцвэртэй хөгжил гэдэг зүйлийг л бид нар ухагдахуунаар нь ойлгох хэрэгтэй. Улаанбаатар хотод насаараа амьдарсан хүмүүс, хөдөө орон нутагт насаараа байсан хүмүүс 2-ын хооронд их том ялгаа байгаа. Одоо Их Хурлын гишүүд хөдөө, орон нутагт ажиллаж ирээд нээрээ бас бодохоор юм их байдаг юм байна гээд саналаа хэлж байгаа шүү дээ. Тэгэхээр энийг Их Хурлын гишүүд, нийслэлээс сонгогдсон жагсаалт, бусад уул уурхай ашигт малтмалын нөлөөлөлд өртдөггүй бүсээс сонгогдсон гишүүд бас ойлгох хэрэгтэй. Тэнд очиж үзэх хэрэгтэй. Энэ өөрөө их ийм ялгаатай байдал байдаг шүү гэдгийг би бас зориуд хэлье гэж бодож байгаа юм.

Яагаад гэвэл алтыг нь аваад, авдрыг нь хаяж болохгүй. Тэнд амьдран сууж байгаа хязгаар нутгийн иргэдийн эрх ашиг. Энийг маш .../минут дуусав/

С.Бямбацогт: Асуулт асуусангүй. Үг хэлчихлээ.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын дэд дарга Жадамбын Бат-Эрдэнийн урилгаар Булган аймгийн Дашинчилэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2006 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төгсөлтийнхөө 20 жилийн ойг хийж байгаа, Төрийн ордонтой танилцаж байгаа та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Батбаярын Жаргалан гишүүн асуултаа асууя.

Б.Жаргалан: Ардчилсан хувьсгалаас хойш зах зээлийн эдийн засагт шилжсэн цаг үеэс хойш Монголчуудын бас итгэл мөрөөдлийг бадраасан нэгэн үйл явдал, бид нарыг хүүхэд байхад болсон үйл явдал бол Монгол Улсын анхны Ерөнхийлөгч Очирбат Монгол Улс газрын тостой боллоо гээд дээлийнхээ энгэрт мялаагаад зогсож байсан тэр цаг мөч байдаг. Тэгээд тухайн цаг үед монголчуудад юу бодогдож байсан бэ гэхээр бид бол газрын тосны нөөцтэй, ер нь цаашдаа эдийн засгийн хөгжил их дардан замаар явах юм байна. Монгол Улс дараагийн Азийн бар улс болох юм байна гэсэн тийм мөрөөдөл байсан. Гэвч ингээд 30 хэдэн жилийн туршид газрын тосны салбар бас тийм ахицтай хөгжил гарсангүй. Өнгөрсөн хугацаанд манай улс бол ердөө 12 сая тонн газрын тос олборлосон байна. Тэгээд сүүлийн үеийн бас монголчуудын мөрөөдөл бол энэ шатахууныхаа үйлдвэрийг байгуулах. Өөрсдөө эрчим хүчний, шатахууны хараат байдлаасаа гарах гэсэн мөрөөдөл байгаа. 2015 онд Энэтхэгийн Ерөнхийлөгч Монгол Улсад айлчилж ирсэн. 1 тэрбум ам.долларын зээлийн асуудал анх тухайн үед яригдсан. 2017 онд энэ 1 тэрбум долларын Энэтхэгийн зээлийг бол энэ газрын тосны үйлдвэр барьж байгуулах ажилд зориулъя гэдэг шийдвэр гарсан. Тэгээд 2021 онд Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хууль гэж хүртэл гарч байсан. Энэ жил бид нар 2026 онд бас газрын тосны үйлдвэрийн зээлтэй холбоотой зээлийн ашиглалтыг төсвөөс бас гаргах ийм тусгайлсан хууль батлаад өглөө.

Өөрөөр хэлбэл шатахууны үйлдвэртэй болчихъё, газрын тосны салбараа босгочихъё гэдэг эрмэлзэл бол маш ихээр байгаад байна. Харамсалтай нь бас өртөг их өндөр байна. Хугацаа маш тодорхойгүй байна. Газрын тос боловсруулах үйлдвэр дээр анх 1 тэрбум доллар гэж байсан бол 1,7 тэрбум. Тэгээд энэ чинь хэд юм 6 их наяд төгрөг. Хийн хоолой барьсан. Бас 1 их наяд төгрөг орчим уу. Тэгээд өнөөдрийн өнөөдрийн орж ирж байгаа энэ Бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой татварын өр төлбөр актуудыг Засгийн газар өөрсдийнхөө төлбөрт суутгаж авна буюу тэр актуудыг хүчингүй болгоно гэж байна шүү дээ. Энэ чинь болохлоор нийт өртөг нь 762 тэрбум. Тэгэхээр энэ газрын тосны цогцолборын маань өртөг нь бол одоогоороо 8 их наяд орчим болчихоод байна. Тэгээд яах вэ, энэ тоонуудаа та бүхэн маань тодруул л даа. Би сая зүгээр яг байгаа мэдээллийнхээ, нээлттэй мэдээллийн хүрээнд л ийм тоо хийлээ. Өнөөдөр энэ хууль батлагдсанаар Монгол Улс 762 тэрбум, нөгөө акт төлбөрүүдээсээ бол татгалзаж байгаа гэсэн үг шүү дээ. Тэгэхээр энэ 762 тэрбумыг хэдэн жилийн төсвийн хугацаанд суутгаж тооцох юм бэ. Бүтээгдэхүүн хуваах гэрээндээ. Тэгээд улсын төсөвт бол энэ газрын тосны салбараас 230-300 тэрбум төгрөг жил бүр төвлөрч ирсэн гэж байна. Тэгэхээр энэ

төлбөрт ямар өөрчлөлтүүд орох юм бэ. Татварын орлогод ямар өөрчлөлт гарах вэ гэдэг асуудал. Татвар биш бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олж байгаа орлогод ямар өөрчлөлт гарах вэ гэдэг асуулт.

Тэгээд энэ Петрочайнагийн гэрээ бол дуусаж байгаа гэж ойлгож байгаа. Тэгээд бид нар энэ удаадаа буулт хийгээд, тэгээд дараа нь гэрээгээ шинэчлэхдээ ер нь яг ямар нөхцөлөөр шинэчлэх юм бэ. Ямар нөхцөлөөр айлтай тохирч байгаа юм бэ. Ямар шийдэл байна гэдэг дээр бас яг тодорхой хариулт авъя. Тэгэхгүй бол нөгөө манай маш их өндөр өртгөөр бариад байгаа газрын тосны цогцолбор чинь болохлоор бас түүхий эдийн нөөц баталгаагүй гээд байгаа шүү дээ. Тэгээд өнгөрсөн хугацаанд бид нар энэ 2017 оноос хойш явсаар байгаад энэ асуудлуудаа бас яагаад шийдэхгүй он удаан жил явчихсан юм бэ. Тэгээд хамгийн эцсийн мөчид гэнэт ингээд энэ түүхий эдийнхээ асуудлыг одоо ярья..../минут дуусав/

С.Бямбацогт: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Петрочайна компанийн ашиглалтын хугацаа 2032 оны 12 сарын 6-нд дуусна. Доншен компани 2031 оны 7 сарын 5-нд дуусна. Дахин сунгах хүсэлт гаргасан тохиолдолд 5, 5 жилээр 2 удаа сунгана. 10 жил. Тэгээд гол талбай маань 2032 онд дуусна. Энэ үед гэрээ шинэчлэх, нөхцөлөө өөрчлөх асуудал яригдана гэсэн үг. Тэгээд ганц Газрын тос биш. Бид нар үнэхээр газрын ховор элементтэй байж ашиглаж чадахгүй байна. Дотроо 100 хувь хангах бололцоотой бордооны нөөц, фосфоритын ордтой байж ашиглаж чадахгүй байна. Уул уурхайд хамгийн их шаардлагатай тэсрэх бодисоо үйлдвэрлэх нөөцтэй байж ашиглаж чадахгүй байна. Мөн ашиглалтад бэлэн болсон 200 тонн алттай байхад бид нар ашиглаж чадахгүй л хэвээрээ л байна. Байгаа нөөцөө ашиглаж чадахгүй учир шалтгаан ард түмний нэр барьсан байгууллага хөдөлгөөнүүд, дээрээс нь хууль, эрх зүйн ойлгомжгүй байдал, давхардсан байдлууд.

Үнэхээр та яагаад 30 жил энэ чинь 35 жил болоод байхад энийгээ хийж чадсангүй вэ гэж. Хөрөнгө нь ороод, хайгуулд нэмэгдээд, олборлолт чинь 1 сая 400 мянган тонн хүрч байсан. Тэгээд манайх яасан. Одоо 1 сая 400 хүрээд ирлээ, одоо бид нар татвар тавья, мөнгө олж авъя гээд л хуулиа өөрчлөөд л дайрсан. Үр дагавар унасаар байгаад өнөөдөр 200 мянган тонн руу буучихсан. Хэрвээ энэ 1 сая 400 мянган тонноор олборлолтдоо буцаад хүрэхэд энэ тавьсан асуудал 1 жилийн дотор суутган тооцоод л дуусчих асуудал байхгүй юу даа. Боломж байгаад байдаг, үйлдвэр маань баригдаад байдаг, түүхий эдийнхээ геологи, эрэл хайгуул, шинэ талбайд хөрөнгө оруулагчийг урих хэрэгтэй байдаг. Гэтэл бидний байгаа байдал эрх зүйн орчноо тогтворгүй болгоод, хөрөнгө оруулагчдаа үндсэндээ амласан хөрөнгө оруулалтын Бүтээгдэхүүн хуваах гэрээгээ зөрчөөд ингээд ирсэн байдал байдаг. Тэгээд энийгээ л засах ёстой. Цаг алдсан. Маш олон зүйл дээр алдаж байна шүү дээ. Газрын ховор дээр алдаж байна. Алтан дээр алдаж байна. Бордоон дээр алдаж байна. Тэсрэх бодис дээр алдаж байна. Газрын тосон дээр алдаж байна. Үүний цаана чинь дандаа 100, 100 тэрбумыг гадаад экспорт, импортод яваад байна шүү дээ. Тэгээд дотооддоо хийх ёстой газрын тосон дээрээ бид нийлээд, улс төржилгүйгээр бүгд хамтраад, үүний ард гаргах ёстой. Монголд нөөц байгаа нь тодорхой байна шүү дээ. Газрын тосны нөөц байна. Боломж байна. Ирээдүй байна. Эрх зүйн орчноо л янзлаад өгвөл хөрөнгө оруулалтууд орж ирэх боломж нээгдэх гээд байдаг. Бид нэлээн хатуурхчихсан. 30 жил харлаа, 1 ч хөрөнгө оруулалт нэмэгдсэнгүй. Анхны 1991 оны гэрээн дээр тулгуурлаад 4 тэрбум долларын хөрөнгө

оруулалт хийгээд, жоохон нефтээ олборлосон. Энэ дээр хуулийн маргаан үүсгэчихсэн. Эрх зүйн орчин нь өөрчлөөд ингээд өөр өөрсдийгөө хорлочихсон ийм байдалтай сууж байна.

Тэгэхээр энийгээ засаад янзлаад .../минут дуусав/

С.Бямбацогт: Жаргалан гишүүн тодруулж асууя.

Б.Жаргалан: 1 дүгээрт энэ 762 тэрбум төгрөгийн өр төлбөртэй холбоотой төсвийн нөлөөлөл нь ямар байх вэ гэдэг тодорхой асуулт асуусан. Энэ дээр бас Сангийн яам нэмээд хариулж өгөхийг хүсье.

Тэгээд миний хэлээд байгаа юм яг тэр байхгүй юу даа. Анх энэ газрын тосны үйлдвэр барина гээд л 2017 оноос хойш явсан. Үе үеийн Ерөнхий сайд нар МАН-аас сонгогдсон Ерөнхий сайд нар шоуддаг. Одоо энэ жил ашиглалтад орох гэж байна, энэ жил ашиглалтад орох гэж байна гээд л яваад байдаг. Одоо ингээд 9 дэх жилдээ явж байгаа. Тэр хугацаанд та бүхэн маань бүгдээрээ Засаг барьж байлаа. Тэгээд эн Их Хурал ч гэсэндээ энэ газрын тосны үйлдвэрийг чинь бүх талаараа дэмжээд, дандаа ийм стандарт бус яг энэ төсөлд чинь зориулсан бусад тогтолцооноосоо гаргасан энэ зээлийн ашиглалт гэж байна. Энэ өнөөдрийн орж ирж байгаа энэ өр төлбөртэй холбоотой асуудлыг бас зохицуулах энэ хууль гээд л бүгдийг нь шийдэж өгөөд байгаа шүү дээ. Тэгээд хэзээ ашиглалтад орох юм бэ. Яг тодорхой тэр өдөр судраа хэл л дээ. Хэзээ ашиглалтад орох юм. Тэр түүхий/минут дуусав/

С.Бямбацогт: Дамдинням сайд хариулъя. Дараад нь Сангийн яам тэр төсөвтэй холбоотой асуудал дээр Санжаадорж дарга бэлдэж байгаарай. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Дамдинням хариулъя.

Г.Дамдинням: Тэгэхээр энэ газрын тосны үйлдвэр дээр хэдүүлээ 1 юмыг ойлгох ёстой юм байгаа юм. 1 дүгээрт БНЭУ-ын Ерөнхий сайд айлчилж ирээд, 1 тэрбум долларын хөнгөлөлттэй зээлийг юунд хийх вэ гэж асуусан юм байна лээ. Тэгээд 1 тэрбум долларыг газрын тосны үйлдвэрт хийе гэж шийдсэн. Тэр үед ТЭЗҮ байгаагүй. ТЭЗҮ-г нь хийгээд дууссан чинь 1,7 тэрбум болсон. Ийм л юм байна лээ. Анхнаасаа 1 тэрбумд гэж байгаагүй.

2 дугаарт зээлийг нь батлаад ингээд явсан чинь яг барилгын ажил бол 2019 онд л эхэлсэн юм байна лээ шүү дээ Жаргалан гишүүн ээ. Шийдэхгүй явсаар байгаад, тэгээд ковид гарсан. Тэгээд одоо 2 жил ажиллаж байна. Үнэндээ яг барилгын ажил гуравхан жил явж байгаа. И Пи Си 4 гэдэг 4 дүгээр багц ажил нь 2025 онд гэрээ нь байгуулагдаад, ажил нь одоо дөнгөж эхэлж байна. 2028 онд ашиглалтад орно. Ажил маш идэвхтэй яваа. Та нартаа их баярлаж байгаа шүү. Сүүлд тэр гадаад зээлийн ашиглалтын хуулийг бас ойлгож, баталж өгсөнд. Ажлын тоо хэмжээ нь нэмэгдээд, санхүүжилт нь нэмэгдээд яваад байгаа юм.

С.Бямбацогт: Сангийн яам хариулъя.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Баялгийн өгөөжийг хүртэх хэд хэдэн хувилбар байдаг. Улс орнуудад хэрэглэж байгаа гэрээнүүд. Яг энэ хувилбар бол яаж байна гэхээр олборлосон бүтээгдэхүүнээ гаргаж ирээд, энэ хэсгээр нь болохоороо зарлагаа хаагаад, энэ

хэсгийг нь танайх аваад, энэ хэсгийг нь манайх аваад, тэгээд дээр нь роялти өгье ч гэдэг юм уу ийм байдлаар гарч ирж байгаа. Бүтээгдэхүүн дээр гэсэн үг. Гэтэл одоо манай 2 зөрчил үүсчхээд байгаа нь болохоороо ашгаас нь авдаг буюу зарлагаа тооцож гаргасны дараа, орлогоо тооцсоных нь дараа ашгаас нь татвар авдаг ийм 2 зөрчил гарчхээд байгаа юм.

Тэгээд компани болохлоороо өөрөө юу гэж хэлээд байна гэхээр та нар Монголын төр байгуулсан гэрээгээ бариач ээ л гэдэг ийм асуудал үүсчхээд байгаа юм. Бид бол энийг ажлын хэсэг дээр ярьж байгаад ямар байдлаар шийдэж болох вэ гэхээр нэгэнт манай татварын байгууллага татвараа ногдуулчихсан юм чинь энэ авах ёстой актын төлбөрүүдээ татвараа авъя. Энэ авсан төлбөрүүдээ нөгөө талдаа бол бүтээгдэхүүн хуваах гэрээнд нь тооцож суутгая л гэдэг зүйл ярьж байгаа юм.

Хуулийг нарийн үзэх юм бол тэр дотроо .../минут дуусав/

С.Бямбацогт: Санжаадорж дарга гүйцээгээд хариулчихъя. 4.

М.Санжаадорж: Тэгээд хуулийг та үзэх юм бол хууль дээр ингэжхээд байгаа юм. Татварын ерөнхий хууль дээр болон тэр дагаж байгаа хуулиуд дээр юу гэж заасан байна гэхээр жил болгоны Төсвийн тухай хуулиар зохицуулна гэххээд байгаа юм. Тэгэхээр тухайн жилд нь одоо үүсчхээд байгаа тэр 700 гаруй тэрбум төгрөгийг жишээ нь 2027 оны төсөв дээр бид нар яаж орж ирэх вэ гэхээр 200 тэрбум байх нь уу, 300 тэрбум төгрөгийг нь одоо бид нар татварын актаа авъя. Энийгээ болохоор бүтээгдэхүүн хуваах гэрээний тэр тохиролцсон гэрээний зүйлдээ нөхөн төлүүлэе, суутгая гэдэг ийм байдлаар хуулийн төсөл орж ирчхээд байгаа юм. Тэгэхээр жил болгоны төсвөөр орж ирнэ. Тооцоолол бол 3 жил орчим үргэлжлэх болов уу гэж бодоод байгаа юм. 1 дэх нь энэ.

2 дахь нь бол одоо үргэлжилж байх хугацаанд дахиад нэгэнт акт тавьчихсан юм чинь дахиад үргэлжлээд татварын байгууллага маань акт тавиад байж магадгүй болчхоод байгаа юм. Тэгэхээр энэ асуудлыг шийдэхийн тулд энэ гэрээг бол дахиж акт тавихгүй байхаар тооцоод, олон улсын гэрээтэй тэрийг зүйрлэе гэдэг байдлаар адилтган үзэх байдлаар бас хуулийн заалт .../минут дуусав/

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Увс аймгийн ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2006 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төгсөлтийнхөө 20 жилийн ойг тэмдэглэж, Төрийн ордонтой танилцаж байгаа та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн асуултаа асууя.

Д.Жаргалсайхан: Хуульд өөрчлөлт орж байгааг бол дэмжиж байгаа. Ер нь орон нутагт үйл ажиллагаа явж байгаа аж ахуйн нэгжүүд бас орон нутгийнхаа иргэдтэй, засаг захиргааныхаа байгууллагатай харилцаа хамтын ажиллагаагаа сайжруулж явах нь аль аль талдаа зөв байгаа юм. Тэгэхгүй бол тэгээд л баахан хариуцлагагүй уул уурхай, дээрээс нь тэгээд л ард иргэддээ хүндрэл учруулаад л, нөлөөлөл учруулаад л ийм байдлаа бол аж ахуйн нэгжүүд бас энэ иргэдтэйгээ ойлголцоод явах нь зөв. Тэгээд тийм ч учраасаа яг Матад сумд очиход нөхцөл

байдал бол хүнд байдаг л даа. Тэгээд үүнтэй холбоотой бол хууль орж ирж байгааг бол дэмжиж байгаа.

Энэ хуулийн өөрчлөлтөөр бас хэд хэдэн зүйлийг бол анхаармаар байгаа юм. Ер нь манай энэ газрын тосны үйлдвэртэй холбоотой бас сая Дамдинням сайд хэлж байна л даа. ТЭЗҮ байхгүй байсан гэж. Энэ үнэн л дээ. Ер нь бид нар бол юмыг их нууж ирлээ. Харин та хэлж байгаа нь сайн байна.

Үнэхээр энэ газрын тосны үйлдвэр бол эхнээсээ маш буруу эхэлсэн. ТЭЗҮ байхгүй, ажлын дараалал байхгүй. Жишээ нь үйлдвэр нь баригдаагүй байхад ажилчдынхаа барилгыг бариад дуусгачхаж байгаа байхгүй юу. Дорноговь аймагт ажилчдын байр гээд баригдчихсан шүү дээ. Орон сууц баригдчихсан шүү дээ. Жишээ нь энэ төсөл дээр нь би бас ЗХЖШ-т ажиллаж байсны хувьд ажиллаж байсан. Зэвсэгт хүчний ангиуд ажиллаж байсан юм. Ингээд барилгаа бариад дуусчхаж байгаа юм. Одоо нөгөө барилга нь ажилчид нь байхгүй, үйлдвэр нь ашиглалтад ороогүй хэдэн жил болж байгаа. Ингээд ашиглахгүй болохоор эргээд нураад эхэлдэг. Ямар ч эд материал тэгээд эзэнгүйдээд эхэлж байгаа юм. 1 дэх асуудал.

2-т нь Матад сум руу Аж үйлдвэрийн парк буюу тэр Дорноговь аймгийн Алтанширээгээс төмөр зам тавина. Төмөр замаар яах гэж байгаа вэ гэхээр нөгөө түүхий эдээ зөөх гэж байгаа юм. Гэтэл хэдхэн хоногийн дараа ажил нь эхэлчихсэн, Зэвсэгт хүчний ангиуд гарчихсан төмөр замаа тавих гээд ингээд ажил нь эхэлчихсэн байж байхад сольчихож байгаа юм. Хоолой байна гээд ингээд л сольчихож байгаа юм. Ийм том төсөл дээр ийм байдлаар ажил хийнэ гэдэг бол үндсэндээ удаашрахын хэлбэр. Үнэ өртөг нэмэгдэхийн хэлбэр. Ийм л юм болж байгаа юм.

Тэгэхээр би юу гэж хэлэх гэж байгаа вэ гэхээр энэ төслийн баг, менежментийг хариуцаж байгаа баг дээр та бүхэн маань юу гэж боддог юм бэ. Харж байгаагаар бол ерөөсөө өөрчлөлт, шинэчлэлт хийгдэхгүй яваад байгаа юм. Би бол энэ үйлдвэр хурдхан шиг ашиглалтад ороосой гэж залбирдаг хүн. Импортынхоо хамаарлаас ч гэсэн Монголын ард түмэн, төр ч гэсэн жоохон ч гэсэн хувиар багасаасай. Шатахууны ийм өндөр өртөгтэй явж байгаа. Үүний цаана бол бүх бараа бүтээгдэхүүний үнэ өсөж байна шүү дээ. Ард түмний амьдрал өдөр ирэх тусам дордож байна шүү дээ. Тэрэнд нь бас нэг нэмэр болоосой гэж ингэж боддог. Тэр ч үүднээсээ тэр гадаад зээлийн ашиглалтыг сайжруулах дээр тэр тусмаа газрын тосны үйлдвэрийг дуусгах тэр зээлийн хуулийг бол дэмжсэн. Энэ дээр бол нэлээн голлох үүрэгтэй бас бүлгийн хурал дээрээ дэмжих талаар саналаа бол хэлж байсан. Тэгэхээр энэ тал дээр та бүхэн маань ямар бодолтой байдаг юм. Энэ төслийг хурдан дуусгахын тулд ямар байдлаар бас энэ дээр өөрчлөлтийг хийхийг зорьж байна. 1 дэх нь энэ.

2-т нь бид нар үйлдвэр ашиглалтад орчихлоо. Түүхий эдээ бол энэ Петрожайна дайчин тамсаг компаниас компаниас авах юм байна. Гэтэл эдний олборлож байгаа нь жилд 200 мянган тонн. Үйлдвэр маань 1 сая. Олборлолтыг яаж сайжруулах юм. Тэр аж ахуйн нэгжээ шахах юм уу, эсвэл өөр ордоос бид бүхэн түүхий эдээ зөөх гэж байгаа юм уу гэсэн ийм 2 дахь асуулт.

Ер нь цаашдаа бид нар энэ ТЭЗҮ-г батлах, төсөвт өртгийг яг тодорхой болгох энэ процессоо яаж сайжруулах юм. Дамдинням сайдын хэлж байгаагаар бол ТЭЗҮ-

гүй ажил эхэлчихсэн байна шүү дээ. Тэгээд явцын дунд ингээд бүх ажлууд нь өөрчлөгдөөд байдаг, дараалалгүй байгаад байдаг. Аж үйлдвэрийн байнгын хороо гэж байсан. Энэ Байнгын хорооноос ажлын хэсэг очиж ажилласан. Газрын тосны .../минут дуусав/

С.Бямбацогт: Хэн хариулах вэ. Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Жаргалсайхан гишүүн бас ажиллаж байсан. Ер нь бол 1 дүгээрт юу байгаа юм. Манай Улсын хувьд бол 2 дахь үйлдвэр. Бид нар бас өмнөх түүхээ үгүйсгээд байж болохгүй. Бид нар 1941 оноос эхэлж олборлолт хийж байсан улс. Тухайн үедээ бас Дорноговь аймгийн Зүүнбаянд бас дотоодын хэрэглээнийхээ 20 хувийг хэрэглэдэг, гаргачихдаг тийм үйлдвэртэй байсан. Тэгээд бас осол аваар болоод зогсоосон юм байна лээ. Энэ үйлдвэр нэлээн масс хэмжээний том үйлдвэр. Ер нь хамгийн комплекс, хүнд үйлдвэр шүү дээ. Газрын тосны том цогцолбор үйлдвэр бол. Тэгэхээр бас мэдэхгүй, чадахгүй юм их байсан юм байна лээ тухайн үедээ. Хөөрхий. Тэгээд одоо бол манай яаманд ТЭЗҮ-г анх 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр баталж, хүлээж авсан юм байна лээ. 2019 он. Дараа нь 2023 оны 10 дугаар сард бас дахиж тодотгож авсан байгаа юм. 2 удаа тэгж авсан ийм мэдээлэл байдаг.

Тэгээд таны хэлээд байгаа тэр орон сууцыг бол ашиглаж байгаа. Эзэнгүй хаяагүй. Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрийн барилга барьж байгаа аж ахуйн нэгжүүдийн компанийн зардлыг бууруулж, тэдгээр мэргэжилтнүүд амьдарч байгаа. Тэгээд тэндээс бас орлого олоод байгаа. Энд чинь бас 3500 орчим хүн ажиллаж байна. Сая Гадаад зээлийн ашиглалтын тухай хуулийг та хэд маань бас батлаад өглөө. Ойлгоод. Тэр бас хязгаар байсан шүү дээ. Гадаад зээлийг орлого талдаа бүртгээд, зарлага талдаа бүртгэхчхээд зэрэг жилдээ 60, 70 сая доллароор л ажил хийдэг. Илүү ажил хийх боломж байдаггүй. Зээл нь байгаад байдаг, ажил нь байгаад байдаг, хугацаа яваад байдаг. Тэгээд энийг бас сая чөлөөлж өгсөн учраас энэ жилээс бол ажлын тоо хэмжээ эрс нэмэгдэж байна. Менежмент шал өөр болж байна. Тэр ажиллаж байгаа хүмүүс чинь хөөрхий бас санхүүжилт нь байхгүй байгаад байгаа учраас ажил нь явахгүй байгаад байсан байхгүй юу. Манай нөгөө төсвийн тухай хуулиар хязгаарлалттай байгаад байсан. Сая энийг нь аваад өглөө. Тэгээд ямар ч ажиллах боломж, санхүүгийнх нь боломжийг нь гаргаж өгөхгүй байж ажлаа хийсэнгүй гээд шахаад авах бас жоохон учир дутагдалтай байсан л даа. Тэгээд одоо бол яг ийм байгаа шүү дээ. Нийт ажлын тоо хэмжээ бол 50 хувь гараад явчихсан. Олгосон санхүүжилт нь 20-оод хувьтай явж байгаа. Санхүүжилтийг нь бүтэн өгөхгүй ингээд гүрийлгээд л явж байсан байхгүй юу. Тэгэхээр бас манай энэ хууль, эрх зүйн орчин зохицуулалттай холбоотой асуудлуудаас болж удааширсан юмнууд бас байгаа. Энийгээ бас бид нар хаа хаанаа ойлгож, сая засаж янзаллаа. Тэгээд одоо бол хурд нэмэгдэж байгаа. 2028 ондоо оруулна гээд нэлээн итгэлтэй байна. Суурийн ажлууд ер нь бүрэн дууссан. Одоо технологийн байгууламжууд захаасаа ирээд угсрагдаад явж байна.

С.Бямбацогт: Жаргалсайхан гишүүн тодруулж асууя. Менежментийн багтай холбоотой Газрын тосны газар хэн хариулах вэ. “Эрдэнэс Монгол”-оос байна уу. Жаргалсайхан гишүүн тодруулъя.

Д.Жаргалсайхан: Тэгээд сая яам бол хэлж л байна л даа. Мөнгөгүй, мөнгөө өгч чадахгүй гээд. Яг гол юм чинь үйлдвэр шүү дээ. Тэгэхэд мөнгөгүй байсан хэр нь

ажилчдынхаа барилгыг барьчихсан л байгаа байхгүй юу. Яагаад ийм дараалалд алдаа гаргаж байгаа юм бэ л гэж асууж байна шүү дээ. 1 дэх асуудал.

2-т нь ингээд ТЭЗҮ батлагдаагүй байхад яагаад бид нар зээл авдаг юм. ТЭЗҮ батлагдаагүй байхад яахаараа ийм ажлууд эхэлдэг юм. Яагаад мөнгө зарцуулдаг юм бэ л гэж асууж байна шүү дээ. Бид нар чинь бас олон улсын стандарт, норм дүрэм зээл авч байгаа бол бас тэр зээлийг чинь юунд зарцуулах гэж байгаа юм гээд ТЭЗҮ үзүүлэх ёстой шүү дээ. Бид нар яагаад эхнээсээ яг ийм ТЭЗҮ-гүй гэрээ байгуулсан юм.

3-д нь болохоор тэр барилга гээд. Одоо яг барилгыг ямар хүмүүс ашиглаж байгаа юм. Энийг асуучихъя. ТЭЗҮ батлагдсан байх гээд ярьж байна. 2021 оны 06 сард Зэвсэгт хүчний ангиуд гарчихсан байсан юм. Тэгэхэд энэ чинь 2019 онд ТЭЗҮ нь батлагдсан байсан. ТЭЗҮ гэдэг чинь юуг шийддэг вэ гэхээр төмөр замаар явах уу, хоолойгоор явах уу гэдгээ шийдчихсэн байдаг байхгүй юу. Тэгэхээр яагаад энэ ТЭЗҮ-г өөрчилсөн юм.

С.Бямбацогт: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Энэтхэг Улс Монгол Улсыг бодлогоор дэмжээд, төрийн дээд хэмжээний айлчлалын хүрээнд тэрбум долларын зээл өгье гэж, нэн хөнгөлөлттэй зээл өгье. Та нар улс орондоо хэрэгтэй бодлогынхоо төсөл хөтөлбөрөө санхүүжүүлээрэй гээд. Монгол Улс ярьж байгаад газрын тос боловсруулах үйлдвэр барья. Энийг ашиглая л гэж. Ингээд зээл тохирч байгаа юм. Ажил эхлээд, ТЭЗҮ, зураг төсөл явагдаад ирсэн. Өртөг бол 1,7 дээр гарлаа гэж. Ингээд Энэтхэгийн талд бас дахин асуудлаа тавиад, нэмэлт зээлийн асуудал шийдэгдээд явж байгаа л зүйл шүү дээ.

Тэр байрны тухайд бол үйлдвэр барихын тулд хүмүүс очиж байгаа. Би бол түрүүлээд тэр байр барьсан нь зөв гэж үздэг хүн байхгүй юу. Байр барьж байж тэр байранд хүн очиж, тэр хүйтэн сэрүүн бүсэд очиж байж тэр хаврын хавсрага дотор тухтай орон сууцад амьдарч байж ажлаа явуулах нь дээр болов уу. Одоо тэр байр бүрэн ашиглалттай .../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя. Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Тэр байранд одоо тэр ажиллаж байгаа инженер, техникийн ажилчид бүгд байрлаад, ажлаа хийж байна.

2 дугаарт бүтээгдэхүүн, газрын тос нийлүүлж яах вэ гэж. Нэгэнт Зүүн бүсийн сав газар маань жилдээ 1 сая 400 мянган тонн олборлож байсан. ТЭЗҮ үндэслэл нь 1 сая 400-аас буухгүйгээр ашиглана гэдэг ийм тооцоо байгаа. Бодитой байгаа, боломж байгаа, нөөц байгаа. Эрх зүйн орчин ойлгомжгүй байдал үүсээд 200 мянган тонн руу уначихсан байхгүй юу. Одоо буцаагаад энэ асуудлаа шийдсэний дараа нөгөө үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд олборлолтоо нэмэгдүүлээд, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлээд явъя. Яагаад гэвэл эд нар олборлолт хийх тусам татварын акт, нөгөө торгууль нь нэмэгдэх гээд байдаг. Ингээд бүх юмыг агшаачихсан байхгүй юу. Тэгээд та энэ асуудлыг Монгол Улс шийдвэл бид нар хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлээд, олборлолтоо нэмэгдүүлээд явна л гэж байгаа юм. Энэ дээр чинь гэрээ байгаа шүү дээ. Монгол Улс газрын тос боловсруулах

үйлдвэр баривал түүхий эдээр эн тэргүүнд хангана гэсэн үүрэгтэй ийм гэрээтэй байгаа байхгүй юу. Тэгэхээр бид ажлаа хурдлах хэрэгтэй.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, дэмжээгүй байр суурьтай гишүүд урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу үг хэлнэ. Сархадын Зулпхар гишүүн. Индрийн 1 дүгээр микрофон.

С.Зулпхар: Их Хурлын дарга, эрхэм гишүүдийнхээ дахин амгаланг айлтгая. Газрын тос бол манай улсын бие даасан байдлыг бэхжүүлэх гол үндсэн стратеги. Энийг та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа учраас энийг би бас энэ индэр дээрээс дахин тэмдэглэж байна.

Нөгөөтээгүүр эдийн засгийн хөгжлийн үндэс нийгмийн сайн сайхан байдлыг бий болгох гол үндсэн жишээ нь арга зам хөшүүргийг бий болгодог энэ нөөц гэж ойлгох ёстой. Энэ улс орнуудын хөгжил ч гэсэн бас энэ дээр суурилсан байдлаар өнгөрсөн 100 гаруй жилийн хугацаанд бол явж ирлээ. Энэ үүднээс өнөөдрийн бидний энэ хэлэлцэх гэж байгаа хууль буюу Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль бол өөрөө бас онцгой ач холбогдолтой хуулиудын 1 гэдгийг та бүхэн бас мэдэж байгаа байх.

Ойрын хугацаанд дэлхийн геополитик бол эрчимтэй өөрчлөгдсөн, янз янзын бас зөрчлүүд байх шиг байна. Тэрний цаана жишээ нь 3 үндсэн хүчин зүйл байгаа гэж бас судлаачид хэлж байгаа юм.

1 нь бол цэвэр эрчим хүчний өрсөлдөөн,

2 дахь нь бол худалдааны өрсөлдөөн,

3 дахь нь усны эрхийн төлөөх өрсөлдөөн явж байна гэж. Тэгээд цаашдаа ч гэсэн энэ өрсөлдөөн бол үргэлжлэх байх.

Нөгөөтээгүүр бидний хувьд бидэнд байхгүй нөөц, бидэнд байхгүй жишээ нь нөхцөл байдал бол дандаа бидний сул тал байдаг бол газрын тосны үйлдвэр бидний сул талыг даван туулах гол үндсэн стратеги. Энэ үүднээс нь газрын тостой холбоотой эхэлсэн үйлдвэрийн жишээ нь том бүтээн байгуулалтыг бид тал талаар нь дэмжиж байгаа. Цаашдаа ч гэсэн дэмжих ёстой гэж байгаа юм. Ганцхан тоо бидэнд бас хэлнэ. Жил болгон бид нар 2 тэрбум ам.долларыг дан ганц жишээ нь энэ газрын тосны бүтээгдэхүүн худалдаж авахаар гадагшлуулж байгаа. Төдий хэмжээгээр манай эдийн засгаас валют гадагшилж байгаа гэдгийг та бүхэн мэдэж байгаа байх.

Нөгөөтээгүүр аливаа хөрөнгө оруулалт 2 тал бол эрх тэгш, харилцан ашигтай байх ёстой бол үүнтэй уялдсан бас бэрхшээлүүд, сорилтууд байгаа бол бид энийг давах ёстой. Бид энийг зөвхөн болох талаас нь ярих ёстой болохоос биш болохгүй зүйлийг нь байнга яриад байвал бас болно. Гэхдээ болохгүй зүйлийг нь бид яаж шийдэх вэ, гэхдээ эрх тэгш, харилцан ашигтай байдлаар гэдэг талаас нь энэ хуулийн төсөл орж ирж байна гэдгийг бол тэмдэглэмээр байна. Гэхдээ цаашид бас анхаарах ёстой зүйл бол бий. Геологийн хайгуул хийхгүйгээр болохгүй. Саалиа

бэлтгээд саваа бэлд гэсэн Монгол үг байдаг бол одоо бид эсрэгээрээ саваа бэлдэж байгаа бол саалиа давхар бэлдэх ёстой болчихлоо л гэсэн үг. Нөөц нь байхгүй бол энэ үйлдвэр чинь ажиллахгүй учраас энийг бас гишүүд бол хэлж байна.

2 дахь зүйл бол үйлдвэрийг тогтсон хугацаанд нь бас ашиглалтад оруулах ёстой. Энэ удах тусмаа бол өртөг нь нэмэгдэж байна. Төдий хэмжээгээр бидэнд бол өр нэмэгдэж байна. Яаралтай шуурхай оруулах талаас нь ажиллах ёстой. Үүнтэй уялдсан байдлаар сая бас хэлж байна. Энэ үйлдвэрийг чинь хүн ажиллуулдаг учраас хүнээ бэлдэхгүй бол маргааш бас гаднынхныг царайчлаад сууж байж болохгүй. Менежмент нь мэдээж хэрэг гаднынхан нь эхлээд туслах байх. Яваандаа энэ менежментийг бид өөрсдөө аваад явах, үйлдвэрийн техник технологийн ажилтнууд, инженерүүд, жишээ нь бүгд манай дотоодын мэргэшсэн ажиллах хүчин байх бүрэн боломжийг бас эрэлхийлэх ёстой. Тогтвортой үйл ажиллагааг нь бид бас анхаарах ёстой.

Төгсгөлд нь мэдээж хэрэг орон нутгийн иргэдийн эрх ашгийг бид заавал хангах ёстой. Одоо орон нутгийн иргэдийн эрх ашиг бол тэр байгалийн баялгаас үр өгөөжийг нь хүртэх л тухай асуудал шүү дээ. Энэ чинь Үндсэн хуулиар тогтсон өөрийнх нь эрх нь, цаашлаад орон нутгийн өөрт нь байгаа тэр байгалийн баялгийг бол илүү хүртэх эрх нь бол одоо орж ирж байгаа энэ ашигт малтмалын хуулийг дагуулсан хууль дээр бас зохих хэлбэрээр орж ирж байх шиг байна. Бадамсүрэн гишүүн бол АМНАТ-өөс орон нутагт зохих түвшинд хүртэх энэ эрхийг нээгээч гэж байна. Би бол хувьдаа бол энийг дэмжиж байна. Бүхий л тал бол ашигтай, үндсэндээ Монгол Улсын хөгжилд ашигтай, Монгол Улсын хөгжил стратегийн үндэс болсон шийдэл болох ёстой гэдэг үүднээс эрхэм гишүүд та бүхэн энэхүү хуулийг бас дэмжиж, яаралтай шийдэж, шийдвэр гаргаж өгөхийг би хүсэж байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Зулпхар гишүүнд баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалтыг 17 цагт нэгтгэн явуулна. 17 цагт гишүүд санал хураалтад бэлэн байна шүү. 5 санал хураалт байна. Санал хураалтыг хойшлууллаа.

11.58 цаг.

Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатарын урилгаар Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын Сэтгэл зүйн тэнхим төслийн хүрээнд ажиллаж байгаа Бүгд Найрамдах Солонгос Улсын Мён жи их сургуулийн багш, оюутнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Хүрэлцэн ирсэн эрхэм зочдодоо Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Монгол Улсад тавтай морилно уу. Цогтбаатар гишүүн энэ байж байна. Гараа хөдөлгөөд харуулаарай. Их хөөрхөн охид ирж байна.

Дараагийн асуудалдаа орёе.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Доржсүрэнгийн Үүрийнтуяа танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Д.Үүрийнтуяа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг 2026 оны 06 сарын 18-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 06 сарын 24-ний өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Сэддорж уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн өмчийн компаниуд, тухайлбал аймгуудын ДЦС-ыг нүүрсээр хангадаг компаниудын хэвийн, тогтвортой үйл ажиллагааг хангах зохицуулалтыг хуулийн төсөлд хэрхэн тусгасан талаар, Улсын Их Хурлын гишүүн Мандхай хуулийн төслийн нэрээс бүтээмж гэдэг агуулга хасагдсан нь бодит үр ашиг, хөдөлмөрийн бүтээмж, хөрөнгийн өгөөжийн алдагдал гэх мэт үндсэн хэмжих үзүүлэлт нь өөрөө тодорхойгүй болж байгаа бөгөөд яагаад хасагдсан талаар, мөн төрийн өмчийн компанийн хувьцааг нийтэд санал болгох үед компанийн үнэлгээг хэн, ямар аргачлалаар, ямар хараат бус, хяналттайгаар зохион байгуулах талаар асуулт асууж, үг хэлсэн болно.

Байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д зааснаар хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулахаар өгсөн чиглэлийн хүрээнд зарчмын зөрүүтэй 20 санал, мөн хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн 5 зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Эдийн засгийн байнгын хорооны хурлаар хэлэлцүүлсэн. Үүнд хуулийн төслийн нэрийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын тухай хууль байхаар өөрчлөх, төрийн болон орон нутгийн өмчит компанийн 34-100 хүртэл гэснийг 1/3-ээс гэж өөрчлөн өмчлөлийн ангиллыг компанийн эрх зүйн зохицуулалттай нийцүүлэн төрийн болон орон нутгийн өмчит компанийг үйл ажиллагааны зорилго, чиг үүргээс нь хамааруулан арилжааны эсхүл нийтийн үйлчилгээний гэж ангилах, ногдол ашгийн бодлогыг бүхэлд нь шинэчлэн найруулж төрийн болон орон нутгийн өмчит компаниуд ногдол ашиг хуваарилахдаа аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэх, компанийн хөрөнгө оруулалтын хэрэгцээ, мөнгөн урсгал, санхүүгийн тогтвортой байдал болон нийтийн үйлчилгээний үүргийг харгалзан үзэх зохицуулалтыг тусгах, мөн арилжааны зорилготой ТӨК-ийн хувьд хуваарилж болох цэвэр ашгийн 30-аас доошгүй хэмжээгээр ногдол ашиг хуваарилах зарчим тогтоож, тодорхой үндэслэл бүхий тохиолдолд уг хэмжээг бууруулах боломжийг бүрдүүлэх, харин нийтийн үйлчилгээний чиг үүрэгтэй компанид энэхүү доод босго хамаарахгүй байх. Мөн ТУЗ-ийн хараат бус байдлыг бэхжүүлж, хараат бус гишүүдийн оролцоо болон нээлттэй сонгон шалгаруулалтын зохицуулалтыг боловсронгуй болгох, ТӨК-ийн аудит,

хяналтын тогтолцоог шинэчилж, төрийн аудит болон хөндлөнгийн аудитын зохицуулалтыг тодорхой болгох, төрийн болон орон нутгийн өмчит компани нь энгийн хувьцаа нэмж гаргах, дотоодын болон гадаадын хөрөнгийн зах зээлд санал болгох, давхар бүртгэл хийх, төрийн эзэмшлийн хувьцааг арилжих эрх зүйн үндсийг нарийвчлан зохицуулах, түүнчлэн хувьцааг нийтэд санал болгох ажиллагааг компанийн өрсөлдөх чадвар, ил тод байдал, засаглалыг сайжруулах, иргэд болон хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх зорилготой уялдуулж хувьцааны төвлөрлөөс сэргийлэх, хөрөнгө оруулагчдын ангиллыг тогтоох, стратегийн ач холбогдол бүхий төрийн өмчийн компанийн хувьцааг худалдах асуудлыг Улсын Их Хурлаар шийдвэрлэх зохицуулалтыг тусгах, мөн ажилтанд олгох опцион эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийг шинээр бий болгох, хуулийн шинэ зохицуулалтыг хэрэгжүүлэх шилжилтийн хугацааг тогтоож ТУЗ-ийн шинэчилсэн шаардлагыг төрийн болон орон нутгийн өмчит компаниудад үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгах, мөн орон нутгийн өмчит хуулийн этгээдийг хуульд заасан шаардлагад нийцүүлэн авах арга хэмжээг 2028 оны 01 сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлэх.

Байнгын хороо нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж, олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналыг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тусган хууль зүйн техникийн засвар өөрчлөлтийг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон зарчмын зөрүүтэй саналыг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Эдийн засгийн байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Үүрийнтуяа гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя.

Сандагийн Магнайсүрэн Монгол Улсын Ерөнхий аудитор, Дорждэрэмийн Цолмон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, Болдын Цэнгэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Сүхээгийн Тэнгис Монгол Улсын Ерөнхий сайдын Засаглал, цахим бодлого хариуцсан зөвлөх, Буянтогтохын Бундхорол Үндэсний аудитын газрын Тамгын газрын дарга, тэргүүлэх аудитор, Бат-Эрдэнийн Төрбат Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ахлах референт, Цэрэндаваагийн Баяр-Эрдэнэ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга, Даваахүүгийн Нарангэрэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга, Жаргалсайханы Мөнх-Оргил Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Батсуурийн Ариунзаяа Үндэсний аудитын газрын хуулийн менежер, Ганхуягийн Давааням МУИС-ийн багш, доктор, Сарангэрэлийн Батбаяр МУИС-ийн багш, доктор, Балжиннямын Гэрэлээ

“Эрдэнэс Монгол” компанийн Мэргэжлийн нэгдсэн зөвлөлийн зохицуулагч, Очирсайханы Баярмагнай “Эрдэнэс Монгол” компанийн Ерөнхий аудитор.

Ажлын хэсэг Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандаж, Их хурлын гишүүдийн асуусан асуултад үнэн зөв, бодитой хариулт өгөх ёстой, гүйцэд хариулт өгөх ёстой. Худлаа мэдээлэл өгөх, дутуу мэдээлэл өгөх, асуултад хариулахаас зайлсхийх, Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд хүрэлцэн ирэхгүй бол холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээдэг болохыг та бүхэнд сануулъя. Тэгэхээр Их Хуралд бас хүндэтгэлтэй хандаж, асуултад товч, тодорхой, гүйцэд хариулахыг та бүхэн хичээгээрэй гэдгийг сануулъя.

Ингээд гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Наранцэцэгийн Алтаншагай гишүүн алга байна. Отгоны Саранчулуун гишүүн алга байна. Батын Батбаатар гишүүн алга байна. Нанзадын Наранбаатар гишүүн алга байна. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн алга байна. Өлзийхүүгийн Шижир гишүүн асуултаа асууя.

Ө.Шижир: Өдрийн мэнд хүргэе. Уг нь бол энэ Компанийн тухай хуулиар зохицуулах харилцаа юм байгаа юм л даа. Тэгээд төр нь өөрөө ингээд төрийн өмч дээрээ тусдаа компани байгуулчихдаг. Хувийн хэвшилд тусдаа хууль гаргачихдаг. Хувийн хэвшил дээрээ дахиад тусдаа хуультай. Тэгээд 2 өөр хуулийн зохицуулалтаар 2 төрлийн бизнесийн байгууллагууд яваад байдаг ийм ойлгомжгүй байдал бий болоод байгаа юм. Уг нь бол төр өөрөө ийм ялгавартай байдлыг бий болгож өгч болохгүй гэдгийг би байнга хэлж байгаа. Тэгтэл ингээд хуулиар бас ялгавартай байдлыг бий болгож өгөөд байгаа юм. Тэгээд нөгөө төр, хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчим гэх мэт зүйлүүд нь бас энэ хууль дээр ерөөсөө харагдахгүй байгаа юм.

Тэгээд хэдүүлээ нийтдээ хараад үзье л дээ. Нийтдээ төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд гээд харахаар нийтдээ 465 аж ахуйн нэгж байгаа юм. 465 аж ахуйн нэгж дээр 67.596 хүн ажиллаж байгаа юм. 67.596 хүний ажиллаж байгаа энэ юу өөрийн хөрөнгө нь 143 их наядын хөрөнгөтэй байгаа байхгүй юу. Тэгээд төр чинь өөрөө ийм их том, ДНБ-ий 74 хувийг үйлдвэрлэдэг. Тэгээд нөгөө талдаа энэ яагаад ингээд байна вэ гэхээр сайд нар чинь эрх мэдлээ булаацалдаад байна. Энд чинь 1 ч сайд байхгүй байна шүү дээ. Идэрбат сайдаас өөр хүн байхгүй байна шүү дээ. Ингээд сайд нар чинь яагаад эрх мэдлээ булаацалдаад байдаг юм гэхээр төрийн өмчит компаниудаар далимдуулаад томилгоо хийдэг байхгүй юу даа. Одоо томилгоо хийгээд яадаг вэ гэхээр тэндээс хамгийн өндөр цалинтай, хамгийн өндөр орлоготой хүмүүс дээрээ өөрийнх нь намын төлөөний хүмүүсийг тавьдаг юм. Одоо хамгийн сүүлийн жишээ гэхэд Дархан төмөрлөгийн үйлдвэр дээр эрх барьж байгаа намын залуучуудын байгууллагын нарийн бичгийн дарга очсон. Ямар өрсөлдөх чадвараар энэ залуу очсон бэ гэдэг асуулт байгаа юм. Тэгээд энэ хууль батлагдаад би бол нөхцөл байдал сайжирна гэж итгэхгүй байна. Энэ бол улам дордоно. Нэг ийм нөхцөл байдлууд дээр бид нар өөрсдөдөө 1 дүгээрт дүгнэлт хийх хэрэгтэй байгаа юм. Одоо зөвхөн энэ төрийн өмчийн оролцоотой 102 аж ахуйн нэгжүүд чинь 40 нь 10 саяас дээш төгрөгийн цалинтай байгаа шүү дээ. Гүйцэтгэх захирлууд нь. Тэгээд үр дүн нь хэр байгаа юм, үр ашиг нь хэр байгаа юм гээд явдаг.

Төрийн өмчит компаниудыг дагаад дандаа авлига, албан тушаал яригддаг, төрийн өмчит компаниудыг дагаад дандаа улс төрийн намуудын сонгуулийн санхүүжилт явагддаг. Төрийн өмчит компанийн захирлууд нь сонгуульд нэр дэвшихдээ тухайн компанийн маркетингийн зардлаар ингээд зарлал хийлгэдэг. Хэдүүлээ сая татан буугдаад нэрийг нь өөрчилсөн “Эрдэнэс Монгол” нэгдэл Чингис хаан хөгжлийн корпорац болчихсон энэ. Ингээд харахад зөвхөн 2024 онд борлуулалт, маркетингийн зардал нь 3,2 их наяд төгрөг гарсан байгаа шүү дээ. 2025 онд 2,5 их наяд. Гэтэл Эрдэнэт үйлдвэрийн зэсийн баяжилт, Эрдэнэс Тавантолгойн нүүрсийг маркетингийн сурталчилгаа хийх ямар ч шаардлага байхгүй. Энэ өөрөө хүссэн, хүсээгүй хэдэн жилээр хүлээгдээд, зах зээл нь бэлэн байж байгаа. Ерөнхий удирдлагын зардал нь 2024 онд 400 тэрбум. Та нар бод доо. 400 тэрбум. 2025 онд 451 тэрбум. Менежментийн төлбөр нэрээр 2023 онд 170 тэрбум төгрөг цуглуулсан. Энэ Чингис хаан Үндэсний корпорац. Захирал нь сарын 20 мянган долларын цалинтай. Жишээ нь “Эрдэнэс Монгол” корпорац энгийнээр ярих юм бол ямар ч үйлдвэрлэл явуулдаггүй. Доороо Засгийн газрын тогтоолоор байгаа хэдэн аж ахуйн нэгжүүдээсээ менежментийн төлбөр нэрээр авдаг. Тэгээд маш их хэмжээний юугаар татан буулгадаг. Ийм хөрөнгийн үр ашиггүй зарцуулалтыг хохирлыг нь хэн хариуцах юм. Шийдвэр гаргасан Засгийн газар нь хариуцах юм уу. Эсвэл тухайн удирдаж байгаа албан тушаалтнууд хариуцах юм уу. Бид нар ингээд төрийн өмч л болохоор яаж ч өөрчилж болдог, нэрийг нь яаж ч өөрчилж болдог. Энэ чинь нэр өөрчлөхөд алдагдаад бичиг баримт, бланк гээд бүх юм чинь өөрчлөгдөөд, энийг чинь дагаад л зардал гарна шүү дээ. Тэгээд ийм юмнууд ерөөсөө бид нар нэг юугаар харахгүй бол одоо та хэд маань ёстой нээрээ хүний юманд хандаж байгаа юм шиг л хандаж байна шүү дээ.

Тэгээд 1 ийм сайхан гоё нэртэй хууль оруулаад ирдэг. Тэгээд яагаад аудитыг нь бас аваад хаячхав. Төрийн өмчит компаниудад яагаад Төрийн аудитын газар аудит хийх боломжгүй, тухайн компанийн ТУЗ-ийн гишүүд аудитын компани сонгох боломжтой ийм хуулийн төсөл оруулаад ирэв. Тухайн компанийн ТУЗ-ийн гишүүд эрх барьж байгаа намын томилгоогоор томилогдож байгаа шүү дээ.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч хариулъя. Эцсийн хэлэлцүүлэг явж байгаа учраас Эдийн засгийн байнгын хорооны дарга, эсвэл ажлын хэсгийн ахлагч хариулна. Манай Үүрийнтуяа, Сайнзориг нарын гишүүд ахалж ажиллаж байгаа. Сайнзориг гишүүн бас нэмж хариулж болно. Хэн хариулах вэ. Үүрийнтуяа гишүүн хариулъя.

Д.Үүрийнтуяа: Төрийн компани хувийн компанийн хууль, эрх зүйн орчин ялгаатай байдаг олон улсын жишиг, хууль, эрх зүйн зарчим байдаг юм байна лээ. Энэ дээр Сайнзориг гишүүн бас хуульч хүний хувьд тодорхой хариулчих байх гэж бодож байна.

Өнөөдөр байгаа нөхцөл байдлууд дээр та олон зүйлийг бас тодорхой тоо баримт хэллээ. Үнэхээр 465 аж ахуйн нэгж байна. 133 их наядын хөрөнгөтэй байна гэдэг энэ тоо баримтууд хэлж байгаа. Өнөөгийн нөхцөл байдал яг л энэ байдлыг бид засаж залруулахын тулд энэ хуулийг оруулж байгаа. Өнөөдөр бол бид нар төр өөрөө 1/3-ээс доош хувьцаа эзэмшдэг байдлыг зогсооё. Энэ төрийн өмчит компанийн тоог цөөлөе. Хувийн хэвшилтэй өрсөлддөг, төрийн өмчит компани дураараа байгуулдаг, орон нутгийн өмчит компани дураараа байгуулдаг асуудлууд дээр хязгаарлалт тогтоосон олон заалтуудыг энд оруулж өгсөн байгаа.

Цаашдаа энэ компаниудын тоо нэмэгдэхгүй, харин ч байгуулагдсан компаниудыг цэгцлэх асуудлууд энэ хуулийн дараа хийгдэнэ гэдгийг хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Аудит хийх боломжгүй боллоо гэдэг асуудал та 1 дүгээрт энэ дээр буруу ойлголттой байна уу Шижир гишүүн ээ. Ийм зүйл бол байхгүй. Төрийн аудит төрийн аудитын хуулиараа санхүүгийн тайлагналын, гүйцэтгэлийн, нийцлийн аудит хийдэг. Нийцлийн болон гүйцэтгэлийн аудитыг өөрсдийн хүчээр хийдэг. Санхүүгийн тайлагналын аудит хийхдээ гаднын аудитын байгууллагуудаас туслан гүйцэтгэгчээр хамтарч ажилладаг. Энэ хамтарч ажиллаж байгаа байгууллагуудыг өнөөдөр шууд Үндэсний аудитын газар өөрсдөө сонгоод, энэ компанид энэ аудитын байгууллага хийгээд шууд оруулж байгаа. Энэ дээр Үндэсний аудитын газрын гаргасан жагсаалтын хүрээнд төрийн өмчит компани харин ч нээлттэй тендер шалгаруулж, аудитын байгууллагыг шалгаруулж болдог ийм зарчим руу орж байгаа юм. Үндэсний Аудитын газар, Олон улсын аудитын газар давхардуулж аудит хийгээд, IPO гаргах юм уу, олон улсын аудит хийлгэх шаардлагатай компаниуд дээр 2 дахин зардал төлдөг. Санхүүгийн тайлангийн аудитыг 2 давхар хийдэг. Энэ байдлыг үгүй болгож олон улсын аудитын хийсэн санхүүгийн тайлагналын аудитын үр дүнг төрийн аудитын байгууллага хүлээн зөвшөөрдөг болох энэ зарчмыг энэ аудитын тогтолцоонд оруулж өгсөн. Харин ч энэ хуулийн төсөл дээр олон улсын аудит болоод төрийн аудит, дотоод аудитын ялгаа зарчмыг гаргаж, хоорондын уялдаа холбоог нарийн гаргасан бүхэл бүтэн аудитын тогтолцооны асуудлыг оруулж ирснээрээ онцлог байгаа гэдгийг бас хэлэхийг хүсэж байна.

Та мөн албан тушаал дээр төрийн өмчит компанийн дарга нар дээр улс төрөөр томилогдож байна гэж. Өнөөдрийн байгаа энэ нөхцөл байдлыг халахын тулд бид энэ хууль дээр хараат бус гишүүдийг сонгон шалгаруулалттай байх, гүйцэтгэлийн удирдлагын багийг сонгон шалгаруулдаг байх, багаар удирддаг менежментийн тогтолцоог оруулдаг байх энэ олон зохицуулалт өөрчлөлтүүдийг хийж өгсөн байгаа гэдгийг эрхэм Шижир гишүүний асуултад хариулт болгож өгье.

С.Бямбацогт: Сайнзориг гишүүн нэмж хариулъя.

П.Сайнзориг: Ер нь Үүрийнтуяа дарга хариулчихлаа даа. Зүгээр яах вэ ялгамжтай гэдэг зүйлийг би зөвөөр ойлгоосой гэж хүсэж байна. Компанийн хууль бол цэвэр хувийн эрх зүйн харилцаа. Энэ хувийн эрх зүйн харилцаан дээр үйлчлэх хүртэл төр өөрөө компанийн хувьцаа эзэмшигчийн хувьд ямар дотоод процедуртай явах вэ гэдэг энэ компанийн хуулиар зохицуулж болж байгаа юм. Энэ 2 хуулиуд давхцаад, бие биеэ үгүйсгээд байгаа юм биш. Энэ хэсэг нь бол захиргааны эрх зүй гэж явдаг Шижир гишүүн ээ. Тэгэхээрээ энэ захиргааны эрх зүйн хүрээнд гаргасан шийдвэрээсээ цаашлаад ТУЗ-ийн гишүүнийг томилоод, ер нь цаашдаа бол Компанийн хуулиараа явдаг ийм жишигтэй юм. Тэгээд энэ яах вэ зүгээр хуулийн уялдааг хангах хүрээндээ энэ хуулиудыг уялдаатай байдлаар боловсруулж орж ирсэн гэдгийг 1 дүгээрт танд бас хэлье.

Аудит дээр та буруу ойлголттой байна. Сая Үүрийнтуяа гишүүн хэллээ. Энэ аудит шууд өөрөө жагсаалт гаргаад хүн хүч нь хүрэлцэхгүй бол өөрөө энэ компаниар хийлгэ гээд явуулдгийг тэндээс нь Худалдан авах ажиллагааны хуулийн дагуу нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгож аудит хийлгэдэг болох гээд байгаа юм. Үнэхээр төрийн аудитын хүн хүч нь хүрэлцэхгүй бол. Өөрсдөө хийе гэсэн

компани дээрээ угаасаа хийж байгаа. Том том аж ахуйн нэгжүүд дээр өөрөө хийдэг. Бусад төрийн өмчит компани дээр хийх хүний нөөц нь хүрэлцэхгүй учраас аудитын тусгай зөвшөөрөлтэй компаниудаас шууд нэр заагаад явуулдгийг нь энэ болохгүй. Худалдан авах ажиллагааны хуулийн дагуу нээлттэй сонгон шалгаруулалтаар хийх нь зөв гэдэг. Энийг Үндэсний аудитын байгууллага энэ тэртэй бүгдийг нь тохирч ойлголцсон байгаа гэдэг зүйлийг би бас танд хэлмээр байна.

С.Бямбацогт: Шижир гишүүн тодруулъя.

Ө.Шижир: Өргөн барьсан хуулийн төслийн чинь 37.4, 37.5 дээр энэ байна л даа. Тэгээд дагаж орж ирж байгаа хуулийг чинь Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай дээр чинь ингээд хасаад хаячихсан байна шүү дээ. Тэгээд төрийн өмчит компаниудын чинь бодитоор УЗ-ийн тэр 9 гишүүн намын томилгоо л хийгдэж байгаа шүү дээ. Энийг та нар бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Сая Нийслэлийн сонсголоор бүгдээрээ харж байгаа шүү дээ. Тэгээд намаар томилогдсон хүмүүс төрийн аудитаар хянуулахгүй гэдэг л логик байхгүй юу даа. Намаас томилогдсон ТУЗ-ийн гишүүд чинь тухайн гүйцэтгэлүүдээ төрийн аудитаар хянуулахгүй гэсэн ийм зөрчил үүсээд байгаа юм.

Одоо хэдүүлээ ингээд дахиад л аудитын дүгнэлтүүдийг хараад ярихад тэнд жишээ нь төрийн өмчтэй холбоотой хөрөнгө байгаа юм. Манай төр өөрөө маш их объектойд. Тэрийгээ бусдад түрээслүүлдэг. Бусдад түрээслүүлэхдээ дунджаар 50 мянгаар түрээслүүлдэг. Бусдаас түрээслэхдээ хамгийн ихдээ метр квадратыг нь 171 мянган төгрөгөөр түрээсэлдэг. Хамгийн багадаа 100 мянгаар түрээсэлдэг.

Одоо та бүгд аягүй сайн мэднэ. Монголбанкны хажууд Голомт банк байгаа. Тэр жишээ нь төрийн өмч шүү дээ. Тийшээ яагаад төрийн байгууллагуудаа оруулж болохгүй, бусдад түрээслээд байгаа юм.

С.Бямбацогт: Сайнзориг гишүүн хариулъя.

П.Сайнзориг: Тэр байр савны түрээсийн асуудал энэ хуулийнх биш. Энэ бол төрийн өмчийн цаашдаа бас нийтийн өмчийн хуулийг бас бид нар батлаад явах ёстой. Шижир гишүүний ярьж байгаа 34.5, 34.4-ийг бид нар эцсийн хэлэлцүүлэгт бэлдсэн саналын 16 дээр санал хурааж өөрчлөх гэж байна. Энийгээ бид нар гүйцээн боловсруулалт чиглэл авчихсан байсан Шижир гишүүн ээ. Энийгээ асуудлуудыг/минут дуусав/

С.Бямбацогт: Уучлаарай. Зочин танилцуулъя. Түр сууж байгаарай. Хариултуудыг гүйцээчихье.

П.Сайнзориг: 16 дугаар санал дээр таны бас анхаарч байгаа зүйлүүдийг бид нар засаад хураалгах гэж байна гэдэг зүйлийг хэлье. Энэ хууль бол ерөнхийдөө цэгцлэх эхлэлийг тавина Шижир гишүүн ээ. Одоо хэдүүлээ энэ төрийн өмчит компанийг тойрсон найран дундаа явдаг энэ зүйлүүдийг үүгээр цэгцэлж дуусгана. Улс төрийн томилгоонуудыг энэ хуулиудаар эцэслэж дуусгана. Хараат бус гишүүд нь 40-өөс доошгүй хувьтай байдаг болно. ТУЗ-ийн гишүүдээр ажиллах хүмүүсийн шаардлага тавьдаг болно. Ажлын үр дүнгийн даалгаврын гэрээгээр бид нар үнэлдэг болно. Ажлаа хийж чадсан хүмүүст нь урамшууллыг нь өгдөг болно. Эсвэл хариуцлагыг нь тооцдог болно. Энэ мэдээллийг нэгдсэн байдлаар Улсын Их Хурлын

бүрэн хяналт тавьж, төсвийн бодлогоороо төрийн өмчит компанийн үр өгөөжийг нийт ард түмэнд хүртээдэг болно. Түүнээс биш улс төрийн шийдвэр гаргаад, төмөр зам бариулдаг, жорлон сайжруулдаг ийм зүйлүүдийг хэзээ ч хийлгэхгүй. Энэ бүх зүйлүүд ард түмний өмч. Тийм учраас энэ нэгдсэн төсвийнхөө бодлогоор явж шийдэгддэг байх энэ зарчим .../минут дуусав/

С.Бямбацогт: Шижир гишүүн тодруулъя.

Ө.Шижир: Энэ хууль батлагдаад байдал өөрчлөгдөхгүй. Бодитойгоор. 2028 онд энэ хэвээрээ л байна. Бид нар ингээд сайхан нэртэй, гоё зорилготой ийм хуулийн төслүүд зөндөө оруулж ирдэг. Батлагдаад явдаг. Хэрэгжилтээрээ дандаа 0. Одоо жишээ нь энэ хуулиар тэгвэл дахиад тодруулъя. Засгийн газрын Хэрэг эрхлэх дээр байгаа 31 компани, Эрчим хүчний яам дээр байгаа 21 компани чинь Төрийн өмчийн хороо дээр очих юм уу. Очихгүй шүү дээ. Сайд нар чинь компаниудаа өгөхгүй. Яагаад гэвэл тэнд маш их зардлыг үргүй зардал болгож үйл ажиллагааг санхүүжүүлдэг. Сайд нар өөрсдийнхөө багцад рекламных нь зардал гээд 24 тэрбум төгрөг 2024 онд жишээ нь хэвлэл мэдээлэлд гаргасан байгаа шүү дээ. Зөвхөн 1 сайд өөрийгөө сурталчлах гэхээр 1,1 тэрбум төгрөг л зарцуулчихсан байгаад байгаа юм. Энэ компаниуд төсвөөс гардаг, төрийн өмчит компаниудаас гардаг байхгүй юу даа. Тэгэхээр энэ байдал чинь өөрчлөгдөхгүй. 2 жилийн дараа би та 2-оос/минут дуусав/

С.Бямбацогт: Үүрийнтуяа гишүүн хариулъя.

Д.Үүрийнтуяа: Шижир гишүүн ээ, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх болон төрийн захиргааны үүргийг хэрэгжүүлж байгаа байгууллагуудын ялгааны л асуудал яригдаад байна л даа. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар бол төрийн өмч хөрөнгөтэй холбоотой бүртгэл, хяналтын тогтолцоо, захиргааныхаа асуудлыг л хариуцаж байгаа байгууллага. Одоо “Эрдэнэс Монгол” байж байгаад нэр нь өөрчлөгдөж байна. “Эрдэнэс Монгол” нэгдлээр дамжуулаад Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Засгийн газар, яамд гэхээс илүү Засгийн газар өөрөө хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа субъект юм. Тэгэхээр захиргааны чиг үүрэг, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа чиг үүргийн ялгаа энэ дээр байгаа юм шүү гэдгийг тодотгож хэлье.

2 дугаарт аудитын асуудал дээр дахиад нэмээд хэлэхэд сая гүйцээн боловсруулах чиглэл авсан 2 асуудлыг та хуучнаар нь ярьж байх шиг байна. Гүйцээн боловсруулах чиглэлээр санал хураагдана. Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлан баталгаажуулахаас гадна гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийдэг бүрэн эрх нь хэвээрээ байгаа гэдгийг хэлье.

С.Бямбацогт: Үгүй ээ, бид нар чинь болохгүй, бүтэхгүй байгаа зүйлүүдийг засаж залруулах гэж, сайжруулах гэж яах аргагүй төрийн өмчит компаниуд дээр үнэхээр засаглал нь муу байна, үр ашиггүй байна, бүтээмжгүй байна, үүнийг өөрчилъё гэж хүн болгон, амтай болгон шүүмжилдэг. Үүнийг засах гэж хууль оруулж ирсэн. Одоо засаад, сайжруулаад хууль маань гарч байгаа байх гэж ойлгож байгаа. Тийм болохоор энэ хууль хэрэгждэг байх ёстой, хууль маань энэ хөгжил дэвшил, өөрчлөлтөд нийцэж илүү сайн зүйлийг л авчрах, сайн үр дагавар, үр дүн гаргадаг байх ёстой шүү. Тэгээд энэ талаар хийгдсэн байх гэж найдаж байгаа. Саруулсайханы Цэнгүүн гишүүн асуултаа асууя.

С.Цэнгүүн: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Ер нь төрийн өмчит компаниудын хамгийн их алдагдалтай ажиллаж байгаа нийт салбараар нь аваад үзвэл эрчим хүчний компаниуд бол хамгийн алдагдалтай байдаг. Тэгээд эрчим хүчний компаниуд алдагдалтай ажилладаг ч гэсэн ТУЗ-ийн гишүүд нь, гүйцэтгэх захирлууд нь хариуцлага хүлээдэггүй явсаар ирсэн ийм гажиг тогтолцоо байсан. Ингээд ТУЗ, гүйцэтгэх захирал хариуцлага хүлээхгүй байхад нь Засгийн газар БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль гээд бид бүхний хэлж заншсанаар бол БЭТ томилоод л тухайн хүмүүсийг хариуцлагаас чөлөөлчих ийм дүр зураг байдаг байсныг, энэ Улсын Их Хурлын хаврын чуулганаар тухайн БЭТ-ийг томилдог хуулийг бид бүхэн хүчингүй болгосон. Энэ бол төрийн өмчит компаниудын засаглал дээр хийгдэж байгаа маш том ахиц, алхам болж гарсан гэдэг нь бас дуулгахад таатай мэдээ гэж бодож байна.

Төрийн өмчит компаниудын гүйцэтгэх удирдлагатай холбоотой асуудал байдаг нь бол төрийн өмчит компаниудын удирдлагуудын цалингийн тухай асуудал маш өндөр байдаг. Одоо жишээ нь би дурдаад хэлбэл төрийн үнэт цаасны хэвлэл гээд энэ газрын гүйцэтгэх захирал бол 38 сая төгрөгийн цалин авч байгаа. Нөгөө алдагдалтай ажилладаг эрчим хүчний компаниудынх ч гэсэн өндөр цалинтай, Диспетчерийн үндэсний төв 25 сая төгрөг, ЦДҮС 20 сая төгрөгийн цалинтай гэх мэтчилэн маш өндөр цалин авдаг. Тэгээд тухайн гүйцэтгэх захирлын авч байгаа цалин нь өөрөө тухайн жилийнхээ яг үндсэн төлөвлөгөөгөө биелүүлсэн үү, тухайн компанийн үйл ажиллагаа хэрхэн сайжирсан бэ гэдэгт нь хяналт, үнэлгээ, дүгнэлт хийгдэхгүй явсаар байдаг. Тэгээд гүйцэтгэх захирлын сонгон шалгаруулалт нь өөрөө ил тод байх ёстой боловч дутуу. ТУЗ-ийн гишүүд нь бас дутмаг. Би эрчим хүчний салбарт байгаа ТУЗ-ийн гишүүдийн мэдээллийг авахаар бүх компаниуд руу албан бичиг ирүүлсэн ч 12 газраас бусад нь хуулийн хугацаандаа ТУЗ-ийн гишүүдийнхээ мэдээллийг өгөхгүй байгаа. Тэгэхээр ямар том хаалттай байгаа вэ гэдэг нь эндээс харагдаж байгаа юм л даа.

Ингээд үндсэндээ бол бид нар ТУЗ болон гүйцэтгэх захиралдаа хяналт тавьж чадахгүй ийм төрийн өмчит компаниуд байгаад байгаа нь хамгийн том алдагдлыг гаргаад байгаа юм. Ингээд 58 мянган хүн ер нь бол төрийн өмчит компаниуд дээр ажиллаж байна. Энэ 58 мянган хүн маань өөрөө гүйцэтгэл, бүтээмж гэдэг үнэлгээ байхгүйгээр яваад байгаа нь хамгийн том асуудал.

Тэгээд анхандаа бол энэ хуулийн төсөл орж ирж байхад би бол эсрэг байр суурьтай байсан. Яагаад гэхээр энэ төрийн өмчит компанийн хуулиараа бид бүхэн төрийн өмчит компани нэмж байгуулах гэж байгаа юм шиг агуулгууд бол анхны хуулийн төсөл дээр байсан. Сайнзориг гишүүн, Үүрийнтуяа гишүүний ажлын хэсэг бол нэлээн нухацтай ажилласан. Би ажлын хэсгийн гишүүн байгаагүй ч гэсэн ер нь бол 90 санал оруулаад, хажууд нь бас ажлын хэсэгт саналаа оруулахаар бол нэлээн тулж ажилласан байгаа. Тэгээд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг сайн ажилласан гэж миний хувьд бол үзэж байгаа. Яагаад гэхээр анхны орж ирсэн төслөөсөө бол нэлээн хумьж, төрийн өмчит компаниудыг тодорхойлж, ямар нөхцөлд төрийн өмчит компани байгуулах юм. Ямар нөхцөлд байгуулахгүй юм бэ гэдгийг тодорхойлохыг оролдсон.

Тэгээд Улсын Их Хурлын гишүүддээ хэлэхэд бол энэ хуулийн 8.1 дэх заалтыг та бүхэн нэлээн сайн нухацтай хараарай гэж үзэж байна. Ажлын хэсэг дээр бол бид бүхэн энэ нийтийн үйлчилгээ гэдэг нь юу юм бэ гэдгийг тодорхойлох гэж нэлээн хэд

хоног суусан. Гэхдээ бас яг миний хувьд ч гэсэн бүрэн дүүрэн бид бүхэн ажиллаж чадаагүй юм уу даа гэсэн бас бодол байгаа. Жишээ нь зүй ёсны монопол гэдгийг бид бүхэн юу гэж ойлгох вэ. Төрийн оролцоотойгоор ямар нэгэн төрийн хаалт, төрийн хуультай байж байж монопол өөрөө үүсэх үндсэн эрх нь үүсэж байгаа. Тэгээд нөгөө салбаруудаар бас бид нар ялгаад өгчихөөр бас хэт ерөнхий тал ажиглагдах байдал байгаа. Гэхдээ ямартай ч энэ өөрөө ийм тодорхой хэмжээнд ахиц дэвшил гаргаж байгаа учраас ажлын хэсгийн саналуудыг бол дэмжээд явчих нь зүйтэй гэж Улсын Их Хурлын гишүүддээ бас хэлмээр байгаа юм.

Үндсэн гол асуудал маань бол энэ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь бол бүртгэлээ хийгээд, хяналтаа хийгээд явчихна гэж байгаа юм. Гэтэл .../минут дуусав/

С.Бямбацогт: Асуултаа гүйцээгээд асуучихъя.

С.Цэнгүүн: Тэгэхээр нөгөө Засгийн газар өөрөө тухай бүрд нь жишээ нь шийдвэрүүдээ гаргаад явахаар нөгөө төрийн өмчит компанийн удирдлага өөрөө тогтворгүй байдал үүсэх юм биш үү. Энэ чинь ер нь бодлого нь хаанаа зангидаж явах вэ гээд энэ асуултыг асуумаар байгаа юм. Энийгээ бид нар тодорхой ойлгомжтой болгохгүй бол Ерөнхий сайд солигдох болгонд л энэ төрийн өмчит компаниудын захирлууд нь бас солигдоод явчихдаг байдал үүсэх үү. Нөгөө талдаа яам өөрөө бодлого гаргах ёстой чиглэл байтал төрийн өмчит компани удирдаад, аж ахуйн шинжтэй ажил руу буцаад энэ хуулиар ордог байвал энэ маань өөрөө бас төдийлөн сайн ахиц гарахгүй юм болов уу гэж бол хараад байгаа. Энэ дээр ажлын хэсгийн ахлагчийн байр суурийг сонсьё.

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Сая зочин танилцуулж амжаагүй байтал гараад явчихлаа. Уучлаарай. Зочин танилцуулчхаад гаргаж байвал манай зочид хариуцсан Тамгын газрын ажилтнууд.

Улсын Их Хурлын гишүүн Оюунсайханы Алтангэрэл, Ганбатын Хосбаяр нарын урилгаар Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 1981 оны 10^а, 10^б, 10^в, 10^г ангийн төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа, төгсөлтийнхөө ойг тэмдэглэж байгаа та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Ажлын хэсгийн ахлагч Үүрийнтуяа гишүүн хариулъя.

Д.Үүрийнтуяа: Цэнгүүн гишүүн маань ажлын хэсгийн үйл ажиллагаанд ажлын хэсгийн гишүүдийн нэгэн адилаар маш идэвхтэй оролцсон Улсын Их Хурлын гишүүдийн 1. Олон ч зарчмын зөрүүтэй саналуудыг гаргаж, бас ярилцаж, хамтарч энэ 8 дугаар бүлэг дээр бол нэлээн сайн ажилласан. Тэгээд Цэнгүүн гишүүндээ бас юуны өмнө талархлаа илэрхийлмээр байна.

Өнөөдөр бид яг энэ хууль дээр хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа субъектийг ерөөсөө Засгийн газар л гэж авч үзэж байгаа. Засгийн газар хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэхдээ дотооддоо зохион байгуулалтаа хийж, аль нэг яамандаа хариуцуулах, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар бол өөрөө Засгийн газрын бүтцийн нэгж. Энэ бол Засгийн газрын өөрийнх нь дотоод асуудал

руу хуулиар оролцож, шууд харьяаллыг тогтоох боломж бас байхгүй байгаад байгаа юм. Хувьцаа эзэмшигчийн эрхийг Улсын Их Хурлын өмнө хэн хариуцах вэ гэхээр Засгийн газар л хариуцна. Төрийн өмчит компаниудын хувьцаа эзэмшигчийн эрхийнхээ үүргийг хэрхэн хэрэгжүүлсэн нь. Бид бол яах вэ, гүйцэтгэх удирдлагын ТУЗ, гүйцэтгэх удирдлагын томилгоо, ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх энэ асуудлуудыг бас тодорхой зохицуулалттайгаар оруулж өгсөн. Гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулдаг, менежментийн багаар ажилладаг, ингэхдээ даалгаврын гэрээтэй байдаг байх, санхүүгийн тайлагналын аудитаар 2 жил дараалан зөрчилтэй дүгнэлт авах юм бол чөлөөлдөг байх, хариуцлага тооцдог байх. Өнөөдөр ТУЗ-ийн гишүүд ямар ч хариуцлага хүлээхгүй байгаа, гаргасан шийдвэртээ хариуцлага хүлээхгүй байгаа энэ нөхцөл байдал дээр хариуцлага хүлээлгэдэг болгох, ТУЗ-ийн цалин хөлсний хэмжээ хязгаарыг гүйцэтгэх удирдлагын түвшинд барих гээд олон зохицуулалтыг энд бас оруулж өгснийг та бас ажлын хэсгийн явцад мэдээллүүдийг нэлээн тодорхой аваад, бас ярилцсан. Саналаа бас энэ дээр оруулсан. Тэгэхээр цаашдаа бид энэ хуулийнхаа хэрэгжилтийг хангах тал дээр Засгийн газрын зүгээс хийж хэрэгжүүлэх олон ажлууд байгаа. Хууль батлагдаад гарсны дараа бол Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Засгийн газар энэ дээр ажиллаад, төрийн өмчийн үндсэн чиглэлээ, төрийн өмчит компанийн хувьд барих энэ үндсэн чиглэл бодлогоо тодорхойлж оруулж ирнэ. Үүгээр бол их олон асуудлууд тодорхой болно гэж харж байгаа.

Энэ үндсэн чиглэлийнхээ хүрээнд төрийн өмчит компаниудын түвшинд хийх энэ өөрчлөлтүүд, энэ хуулийн хэрэгжилт биеллээ олоод хууль хэрэгжээд явах ийм боломж бүрдэх юм байгаа юм.

Тэгэхээр мэдээж энэ улс төрийн нөлөө бага байх зорилгоор, улс төрийн нөлөөлөлгүй байх зорилгоор тодорхой хараат бус гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх, энэ дээр улс төрийн шийдвэр гаргадаггүй байх боломжуудыг олгох зохицуулалтуудыг бас тусгаж өгсөн байгаа гэдгийг нэмж хэлэх нь зүйтэй байх.

С.Бямбацогт: Баярлалаа. Тодруулж асууя Цэнгүүн гишүүн.

С.Цэнгүүн: Ер нь хууль хэрвээ цаашдаа хэлэлцэгдээд батлагдсан тохиолдолд бид нар бас Засгийн газарт чиглэл өгөх шаардлагатай харагдаж байгаа. Ер нь цаашдаа ахиж төрийн өмчит компанийг жил болгон улам нэмэгдүүлдэг байж болохгүй. Дээрээс нь одоо алдагдалтай ажиллаад байгаа хувийн хэвшил гүйцэтгэх бүрэн дүүрэн боломжтой тэр компаниудыг татан буулгах, хувьчлах гэх мэт зүйлүүдийг маш хурдтай яаралтайгаар хийх ёстой. Энэ салбарт байгаа 58 мянган хүнийг бид бүхэн чөлөөлөөд, чөлөөт ажлын байрны зах зээл рүү гаргах юм бол манай ажлын байран дээрх хүн хүчний нөөцийн дутагдал ч гэсэн арилах маш том суурь нь өөрөө энд байж байдаг. Тэгэхээр ер нь бол төр өөрөө компанийн үйл ажиллагаа явуулаад байна гэдэг суурь үндсэн буруу зарчмаасаа гарахад энэ өөрөө ахиц гаргаж байгаа шат юм болов уу гэж гэж би бол харж байгаа. Үүнийхээ дараагаар бид бүхэн ахиад яаж төрийн энэ маш том өмчийг багасгах талд нь цаашдаа бас дараа дараагийн алхмуудаа хийгээд Засгийн газартаа чиглэлээ өгөөд ажиллах шаардлагатай гэж харж байна.

С.Бямбацогт: Сайнзориг гишүүн, ажлын хэсгийн ахлагч хариулъя.

П.Сайнзориг: Цэнгүүн гишүүндээ бас баярлалаа. Тэгээд энэ хуулийг бас энэ хаврын чуулгандаа баталж байгаагийн бас 1 гол ач холбогдол өгч байгаа зүйл нь намрын чуулганд энэ хуульд тусгагдсан тэр төрийн өмчит компанийн талаарх төрийн өмчлөлийн бодлогын асуудлыг Улсын Их Хуралд Засгийн газар маань өргөн барина. Тэгэхээр энэ таны өмнөх асуулт дээр буюу бодлого ер нь хаана байна вэ гээд. Тэгэхээр бид хэд ер нь энэ төрийн өмчит компанийн яг эцсийн бөгөөд суурь эцсийн шийдвэр гаргалт бол Улсын Их Хурал дээр гарна л гэж ойлгож болно. Бид энэ компаниудыг цаашдаа үр өгөөжтэй байлгах үүднээс нь аль хэсэг дээр нь хяналтыг олон нийтийн оролцоог хангаж IPO хийх вэ, хэдэн хувиар хийх вэ, ямар цаг хугацаанд хийх вэ гэдгийг Улсын Их Хурал дээр бодлогын бичиг баримтаар нэг бүрчлэн гаргана. Ер нь бол энэ хууль батлагдсанаар цаашдаа төрийн өмчит компаниуд бол хумигдана гэдэгт бол би 100 хувь итгэлтэй байна. Тэгээд үүний бас хэрэгжилтийн үр дагаврыг жил тутам бид нар бас үнэлээд явах, Улсын Их Хурал дээр хяналтаа тавих, төсвийн бодлоготойгоо уялдуулах, эдийн засгийн төлөвлөлттэйгөө уялдуулах, бизнес хувийн хэвшилтэйгээ өрсөлддөггүй .../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчих. Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Тэгээд ийм зүйлүүд нь яригдана. Тэгээд бас Цэнгүүн гишүүнтэй би бас Эдийн засгийн эрх чөлөөний хууль дээр бас хамтраад нэг ажлын хэсэгт байгаа. Бид нарын бас оруулж байгаа 1 зүйл нь энэ төрийн өмчит компаниудын бас зах зээлийн зарчим руу орохгүй буюу засаглал бас болж өгөхгүй байгаа зүйл нь бол тарифын зохицуулалт байгаа. Тэгэхээр энэ тарифын зохицуулалтыг бид нар жил тутам ямар ямар салбарууд тарифын зохицуулалттай байна. Энэ дээр ямар тарифын зохицуулалтыг өөрчлөлт, сулруулалт явах юм, хугацааны асуудлыг нь яг Засгийн газар бодитой зарлана. Энд өгч байгаа татаас, үр өгөөжийн асуудал хэрхэн байгаа юм бэ гэдэг зүйлийг үнэлж байж энийг зах зээлийн асуудлыг хувийн хэвшилд тавьж өгөх үү, зах зээлийн ийн зарчим руугаа шилжих үү гэдэг асуудлыг бас тэр цаашдаа ярих юм. Тэгээд бүх энэ хуулиуд бас өөр хоорондоо уялдаатай, ингээд харилцан шүтэлцээтэй явж байгаа гэдэг зүйлийг бас хэлье. Тэгээд Цэнгүүн гишүүнд бас идэвхтэй ажилласанд нь бас талархаж байна.

С.Бямбацогт: Жудагийн Баярмаа гишүүн асуултаа асууя.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье. Тэгээд энэ төрийн өмчит компаниуд гэж үнэндээ бараг АН гэлтгүй МАН-ынхан өөрснөө ч бараг ойлгож байх шиг байна лээ. Ний нуугүй хэлэхэд сонгуулийн менежерүүдийн орогнодог үүр уурхай гэж жоохон хатуу хэлбэл ийм юм болчихсон байгаа. Тэгээд зогсохгүй тэр төрийн өмчит компаниудаараа дамжуулж, дараагийнхаа сонгуулийн бас мөнгийг бэлтгэдэг ийм бааз суурь шахам болчихсон. Хатуухан хэлэхэд. Ардын намынхан өөрсдөө ч бас энэ тал дээр дуугараад эхэлсэн байна лээ. Тэгэхээр энэ дээр заавал ч үгүй ач холбогдол өгч, энийг яах вэ гэдэг асуудлыг хэлэлцэх нь зүйтэй. Энийг бас ямар ч байсан энэ хуулийн төсөл оруулж ирж байгаад бол талархаж байгаа.

Гэхдээ нэг зүйл дээр бол санаа зовж байна л даа. Үндэсний эдийн засгийн ашиг сонирхол, стратегийн ач холбогдол, нийтийн үйлчилгээ гэсэн ийм шалгууруудыг зөвхөн эдгээрт чиглэсэн компаниуд ажиллана гэж оруулсан нь бол 1 дүгээрт хэтэрхий ерөнхий, 2 дугаарт одоо ч гэсэн тийм л байгаа. Одоогийн энэ байгаа компаниуд чинь яг л ийм л агуулгаар оршиж байгаа. Бүгдээрээ л үндэсний

хэмжээний, үндэсний стратегийн ач холбогдолтой, ашиг сонирхлыг хангах ёстой гэсэн ийм юмаар яваад байгаа учраас нарийн ялгаа заагийг нь яаж гаргах юм бол. Энэ дээр нь ямар нэгэн шалгуур, тэгээд дээрээс нь үнэлгээ хийх зарчим ч юм уу ийм зүйлүүд тусгагдахгүй харагдаад байгаа юм. Тэгэхээр явсаар байгаад энэ хууль нь өөрөө энэ олон ашиггүй ажиллаж байгаа, энэ тоо баримтууд бас их зөрүүтэй байгаа. Жишээлбэл, 100 гаруй төрийн өмчит компаниуд төрийн үйлдвэрийн газрууд байна гээд, тэгээд ерөөсөө 4,7 их наядын ашигтай. Тэрийг нь 4, 5 компани бүрдүүлж байна гээд. Тэгээд бусад нь үндсэндээ ашиггүй ажиллаж байна гээд. Тэгэнгүүт энэ олон ашиггүй ажиллаж байгаа компаниудыг бүгдийг нь ер нь бараг байхгүй болгох тал руу явах ёстой атал энэ хуулийг хийснээр үйл ажиллагааг нь сайжруулах чиглэл рүү орчих юм биш байгаа. Үйл ажиллагааг нь сайжруулж, засаж янзалж авчих гээд л хичээгээд байгаа юм биш байгаа гэж жоохон санаа зовж байна.

Тэгээд мэдээж бид нар бүгд л гаднын туршлага ярьдаг. Төрийн өмчит компаниудынхаа менежментийг сайжруулж, үр дүнд хүрдэггүй. Хувьчилж, байхгүй болгож, олон нийтийнх болгож үр дүнд хүрдэг. Наад зах нь бид нарын онигоонд ортлоо явдаг. Тимосек. Ерөөсөө очиж үзээгүй гишүүн бараг байхгүй гэтлээ яригддаг. Энэ компани чинь хүртэл сайд юм уу, төрөөс ямар ч удирдлага байхгүй. Цэвэр мэргэжлийн байгууллагууд удирддаг. Тэгэхээр манайх бол сайд нар л удирдаж таарах гээд байдаг л даа явж явж. Дээр нь ямар нэгэн салбарын сайд эсвэл Хэрэг эрхлэх газар юм уу байж байдаг. Гэтэл энийг яг бүрэн агуулгаар нь хувийн хэвшил эсвэл мэргэжлийн баг удирдах тийм боломжууд нь тусгагдаагүй санагдаж байна. Тэгээд одоо жишээлбэл ямар үйл ажиллагааг өмнө нь ч бодвол ярьсан л байх л даа. Хувийн хэвслээр хийлгэж болно, болохгүй гэж үзэх юм бэ гэдэг тэр нарийн шалгуурыг нь хэн, хэзээ тогтоох нь мэдэгдэхгүй.

Гэтэл хүнсний зах ажиллуулж байгаа шүү дээ төр. Миний санаж байгаагаар Хан-Уул дүүрэгт байдаг. Хүнсний зах. Тэр хүнсний захыг хувийн хэвшил ажиллуулж чадахгүй гэж үзээд, хувийн хэвшлийн ажлыг булаацалдаж, хүнсний зах ажиллуулаад байдаг юм уу гэмээр ийм юмнууд маш их байгаа. Тэгэхээр энэ хууль батлагдсанаар хэд орчим төрийн өмчит компани байхгүй болж, эсвэл нэгтгэгдэж, татан буугдана гэж та бүхэн харж байгаа вэ.

Дахиад нэг зүйлийг тодруулж хэлэхэд Засгийн газар бүх ажил руу нь орж таараад байна. Компанийг бол Засгийн газар байгуулах нь, ТУЗ-ийг нь томилоход бас л төр оролцох нь, хувьцаа эзэмшигчийн эрхийг нь..../минут дуусав/

С.Бямбацогт: 1 минут. Асуултаа гүйцээгээд асуучихъя. Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: Төр хэрэгжүүлнэ. Тэгээд нөгөө татан буулгах, нэгтгэх шийдвэрийг дахиад л төр гаргана гээд ингээд байхаар чинь нөгөө төрөөсөө хамааралтай хэвээрээ нөгөө цэвэр аж ахуйн нэгжийн агуулгаар ажиллахгүй ийм байх юм биш байгаа гэж санаа зовж байгаа юм. Тэгээд хамгийн гол зүйл бол төрөөс дэмжлэгтэйгээр оршин тогтноод байгаа энэ олон компаниуд яг ямар агуулгаар татан буугдаж, ямар зарчмаар гэдэг нь дахиад л тодорхой байна. Жишээлбэл энэ хуульд магадгүй алдагдалтай ажиллавал тэдэн жилийн дотор татан буулгана ч гэдэг юм уу, эсвэл ямар хугацаанд тодорхой зааж өгөөд тухайн тэр компанийн захирлыг огцруулна ч гэдэг юм уу ийм маш нарийн тодорхой заасан зүйл харагдахгүй л байгаад байна. Тэгээд дахиад хэлэхэд энэ төрийн өмчит компаниудын үйл

ажиллагааг нь сайжруулах чиглэлийн хууль болчих вий дээ. Аль болох л байхгүй .../минут дуусав/

С.Бямбацогт: Үгүй ээ, үйл ажиллагааг нь сайжруулах гэж энэ хуулийг хийж байгаа биз дээ. Үйл ажиллагааг нь сайжруулах болчих вий дээ гэдэг чинь. Сайнзориг гишүүн хариулъя.

П.Сайнзориг: Баярмаа гишүүний асуултад нь хариулъя. Мэдээж энэ туйлын өмчгүй ч юм уу төрийн өмчит компани огтоосоо байхгүй улс орон бол байхгүй байх. Харин ямар компаниудыг яг авч үлдэх вэ. Энийг яаж ашигтай ажиллуулах вэ. Татвар төлөгчдийн мөнгөөр алдагдлыг нь үүрүүлдэггүй байх уу, улс төрийн томилгоо явж хэн нэгэн этгээд шимэгчлээд байдаггүй яаж байлгах вэ гэдгийг л энэ хууль зорьж байгаа. Байгаа дээр нь бол яаж харин сайжруулах вэ гэдгээ явна.

Мэдээж энэ хуулийн бас нэг зорилго бол олон нийтийн хяналтад оруулах. Энэ өөрөө хэлж байгаа нь нөгөө хувьчлах гэсэн үг. Мэдээж энэ хувьчлах үе шатуудыг нээлттэй ил тод байдлаар биржээр арилжаалах энэ нөхцөл байдал руугаа орно. Ер нь бол Монгол Улсын үндсэн зовлон бол энэ авлига. Авлигын чинь суурь нь төрийн өмчит компани дээр байна л гэж байгаа юм. Энэ төрийн өмчит компанийн менежмент сайжрах юм бол улс төрийн намын санхүүжилт ч гэсэн цаашдаа яригдана. Энэ зөв зүйл рүүгээ явна. Дээрээс нь энэ авлигын индекс урагшилна. Монголд бизнес хөрөнгө оруулалт хийх таатай нөхцөлүүд буюу өрсөлдөхгүй байх, зах зээлийг булаацалддаг энэ зүйлүүд бол гарахгүй байх. Энэ чиглэл дээр нэлээн тодорхой зүйлүүд болно.

Таны ярьж байгаа энэ зүйлүүд бол 7 дугаар зүйл дээр төрийн өмчит компанийн талаар баримтлах төрийн өмчлөлийн бодлого гэж байгаа. Энэ дээр ерөөсөө Улсын Их Хурал дээр компани компаниар нь case by case гэдэг шиг компани компаниар цаашдаа яах вэ гэдэг зүйлийг ярина. Ер нь бол энэ компаниудын ашигтай ч гэдэг юм уу, алдагдалтай ажиллаж байгаа, эсвэл энэ хувийн хэвшил хийлгэх бололцоотой бүх зүйлүүд дээр ер нь бол цаашдаа яг зоригтой шийдвэрүүд гарна, хувьчилна, олон нийтийн болгоно. Энэ нь нэг талдаа бас олон нийтийн болгох асуудлыг бас өмчийн төвлөрөл үүсгэх ч гэдэг юм уу тодорхой мөнгөтэй этгээдүүдэд өгчихгүй. Энэ компаниудын хувьчлалыг олон нийтийн болгохдоо бид нар тодорхой яг Монгол Улсын иргэд болон стратегийн хөрөнгө оруулагч болон мэргэжлийн хөрөнгө оруулагч бас авах бололцоог нь бүрдүүлж өгнө гэж үзэж үзэж байгаа.

Дараагийн нэг асуудалд үүсгэн байгуулах үндэслэлүүд 8 дугаар зүйлд байгаа боловч энэ үүсгэн байгуулахдаа бид нар 9 дүгээр зүйл дээр нь компанийн үүсгэн байгуулах хэрэгцээ шаардлага буюу хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх гэсэн бодлоготой нийцэж байгаа юу. Зах зээлийн эрэлт хүлээлт, компаниас гаргах бараа, ажил үйлчилгээний жагсаалт, тэдгээрийг борлуулах чадамж бүтээгдэхүүн үйлчилгээний өрсөлдөх байдлын талаарх зах зээлийн судалгаа, байршил, хөрөнгө оруулалтын хэмжээ, оролцоо, энэ эх үүсвэрийг хаанаас бүрдүүлэх вэ зэрэг маш олон хүчин зүйлүүдийг судалгаан дээр үндэслэж байж энэ компани байх, байхгүй, байгуулах уу, үгүй юу гэдгийг шийднэ. Тийм учраас нарийвчилж энэ зүйлүүд нь бол шийдэгдээд явна гэж танд бас хэлмээр байна.

Мэргэжлийн баг бол удирдана. ТУЗ болон гүйцэтгэх удирдлагууд дээр тодорхой хэмжээний дандаа шалгуурууд тавьсан. Улс төрөөс ангид байх

шалгуурууд тавьж байгаа. Ер нь бол бүх зүйлүүд нээлттэй сонгон шалгаруулалтаар явна. Энэ хараат бус гишүүд нь бол энэ хуулиар биш, Компанийн хуулиараа сонгон шалгаруулалтад явна. Энэ зэргээс бол нэлээн өөрчлөлтүүд гарна. Энийгээ дагасан бас цалин урамшуулал болон хариуцлагын тогтолцоо орж ирж байгаа. Тухайн компанийг тодорхой түвшинд 2 жил хүртэл хугацаанд алдагдалтай ажиллуулах юм бол тэр .../минут дуусав/

С.Бямбацогт: Зочид түр хүлээж байгаарай. Тодруулсны дараа танилцуулъя. Баярмаа гишүүн тодруулъя.

Ж.Баярмаа: 1 зүйлд их баяртай байна. Ер нь бол энэ төрийн өмчит компаниудыг шимэгчилж амьдардаг ийм бүхэл бүтэн арми бий болсныг бол бас хаа хаанаа хүлээн зөвшөөрч байгаа юм байна.

Өнөөдрийг хүртэл маш олон жил, сүүлийн 1, 2 жил байнга л энэ төрийн өмчит компаниудыг ярьж байгаа. Тэгэхээр яг ямар ямар компаниудыг татан буулгаад, ямар ямар компаниудыг ямартай нь нэгтгээд гэдэг дээр гарсан судалгаа байгаа юу. Яг энэ хууль батлагдсаны ар дээр тэдэн компани байхгүй болж, татан буугдана. Тэгээд яг ийм чиглэлээр дахиж тийм компани баригдахгүй гэсэн баталгаа, хориглосон заалт энэ хуульд ямар маягаар тусгагдсан бэ. Судалгаатай холбоотой гол нь судалсан тийм тоо баримт, хувь байна уу.

С.Бямбацогт: Үүрийнтуяа гишүүн хариулъя.

Д.Үүрийнтуяа: Энэ хууль бол төрийн өмчит компанийн засаглалыг одоогийн байгаа нөхцөлөөс сайжруулах л хууль. Өмчийн асуудал бол нийтийн өмчийн хуулиар зохицуулагдаж явна. Өнөөдөр төрийн өмчит компанийн бодлогыг энэ хуулиараа Засгийн газар боловсруулаад, Улсын Их Хурал батлах ёстой. Өөрөөр хэлбэл үндсэн чиглэлийг. Энэ үндсэн чиглэлийн хүрээнд Улсын Их Хурал өөрөө чиглэл өгөөд ийм ийм компаниуд чинь төртэй, хувийн хэвшилтэй давхардаж бизнес хийж болохгүй юм гэдэг дээрээ бид даалгавар өгч, үүнийг намар бид батлах ёстой. Энэ хуулийн ар дээр. Тэгэхээр энэ хууль батлагдсанаараа дараа дараагийн хяналт тавьж ажиллах боломжууд энэ дээр гарах юм байгаа юм. Хэлэлцүүлгийн явцад бол Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас олон тооцоо судалгааг бас танилцуулж байсныг хэлэх нь зүйтэй байх.

Төрийн өмчит компанийн шимэгчдийн тухай асуудал гэж ярихаар нам намд л байгаад байгаа. Олон хяналт бүтээмжийн менежерүүд өнөөдрийг хүртэл .../минут дуусав/

С.Бямбацогт: Хассуурийн Ганхуяг гишүүн асуултаа асууя. Уучлаарай зочин танилцуулчихъя.

Нийслэлийн ерөнхий боловсролын 72 дугаар сургуулийн 1996 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа, төгсөлтийнхөө ойг тэмдэглэж байгаа та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Багштайгаа явж байна. Сайхан байна.

Хассуурийн Ганхуяг гишүүн асуултаа асууя.

Х.Ганхуяг: Ер нь яах вэ бас өмнөх байсан хуулиа бодвол дэвшилттэй зүйлүүд гарсан байна. Тэгээд бас манай сайн 2 гишүүн энэ хуулиар ажилласан байна. Гэхдээ яах вэ, зүгээр хэрэгжилтийн явцдаа асуудлууд яах бол гэдэг дээр бас жоохон эргэлзээ үүсээд байгаа юм. Өнгөрсөн 4 жилийн хугацаанд, 4 жил ч юу байх вэ дээ, өнгөрсөн 36 жилийн хугацаанд бол энэ гол хулгай зэлгий бол дандаа л төрийн өмчит компаниудаар явагдлаа шүү дээ. Өнөөдөр бараг 100-аад мянган иргэн ажиллаж байна. Энэ ТУЗ-ийн гишүүдийн хараат бус байдал дээр бол дандаа эргэлзээ төрдөг. Хөрөнгө оруулалтын хэмжээ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаас давчихсан явдаг. Худалдан авалт нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа худалдан авалтаас давчихсан явдаг. Тэгээд энэ дээр хяналтын асуудлууд яг энэ хууль батлагдсанаар хэрхэн яаж сайжирна гэж бодож байгаа вэ. Би энэ дээр бас яг Төрийн өмчийн хорооны даргаас энэ асуулт дээр хариу авчихмаар байна. Үндсэндээ бол өнгөрсөн 4 жилийн хугацаанд зүгээр ил болсон нь л Хөгжлийн банк, нүүрс гээд л явсан. Ил болоогүй нь одоо миний зүгээр санаж байгаагаар, хэвлэл мэдээллээр явж байгаа юмыг харах юм бол бараг шоронд суугаагүй, шалгагдаагүй 1 ч төрийн өмчит компанийн захирал байхгүй байна шүү дээ. Тэгээд энэ дээр би дорвитойхон шиг хариу авчихмаар байна. Энэ хууль батлагдсанаар энэ нөхцөл байдал сайжрах уу.

Энэ цалин урамшуулал, худалдан авалтын асуудал, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж чадах уу. Тэр ангид байж чадна гэвэл яг энэ асуудал дээр дараа нь яг эцсийн өмчлөгч нь бол Төрийн өмчийн хороо гэдгээр хууль дээр орж ирж байгаа юм байна л даа компаниудын. Тэгэхээр энэ дээр хэн нь хариуцлага хүлээх вэ. Зүгээр нэг хэдэн гүйцэтгэх захирал, хэдэн хүүхдүүдийг ингээд шалгаад шалгаад суулгахыг нь суулгаад явдаг юм байгаа биз. Гэхдээ энэ нөхцөл байдал дээр дорвитой өөрчлөлт орох эсэх дээр би хариу авчхаад, эргээд тодруулъя.

С.Бямбацогт: Үүрийнтуяа гишүүн хариулъя.

Д.Үүрийнтуяа: Төрийн өмчит компанийн засаглалын асуудлыг их тодорхой оруулж ирж байгаагийн хувьд гүйцэтгэх удирдлага, ТУЗ-ийн гишүүдийн үүрэг, хариуцлага, тэдний цалин хөлсний асуудлуудыг ямар ямар зарчмаар тодорхойлох ёстой вэ гэдгийг бас оруулж, энэ журмыг нь боловсруулах, энэ хэрэгжилтийг хангах, хяналт тавих субъектүүдийг тодорхой заасан ийм хуулийн төсөл байгаа. Гүйцэтгэх удирдлага би түрүүн хэлсэн даалгаврын гэрээ байгуулна. ТУЗ-ийн гишүүд хариуцлага хүлээдэг болно. Гаргасан шийдвэртээ хариуцлага хүлээдэг болно. Хувьцаа эзэмшигчийн зүгээс гэдэг юм уу, улс төрийн даалгавраар аливаа үүрэг, чиглэл өгөхгүй байх энэ боломжуудыг бас оруулж ирж өгч байгаа. Өнөөдөр бид нар төрийн өмчит компанийн гүйцэтгэх удирдлагыг цалин хөлс өндөр авч байна гэдгээр нь янз янзаар хэлж байгаа юм. Хулгай зэлгий хийчихсэн юм шиг хэлж байгаа юм. Үүрэг хариуцлага хүлээж байгаа бол үүнийхээ хариуд цалин хөлсөө, тохирсон цалин хөлсөө авдаг байх жишиг нь аль ч бизнесийн байгууллагад байдаг зарчим.

Гэхдээ борлуулалтын орлого, цэвэр ашиг, эрсдэлийн түвшин, хариуцан ажиллаж байгаа ажилтны тоо, хэмжээ гээд олон зүйлс ялгаатай байхад ойролцоо, ижил тэгш цалин өгдөг байх тэр зарчмыг бол бид дэмжихгүй. Үүгээр бас хязгаарлана. Энэ дээр төрийн өмчит компанийн шинэчлэлийн бодлого дээр ч тодорхой орох ёстой. Ер нь гүйцэтгэх удирдлагатай, гүйцэтгэлийн багтай, менежментийн багтай ажиллаж, үр дүнгээр нь урамшуулдаг, хийж чадаагүй бол хариуцлага тооцдог болох механизмыг бүрдүүлэхийн төлөө л энэ хуулийг

санаачлан оруулсан. Яах вэ, төрийн өмчит компаниуд руу манай улс төрчид янз янзаар их дайрдаг. “Эрдэнэс Монгол” нэгдлийг байгуулахад бүх албан тушаалтнуудын сонгон шалгаруулалтаар шалгаруулж авч байсныг та бүхэн санаж байгаа байх. Энэ бол шинэ жишиг уг нь тогтсон, тогтож байсан. Гэхдээ үүний дараа хамтарсан засаг байгуулагдахдаа 3 намаас баахан бүтээмжийн менежер, хяналтын менежерүүдийг шууд улс төрийн зорилгоор ил томилоод, тэд нар нь 10, 20 сая төгрөгийн цалинтай, туслахтай, жолоочтой, машинтай, том том өрөөтэй ийм л байдал руу эргээд шилжүүлсэн шүү дээ. Тэгээд энэ шийдвэрийг бид өөрсдөө л гаргадаг. Улсын Их Хурал төрийн өмчийн компаниудад төрийн өмчийн чиглэлээр барих энэ үндсэн чиглэлдээ хяналтаа хэрэгжүүлэх үүргээ бас бид хангалттай хэрэгжүүлэх ёстой гэж нөгөө талаасаа харж байгаа. Тэгэхээр хаа хаанаа хичээгээд хуулийнхаа хэрэгжилтийг хангаад явахад боломжгүй, хэрэгжих боломжгүй хуулийн төсөл бол биш. Засгийн газрыг бас энэ хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс үндсэн чиглэлээ боловсруулаад, намрын чуулганд өргөн барьж, Улсын Их Хурлаар хэлэлцүүлнэ гэж ингэж бодож байгаа.

Аливаа асуудал дээр бид бас улс төржиж хандахаас илүү бодит нөхцөл байдлаа үнэн зөвөөр харах нь зөв байх. Энэ хэдэн менежерүүд өнөөдрийг хүртэл нэрээ солиод л төрийн өмчит компаниудад хэвээр байж л байгаа. Тэгээд энэ зүйлийг л өөрчлөх хууль юм байгаа юм.

С.Бямбацогт: Сайнзориг гишүүн нэмж хариулъя.

П.Сайнзориг: Ганхуяг гишүүн бас энэ хяналтын асуудал гээд маш зөв яриад байгаа юм. Хяналтын компанийн засаглалыг дагаад л үндсэн асуудлууд бүгд хэвээрээ байгаа. ТУЗ-тэй байна, мэргэжлийн байна, улс төрөөс хараат бус байна. Үр дүнгээ дүгнүүлж урамшуулах уу, хариуцлага хүлээхээ тодорхой тооцно. Дээрээс нь ерөөсөө энэ бүртгэл тайлагналтын асуудал жил бүр Улсын Их Хурал намрын чуулган дээр төрийн өмчит компанийн үр ашигтай байдлын энэ асуудлуудыг хэлэлцэж, ямрыг нь татан буулгах вэ, ямрыг нь IPO хийх вэ, ямрыг нь авч үлдэх вэ гэдэг зүйлүүдээр шийддэг болно.

2 дугаарт энэ хамгийн том хяналт IPO буюу олон нийтийн болох энэ гарцуудыг бүрдүүлж байгаа.

Дээрээс нь бас нэг бүх компани дээр биш, зарим шаардлагатай компани дээр, магадгүй эрчим хүчний компани дээр ажилчдад нь бас тодорхой хэмжээний опционы хөтөлбөр гаргана. Ингэж байж компанид байгаа ажилчид өөрсдөө шүгэл үлээнэ. Энэ тендер, худалдан авалт чинь болохгүй байна. Шахааны хүмүүс орж ирээд байна. Үр ашиггүй худалдан авалтуудыг хийгээд байна гэдэг зүйлүүд дээр бас өөрсдөө өөрийн эзэн юм шиг мэтээр бас хандаж явах энэ бололцоог өгч .../минут дуусав/

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Одоо зарчмын зөрүүтэй 25 саналаар санал хураалт явуулна. Дэмжсэн дэмжээгүй байр суурьтай 2 хүртэл гишүүн үг хэлнэ. Санал хураалтыг 17 цагаас нэгтгэж явуулна. Хойшлууллаа.

12.50 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Доржсүрэнгийн Үүрийнтуяа танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Д.Үүрийнтуяа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийг баримтлан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Эдийн засгийн байнгын хорооноос боловсруулан анхны хэлэлцүүлгийг 2026 оны 06 сарын 24-ний өдрийн хуралдаанаараа явууллаа.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллууд дэмжигдсэнтэй холбогдуулан боловсруулсан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гараагүй тул хуралдаан даргалагч Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24-д заасныг баримтлан хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан боловсруулсан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслүүдийг эцэслэн баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Үүрийнтуяа гишүүнд баярлалаа. Ажлын хэсэг түрүүний ажлын хэсэг хэвээрээ. Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Наранцэцэгийн Алтаншагай алга байна. Ганбатын Хосбаяр гишүүн алга байна. Одонгийн Цогтгэрэл гишүүн алга байна. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн алга

байна. Батын Батбаатар гишүүн алга байна. Хассуурийн Ганхуяг гишүүн алга байна. Цэндийн Баатархүү гишүүн алга байна. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн алга байна. Мэндбаярын Мандхай гишүүн асуултаа асууя.

М.Мандхай: Энэ төрийн хэмнэлтийн тухай хуулийн гол хүчингүй болгож байгаа 1 заалт байгаа. Энэ заалт дээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.4 дэх хэсгийг хүчингүй болгож байгаа. Энэ дээр үндсэн гол асуудал бол төрийн өмчийн компанийн гүйцэтгэлийн удирдлага 1 жилийн хугацаатай гэрээ байгуулдаг байсныг 3 хүртэлх жилээр сунгаж өөрчилж байгаа юм байна. Тэгэхээр энэ 3 хүртэл жилийн гэрээ байгуулаад, жил бүрийн энэ үнэлгээнд нь сунгаж байгаа энэ заалт чинь хэрэв 2 жил дараалаад муу үнэлгээ авбал яах вэ. Хугацаанаас нь өмнө цуцлах ямар зохицуулалтууд байж байгаа вэ.

2 дугаарт энэ чинь урт хугацаа 1 жил байсныг 3 жил болгоод сунгаж байгаа учраас энэ төрийн өмчийн компанийн засаглалын тухай хуулиар 35.2 дээр хөрөнгийн өгөөж, ашигт ажиллагаа, зах зээлд эзлэх байр суурь, өсөн нэмэгдсэн бол гүйцэтгэх удирдлагад урамшуулал олгохоор энэ тэр гээд зохицуулалтууд байгаад байгаа. 35, 34 дүгээр заалтууд дээр. Тэгэхээр 1 дүгээрт энэ 3 жил ажиллахад нь ямар шалгуур үзүүлэлтээр энэ урт хугацааны гэрээг гүйцэтгүүлэх вэ. Ямар шалгуур үзүүлэлтээр ялангуяа төр өөрөө хянадаг байх вэ. Хэрэв 2 жил дараалаад муу гүйцэтгэлтэй ажилласан байх юм бол ямар хариуцлага тооцох вэ. Хариуцлагын механизмыг тодорхой болгож өгч чадсан уу. Ингээд энэ асуултыг асуучихъя.

С.Бямбацогт: Үүрийнтуяа гишүүн хариулъя.

Д.Үүрийнтуяа: Мандхай гишүүний асуултад хариулъя. Төрийн хэмнэлтийн хуулийн 15.4-д энэ төрийн болон орон нутгийн өмчит компанийн гүйцэтгэх удирдлагатай хийж байгаа 1 жилийн гэрээг 3 жил болгож, Төрийн өмчийн хуульд одоо энэ бидний оруулж байгаа хуулийн төсөл дээр өөрчилж байгаатай холбогдуулан энэ хуулийн өөрчлөлтийг оруулж байгаа. Одоо бол бид нар төрийн өмчит компаниудын гүйцэтгэх удирдлагууд 1 жилийн гэрээтэй явж байгаа. Ер нь бол жилийн дараа ажиллах эсэх нь тодорхойгүй хоноцын сэтгэлээр ажилладаг байж боломгүй байгаад байгаа юм л даа. 1 жилийн хугацаанд хариуцсан ажлын бодитой үр дүнг гаргах цаг хугацааны хувьд ч бас биш байгаад байгаа юм. Тухайлбал томоохон компаниуд дээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлээ гэхэд 2-3 жилийн хугацаанд хэрэгждэг төсөл хөтөлбөрүүдийн үр дүн гарах ч боломжгүй байгаад байгаа юм. Энэ хуулиар бид нар даалгаврын гэрээтэй болгоод, 3 жилийн хугацаатай даалгаврын гэрээ байгуулснаар жил тутамдаа даалгаврын гэрээг нь дүгнэнэ. Үндэсний аудитын газар, хууль хяналтын байгууллагын хийсэн хяналт шалгалтын дүн, компанийн дотоод аудит буюу ТУЗ-ийн дэргэдэх аудит энэ бүх хяналт шалгалтын дүнг үндэслэж жил болгон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны үр дүнг дүгнэнэ. 2 жил дараалан зөрчилтэй дүгнэлт авахад ажлаас халагдана. Компанийн удирдлагыг өөрчилнө. Үндэслэл болно.

Хуулийн 33 дугаар зүйл дээр таны асууж байгаа энэ гүйцэтгэх удирдлагад томилох, гүйцэтгэх удирдлага 34 дүгээр зүйл дээр ямар үүрэг хүлээлгэх юм. 36 дээр гүйцэтгэх удирдлагыг чөлөөлөх үндэслэлүүдийг хуулийн заалт бүрээр 1 бүрчлэн оруулж өгсөн байгаа. Бид хариуцлагын тогтолцоог улам бүр нэмэгдүүлэхийн тулд гүйцэтгэх удирдлагатай хийж байгаа гэрээг үе шаттайгаар дүгнэх боломжтой цаг

хугацааг 3 жилээр томъёолон хуулийн төсөлд оруулж ирсэн. Үүнтэй холбогдуулан энэхүү өөрчлөлтийг хийж байгаа.

Чөлөөлөх үндэслэлүүдийг та асуусан учраас би дараах зүйлүүдийг хэлье. Дараах тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчит компанийн захирал, гүйцэтгэх захирлыг ажлаас нь чөлөөж, гэрээг хугацаанаас нь өмнө цуцална гэж 36 дугаар зүйлд заасан. 36.1. Үндсэндээ 36 дугаар зүйл дээр чөлөөлөх 14 үндэслэл байгаа. Хугацаанаас нь өмнө чөлөөлөх 14 үндэслэл байгаа. Тухайлах юм бол хангалтгүй үнэлгээ 3 жил дараалж авах, компанийн төлбөрийн чадваргүй болох, болгосон. ТУЗ-ийн талаар ТУЗ-д ямар нэгэн байдлаар мэдээллээр хангаагүй, өөрийнхөө хүлээсэн үүргийг биелүүлээгүй, санхүүгийн тайлангийн талаар худал мэдээлэл өгсөн, компанийн төсвийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр баталсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан, үр ашиггүй зарцуулсан, мөн бизнес төлөвлөгөө, стратеги төлөвлөгөө боловсруулахад тухайн гүйцэтгэх удирдлагын мэдлэг, ур чадвар хүрэхгүй байгаа нөхцөл байдал үүссэн гэх мэтчилнээр 14 асуудлыг оруулж өгсөн байгаа.

Мөн гүйцэтгэх удирдлага бол энэ хуулиар хүлээсэн гүйцэтгэх удирдлагын үүрэгтэй холбоотойгоор ямар нэгэн компанид буруутай үйл ажиллагаа гаргах юм бол тэр буруутай үйл ажиллагааг гүйцэтгэх удирдлага .../минут дуусав/

С.Бямбацогт: Мэндбаярын Мандхай гишүүн тодруулъя.

М.Мандхай: Яах вэ ерөнхий заалтууд бол байна. Гэхдээ энэ олон улсын жишгийг хэр сайн судалсан бэ. Жишээлбэл, Орос, Солонгос, Хятад, Бутан энэ тэр улсууд бол 2 жил дараалан тодорхой зааж өгсөн KPI үзүүлэлтээр биелүүлээгүй байх юм бол чөлөөлдөг ийм механизм байгаа.

2 дугаарт энэ компанийн хөрөнгийн өгөөж, ашигт ажиллагаа, зах зээлд эзлэх байр суурь өсөн нэмэгдсэн бол тухайн удирдлага урамшуулдаг ийм тогтолцоог оруулсан байна. Энэ яагаад өрийн харилцаа, хөдөлмөрийн бүтээмж гээд KPI үзүүлэлтүүдийг тодорхой зааж өгөөгүй юм бэ. Тэгэхээр энэ өмнөх байсан хуулиасаа яг энэ ашигт ажиллагаа, гүйцэтгэх удирдлагад тавигдаж байгаа өөрөө шаардлага яг ямар түвшинд сайжирч өөрчлөгдсөн юм бэ гэдгийг бас яг сайн энэ хуулиас бол харахгүй байна. Тэгэхээр энэ дээр бас тодорхой хариулт өгөөч. Ер нь олон улсын ямар жишиг улс орныг .../минут дуусав/

С.Бямбацогт: Сайнзориг гишүүн хариулъя. Ажлын хэсгийн ахлагч.

П.Сайнзориг: Компанийн бизнес төлөвлөгөө гэж зүйл байгаа. Энэ зүйлүүдийг ТУЗ баталж өгнө. Гүйцэтгэх удирдлага үүний дагуу даалгаврын гэрээ байгуулж байгаа. Бид нар хөдөлмөрийн гэрээ гэдэг зүйлээр яваад, халагддаг ч үгүй шүүхдэлцдэг хэдэн хүмүүсийг бий болгоод байгаа байхгүй юу. Энэ удаад даалгаврын гэрээ. Тодорхой үр дүн гаргаж чадсан уу, үгүй юу гэдгийг нь үнэлж байж цалин урамшууллаа авна. Энэ бүх зүйлүүд таны яриад байгаа тэр KPI. Энэ дээр маш тодорхой заачихсан байгаа. Энэ зүйлүүдэд хүрч чадаагүй бол ингэж чөлөөлнө шүү гэдэг зүйлүүдийг ярьчихсан. Одоо компанийн төлбөрийн чадваргүй болсон талаар ТУЗ-д мэдэгдээгүй, дампуурлын өргөдөл гаргаагүй, хууль болон компанийн дүрэмд гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй. Энийг нөгөө гэрээнд нь энэ үзүүлэлтүүдийг зааж өгнө шүү дээ.

Тухайн компанийн эрхлэх асуудлын хүрээ гэдэг юм уу, яг компанийн дүрэмд заасан тэр бизнесийн үйл ажиллагааны онцлогт нь тааруулаад энэ бүх зүйлүүдийг ТУЗ болон төрийн өмчийн компанийн талаар баримтлах төрийн өмчийн бодлогод тусгасан энэ.../минут дуусав/

С.Бямбацогт: Цэндийн Баатархүү гишүүн асуултаа асууя. Алга байна. Чинбатын Ундрэм гишүүн асуултаа болилоо гэж байна. Гишүүд асуулт асууж дууслаа.

Байнгын хорооны гаргасан горимын саналаар санал хураалт явуулах ёстой. Санал хураалтыг хойшлууллаа. 17 цагаас.

13.00 цаг.

Цайны завсарлагагүй хуралдъя гишүүд ээ. Өнөөдөр 19 асуудал хэлэлцэх ёстой. Одоогоор 7 дахь асуудал дээр явж байгаа. Бас олон санал хураалтууд байгаа. Тийм болохоор цайны завсарлагагүй явна. Манай Тамгын газрынхан бас ээлжлээд, боломжоороо цайндаа орчхоорой.

Асуулт асуух, үг хэлэх гишүүд бас чуулганы хуралдааны танхимдаа хүрэлцэн ирээрэй. Бас ээлжлээд орж, гараад цайгаа уучих боломжтой байх гэж бодож байна.

Одоо “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” асуудлыг хэлэлцэнэ. Газар зүйн нэрийн жагсаалт батлах, араас нь Бизнесийн эрх чөлөөний тухай хууль, Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулна. Араас нь Орон сууцжуулалтын тухай хууль гээд ингээд хэлэлцүүлэг байгаа шүү. Асуулт асуухаар, үг хэлэхээр нэрсээ өгсөн гишүүд бэлтгэлтэй байгаарай. Чуулганы танхимдаа хүрэлцэн ирээрэй гэдгийг бас хэлье.

Дараагийн асуудалдаа оръё.

“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Б.Уянга: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2026 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр шилжүүлсэн.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа дээрх тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулсан.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдэлж, Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн тогтоолын заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөн бүтэц найруулга, латин хөрвүүлэхэд холбогдох хууль зүйн техникийн засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулга, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг хэлэлцэн тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Уянга гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Анандын Энхманлай Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга, Далхаагийн Мөнхцэцэг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын Геодези, зураг зүйн хэлтсийн дарга, Баянмөнхийн Оюунхорол Сүхбаатар аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга, Цэгмэдийн Цэрэндорж Шинжлэх ухааны академийн Нийгмийн шинжлэх ухаан хариуцсан дэд ерөнхийлөгч, шинжлэх ухааны доктор, академич, Нямхүүгийн Нарангэрэл Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албаны дарга, Цэрэнгийн Наранцацрал Шинжлэх ухааны академийн Газар зүй, геологи, геоэкологийн хүрээлэнгийн Газар зүйн мэдээллийн систем, зураг зүйн салбарын дарга, Очирбатын Самбуудорж Шинжлэх ухааны академийн Хэл, зохиолын хүрээлэнгийн Хэл шинжлэлийн салбарын эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор, Мөнхбатын Очирцэнд Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн Харьцуулсан хэл шинжлэлийн салбарын эрдэм шинжилгээний дэд ажилтан, Дурангийн Оюунчимэг Монгол Улсын гавьяат барилгачин, зөвлөх инженер.

Гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Батын Батбаатар гишүүн алга байна. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэболд: Энэ их чухал зүйл гэж харж байна. Тодруулах зүйл байгаа. Одоо энэ тогтоолын нэмэлт дээр яг латинаар галиглаад газар усны нэрийг бичсэн байгаа. Гэхдээ дотроо бас яг ингээд англи холимог бас байгаад байна гэж харж байгаа юм. Жишээлбэл Цагаан нуурыг галиглахдаа “Т, S” гээд англи галиг байгаад байгаа. Заримдаа болохлоороо “И” үсгийг “Y”-аар бичээд, латин галигаар нь бичээд заримдаа болохлоор жишээлбэл Ар булгийн ам гэхийг 2 цэгтэй “ii”-аар бичээд.

Тэгэхээр энэ яг нөгөө латин галиг, англи хэлний галиг 2-ыг яг яаж ойлгох юм бэ гэдэг асуулт байгаад байгаа юм. Тухайлбал мэдээж латин галиг нь шинжлэх ухааны яг этимологи буюу үг зүйн гарваль зүй талдаа зөв байх л. Тэгэхээр яг одоо бол бид нар энгийн хэрэглээн дээр google map ч гэдэг юм уу ингээд аялал жуулчлын газрын зураг дээр бүгдээрээ англиар гарч ирдэг. Тэгэхээр миний асуулт болохлоороо яг тогтоол дээрээ латинаар галиглахаас гадна, ард нь англи галиг нь давхар оруулбал болох байсан уу. Би дан латин галигаар нь оруулж байгаа юм байна гэж бодсон чинь үсэгчлэлийн хувьд гэх юм англитай холимог ороод ирж байна л даа. Тэр 9 дүгээр хуудсан дээр байж байгаа зүйлс гээд аваад үзэх юм бол. Тэгэхээрээ харьяалахын тийн ялгалыг жишээлбэл нэг бол “Y”-аар, нэг бол 2 цэгтэй “ii”-аар бичдэг ч гэдэг юм уу. Энэ дээр яг яаж журамлах юм бэ. Энэ дээр хариулт авмаар байна. Тэгээд хариултаас нь хамаараад тодруулъя.

С.Бямбацогт: Болдын Уянга гишүүн хариулъя.

Б.Уянга: Эрдэнэболд гишүүн нэлээн нарийн харсан байна. Энэ бас Их Хурал дээр байгуулагдсан ажлын хэсэг дээр яригдсан зүйл юм байгаа юм. Тэгээд жишээ нь харьяалахын тийн ялгал дээр бол “Y” үсэгтэй харагдаж байгаа нэрүүд нь 2003 онд Улсын Их Хурлын тогтоол гарахдаа тухайн үед Монгол үсгийг латин хэл рүү хөрвүүлэх MNS стандартад нь харьяалахын тийн ялгалыг “Y”-аар бичдэг байсан юм байна лээ. Ингээд 2 “ii”-аар бичиж байгаа нь болохоороо одоо 2012 оноос хойш мөрдөж байгаа MNS стандарт дээр харьяалахын тийн ялгалыг 2 “ii”-аар бичиж байгаа. Тэгээд ингээд холигдож уншиж байгаа юм шиг харагдаж байгаа боловч нөгөө 2003 онд батлагдсан “Газар зүйн нэрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад нь өөрчлөлт оруулж байгаа учраас тухайн үеийн стандартаар бичигдсэн галигласан нэрс нь тэгээд одоогийнх руу хөрвүүлж шинээр нэмэгдэж байгаа нь гээд ийм харьяалахын тийн ялгал дээр та жишээ авч ярьж байна. Яг наадах дээр илүү тод харагдана. Өшөө бас “Ө” үсэг дээр дээрээ 2 цэгтэй байдлаар ингээд харагдаж байгаа.

Ингээд ажлын хэсэг дээр нэлээн асуудал болсон. Стандартууд шинээр латин хэл рүү хөрвүүлэгдэх стандартууд өөрчлөгдөх тухай бүрд нь энэ тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулаад байх юм уу. Эсвэл яг энэ галиглаж хэрэглэхдээ тухайн үед хүчин төгөлдөр байгаа стандартаа мөрдөх ёстой юм уу гээд. Тэгээд хамгийн зөв шийдэл нь хэлний бодлогын зөвлөл рүү явуулаад чиглэл авъя гэсэн байгаа юм. Зөвлөмж авсан. Тэгээд энэ өөрсдийнхөө тогтоолын хавсралтыг хэлний бодлогын зөвлөл рүү явуулаад, үзүүлээд, тэгээд бид нарт ямар хариу ирсэн бэ гэхээр 1 дүгээрт Монгол хэлнийхээ дүрмийг барьж нэрсээ бич. Яг одоо Монгол хэлнийхээ хэл зүйн дүрмээрээ. 2 дугаарт болохоороо стандартаа латин үсэг рүү хөрвүүлж байгаа стандартаа одоо мөрдөгдөж байгаа 2012 оны MNS стандартыг мөрд гэсэн ийм чиглэл ирсэн. Үүний хүрээнд нь тогтоолынхоо хавсралтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны манай зөвлөх, референтүүд нийлж байгаад эцэслээд гаргаад, Байнгын хорооны хурлаар ороод гаргасан байгаа юм.

Тэгээд ингээд ер нь бол Ганхүлэг гишүүнээс л их санал гарсан байгаа юм. Яасан гэхээр дараа дараа стандартууд мэдээж өөрчлөгдөнө. Жишээ нь дээрээ 2 цэгтэй “Ө” үсгийг яаж бичих юм бэ гээд. Тэгээд ингээд стандартаа барь гээд хэлний зөвлөлөөс ирсэн хэдий ч 2012 оны стандарт сайжруулагдана гээд л яриад байгаа юм. Нөгөө гүүгл дээр хэрэглэгддэг үсгүүд рүүгээ хөрвөнө гэх мэт. Энэ нь арай

эцэслэгдээгүй байгаа үед энэ тогтоолын хавсралт батлагдах гэж байгаа учраас 2012 оноо бариад ингээд гарч байна. Тэгэхдээ цааш цаашдаа хэрвээ стандарт латин үсэг рүү Монгол үсгийг хөрвүүлэх стандарт шинэчлэгдэх юм бол тухай бүрд нь Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас энэ нэрсийгээ хэвшүүлж, хэрэглээнд нэвтрүүлэхдээ тэр үеийнхээ стандартаар хөрвүүлэе л гэсэн ийм байдлаар тогтоолын төсөлд нэмж бас тусгасан байгаа. Улсын Их Хурлын тогтоолын төсөлд.

С.Бямбацогт: Эрдэнэболд гишүүн тодруулж асууя.

С.Эрдэнэболд: Ойдовын Сүхбаатар гээд профессор байгаа. Ер нь түүхэн газар зүйч, газар зүйгээр мэргэшсэн. 1 сая гаран километр өөрөө явж үзсэн, судалгаа хийсэн хүмүүс байгаа. Тэгэхээр ер нь бол энэ газрын зураг дээр газар усны нэр 1 дүгээрт монголоороо байх ёстой. Монголоороо гэдэг нь одоо бол кирилл бичиг бид нар хэрэглэж байна. 2025 оны 01 сарын 01-ээс Монгол хэлний хуулиар Монгол бичиг маань төрийн цөм хэрэглээ болж байгаа. Тийм учраас яг энэ зүйл дээрээ, тогтоол дээрээ бас кириллээс гадна Монгол бичгээрээ яг ингэж бичнэ гэдгийг нь журамлах зайлшгүй шаардлагатай байгаа.

2 дугаарт олон улсын яг шинжлэх ухаан талаасаа бол латин хэлээр нь оруулаад, дээрээс нь нэмэлт санал нь болохоор англи хэл дээр заавал оруулах ёстой. Яагаад гэхээр жуулчдад бас энэ латин хэл дээрх юм харагддаггүй шүү дээ. Тэгэхээр энийгээ нөгөө .../минут дуусав/

С.Бямбацогт: Асуултаа гүйцээгээд асуучихъя. Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Тэгэхээр яг нөгөө google map, google earth дээр орохоор яг англи хэл дээр энэ чинь ингээд галигчлаад гараад ирдэг. Гэхдээ бид нар бол одоогийн байдлаар google рүү галиглаж өгөхгүй байгаад байгаа. google бол өөрсдөө ингээд галиглаж байгаа. AI буюу хиймэл оюун ашиглаад байх шиг байгаа юм. Тэгэхээр энэ дээр бид нар ч гэсэн яг энэ хэлний зөвлөл, энэ тогтоолын төсөл санаачлагчид маань бас яг ингэж ингэж англи хэлээр оруулна гэдгийг нь тавьж өгвөл их зүгээр. Одоо манайх чинь бас нэг үеэ бодвол олон зуун, мянган жуулчид авдаг болчихсон байгаа. Тэгээд тэр нь болохоор энэ латин чинь болохоор тогтоол дээрээ л байгаад байгаа болохоос биш google map руу орохгүй шүү дээ. Тэр google map руугаа ордог тэр англи хэлнийх нь этимологи талаас нь лингвистик талаас нь тодорхойлолтуудыг нь гаргаж өгмөөр байна. Ийм гүйцэтгэлийн боломж байгаа юу гээд тодруулчихъя.

С.Бямбацогт: Уянга гишүүн хариулъя. Ажлын хэсгээс нэмж хариулж болно шүү.

Б.Уянга: Энхманлай дарга юм уу, эсвэл ажлын хэсгээс нь нэмээд хариулаарай. Гэхдээ би 1 зүйлийг хэлэх гээд. Тэр нь болохоор Геодези, зураг зүй газрынхан болохоороо ер нь бүх аймгуудынхаа энэ газар зүйн нэрийг нь шинээр тогтоогоод, эсвэл шаардлагатайг нь нэмж оруулаад ингээд Улсын Их Хурлын тогтоолууд ирэх намрын чуулганаас орж ирээд байх юм байна лээ. Тэгээд жишээ нь 2027 оны намрын чуулганд Баян-Өлгий аймгийнх тэр чигтээ бүхэлдээ, бүх сумдаараа орж ирнэ гэх мэтчилэн. Тэгэхээр яг энэ үед нь тогтоолынх нь аль нэг заалтад нь хөрвүүлээд явуулах боломжтой байх. Тэгээд Байнгын хороон дээрээ бас нөгөө Монголын Тувачуудын нийгэмлэгийнхэн бас ирээд зарим үгийн орчуулга нь

өөр байна гэсэн асуудлуудыг бол тавьсан. Тэгэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороон дээр ер нь энэ нэрийн орчуулгууд газар зүйн нэртэй холбоотой мэдээлэл сонсьё гэж байгаа. Тэгээд тэр үед нь бас Эрдэнэболд гишүүнд мэдээллийг нь хүргүүлъя. Манай ажлын хэсгээс нэмээд хариулъя.

С.Бямбацогт: Энхманлай дарга, араас нь бас нэмээд хариулчхаарай. 4 дүгээр микрофон.

А.Энхманлай: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Газар зүйн нэрийн тодруулалтын ажил өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд нийтдээ 19 аймгийн 159 сум дээр, мөн нийслэлийн 9 дүүрэг дээр хийгдэж дуусаад байгаа. Өнөөдөр бол зөвхөн 2 аймгийн газар зүйн нэрийн асуудал орж ирж байгаа. Тэгэхдээ бид нар энэ 2003 онд батлагдсан газар зүйн нэрийг шинээр тодруулахдаа мэдээллийн сан үүсгэж байгаа. Тэгээд мэдээллийн сангаараа дамжуулаад бид бүхэн бас газар зүйн нэрийн нэгдсэн системийг байгуулж байна. Энэ системээр дамжуулаад саяын дурдаж байгаа газар зүйн нэрийг галиглаж хэрэглээнд гаргах, энэ шууд системийн хөгжүүлэлтийг хийсэн. Өөрөөр хэлбэл латин нэр лүү, Монгол бичиг рүү, англи хөрвүүлэг рүү зэрэг шууд энэ системээс хүмүүс хэрэглэхдээ шууд тухайн газар зүйн нэрийг хөрвүүлгээр нь зөв галигаар нь шууд хэрэглэх бололцоотойгоор ингэж системийн хөгжүүлэлт хийж байгаа. Энэ талаараа бас өнөөдөр .../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя. Энхманлай дарга. 4.

А.Энхманлай: Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр бас ийм өөрчлөлтийг оруулж өгсөн. Зарим бас ажлын хэсгийн гишүүдээс яг энэ төрлийн хүсэлтийг гаргасан. Мөн google программ дээр гээд олон улсад хэрэглэгдэж байгаа программууд дээр бас энэ өгөгдлүүдийг бид нар хүргэхдээ тус системээс шууд дамжуулж, газар зүйн зөв нэрлэлүүдийг гаргахаар ийм бас системийн тохируулгуудыг хийж өгч байгаа.

С.Бямбацогт: Нэмээд хариулчихъя. Өөрийгөө танилцуулаад, хариулчхаарай.

Ц.Цэрэндорж: Цэрэндорж ажлын хэсгийн гишүүн. Эрдэнэболд гишүүний галигийн тухай асуултад нэмэлт хариулт өгье.

Манайхны дунд бас ийм жоохон буруу ойлголт байгаад байгаа юм. Англи галиг гэж юм яриад байгаа юм. Англи галиг гэдэг юм хаана ч байхгүй. Шулуухан хэлье. Ажлын хэсэг дээр, Байнгын хороо дээр бас тиймэрхүү юм гарсан. Ерөөсөө Монгол хэлийг латин үсгээр хэрхэн галиглах вэ л гэдэг л ганцхан асуудал байгаа. Оноосон нэр хүний нэрийг Англи болгож болохгүй шүү дээ. Газар усны нэрийг ч болохгүй. Тийм учраас энэ латин үсгийн галиг бол Монгол улсад мөрдөгдөж байгаа ганцхан стандарт MNS 52172012 гэсэн энэ стандартын дагуу энэ газар усны нэрийг бид нар латин үсгээр галиглаж байгаа. Тэгээд яагаад зарим нь “I”-аар зарим нь “Y”-аар үсгээр байна гэхээр Монгол хэлний эр, эмийн “И” гэж 2 “И” үсэг байгаа шүү дээ. Тэрний эр үгийн “И”-г нь “Y” үсгээр, эм үгийн “И”-г нь 2 “ii” үсгээр галиглаж байгаа гэх мэт ийм жишээтэй байгаа юм. Тэгэхээр Монгол улсад мөрдөгдөж байгаа ганцхан энэ стандартын дагуу л бид нар галиглаж яваа. Үүгээр ч ер нь галиглах ёстой. Харин манайхан паспорт дээрээ, гадаад паспорт дээр шал өөр маягаар галиглаад, хүмүүс тэрийг нь зөв гээд ингээд ойлгоод байдаг. Тийм эндүүрэл байгаа юм байна лээ.

Тэгэхээр энд бол хууль зөрчсөн ч юм уу, ямар нэгэн алдаа гаргасан зүйл байхгүй гэдгийг хэлье. Баярлалаа.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Энэ бол их чухал асуудал хэлэлцэж байгаа. Засгийн газраас өнгөрсөн намар өргөн барьсан. Монгол Улсын газар, усны нэрүүдийг дур дураараа өөрчилдөг, өөр өөрсдийн үндэстэн ястан, онцлогоороо дууддаг, нэрлэдэг, өөрчилдөг энэ асуудлыг таслан зогсоож байгаа. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр Монгол Улсын хууль үйлчлэх ёстой. Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж болгон Монгол Улсад амьдарч байгаа, оршин сууж байгаа иргэн болгон Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулах үүрэгтэй. Энэ хүрээндээ Монгол Улсын газар зүйн нэршлүүдийг Монголын албан ёсны хэлээр, албан ёсны оноосон нэрээр оноосныг өөрчлөхийг хориглосон, өөрчилснийг зассан ийм хууль, тогтоолыг бид батал батлах гэж байна.

Мөн бас энд галиглах асуудал дээр гадаад дотоодын иргэд бас Монгол кирилл үсэг тэр болгон уншиж ойлгодоггүй учраас кириллээр албан ёсны Монгол албан ёсны нэрлэсэн нэрийг англиар галиглаж ингэж бичих юм гэдгийг л бас бид нар цэгцэлж өгч байгаа. Тийм учраас үүнээс хойш, түүнээс цааш Монгол Улсын нутаг дэвсгэр дээр Монгол Улсын газар нутгийн нэрийг хэн нэгэн дураараа өөрчлөх, нэрлэх энэ асуудал таслан зогсоож байгаа шүү. Энэ тогтоолоор. Ийм чухал тогтоолыг бид нар бас баталж байгаа гэдгийг хэлье. Энэ бас мөрдөгдөх ёстой, мөрдүүлэх ёстой шүү гэдгийг хэлье.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч үг хэлж дууслаа. Санал хураалтыг 17 цагаас тусгайлан явуулна. Үг байхгүй.

13.17 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Бизнесийн эрх чөлөөний тухай /Эдийн засгийн эрх чөлөөний тухай/ хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулна.

Төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг танилцуулна.

Г.Уянгахишиг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдөр өргөн мэдүүлсэн Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг 2026 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Мөн Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Б.Жаргалан, Г.Очирбат нарын гишүүд 2026 оны 06 дугаар сарын 05-ны өдөр өргөн мэдүүлсэн Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг 2026 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн Улсын Их Хурлын

чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, дараах санал, дүгнэлтийг танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Их Хурлын даргын 2026 оны 278 дугаар захирамжаар дээрх хуулийн төслүүдийг нэгтгэн Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшинээр ахлуулж, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, С.Зулпхар, Б.Мөнхсоёл, Э.Одбаяр, Б.Пунсалмаа, Д.Пүрэвдаваа, П.Сайнзориг, Г.Уянгахишиг, Д.Үүрийнтуяа, С.Цэнгүүн нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Ажлын хэсэг Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлтэй холбоотойгоор Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн нэгтгэсэн төслийн нэрийг Эдийн засгийн эрх чөлөөний тухай тухай гэж өөрчлөх, нэгтгэсэн төсөлд хуулийн зорилт, эдийн засгийн эрх чөлөөг хангах талаар баримтлах зарчмыг тодорхойлох, эдийн засгийн эрх чөлөөг хангах, төрийн бодлого, зохицуулалт, ил тод байдлыг хангах, хянах, төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэр, үйл ажиллагаа, үйлдэл, эс үйлдэхүйгээс бизнес эрхлэгчид учирсан хохирлыг түр хуульд заасны дагуу нөхөн төлөх, хууль зөрчсөн төрийн байгууллага, албан тушаалтан, хүн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх зэрэг 28 зарчмын зөрүүтэй санал бэлтгэсэн.

Мөн Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбоотойгоор зарчмын зөрүүтэй саналыг бэлтгэсэн байна.

Нэгтгэсэн хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан болон ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн бэлтгэлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.26 дахь хэсэгт 1 асуудлаар 2 ба түүнээс дээш хуулийн төсөл өргөн мэдүүлсэн бөгөөд хууль санаачлагчид нь нэгтгэн хэлэлцэхийг зөвшөөрсөн бол Байнгын хороо тэдгээрийг анхны хэлэлцүүлгийн шатад нэгтгэн 1 төсөл болгож, Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамтаар нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ гэж заасныг үндэслэн нэгтгэсэн 1 төсөл, олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.Пүрэвдорж: Гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулна.

Жадамбаагийн Энхбаяр Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Хаш-Эрдэнийн Сүрэнхорол Ерөнхий сайдын зөвлөх, Сүхээгийн Тэнгис Ерөнхий сайдын зөвлөх, Ганбаатарын Жавхлантөгс Шадар сайдын зөвлөх, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Батжаргалын Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалт бодлогын газрын дарга, Саруулын Пүрэвсүрэн Эдийн засаг, хөгжлийн яамны Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга, Жамбалдоржийн Мягмарсүрэн Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга.

Ажлын хэсэг гишүүдэд үнэн зөв мэдээлэл өгөх ёстой. Хэрвээ буруу мэдээ мэдээлэл өгч, худал мэдээлэл өгөх юм бол хариуцлага тооцно.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Отгоны Саранчулуун гишүүн асуулт асууя. Алга байна. Батын Батбаатар гишүүн алга байна. Мэндбаярын Мандхай гишүүн алга байна. Цэндийн Баатархүү гишүүн алга байна. Равжихын Эрдэнэбүрэн гишүүн алга байна. Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууя.

Х.Ганхуяг: Энэ их чухал хуулиуд орж ирсэн байна. Тэгэхдээ хэдэн 5, 6 асуулт байна.

1 дүгээр асуулт бол би энийг Тамгын газраас техникийн хувьд асуух гэсэн юм. Малгай хуулийн доор дагасан хуулийг дахиад дагасан хууль орж ирж байгаа зохицуулалт нь ер нь хэр оновчтой байсан бэ гэдэг 1 дүгээр асуулт. Энийг Тамгын газраас тодруулчаарай.

2 дугаарт энэ Зөвшөөрлийн хуультай холбогдуулаад Стандарт хэмжил зүй, Төрийн хяналт шалгалтын хуулийг хамт оруулж өгөх ёстой байсан юм. Яагаад гэхээр бид нар энэ хуучин Зөвшөөрлийн хуулийг Зөвшөөрөл мэдэгдлийн хууль болгоод, мэдэгдлийг бол шууд мэдэгдээд үйл ажиллагаа эрхэлж болно гээд, зөвшөөрлийн нэг төрөл буюу хялбаршуулж байгаа гэсэн үг. Тэр бол эргээд ямар нэгэн бичиг баримт авахгүйгээр, тэр стандартынхаа шаардлагыг хангаад, ажлаа эхэлж болно гэдэг тийм зөвшөөрөл байхгүй юу. Тэгэхээр энэ чинь өөрөө эргээд эрсдэлийн үнэлгээ дээр тулгуурлаж аль зөвшөөрөл, мэдэгдэл байх вэ гэдгийг анх энэ хууль бичихдээ бид нар гаргаад оруулсан байдаг юм. Тэгээд энэ дээр яалт ч үгүй хамт явах ёстой юм нь Стандартын хууль хамт явах ёстой байсан. Стандарт хэмжил зүйн хууль хамт явах ёстой байсан, Уг нь бол тэр юунд байхдаа уг нь биччихсэн байсан. Тэгээд энийг өргөн барихгүй хаягдуулчихлаа л даа. Тэгээд

Төрийн хянан шалгалтын хууль. Яагаад вэ гэхээр тэр мэдэгдлийн дагуу үйл ажиллагаа явуулаад хэзээ, яаж шалгадаг байх вэ гэдгийг нь хуулиараа бид нар оруулж өгөх ёстой байсан. Тэгээд энэ 2 хууль хаягдсан байна гэдэг асуудал. Тэгээд энэ дээр бас хууль санаачлагчдын зүгээс байр суурийг нь тодруулчихмаар байна.

3 дугаар асуудал нь бол энэ ангилалтаы холбоотой асуудал байгаа. Бид нар хуучин тусгай зөвшөөрөл энгийн зөвшөөрөл гээд ангилалтай байсан. Одоо манай Пүрэвдорж дэд дарга бол маш сайн гэж байгаа. Энэ ангиллуудыг нь бид 2500 зөвшөөрлийг 370 болгоод, тусгай зөвшөөрлийг болохоор эрсдэлтэй, Үндэсний аюулгүй байдал, байгалийн баялаг ашиглах зэрэг аж ахуйн чиглэлийн зөвшөөрлүүд бол тусгай зөвшөөрөл болгосон. Энгийн зөвшөөрлүүд бол өрхийн хэрэглээний, иргэний хэрэглээний зөвшөөрлүүдийг энгийн зөвшөөр үлдээсэн байдаг. Мэдэгдлийг оруулж ирэхдээ энэ 2 зөвшөөрлүүдээс мэдэгдэл рүү шилжихээр уг нь хуулийн зохицуулалтыг оруулж ирсэн боловч тэгээд энэ дундаа жоохон найруулгын асуудлууд орж ирээд нөгөө эрсдэлтэй үйл ажиллагаагаар нь ангилаад энэ 3 ангилал руу оруулж байгаа байдлаар ингээд томьёолсон байна. Гэтэл нөгөө салбар хуулиуд руугаа тэр томьёоллуудаа оруулсан нь жоохон дутуу ажилласан нь харагдана лээ. Тэгээд энэ дээр бас ажлын хэсэг ажиллах шаардлагатай гэж харж байна. Энэ дээр ажлын хэсгийн ахлагч бас анхаарна биз дээ.

4 дэх асуудал энэ айма, нийслэл ингээд дураараа зөвшөөрөл бий болгодог асуудал байгаа. Нөгөө бүртгэл нэрээр иргэдийн Хурал нь 1 тогтоол гаргаад, тэгээд бүртгэж байгаа гээд л нөгөө үсчин, гоо сайхан, 8 нэрийн барааны дэлгүүрүүдийг бүртгэл нэрээр бүгдийг нь зөвшөөрүүлжүүлээд хаячихдаг. Тэгээд энэ чинь бараг 100 гаруй зөвшөөрөл тухайлбал нийслэл бол ингээд гаргачихсан байсан. Тэгээд энийг уг нь хязгаарлалт хийх хуулийнх нь төслийг нь уг нь бичиж өгсөн. Тэгээд энийг хамт өргөн бариагүй байна л даа. Тэгээд энэ дээрх ер нь хязгаарлалтын зохицуулалтаа ер нь яаж энэ хуулиараа хангах вэ гэдгийг асуучихмаар байна.

5 дахь асуудал энэ салбар хуулиудаар хуулийн хулгай гэх үү ингээд зөвшөөрлүүд нэмээд явчихдаг. Нөгөө зөвшөөрлийн зөвлөлөөрөө ч ордоггүй, Засгийн газраар ч ордоггүй. Яг өнөөдөр энэ Их Хурал дээр хэлэлцэгдээд явж байгаа энэ Тамхины хяналтын хууль дээр 12 төрлийн нэр төрлийн зөвшөөрлийг задлаад ороод ирж байгаа. Уг нь бол салбар хуулиар зөвшөөрлийг задлах, нэмэх хориотой байгаа. Гэтэл ингээд задлаад ороод ирчихсэн байдаг. Өнөөдөр яг ингээд бид нар бас хэлэлцэх гээд байж байгаа. Тэгээд энэ асуудал дээр ямар зохицуулалт орж ирж байгаа юм. Энийг хязгаарлах тал дээр. Энэ чинь бол одоо.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Эдийн засаг хөгжлийн сайд Ж.Энхбаяр хариулна.

Ж.Энхбаяр: Энэ цогц хууль орж ирэх учир шалтгаан Монгол Улсын бизнес, хөрөнгө оруулалтын орчин ер нь ямар байгаа талаар ингээд Засгийн газар үүрэг өгөгдөөд, бүтэн өвөлжингөө ажилласан. Үнэхээр манай бизнес, хөрөнгө оруулалтын орчин нэлээн хүндэрчихсэн байгаа. Дэлхийн эдийн засаг дахь эрх чөлөөт байдлын индексээр нэлээн, үүн дотор хөрөнгө оруулагчид ээлтэй байдал нэлээн хойгуур болсон. Манайд орж байгаа хөрөнгө оруулалтын урсгал саарсан. Эсрэгээрээ Монголоос гарч байгаа хөрөнгө оруулалтын урсгал нэмэгдээд байгаа ийм байдал үүссэн. Энэ болгонд үндсэндээ дүн шинжилгээ хийгээд, Монгол Улс хөрөнгө оруулалтынхаа орчныг эрс сайжруулах шаардлагатай байна. Энэ хүрээнд бизнесийн эрх чөлөөний суурь хууль буюу өмчийн халдашгүй дархан байдал,

бизнесийн нэр хүндийн асуудал, эдийн засаг дахь төрийн оролцооны асуудлыг нэг мөр шийдье. Энийгээ дагаад хөрөнгө оруулалтын орчноо таатай, хөрөнгө оруулалтад ээлтэй ийм орчныг бүрдүүлье. Энийгээ дагаад гол хөрөнгө оруулалтын орчин сөргөөр явж байгаа зөвшөөрөл, мэдэгдлээр бизнес үйл ажиллагааг хязгаарлаж байгаа, оролцож байгаа зохицуулалтыг нэг мөр болгож, өөрчлөлт оруулъя гэсэн ийм бодлого чөлөөлье гэсэн энэ үзэл санааны хүрээнд, Засгийн газрын бодлогын хүрээнд орж ирж байгаа.

Төрийн хяналт шалгалтын тухай хууль дээр Улсын Их Хурлаас чиглэл өгөөд ажилласан. Төр, олон нийтийн хяналтын тухай хууль гэдгээр боловсрогдоод Засгийн газар дээр танилцагдаад, Улсын Их Хуралд өргөн барихаар бэлэн болчихсон тул энэ асуудалд ороогүй. Мөн өчигдрийн Засгийн газрын хуралдаанаар бид нар Стандарт хэмжил зүйн тохирлын энэ чиглэлийн хуулийн шинэчилсэн найруулгыг Засгийн газар хэлэлцээд, мөн Их Хуралд өргөн барихаар шийдэгдсэн. Нэг талдаа бизнесээ дэмжье, нөгөө талаас төрийн хяналт шалгалт оролцоо яаж байх юм. Энэ 2-ын дунд буюу гол тохироо болсон тэр стандартууд, техникийн тохирлууд, лабораторийн хяналтууд яаж явах вэ гэдэг юмаа ингээд цогцоор нь дагаж орж ирж байгаа. Тэгээд бид ээлж дараатай өргөн бариад, ингээд явж байна. энэ суурь 3 хууль маань гарсны дараа бид энэ төрийн хяналт шалгалтын хуулийг Төр олон нийтийн хяналтын тухай хууль, Стандарт хэмжил зүйн хууль 2-ыг ингээд хамт өргөн барихад бэлэн болчихсон байгаа. Чадвал энэ хаврын чуулган завсарлахаас өмнө өргөн барина. Ингээд нэг цогц эдийн засаг дахь төрийн оролцоо, төрийн хяналт шалгалт, үүнд олон нийтийн тавих хяналт, Монгол Улс мөрдөх хяналт, техникийн тохирол, лабораторийн асуудлууд нэг мөр шийдэгдэх юм. Ийм цогц хүрээнд энэ бодлогоор ингэж орж ирж байгаа.

Тэгэхээр саяын хэлдэг төрийн хяналт шалгалтын хууль, Стандартын хууль бол бие даасан хуулиудаараа шинэчлэн орж ирж байгаа шүү гэж. Бусад нь ажлын хэсэг хариулаарай.

Б.Пүрэвдорж: Тэр 12 зөвшөөрөл ингээд дагалдаад ороод ирчихсэн байна. Тэр дагалдах хуулиар хориглочихсон байтал яагаад орчхов гэдэг асуудал дээр ажлын хэсэг. Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн гишүүн Жаргалан хариулъя.

Б.Жаргалан: Өнгөрсөн хугацаанд бол яах аргагүй Монгол Улсын эдийн засаг дахь төрийн оролцоо хэрээс хэтэрсэн. Бүх зүйлд төр оролцдог болсон. ДНБ төсвийн зарлагын эзлэх хувь, татварын ачаалал, энэ төрийн өмчит компаниудын борлуулалтын орлого гэх мэт ер нь төрийн оролцоогүй зүйл байхгүй болсон. Энэ зөвшөөрлийн харилцаа бол бас яг энэ асуудлын нэг хэсэг. Ер нь бол Монгол Улсад яг ийм байнгын үйлчлэлтэй 400 гаруй хууль байгаагаас бараг 80 орчим нь яг ийм зөвшөөрлийн агуулгатай. Ямар нэгэн зөвшөөрөл олгох гээд байдаг. Тэгэхээр энэ Эдийн засгийн эрх чөлөөний хууль батлагдсанаар цаашид ийм зөвшөөрлүүдийг бол ингэж дураараа батлахгүй. Ийм хязгаарлалтууд, ийм зарчмуудаа бол томьёолж байгаа. Гэхдээ бол Хассуурийн Ганхуяг гишүүний хэлж байгааг бол ойлгож байна. Сая жишээлэх юм бол одоо бид нар энэ Эдийн засгийн эрх чөлөөний хуулийг хэлэлцэж байх явцад давхар шинэ төрлийн зөвшөөрлүүд бий болгож байгаа бас хуулиуд орж ирээд байгаа нь бол асуудалтай байгаа. Өөр хуулиудаар.

Б.Пүрэвдорж: Хассуурийн Ганхуяг гишүүн 5 асуулт асуусан. Тэр индэр дээрээс 4 дүгээр микрофоноос эхлээд хариулъя. Ажлын хэсгийн ахлагч Энхтүвшин хариулна.

Д.Энхтүвшин: Энэ хууль бол ер нь хувийн хэвшлийн эдийн засгийн эрх чөлөөнд маш чухал хууль. Зөвшөөрлийн тухай хуулийг баталсан байгаа. Энэ хуулийг 3 жилийн өмнө баталсан. Тэгээд энэ хуулийг Ганхуяг гишүүн ахалж ажиллаж байсан. Тэгэхээр энэ хуулийн хаана нь юу байгааг, илүү сайжруулах орон зайг бол хамгийн сайн мэдэж байгаа гишүүн бол Ганхуяг гишүүн байгаа. Тэгэхээр энэ эрсдэлийн үнэлгээ дээр суурилсан төрийн хяналт шалгалттай холбоотой стандарт хэмжил зүйтэй хамт өргөн барих энийг бол санал нийлж байгаа.

Тэгэхээр энэ хаврын чуулганы эхэнд бол Стандарт хэмжил зүйн тухай хуулийг буцаагаад татчихсан байгаа. Тэгээд сая Энхбаяр сайдын хэлснээр энэ хуулиудыг бол буцаагаад өргөн барьж, оруулж ирэх юм байна гэж бодож байна. Тэгээд ингэснээрээ илүү цогц болно. Өөрөөр хэлбэл чөлөөтэй эрхлэхээс гадна энэ зөвшөөрлийн бас хуулийн агуулга нь нийтийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой зохицуулалтууд нь энэ хуулиудаар хангагдах ёстой байгаа. Тэгээд аймаг нийслэлтэй холбоотой энэ зөвшөөрлүүдийн нэг том орон зай болохоор засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний нэгжийн удирдлагын тухай хууль дээр.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

С.Тэнгис: Ерөнхий сайдын зөвлөх Тэнгис байна. Ганхуяг гишүүний асуултад багцлаад хариулъя. Нөгөө хоорондоо уялдаатай асуудлууд байгаа учраас.

1 дүгээрт стандартын тухай хууль, одоо стандарт бол Монгол Улсад байгаа. 7, 8 мянган стандарт байгаа. Тэгээд одоо байгаа стандартууд маань өөрөө тодорхой худалдаа, үйлчилгээ, зөвшөөрөлтэй үйл ажиллагаа нь бүгдэд нь үйлчилж байгаа. Зөвшөөрөлгүй үйл ажиллагаанд ч гэсэн стандарт үйлчилж байгаа. Мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаанд ч гэсэн үйлчилж байгаа. Тэгэхээр стандартын хууль тогтолцоо нь гэхээсээ илүү одоо байгаа стандартуудад зориулсан үйл ажиллагаанууд дээр тэр тухайн тухайн зөвшөөрлөөр тавигдах нөхцөл шаардлага дээр стандартууд маань хэвээр үйлчилж байгаа учраас заавал Стандартын хууль буюу тэр тогтолцоог нь хөндөх асуудал нь бол хамт ороогүй. Энэ стандартыг хариуцсан Шадар сайд бас шинээр өргөн барихаар боловсруулж байгаа.

Мөн хяналт шалгалтын хуулийг ч гэсэн Засгийн газрын хуралдаанаар удахгүй хэлэлцээд бас оруулж ирэхээр ажиллаж байгаа. Зөвшөөрлийн тухай хуулийн одоо өргөн барьсан дээр хяналт шалгалтын асуудал .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж 1 минутад хариулъя.

С.Тэнгис: Хяналт шалгалтын тал дээр бол сая өнгөрсөн хугацаанд Зөвшөөрлийн тухай хуулийг өргөн мэдүүлээд өвөл Энхтүвшин гишүүн ахалж байгаад бүх салбарын төлөөлөлтэй уулзаж байгаад хяналт шалгалт болон зөвшөөрлийг сунгахтай холбоотой магадлах ажиллагаа давхацдаг талаар маш их санал ирүүлсэн учраас энэ удаа хуулийн төсөл дээр хэрвээ тухайн хугацаанд зөвшөөрлийн нөхцөл шаардлагатай ижил агуулгаар төрийн хяналт шалгалт орсон

бол зөвшөөрлийг тэгээд тэр дүгнэлтэд үндэслэж зөвшөөрөл олгогч байгууллага нь шалгаж үзээд сунгахаар бас орж ирсэн.

Дээрээс нь бас зөвшөөрөл нэмэх, хасахтай холбоотой асуудлуудыг ярьж байна. Зөвшөөрлийг нэмэхдээ бол одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Зөвшөөрлийн хуулиар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээрх зөвшөөрлийн зөвлөлөөс холбогдох үнэлгээний дагуу зөвшөөрлийнхөө дүгнэлтийг авч орж ирэх ёстой. Гэтэл харамсалтай нь тухайн Зөвшөөрлийн эрсдэлийн үнэлгээний журам бол батлагдахгүй ингээд 3 жил явчихсан байсан. Тийм учраас сая Засгийн газар дээр бараг сар хагасын өмнө тэр зөвшөөрөлд эрсдэлийн үнэлгээ хийж, тухайн зөвшөөрөл 1 зөвшөөрөл байх юм уу, энгийн байх юм уу, тусгай байх юм уу..../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Гүйцэд хариулахгүй л байна даа. Дахиад өөр хүн гарч байгаад хариулъя. Хассуурийн Ганхуяг гишүүн нэмж тодруулъя.

Х.Ганхуяг: Энэ 2022 онд батлуулснаас хойш энэ хуулийн хэрэгжилтийг шалгаж, 3 удаа ажлын хэсэг ажилласан байдаг юм. Ер нь хамгийн том бэрхшээл нь нийслэл юм уу, аймаг ч юм уу, иргэдийн Хурлаараа тогтоол үйлдээд л бүртгэл гээд л баахан зөвшөөрөл бий болдог. Бид нар энд сайхан зөвшөөрлийн хууль батлаад байдаг. Тэнд бүртгэл нэрээр баахан зөвшөөрөл бий болгодог. Энэ асуудлыг энэ хуулиар та нар зогсоох ёстой байсан. Тэр хуулийг нь дагалдуулаад оруулаад ирэхгүй.

Яах вэ, тэгээд үндсэндээ энэ зөвшөөрөлтэй холбоотой хууль бол Жаргалан гишүүн ээ, 200-аад хууль байдаг юм. Монгол Улсын хэмжээнд бол 910 хууль байна. Энэ дотроос зөвшөөрөлтэй холбоотой 200-аад хууль байгаа юм. Тэгээд ер нь яах вэ, энэ бизнесийн эрх чөлөөтэй холбоотой асуудал дээр бол хамгийн их саад тотгор болж байгаа юм чинь бол уг нь бол энэ шүү дээ. Системжсэн авлига л байгаад байгаа байхгүй юу. Одоо энэ стандарттай холбоотой асуудал ч байна. Тэр сая нөгөө Заамарт болдог үйл явдал ч байна. Бид нар ингээд 1 юм баталдаг. Тэгээд бүх .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Ажлын хэсгийн гишүүн Сайнзориг хариулъя.

П.Сайнзориг: Хассуурийн Ганхуяг гишүүн өөрөө нөгөө энэ Зөвшөөрлийн хуулийг бас ахалж батлуулсан учраас бас яг ньюансыг нь мэдээд л байна л даа. Тэгээд энэ буруу практикийг л бид нар халаад байгаа юм. Одоо ингээд хууль тогтоогч буюу энэ Зөвшөөрлийн тухай хуульд заасан жагсаалтад ороогүй бол зөвшөөрлийг нэмж, одоо байгаа жагсаалтаа зөвшөөрлийг болон энгийн зөвшөөрлийг задалж олшруулах буюу энэ зүйл байхгүй болсон. Гол нь орон нутагт энэ хууль тогтоомжийн асуудлыг маш сайн сурталчилж таниулах хэрэгтэй байна.

2 дугаарт ийм хууль бус эрх зүйн акт гаргаад байгаа бол энийг яах вэ, хяналтын механизм байгаа л даа. Захиргааны шүүхээр явах гэдэг юм уу. Эргээд энэ зөвшөөрлийн зөвлөл дээр ийм мэдээллүүдийг авдаг. Орон нутагтаа энэ зөвлөмж, энэ зүйлүүдээ цэгцлэх үүргийг нь бас өгдөг, уялдаатай ажиллах л энэ төрийн функцийн асуудал байгаа. Хуучин бол Монгол банк дээр хоёрхон зөвшөөрөл байсан шүү дээ. Банк байгуулах, банкны үйл ажиллагаа эрхлэх. Банкны үйл

ажиллагаа эрхлэхийг 32 задалчихдаг байхгүй юу. Ийм л байсан. Тэгэхээр энэ зөвхөн иргэдийн Хурал биш, ер нь Улсын Их Хурлын .../минут дуусав/п

Б.Пүрэвдорж: Яг тэр 2022 оны Зөвшөөрлийн тухай хуульд би ажлын хэсэгт нь байсан юм. Ганхуяг гишүүн ахалсан. Тэгээд энэ дээр 381 зөвшөөрөл үлдээсэн байхгүй юу. 1500-аас. Тэгсэн чинь энэ хооронд хоёрхон жилийн дотор нөгөө зөвшөөрөл нь алга болчихсон. Албан тушаалтнууд авлига, хээл хахууль авахын тулд яасан бэ гэхээр 264 бүртгэл нэмсэн байгаа юм. Бүртгэлийн бичиг баримт. Дээрээс нь 232 дүгнэлт, 132 гэрчилгээ, 30 магадлан итгэмжлэл, 9 сертификат нэмээд, тэгээд 667-оор буцаагаад, нөгөө янз янзын хүнд суртал үзүүлдэг тэр бичиг баримтаа нэмчихсэн. Тэгэхээр аль болох энэ дураараа нэмдэг яамдын болон агентлагуудын бас орон нутгийнхны нэмдэг энэ бичиг баримтыг хязгаарлах ийм заалтыг заавал оруулах ёстой шүү гэдгийг хэлмээр байна.

Ингээд Мэндбаярын Мандхай гишүүн асуулт асууя.

М.Мандхай: Энэ их чухал хууль юм. Дэлхийн өв уламжлалын сангаас эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийг 176 орноос 76-д бол эрэмбэлэгдсэн. 5 түвшинд байгаа эдийн засгийн эрх чөлөөг сайжруулах бодит хэрэгцээ бол байгаа гэж харж байгаа. Тэгэхээр энэ өөрөө ач холбогдолтой чухал хууль. Тэгээд энэ эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекст хамгийн бага оноо авсан буюу 50-аас энэ доош оноо авсан 2 үзүүлэлт харагдаад байгаа юм.

Нэг нь төрийн өмч зарчимт байдал. Одоо авлигын талаарх энэ олон нийтийн мэдэх эрх, хээл хахууль энэ авлига хээл хахуулийн эрсдэл өндөртэй бол энэ хэрэгцээ, шаардлага тулгардаг. Хянан шалгалтын асуудал зөвшөөрөлтэй холбоотой төр авлигалыг илрүүлэх, таслан зогсоохтой асуудал гээд энэ их чухал зарчимт байдал байгаа. Тэгээд энэ эдийн засгийн эрх чөлөөний индексийн хамгийн муу оноотой асуудлыг бодитоор сайжруулах, Засгийн газрын тэр авлига, хээл хахуулийг бууруулахад чиглэсэн ийм шинэ тодорхой хэрэгжих боломжтой зохицуулалт бас өөрөө хангалттай тусгагдаагүй байна гэж харагдаж байна. Тэгэхээр энэ хуулийн төслийн хэрэгжилт нь эдийн засгийн эрх чөлөөний индексийн гол үзүүлэлтүүдийг дээшлүүлэх зорилготой бодит үр дүн үзүүлэх хууль. Тэгэхээр яг ямар зохицуулалт яг энэ хамгаалах, бэхжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг нэгтгэсэн энэ хуулиараа оруулж ирж байгаа вэ.

2-т нь өмчийн эрхийн асуудал байгаа. Тэгээд энэ хууль дээр өмчийн эрхийг хамгаалахтай буюу оюуны өмч, хувийн хөрөнгийг дайчлах, гэрээний хэрэгжилт шүүхийн маргаан гээд хурдан үр дүн үзүүлэх. Тэгэхээр энэ өмчийн эрхийг өмнөх эрх зүйн зохицуулалтаас илүү баталгаажуулсан бас бодит шинэчлэл харагдахгүй, илүү Үндсэн хууль дээр тогтоогдчихсон энэ суурь зарчмыг оруулаад тавьчихсан харагдаж байна.

Тэгэхээр 1 ийм санал байгаад байгаа юм. Бизнес эрхлэгчдээс бас ирсэн саналыг би бас уншаад өгчихье. Өмчийн эрхийг бодитоор баталгаажуулах үүднээс хөрөнгийг дайчлан авах өндөр эрсдэлтэй төрийн эрх мэдлийг хязгаарладаг байх, өмчийн эрхийг шүүхийн шийдвэрийн үндсэн дээр хураах, төр шийдвэр гаргах замаар хувийн өмчид халдахгүй байх энэ зарчмыг энэ хуульдаа хуульчлах ийм шаардлага хэрэгцээ байна гэж үзэж байгаа.

Дараагийн асуулт бол Эдийн засгийн бодлогын зөвлөл байгуулахаар энд тусгагдчихсан. Байгуулагдсан гэж сая хэллээ. Нэмэлт бүтэц, нэмэлт үйл ажиллагаатай холбоотой нэмэгдэл зардлууд бол гарахаар харагдаж байгаа. Ялангуяа энэ хуралдаан энэ тэр зохион байгуулахтай холбоотой. Тэгээд энэ зардлыг хаанаас гаргах вэ. Төсөвлөгдсөн тооцоо байна уу.

2 дугаарт энэ зөвлөл өөрөө зөвлөмж гаргах ийм чиг үүрэгтэй юм байна. Тэгээд энэ зөвлөмж гаргахаар энэ бодит үр дүн, үр нөлөө ер нь багатай юм биш үү гэж харагдаж байна. Яг энэ зөвлөлийн ач холбогдлыг бас тодорхой хэлээд өгөөч.

2-т нь энэ төр бизнесийн эрх чөлөөг хязгаарлахдаа хамгийн бага хэмжээнд хязгаарлана гээд заагаад өгчихсөн. Тэгтэл ялангуяа хүнс, эм, барилга, уул уурхай, байгаль орчин гэх мэтчилэн иргэдийн амь нас, эрүүл мэндтэй, нийтийн эрх ашигтай шууд холбоотой өндөр эрсдэлтэй салбарт зөвшөөрөл хэрвээ хугацаандаа гараагүй бол олгосонд тооцно гэсэн ийм зохицуулалт яваад байгаа. Тэгэхээр энэ өөрөө нөгөө аюулгүй байдлын эрсдэл үүсгэхгүй гэдгийг яаж баталгаажуулж байгаа юм бэ гэдэг 2 дахь асуулт.

3-д нь үнэ тарифыг тогтоож байгаа, зохицуулж байгаа энэ эдийн засаг, бизнесийн боломжийг хумьж байгаа асуудал дээр яг ямар зохицуулалтууд орсон бэ. Энэ үнэ тарифыг нь тогтоохтой холбоотой. Энэ дээр асуултад хариулаад, тодруулъя.

Б.Пүрэвдорж: Ажлын хэсгийн хэсгийн гишүүн Жаргалан.

Б.Жаргалан: Мандхай гишүүн маш зөв асуудлуудыг хөндөж байна. Үнэхээр өнгөрсөн хугацаанд бол манай улсад эдийн засгийн эрх чөлөө үлэмж хумигдсан. Ер нь эдийн засгийн эрх чөлөө гэж ойлголт бараг байхгүй болсон. Тэгэхээр энэ Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг өнөөдрийн оруулж ирж байгаа байдлаар баталснаар бид нар, Монголын төр ер нь суурь зарчмуудаа тодорхойлчхож байгаа юм. Бид бол эдийн засгийн эрх чөлөөг дараах суурь зарчмуудаар тодорхойлж байна. Түүнд бол таны санаа зовж байгаа хувийн өмчийн халдашгүйгүй байдал, үнэ тогтооход төр оролцохгүй байх гэх зэргээр нөгөө бизнес эрхлэгчдийн эрх ашгийг бүхий л талаар хангах ийм суурь зарчмуудаа энэ 3 дугаар зүйл дээр эдийн засгийн эрх чөлөөг хангах талаар баримтлах зарчим гээд оруулаад өгчихсөн байж байгаа. Тэгэнгүүт эдийн засгийн эрх чөлөөг хангах үйл ажиллагаа гэдэг дээр эдийн засгийн эрх чөлөөг хангах төрийн бодлого, зохицуулалт, ил тод байдлын тухай асуудлуудыг бас тусгачихсан. Мөн хамгийн чухал нь төрийн бодлого, үйл ажиллагаанд хориглох зүйл гээд бас төр ийм ийм зүйлийг хийж болохгүй гээд бүр ингээд тусгаж байна шүү дээ. Тэгээд энэ бол бас Монголын төр бол энэ цаг мөчөөс хойш ер нь бол эдийн засагт дураараа ингэж оролцдог байдлаа таслан зогсооно. Бид бол энэ эдийн засгийн эрх чөлөөний индексээ нэмэгдүүлж, байр байршлаа нэмэгдүүлж, дээрээс нь хөрөнгө оруулалт, эдийн засаг, бизнесийн орчноо маш таатай ийм орчинтой болгоно гэдэг ийм зарлан тунхаглаж байгаа явдал.

Тэгээд таны бас сая эш татсан хууль болохоор өвөл Засгийн газраас өргөн баригдаад буцаан татсан хуулиас эш татаад байх шиг байна. Тэгээд одоо бол өнөөдөр хэлэлцэж байгаа хуульд ямар ч тийм шинээр байгууллага байгуулсан зүйл байхгүй. Гагцхүү нэг зохицуулалт байгаа нь юу вэ гэхлээр Засгийн газар эдийн засгийн эрх чөлөөний тайланг жил болгон Улсын Их Хуралд тайлагнана гэсэн үг.

Тэгэхээр эдийн засгийн эрх чөлөөний төлөв байдал ямар байна вэ. Ер нь өнгөрсөн цаг хугацаанд төр эдийн засагт ямар арга хэлбэрээр оролцсон бэ. Тэр татаас олгосон бол ямар арга хэлбэрээр тэрийгээ олгосон бэ. Дээрээс нь саяын зөвшөөрөл энэ тэр ямар түвшинд яаж байгаа вэ гэдэг бүх тоо баримттай, тэр эдийн засгийн эрх чөлөөний тайланг бол Засгийн газар Улсы Их Хурлаар хэлэлцүүлнэ. Тэгж байж бид нар бол улс орон даяараа хүний эрхийн тайланг хэлэлцдэг шиг эдийн засгийн эрх чөлөөний тайланг бас хэлэлцэх ийм зохицуулалтууд орсон байж байгаа.

Тэгээд энэ хуулийн онцлог болохоор Засгийн газраас өргөн барьсан Бизнесийн эрх чөлөөний тухай хууль болон дагасан Зөвшөөрлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хуулиудтай хамтаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн нэр бүхий гишүүдээс санаачилсан Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуультай хамтатгаж хэлэлцээд, ерөнхийдөө бол олонхын бүлэг цөөнхийн бүлэг энэ эдийн засгийн эрх чөлөөг хангах суурь зарчмууд дээрээ санал нийлээд энэ хуулийг бас батлуулж байгаа нь гадаад зах зээл дээрээ, ер нь зах зээлд бол ийм тодорхой сайн дохио өгнө гэдэгт бол бас итгэж байгаа. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Ажлын хэсгийн ахлагч Энхтүвшин нэмж хариулъя.

Д.Энхтүвшин: Мандхай гишүүний асуултад хариулъя. Энэ хуулиар зөвшөөрөл олгох энэ харилцаа болохоор Зөвшөөрлийн зөвлөл гэж байгаа. Тэгэхээр энэ зөвлөлийн бүтцийг бас өмнө нь төрийн төлөөллүүд голдуу ордог байсныг хувийн хэвшлийн төлөөлөл орж, энэ Зөвшөөрлийн зөвлөлийн шийдвэрийг ямар зөвшөөрөл шинээр бий болгох юм бэ гэдгийг Зөвшөөрлийн зөвлөлөөр орж байж эрсдэлийн үнэлгээ хийж байж ингэж гаргадаг болгож байгаа. Тэгэхээр үүнтэй холбоотой ийм зөвлөлийн бүтэц байгаа. Түрүүн энэ Засгийн газрын дэргэд байгаа, Ерөнхий сайд өөрөө ахалж байгаа учраас энэ зардал бол нэмэлт зардал гарахааргүй байгаа. Эрсдэлийн хувьд болохоор автоматаар олгогддог энэ хүсэлт өгөөд, тодорхой хугацааны дараа хариу өгөхгүй бол автоматаар олгогдох энэ харилцаа тусгай зөвшөөрөл дээр бол байхгүй. Тусгай зөвшөөрөл бол заавал хариу өгч байж үйл ажиллагаа эрхэлнэ. Тусгай зөвшөөрөл нь өөрөө эрсдэлийн түвшнээр өндөр гэж байгаа учраас энэ нь эрсдэлтэй холбогдуулж байгаа юм. Энгийн зөвшөөрөл дээр бол энэ харилцаа байгаа. Тэгэхээр энэ.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Мандхай гишүүн асуухгүй юм байна. Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууя.

А.Ариунзаяа: Манай дарга хоол цайндаа яараад бас тодруулъя гэсэн тодруулгыг нь өгөхгүйгээр явж байх шиг байна. Би 1 ийм юм асуух гэсэн юм.

Бизнес эрхлэгчийн ажил хэргийн нэр хүндэд халдах үндэслэлгүй хуурамч мэдээлэл түгээх энэ ажиллагаа төрийн бодлого, үйл ажиллагаанд хориглох зүйл гэсэн ийм заалт орж ирж байгаа. Эрүүгийн хуулийн 13.14-ийг бид нар чинь хүчингүй болгочихсон шүү дээ. Ер нь бол одоо бизнес эрхлэгч байгууллагын ч нэр хүндийг хуулиар хамгаалсан зүйл заалт 1 ч байхгүй. Тэгэхээр энэ бизнес эрхлэгчийн ажил хэргийн нэр хүндэд төр халдаж байгааг хэн тогтоож, ямар хариуцлага хүлээлгэх вэ гэдгийг бас уг нь тодорхой болгох ёстой гэсэн ийм асуултыг би тэнхимийн Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан, энэ ажлын хэсгийн дарга Энхтүвшинээс энэ асуултыг асууя.

2 дахь нь болохлоор Зөвшөөрлийн тухай хуулийг өнгөрсөн онд намрын чуулганы сүүлийн өдөр 3 гишүүн хамтдаа өргөн бариад, тэгээд бид нар бас 2, 3 сарын хугацаанд нэлээд ажиллаж, тэгээд ер нь бас эгүүлэн татаад Засгийн газар энийгээ бас Стандартын тухай хуультайгаа хамт өргөн баримаар байна гэдэг ийм асуудлыг дэвшүүлсэн. Тэгээд Бизнесийн эрх чөлөөний тухай хууль гэж нүүрээ хувиргаад ингээд орж ирсэн. Стандартынх нь асуудал нь бол орхигдсон байгаа. Тухайн үед ажлын хэсэг дээр асуудалтай гэж яригдаж байсан асуудлууд зарим дагасан хуулиасаа хасагдсан байна лээ. Мэдэгдлийн түвшинд явуулах нийтийн үйлчилгээний энэ асуудлууд хасагдсан байна лээ. Тэгэхээр мэдэгдлийн түвшинд шууд нээлттэй үйл ажиллагаагаа явуулна гэж ярьсан байгаа асуудлууд хэрхэн яаж шийдвэрлэгдэхээр байгаа вэ гэдгийг бас ажлын хэсгийн зүгээс юм уу, эсвэл хууль санаачлагчаас асууя. Яагаад гэвэл олон нийтэд өгсөн ойлголт, мэдээлэл нь хэн хүссэн юмаа зүгээр л мэдэгдээд л хийчхэж болно гэсэн ийм ойлголтыг өгчихсөн байгаа учраас энэ хэвээрээ юу, мэдэгдлийн түвшинд юу хийж болох вэ гэдэг энэ асуудлыг бас ярих нь зүйтэй. Яагаад гэвэл хуулийг бид нар бас эцэслэн батлах ч гэдэг юм уу, дараагийн 7 хоногт шууд батлагдаад явах ийм асуудал байна.

3 дахь асуудал нь юу юм бэ гэхээр хуулиас давсан журам байж болохгүй гээд хуульдаа оруулаагүй мөртөөсөө наана нь Засгийн газар маш олон журмаа цуцалчихсан. Ингээд ямар ч зохицуулалтгүй салбарууд байгаа шүү. Тэгэхээр энэ хийрхэлээсээ, попролоосоо салаад, зохицуулах ёстой салбаруудаа журамлаарай. Тэгэхгүй бол бас энэ хуулийн дагуу буцааж байгаа хуулийн төслүүд байгаа. Төр иргэнийхээ аюулгүй байдал болон хэтэрхий эрх чөлөө олгож байна гэсэн попрол биш. Харин төр бол энэ төрийн үйл ажиллагааг зохицуулах ёстой байхгүй юу. Тэгэхээр энэ журмуудаа та нар өөрсдөө шуурхай батлаарай. Тэгэхгүй бол энэ зохицуулалтгүй салбарууд бас маш их байна шүү гэдгийг анхааруулан хэлье. Асуултын хариултыг Энхтүвшин гишүүнээс.

Б.Пүрэвдорж: Энхтүвшин ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Д.Энхтүвшин: Энэ бизнесийн нэр хүндэд бол халддаг жишээ бол ер нь бол нийтлэг болсон байгаа. Тэгээд тодорхой хугацаанд санаатай, санамсаргүй байдлаар аж ахуйн нэгжүүдийг бол янз бүрийн байдлаар үйл ажиллагаанд нь, нэр хүндэд нь, алдар хүндэд нь халддаг ийм бол нэлээн жишиг болчихсон. Ямар ч хариуцлага хүлээдэггүй. Тэгээд дээр нь бас сая Үндсэн хуулийн цэцийн шийдвэртэй холбоотойгоор яг энэнтэй холбоотой бас заалт өөрчлөн найруулж орж ирэх гэж байсан боловч энэ заалтыг оруулж ирээгүй байгаа. Тэгэхдээ бид нарын хүлээлт бид нар бол бид нар гэж Улсын Их Хурлын гишүүдийн хувьд ч гэсэн энэ зүйл заалт бол бас тодорхой хэмжээнд зохицуулагдах ёстой гэж бодож байгаа. Тэгээд энэ хуулийн заалтуудыг оруулж ирэх ёстой. Оруулж ирнэ гэсэн хүлээлт байгаа. Тэгэхээр энэнтэй холбоотой зарчмын асуудлуудыг энэ Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль дээр заагдсан байгаа. Өөрөөр хэлбэл энэ Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль дээр заасан зарчмуудын хүрээнд хууль тогтоомжуудыг сайжруулах, өөрчлөх энэ үндэс сууриуд болж байгаа. Тэгэхээр үүнд нийцээгүй хуулиудыг жил болгон тайлан гарч байгаа учраас энэ тайланг хэлэлцүүлээд эдийн засгийн эрх чөлөөг хэрхэн хангаж байгаа, энэ эрх чөлөөг, энэ зарчмуудыг зөрчиж байгаа хууль тогтоомжийг яаж өөрчлүүлэх талаар жил болгон хэлэлцэх ийм бололцоо боломжууд гарч ирж байгаа юм.

Мэдэгдлээр чөлөөтэй эрхэлнэ гэдэг дээр Зөвшөөрлийн тухай хуулийн үзэл баримтлал бол хуулиар хориглосон болон Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулснаас бусад үйл ажиллагааг чөлөөтэй эрхэлнэ гэсэн ийм хуулийн үзэл баримтлал байгаа. Нөгөө талдаа түрүүн бас Ганхуяг гишүүний ярьж байсан энэ орон нутаг дээр худалдаа үйлчилгээний төрөл, ангилал худалдаа үйлчилгээ эрхлэхэд тавигдах шаардлага гэдэг ийм зөвшөөрлийн маягтай эрх олгосон Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний нэгжийн удирдлагын тухай хууль дээр ингээд орчихсон байгаа. Тэгэхээр энийг өөрчлөх хэрэгцээ шаардлага, энийг дагаж өөрчилж байж энэ үйл ажиллагаанууд илүү цогц болж харагдана. Тэгэхээр энэтэй холбоотой өөрчлөлтийг бас өргөн барих шаардлагатай байгаа. Түрүүчийн хэлсэн Төрийн хяналт шалгалт болон Стандарт хэмжил зүйтэй холбоотой хуулиудтай хамт өргөн барьж өөрчлөлт хийж байж цогц болно гэж бодож байгаа юм.

Энэ хуулийн төсөл орж ирэхэд Зөвшөөрлийн тухай хууль шинэчилж сая орж ирэхэд ажлын хэсэг дээр өмнө нь бас Ариунзаяа гишүүн бас нэлээн олон чухал саналуудыг хэлж байсан. Тэгээд энэ бүх журмуудаа захиргааны хэм хэмжээний актуудыг бүгдээрэнг нь цуцалчихсан байгаа. Энийг зөвхөн хуулиар л тавигдах шаардлагуудыг тогтооно гээд. Тэгээд энэ зүйл заалтуудаа зөвшөөрөл олгогч байгууллагууд энэ Зөвшөөрлийн тухай хууль дээрээ бүгдийг нь оруулж ирсэн байгаа. Тэгэхээр зарим нь бол бас тодорхойгүй зохицуулалт нь үзэмжийн шинжтэй асуудлууд байсан учраас тухайлбал Харилцаа холбооны зохицуулах хороотой холбоотой 4 жишээлбэл хуулийг тодорхой хэмжээгээр үзэмжээр энэ сонгон шалгаруулалтад хандах бололцоо боломж байгаа учраас гээд энэ хуулийн төслүүдийг буцаасан байгаа. Мөн үүнтэй адил .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж Шадар сайд Ж.Энхбаяр хариулъя.

Ж.Энхбаяр: Бизнесийн үйл ажиллагаан дахь төрийн дарамтыг арилгах, нөгөө талдаа эдийн засаг дахь төрийн оролцоог багасгах ийм том зорилт энэ хуулиудын цаана байгаа. 1 удаагийн шинжтэй эрсдэлийн түвшин багатай аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг мэдэгдээд эхлэхийг 9 бүлэг, 38 зүйлээс бүрдсэн нийт 338 зөвшөөрөл, мэдэгдлээр явж байгаа. Энд бас 1 том өөрчлөлт саяхан бид нар нээсэн. E-Business.mn гэж байгаа. Энэ системд бизнес эрхлэгч хаана, юу хийхээ мэдэгдээд, хүлээлгүйгээр шууд бизнесийнхээ үйл ажиллагааг нээх эрхийг нээж байгаа. 8 төрлийн 146 бизнес эхний ээлжид E-Business.mn-д ороод аливаа тийм төрийн зөвшөөрлөөсөө чөлөөлөгдсөн байгаа. Тэгээд нийт 251 тусгай зөвшөөрлөөс 233-ыг нь цахим хэлбэр лүү бас оруулсан. E-Business.mn рүү оруулсан байгаа. Явцын хяналт шалгалтаар үйл ажиллагаа.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ явцын хяналт шалгалтаар үйл ажиллагаа нь хэвийн тохиолдолд зөвшөөрлийн хугацааг шууд сунгадаг болж байгаа. Зөвшөөрлийн хугацаануудыг уртасгаж байгаа. Тусгай зөвшөөрлийг 10-аас доошгүй жил, энгийн зөвшөөрлийг 5 жилээс доошгүй, мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаа 3 жилээс дээшгүй гээд. Төрөөс олгож байгаа 120 зөвшөөрлийг мэргэжлийн нэгдсэн холбоонд бас шилжүүлэх ийм бололцоог олгож байгаа. Ингээд энэ чинь нийтдээ тусгай болон энгийн зөвшөөрөл авахад тавигдах нөхцөл шаардлагыг салбарын дагалдах хуулиудад зааж өгч байгаа юм. Зөвшөөрөл бол хуульд хуульчлан тусна гэсэн үг. Тусдаа эрх зүйн акт гаргаад зохицуулдаг энэ байдал хязгаарлагдана. Зөвхөн

салбарын дагалдах хуулиудад зөвшөөрөл нь хуульчлагдан заагдана. Энэ дотор 83 дагалдах хуулийн өөрчлөлт яваа. Энэ бол үнэхээр эдийн засаг дахь төрийн оролцоо бизнес үйл ажиллагаан дахь төрийн дарамтыг нэлээн эрс цөөлсөн ийм ажил болно. Тэгэхээр бүгд тэр E-Business.mn-ийг өргөн ашиглаарай. Ажиллаад эхэлсэн байгаа.

Б.Пүрэвдорж: Жудагийн Баярмаа гишүүн асуулт асууна.

Ж.Баярмаа: Эдийн засгийн эрх чөлөөний хууль, тэгээд Бизнесийн эрх чөлөөний хууль гэж орж ирж байгаа. Тэгээд энэ уг нь бид нар чинь зах зээлийн тогтолцоонд шилжээд, 36 жил болж байгаа. Үндсэндээ энэ чинь 36 жилийн өмнө Бизнесийн эрх чөлөө чинь нээгдчихсэ, энэ эдийн засаг чинь эрх чөлөөтэй болчихсон байх ёстой байсан. Тэгээд 36 жилийн дараа ийм нэртэй хууль орж ирж байгаа нь бол Монгол Улсын бизнесийн эрх чөлөө, эдийн засгийн эрх чөлөө төдий чинээ байхгүй байсны илрэл гэж харж байна. Тэр чинь их сонин шүү дээ. Энэ чинь бизнесийн эрх чөлөөний тухай хууль гээд үгүй ээ, нэрнээсээ харахад л эрх чөлөөгүй учир ийм эрх чөлөө олгох гэж хууль оруулж ирж байгаа юм уу гэдэг ийм логик үүсэж байгаа байхгүй юу. Эдийн засгийн эрх чөлөө ч гэсэн адилхан.

Тэгэхээр энэ бол тун харамсалтай байгаа юм. Тун харамсалтай байгаа юм. Тэгээд ер нь бүхий л энэ хууль тогтоомжуудад энэ бизнесийн эрх чөлөө, эдийн засгийн эрх чөлөө хангагдчихсан байх ёстой. Тэгэхээр бусад энэ зөвшөөрлийн тухай хууль, Компанийн тухай, энэ 800, 900, мянгаад бараг хууль байна гэж байгаа. Энэ хуулиудад тусгаад, нэмэлт, өөрчлөлт оруулаад ч юм уу ингээд явах боломж байгаагүй юм уу. Заавал ийм бие даасан анхдагч хууль байх шаардлагатай байсан юм уу гэдэг эхний асуултыг асууя.

Б.Пүрэвдорж: Шадар сайд Энхбаяр хариулъя.

Ж.Энхбаяр: Бид энэ богино 30-аад жилийн хугацаанд харьцангуй өндөр ололт амжилтыг үзүүлсэн. Дэлхийн бүх улс орнуудаас дэлхийн 200-аад орнуудаас Монгол Улс эдийн засгийн эрх чөлөөт байдлаараа бид нар 69-д яваа. Энэ маш сайн амжилт. Бидний сайжруулах зүйлүүд бас байгаа нь тодорхой болж байгаа. Өнгөрсөн 35 жилийнхээ бизнес эрх зүйн орчинд дүгнэлт хийгээд, одоо нэг сайн дүгнээд, ахиад сайжруулах шаардлага гарч байна гэж үзэж байгаа. Ялангуяа энэ хөрөнгө оруулалтын гомдол маргаантай холбоотой, хөрөнгө оруулагчид ээлтэй байдлаараа бид нар 109-д яваад байгаа юм. Тэгээд шүүхийн маргаан шийдвэрлэх хугацаа их урт, шийдвэр биелдэггүй. Энэ дээр бид нар их муу оноо авч байна. Бизнес эхлэхэд үе шат, хугацаа, эхлэхэд зардаг зардал их өндөр. 85-д явж байна. Өмчийн эрхийн баталгаа бүрэн баталгаажаагүй байдлаар бид нар 94-д явж байна. Бүх шатад төрийн зөвшөөрөл, нөгөө төрийн зарчимч байдлаар бид нар 115-д явж байна. Тэгэхээр энэ хэд дээр төвлөрөөд төрийн олгож байгаа тэр бизнес эхлэхэд олгодог тэр зөвшөөрлүүдийг цэгцэлье.

2 дугаарт тэр өмчийн эрхтэй холбоотой асуудлыг энэ Бизнесийн эрх чөлөөний хуулиар баталгаажуулж, дахин нотолж, тэр Монгол Улс өөрийнхөө хүсэл эрмэлзлээ илэрхийлж байгаа байхгүй юу. Тунхаглаж байна гэсэн үг. Бизнесийн нэр хүнд халдашгүй байна. Өмч халдашгүй дархан байна. Эдийн засагт төрийн оролцоо ингэж хязгаарлагдана. Төр зөвхөн ингэж оролцоно. Төрийн үйл ажиллагаа нь л энийг хориглоно гэдгийг нь улам тодотгож өгч байна. Тэгээд бизнес эхлүүлэхэд шаардлагатай тэр 85-д ороод байгаа үзүүлэлт сайжруулахын тулд E-Business.mn

гэдэг энэ платформыг хөгжүүлээд, мэдэгдээд үйл ажиллагаагаа эхэлдэг чиглэлээр бид ажлаа эхлээд явж байна.

Дараагийн цогц асуудал бол энэ хууль шүүхийн байгууллага дээр шүүхийн маргаан шийдвэрлэх хугацаа, шийдвэр гүйцэтгэлийн хэрэгжилттэй холбоотой шийдэгдээгүй асуудлын хугацаа их өндөр гараад байгаа юм. 2 жил, 5 жил, 8 жилийн шийдвэрлэгдээгүй асуудлууд байна. Энэ бол хөрөнгө оруулагчдад бас маш сөрөг нөлөөлдөг ийм үзүүлэлтүүд байгаа. Тэгэхээр бид энэ хөрөнгө оруулагчдын гомдол маргааныг нь шийддэг, шүүхийн шийдвэрүүд нь гардаг. Ер нь шаардлагатай бол цаашдаа энэ бизнесийн дагнасан шүүх тогтолцоотой болох нь их зөв байна гэдэг ийм эхний дүгнэлт хийгдчихээд явж байна. Энэ бол дараагийн хэсэгт яригдах асуудал. Тэгээд энэ хуулиар бол эхний сууриудаа сайхан цэгцэлчихье. Тэгэхээр энд үгүйсгээд юм байхгүй байсан гэж ярьж болохгүй шүү. Их сайжраад, үндсэндээ бараг 0-ээс эхэлсээр байгаад бид нар чинь үндсэндээ 100 хувь бүх юм төрийн өмчит бизнес, төрийн зохицуулалттай эдийн засгаас бид нар гарсан гээд бодоход бол маш өндөр түвшинд, эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексээр Монгол Улс дэлхийд 69-д ороод байгаа. Маш дэвшилттэй байгаа шүү.

Тэгэхээр өнгөрсөн рүү битгий их үгүйсгэсэн ийм хандлагаар хандаж яриач ээ гэж бас уриалмаар байна.

Б.Пүрэвдорж: Ажлын хэсгийн гишүүн Жаргалан нэмж хариулъя.

Б.Жаргалан: Энэ ардчилсан хувьсгалын араас төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас чөлөөт зах зээл рүү шилжсэний дараа 36 жилийн дараа бид нар бас Эдийн засгийн эрх чөлөө, Бизнесийн эрх чөлөөний тухай хууль батлаад сууж байгаа нь ер нь бол аргаа барсан хэлбэр. Өнгөрсөн хугацаанд бол энэ уул уурхайн салбарын огцом орлогын нөлөөнд бас энэ Голланд өвчин зэрэг, энэ нөлөөнд бол манай төр хэрээс хэтрээд томорчихсон, эдийн засагт маш их хэмжээгээр оролцдог болчихсон. Тэгээд одоо энэ цаг мөч дор бид нар эдийн засгийн эрх чөлөөнийхөө энэ зарчмуудыг томъёолоод авчихъя. Цаашдаа энэ эдийн засгийн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжууд дээрээ ч гэсэндээ энэ үндсэн зарчмуудаа баримтлаад явъя гээд сэтгэлгээний хувьд нэг ийм хугарлын цэг хийж байгаа л ийм арга хэмжээ.

Тэгээд энэ цаг мөчөөс хойш энэ эдийн засгийн харилцаагаа бол энэ зарчмууддаа тулгуурлаад л хөгжүүлээд явъя гэсэн санаа л энэ хуулиар бас орж ирж байгаа.

Б.Пүрэвдорж: Ер нь бол бизнесийн эрх чөлөөний асуудал дээр 2 намын гишүүд ээлжлээд хариулах нь бол яг энэ ялгааг бас тодорхой харуулж байна.

Зочин танилцуулаадахъя.

Улсын Багшийн дээд сургуулийн Физик, математикийн ангийн 1986 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордны үйл ажиллагаатай танилцаж байна. Та бүхэнд эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Ажлын хэсгийн гишүүн Доржханд сайд бас нэмж хариулъя.

Т.Доржханд: Энэ 2 намын төлөөллийн байр суурь яваад байх шиг байна. Би ажлын хэсгийн хуваарь хэлчихье. Тэгэхээр Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал бол угаасаа уул уурхайгаас хамааралтай. 80 хувийнх нь экспорт нь уул уурхай байдаг. Уул уурхайгаас хамааралтай орнуудад 1 л зовлон байгаад байдаг. Тэр нь юу байна гэхээр төр менеж хийж явах юм уу, хувийн сектор менеж хийж явах юм уу гээд. Хувийн сектор менеж хийж явсан улсууд нь бол хөгжихсөн байгаа. Төр ингээд менеж хийсэн улсууд нь бол хөгжил их хойно явдаг. Энэ бол бодит байдал. Тэгэхээр эдийн засгийн онцлогоосоо хамаараад манайх бол өнөөдөр төрийн оролцоо байгаа гэдэг нь бодитой үнэн. Гэхдээ энэ төрийн өмчийн компаниуд дотор шүү.

Яг эдийн засгийн эрх чөлөөний асуудлаар байх юм бол Монгол Улс ардчилсан улс. Тэгээд дэлхийн маш олон улсуудтай харьцуулаад үзэх юм бол яг энэ эрх чөлөө, ардчилал .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Их сайн хариулт болж чадсангүй. Жудагийн Баярмаа гишүүн нэмж асууя.

Ж.Баярмаа: Business doing гээд ийм индекс гаргадаг байсан. Одоо больсон байх. Тэр индексээр бол миний санаж байгаагаар Монгол Улс бараг л бизнесийн эрх чөлөөгүй категорит орон алдсан. 1,2 оноо дутуу байсан шиг санаж байна. Тэгэхээр таны түрүүний тэр их сайн байгаа. 69-д байгаа гэдгийг сайн ойлгосонгүй. Бараг л эрх чөлөөгүй гэдэг категори руу орон алдаж байсан л даа. Тэгээд тодорхой асуултууд жишээлбэл төр ямар хариуцлага хүлээх вэ гэдэг дээр. Төр хэрвээ өөрөө зөвшөөрөл олгох ёстой асуудал дээрээ хойрго хандаад, хугацаандаа өгөхгүй бол яах вэ гэдэг зүйл тусгагдсан уу. Мөн төрийн буруутай үйл ажиллагаанаас болж бизнесүүд асар их хохирдог. Ёстой нээрээ улаа эргэтэл шүүхээр яваад, гаднынхан нь болохоор бүр махаа идээд, тэгээд гараад явдаг шүү дээ. Ер нь бол үндсэндээ. Тэрнээс чинь болж бас энэ гаднын хөрөнгө оруулалт чинь зогсонги байдалд ордог .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн алга байна. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн асуулт асууна.

Ц.Даваасүрэн: Би энэ гишүүдийн бас энэ хуулийн нэртэй холбогдуулаад шүүмжлээд байгааг бас зөв гэж хараад байгаа юм. Энэ яг нэрийг нь харах юм бол би хэрвээ гаднын хөрөнгө оруулагч бол энэ эрх чөлөөгүй орон байсан юм байна даа л гэж бодно. Одоо дөнгөж эхлэх гэж байгаа юм байна. Больё доо л гэж бодно. Үгүй ээ үгүй. Энэ бол попрот бол байж хэрэггүй байхгүй юу. Зүгээр нэрийг нь арай нэг өөр болгочих. Бидэнд засах юм бол байгаа байх. Жишээ нь олон улсын үнэмлэхтэй хүн Монголд машин барьж болдоггүй юм байна лээ шүү дээ. Гэтэл бид нар бусад улс оронд очоод л өөрийнхөө үнэмлэхтэй машин түрээслээд л яваад л байдаг шүү дээ. Тэгэхэд Монголд болохгүй. Энэ мэтийн юм байгаа нь үнэн. Тэгэхдээ бид нар нэг их эдийн засгийн эрх чөлөөгөөр айхтар дутчихсан юм бол бас би байхгүй гэж бодож байна. Зүгээр бидэнд юу гай болоод байна вэ гэж. Бидэнд ерөөсөө 1 тийм хувийн эрх ашиг давамгайлсан, ялангуяа төрд байгаа хүмүүсийн ашиг сонирхол. Төрөө мөнгөний машин болгоод байгаа явдал байхгүй юу. Яг тийм байгаа. Яг юман дээр тулаад ирвэл. Энийгээ л өөрчлөх, энэ улс төрчдийнхөө ёс зүйг өөрчлөх тухай асуудал байхгүй юу. Тэгээд л сайд болох гэж улайрцгаагаад, тийшээ нь очиж ингэх

гээд л. Яг цаанаа бол тийм байгаад байгаа байхгүй юу. Тэрийгээ эхлээд өөрчлөх хэрэгтэй. Улс төрчид эхлээд өөрсдийгөө өөрчлөх хэрэгтэй.

2 дугаарт гай болж байгаа юм бол банк, санхүүгийн салбар байхгүй юу. Энэ өндөр зээлийн хүүтэй энэ банкны том монополын орчинд хэн, яаж бизнес эрхлэх юм бэ. Засах юм чинь энэ байгаад байна шүү дээ. Яаж энэ бизнес эрхлэгчдэдээ бид нар хямд эх үүсвэр олж өгөх юм. Санхүү, зах зээлийн орчныг нь яаж сайн болгож өгөх юм гэдэг асуудал болохоос биш нэг их төр нь аймар дарамттай, тэгээд дарангуйлсан тогтолцоотой тийм юм байхгүй шүү дээ. Эрх чөлөө хангалттай. Хулгай луйвраа хангалттай хийж байна шүү дээ. Эрх чөлөө, тэдний харин эрх чөлөөг хязгаарламаар байгаа байхгүй юу. Тэгэхээр би зүгээр энэ хуулийн хувьд бол бид нар харин энэ хуулийг гаргаж байсан дор бол яаж гаднын банк оруулж ирэх вэ, яаж хямд эх үүсвэр бий болгох вэ, яаж шууд зээллэгээний тогтолцоог бий болгох вэ гэдэг юмнуудыг л одоо яримаар байгаа байхгүй юу. Тэрнээс биш нэг их төр гай болоод, төр бизнест оролцоод ингээд л байхгүй. Бид юу ч үйлдвэрлэж чадахгүй байна шүү дээ. Сая бид нар Беларус ороод ирлээ. Беларус бүх машин техникээ үйлдвэрлэж байна шүү дээ. Бүх хогийн машин, галын машин, эмнэлгийн машин, том ачааны машин, трактор, комбайн бүгдийг нь үйлдвэрлэж байна. Мотоциклоо хүртэл үйлдвэрлэж байна шүү дээ. +Бид юу үйлдвэрлэж байна. Энэ бизнес рүү хэн ч орж болно шүү дээ. Хэн ч хутгалдахгүй байна шүү дээ. Бид хуурай сүү ч хийж чадахгүй, молоко ч хийж чадахгүй. Тэнд бүх юм байна. Тэнд далайн гарцгүй. Тэгэхэд далайн бүх төрлийн загасыг үржүүлээд дотоодынхоо бүрэн хэрэгцээг хангачихсан байна шүү дээ. Загасаа бүр экспортолдог. Үгүй ээ, ийм бололцоо бизнесийнхэндээ биш шүү дээ. Энд хэн төр оролцоод байгаа юм. Төр оролцоод байгаа юм байхгүй шүү дээ. Хий л дээ. Яагаад хийхгүй байгаа юм. Банк, санхүү зээлийн чинь орчин.

3-д татварын орчноо өөрчил. Татварын таатай орчин байх ёстой. Шинээр бизнес эрхэлж байгаа хүнд өөр татвар байх ёстой. Импортын бүтээгдэхүүн, орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа бол тэрийг импортын татвар тавьж өгөх хэрэгтэй. Ижил төрлийн бараан дээр нь. Үгүй ээ, ингэхгүй хаячхаж байгаа байхгүй юу. Нэг муу амьтан бизнес эрхлээд л, шинээр нээгээд л, үхтлээ шатаад л, тэгээд зээлийн өрөнд баригдаад, тэгээд хаалгаа хааж байгаа шүү дээ. Энэ л гай болоод байгаа шүү дээ. Тэгэхээр би бол зүгээр гай болж байгаа юмаа олж хар л гэж хэлмээр байна. Тэгээд тэрийгээ эмчил. Тэрнээс биш одоо ингээд бүр 1990-ээд оны үеийн сая энэ Баярмаагийн хэлээд байгаа үнэн шүү дээ. Ийм юм ярихаа больё л доо хэдүүлээ. Бид чинь бас зах зээлд ороод удаад, энэ замаар чинь нэлээн олон 10 жил явчихлаа шүү дээ..../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж тодруулъя.

Ц.Даваасүрэн: Энэ хууль дээр ингээд хууль санаачлах эрхэд хязгаарлалт тавьчихсан ийм заалт байгаад байгаа юм. Ийм төрлийн хуулиудыг болохгүй шүү гээд. Тэгээд 1 талаараа энэ чинь бас гишүүний хууль санаачлах эрхэд халдсан заалт байна гэж ойлгож байгаа. Гэхдээ нөгөө талаараа тэр үндэсний аюулгүй байдалтай чинь холбоод л юу гэдэг юм хүнсний аюулгүй байдал гээд нийтийн эрх ашгийн төлөө гэдэгтэй чинь холбоод санаачилбал болохгүй юм бас байхгүй байгаа юм. Тэгээд хоёрдмол утгатай заалт байж байгаа байхгүй юу. Нэг талаараа болохгүй гэгчихсэн мөртөө нөгөө талаараа ерөнхий үгнүүд оруулаад нээгээд өгчихсөн байгаа байхгүй юу. Энэ нь юу үүсэх вэ гэхээр байна шүү дээ. Асар их маргаан үүснэ. Хууль санаачлагч юу гэх үү, үндэсний аюулгүй байдалтай холбосон гэнэ. Нөгөө нөхөр

бизнес хязгаарлаж байна гээд л ингэнэ. Ийм мэтийн маргаантай заалтуудаа жоохон өөрчлөхгүй бол сайн боловсруулж чадаагүй хууль байна лээ шүү гэдгийг л бас анхаараач ээ. Энэ заалтыг яах юм бэ гэж би асуумаар байна.

Б.Пүрэвдорж: Шадар сайд Доржханд хариулъя.

Т.Доржханд: Даваасүрэн гишүүний тэр агуулгатай бол санал нийлж байна. Яг үнэндээ бол нэр томъёогоор хөөцөлдмөөргүй байгаа. Агуулга бол ер нь бизнесийг дэмжих л ийм агуулгатай хууль шүү дээ. Хувийн секторыг дэмжих. Тэгэхээр энэ дээрээ нөгөө 2 ажлын хэсэг маань 1 ажлын хэсэг болчихсон. 2 хуулиа нэгтгэхдээ энэ дээрээ попорсон ийм нэр томъёо биш, харин яг бодитой нэр томъёогоо өгөөд явах юм бол энэ зөв байх гэж.

Даваасүрэн гишүүнтэй санал нийлээд байгаа зүйл нь бол яг энэ бизнес ингээд хийе гэхээр санхүүжилтийн өртөг чинь үнэ өндөр байхгүй юу. Тэгээд энэ дээр яг бодитой юу туссан юм бэ гэдгийг хэлчихмээр байна.

Өнөөдөр хүртэл Монгол Улс нөгөө банкаар дамжаад санхүүжилтээ хийдэг. Дэлхийд 70 жилийн өмнө байсан тэр уламжлалт санхүүгийн тогтолцоо Монголд яваад л байгаа. Яагаад ингээд байсан бэ гэхээр нэг жишээ нь, банк ингээд мөнгө төгрөг татаж авах юм бол 5 хувийн хүүгийн татвар төлдөг. Бусад санхүүгийн байгууллагууд хөрөнгийн зах зээлээр юм уу, компанийн бонд юм уу. Тэр дээр ингээд хөрөнгө татахаар 20 хувь. Тэгэнгүүт нөгөө мөнгө чинь хаашаа ордог вэ гэхээр банк руу, своп хийхлээр банк руу. Банк руу, банк руу гээд яваад байдаг. Гэтэл банкны санхүүжилт маань өөрөө өртөг нь хямдхан байна уу гэхээр үгүй байдаг. Одоо энэ хуулиар энийг засаж өгч байгаа юм нь юу байна гэхээр ижилхэн 5 хувь руу оруулж өгөөд, өнөөдөр хамгийн их эрсдэл хийдэг, богино хугацаанд шуурхай хөрөнгө оруулалт хийдэг ийм эх үүсвэр чинь юу юм. Сангууд шүү дээ. Дэлхий даяараа нөгөө банк болон хөрөнгийн зах зээл чинь ингээд уламжлалт болоод хажуу талаар нь ингээд сангууд дэлхий даяар маш олон их наядаар нь хэмжих хөрөнгө оруулалт хийгээд байхад бид нар хоцорчхоод байгаа юм. Тэгвэл одоо энийг бид нар нээж өгч байгаа. Тэр сангуудыг оруулж ирье. Өрсөлдүүлье. Ганцхан банкны эх үүсвэрээр санхүүждэг биш эсрэгээр нь хажуу талд нь өрсөлдөгчдийг нь оруулж ирье. Тэр нь бол сангууд байна. Private Equity Fund байна. Hedge Fund байна. Янз янзын сангууд орж ирэх нөхцөл нь бол бүрдэж байгаа шүү. Энийг хэлчихмээр байна.

2-т нь бол үнэн. Зээлийн хүүгийн эх үүсвэр нь нөгөө хадгаламжтайгаа ингээд харьцуулах юм бол өндөр байгаа болохоор өндөр л гэдэг банкнууд бол юм ярьдаг. Гэтэл өрсөлдөөн байдаггүй. Тэгээд энэ дээр нэг зохицуулалт нь юу байсан бэ гэхээр бид нар нөгөө гэр бүлийн банкнууд байгаад байна. Тэд нар маань ингээд орж ирсэн төслүүдийг дарж аваад уул уурхай руу хүртэл санхүүжилт аваад ингээд барьдаг болчихлоо. Энийг хязгаарлая гээд 1 банкны хувьцаа эзэмшигч нь 20-оос дээшгүй байя гээд Даваасүрэн гишүүн мэдэж байгаа шүү дээ. Хязгаарлалт хийчихсэн байсан. Үүний нөгөө сул дутагдалтай тал нь юу байна гэхээр гаднын банкнууд орж ирэхээ больчихсон. Үгүй ээ би ядаж нэг хяналтын 34-ийг авмаар байна шүү дээ. Ядаж менежментээ хийдэггүй юм гэхэд энийг чинь гаднын банканд хамааралгүй болгож өгч байгаа. Тэгээд татварын бас нэлээн олон зохицуулалтууд орж ирж байгаа. Үр дүнд нь юу вэ гэхээр санхүүгийн өртөг энэ хуулиар бол бууна шүү. Бодитойгоор бууна. Өрсөлдөөн бий болно. Тэгээд татварын хуулиуд нь дагаж орж ирж байгаа болохоор энэ бол ийм шүдгүй .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Даваасүрэн гишүүн нэмж тодруулъя.

Ц.Даваасүрэн: Тэгэхдээ би бид өөрөө сэтгэхүйгээ өөрчилмөөр байгаа байхгүй юу. Би бол нэрийг нь бол бизнесийн орчныг сайжруулах хууль гэдэг ч юм уу ингэмээр байгаа юм. Тэгээд харин ёстой тэр нөгөө луйвар хулгайг цэгцлэх асуудлууд, мөн тэр банк, санхүүгийн орчныг яаж сайжруулах вэ, татварын тогтолцоондоо ямар өөрчлөлт хийх вэ гэдэг асуудал. Бид нарын татварын тогтолцоо шал буруу яваа учраас хадгаламжийн чинь мөнгөн хөрөнгийн чинь 90 хувь хүн амын 3 хувьд төвлөрчихсөн байгаа байхгүй юу. Энийг бид нар өөрчлөхийн тулд татварын тогтолцоогоо, тэгж байж жижиг дунд бизнес чинь хөгжинө. Зөвхөн том бизнес хөгжөөд байгааг бид нар татвараар зохицуулахаас өөр аргагүй шүү дээ. Тэгэхээр ийм юмнуудаа анхаарч хийж өгвөл арай бодитой болно. Зүгээр ингээд нэг попорсон юм гаргаад л байвал бид нар 30 жил гаргалаа, одоо ахиад 30 жил, 60 жил гаргана.

Б.Пүрэвдорж: Ажлын хэсгийн гишүүн Батбаярын Жаргалан хариулъя.

Б.Жаргалан: Даваасүрэн гишүүний асуултад бол 2 бас зөрчилтэй зүйл байгаад байна. Өнгөрсөн 30 жил бид нар үйлдвэрлэгч болж чадаагүй гэж байна. Өнгөрсөн 30 жил бид нар тодорхой ийм эдийн засгийн эрх чөлөөнд хүрэх алхмуудаа бас хийж чадсангүй шүү дээ. Тэгээд шалтгаан нь юу юм. Шалтгаан нь энэ төр байгаад байна шүү дээ. Төрд байгаа энэ тогтолцооны авлига байгаад байна. Төр эдийн засагт хэтэрхий их хутгалдсаны чинь улмаас наад банк санхүүгийн асуудал чинь ч байна, татварын асуудал чинь ч байна. Тэгэхээр одоо энэ цаг мөчөөс хойш ер нь төр эдийн засагт янз бүрийн арга хэлбэрээр оролцохгүй гэдгээ бас тунхаглачихмаар байгаад байгаа юм.

Тэгээд нөгөө талаас Монгол Улсын хамгийн том давуу тал бол бид ардчилсан улс шүү дээ. Бид улс төрийн хувьд эрх чөлөөтэй улс. Тэгээд энэ эдийн засгийн эрх чөлөөтэй гэдгээ зарласнаараа попорсон зүйл бас болчихгүй гэж бодоод байна. Энэ сэтгэлгээг өөрчлөхийн тулд ядаж энэ зарчмуудаа тохирмоор байгаа байхгүй юу. Одоо цаашид бол бид ямарваа нэгэн хууль тогтоомж батлахдаа ингэнэ гээд. Тэгээд таны санаа зовж байгаа тэр хуулийн ../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Гүйцээж хариулъя.

Б.Жаргалан: Таны санаа зовж байгаа нөгөө хууль санаачлагчийн эрхэнд халдаж байгаа гэдэг заалт болохоор бас тодруулгатай. Үндэсний аюулгүй байдал, хүний үндсэн эрх, эрх чөлөө, хүн амын эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах зорилгоор нийтийн ашиг сонирхол, шударга өрсөлдөөнийг хамгаалахаас бусад тохиолдолд эдийн засгийн эрх чөлөөг хязгаарласан хууль гаргахгүй л гэж байгаа шүү дээ. Тэгэхдээ яах вэ, ер нь бол бид нар харин хууль санаачлагчийн хувьд ч гэсэн дээ ийм эдийн засгийн эрх чөлөөг хязгаарласан, эдийн засагт хэт их оролцсон, төрийг данхайлгасан, авлигыг өөгшүүлсэн тийм хууль санаачлахгүй л байх хэрэгтэй биз дээ. Ер нь аль ч утгаараа. Тэгэхээр тэр зарчмаа энэ дээрээ томъёолоод, тунхаглаад оруулчихад бол бас буруу зүйл байхгүй л гэж бодоод байгаа юм.

Б.Пүрэвдорж: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Санал хураалтыг 17 цагаас явуулна.

14.23 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууц сууцжуулалтын сайд Энхтайваны Бат-Амгалан танилцуулна. Индэрт урьж байна.

Зочин танилцуулъя.

Өвөрхангай аймгийн шинэ зууны залуучууд уулзалтад оролцогчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Э.Бат-Амгалан: Эрхэм Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд иргэдийн орон сууцын хүртээмжийг нэмэгдүүлэх, хот, суурин газрын төлөвлөлтийг боловсронгуй болгох, бүсчлэлийн хөгжлийг дэмжих, орон сууцны санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэх зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Орон сууцжуулалтын тухай анхдагч хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг боловсруулж, 2026 оны 06 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Хуулийн төслийг Улсын Их Хурал дахь намын бүлэг, зөвлөлүүд болон Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлээд байна.

Өнөөдөр Монгол Улсад 1 сая орчим өрх амьдарч байгаагаас 1/3 орчим нь инженерийн бүрэн хангамжтай орон сууцад, үлдсэн хэсэг нь гэр болон стандартын шаардлага бүрэн хангаагүй сууцад амьдарч байна. Агаар, хөрсний бохирдлын дийлэнх эх үүсвэр нь эдгээр бүсээс шалтгаалж байгаа нь орон сууцжуулалтын бодлогыг шинэ шатанд гаргах шаардлагатайг харуулж байна.

Өнгөрсөн хугацаанд төрөөс орон сууцын ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоо бүрдүүлэх хөтөлбөр, төрийн орон сууцын хөтөлбөр, гэр хорооллын дахин төлөвлөлт, аймаг бүрд мянган айлын орон сууц зэрэг төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн боловч 2016 оноос хойш төрийн өмчийн түрээсийн орон сууцны санд 1512 айлын орон сууцыг бүрдүүлж, зорилтот бүлгийн иргэдийг хамруулаад байна. Өрхийн орлогын судалгаагаар нийт өрхийн тал орчим хувь нь ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөр бүрдүүлэх бага болон дунд орлоготой, залуу өрхүүдийн хувьд орон сууцад хамрагдах боломж хязгаарлагдмал хэвээр байгаа нь төрийн өмчийн орон сууцын санг нэмэгдүүлэх шаардлагатайг илтгэж байна.

Мөн орон сууцын үнэ жил бүр инфляцын түвшнээс давсан буюу дунджаар 15 орчим хувиар өсөж байгаа ч өрхийн орлого 11-13 хувиар өсөж байгаа нь цаашид

иргэдийн худалдан авах чадвар улам бүр буурах эрсдэл үүсэхээр байна. Улсын хэмжээнд жилд дунджаар 20 мянга орчим орон сууц ашиглалтад орж байгаа ч орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд газар хөгжүүлэлт инженерийн дэд бүтцийн хүртээмж дутагдалтай байгаа нь орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд тулгамдсан асуудал болж байна. Дэд бүтэцгүй газарт орон сууцны төсөл хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал бөгөөд шаардлагатай хөрөнгө оруулалт төлөвлөлтийг урт хугацаанд үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлага бий болоод байна. Эдгээр нөхцөл байдлаас үзэхэд орон сууцны эрэлт нийлүүлэлтийн зөрүү нэмэгдэж, зөвхөн эрэлтэд суурилсан санхүүжилтийн бодлогоор асуудлыг бүрэн шийдвэрлэх боломж хязгаарлагдмал байгааг илтгэж байна.

Иймээс орон сууцжуулалтын бодлогыг зөвхөн ипотекийн зээлээр хязгаарлах бус газар хөгжүүлэлт, дэд бүтэц, орон сууцны нийлүүлэлт, санхүүжилтийн тогтолцоо, нийгмийн хамгааллын бодлоготой уялдуулан цогцоор нь шийдвэрлэх шаардлагатай гэж үзэж байна.

Хуулийн төсөл батлагдсанаар төрөөс орон сууцны төслүүдийг бодлогоор дэмжиж батлан даалт гаргана. Зорилтот бүлгийн иргэдэд зээлийн батлан даалт гаргана. Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцад хамруулна. Орон сууцны эрэлт нийлүүлэлтийг уялдуулж цогцоор нь шийдвэрлэнэ. Гэр хорооллын дахин төлөвлөлт эрчимжихээс гадна урт хугацаанд иргэдийн амьдрах орчин амьдралын чанарыг дээшлүүлэх чухал нөхцөл бүрдэх юм.

Иймд Орон сууцжуулалтын тухай анхдагч хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэхийг дэмжиж өгөхийг та бүхнээсээ хүсье. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Төслүүдийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гончигдоржийн Уянгахишиг гишүүн танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Г.Уянгахишиг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 06 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагчийн зүгээс уг хуулийн төсөл батлагдсанаар орон сууцжуулах бодлого нэгдсэн тогтолцоонд орж, орлогод нийцсэн орон сууцны нийлүүлэлт нэмэгдэхийн зэрэгцээ барилга, дэд бүтцийн салбарын үйл ажиллагаа идэвхжин ажлын байр нэмэгдэх, гэр хорооллын бүсийн орон сууцжуулалт эрчимжиж, агаар, хөрсний бохирдол буурах, хөрөнгийн зах зээлд орон сууцны санхүүжилтийн шинэ хэрэгслүүд нэвтрэх боломж бүрдэх, улмаар бага, дунд орлоготой болон зорилтот бүлгийн иргэдийг орон сууцаар хангах бодит нөхцөл бүрдэнэ гэж үзжээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай ипотекийн санхүүжилт нэмэгдэхийн хэрээр орон сууцны эрэлт ихсэж байгаатай холбогдуулан төсвийн болон өрийн эрсдэлийг бүрэн тооцсон

эсэх, тухайлбал батлан даалт хэрэгжих үед улсын төсөвт өр үүсэх эсэх, мөн хөлслөөд өмчлөх орон сууцын талаарх судалгаа тооцоог хэрхэн хийж, ямар хувь хэмжээтэй байхаар тооцсон талаар, энэ хууль хэрэгжсэнээр нийт хүсэлт гаргасан төлбөрийн чадваргүй зорилтот бүлгийн иргэдийн хэдэн хувийг эхний жилүүдэд хамруулах боломжтой талаар, Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулж, 21 аймагт орон сууцын зээлийг хэрэгжүүлэх тал дээр ямар бодлого баримтлах талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар байр сууриа илэрхийлэх үед Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.4.5-д энэ хуулийн 7.2-т заасан сарын суурь төлбөр болон энэ хуулийн 7.4.4-д заасан иргэний сард төлөх төлбөрийн зөрүүг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний жил бүрийн төсөвт тусгана гэж заасантай холбоотойгоор тооцоо судалгааг нь нягталж анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж төвлөрлийг сааруулах талаар тус тус саналаа хэлсэн болно.

Орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Орон сууцны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаар санал хураалт явуулахад Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх тухай Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Бүлгийн танилцуулга уу, завсарлага уу. Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэгт үг өгье. Жаргалан гишүүний микрофон.

Б.Жаргалан: Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс энэ Орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хувьд бүлэг дээрээ бас байр сууриа нэгтгэх шаардлагатай байгаа учраас Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу завсарлага авах хүсэлтэй байгаа тул шийдвэрлэж өгнө үү. 5 хоног.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг завсарлага хүссэн тул ажлын 3 өдрөөр завсарлага өглөө.

14.27 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Энхтайваны Бат-Амгалан танилцуулна.

Э.Бат-Амгалан: Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд иргэдийн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх, хот, суурин газрын төлөвлөлтийг боловсронгуй болгох, бүсчилсэн хөгжлийг дэмжих, орон сууцны санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэх зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай анхдагч хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг боловсруулж, 2026 оны 06 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Хуулийн төслийг Улсын Их Хурал дахь намын бүлэг, зөвлөлүүд болон Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлээд байна.

Өнөөдөр Монгол Улсад 1 сая орчим өрх амьдарч байгаагаас 1/3 орчим нь инженерийн бүрэн хангамжтай орон сууцад, үлдсэн хэсэг нь гэр болон стандартын шаардлага бүрэн хангаагүй сууцад амьдарч байна. Агаар, хөрсний бохирдлын дийлэнх эх үүсвэр нь эдгээр бүсээс шалтгаалж байгаа нь орон сууцны бодлогыг шинэ шатанд гаргах шаардлагатай байгааг харуулж байна. Тухайлбал, ипотекийн зээлийн хөтөлбөрөөр нийт 11 их наяд төгрөгөөс давсан санхүүжилт олгож, 144 мянга гаруй өрхийг орон сууцтай болгоход дэмжлэг үзүүлсэн хэдий ч гэр хорооллын бүсийн хэмжээ дорвитой буураагүй байна.

Мөн орон сууцны үнэ жил бүр инфляцын түвшнээс давсан буюу 15 орчим хувиар өссөөр байгаа нь орон сууцны эрэлт нийлүүлэлтийн зөрүү нэмэгдэж, зөвхөн эрэлтэд суурилсан санхүүжилтийн бодлогоор асуудлыг бүрэн шийдвэрлэх боломж хязгаарлагдмал байгааг илтгэж байна. Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөр 2013 онд эхэлснээс хойш нийт олгогдсон санхүүжилтийн 24 орчим хувь буюу 2,6 их наяд төгрөгийн зээл хөдөө орон нутагт олгогдсон байна. Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкнаас санал болгох зээлийн бүтээгдэхүүний хувьд хөнгөлөлттэй буюу 6 хувийн зээлийг орон нутагт олгох, мөн Улаанбаатар хотын алслагдсан дүүрэгт байр худалдан авч буй иргэдэд зах зээлийн нөхцөлөөс хөнгөлөлттэй хүүтэй зээл олгох зохицуулалтууд тусгасан нь орон нутаг болон алслагдсан дүүргүүдэд зээлийн хүртээмж нэмэгдэх, бүс нутаг, дэд төвүүдийн хөгжлийг дэмжих ач холбогдолтой гэж үзэж байна.

Өнгөрсөн жилүүдэд жил бүр 19 мянга орчим шинэ ипотекийн зээлийн өсөлт арилжааны банкнуудад ирж байна. Гэвч дунджаар 9,5 мянган хүсэлтийг шийдвэрлэж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар 47 гаруй мянган өрхийн хүсэлт хуримтлагдаж, 6,7 их наяд төгрөгийн санхүүжилтийн хэрэгцээ үүсээд байна.

Засгийн газраас ипотекийн зээлийн тогтолцоог сайжруулах чиглэлээр Дэлхийн банкттай 2023 оноос хойш хамтран ажиллаж байгаа бөгөөд Монгол Улсын орон сууцны бодлогыг шинэчлэх ажлын хүрээнд орон сууцны санхүүжилт, татаас болон институцийн тогтолцоонд цогц шинэчлэл хийх шаардлагатайг онцолсон. Үүний хүрээнд Дэлхийн банкнаас орон сууц болон орон сууцны санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх замын зураглалыг гаргаж, хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн зээлийн хөтөлбөрийг Засгийн газарт үе шаттай шилжүүлж, санхүүжилтийн төрөлжсөн бүтээгдэхүүн болон иргэдийн худалдан авах чадварт нийцсэн үнэтэй орон сууцны шийдлүүдийг хөгжүүлэх суурь бодлогын арга хэмжээнүүдийг санал болгосныг энэхүү хуулийн төсөл боловсруулах суурь судалгаанд ашигласан.

Хуулийн төсөл батлагдсанаар төрөөс хэт хамааралтай санхүүжилтийн тогтолцооноос зах зээлийн зарчимд суурилсан тогтолцоонд шилжинэ. Орон сууцны зээлийн хүртээмж нэмэгдэнэ. Төрийн санхүүгийн ачаалал буурна. Хөрөнгийн зах зээл хөгжиж, санхүүжилт нэмэгдэнэ.

Иймд Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай анхдагч хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг та бүхнээсээ хүсье. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Төслүүдийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга танилцуулна. Уянга таныг урьж байна.

Б.Уянга: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 06 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагчийн зүгээс уг хуулийн төслийн зорилго нь өрх гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй, эрэлт хэрэгцээнд нийцсэн байр сууцаар хангах, урт хугацааны санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, өрхийн төлбөрийн чадварт нийцүүлж ипотекийн хөнгөлөлттэй зээлийн бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банк байгуулах, түүний бүрэн эрх, удирдлага, зохион байгуулалт, эрхлэх үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, түүний үйл ажиллагаанд хяналт тавихтай холбогдсон харилцаа ба төрийн байгууллагын бүрэн эрх, үүргийг зохицуулахад оршино гэж үзжээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банк байгуулах саналын зорилго, Монголын ипотекийн корпорацаас ялгарах онцлог, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, судалгааны талаар болон шинээр байгуулах байгууллагын бүтэц, чиг үүргийг тодруулж, одоо ажиллаж байгаа Монголын

Ипотекийн корпорацын тогтолцоотой харьцуулахад ямар хэрэгцээ давуу тал байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкнаас гаргах нийт үнэт цаасны хэмжээ болон зах зээл дээр хэдэн хувийн хүүтэй үнэт цаас гаргах талаар, Засгийн газар ямар үнийн дүн бүхий үнэт цаас гаргаж, Монгол банканд худалдахаар тооцоолж байгаа талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар байр сууриа илэрхийлэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү хуулийн төслийн үзэл санааг илүү сайн нягтлах, иргэдийн хүлээлтэд нийцсэн ил тод зарчмаар орон сууцад хамрагдах дарааллыг хэрэгжүүлэх нь төрийн дунд шатад авлига үүсэх эрсдэлээс сэргийлэх ач холбогдолтой талаар үг хэлсэн болно.

Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төв банк, Монгол банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаар санал хураалт явуулахад Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх тухай Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Мөнгөнцогийн Ганхүлэгийн урилгаар Бүгд Найрамдах Солонгос Улсын Мирал зүрхний сангийн төлөөлөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Мирал сангийнхан маань Монгол Улсад эрүүл мэндийн салбар дээр маш том туслалцаа үзүүлж байсан. 300-аад хүүхдийн эрүүл мэндийг аврах, амь насыг аврах ийм буянтай үйлс бүтээсэн хүмүүс байгаа шүү. Та бүхэндээ ажил үйлс, амьдралд нь хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Жаргалан.

Б.Жаргалан: Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс 11 дүгээр асуудал буюу Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд дээр үзэл баримтлалын хувьд бас байр сууриа нэгтгэх шаардлагатай байгаа учраас Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу 3 хоногийн завсарлага өмнөхтэйгөө адилхан олгож өгнө үү.

Ж.Бат-Эрдэнэ: Ардчилсан намын гаргасан хүсэлтийн дагуу 3 хоногийн завсарлага өгч байна.

14.36 цаг.

Дараагийн асуудалдаа орёё.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ.

Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааны явцад Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшиний гаргасан горимын санал дэмжигдэж, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хойшлуулсан байгаа. Ингээд үргэлжлүүлэн хэлэлцүүлье.

Та бүхэнд ажлын хэсгийг танилцуулъя. Ренчинбямбын Цэрэнханд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал хуримтлалын Сангийн бодлогын газрын дарга, Басангийн Батжаргал Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Баттулгын Солонго хуульч, Баянмөнхийн Буянзаяа хуульч, Пүрэвээгийн Баттулга хуульч, Болор-Эрдэнийн Төрболд хуульч, Лхагвасүрэнгийн Батхуяг эдийн засагч. Ажлын хэсгийг урьж байна.

Ажлын хэсгийнхэнд хууль танилцуулаадахъя.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-д “нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа Засгийн газрын гишүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан үнэн зөв, бүрэн гүйцэт мэдээлэл өгөх үүрэгтэй. 21.25-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, Улсын Их Хуралд худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно. 21.31-д чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож, тухайн этгээдэд Төрийн албаны тухай хууль болон холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж тус тус заасныг та бүхэнд танилцуулж байна.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Асуултыг өгсөн байна. Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн алга байна. Отгоны Саранчулуун гишүүн алга байна. Наранбаатар гишүүн алга байна. Нанзадын Наранбаатар гишүүн алга байна. Мэндбаярын Мандхай гишүүн алга байна. Цэндийн Баатархүү гишүүн алга байна. Мягмардашийн Сарнай гишүүн алга байна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн алга байна. Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн алга байна. Өлзийхүүгийн Шижир гишүүн алга байна. Болдын Уянга гишүүн үг хэлэхгүй гэж байна. Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн алга байна. Батын Батбаатар гишүүн алга байна. Үг хэлэхээр өгсөн гишүүд алга байна.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асуух гишүүд алга байна. Үг хэлэх гишүүд дээр нэрсээ өгнө үү. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн алга байна. Үг хэлэх гишүүд алга байна.

Хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн эсрэг байр суурьтай гишүүн байхгүй байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулах ёстой. Санал хураалтыг 17 цагаас явуулна.

14.41 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Загджавын Мэндсайхан танилцуулна. Мэндсайхан сайдыг дуудаарай. 2 ч хууль хэлэлцэх байсан болохоор цаг хугацаа нь наашилж байна. Тийм болохоор Мэндсайхан сайдыг дуудаарай.

Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Нарантуяа-Нарагийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын “Голомт” цогцолбор сургуулийн Жанаргуль багштай 9.1 дүгээр ангийн сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Багш, сурагчид та бүхэндээ сурлагын өндөр амжилт, амьдралын хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Сая Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс 2 ч хууль дээр завсарлага авсан. Тийм болохоор хуулиуд шахагдаж байна. Үүнтэй уялдуулаад ажлын хэсгийнхэн маань мэдээллээ цаашаа өгөөрэй. Мэндсайхан сайд яаман дээрээсээ дуулагдаж ирж байна. Мэндсайхан сайд ороод ирлээ. Индэр дээр урьж байна.

3.Мэндсайхан: Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын болон Евроазийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнуудын хооронд худалдааны түр хэлэлцээрийг 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр соёрхон баталсан билээ.

Тус хэлэлцээр нь Монгол Улсын гадаад худалдааны урсгалыг нэмэгдүүлэх, экспортын боломжийг өргөжүүлэх ач холбогдолтой хэдий ч тарифын хөнгөлөлт эдлэх барааны жагсаалтад тамхи, тамхин бүтээгдэхүүн хамрагдсан нь тодорхой эрсдэлийг бий болгож байна. Тухайлбал, тамхи, тамхин бүтээгдэхүүний гаалийн тариф 0 хувь болсноор импортын өртөг буурч, зах зээлийн үнэ хямдрах, улмаар

хэрэглээ нэмэгдэх эрсдэлтэй бөгөөд энэ нь нийтийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх нэгэн хүчин зүйл болохоос гадна гаалийн албан татварын орлого буурч, улсын төсвийн орлогын тогтвортой байдалд нөлөөлөх нөхцөл үүсгэж болзошгүй юм.

Иймд Улсын Их Хурлаас хэлэлцээрийг соёрхон баталсантай холбогдуулан “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр 117 дугаар тогтоолыг баталж, тамхи, тамхин бүтээгдэхүүний гаалийн тарифыг дэмжсэнтэй холбоотой төсөв, татвар, нийгэм, эдийн засаг болон нийтийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тооцож, шаардлагатай хууль тогтоомжийг төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.

Дээрх тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Сангийн яамнаас Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслийн гол зорилго нь гаалийн тариф тэглэснээс үүдэн тамхи, тамхин бүтээгдэхүүний үнэ буурах, нөлөөллийг сааруулах, хэрэглээг татварын бодлогоор зохистой түвшинд хязгаарлах, улсын төсвийн орлогын тогтвортой байдлыг хангахад оршино.

Өнөөгийн байдлаар тамхи, тамхин бүтээгдэхүүнд онцгой албан татварыг биет нэгжид суурилсан хэлбэрээр ноогдуулж байна. Харин хуулийн төсөлд одоо мөрдөгдөж буй зохицуулалтаас гадна импортын тамхи, тамхин бүтээгдэхүүнд гаалийн үнэд суурилсан хувь хэмжээний онцгой албан татвар ногдуулах буюу биет нэгж болон үнийн дүнд суурилсан хосолсон татварын хэлбэрийг нэвтрүүлэхээр тусгалаа.

Ингэснээр импортын гаалийн тариф тэглэсэнтэй холбоотой зах зээлийн үнэ огцом буурах, хэрэглээ нэмэгдэх эрсдэлийг бууруулж, гаалийн албан татварын орлого буурснаас үүсэх төсвийн сөрөг нөлөөллийг нөхөх боломж бүрдэнэ.

Мөн хуулийн төслийн хамт “Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээ батлах тухай” Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан болно.

Иймд Монгол Улсын Их Хурлын 2025 оны 117 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд боловсруулсан Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг Улсын Их Хурлын эрхэм гишүүдээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Төслүүдийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн танилцуулна.

Д.Энхтүвшин: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 06 сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлснийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 06 сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, Төсвийн байнгын хороо 2026 оны 06 сарын 24-ний өдрийн хуралдаанаараа хууль, тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явууллаа.

Монгол Улс болон Евроазийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээр нь худалдааны урсгалыг нэмэгдүүлэх, экспортын боломжийг өргөжүүлэх ач холбогдолтой ч тарифын хөнгөлөлт эдлэх барааны жагсаалтад тамхи, тамхин бүтээгдэхүүнийг хамруулсан нь уг бүтээгдэхүүний өртөг буурч, зах зээлийн үнэ хямдрах, улсын төсвийн орлогын тогтвортой байдалд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй тул тамхи, тамхин бүтээгдэхүүнд онцгой албан татварыг хосолсон хэлбэрээр ногдуулах, мөн үнэд суурилсан татварын хувь хэмжээг тодорхойлон зохицуулахаар хууль, тогтоолын төслийг боловсруулсан байна.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг D-Parliament.mn цахим сайтад байршуулж, иргэд олон нийтийн саналыг авч байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцүүлэх үед Улсын Их Хурлын гишүүн Түвшин онцгой албан татварын хэмжээг одоогийн зах зээлд борлуулагдаж байгаа тамхины үнэтэй уялдуулан тогтоосон эсэх, Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар 1 бүтээгдэхүүнд онцгой албан татварыг хосолсон хэлбэрээр ногдуулах боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Батжаргал Улсын Их Хурлын гишүүд болон Засгийн газраас өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуулийн төслүүдэд давхардаж тусгагдсан зохицуулалтыг хэрхэн уялдуулж хэлэлцүүлэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн тамхи, тамхин бүтээгдэхүүний онцгой албан татварыг түүнд агуулагдсан никотины хэмжээ, нийтийн эрүүл мэндэд нөлөөлөхтэй холбоотой судалгаа шинжилгээний дүгнэлтийг харгалзан тогтоодог байх, Улсын Их Хурлын гишүүн Түвшин Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүдээс өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдэд тусгагдсан зохицуулалтуудыг хэрхэн уялдуулах болон тамхи, тамхин бүтээгдэхүүний гаалийн тарифыг тэглэсэнтэй холбоотойгоор онцгой албан татварыг хувь тэнцүүлэн ногдуулахдаа Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан тамхины никотины хэмжээтэй уялдуулан ялгавартай тогтоох, Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа бөгөөд Евроазийн хэлэлцээрийн хүрээнд тамхи, тамхин бүтээгдэхүүний гаалийн албан татварыг тэглэсэнтэй холбоотойгоор онцгой албан татварыг нэмэгдүүлж байгаа нь далд эдийн засгийг үүсгэх эрсдэлтэйг анхааруулж, энэ талаар Засгийн газраас хэрэгжүүлэх хяналтыг сайжруулах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Булгантуяа байгаль орчин, нийтийн эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй тамхи, тамхин бүтээгдэхүүнд ногдуулах онцгой албан

татварын хэмжээг нэмэгдүүлж байгаа нь зүйтэй хэдий ч одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Онцгой албан татварын тухай хуулийн үзэл баримтлалд нийцэх эсэхийг анхаарах нь зүйтэй талаар үг хэлсэн болно.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээ хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 55,6 хувийн саналаар дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Ажлын хэсэг танилцуулъя. Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Рэнцэнгийн Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга, Чойдоржийн Чимгэрэл Гаалийн ерөнхий газрын Барааны ангиллын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа Засгийн газрын гишүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан үнэн зөв, бүрэн гүйцэт мэдээлэл өгөх үүрэгтэй. 21.25-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, Улсын Их Хуралд худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно. 21.31-д чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож, тухайн этгээдэд Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад заасан хариуцлага хүлээлгэнэ гэж тус тус заасныг ажлын хэсгийнхэнд танилцуулж байна.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн үзэл баримтлалтай холбогдуулан урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Сүхбаатарын Эрдэнэболд.

С.Эрдэнэболд: Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн боловсруулах үзэл баримтлал дотор гарч ирж байгаа нэг зүйл нь болохлоор хуурамч шатахуунтай холбоотой зүйлс байгаа. Тэгээд энэ дээр бүр яг албан ёсны бичиг дээрээ бичихдээ бол албаныхан болон хууль хяналтынхан энэ байдлыг мэдэж байгаа боловч шийдвэртэй алхам хийхгүй байна гэж байгаа. Энэ ингээд хууль батлагдахаар яаж хумигдах юм бэ, буурах юм бэ. Одоо яг энэ төслийг боловсруулах явцад судалгаан дээр хэчнээн хувь нь ер нь хуурамч

шатахуун яваад байгаа юм бэ. Хуурамч шатахууны хувь хэмжээг ер нь багцаалдаж тооцоолсон зүйл байгаа юу. Энэ батлагдахаар ингээд шууд хамаарлаараа яаж буурах вэ. Энэ асуултад хариулт авъя.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсгийн ахлагч хариулах уу. Хэн хариулах вэ. Мэндсайхан сайд.

3.Мэндсайхан: Эрдэнэболд гишүүн ээ, энэ тамхитай холбоотой онцгой албан татварын л өөрчлөлт орж ирж байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Отгоны Саранчулуун гишүүн алга байна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр нөгөө Нямдорж гишүүн чинь би хэлсэн шүү дээ гээд хэлээд байдаг. Би Номинчимэг гишүүнд бас хэлж байсан. Тийм ээ. Өөрөөр хэлбэл яг энэ Евроазийн эдийн засгийн чөлөөт хэлэлцээрт орсонтой холбоотойгоор энэ тамхины татварын асуудал чинь гарч ирнэ гээд. Тэгээд ер нь бол Евроазийн эдийн засгийн чөлөөт хэлэлцээрийг батлахад бол би их хувь нэмэр оруулсан учраас дараа нь энэ дээр тамхины татвар нь тэглэгдэх дээр асуудал гарна гэж үзээд, өөрөөр хэлбэл 6, 7 сарын дараа болох асуудлыг цэгнээд, 2025 оны 11 сард би зарчмын зөрүүтэй санал Төсвийн хууль дээр гаргаж байсан.

Өөрөөр хэлбэл үндэслэл нь болохоор Монголын экспортын зах зээлийг тэглэх, хөдөө аж ахуй, уул уурхайн бүтээгдэхүүнийг мах, арьс шир, ноос ноолуур гэх мэт Орос, Казахстан руу илүү хялбар нийлүүлэх, Монголын 250 мянган малчны орлогыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор Улсын Их Хурал, Монгол Улс болон Евроазийн Эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгохыг дэмжсэн шийдвэртэй холбоотойгоор дараах зарчмын зөрүүтэй санал гаргаж байна. Бүх төрлийн тамхинд ногдох онцгой албан татварыг Евроазийн эдийн засгийн чөлөөт холбоонд орсон орнуудаас импортлох бүх төрлийн тамхинд ноогдох онцгой албан татварын хэмжээг 30 хувиар нэмэх гэж ингэж оруулж байсан байна л даа. Тэгэхээр ер нь бол зарим гишүүд энэ дээр жоохон андуураад байх шиг байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ чинь тэр Евроазийн эдийн засгийн 5 орноос л орж ирж байгаа тамхин дээр 30 хувийн гаалийн татвар байхгүй болчихоор нөхөж, 30 хувийн онцгой татвар орлуулж байгаа юм. Өөрөөр хэлбэл тэр 5 улсаас бусад орнууд бүгдээрээ 30 хувийн татвартаа оруулаад, зөвхөн энэ 5 орон 30 хувийн татваргүй оруулчих юм бол энэ чинь нөгөө худалдааны зөрүү, тэр хуулиар татвар хулгайлсан ийм л асуудал руу орох байхгүй юу даа.

Тийм учраас Засгийн газраас энэ асуудлыг оруулж ирээд, яаралтай ингээд хэлэлцүүлээд дэмжээд, баталж байгаа нь маш зөв байгаа юм. Ингэснээр энэ худалдааны тэгш байдлыг илүү бий болгох боломжийг бий болгож байгаа. Тийм учраас дараа дараа нь Их Хурлын гишүүд янз янзын асуудал байлаа гэхэд ер нь бол өөрийн өргөн барьсан хууль болон бусад асуудлууд ирээдүйд ийм зүйлийг бий болгоно гэдэг дээр бас анхаарч, тодорхой хэмжээний саналуудыг энэ Их Хурлын хэлэлцүүлгийн аль ч шатад гаргаж байх нь зүйтэй гэж бас зөвлөмөөр байна. Надад бас Нямдорж гишүүн зөвлөж байсан юм. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Үг хэллээ. Батийн Батбаатар гишүүн алга байна. Пүрэвжавын Сайнзориг гишүүн алга байна. Хассуурийн Ганхуяг гишүүн алга байна. Банзрагчийн Түвшин гишүүн.

Б.Түвшин: Энэ онцгой татварын асуудлыг бол яг энэ орж ирж байгаа хэлбэрийг бол дэмжиж байгаа. Энэ Евроазийн хэлэлцээрээр гаалийн татвар ногдуулдаг байсан дүнтэй тэнцэх хэмжээний онцгой албан татварыг тогтоож байгаа. Тэгэхээр энэ улсын төсөвт ордог орлогыг алдахгүй, нэг талдаа тамхины үнийг хэт бууруулахгүй гэсэн ийм бодлого учраас энийг бол дэмжиж байгаа юм.

Гэхдээ нэг асуудал байгаад байна л даа. Хамрын тамхийг онцгой албан татвараас чөлөөлнө гээд ингээд заачихсан. Энэ заалт авч хаяагүй мөртөө одоо яг тэр гаалийн татварын оронд онцгой албан татвар луу ороод ирчихээр энэ чинь хуулийн зөрчилтэй болчихож байгаа юм биш үү. Энийг 1 дүгээрт тайлбарлаад өгөөч.

2 дугаарт энэ хосолсон онцгой албан татвар гээд яриад байгаа. 1 талдаа тоо ширхэгт нь ногдуулна, нөгөө талдаа үнийн дүнд нь ногдуулна гэж байгаа. Тэгээд энэ гаалийн татварыг хөрвүүлэхдээ яг аль нэгээр нь болохгүй байна уу. Энийг нь хослуулж байж заавал тэр дүн нь таараад байгаа юм уу. Яагаад заавал хосолсон гээд байгаа юм. Энэ хосолсон онцгой албан татвар ногдуул болж байгаа арга хэлбэрүүдээ тодорхой тайлбарлаад өгөөдхөөч.

3 дугаарт Засгийн газраас өргөн мэдүүлсэн Тамхины тухай хууль байгаа. Номинчимэг нарын өргөн мэдүүлсэн тамхины тухай хууль байгаа. Одоо энэ гаалийн татварыг онцгой албан татвар болгож байгаа хууль байгаа. Энэ 3 хууль хэрвээ ямар нэгэн цаг хугацаанд давхцах бол яг нийт гарах үр дүнг нь ер нь яаж шийдэхээр байгаа вэ. Өнөөдрийнхийг шууд ойлгож байгаа. Гаалийн татварын хэмжээгээр шууд онцгой албан татвар ногдуулж байгаа учраас энийг зарчмын хувьд дэмжээд байгаа. Нөгөөдүүл нь энэ хуультай орж ирэхээрээ энэ онцгой албан татвар чинь ер нь юу болж хувирах вэ. Энэ ирээдүйгээ ер нь харж байна уу.

3 дугаарт ер нь энэ тамхины хамгийн хортой гээд байгаа зүйлийг бол никотин л гэж байгаа. Энэ никотин нь тэр бүх төрлийн тэр вейп, янжуур, дүнсэн тамхинд байдаг зүйл гэж ойлгож байгаа. Энэ никотин чинь өөр хэлбэр лүү шилжээд чихэр, гаанд орж ирээд, ялангуяа залуучууд, хүүхдүүдийг маш ихээр уруу татаж байна гэж яриад байгаа. Тэгэхээр энэ чихэр гаанд онцгой албан татвар ногдуулах уу. Тэрний никотинд нь ногдуулах уу. Миний хувьд зүгээр барьж байгаа байр суурь бол яг тэр никотинд нь бол онцгой албан татварыг тусгайлан хувь ногдуулах нь зөв байх гэж ингэж бодож байгаа. Тийм учраас одоо бол тамхи, никотинтой чихэр, гаа энэ тэр бол эцсийн үр дүндээ ялгаагүй хүмүүсийг уруу татдаг татдаг, ялангуяа залуу үеийг уруу татдаг ийм ийм бүтээгдэхүүн болчихсон ийм болчихсон юм байна. Энэ талаар ямар бодлого барьж байгаа вэ гэсэн ийм асуултад хариулж өгөөч.

Ж.Бат-Эрдэнэ: Мэндсайхан сайд хариулъя.

3.Мэндсайхан: Түвшин гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр хамрын тамхины хувьд бол өмнө гаалийн татвар нь 20 хувь байсан. Онцгой албан татвар хамрын тамхинаас авахгүй гэдэг заалттай. Тэгэхээр энийг нь бид нар яаж оруулж ирж байна вэ гэхээр гаалийн татвар нь нэгэнт энэ 5 улсаас Евроазийн хэлэлцээрийн хүрээнд тэглэхэж байгаа учраас гаалийн татвараас авдаг байсан 20 хувийг нь

онцгой албан татварт оруулаад, таны хэлж байгаа тэр онцгой албан татварын өөрчлөлтийг нь хийгээд явна.

Ер нь хосолсон татвар гэдэг дээрээ юу хэлж байна вэ гэхээр энэ дэлхий нийтээрээ ер нь бол 63 оронд хэрэглэдэг юм байна. Манай дээр ч гэсэн хэрэглээд явж байгаа онцгой албан татвар дээр. Жишээлбэл, суудлын автомашин дээр цилиндрээс нь болон үнийн дүнгээс нь цилиндрийнх нь моторын хэмжээнээс нь болон үнийн дүнгээс нь аваад явж байгаа. Тэгээд яг үүнтэй адилхан тамхин дээр бид нар онцгой албан татвараа 30 хувиар авна. Тэгээд тоо ширхэг дээр нь мөн 1 ширхэг дээр 836 төгрөг гээд, задгай дүнсэн тамхин дээр 1кг дээр 3130 гээд явна. Энэ яагаад ийм бодлогууд явж байна гэхээр ДЭМБ-д Тамхины хяналтын суурь конвенцад Монгол Улс 2003 онд нэгдэж орсон. Гол барьж байгаа бодлого бол татварыг өсгөх замаар тамхины хэрэглээг бууруулна гэж байгаа юм. Тэгэхээр энэ бодлоготой уялдуулаад бид нар энэ татварынхаа тоо хэмжээг, хувь хэмжээг тогтоогоод явж байгаа.

Номинчимэг гишүүний оруулж ирэх хууль бол бид нарын энэ оруулж ирж байгаа онцгой албан татварын 30 хувийг хөндөхгүй, зөвхөн тоо ширхэг дээр орж ирэх өөрчлөлт орж ирнэ. Тэгэхээр бид нар тэр хууль хэзээ батлагдахыг хэлэлцүүлгийн явцад Их Хурал шийдэх учраас тэрнээс өмнө яаралтайгаар одоо явж байгаа татварынхаа зохицуулалтыг төсвийн орлогод нь нөлөөлөхгүй, мөн татварын бодлогоор бизнес эрхлэгчид давуу тал олгохгүй, өмнөх татварын хувь хэмжээгээ хадгалах зорилгоор оруулж ирж байгаа.

Тэр нөгөө бохины асуудлаар ажлын хэсэг нэмээд хариулчих. Чимидсүрэн дарга.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг. 4 дүгээр индэр.

Ч.Чимидсүрэн: Түвшин гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Татварын бодлогын газар Чимидсүрэн. Тэгэхээр энэ удаагийн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа асуудал бол зөвхөн гаалийн татварыг Евроазийн түр хэлэлцээртэй холбоотой тэглэсэнтэй холбоотой. Түүнийг болиулаад тэглээд, тэгээд онцгой албан татвараар гаалийн тэр 30 хувиа онцгой албан татвараар нөхөхтэй л холбоотой зөвхөн зохицуулалт бол энэ хуулийн зохицуулалтаар орж ирж байгаа.

Номинчимэг гишүүнээр ахлуулсан гишүүдийн санаачилсан хууль дээр түрүүний хэлсэн тамхины хоруу чанартай холбоотой зохицуулалтын асуудал нь бол тэр хууль дээрээ орж байгаа учраас Засгийн газраас өргөн барьсан энэ хууль дээр бол энэ асуудал хөндөгдөөгүй байгаа гэж хариулах байна.

Ж.Бат-Эрдэнэ: Түвшин гишүүн тодруулъя.

Б.Түвшин: Энэ бол угаасаа нөгөө гаалийн татварыг нөхөж байгаа гэдэг утгаар зарчмын хувьд ойлгомжтой асуудал. Гэхдээ дараагийн яг өөрчлөлт шинэчлэлтээр тэр никотинтой бохь, чихэр, гааны асуудлыг зайлшгүй хөндөх шаардлагатай.

2 дугаарт тэр хамрын тамхин дээр онцгой албан татвар ногдуулахгүй гэдэг заалтаа өөрчлөхгүй бол Онцгой албан татварын тухай хууль дээр хамрын тамхин

дээр онцгой албан татвар ноогдуулахгүй гэж заачхаад, одоо гаалийн татвараа онцгой албан татвар болгож хувиргаж байгаа буюу хуулийн зөрчилтэй болж байгаа шүү гэдгийг сануулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Батбаярын Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Өнөөдрийн Засгийн газраас оруулж ирж байгаа Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал бол Засгийн газар өөрийнхөө гаргасан алдааг л залруулж байгаа хэлбэр юм л даа. Тэгэхээр Евроазийн хэлэлцээрийг байгуулахдаа бас Засгийн газрын зүгээс маш их хайнга хандсан нь яг энэ тамхины асуудал дээр илрээд байгаа юм. Угаасаа Казахстан гэдэг улс орноос манай импортын бас тодорхой хувь нь яг энэ тамхин бүтээгдэхүүн дээр байгаа нөхцөлд ийм хариуцлагагүй байдлаар энэ хэлэлцээрийн хүрээнд импортын татвар тэглэгдэж байгаа бараа бүтээгдэхүүний жагсаалт оруулсан нь бол маш хариуцлагагүй л явдал боллоо гэж үзэж байгаа.

Тэгээд ер нь бол сүүлийн үед манай Засгийн газраас орж ирж байгаа хуулийн төслүүд, дэвшүүлж байгаа хөтөлбөрүүд энэ тэр дээр ийм хариуцлагагүй алдаанууд маш их гарч байна. Тэгээд уг нь бол энэ төр чинь данхайгаад л байдаг. Энэ төрийн захиргааны албан хаагчдын тоо олшроод л байдаг. Тэгээд уг нь бол ингээд гарч байгаа бүтээгдэхүүн, ядаж энэ Улсын Их Хуралдаа оруулж ирж байгаа тэр бичиг баримтууд нь бас нэг ийм боловсруулалтын түвшинд аятайхан юм орж ирмээр байх юм. Гэтэл тэгээд ийм болхи, бүдүүлэг алдаа гараад, тэгээд дараа нь энийг нь Улсын Их Хуралы яаралтайгаар хэлэлцээд л. Тэгээд одоо бид нар чинь ингээд он удаан жил тамхин бүтээгдэхүүн дээр гаалийн татвар өндөр хувь хэмжээтэйгээр ногдуулж ирж байгаад, одоо тэгээд бүтнээр нь тэглээд, тэгээд онцгой албан татварыг ийм 2 хэлбэрээр авдаг татварынхаа бодлогын бас ийм горимыг өөрчилж байна шүү дээ. Тэгэхээр ингээд ийм хариуцлагагүй алдааны улмаас ийм сонин, болхи шийдэл рүү орж байгаа нь ч гэсэндээ бас л асуудал юм.

Тэгэхээр ер нь бол цаашдаа бол энэ Засгийн газар боловсруулж байгаа бичиг баримтууд дээрээ, тэгээд эсвэл янз бүрийн ашиг сонирхол ороод байдаг юм уу. Яахаараа ийм алдаанууд гараад байдаг юм. Яахаараа энийг нь тэгээд дараа нь Улсын Их Хурал ийм яаралтай горимоор яаруу сандруу батлахгүй бол болохгүй, эс бөгөөс ингээд л энэ хэлэлцээр үйлчлээд эхлэх юм бол ийм асуудал үүсчихлээ энэ тэр гээд. Тэгээд яагаад ингээд Их Хурал энэ дээр нь ингэж хуралдаж байх ёстой юм. Би бас ойлгохгүй л байгаад байгаа.

Тэгээд энэ Евроазийн хэлэлцээрт энэ тамхин бүтээгдэхүүнийг чөлөөлөгдөж байгаа барааны нэр төрөлд оруулсан субъектүүдийг нь олж тогтоогоод, тэгээд ер нь бол бид нар эзэн холбогдогч, тэр хариуцсан этгээдүүдтэй нь бас хариуцлага тооцох ёстой шүү дээ. Тэгэхгүй тэгээд үүнээс чинь болж ингээд л улс орноороо янз бүрийн тодорхой бас байдалд ороод, энэ гаалиа яах юм, энэ онцгойгоо яах юм энэ тэр гээд л бас л бөөн хэлэлцүүлэг, ийм ойлгомжгүй байдал үүсэж байгаа юм.

Тэгэхээр одоо болохоор манай онцгой албан татвар ийм 2 горимтой болж байгаа. Үүний улмаас. Гаалийн албан татварынхаа 30 хувийг нөхөхийн тулд нөгөө үнийн дүнгээс 30 хувийн онцгой албан татвар ногдуулаад, тэгээд дараа нь нэгж бүтээгдэхүүн дээрээ Тамхины хяналтын тухай хуульд дагалдсан өнөөдөр үдээс

хойш орж ирэх хуулийн дагуу нэгж бүтээгдэхүүн дээрээ бас ийм онцгой албан татвар ногдуулаад ингээд ийм дэглэмтэй болж байгаа. Тамхин бүтээгдэхүүн дээр.

Тэгээд энэ Евроазийн хэлэлцээрийн хүрээнд энэ асуудлыг оруулж ирсэн тэр хариуцсан эздүүдтэйгээ бас Засгийн газар хариуцлага тооцооч ээ л гэж хүсэх байна.

Ж.Бат-Эрдэнэ: Мэндсайхан сайд хариулъя.

3.Мэндсайхан: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Энэ субъектүүдтэй хариуцлага тооцох гэдэг зөв өө зөв. Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Гантөмөр Евроазийн хэлэлцээрийг хамгийн сүүлчийн байдлаар эцэслэн тохирсон юм байна лээ. Тэгээд тэр тохирсон хэлэлцээрийн дагуу та бид Их Хурлаар баталсан хэлэлцээр байгаа. Тэгээд ийм алдаа гарсан байна. Энийг Засгийн газар залруулж энэ хуулийг оруулж ирж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Евроазийн хэлэлцээр Гантөмөр сайдаас ч өмнө бас хэлэлцэгдээд явж байсан байх. Тэгэхээр хэдүүлээ ийм бичил улс төржилтөө болиод, тэгээд энэ чинь Монгол төрийн ажил явж байна шүү дээ. Тэгээд цаана нь болохоор ингээд бас бүхэл бүтэн нийгмийн нөлөөлөл энэ тэрийг нь бас тооцож үзэх ёстой шүү дээ. Тэгээд ийм юм ярихаар урдаас улс төржөөд байх юм. Тэгээд та хэд түрүүнээс хойш тэгээд мэдсээр байж тэгвэл өнгөрсөн хугацаанд яаралтайгаар энэ хуулиа оруулаад ирэх нь яасан юм. Яагаад заавал ингээд наадам дөхүүлээд, тэгээд энэ Их Хурлыг ямар ч зогсоо зайгүй хуралдуулаад ингэж оруулж ирж байгаа юм бэ. Зөндөө цаг хугацаа байлаа шүү дээ. Энэ алдаагаа залруулахад. Тэгээд Засгийн газар ер нь юу хийж байсан юм тэгвэл тэр хугацаанаас хойш. Наад хамтарсан Засгийн газар чинь огцроод даруй 1 жилийн хугацаа өнгөрлөө шүү дээ. Бүгдээрээ л мэдэж л байгаа шүү дээ. Тэгээд 1 жилийн хугацаанд юу ч хийгээгүй юм байж байж. Одоо тэгээд л эзэн холбогдогчийг нь олж илрүүлж гэнэ. 1 жилийн хугацаанд та нар л байсан биз дээ. Тэгээд яагаад ингээд заавал наадам дөхүүлчихсэн байгаа энэ цаг хугацаан дээр ингэж яаралтай энэ тэр гэж авчирч байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Үг хэллээ. Одсүрэнгийн Номинчимэг.

О.Номинчимэг: Өнөөдөр иргэдийн амьдрал амаргүй, татварыг буулгах, багасгаж өгөхийг хүсэж байгаа. Тэр бол үнэн. Гэхдээ бидний хувьд хэзээ ч буулгаж болохгүй татвар гэж байдаг. Энэ бол архины татвар, тамхины татвар. Энэ бол ирээдүй хойч үеийнхээ эрүүл мэнд, амь нас, сайн сайхан бүхнийг нь хамгаалахын төлөө хийдэг бидний төрийн бодлого байдаг. Тэгээд Тамхины хяналтын тухай хуулийг өргөн барьснаас хойш, өргөн барьсны дараа шүү. 3 сарын дараа энэ Улсын Их Хурал Евроазийн хэлэлцээрийг баталсан. Энэ дээр манай гишүүдийн ярьж байгаа Засгийн газар ч гэсэн энэ буруугаа хүлээн зөвшөөрсөн янжуур тамхины гаалийн албан татварыг 30 хувийн татварыг тэглээд орж ирсэн. Энэ асуудлыг ер нь босгоод, энэ чинь болохгүй шүү дээ, яана шүү дээ. Энийгээ арга хэмжээ аваач гэдэг асуудлыг бол байнга л ярьж ирсэн.

Улсын Их Хурлаас энийгээ тэгвэл дотоодын хууль тогтоомжоороо нөхөөд, одоо бүр янжуур тамхины баянбүрд болчихоод байгаа энэ Монгол Улсад чанар муутай, хямдхан тамхиа бүр хямд болгож, бүр олон хүнийг өвчлөлд хөтлөхгүйн

төлөө энийгээ засаад ороод ир гэдэг даалгаврыг түрүү жилийн 12 сард Засгийн газарт өгсөн. 7 сарын дараа гуйж гувшуулж, бараг ичиж үхмээр шүү гэж баахан хэлүүлж байж орж ирж байна. Яагаад гэвэл 7 сарын 22-нд энэ Евроазийн хэлэлцээр хэрэгжиж эхлэх гэж байна. Тэгээд энэ дээр бол эс үйлдэхүй зөндөө байсан. Харин ч энэ асуудлыг бас ойлгоод, нэн яаралтайгаар энийг шийдэх ёстой юм байна гээд оруулж ирж байгаа Мэндсайхан сайдад би баярлаж байгаа. Урьд нь би өмнөх сайд нартай нь зөндөө ярьсан. Зөндөө л бүгдээрэнд нь шаардлага тавьсан. Асуулга тавьсан. Гэтэл энэ асуудал эс үйлдэхгүйгээрээ хааж байсан асуудлыг энийг ямартай ч шийдэх ёстой гээд орж ирж байгаа бол Сангийн сайдад баярлаж байна. Учрал сайдад асуулга тавиад, энийг ойлгоод бас орж ирж байгаа Ерөнхий сайддаа бас талархаж байгаа. Ямартай ч энэ асуудлаа шийдчихье гээд.

Тэгээд энэ хэлэлцүүлэг, үүний дараа ч гэсэн Тамхины хяналтын тухай хууль орно. Гишүүдийн өргөн барьсан. Тэгээд тэрэнтэй бас ингэж хольж хутгаж байгаа, сошиал орчинд зориудаар бас түгээж байгаа мэдээлэл байна л даа. Тэгэхээр энэ бол урьд нь Евроазийн хэлэлцээрээр тэглэчихсэн гаалийн янжуур татварынхаа шүү. Гаалийн албан татварыг нөхөж орж ирж байгаа юм.

Гэхдээ энэ дээр Түвшин гишүүний хэлж байгаа зөв. Бид нар одоо энэ онцгой албан татвар болон Улсын Их Хурал дээр анхны хэлэлцүүлгээ хийх гэж байгаа Тамхины хяналтын тухай хуулийнхаа нийцлийг бас сайтар харах ёстой. Тэгэхгүй бол яг энэ чигээрээ Засгийн газраас орж ирсэн энэ хуулийг энэ чигээр нь батлах юм бол өнөөдөр үйлчилж байгаа тамхины янжуурын татвар багасна. Яагаад гэвэл энэ дээр хувь хэмжээ заагаад, номинал үнэ буюу ширхэгээр оноодог тоог нь бол тавиагүй байгаа.

Түрүүн бас тэр хамрын тамхитай холбоотой асуудлыг хөндлөө. Тэгэхээр энэ 2 хууль маань зэрэгцээд явж байгаа учраас хамтатгаад, нийцэл бичилтийг нь хийдэл байхгүйгээр хийхгүй бол ямар нэгэн болчимгүй алдаа байдаг юм уу, цаг хугацааны зөрүүнээс болоод асуудал болох вий гэдэг дээр үнэхээр болгоомжилж байна.

Улсын Их Хурлын гишүүддээ ч гэсэн, хурал даргалагч Улсын Их Хурлын даргад ч гэсэн энэ 2 хуулийг хамтатгаад, нийцүүлээд, 1 гараар хурдхан шиг гаргаад явсан нь илүү зөв байх гэдэг ийм байр суурийг бас илэрхийлье.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн үзэл баримтлалтай холбогдуулан урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж дууслаа. Хариулт авч дууслаа.

Хууль, тогтоолын төслүүдийн талаарх Байнгын хорооноос гарсан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн. Индэр дээрээс. 2 номерын индэр.

М.Нарантуяа-Нара: Өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр онцгой татварын асуудал бол үнэхээр хүний эрүүл мэндэд хор хөнөөлтэй, хүний эрүүл мэндэд өөрт нь болоод өрөөл бусдад шууд болон шууд бусаар хортой бүтээгдэхүүн, аливаа төрлийн хор хөнөөл учруулж байгаа бүтээгдэхүүнд онцгой татвар байх нь маш зөв. Тэр дундаа

тамхи, тамхин бүтээгдэхүүн, бүх төрлийн тамхи, тамхин бүтээгдэхүүнд онцгой татвар ногдуулах нь маш зөв.

Харин энд төрийн бодлогын уялдаа холбоо гэдэг зүйл байхгүйн улмаас өнөөдөр тэнд Евроазийн хэлэлцээр, тэнд байгаа Евроазийн хэлэлцээрээр зарим нэгэн улсаас орж ирж байгаа янжуур тамхи болон бусад тамхин төрлийн бүтээгдэхүүний татварыг тэглэх. Энд гэтэл хууль санаачлаад орж ирсэн зүйл нь ингээд хоорондоо харшаад байгаа энэ бүх болж байгаа асуудал бол өөрөө төрийн бодлогын уялдаа холбоо байхгүй байгаагийн илрэл. Тэгэхээр ямар ч л байсан яаралтайгаар энэ он удаан жил аль аль Засгийн газрууд авч хэлэлцэхгүй байж байгаад ийм удааширсан асуудлыг бас Сангийн сайд оруулж ирж байгаа юм байна. Тэгэхээр энийг бол бас нэгэнт цаг хугацаа нь тулчихсан, 07 сарын 22 гээд хэрэгжиж эхлэх энэ асуудлыг бол яаралтай шийдүүлээд явах нь зөв.

Тийм учраас энэ хуулийг бол дэмжиж байна гэсэн байр суурьтай байна.

Ж.Бат-Эрдэнэ: Дэмжсэн байр суурьтай үг хэллээ. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн үг хэлэхгүй юм байна. Гишүүд үг хэлж дууслаа.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулах ёстой. Санал хураалтыг 17 цагт явуулна.

15.18 цаг.

Дараагийн асуудалд орёё.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн танилцуулна.

Ж.Чинбүрэн: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг нарын 78 гишүүн 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлдүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын даргын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 518 дугаар захирамжаар дээрх хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэнгээр ахлуулж, ажлын

хэсгийн дэд ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар, гишүүд Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал, Бум-Очир, Ганбаатар, Жаргалан, Сайнзориг, Ундраа, Цэнгүүн, Энхнасан, Нарантуяа-Нара нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллалаа.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулсан талаар дараах санал, дүгнэлтийг танилцуулж байна.

Ажлын хэсэг, тамхины хэрэглээг бууруулах, хүн амыг тамхи болон никотин хамаарлаас үүдэлтэй эрүүл мэндийн эрсдэлээс хамгаалах, электрон болон шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хүүхэд, өсвөр үе, залуучуудыг тамхины хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, тамхинаас гарах эрүүл мэндийн тусламж үйлчилгээг дэмжих, тамхины хяналтын тогтолцоо, хяналт, хариуцлагын механизмыг боловсронгуй болгох, олон улсын гэрээ, судалгаа, ДЭМБ-ын зөвлөмжид нийцсэн эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн өөрчлөлтүүдийг хуулийн төсөлд тусгах дараах зарчмын зөрүүтэй саналыг боловсруулсан. Үүнд:

1.Тамхи, тамхин бүтээгдэхүүний талаарх нэр томьёо, ойлголтыг боловсронгуй болгож, электрон тамхи, халаадаг, тамхи, усан тамхи болон никотин агуулсан шинэ төрлийн бүтээгдэхүүнийг тамхин бүтээгдэхүүний ангилалд хамруулж, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах.

2.Тамхин бүтээгдэхүүнд ноогдох никотины хувь хэмжээ болон зурагт анхааруулгыг стандартын техникийн зохицуулалтад нийцүүлэн түүнийг баримтлахаар тусгах.

3.Тамхины хяналтыг хэрэгжүүлэх талаар төрийн байгууллагын үүргийг зохицуулалтыг холбогдох хуульд нийцүүлж, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үүрэгт тамхины хамаарлаас гарах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, тамхины хэрэглээ болон тамхины хяналтын талаар хүн амд чиглэсэн сургалт сурталчилгаа, эрүүл мэндийн боловсролын үйл ажиллагааг зохион байгуулах үүргүүдийг нэмж тусгах.

4.Түүнчлэн Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

-Цахилгаан халаадаг тамхийг янжуур тамхитай адилтган нэг төрөлд оруулж татвар ноогдуулж байсныг тусад нь ангилах;

-Аманд уусах, зажлах зориулалттай тамхин бүтээгдэхүүнээс онцгой албан татвар ноогдуулахаар тусгах;

-Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тамхин бүтээгдэхүүний жижиглэнгийн үнийн талаарх зөвлөмжийн дагуу 5 жилийн хооронд үе шаттайгаар нэмэгдэх онцгой албан татварын хэмжээг 60 хувьд хүргэхээр тооцох;

-Тамхин бүтээгдэхүүнд онцгой албан татвар ноогдуулахдаа ялгавчтайгаар тогтоох;

-Никотин агуулагдаагүй тамхи татах төхөөрөмж, түүний эд ангид онцгой албан татвар ноогдуулахгүйгээр тусгах.

5.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Импортын гаалийн татварын хувь хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд бүтээгдэхүүний нэр томъёог нийцүүлж үндэсний ангиллын кодыг шинэчлэн тусгах зэрэг болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Мөнхсайхан Онцгой албан татварын хувь хэмжээг нэмэгдүүлснээр тамхины хэрэглээ хэр хэмжээгээр буурах тооцоолол, судалгаа байгаа эсэх, мөн татвараас бүрдэх орлогын тодорхой хувийг Эрүүл мэндийн даатгалын сан болон тамхидалтыг бууруулах арга хэмжээнд төвлөрүүлэх зохицуулалт байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Саранчулуун татах төхөөрөмж гэдэгт ямар төрлийн төхөөрөмжүүд хамаарах, эдгээрийг хэдэн төрөлд ангилж байгаа, одоогоор зах зээлд хэрэглэгдэж буй ижил төрлийн бүтээгдэхүүнээс юугаараа ялгаатай болох талаар, ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнд донтолтыг мэргэжлийн талаас тодорхойлох зан үйл судлаач орж ажилласан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Нарантуяа-Нара хуулийн төсөл нь Байнгын хорооны анхны хэлэлцүүлгийн шатад судалгаа, нотолгооны хангалттай үндэслэлгүйгээр хэлэлцэгдэж байгаа талаар, тамхинаас гарах эмчилгээ, зөвлөгөөний үйлчилгээ, сэтгэцийн асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллага хариуцахаар тусгасан нь тухайн байгууллагын хүний нөөц, ачаалалтай нийцэж байгаа эсэх талаар, мөн хуулийн төсөлд электрон тамхины амт, үнэрийг хориглохоор тусгасан нь бий болох үр нөлөө, эрсдэл, хууль бус зах зээл болон цаашид хүүхэд хэрэглэхгүй гэсэн баталгаа, бодит судалгаа, тооцоололд үнэлэгдсэн эсэх нь тодорхойгүй талаар, Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа Боловсролын хөтөлбөр дамжуулан эрүүл мэндийн хичээлийн хүрээнд тамхины хор уршгийг таниулах, урьдчилан сэргийлэх талаар тусгасан зохицуулалт, мөн сургуулийн орчинд тамхины хэрэглээ, худалдааны зөрчил илэрсэн тохиолдолд мэдээлэх, хамтран ажиллах талаар Боловсролын яамны үүргийг тусгасан зохицуулалтыг ямар шатлалаар хассан талаар, Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг улс орнууд тамхины хяналтын бодлого боловсруулахдаа тамхины үйлдвэрлэл, худалдааны байгууллагын ашиг сонирхлоос ангид байх зарчмыг тусгасан зохицуулалт, мөн онцгой албан татварын орлогын тодорхой хэсгийг тамхидалтыг бууруулах арга хэмжээ болон шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтэд зарцуулах зохицуулалт, тамхин бүтээгдэхүүний зурагт анхааруулгын хэмжээг 70 хувь болгон нэмэгдүүлэхээр төсөлд тусгасныг ямар үндэслэлээр хассан талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Ажлын хэсгээс гаргасан 32 зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгахад Байнгын хорооны гишүүдийн олонх нь дэмжсэн бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Нарантуяа-Нара, Энхнасан, Батбаатар, Мөнхсайхан, Ганхуяг нарын зарчмын зөрүүтэй 14 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй бол Улсын Их Хурлын гишүүн Шижир зарчмын зөрүүтэй 1 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Бат-Ирээдүйн Анар Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Намжилын Эрдэнэбаяр Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Чойжилсүрэнгийн Чимидсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Баясгалангийн Батшагай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, Батмөнхийн Цэцэгсайхан Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Цэндгомбын Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Чимэддоржийн Чимгэрэл Гаалийн ерөнхий газрын Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн даргын үүргийг орлон гүйцэтгэгч, Рэнцэнгийн Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга, Жаргалсайханы Төрболд Сангийн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн, Далхсүрэнгийн Долгорсүрэн Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын мэргэжилтэн, Бямбаагийн Отгонбаяр Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын Татварын улсын байцаагч, Эрдэнийн Чойсүрэн Боловсролын яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч, Хадбаатарын Майцэцэг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хүнсний худалдаа, тусгай зохицуулалтын асуудал хариуцсан шинжээч, Дорждагвын Ганзориг Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Эрүүл мэндийн инновац, технологи, цахим хөгжлийн хэлтсийн Анагаахын шинжлэх ухааны судалгаа, эрдэм шинжилгээ хариуцсан шинжээч, Сүхбаатарын Болормаа Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын суурин төлөөллөгчийн газрын Халдварт бус өвчний урьдчилан сэргийлэлт, хяналтын асуудал хариуцсан мэргэжилтэн.

Та бүхэнд хуулийн заалт уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-д “нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа Засгийн газрын гишүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлэл өгөх үүрэгтэй.”, 21.25-д “нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, Улсын Их Хуралд худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно.”, 21.31-д “чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож, тухайн этгээдэд Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэж тус тус заасныг та бүхэнд танилцуулж байна.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Наранцэцэгийн Алтаншагай гишүүн.

Н.Алтаншагай: Хуулийн төслийг бол үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаа. Тамхидалт болон энэ өсвөр насныхны эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр тодорхой тусгагдсан ийм хуулийн зохицуулалттай хууль өргөн баригдсан гэж энэ хуулийн төсөл дээрээс уншихад бас ойлгогдохоор байгаа. Энэ электрон тамхины хэрэглээ сүүлийн үед ихэссэн. Энэ амт, үнэр зэргээс шалтгаалж хүүхдүүдийн хэрэглээ ихсэж, сонирхох, өсвөр насны хүүхдүүд энийг бас дам нөлөөллөөр тэр үнэр, амтанд татагдаж маш ихээр татаж, хэрэглэх, ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдын дунд бас түгээмэл болоод байгаа юм. Тэгээд энэ электрон тамхийг цахилгаан хэрэгсэл гэсэн ангиллаар гаалиар нэвтэрдэг гэж хуулийн танилцуулгад дурдсан байна. Хуулийн төсөлд электрон тамхины шингэн, бүх төрлийн тамхины төхөөрөмж, дагалдах эд ангид онцгой албан татвар ноогдуулах, онцгой албан татварыг өсгөх зохицуулалтыг тусгасан байгаа. Тамхины татварыг нэмэгдүүлэх нь тамхидалттай тэмцэх бас үндсэн аргуудын 1 гэж үзэж, миний хувьд бол үзэж байгаа юм.

Хуулийн төсөлд татварыг нэмэгдүүлэх талаар яг хэрхэн тусгасан бэ. Энэ дээр бид нар томоохон бодлого гаргаж явахгүй бол маш олон жил энэ Тамхины тухай хууль лоббинд ордог юм уу, хойшоо тавигдсаар ирсэн. Тэгээд шинэ тутам үүсэж байгаа энэ харилцаан дээр, электрон тамхи дээр яг ямар зохицуулалтууд хийх вэ. Энэ хуулийн төслийг барьснаас хойш энэ чинь энэ санаачлагч руу маш их дайрч байгаа юм Илт. энийг чинь бүр мушгин гуйвуулаад, нөгөө хөөргөний тамхи, хамрын тамхи болгочихсон, хөөргөний зураг тавьчихсан. Хорих гэж байна гээд. Хамрын тамхийг хорих гэж байна гээд ингээд буруу суртал ухуулгыг энэ сошиал, олон нийтийн сүлжээнд хийгээд, энэ хуулийг барьсан алгын чинээ эмэгтэй рүү бүгдээрээ сүрэглэн дайрч байгаа юм. Энийг яг зориуд, санаатай хийгээд байгаа, энэ тамхиныхны лобби гэдэг нь л байх. Тэр эрх ашиг нь хөндөгдөөд байгаа учраас л ингэж байгаа юм. Энэ нөхдүүдэд ашиг л хэрэгтэй байгаад байгаа байхгүй юу. Тэрнээс Монголын иргэдийн, хүүхдийн эрүүл мэндийн асуудал ерөөсөө чөрт. Ямар ч падлий алга, хамаа алга.

Тэгэхээр энэ төр байгаа юм бол зохицуулалтаа хийж, хамгаалж өгөх ёстой. Энэ дээр 1 дүгээрт хариулт авъя.

2-т олон нийтийн газарт утаа тамхи татахыг хориглосон хуультай. Сүүлийн үед энэ электрон тамхи болон нөгөө уурын тамхи байх ийм сордог. Эд нар чинь бас хүүхдүүдэд буруу үлгэр дуурайлал үзүүлж байгаа шүү дээ. Энэ дээр энэ тамхины төөл гэж энийгээ нэрлэж л байгаа юм бол адилхан бас хориг тавьж, хориглолтод оруулаач гэж. Энэ талаар тодруулга авъя.

3 дугаарт нь электрон тамхины хайрцаг, сав баглаа боодол дээр анхааруулах зураг, бичиг тавих шаардлагатай байна гэж хуулийн төсөл дээр тусгасан ийм зохицуулалт байгаа юу. 3 дугаарт нь.

Яг шинжлэх ухаанаар нотлогдсон, нотлогдоогүй гээд, хортой, хоргүй гээд яг ийм маргааны гол сэдэв болж байгаа. Хуулийн төсөл өргөн барьж байгаа хүмүүс маань бол шинжлэх ухааны хувьд бол нөлөөлөл үзүүлнэ, хортой гэж. тэр тамхи

оруулж ирдэг юм уу, тэр нөхдүүд нь болохоор бараг л хоргүй, нөлөөгүй гээд ийм буруу ойлголт байна. Тэгэхээр энэ дээр саяын асуусан асуултад яг шинжлэх ухааны үндэслэлтэй тэр дүгнэлт байна уу. Энүүгээр нь албан ёсны хариулт өгөөч ээ гэж хүсэж байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Чинбүрэн гишүүн хариулъя.

Ж.Чинбүрэн: Алтаншагай гишүүний асуултад хариулъя. Мэдээж Тамхины хяналтын тухай хуулийн гол зорилго бол ерөөсөө л өсвөр үеийнхний, залуучуудын нокатин хамааралтай энэ бүтээгдэхүүнд донтох эрсдэлийг бууруулах ийм гол үндсэн агуулга агуулж байгаа. Энэ ч утгаараа ерөөсөө таны хэлж байгаатай яг ижил ерөөсөө амт, үнэр, гадна үзэмж энэ тэр бол хүүхэд насандаа дурлах, сонирхох энэ маркетингтайгаа шууд хамааралтай гэдгийг бол Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон бусад судалгаагаар нотлогдож байгаа.

Тийм учраас манай ажлын хэсэг дээр бол бас гол яригдсан зүйл бол хэдийгээр бид ажлын хэсэг дээр бас санал 100 хувь нийлээгүй ч гэсэн дэмжигдсэн асуудал бол энэ амт, үнэрийг хорих асуудал орсон. Ингээд ажлын хэсгээс бол ялангуяа тамхинд, ялангуяа электрон тамхин дотор агуулагдаж байгаа амт, үнэр болон шоколадны амттай, коланы амттай, дээрээс нь жимсний амт гээд байгаа энэ дурлах сонирхлыг төрүүлж байгаа зүйлүүдийг хорино гэсэн ийм саналтайгаар Байнгын хороогоор санал хураагдаж дэмжигдсэн. Үүнтэй ижил бас Шижир гишүүний саналаар энэ гааны амтыг бүх төрлийн тамхинаас хасъя гэдэг ийм нэмэлтээр санал хураалгаж, дэмжигдсэн байж байгаа.

Тэгэхээр бол гол нь энэ залуучуудаа, өсвөр үеийнхнээ энэ никотинд хамааралтай болгохгүй байх гол арга зам бол амт, үнэртэй тэмцэх асуудал юм байна гэсэн ийм байр сууринаас хандлаа.

2-т ер нь энэ тамхины хэрэглээг бууруулах нотлогдсон арга бол ерөөсөө л татварын бодлого. Тэгэхээр энэ татварын бодлогоороо бид онцгой албан татварыг нэмэгдүүлэх бодлогыг хууль санаачлагчийн өргөн барьсан саналын дагуу бас судлаач судалгаа хийж, бид бас ажлын хэсэг дээрээ дэд ажлын хэсгийг гишүүдээрээ ахлуулсан. Татварын ажлын хэсгийг бол Жаргалан гишүүн ахалж ажилласан. Ингээд энэ судалгаа, дүгнэлт Сангийн яам, Эдийн засгийн яам болон бусад судлаач нартай хамтарч ажиллаад ямар ч байсан нийгэм, эдийн засгийн нөлөөллийг нь тооцоод, бид тамхийг 5 жилийн хугацаанд нийт тамхины татварын хэмжээг 60 хувьд хүргэнэ гэсэн ийм том зорилт т тавьсан. Үүгээрээ татвараа бол нэмсэн. Онцгой албан татвар.

Дээрээс нь бас 1 чухал зүйл бол бүх тамхины төрлүүдийг никотин агуулсан тамхины төрлүүдийг дотор нь олон улсын гаалийн конвенцод нэгдсэнтэй холбоотой, түүнийх нь дагуу бас ангилж, бүх төрлийг хамруулж, онцгой албан татварыг нь тооцдог ийм юу руу орууллаа. Ангилал руу орууллаа. Ингээд утаа ялгаруулдаг тамхыг бол 100 хувь гэж үзэх юм бол түүнтэй дүйцэх тамхинуудыг яг халаадаг тамхи болон бусад тамхиуд 75 хувиар тооцохоор ингэж орсон.

Үүний ард бас 1 зүйлийг ойлгоорой. Энэ нөгөө Номинал дүн буюу тухайн бүтээгдэхүүний өөрийнх нь өртөгтэй хувилж байгаа учраас бусад төрлийн тамхины татвар буурчихлаа. .../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулах уу. Гүйцээж хариулъя. Чинбүрэн гишүүн.

Ж.Чинбүрэн: Ингэж оруулсан байгаа. Тэгэхээр энэ таблицаар танд бас өгчихсөн байгаа. Энэ нэмэгдсэн хэмжээг өгсөн байгаа. Мөн бид бас энэ татвар дээр холбоотой импортын татварыг бас хууль санаачлагчийн саналын дагуу импортын татвар буюу гаалийн татвар гэж ойлгох юм. Гаалийн татвар бүх тамхин бүтээгдэхүүн дээр 30 хувь байхаар орсон. Энэ дээр 1 ялгаатай гаргасан зүйл бол дагалдах хэрэгсэл гэж байгаа. Шууд никотин агуулаагүй, дагалдаж хэрэглэж байгаа зүйлийг бид онцгой албан татвар бол авахгүй. Харин хуучин зүгээр импортын татвар нь электрон бараатай ижил байдаг байсан бол гаалийн татварын нэмж, 30 хувь гэдгээр орж байгаа гэдгийг бас онцгой анхаараасай гэж хүсэж байна.

Дараа нь анхааруулга тэмдэгтэй холбоотой бас зүйл хэллээ. Тэгэхээр бид бас ажлын дэд хэсэг дээр стандарт, технологитой холбоотой зүйлийг Баярбаатар гишүүн ахалж ажилласан. Энэ дээрээ бид анхааруулах тэмдэг, тэмдэглэгээг бас Стандарт хэмжил зүйн газраас тодорхойлж хийж байя гэсэн ийм .../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Даваахүүгийн Пүрэвдагва гишүүн. Уучлаарай Пүрэвдаваа гишүүн.

Д.Пүрэвдэваа: Өдрийн мэнд хүргэе. Номинчимэг гишүүний санаачилсан энэ тамхины тухай хуулийг дэмжиж байгаа юм. Бүр дээрээс нь нэмээд хэлэх юм бол үнэр, амт эдгээрийг хязгаарлахаас гадна бүр хорьчихвол яадаг юм бэ гэдэг саналтай хүн байгаа юм. Эцэг, эхчүүд үр хүүхдүүдээ хэн нэг нь тамхи татаасай, вэйп татаасай, үнэр, амтгүй ч гэсэн татчихаасай гэж бодож байгаа 1 ч эцэг эх байхгүй байх гэж бодож байгаа.

Дээрээс нь энэ өгөгдсөн мэдээллээс харахад 13-17 насны 4 сурагч тутмын 1 нь өнөөдөр электрон тамхи татаж байна гээд. Энэ бол айхтар мэдээ.

Дээрээс нь 4300 орчим иргэн тамхины улмаас нас барж байна. Хавдраар миний санаж байгаагаар бас 4 мянга орчим байдаг гэдэг. Бид нар сая 1 хууль батлаад, үзэн ядаад байсан нөгөө сүүтэр чинь хэчнээн хүн бас мөргүүлж гэмтсэн юм. Лав л 4 мянга лав биш байх. Тэгэхээр энэ хорт зуршил бол ирээдүйг бол маш өндөр хувиар мөхөөж байгаа, хорлож байгаа ийм бүтээгдэхүүн байгаа юм. Тэгээд би хэдэн зүйл асууя.

Энэ и-тамхи хэрэглэдэг хүүхдүүд хорт зуршилд орох магадлал хэр өндөр байдаг юм бэ. Судалгаа байгаа юу.

Дараагийнх нь зүйл энэ борлуулалтын салбар дээр хамгийн ойрхны хөрш хойд Орос Улсад гэхэд ердөөсөө ил зардаггүй. Яг кассын ард байдаг нэг төмөр саванд, тэгээд бүх тамхиных нь ердийн тамхи гэхэд бүгд ижил өнгийн, хамгийн хүний харахад таагүй өнгийг санал болгож байгаа. Саарал, зэгэл саарал өнгөтэй бүх тамхинууд ижил өнгөтэй байдаг. Монголчууд маш их явдаг жишээгээр, миний харж байгаа нь Тайланд улс яг адилхан байсан. Тайланд улсын тэр тамхи борлуулж байгаа цэгүүд гээд харахад бол бас ил зардаггүй, бүх тамхинууд нь ижил өнгийн. Тэгэхээр зэрэг үнэхээр өөрөө хэрэглэгч тэр хүн өөрөө зорьж очоод, ийм нэртэй тамхийг авъя гэж л зааж өгөхгүй бол шинэ хэрэглэгч бол сонгох, дээрээс нь сурталчилгаанд автах тэр боломжийг бол хааж өгсөн байдаг юм байна лээ.

Тэгэхээр ажлын хэсгийнхэн та бүхэн маань энэ маркетингийг бүрэн хаах, шинэ хэрэглэгч аль болохоор нэмэгдүүлэхгүй байх тэр хөшүүргийг энэ хуульдаа хэрхэн тусгасан бэ гэж асуумаар байна.

Тэгээд дээрээс нь түрүүн Алтаншагай гишүүн ч хэллээ. Үгүй ээ, энэ яасан айхтар энэ хууль санаачилсан хүмүүс рүүгээ дайрдаг юм бэ. Нөгөө үг мушгина гэдэг шиг. Хамрын тамхи, наадам болох гэж байгаа өв соёл мөн үү. Мөн. Бүгдээрээ л сайхан мэнд усаа мэдэлцээд, хөөрөг зөрүүлдэг. Тэрийг хорих гэж байгаа юм шиг мэтээр илт гүтгэлгийн шинжтэй ийм үйл ажиллагаа явуулж байгааг бусад энэ хууль хүчний байгууллагынхан тэр дээр ямар хязгаарлалт хийж байгаа юм. Дараа нь нийгэмд эерэг өөрчлөлт авчрахуйц хууль санаачилсан хүн болгоноо ингэж харлуулж байх юм уу. Үүнийг хамгаалсан эрх зүйн хэм хэмжээ, зохицуулалт байдаггүй юм уу. Энэ 3 асуултыг асуучхаад, тэгээд тодруулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Мөнхтөрийн Нарантуяа-Нарагийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын “Голомт” цогцолбор сургуулийн Сэлэнгэ багштай 7³ дугаар ангийн сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Багш, сурагчид та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс сурлагын өндөр амжилт, ажлын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Та бүхнийг урьсан Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн асуултаа асууна. Чинбүрэн гишүүн. Уучлаарай Чинбүрэн гишүүн. Шууд явчих гэж байна.

Ж.Чинбүрэн: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Тэгэхлээр үнэр, амт бүр хорьчих гэдэг саналаар орж ирсэн байгаа шүү. Тэгэхээр ажлын хэсгээс тэр санал дэмжигдсэн. Байнгын хороо дээр бас дэмжигдээд, орж ирж байгаа. харин гишүүд та бүгдийн сонголтоор энэ асуудал дэмжих, дэмжигдэхгүй эсэх нь шийдэгдэнэ.

Ямар ч тамхи утаатай ч бай, утаагүй ч бай бүгд л никотин агуулж байгаа учраас бага нас буюу өсвөр насанд татах нь өөрөө донтолт үүсэх хамгийн том эрсдэл гэж үздэг. Энэ бол нотлогдсон зүйл. Энэ дээр ямар ч маргаан байхгүй. Тийм учраас энэ дээр бол судлаачид 1 зорилгоор, 1 саналаа хэлж байгаа зүйл бол аль болохоор л өсвөр насандаа тамхи татахгүй, тамхи хэрэглэхгүй байх нь никотины хамааралд донтохоос сэргийлэх хамгийн том арга. Тийм ч учраас энэ хяналтын хуулийн зорилго бол ерөөсөө л өсвөр үеийн хүүхдүүдийг тамхинд, никотинд хамааралтай болгохгүй байх ийм том зорилго агуулж байгаа. Тэр зорилгоороо бид бас энэ хуульд орж байгаа хяналтын 1 том арга зам бол худалдааны байгууллагуудад ил байршуулахгүй байх гэдэг таны хэлж байгаа саналтай яг ижил утгаар орсон байгаа шүү. Тэгэхээр бол худалдааны байгууллагад ил тавих асуудлыг хориглосноороо бид маркетингийн хувьд сонирхол татах, өнгө үзэмж, үнэр танар, гоё зураг дүрсээр хүүхдүүдийг уруу татах энэ байдлыг хорихоор зорьж байна. Тийм учраас энэ Хяналтын тухай хуулийн ерөөсөө гол зорилго бол өсвөр үеийнхнийг тамхинд оруулахгүй байх. Энэ утгаараа бол бүх төрлийн тамхийг 5 төрлөөр нь ялгаж өгч байгаа 1 санаа нь бүгд никотинд агуулж байгаа тамхи мөн шүү гэдгийг бас зориуд хэлж өгч, үүнийгээ бид зөвхөн гадна үзэмж, дүрс зураг, өнгө амтаас нь гадна санхүүгийн бас дарамттай болгож, татваруудыг нэмснээрээ хэрэглэх боломжийг хорих энэ арга бас өөрөө нотлогдсон сайн арга байдаг. Тийм учраас Монгол Улс энэ чиглэл рүү бас орохыг зорьж байгаа ийм Тамхины хяналтын тухай хуультай

болохоор зорьж байгаа. Энэ ч утгаараа бас ажлын хэсэг энэ чиглэлд ажиллалаа гэж хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Пүрэвдаваа гишүүн тодруулъя.

Д.Пүрэвдаваа: Та хэллээ. Энэ и-тамхи хэрэглэдэг хүүхдүүд бол хорт зуршилд илүү хамрагдах магадлал ер нь бүх тамхи хэрэглэдэг нөхдүүд илүү магадлал өндөр гэж хэлж байна шүү дээ. Миний харж байгаагаар бол и-тамхи буюу энэ халаадаг тамхи байна уу, тэр вэйп байна уу, тэр тосыг уур болгодог байна уу энэ бол химийн аргаар тэр никотин болон бусад тэр дадлыг хийж өгч байгаа байх. Уламжлалт тамхи нөгөө байгаль дээрээ байгаа бохь, тэр никотин нь байгаа байх. Тэгэхээр зэрэг Казахстан Улс бол ингэж харсан юм байна лээ л дээ. Энэ химийн аргаар хийж байгаа зүйл дээрээ төр хяналт тавьж чадахгүй. Тэгээд энэ нь хар тамхины чиглэлийн үйл ажиллагаа ийшээ орох маш өндөр эрсдэлтэй гэж үзээд, тэгээд энэ вэйп гэдгийг бол бүрэн хорьсон юм байна лээ. Тэгэхээр та надаа яг албан ёсоор хэлээдэх. Монгол Улсад энэ вэйпээр дамжуулж мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх хар тамхины төрлийн .../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Чинбүрэн гишүүн хариулъя.

Ж.Чинбүрэн: Та чухал сэдэв хөндөж байна. Ер нь бол цэнэглэдэг, ялангуяа бид вэйп-ийг ярьж байна. Цэнэглэдэг тохиолдолд задгай систем гэж нэрлээд байгаа юм. Задгай систем учраас дотор нь юу ч хольж болно. Тэр утгаараа канабис ч юм уу, энэ мансууруулах нөлөөтэй бодисыг холиод, бид нарын дунд татаад явахад бид ерөөсөө ялгаж харж мэдэхгүй. Тийм учраас Монгол Улсын энэ Хяналтын тухай хуулийн төсөл дотор бид бас дэмжиж оруулж өгсөн зүйл бол Монгол Улсад задгай системт буюу цэнэглэдэг тогтолцоог бүрмөсөн хориглож байгаа. Тэгэхээр аав хүний хувьд таны санаа зовж байгаа зүйлийг бид дэмжиж, Монголд энэ вэйп дотор элдвийн бодис холих боломжийг хориглож байгаа.

1 удаагийн хэрэглээ бол тогтолцоо систем нь өөрөө бие биеэ танихгүй байх , дээрээс нь дахиж задлаад хийх тохиолдолд ажиллахгүй байх ийм тогтолцоо үйлдвэрээсээ ийм хамгаалалтууд байдаг юм байна. Тэр утгаараа бол хар тамхины төрлийн зүйлийг нэмэх боломжгүй тийм зүйлийг Монголд зөвшөөрнө л гэж ойлгож болно.

Ж.Бат-Эрдэнэ: Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн.

М.Нарантуяа-Нара: Өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр энэ хууль бол үзэл баримтлалын хувьд бол зөв байгаа. Ялангуяа хүүхдийг аливаа донтолтоос сэргийлье гэдэг нь бол зөв. Түүнчлэн тамхи, тамхин бүтээгдэхүүн, хүний эрүүл мэндэд хор хөнөөл учруулж байгаа бүх төрлийн бүтээгдэхүүнд татвар ноогдуулах, онцгой албан татварыг нэмэгдүүлэх нь бол маш зөв.

Гэхдээ яг бид нар энэ хуулийг хэлэлцэхийн өмнө Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийг хэлэлцэж байна. Хүний эрүүл мэндийн төлөө гэж байна. Энд 1 зүйлийг бас анхаарах хэрэгтэй. Хүүхдийн төлөө, хүүхдийг донтолтоос сэргийлье гээд оруулж ирж байгаа энэ бол туйлын зөв. Гэхдээ хүүхдэд татахгүй байх тухай энэ зүйл, заалт 21 нас хүрсэн хүнд худалдаалах тухай энэ хуульд орж ирчхээд давхар вэйп болон бусад тамхин бүтээгдэхүүний үнэр, амтыг хориглож, татварыг нэлээн

дээгүүр тавьж өгч байгаа нь энэ өөрөө тамхи, тамхин бүтээгдэхүүний хэрэглэгчид нь тэр дундаа вэйп-ийн хэрэглэгчид нь бол зөвхөн хүүхдүүд биш байгаа гэдгийг ерөөсөө ойлгоогүй байна.

Нөгөө талд насанд хүрсэн хэрэглэгчдийн хэрэглээний сонголтод, хэрэглээний эрх чөлөөнд, түүгээр үл барам тэдний эрүүл мэнддээ сонгох сонголтыг бас боомилж өгсөн ийм нөхцөл байдал харагдаж байна. Тэгэхээр /FYI буюу For Your Information/-ийн 2019 оны судалгаагаар бол 4 хүүхэд тутмын 3 татаж байна гэсэн ийм судалгаа байгаа. Энэ 1209 оны судалгаа. Одоогоос хэдэн жилийн өмнөх вэ, 6, 7 жилийн өмнөх судалгаа болж байна. бол энэ нөхцөл байдал арай өөр болсон байгаа шүү дээ. Тэгээд энэ хүүхдэд зарахгүй гэж хуулиар нь тогтоож өгч байгаа юм байж, дахиж яагаад тэнд үнэр, амт болон татварын бодлогоор ингэж нэмэгдүүлж байгаа нь өөрөө хэрэглэгчийн эрх чөлөөг яаж харж байгаа юм бэ. Насанд хүрсэн хэрэглэгчдийн энэ daily habit гэдэг өдөр тутмын дадал зуршлыг бид нар яах вэ гэдэг энэ асуулт. Энийг нь бид нар юугаар орлуулж өгөх вэ.

Тэгээд нөгөө талд янжуур тамхи гээд арай нөгөө үндсэн янжуур тамхины хорыг арай багасгасан гааны амттай тамхиных нь гааг ингээд хориглоод өгчихлөө. Энэ дундаа ялангуяа эмэгтэйчүүдийн асуудал, эмэгтэйчүүд бас адилхан тамхи татдаг. Ялангуяа эмэгтэйчүүд эрүүл мэндээ бодоод нэгэнт ийм дадал зуршилтай болчихсон байгаа эмэгтэйчүүд эрүүл мэндээ бодоод ядаж л нөгөө вебийг нь ингээд татъя гэдэг ийм байдал руу шилжиж, эрүүл мэндээ бодож байгаа энэ асуудлыг бас таслан зогсоочхож байгаа явдал болчихож байгаа юм биш байгаа гэдэг ийм асуулт байна.

Тэгээд дээрээс нь бид нар хүүхдүүдийг хамгаалаад ингээд тавиад өгчихлөө. Тэгсэн чинь хүүхдүүдээ нөгөө талд бүр нөгөө муу хор хөнөөлийн зэрэг нь илүү өндөр янжуур тамхи болон бусад химийн хор найрлагатай газ үнэрлэх, мансууруулах бодис руу явуулахгүй гэсэн баталгаа юу байна вэ. Мөн түүнчлэн бид нар хар зах зээлийг яаж хянах вэ. Татвар төвлөрүүлээд бас хэдэн тэрбум олж байсан юм чинь энэ хуулиараа бүр нөгөө үнэр, амттай вэйп болон бусад тамхин бүтээгдэхүүн чинь хар зах зээлээр орж ирээд, хууль бус худалдаа нэмэгдэхийг бид нар юугаар, ямар механизмаар хянах гэж байна. Ийм асуултуудыг асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсгийн ахлагч Чинбүрэн гишүүн хариулъя.

Ж.Чинбүрэн: Бид олон улсын туршлагын араас явж байгаа л даа. Монгол Улс анхны ийм хууль гарах гэж байгаа улс биш. Тэгэхээр олон улсын судалгаануудыг хараад, туршлагуудыг хэрэгжүүлсэн цаг хугацаатай нь уялдуулаад харахаар тухайн улс яг ямар зорилгыг 1-т тавиад байгаа юм бэ гэдгээс хамаарч энэ бодлого явж байна. Түүрүн би хэллээ. Өсвөр үеийнхнийг тамхины, никотины хамаарлаас холдуулъя гэж байгаа бол бид амт, үнэр хорих нь хамгийн үр дүнтэй юм байна гэж үзэж байна. Тэгвэл тамхи татдаг насанд хүрэгчдийн хэрэглээг зөв зохистой болгох, илүү хор хөнөөл ихтэй бодисоос бага тамхи руу оруулъя гэх юм бол энэ амт, үнэрээ хорихгүй байх гэсэн ийм л бодлого юм байна. Энийг ингээд бүгдийг нь хорихоор яах вэ, бид ажлын хэсэг дээр зөндөө олон талаас нь ярьж үзсэн зүйл бол далд бизнес өсөхөд хэр нөлөөлөх вэ гэдэг асуудал гарсан. Үүнтэй холбоотойгоор жишээлбэл Австрали, Сингапур улсууд амт, үнэр хорьчихсон ийм улсууд байж байна. Үүнтэй холбоотойгоор далд бизнес хувь хүнд өөртөө хэрэгтэй, амт үнэртэй ийм тамхиа зөөдөг, барьдаг гэсэн асуудлууд бас нэлээдгүй дурдагдаж, яригдаж байна. Ер нь

зүгээр тэгээд л гаалийн байгууллагын зохицуулалтууд, түүнээс хяналтын системийн тогтолцоо энэ тэрээсээ их хамаарна.

Бас нөгөө талаасаа шүүмжилж байгаа зүйл бол энэ амт, үнэр хориглосноороо бид утаат тамхиа илүү их дэмжиж байгаа юм биш үү гэсэн ийм бас шүүмжлэлүүд бас нэлээдгүй ирж байна. Тэгээд энийг Их Хурлын гишүүд та бүгдийн өөрсдийн шийдвэрлэх, ямар зорилгоор, яаж ажиллах вэ гэдгээ л гаргах гэж байгаа л ийм шийдвэр болох байх л гэж харж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг нэмж хариулъя. Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Үндсэндээ ажлын хэсэг бол 2 сонголтыг яг дэнсэн дээр тавьж байгаад шийдвэр гаргах хэрэгцээтэй болсон. 1 сонголт нь юу вэ гэвэл өсвөр үе, хүүхдүүдийг хамгаалах уу, эсвэл тамхинаас гарах оролдлого хийж байгаа насанд хүрэгчдээ бодох уу гэдэг энэ 2-ыг дэнсэлж үзэж байгаад энэ шийдвэрийг гаргасан. Бидний хувьд юуны түрүүнд хүүхдийн дээд эрх ашиг буюу хүүхдүүдийг никотинд автдаг ийм дадал, зан үйлийг бид нар дэмжих ийм бодлогыг бид нар яавч баримталж болохгүй гэдэг үүднээсээ бол бид нар ажлын хэсгээрээ ярилцаад, мөн Байнгын хороон дээр ч гэсэн энэ талаар ярилцаад, ямар ч байсан үнэр, амтны асуудлыг бол хориглох шийдвэр нь бол зөв юм гээд энэ 2 сонголтын хамгийн гол сонголт бол бид нарын гол шийдвэр гаргах гол зарчим бол хүүхэд, өсвөр үеийг урт удаан хугацаанд .../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Нарантуяа-Нара гишүүн тодруулъя.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр ажлын хэсэгт миний бие ч гэсэн багтаж ажилласан. Ажлын хэсгийн хурлын мэтгэлцээн олон талын хоорондын маргалдаан, мэтгэлцээн, дээрээс нь ажлын хэсгийн судалгааны үндэслэл хангалтгүй байгаа, олон талыг хангаж харьцуулсан судалгаа хангалтгүй байгаа талаас бол бид нар зөндөө мэтгэлцсэн. Тэр үед энэ асуудлуудыг мөн л тавьж байсан. Тэр үед ч гэсэн ажлын хэсэг, ажлын хэсгийн багууд энэ асуултад хариулт тавьж чадаагүй учраас, тодорхой хариулт тавьж чадаагүй учраас чуулганы индэр дээрээс энийг дахин асууж байгаа юм.

Тэгэхээр бид нар нэгэнт л хүүхдүүдийг хамгаалъя гэж байна. Тэгвэл нөгөө талд энэ хууль батлагдсанаар хүүхдүүд үнэр, амтгүй нөгөө бүтээгдэхүүнийг худалдаж авахгүй гэсэн баталгаа нь хаанаа байна. Үнэр, амтгүй нөгөө вэйп болон бусад тамхин бүтээгдэхүүнийг, янжуур тамхийг худалдаж авахгүй гэсэн баталгааг .../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Хариулъя. Чинбүрэн гишүүн.

Ж.Чинбүрэн: Олон улсын судалгаанууд бол ерөнхийдөө илүү их жин дарж байгаа. Сая бас Баасанжаргал гишүүн хэллээ. Ер нь бол бид 2 жин дээр дэнслээд, алийг нь илүүтэй тавих вэ гэдэг л ийм бодлогын шийдвэр Байнгын хороо болон ажлын хэсгээрээ гаргалаа. Энэ дээр бол ингээд жинлээд тавиад үзэхээр мэдээж олон улсын судалгаанууд, энэ дүгнэлт бол ерөөсөө л амт, үнэр, ялангуяа энэ хэсэгчилсэн амт, үнэр хорих явдал бол тэр дотроо түрүүн хэлж байгаа жимсний төрлийн амтууд, кока кола ч гэдэг юм уу, шоколадны амт энэ тэр нь бол бага насны, өсвөр үеийн хүүхдүүдийг тамхи татах дур сонирхлыг хязгаарлах чухал арга хэмжээ

юм байна гэдгийг олон судалгаа бол батлаад байгаа юм. Энэ дээр бол нотолгоогүй гэж арай хэлж чадахгүй.

Зүгээр харин бид тамхинаас гарах гэж байгаа, буцаагаад нөгөө янжуур тамхи руу оруулж байгаа..../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Нарантуяа-Нара гишүүн тодруулъя.

М.Нарантуяа-Нара: Яах вэ, Тамхины хууль судлалаар Гүрж улсад айлчлал хийсэн зарим гишүүд бол вэйп-ийг бүрэн хорих ийм санал бодолтой байх шиг байна. Гэхдээ нөгөө талд жишээлбэл АНУ, Дани улс, Нидерланд улс, Финлянд улсуудад энэ вэйп тамхийг хориглосноор ямар ямар үр дүн, эрсдэл гарсан бэ гэдэг судалгаагаар жишээлбэл Финлянд улсад гэхэд вэйп-ийг бүрэн хориглосноор вэйп хэрэглэгчдийн тоо 96 хувиар буурсан эерэг үзүүлэлт харагдаж байгаа мөртөө нөгөө талд янжуур болон бусад тамхины бүтээгдэхүүнд орсон 93 хувийн өсөлтийн үзүүлэлт байгаа гэдгийг бас энд дурдмаар байна. Өөрөөр хэлбэл бид нар хүүхдийг үнэр, амтнаас хамгаалахдаа бусад төрлийн хортой бүтээгдэхүүн рүү орохгүй байх тэр бүх хамгаалалтын урьдчилан сэргийлэх механизмыг бүрэлдүүлж өгөөгүйгээр шууд хориглож .../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр энэ хуулийг бол зарчмын хувьд дэмжиж байгаа. Санаачилсан гишүүдийн нэгийн хувьд ч гэсэн. Тэгэхээр ер нь бол анх энэ вэйп гэдэг тамхи орж ирээд, ямар ч хяналтгүй зарагдаж байсан үе бий шүү дээ. Хэдэн ч насны хүн нь хамаагүй авчихдаг. Хараад үзэхэд их гоё жимсний зурагтай, нэг ийм хүнийг урхиддаг, тэгээд хүүхэд бол тэрийг аваад, татаад үзэх ийм сонирхлыг төрүүлэхүйц ийм байсан. энийг хуулийн хүрээнд бас журамлаж байгаа нь бол зүйтэй гэж харж байгаа. Мөн нийслэлд миний бие бас төлөөлөгч байхдаа энэ асуудлыг анх хөндөж тавьж, Төмөртөмөө гишүүн бид нар бас ярилцаж, энийг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дээр бас ярьж байсан. Түүний зэрэгцээ энэ хуулийг санаачилсан Номинчимэг гишүүн нийслэлийн орлогч дарга байхдаа худалдааны журамд байх өөрчлөлт оруулаад, 21 нас хүртэл бол борлуулалтгүй болгож эхэлсэн. Багануур дүүрэг хамгийн түрүүн энийг хэрэгжүүлж байсан. Ингээд алхам алхмаар энэ урагшилж байсан юм. Тэгэхээр онцгой албан татвар авах нь зүйтэй. Энэ вэйп-ийг бас хориглож, хүүхэд татахгүй ийм боломжийг бий болгохгүй бол, ийм байлгахгүй бол тамхи руу татаж оруулаад байгаа нь бол бодитой. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын бас судалгаанууд, юмнууд гараад байгаа.

Гэхдээ нөгөө талдаа бас бид энэ дээр ярих зүйл бас байна. Тамхины хяналтын тухай хууль гараад ер нь бол 2010 онд тамхи таталтын түвшин 31 хувь байж байгаад, 2025 онд 21,1 хувь болж буурсан гэсэн ийм үзүүлэлт байгаа. Энэ үр дүнгээ үзүүлж байна гэсэн үг. Гэтэл энэ хуулийн 6.7.14 дээр 1 сургууль байлаа гэхэд, дотуур байр байлаа гэхэд 500 метр дотор нь бол аливаа тамхийг бол зарахыг хориглосон байгаа. Тэгээд сумын төвөөр яваад, хүмүүстэй уулзаад явахаар энэ нь бол хэрэгжих ямар ч боломжгүй. Яагаад гэвэл нөгөө сумын төв дээрээ сургууль нь ч байна, дэлгүүр нь ч байна.

Тэгээд ингээд АТГ-аас жишээлбэл шууд гортиг татаад, энэ Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргыг бас нэлээн хэрэгт татаж байсан ийм юм байдаг юм

байна лээ. Энэ бодитой баримт. Тэгээд Баруун-Урт сум нь яаж тогтоож байсан бэ гэхээрээ 500 метр явган хүний маршрутаар тогтоож байсан. Радиусаар биш. Радиусаар тогтоох ёстой гээд ингээд ийм байдлаар жижиг, дунд ийм үйлдвэр эрхлэгч нар, 6-8 нэрийн бараа борлуулдаг хүмүүс өнөөдөр энэ тамхийг ерөөсөө нууц байдлаар, нүдэнд ил харагдахгүй байдлаар, албан бус байдлаар зарах руу түлхээд байна гэсэн ийм яриа яваад байгаа юм. Тэгээд энэ тал дээрээ ч гэсэн тэдний байр суурь юмнууд бол бичгээр ирж байна. Бодитой юмнуудаа ярьж байна. Тэгэхээрээ бас Улсын Их Хурал энэ хуулийг гаргах нь бол Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал. Миний бие дахин хэлье. Энэ вэйп-ийг нь хориглох тал дээр бол дэмжиж байгаа. Чадвал бүр хорьчихвол бүр сайн л биз. Гэхдээ нөгөө талдаа бид энэ амьдрал дээр хэрэгжихгүй байгаа нууц, албан бус ийм худалдаа наймаа руу түлхчхээд байгаа энэ асуудлыг бас давхар харж үзэх ёстой.

Ийм учраас энэ хуулийг дагаж гарч байгаа Улсын Их Хурлын тогтоолын төсөл дотор нь энэ асуудлыг хөндөж оруулж болдоггүй юм уу. Засгийн газар луу чиглэл өгөөд, тэгээд энэ дээрээ хуулиа энэ тал дээрээ бас зарим тал дээр амьдралд ойртуулж, илүү хяналттай болгох, 21 нас хүртэл бол огт зарахгүй байх. Энэ бол маш чухал. Түрүүнд бас Чинбүрэн гишүүн хэлээд байна шүү дээ. Өсвөр насандаа ингээд тогтоочихсон энэ донтолт бол и цаашаа явчихдаг юм. 21 нас хүртэл нь ямар ч байсан хорино гэдэг бол өөрөө шинжлэх ухааны үндэстэй. Тэгэхээр энэ тал дээр ажлын хэсэг ямар бодолтой байна. Иймэрхүү тогтоолын төслийг бас энэ дотор нь ийм санааг оруулах боломж байна уу гэж асуух гэсэн юм.

Ж.Бат-Эрдэнэ: Чинбүрэн гишүүн.

Ж.Чинбүрэн: Тэгэхээр би зориуд бас манай ард иргэд бас энэ Их Хурлын чуулганыг нээлттэй сонсож, харж, ажиглаж, ямар гишүүд юу ярьж байгаагаас их хардаг болсон юм байна. Тийм учраас би бас энэ хууль, эрх зүйн хууль тогтоох байгууллагын үйл ажиллагааны бас нэг журмаас зориуд бас хэлье гэж бодож байгаа юм. Тухайлбал, хууль санаачлагч хөндөгдөөгүй сэдвийг ажлын хэсэг бол хөндөх боломж байхгүй. Тийм ээ. Тийм учраас хууль санаачлагчаас ирсэн төсөл дотор бол 500 метр доторх тамхи татахыг хөндсөн эсвэл болиулья гэдэг юм уу эсвэл тэрийг бүр ойртуулья ч гэсэн юм уу тийм хөндсөн сэдэв байгаагүй учраас бид энийг ярих боломж байхгүй байгаад байгаа.

Мөн хууль хэлэлцэх эсэх асуудлыг ярилцаж байх үед бол Идэрбат гишүүн бас хэд хэдэн удаа хэлсэн ийм протоколуудыг би бас уншлаа. Би бас энэ ажлын хэсгийг 05 сарын 8-наас эхлэн ахалж эхэлсэн. Тэгээд сар илүүтэй хугацаа л өнгөрсөн байна. Тэгэхэд бол гишүүдэд бас нэг хэлж байсан зүйл бол гишүүдийн бүрэн эрхийн хүрээнд энэ асуудлыг дахин хөндөж, хуульд дахин нэмэлт, өөрчлөлт юм уу өргөн барих бүрэн эрх нь нээлттэй байгаа гэж хэлж байсан байна лээ. Тэр утгаараа бас Наранбаяр гишүүний хэлж байгаагаар бид хэрвээ энэ хуулийн төслийг Их Хурал дэмжээд баталсан тохиолдолд хууль баталсантай холбоотой гарах Их Хурлын тогтоол дотор бид бас энэ асуудлыг Засгийн газарт чиглэл, үүрэг болгоод өгчих бас боломж бас байгаа. Тэгэхээр бас энийг бас зориуд анхааруулж хэлье гэж бодож байна.

Ж.Бат-Эрдэнэ: Наранбаяр гишүүн тодруулья.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр ажлын хэсгийн бас иймэрхүү амьдралаа харж, уян хатан асуудалд хандаж байгаад талархаж байна. Нөгөө талдаа энэ бол бид энэ 21 нас гэдэг энэ заалтыг бол маш сайн барих ёстой шүү. Ингээд өнөөдөр байж байгаа энэ супермаркетууд болон тамхины нууц ийм худалдааг бол бид байлгаж болохгүй гэдэг үүднээс харж байгаа. Тэгээд энэ тогтоолын төсөлд оруулахыг бол ойлгож байна. Улсын Их Хурлын дэгийн тухай хуулиараа хөндөгдөөгүй асуудлыг бол ажлын хэсэг ч энийг чинь хөндөж гаргаж ирж чадахгүй, болохгүй. Тэгэхээр аливаа зүйл бол 2 талтай. 1 талдаа арилжаа наймаа эрхэлж байгаа хүмүүс байна. Нөгөө талдаа хэрэглэгч байна. Тэгээд бид бол өнөөдөр энэ хуулийн төслийг зарчмын хувьд дэмжээд байгаа нь өсвөр үеээ хамгаалах л явдал. Энэ өсвөр үеийнхээ эрүүл мэндийн хамгаалах явдал байгаа юм. Өнөөдөр улс орнууд улам л шинэ шинэ сорилттой тулгарч байна шүү дээ. Урьд өмнө тамхыг бол ийм байдлаар электроноор дамжиж, электрон багажаар дамжиж ийм никотин гэдэг бодисыг авна гэж ерөөсөө.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Нэмэлт 1 минут.

П.Наранбаяр: Хэн ч төсөөлж байгаагүй. Энэ тал дээр бол улс орнууд бэлэн бус байсныг бол хэлэх хэрэгтэй. Харин манай улс бас энэ дээр арга хэмжээ авч байгаа нь бол зүйтэй. Гэхдээ бид бас нэлээн хожуу хөдөлж байна. 2 хөршөө харья. улс орнууд 2020-оод оны эхэн үеэс л янз бүрийн арга хэмжээ аваад эхэлчихсэн. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын бас энэ сануулга, гаргаж байгаа бүх судалгаануудыг хэдүүлээ сайн харцгаая. Энэ дээр бас арга хэмжээ авахыг сануулаад байгаа. Эцэст нь хэлэхэд энэ хуулийн төслийг санаачилсан хүмүүс руу бас ингэж зүй бусаар дайрах, зүй бусаар энэ хүмүүсийг гүтгэх энэ тэрийн бол энэ Улсын Их Хурлын танхимд оруулж ирж болохгүй. Энэ зүйлийг бол хатуу бид бодох ёстой. Аливаа хуулийг санаачилсан хүн болгоныг ингээд зүрхийг нь сугалж байгаа юм шиг ийм юм хийгээд байж болохгүй гэдгийг хэлмээр байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Тогтмолын Мөнхсайхан гишүүн алга байна. Өлзийхүүгийн Шижир гишүүн.

Ө.Шижир: Өдрийн мэнд. Тамхины хуулийн хэлэлцүүлэг хийгдсэн Нийгмийн бодлогын байнгын хороо дээр бол маш сайн хэлэлцүүлэг явж байна лээ шүү дээ. Тэгээд би Улсын Их Хурлын гишүүн болоод 2 жилийн хугацаанд ийм айхтар хэлэлцүүлэгтэй хуулийн төслийг анх удаа харлаа. Цаашид ер нь бүх хуулийн төслүүд дээр ингэж ажиллавал их зүгээр байна. 2 тал болж хуваагдаад, бие биенийгээ яасан их үгүйсгэж, яасан их элдвээр хэлж сошиал орчинд их явдаг юм. Энийгээ 1 дүгээрт больмоор байгаа юм. Улсын Их Хурлын гишүүд тухайн асуудал дээр өөрийн байр сууриа илэрхийлсний төлөө олон нийтийн хэвлэл, мэдээллийн байгууллагаар элдвээр хэлүүлээд, доромжлуулаад байж болохгүй. Ингээд байдаг бол энэ Улсын Их Хурал дээр ямар ч хууль явахгүй цаашдаа. Тийм учраас бид нар энэ дээр юмнуудаа маш тодорхой харах хэрэгтэй. Ер нь бол тэгээд тамхи л бол тамхи шүү дээ. Электрон гэхээрээ тамхи биш болчихгүй шүү дээ. Халаад тамхи гэхээрээ бас тамхи биш болчихгүй. Бид нар өнөөдөр импортоор орж ирж байгаа согтууруулах төрлийн ундаа бүгдээрээ онцгой албан татвараа төлөөд л явж байгаа шүү дээ. Түүнтэй л адилхан байх ёстой. Ижил тэгш хандах ёстой юм. 1 нь татвар төлдөг, нөгөө нь татвар төлдөггүй байж болохгүй. Тэгээд бараг энэ чинь Байнгын хороо нь ч 2 хуваагдаад, ажлын хэсэг нь ч 2 хуваагдаад энэ Их Хурал нь яаж 2 хуваагдах юм. Санал өгөхөд нь харья. Анх өргөн барьсан 78 гишүүн нь энэ хуулийн

төсөлдөө үнэнч байхыг хүсье. Тэгээд нэмэх нь энэ хууль дээр ач холбогдол өгөхийг хүсье.

Ер нь бол энэ хууль чинь сүүлдээ татварын тухай хууль юм шиг болгож мушгин гуйвуулж байна шүү дээ. Үгүй шүү дээ. Энэ чинь хүүхэд, залуучуудыг ирээдүйд үүсэх хорт зуршлаас нь, ирээдүйд үүсэх өвчин эмгэгээс нь, муу дадал зуршлаас нь, муу хорт зүйлээс нь холдуулах тухай хууль байхгүй юу. Сая Боловсролын сайд байсан хүн юу гэсэн бэ. Вэйп-ийг зарж болно гэсэн утгатай юм хэлчихсэн үү. 500 метр дотор тамхи зарахыг болиулъя гэж байгаа лоббиг хаанаас явж байгааг бүгд мэдэж байгаа шүү дээ. Энэ хэдхэн компанийн л эрх ашиг. Гаатай тамхийг үлдээх гэж байгааг хэн, ямар компани лобби хийж байгааг бүгд мэдэж байгаа шүү дээ. Тэгээд бүр ийм улаан цагаандаа ортлоо ингэж лоббид автаж байгаа хуулийн төслийн хэлэлцүүлгийн би бүр энэ 2 жилийн хугацаанд нээрээ анх удаа харлаа. Үзэл баримтлалаасаа өөрчлөгдөж байгаа хүмүүсийг хараад үнэндээ ичиж байна. Яагаад бид нар асуудалд ингэж хандаад байгаа юм. Цахилгаан, дулааны үнэ нэмээд, татварын үнэ нэмж байхад аа гэж хашгираагүй хүмүүс тамхины хуулийн татварыг нэмэхийг эсэргүүцэж, вэйп-ийн татвар нэмэхийг эсэргүүцэж байна гэнэ үү. Жилийн 800 орчин тэрбумын зах зээл чинь 10 хувийг нь л тараахад энэ чинь 80 тэрбум шүү дээ. Хэдээр худалдаж авсан юм парламентын зарим гишүүдийг. Энийг бүр хэлмээр байгаа юм.

Би цаашдаа бүр ил хэлнэ. Хаанах хаанах, хаанаас лобби хийж байгааг хүртэл мэдэж байна. Тамхины хууль дээр бүр сүүлийн энэ хэлэлцүүлгүүдийг харсан бүр нэлээн юу төрчлөө. Энэ чинь ирээдүйд үүсэх хор уршгийг урьдчилан сэргийлж байгаа хууль байхгүй юу даа. Тэрнээс татварын тухай хууль биш юм. Тамхи татдаг аав, ээжийн тухай хууль биш юм. 1 буруу зуршил аваад сурчихсан хүүхэд цаашдаа буруу зуршилтайгаа л явна. Хүнийг ер нь зүрх сэтгэл нь биш, дадал зуршил нь удирддаг гэж үг байдаг шүү дээ. Буруу дадал зуршилтай болчихсон хүүхэд тэрүүгээрээ л явна. Нэгэнт амандаа юм зуугаад, тэр нь дадал болчихсон хүүхэд бол цаашдаа байгаа юмыг бүгдийг нь зууна. Тийм учраас тамхи л бол тамхи. 1 хуушуур өнөөдөр Төрийн ордны гуанзанд 3500 төгрөг байгаа. 1 хуушуурнаас хямдхан тамхитай улс гэж байж болдог юм уу. 1 хуушуурнаас хямдхан тамхи, 20 ш янжуур зарж байна шүү дээ бид нар. Тэгээд энэ дээр манай гишүүд бас илүү алсын хараатай, бодолтой хандана байх гэж итгэж байна. Энэ хуулийн төсөл цаашаа дэмжигдээд яваасай гэж хүсэж байна. Ирээдүйд гарах хор уршгийг өнөөдрөөс хамгаалахыг хүсэж байна. Нөгөө хүүхдийн төлө За гэж хэлдэг хүмүүс хэлээрэй гэж хүсэж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Аюушийн Ариунзаяа.

А.Ариунзаяа: 2024 онд Улсын Их Хурлын сонгуулийн дараа шинээр бүрдсэн парламент 126 гишүүнтэй бүрдсэн. 5 намын төлөөлөл. Ингээд ер нь бол зарчмынхаа дагуу өмнөх парламентын үед хэлэлцэгдэж эхэлсэн, батлагдаагүй, өргөн баригдсан хуулийн төслүүд бүгдээрээ буцдаг. Шинээр хуулийн төслүүдийг боловсруулж явдаг. Ийм ч учраас дөнгөж үйл ажиллагаа эхэлж байгаа энэ үе дээр нь тухайн үед Улсын Их Хурлын дарга Амарбаясгалан 54 хуулийн ажлын хэсгийг байгуулсан байдаг юм. 2024 оны 10 сард. Тэгээд 1 ажлын хэсэг нь бол Номинчимэг гишүүнээр ахлуулаад, өнөөдөр Монгол Улсад тулгамдаад байгаа тамхины асуудлыг цэгцлэх ийм хуулийн ажлын хэсэг 2024 оны 10 сард байгуулагдсан байдаг шүү. Бүтэн жилийн хугацаанд ажилласан. 2025 оны 09 сард өргөн барьсан. 2025 оны 09 сард өргөн барихдаа 76 гишүүний хамтаар өргөн барьсан байдаг. Тэгэхээр энэ

зөвхөн Номинчимэгийн хийгээд байгаа асуудал огтоос биш. Энэ бол хуучин парламент бүхлээрээ буюу 76 гишүүн хамтдаа өргөн барьсан байдаг юм. Тэгээд энэ өнгөрсөн хугацаанд ажлын хэсэгт орж ажиллах гэж ганц 2 хүн гарын үсгээсээ буцсан байх магадлалтай. Тэрнээс өөрөөр дахиад гарын үсгээ татсан хүмүүс байна уу, үгүй юу гэдгийг хэлж мэдэхгүй байна. Гэхдээ ер нь бол тухайн үедээ маш олуулаа энэ асуудал чухал юм гэж энэ хуулийг өргөн барьсан.

Энэ зөвхөн өсвөр насныхан, залуучуудыг хамгаалах гээд байгаа асуудал бас биш шүү дээ. Энэ ер нь нийгмийн эрүүл мэндэд анхаарсан асуудал. Нас баралтын 30 хувь нь буюу жилд Монгол Улсад тамхинаас шалтгаалсан нас баралт ойролцоогоор 4300 байна гэж Эрүүл мэндийн яам ярьж байгаа шүү дээ. Энийгээ тодруулж Чинбүрэн гишүүн бас хэлж өгөөрэй. Нийт тамхинаас гаралтай тамхины үүсэлтэй, эрүүл мэндийн шалтгаант нас баралт хэд байна вэ. Энэ зөвхөн хүүхдийн асуудал биш.

Эрүүл мэндээ бодоод цахилгаан тамхи татаж байгаа гээд байх юм. Уучлаарай. Та эрүүл мэндээ үнэхээрийн бодож байгаа бол тамхинаас гарах л байхгүй юу даа. Тодорхой асуудлууд шийдэгдэж байгаа. Би бас Жаргалан гишүүнийг яг энэ татварын асуудлыг хариуцаж ахалж ажилласан учраас яг шүүмжлээд байгаа адилхан татвар биш харин шаталсан буюу тухайн бүтээгдэхүүний үнээс нь хамааруулсан ийм ямар татварын зохицуулалт оруулж ирж байгаа вэ гэдгийг хариулж өгнө үү.

Дээрээс нь нөгөө яг цахилгаан тамхи, вэйп зэрэг олон удаа хэрэглэгддэг энэ шинэ тамхи, тамхин бүтээгдэхүүнээс, эд ангиас нь татвар авахгүй гэдэг ийм зохицуулалтыг оруулж ирж байгаа гэдгийгээ бас тодорхой хэлж өгөхийг хүсэж байна.

Номинчимэг гишүүнтэй би чинь 76 гишүүний 1 байхгүй юу. Хамт өргөн барьсан. Бид нар энэ хамрын мамхийг хориглосон асуудал огт оруулаагүй шүү дээ. Тэгээд энийг өчигдөр л энэ гаалийн татвартай холбоотой, Евроазийн хэлэлцээртэй холбоотой онцгой татварыг бүр онцгойлж хамрын тамхи гэж оруулж ирснийг наашаагаа нааж орж ирээд шүүмжлээд байгаа байхгүй юу. Тийм юм огт байхгүй гэдгийг хэлмээр байна. Тэгээд энийг Номинчимэг гишүүн болохгүй бол дахиад энийг хэлж өгөхийг хүсэж байна. Надад бол 1 л анхаарах ёстой асуудал байна гэж санагдаж байгаа. Шижир гишүүний саяын хэлсэн, ярьсантай холбоотой 1 асуудал байгаа. Гэхдээ түүнийг асуултууддаа хариулт авсныхаа дараа нэмж асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Асуултад хариулъя. Ажлын хэсгийн ахлагч Чинбүрэн гишүүн.

Ж.Чинбүрэн: Тамхины энэ хяналтын хуультай холбоотой ажлын хэсгийг ахалж ажиллахад бас зориуд энэ эрүүл мэндийн асуудалтай холбоотой учраас би өөрөө ахалж энд ажиллаж байна. Тэр ч утгаараа ер нь бол Монголд жилдээ 18 орчим мянган хүн нас бардаг. Үүний эрсдэлт хүчин зүйл гэж хэлье. Эрсдэлт хүчин зүйлийн нөлөөлөлд бол тамхи орж байгаа. Тамхи гэдэг дотор ганцхан никотин биш. Никотин бол донтуулж байгаа. Түүний дагалдаж орж байгаа олон арматлаг бодисууд нь хорт хавдар болон бусад өвчний шалтгаан болж байгаа. Тэр ч утгаараа ерөөсөө өвчний гол шалтгаан, эрсдэлт хүчин зүйл гэж бид нэрлэдэг тухайлах юм бол хорт хавдрын шалтгаанд хүний буруу зуршлаас хамааралтай хорт хавдар үүсэх эрсдэл 30 хувь гэж үздэг. 1 ёсондоо илүүдэл жингүй, архи уудаггүй, тамхи татдаггүй

байх юм бол та хорт хавдраар өвдөх эрсдэл 30 хувиар буурна л гэж ойлгох ёстой. Тийм учраас тамхи бол сайн гэж хэлэх хүн энэ дотор байхгүй.

Ж.Бат-Эрдэнэ: Жаргалан гишүүн хариулъя.

Б.Жаргалан: Тамхины хяналтын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн ажлын хэсэгт орж ажилласан. Тэгээд татварын бодлоготой холбоотой дэд ажлын хэсэг байгуулагдаад, хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн энэ татварын бодлоготой холбоотой асуудал дээр тодорхой санал, дүгнэлтүүдийг хийсэн. Өнгөрсөн хугацаанд бас нийгэмд бий болсон, үүссэн хэлэлцүүлгийн хүрээнд гарсан саналууд тодорхой албан байгууллага, холбоодуудын саналуудыг тусгасан гэж харж байгаа. Тэгээд Ариунзаяа гишүүний асуусан тодорхой асуултад халаадаг тамхи болон электрон тамхины шингэнд янжуур тамхинаас 25 хувийн хөнгөлөлттэй татвар ноогдуулахаар болсон. Өөрөөр хэлбэл ийм ялгамжтай татварын бодлого бас ажлын хэсгээс оруулж ирж тавьж байгаа. Тэгээд нөгөө талаасаа бол хууль санаачлагчийн оруулж ирсэн янжуур тамхин дээр тавигдаж байгаа бодлого дээр ч гэсэндээ тодорхой дүгнэлтүүд хийгээд тэгээд .../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Зочид танилцуулъя. Өмнөговь аймгийн Баяндалай сумын ерөнхий боловсролын 8 жилийн сургуулийн 1981 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төгсөгчид та бүхэндээ амьдралын хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Жаргалан гишүүн гүйцээж хариулъя.

Б.Жаргалан: Тэгэхээр энэ тамхидалтыг бууруулах асуудал дээр эдийн засгийн хөшүүрэг буюу татварын бодлого бол маш үр нөлөөтэй байдаг гэдэг маш олон судалгаанууд байгаа. Тэгэхээр манай улсын хувьд бол янжуур тамхин дээр бас харьцангуй маш бага татвартай байсан учраас ер нь бүс нутагтаа ч тэр, дэлхийн олон улсад ч тэр 1 хайрцаг янжуур тамхи Монгол Улсад бол маш бага үнээр худалдаалагдаж байгаа. Тэгэхээр энэ янжуур тамхины үнийг ч гэсэндээ татварын бодлогоороо бас өсгөж, тэр агуулгаараа бас эдийн засгийн хөшүүрэг бий болгож, энэ хорт зуршлаас ангижруулах энэ тал дээр бас тодорхой үр нөлөө гарна гэдэг судалгаанууд дээр бас үндэслэж бас бодлогоо боловсруулсан гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ хууль батлагдсанаар тамхидалт 15 орчим хувиар яг эдийн засгийн хөшүүргийн улмаас бол буурах боломжтой гэсэн үндэслэлтэй судалгаанууд бас байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Номинчимэг гишүүн хариулъя.

О.Номинчимэг: Бидний 2025 оны 09 сард өргөн барьсан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хамрын тамхитай холбоотой асуудлыг хөндсөн 1 ч заалт байхгүй. Одоогоороо энэ бүтээгдэхүүн онцгой албан татвар тавьдаггүй ийм бүтээгдэхүүн байгаа. Тэгээд яах вэ, энэ өчигдөр хэлэлцсэн Евроазтай холбоотой Засгийн газраас оруулж ирсэн энэ хуультай холбоотойгоор зориудаар мушгин гуйвуулсан, зохион байгуулалттай сошиал орчин дахь худал мэдээлэл маш их тарсан байна. Хурдан тарсан байна. Гэхдээ хариуцлагатайгаар бидний энэ хүүхэд, өсвөр үеэ хамгаалъя, тамхидалтаа бууруулъя гэдэг энэ хуулийн үзэл санаатай ямар ч хамаагүй энэ асуудлыг нааж

байгаад бол харамсаж байна. Ийм асуудал манай хуулийн төсөл дээр ямар ч байдлаар хөндөгдөөгүй байгаа гэдгийг хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Зочин танилцуулъя. Өмнөговь аймгийн Баяндалай сумын сая танилцуулсан уу. Дахиад гарчихсан байна уу. Ариунзаяа гишүүн тодруулъя.

А.Ариунзаяа: Ингээд Монгол Улсад тамхины хяналтын хууль анх 1993 онд батлагдсан. 2005 оноос шинэчлэгдээд, нийт 8 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байдаг. Тэгээд энэ зөвхөн Монгол Улсад хэрэгжээд байдаг ийм асуудал огт биш. Энэ дэлхий нийтээрээ л явагддаг асуудал. Номинчимэг гэнэт зүүдлээд, өглөө нь босоод, санаачлаад байгаа асуудал огт биш. Энэ бол дэлхий нийтээрээ мөрдөж байгаа асуудал юм гэдгийг онцлон хэлье.

Бүх төрлийн тамхинд амт, үнэр оруулагч зэргийг хориглох ийм санаачилгыг хууль санаачлагч бол оруулсан. Шижир гишүүн бол зарчмын зөрүүтэй санал гаргаж гаа-г бол хориглох ийм зарчмын зөрүүтэй санал гаргаад, Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн байгаа. Тэгэхээр яг энэ агуулгаараа амт, үнэр, тэгээд Шижир гишүүний санал гаа хориглогдох юм болбоос ердийн тамхины амттай янжуур ч байна уу, эсвэл тэр вэйп цахилгаан ч байна уу энэ нь бол .../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: 1 минут сунгая.

А.Ариунзаяа: Эдгээр нь нээлттэй байгаад, тэгээд зохицуулагдах нь. 1 дүгээрт бол татварын бодлогоор зохицуулагдах нь. 2 дугаарт тамхины цэгт татдаг байдлаараа зохицуулагдах нь байна гэдгийг онцлон хэлэх гэсэн юм. Тэгээд энд бол хэн нэгэнд, ямар нэгэн давуу байдал үүсгэх гээд байгаа ямар нэгэн тийм асуудал бол огт биш шүү дээ. Зүгээр яг нийгмийн эрүүл мэнд талаасаа өөрсдөө эрүүл мэндээ хамгаалж, мөн дээрээс нь бусад улс оронд хэрэглэгддэг ийм асуудлыг бол дэвшүүлж байгаа юм. Тэгээд тодорхой хэмжээнд ажлын хэсэг сайн ажилласан гэж үзэж байгаа. Маргаануудаа бас цэгцэлсэн гэж үзэж байгаа. Энэ нь өнөө маргаашдаа хуулиа хэлэлцээд, батлаад явбал туйлын сайн байна гэж хүсье. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Амгаланбаатарын Ганбаатар гишүүн.

А.Ганбаатар: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе. Юун түрүүнд Номинчимэг тэргүүтэй гишүүдийн энэ санаачилсан хуулийг бол анх санаачилсан өдрөөс нь дэмжсэн. Чуулган дээр болон Байнгын хороо, ажлын хэсэг дээр хэлж байсан үгнүүд өдөр судартайгаа байж байгаа. Ажлын хэсэг дээр 5 зүйл заалт саналаа албан ёсоор цаасаар, бичгээр Чинбүрэн даргад бол өгсөн. Өөрөөр хэлбэл вэйп буюу татвараас гадуур тамхин бүтээгдэхүүн нэрлэгдэхгүй байгаа гэх мэт энэ хүүхэд, залуучуудад хортой ийм бүтээгдэхүүнийг татаж авчирч хуульчилж байгаа нь зөв гэдэгтэй байр суурь нэг байгаагаа эртнээс бол илэрхийлсэн.

Гэхдээ Номинчимэг гишүүнд болон ажлын хэсэгт ганц юм би хэлж байсан. Жоохон академик байна уу, үгүй юу. Амьдралтай асуудалд хандаач ээ. Нэгэнт энэ хуулийн төслийг шийдэж байгаа юм бол бүх хүчин зүйлсийг нь оруулж ирээд, 1 дор базаад хийж болохгүй юу гэдэг санаа. Тухайлбал хууль санаачлагч парламентын судалгааны хүрээлэнгээр хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийлгэхэд 83,3 хувь нь энэ 500 метр дотор тамхи худалдаалах хориглосон хууль чинь зөрчилтэй байна гэж гарч байгаа юм. Өөрөөр хэлбэл Улаанбаатарыг дээрээс нь ингээд

торлоод харах юм бол тамхи худалдаалах цэг байхгүй. Дандаа л лангуун доор, ил далд нууцаар буюу хууль зөрчиж энэ наймаа чинь явж байгаа юм. Энийгээ шийдэж болох юм уу, үгүй юу. Энийгээ оруулж ирээч гэсэн 1 санаа хэлсэн.

Харин сая Шижир гишүүн зарчмын зөрүүтэй санал гаргаад, Байнгын хороо дэмжсэн байна. Анх би бас хэлж байсан. Хэрвээ вэйп-ийнх нь амт, үнэрийг нь авах юм бол гаа-г нь бас ав. Гаа тавьчихаар чинь тэр гаатай компанийн ар талд байгаа юм шиг харагдана гэдэг саналыг хэлсэн. Байнгын хороогоор бол энэ санал нь ороод, зарчмын зөрүүтэй санал дээр аль аль нь амт, үнэргүй болоод орж ирж байгаа юм байна. Энэ бол зөв. Яагаад гэвэл тамхинд дургүй, тамхинаас гарсан хүмүүсийнх нь ихэнх нь муухай амттай учраас гэж ийм хариулт өгсөн байдаг юм байна.

Дараа нь тэр никотин гээд байсан. Никотин дээр нь тавьж байгаа татварын бодлогоо ялгамжтай байгаач гэж байгаа юм. Орцны асуудал байна. Урт, богинын асуудал, тэр дагалдах төхөөрөмжүүдийн асуудал байна. Энэ дээр жоохон уян хатан, ухаалаг татварын бодлогоо бариач ээ гэдэг асуудлыг бас хэлсэн гэх мэт энэ хуулийн төслийг ажлын хэсэгт хэлэлцэж байгаа хүрээнд нь биш бас өмнө нь ийм байж болохгүй юу гэдэг өөрийн үзэл санааг хэлэхээр аль нэг компанийн лоббист болж хувираад байна л даа. Дээхэн үед хэрвээ бид нар санаж байгаа бол социализмын үед зад угаагч аян гээд баахан нөхдүүд орж ирээд, ангиас хумс нь хиртэй байна гээд 1 хүүхэд гаргаж ирээд, захны даавуу нь хиртэй байна гээд бас 1 хүүхэд гаргаж ирээд, бичил биетэн хувцаснаас нь олдлоо гээд анги дагуулаад шившиглэдэг байсан шүү дээ. Тэрэн шиг Ардчилсан намын гишүүн юм би энэ жижиглэнгийн худалдаа эрхэлж байгаа 4 мянган гишүүн чинь бизнес эрхэлж байгаа шүү дээ цаана нь бас адилхан. Тэгвэл яагаад эд нарыг хохироож байгаа юм. Жижиг, дунд бизнес хийхэд тодорхой хэмжээний татвараа төлөөд, адилхан бизнес эрхэлж байгаа хүмүүсийн эрх ашгийг бас хэт хөндөж болохгүй гэдэг байр суурь илэрхийлсний төлөө яагаад ингээд гүтгээд, шившиглээд байгаа юм. Энэ дээр уучлалт гуйх хэрэгтэй. Учиргүй шүүхдээд, сэргийлэгдээд яваад байх нь бол миний хувьд бол зохимжгүй байна. Тэгэхээр дахиад хэлэхэд энэ хуулийг бол дэмжээд гарга.

Дараачийн гишүүдэд тэр 500 метр нь байна уу өөр энэ хуульд нэмэлт, өөрчлөлт орох юм байвал дараачийн шугамаараа, дараа нь санаачлаад явна биз дээ. Тэгэхдээ ер нь цаашдаа бол хууль санаачлагч маань эмзэг, эго дээрээ тулгуурласан ийм байж болохгүй. Ингээд энэ хуулийг дэмжиж байгаа гэдгээ хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Гомбын Ганбаатар гишүүн алга байна. Мэндбаярын Мандхай гишүүн.

М.Мандхай: Бид их чухал хууль хэлэлцэж байгаа юм. Тэгээд түрүүн бас бусад гишүүдийн бас хэлж байгаад бас хариу тайлбар өгсөн нь зүйтэй байх гэж бодож байна. Өнөөдөр энэ тамхины хууль хэлэлцэж байгаатай холбоотойгоор ДЭМБ-ын дэргэдэх IHME (Institute for Health Metrics and Evaluation) гээд судалгааны байгууллага байгаа. Энэ судалгаагаар бол хорт хавдраар нас барж байгаа хүмүүсийн тал хувь нь тамхи, архи, буруу хооллолтоос үүдэлтэйгээр хавдар үүсэж байна гэдгийг бол тодорхойлоод гаргаад ирсэн. Энэ судалгаа ч гэсэн манай ХСҮТ дээр өнөөдөр Монгол Улс элэг ходоодоороо дэлхийд 1-д жагсаж байгаа хавдрын улс болчихсон. Тэгээд энэ хавдар үүсгэгчдийн ерөөсөө хамгийн гол хүчин зүйл бол ерөөсөө дахиад л яг олон улстай адилхан байгаа. Зохисгүй хоол хэрэглээ, тамхи,

архи. Ингээд олон улсын судалгаагаар харахаар хамгийн их хувь эзэлж байгаа тамхины хэрэглээ. Энэ дотроо эрэгтэйчүүдийн хавдрын эмгэг алдагдал 33,2 хувь, эмэгтэйчүүдийнх 8,9 хувь эзэлж байгаа. Хорт хавдрын уушги, түнх, улаан хоолой, давсаг зэрэг олон төрлийн хавдрын 50-80 хувь нь тамхинаас үүдэлтэй ийм хавдар үүсэх юм. Тэгтэл ажлын хэсэг ажилласан, анхны өргөн барьсан хууль бол маш зөв үзэл баримтлалтай байсан. Харамсалтай нь ажлын хэсэг ажиллахдаа электрон тамхины шингэний хязгаарыг сулруулаад өгчихсөн байна. Тэгээд энэ яг ямар логик үндэслэлээр энэ хэрэглээг 10мг-аас их савлана гэсэн ийм заалтыг оруулж өгсөн бэ. 1-д.

2 дугаарт дахин цэнэглэх боломжийг нь үүсгээд өгчхөж байгаа юм. Үгүй ээ, тэгээд сая дахин цэнэглэлтээр дамжуулаад нөгөө сэтгэцэд нөлөөлөх хортой мансууруулах бодисыг чинь тэр цэнэглэлтээрээ дамжуулж оруулж ирэх боломжтой гээд сая ярьж байна шүү дээ. Тэгээд яагаад цэнэглэх тэр боломжийг нь ажлын хэсэг оруулаад ирж байгаа юм бэ.

2 дугаарт эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөр тамхины хор уршгийг тусгах энэ заалтыг хасчихлаа. Өнөөдөр цахим орчноос хүүхдээ хамгаалахын тулд (Digital Literacy) гэдэг маш том бодлогын зарчмыг олон улс хэрэгжүүлж байгаа. Яг үүнтэй адилхан тамхины Literacy буюу тамхины мэдлэг олгох сургалтыг ерөнхий боловсролын сургуулиудад нэвтрүүлэх ийм чухал заалтыг яагаад хассан бэ гэдгийг би дахиад ажлын хэсгээс асууя.

3 дугаарт сургуулийн орчинд тамхи худалдах, хэрэглэхийг хориглох зөрчил илэрвэл мэдэгдэх заалтыг ерөнхий хяналт хэрэгжүүлнэ болоод дахиад сулруулаад ороод ирж байгаа юм. Энэ яг ямар логик дараалал би ерөөсөө энийг нөгөө логикийг нь ойлгохгүй учраас би ажлын хэсэг, ажлын хэсгийн ахлагчаас болон бусад гишүүдээс нь асууя. Мөн хууль хэрэгжих хугацааг энэ хууль батлагдсан л бол яагаад шууд хэрэгжиж болдоггүй юм бэ. Яагаад 2027 оны 01 сарын 01 гээд бүтэн 1 жилээр хойшлуулж байгаа юм. Өнөөдөр өсвөр насны хүүхдийн тамхины хэрэглээ хурдацтай өсөж байгааг бид нар сааруулж чадахгүй байж байтал яагаад хуулийн хэрэгжилтийг бүтэн 1 жилээр хойшлуулсан юм бэ гэдгийг би тодруулаад асууя. Тэгээд хариултаа авчхаад тодруулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Чинбүрэн гишүүн хариулъя.

Ж.Чинбүрэн: Мандхай гишүүн би түрүүн бас хэлсэн. Ахиад хэлье. Шингэний хязгаарлалт 10мл-ээс их болгож байгаа биш, харин эсрэгээр багасгаж байгаа шүү. 10мл-ээс ихгүй гээд. Тийм учраас та зөв уншаарай. Буруу ойлгоод байна шүү. Тийм учраас бид бүр зориуд 30мл хүртэл савлачихсан байдаг, 13 мянган удаа сордог ийм дадлуудыг хорих зорилгоор 10мл-ээс ихгүй байхаар савлахгүй шүү гээд үүрэгжүүлж байгаа шүү.

Дахин цэнэглэлтийн тухай би түрүүхэн бас ярьсан. Дүүргэж, ялангуяа электрон тамхийг дүүргэж цэнэглэдэг байдал нь өөрөө бусад бодисыг холих эрсдэл байгаа учраас дахин цэнэглэхийг бүр Монгол Улсад хориглосон шүү. Тэгэхээр таны яг хэлж байгаагийн яг эсрэгээр ийм хориглосон байдлаар ажлын хэсэг ажилласан шүү. Тэгэхээр бас энийг залруулж хэлье.

3 дахь асуулт ерөнхий боловсролын тэр хөтөлбөрт оруулахгүй яагаад байгаа юм бэ гэж. Тэгэхээр энэ хөтөлбөр Боловсролын ерөнхий хууль дотроо угаасаа орчихсон байгаа. Дээрээс нь Боловсролын ерөнхий хуулиараа хууль тогтоомж та бас хуулийн чиглэлийн хүн байх. Тэгэхээр хууль тогтоомжийнхоо асуудлаараа Боловсролын ерөнхий хуулиараа боловсролын сургуулийн хөтөлбөрийг зөвхөн Боловсролын ерөнхий хуулиар л зохицуулна гээд заачихсан байгаа учраас бид Тамхины хяналтын хуулиар дахин энэ асуудлыг оруул гэж хэлж болохгүй юм байна лээ шүү. Тэр утгаараа бас ингээд хасагдсан боловч цаанаа агуулгаараа байж байгаа гэж ойлгоорой.

Дээр нь боловсролын ерөнхий хууль дотор энэ мансууруулах, сэтгэцэд нөлөөт хорт зуршилтай холбоотой зүйлийн эсрэг боловсрол олгох асуудал өөрөө тусгагдсан байдаг юм байна.

Та чухал зүйл хөндлөө. Ерөнхий хяналтын зохицуулалтууд нь яагаад ингээд буурчхав. Яагаад боловсролын байгууллага зөвхөн арга хэмжээ хэрэгжүүлэгч болчхов гээд. Нөгөө чиг үүргийнх нь хүрээнд энэ бас болохгүй байгаад байгаа. Тийм учраас бид бас Зөрчлийн тухай хуульдаа тааруулж, уялдуулах асуудал яригдаж байна.

Мөн бас яагаад 2027 оны 01 сарын 01 болгоод хойшлуулчхав гэдэг асуудал яригдаж байна. Тэгэхээр бид нэлээн том өөрчлөлтийг энэ Тамхины хяналтын тухай хуулиар оруулж өгч байгаа. Тухайлах юм бол зар сурталчилгаа хийх, гадаргуу дээр нь 70-аас их хувьд нь энэ анхааруулга бичигт таниулах тэмдэг оруулах асуудлууд яригдаж байгаа. Дээрээс нь савлалтын хувьд бид өөр стандарт, өөрчлөлтүүд оруулж өгч байна. Энэ болгонд нөгөө импортлогч байгууллагууд, үйлдвэрүүддээ захиалгаа өгч оруулж ирэх бас боломжийг нь олгохгүй бол шууд өнөөдрөөс ингээд боль гээд шууд хасчих нь өөрөө бас нэлээн зөрчил үүсэхээр юм байна. Тэр ч утгаараа Худалдаа аж үйлдвэрийн тэнхимээс бид нэлээдгүй өмнөх ажлын хэсэг ч гэсэн олон хэлэлцүүлгүүд хийсэн. Тэндээс тийм саналууд ирсэн байна лээ шүү. Үүнийг бас тусгасан гэдгийг дуулгая.

Ж.Бат-Эрдэнэ: Одсүрэнгийн Номинчимэг .

О.Номинчимэг: Өнөөдөр бид нар бүтэн 7 сар, 8 сар хүлээсний эцэст Тамхины хяналтын тухай хуулийн анхны хэлэлцүүлгийг чуулганаараа хэлэлцэж байна. Энэ үзэл санаа нь нэгдэж, дэмжиж байгаа олон гишүүд байгаа. Энэ олон гишүүддээ үнэхээр талархаж байна. Тэгээд сүүлийн үед ерөөсөө л энэ хуулийн зорилт бол бид нар нийгмийн эрүүл мэндээ хамгаалъя, хүүхэд өсвөр үеийнхнийхээ эрүүл мэндийг хамгаалъя, тамхидалтаа бууруулъя гэдэг л энэ зорилгын хүрээнд орж ирсэн. Гэхдээ сүүлийн үед үнэхээр харахад олон янзын эрх ашгийг хөндсөн учраас үүрээ самруулсан амьтан шиг л бужигнаж байгааг та бүх бүгдээрээ л хамтдаа харлаа.

Дэлхийд байхгүй хямдхан үнэтэй болчихсон янжуур тамхиныхаа татварыг нэмье гэхээр тэд нар нь дургүйцэж байна. Хилээр орж ирж байгаа хичээл бичдэг үзэгтэй адилхан татвар авдаг электрон тамхийг нь хортой бүтээгдэхүүн тамхи гэж үзье, зохицуулалтад оруулъя, нэмээд онцгой дотор авъя гэхээр хавиргаа хазаж байгаа хар нохой мэт л сошиал дээр янз бүрээр л явж байна. Тэгээд энэ бүхнийг харахаар үнэхээр хааяа бол бас Монгол төрийн бодлого юуны өмнө, яаж сөхрөх юм, хүчтэй байж чадах юм уу гэж бодох, эргэлзэх үе ч гэсэн надад бол гарсан.

Ялангуяа энэ хуулийг хаврын чуулганаар хэлэлцүүлэх гээд явуулах үед маш их гацаа гарсан. Сүүл рүүгээ өрөөнд орж ирээд чамайг улс төрчийн хувьд хэн ч биш болгоно шүү. Эсвэл албаар би энэ хуулиа батлуулчих юм бол хар зах зээл албаар үүсгэж байгаад чамд харуулна шүү гэж заналхийлэх хүн ч гэсэн орж ирсэн. Яасан их мөнгөтэй юм бэ. Ингээд 1 жоохон эрх ашгийг нь хөндөөд ирэхээр яаж байгааг та бүхэн бас харж байна. Гэхдээ энд ирээдүй хойч үеийнхний төлөө, эрүүл мэндийг нь хамгаалахын төлөө энэ үзэл санаан дээрээ нэгдэж байгаа олон гишүүн байгаа гэдэгт би бол итгэж байна.

Тэгээд энэ хуулийг боловсруулаад бид нар бол олон чиглэлээр нь цогцоор нь бас ингээд шийдэхээр орж ирсэн. Тэгээд ажлын хэсэг бол бас амаргүй нөхцөл байдалд сайн ажиллалаа. Би ажлын хэсгийнхээ гишүүдэд бас талархаж байгаа, байр суурийг нь хүндэтгэж байгаа. Энэ асуудлыг бол парламент олонхоороо л шийдээд явдаг. Энэ олонхоороо шийдэх процесс руу л ороосой гэсэн энэ хүсэл байсан. Тэгээд энэ хууль дээр элдэв 1 талыг нь барилаа ч гэдэг юм уу янз бүрийн төөрөгдүүлсэн мэдээлэл явсан. Миний хувьд энэ хуулийг боловсруулж байхдаа бид нар 2030 он гэхэд хүн амынхаа тамхидалтыг 15 хувиар бууруулна гэсэн Засгийн газар маань, улс орон маань амлалт өгсөн байсан. Тэгтэл бид нар сүүлийн 2019 оноос хойш тасралтгүй 6, 7 жил тамхидалт маш өндөрсөж байгаа. Ази-Номхон далайдаа ч гэсэн маш өндөр байна.

Шинэ төрлийн электрон тамхин бүтээгдэхүүний хувьд ч гэсэн Ази-Номхон далайд БНСУ, Австралид гэхэд хүүхэд залуусын хэрэглээ дөнгөж 3-4 хувьтай байхад бид аль хэдийн 25-26 хувь болчихоод ийм аюултай нөхцөл байдал дээр байна гэсэн үзэл санаагаар л хийсэн. Тэгээд үүний бас 1 бодлого буюу тэр татварын бодлого. Ялангуяа янжуур тамхины татварын бодлогыг та бүхэн маань анхаарч үзээрэй. Энэ бол буух ёсгүй юм шүү. Энэ бол хэтэрхий хямдхан байгаа янжуур тамхиа бид нар үе шат дараатайгаар 2030 он хүртэл ингэж тооцоолж өсгөж байж бид нар сая 14 хувь тамхидал буурах нь гэсэн тооцооллын үндсэн дээр бид нар энэ тамхины татварыг тооцоолсон. Тэгээд тийм ч учраас Евроазийг энэ 30 хувийн татвараа байхгүй болгочихсон байгааг нь заавал нөхөж орж ир гэдэг зүйлийг ч гэсэн олон удаа хэлж, өнөөдөр бас зэрэг хэлэлцэж байх шиг байна.

Тэгэхээр ажлын хэсгээс бол мэдээж ажлын хэсгийн гишүүд маань олонхоороо шийдээд, татварын бодлого дээр бууруулсан ийм заалтууд орж ирж байна. Олон улсын зөвлөмжийнхөө дагуу янжуур тамхины жижиглэнгийн үнийн .../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Номинчимэг гишүүнд минут сунгая.

О.Номинчимэг: 75-аас доошгүй хувь нь татвар байх ёстой гэсэн яг энэ тооцооллыг бид нар сая дөнгөж бага багаар нэмсээр 2030 онд хийхээр байсан. Энийгээ 60 хувь болгож байгаа юм байна. Тэгэхээр энэ 60 хувь болгосноор янжуур тамхины татварыг сулруулж буюу багасгаснаар бид нарын зорьсон 14 хувийн тамхидалтыг бууруулна гэсэн зорилго маань хэд болж буурахаар тооцоолол гарсан бол. Энэ дээр ажлын хэсгийн ахлагчаас бас тайлбар авъя гэж бодож байна.

Ж.Бат-Эрдэнэ: Чинбүрэн гишүүн хариулъя. Чинбүрэн гишүүн.

Ж.Чинбүрэн: Татварын бодлого дээр бид бас Жаргалан гишүүнээр ахлуулж ажилласан. Жаргалан гишүүн бол нэлээн олон удаа бас тайлбараа хэлсэн. Ер нь

бол татварын бодлого бол шууд янжуур тамхитайгаа уялдаж, янжуур тамхи бол бенчмаркинг буюу хэд байхыг зааж байгаа том үзүүлэлт. Энэ утгаараа бид 2027 онд одоогийн байгаа 836 төгрөгийг 2 мянган төгрөг буюу нэмж байгаа. Яг бодит амьдрал дээр эдийн засгийн нөлөө, нийгмийн нөлөөллийг нь аваад үзэх юм бол энэ тийм ч их нэмэгдэл биш. Бас яг бодит байдлаараа. Тийм ээ. Инфляц, дээрээс нь юмны үнийн хөөргөдөл, байгаа байдал, тэгээд 1 зүйлийг бид ойлгох ёстой юм. Тамхины татвар бол орлого олох хэрэгсэл биш шүү. Эрүүл мэндийг хамгаалах зэвсэг гэж ойлгоорой. Тийм учраас энэ их, бага гэж бид ярих гээгүй. Гагцхүү энэ карманд нь мэдрүүлж чадаж байна уу. Тамхи таталтыг болиулах, багасгах нөлөөлөл байна уу л гэдэг нь чухал.

Тийм учраас бид ажлын хэсгээрээ ярьж байгаа зүйл бол орлого олох хэрэгсэл, татварыг бүрдүүлэх зүйл биш. Харин бодитой нэмж, энэ карманд нь мэдрүүлж тамхи таталтыг бууруулна. Нөгөө талдаа бид заавал бас үр дагаврыг нь бодох ёстой. Энэ чинь Их Хурал олон талаас нь бодно шүү дээ. Энэ чинь амьдралыг зохицуулж байгаа хууль учраас нөгөө далд бизнес, контраунд хажуу зэрэгцээ оршиж байгаа орнуудын үнэ хэд байгаа юм. Нөгөө гэнэтхэн Хятадаас, ОХУ-аас тамхиа зөөгөөд унах юм биш биз. Бид энэ дээр яаж анхаарах вэ. Олон зүйлийг дэнслэн бодож энэ тооцооллыг гаргасан гэдгийг хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй уялдуулан асуулт асууж, санал хэллээ. Асуулт асууж, хариулт авлаа. Байнгын хорооны саналаар санал хураан. Санал хураалтыг уучлаарай. Тийм байна. Үг хэлэх юм байна. Байж байгаарай.

Ингээд Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалтын өмнө саналыг тайлбарлаж дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх гишүүдийг нэрсээ өгье. Авсан байна. Лутаагийн Энхнасан гишүүн. 3 хүн өгсөн байна.

Л.Энхнасан: Эрхэм гишүүд ээ,

Тамхины хяналтын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд нэлээд анхаарал татсан байна. Тэгээд олон талын байр суурь өрнүүлж байна. Бид үүнийг харж байна. Хуулийн төслийн үндсэн зорилго болон иргэдийн тамхины хэрэглээг бууруулах, өсвөр үе, хүүхэд, залуучуудын электрон тамхины хэрэглээгээс хамгаалах, мөн тамхины бүтээгдэхүүний татварын бодлогыг сайжруулах, татварыг нэмэхийг зарчмын хувьд бол дэмжиж байна. Хуулийн төсөлд орсон оновчтой олон шийдвэрүүдийг бол дэмжиж байна.

Харин ажлын хэсгийн гишүүний хувьд нийгмийн эрүүл мэндийн бодлогын хувьд тамхи, никотин агуулсан бүтээгдэхүүний эрүүл мэндэд үзүүлэх хор нөлөө харилцан адилгүй байж болох тул татварын бодлого нь эрсдэлийн түвшинтэй уялдуулж ялгамжтай байх нь зүйтэй гэсэн байр суурийг илэрхийлсэн юм. Эрсдэл өндөр бүтээгдэхүүнд өндөр татвар, эрсдэл харьцангуй бага бүтээгдэхүүнд зохистой татвар ноогдуулах нь хэрэглэгчдийн хор хөнөөл багатай сонголт руу шилжих энэ боломжийг хадгалдаг юм. Иймд онцгой албан татварыг ялгамжтай болж ажлын хэсэгт зарчмын зөрүүтэй санал оруулсан. Тэгэхдээ цаашид бас анхаарах хэдэн зүйлүүд байна.

Өнөөдөр хүүхдүүд электрон тамхийг дэлгүүрээс биш сошиал орчин болон онлайн худалдаагаар авч байна. Энэ удаагийн хуулийн төсөлд цахим худалдаа болон хүргэлтийн хяналт, цахим сурталчилгааны зохицуулалт бол хангалттай тусгагдаагүй байна. Иймд энэхүү хууль гарсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай тогтоолд энэхүү асуудлыг тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

2 дугаарт хуулийн төсөлд электрон тамхины амт, үнэрийн зохицуулалтыг тусгасан боловч импортын хяналт, бүртгэл, хилийн шалгалтын асуудлыг хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой зохицуулалт хангалтгүй байна. Хэрэв тамхинаас бусад амт, үнэртэй бүтээгдэхүүнийг хориглож байгаа бол эдгээр бүтээгдэхүүний хилээр нэвтрэхээс эхлээд зах зээлд худалдах хүртэлх хяналтын тогтолцоог тодорхой болгох шаардлагатай байна. Хууль батлагдсан ч амт, үнэртэй бүтээгдэхүүн импортоор орж ирсээр л байна. Эсвэл хууль бус худалдаа нэмэгдэх эрсдэлтэй байна. Тиймээс импортын бүртгэл, бүтээгдэхүүний найрлага, шошгын хяналт, гаалийн байгууллагын шалгалт, лабораторийн баталгаажуулалт зэрэг хэрэгжилтийн механизмыг цогцоор нь ер нь авч үзэх шаардлагатай байна.

3 дугаарт өнөөгийн үйлчилж байгаа хуулийн 6.7.14 дэх заалтын дагуу өөрнхий боловсролын сургууль болон дотуур байрнаас 500 метрийн дотор тамхи худалдаалахыг хориглох нь бодит амьдрал дээр хэрэгжихгүй байна. Монголын жижиглэн худалдаа эрхлэгчдийн холбооноос ирсэн мэдэгдэлд худалдааг хориглосны үр дүнд тамхи татдаг сурагчдын 82 хувь нь хууль бус худалдаалагчаас тамхи худалдан авч, зөвшөөрснөөс бусад газарт худалдаалах нь нийт зөрчлийн 83 хувийг эзэлж байна гэсэн мэдээлэл иржээ. Хууль бус худалдаа далд хэлбэрт шилжиж хяналтгүй өргөжин тэлж байна гэсэн цагдаагийн байгууллагын мэдээллийг бас дурджээ. Энэ заалт өсвөр насны тамхины хэрэглээг хязгаарлах бус харин ч эсрэгээр далд эдийн засаг руу хөшүүрэг болж байна гэж үзжээ. Иймд энэ асуудлыг бас онцгой анхаарах цаг болжээ.

Эцэст нь хэлэхэд ажлын хэсэг болон Байнгын хорооны хэлэлцүүлгийн үеэр мэргэжлийн байгууллагуудын дүгнэлт, тооцоо зарим асуудлаар өөр өөр байсан. Иймээс бие биеийнхээ байр суурийг хүндэтгэж, шинжлэх ухааны нотолгоо, нийгмийн эрүүл мэндийн ашиг сонирхолд тулгуурласан хамгийн оновчтой шийдвэрийг гаргана уу гэж хүсэж байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Сүүлийн өдрүүдэд Тамхины хяналтын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт олон нийтийн анхаарлыг татаад байна. Үүнтэй холбоотой цахим орчинд үүсээд байгаа зарим 1 ташаа ойлголтыг няцаах замаар та бүхнийг энэ тамхины хуульд орж байгаа нэмэлт, өөрчлөлтийг дэмжиж өгөхийг хүсье.

1 дүгээрт энэ хууль насанд хүрсэн иргэний сонголтыг ямарваа нэгэн байдлаар хязгаарлах, сонголтыг нь шийтгэх тухай ийм хууль ерөөсөө биш. Харин хүүхэд, өсвөр үеийнхнийг никотины донтолтоос урьдчилан сэргийлэх, тэдний ирээдүйд үүсэх олон сөрөг үр дагавраас хамгаалах хууль юм.

2 дугаарт электрон тамхи хоргүй гэсэн ойлголт шинжлэх ухааны үндэслэлгүй гэдгийг мөн хариуцлагатайгаар энэ танхимаас мэдэгдье. Электрон тамхины ихэнх бүтээгдэхүүн никотин агуулдаг бөгөөд никотин нь өсвөр насны хүүхдийн тархины хөгжилд сөргөөр нөлөөлдөг болохыг олон улсын эрүүл мэндийн байгууллагууд анхааруулсаар байгаа.

3 дугаарт энэ хуулиар бүхнийг хориглох гэж байна гэдэг ташаа мэдээлэл явж байна. Хуулийн зорилго нь хүүхдийг онилсон өнгө, үнэр, амт, сурталчилгаа, хүртээмжийг хамгийн боломжит хэмжээгээр хязгаарлахыг оролдлоо. Өөрөөр хэлбэл тамхины компаниуд ирээдүйн мянга мянган хэрэглэгчээ бэлтгэж байгаа маркетингийг бид нар таслан зогсоож байна. Хүүхдэд бүрэн зарахгүй гэдэг баталгааг өг гэж манай зарим нэг улс төрчид хэлж байна. Энэ баталгааг дэлхийн аль ч парламент, ямар ч улс төрч энэ баталгааг өгөхгүй. Харин зохицуулалтгүй орчноос илүү хамгаалалттай орчныг бий болгох гэж байгаа оролдлого бөгөөд энэ хамгаалалтыг бий болгох нь төрийн үүрэг бөгөөд парламентын бүх гишүүдийн үндсэн үүрэг гэдгийг бол сануулах ёстой гэж бодож байна.

Эцэст нь энэ асуудал бизнесийн ашиг сонирхлын өнцгөөс бус хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэндийн өнцгөөс нь олж хараасай. Өнөөдөр бид худал мэдээлэл бус нотолгоонд суурилсан шийдвэр гаргах үүрэгтэй. Мөн үүний зэрэгцээ зарим гишүүдийн шүүмжилж байгаачлан зарим зохицуулалтыг дутуу оруулж ирсэн гэж хэрвээ та шүүмжилж байгаа бол та бас энэ хуулийг нэмээд санаачлах эрх нь байгаа гэдгийг мөн сануулъя. Тэгээд гишүүд та бүхнийг дэмжиж өгөхийг хүсье.

Ж.Бат-Эрдэнэ: Мэндбаярын Мандхай гишүүн.

М.Мандхай: Би хэдэн статистик тоог хэлье. Тэгээд зарим гишүүд бас судалгаа хангалтгүй байлаа гээд ярьж байх шиг байна. Бид нар өнөөдөр Тамхины хяналтын тухай хуулийг хэлэлцэхдээ 1 зүйлийг бас санах ёстой. ДЭМБ-ын дэргэдэх, ялангуяа Вашингтоны их сургуулийн дэргэдэх дэлхийд нэр хүндтэй бие даасан судалгааны хүрээлэн байдаг. Энэ судалгааны хүрээлэнгээр хорт хавдраар нас барж байгаа хүмүүсийн тал хувь нь тамхи, архи, буруу хооллолтоос үүдэлтэй гэдгийг судлаад гараад ирчихсэн байгаа. Эдгээрээс хамгийн их хувь эзэлсэн тамхины хэрэглээ байгаа. Хорт хавдрын уушги, төвөнх, улаан хоолой, давсаг зэрэг олон төрлийн хавдрын 50-80 хувь нь тамхинаас үүдэлтэй. Архи нь бол амны хөндий, элэг, бүдүүн гэдэс, хөхний хавдар гэсэн гол шалтгаан гэдгийг нотолсон судалгаанууд байна. Энэ бол зүгээр статистик тоо биш юм. Ялангуяа Монгол Улс бараг хавдрын орон болтлоо дэлхийд 1 номерт хавдраараа жагсаж байгаа улсын хувьд 1 ч гэсэн гэр бүл, үр хүүхдүүдийнхээ ирээдүйг хамгаалахын төлөө, нийгмийн аз жаргалыг авч одож байгаа энэ бол бодит үнэн гэдгийг энэ судалгаагаар бас харах хэрэгтэй.

Дэлхийн олон оронд хийсэн судалгааны дүн дээр тамхины үнэд 10 хувийн өсөлт оруулахад дундаж болон бага орлоготой улсуудад 5 хувиар буурч байгаа юм. Энэ нөлөөллийн тал хувийг хэрэглэгчдийн тоо багассан, үлдсэн талыг нь тамхи татаж үлдсэн хүмүүсийн хэрэглээгээ багассан гэдэг нь тогтоогдчихсон. АНУ-ын эдийн засагчид олон улсын байгууллагуудын хамтарсан судалгаагаар өсвөр үеийнхний дунджаар 7 хувиар бас бууруулж өгч чадсан байна. Тэгэхээр бид тамхины үйлдвэрлэл, худалдаа эрх ашгийг хамгаалах гэж энэ хууль батлахгүй. Монголын хүүхэд эрүүл мэнд, ирээдүйг хамгаалах гэж энэ хуулийг баталж байгаа юм. Тэгэхээр энэ хуулийг шүүмжилж болно. Гэхдээ энэ хууль санаачлагчийн

хуулийн төсөл нь 1 ч гэсэн хүүхдийг өвчлөл, хавдраас сэргийлэх том алхам юм шүү. Чухал заалтуудыг бид нар батлаад явъя. Хэрэгжилтэд хяналт тавъя. Ахиад хуулиа цааш цаашдаа угаасаа сайжруулах хэрэгтэй. Тийм учраас энэ Улсын Их Хурлын гишүүд өөрсдөө хяналтаа тавь. Шаардлагатай бол дахиад сайжруулаад нэмэлт, өөрчлөлтүүдийг хийгээд явах нь хуулиараа бүрэн нээлттэй байгаа. Тэгэхээр хэрэв хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах хамгийн чухал заалтуудаа бид нар сулруулахгүйгээр энэ хууль бол батлагдсан нь илүү бодит үр дүн авчрах юм гэдгийг бас дахин хэлъе.

Ж.Бат-Эрдэнэ: санал хураалт явуулах ёстой. Санал хураалтыг 17 цагаас нэг мөр явуулна.

16.47 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Энхбатын Болормаа танилцуулна. Таныг урьж байна.

Э.Болормаа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Уур амьсгалын өөрчлөлтийн тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2026 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт санал гараагүй.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг нэгдсэн хуралдаанаар явуулах үед хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөн хуулийн нэр томъёоны тодорхойлолтын үг хэллэг, найруулгыг жигдлэх, үндэсний зохицуулагч байгууллагын сааруулалтын үр дүнг тооцон шилжүүлэх, байгалийн болон бусад хүчин зүйлээс шалтгаалан алдагдах эрсдэлийг бууруулах зорилгоор төсөл хөтөлбөрөөс үүсэн баталгаажсан сааруулалтын үр дүнгийн тодорхой хувийг эрсдэлийн санд нөөцлөн хуульд заасан журмын дагуу буцаан олгох, удирдлага хяналтыг хэрэгжүүлэх зэрэг зарчмын зөрүүтэй 6 саналыг гүйцээн боловсруулсныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тариалангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрчим хүч хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Шүрэнчулууны Батбаяр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Цэрэндоржийн Уранчимэг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Тусгай хамгаалалтын газрын Газар нутгийн бодлогын газрын дарга, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Саруулын Пүрэвсүрэн Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга, Харнүдэнгийн Мөнхзул Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга, Цэндээхүүгийн Мөнхбат Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Тусгай хамгаалалтын бодлогын газрын ахлах шинжээч, Алтангэрэлийн Нарангарвуу Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч.

Ажлын хэсгийнхэнд хууль танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа Засгийн газрын гишүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан үнэн зөв, гүйцэд мэдээлэл өгөх үүрэгтэй. 21.25-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, таниулах, Улсын Их Хуралд худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно. 21.1-д чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, худалдаанд оролцсон этгээд худалдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож тухайн этгээдэд Төрийн албаны тухай болон холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ гэж тус тус заасныг та бүхэнд танилцуулж байна.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна. Нэрсийн дагуу Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Сайн байцгаана уу. Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулаад 2, 3 асуулт асууя.

Энэ хууль батлагдсанаар, хэлэлцэн батлагдсанаар яг нийгэм, эдийн засгийн ямар үр ашиг, симуляцын түвшинд гарах вэ. Бид нар ингээд 2024 оны 11 сарын 28-нд байх, хүн төвтэй гэдэг бодлогын бичиг баримт гаргасан. Тухайн үед Улсын Их Хурлын гишүүн Булгантуяа дэд дарга ахлаад. Ингээд Монгол Улсын Их Хурлаас гарч байгаа бүх хууль бөгөөд тогтоолууд нь 5 шалгуурыг хангасан байна гээд ингээд шалгуур үзүүлэлт тогтоочихсон. Тэгээд жил болгон Төрийн байгуулалтын байнгын хороо дээр энэ төлөвлөгөөгөө гаргаад, Улсын Их Хурлаас гаргаж байгаа тогтоолууд болон хуулиудыг үүнд уялдуулж байна гэдэг ийм шийдвэр гаргачихсан. Ингээд харж байхад бол ерөөсөө бид нар энийгээ эшилж, филтер маягаар ингээд зарчим, шалгуур маягаар энэ өмнө гаргасан зүйлүүдээ ашиглахгүй байгаад байгаа. Тэгэхээр яг энэ үндэсний аюулгүй байдлын үндсэн 6 тулгуур баганын 1 нь өөрөө яг энэ өргөн баригдсан энэ хуультай холбоотой асуудал байгаа. Оршин тогтнохуйн аюулгүй байдлын араас орж байгаа. Экологийн том сэдэв байгаа

Тэгэхээр би 3, 4 асуултыг задлаад асуухад 1 дүгээрт яг энэ үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал дээр энэ зохицуулалтуудыг шинэ тутам судалгаа нь хийгдээд явж байгаа. Үүнтэй хэр зэрэг уялдаж байгаа вэ.

2 дугаарт нь эхэнд нь асуусан. Ер нь яг нийгэм, эдийн засгийн ямар үр ашиг гаргах тийм симуляц, үр дүн гарсан бэ.

3 дугаарт нь гэх юм бол энэ одоогийн яваад байгаа энэ уур амьсгалын өөрчлөлт, одоо өнөөдөр 6 сарын 25 гэхэд л зун болсонгүй. Бараг намартаа залгачих гээд байгаа шүү дээ. Тэгэхээр энэ нөхцөл байдал, өөрчлөлтүүдийнхээ энэ судалгаа, зүйлүүдийг яаж тусгасан бэ гэсэн энэ 3 асуултад хариулт авъя.

Ж.Бат-Эрдэнэ: Болормаа гишүүн хариулъя.

Э.Болормаа: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Би нийгэм, эдийн засгийн нөлөө болоод одоо яг энэ уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой судалгаа энэ 2 асуултад хариулъя. Дэд ажлын хэсгийн зүгээс хүн төвтэй бодлоготой хэрхэн уялдаж байгаа талаар нэмэлт хариулахыг хүсье.

Энэ хуулийг маань маш энгийнээр ойлгуулахад Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтөд дэлхийд хүлэмжийн хийн ялгарлын бол 0,1 хувийг л эзэлдэг. Маш бага. Тэгэхээр бид нар энэ уур амьсгалын өөрчлөлтийг дэлхийн хэмжээнд сааруулахад оролцох карбон ах зээлийн үүд хаалгыг нээж өгч байгаа. 1 нийгэм, эдийн засгийн нөлөө нь. Тэгэхээр энэ хууль хэрхэн хэрэгжиж, манайд эерэг ногоон санхүүжилтийг татаж болохуйц төслүүд хэрэгжих вэ гэдэг бол яг өнөөдөр шууд тэдэн төсөл хэрэгжинэ гэж хэлэхэд төвөгтэй ч бид бол 4 улстай 2 талын хэлэлцээр байгуулчихсан. Энэ маань хэрхэн хэрэгжих үүд хаалгыг нээж байгаа юм. Эдгээр нь бол Япон, Өмнөд Солонгос, Швейцар, Сингапур гэсэн 4 улс.

Уур амьсгалын өөрчлөлтийн 2 дахь хэсэг бол таны асуусан асуулттай илүү холбоотой нь өнөөдөр манай Монгол Улс бол уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нэн шаардлагатай болж байгаа. Тэгэхээр бид нар уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий, эмзэг улсуудын 1 нь байгаа нь нүүдэлчин мал аж ахуй дээр

суурилсан эдийн засгийн бүтэцтэй. Өнөөдөр нүүдэлчин мал аж ахуй гэлтгүй Улаанбаатар хотод зуны дунд сард бол цас ороод, энэ цаашлаад бид нарын мэдэхгүй маш олон нөлөөллүүдийг бий болгож байгаа. Тэгэхээр энэ хуулиар гарч ирж байгаа гол зохицуулалт бид одоогийн байдлаар бол Байгаль, орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам гээд нэр төдий энэ асуудлыг тавьсан боловч одоо тодорхой чиг үүргүүдийг нь, эрх, үүргүүдийг нь олгож өгч байгаа. Тэгэхээр яг бидний эмзэг байдлын үнэлгээ ямар байх юм. Эрсдэлийн үнэлгээнүүд юу байх юм. Таны яг онцолж асуугаад байгаа нээрээ тэгвэл цаашдаа шинжлэх ухааны үндэслэлтэйгээр бид өөрсдийнхөө эмзэг байдал болоод эрсдэлийн үнэлгээнүүдийг гаргаад, түүний дагуу Засгийн газар арга хэмжээ авах ийм зүйл заалтууд орж ирж байгаа.

Тэгэхээр энэ хуулийн эхний нэлээд том хэсэг нь бол ерөөсөө төрийн захиргааны байгууллагуудын үүрэг чиглэл. Энэ дотор жишээлбэл уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах арга хэмжээг яам болгон өөрийнхөө салбарын хэмжээнд тодорхойлж, улсын төсөвт тусгуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах гэх мэтчилэн иймэрхүү үүргүүдийг бол оруулж өгч байгаа. Эхний асуултад дэд ажлын хэсгээс нэмээд хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг хариулъя. 4 номерын микрофон .

Ш.Батбаяр: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батбаяр. Гишүүний асуултад хариулъя. Уур амьсгалын өөрчлөлтийн хуулийн төслийг боловсруулахдаа Монгол Улсын байгаль орчин, уур амьсгалын чиглэлээр боловсруулсан стратегийн бичиг баримтуудтай уялдуулан боловсруулсан байгаа. 2024 онд Засгийн газраар баталсан Үндэсний дасан зохицох стратеги, төлөвлөгөө, 2025 онд баталсан Үндэсний тодорхойлсон хувь нэмрүүдийг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчныг илүү тодорхой болгож байгаа юм. Энэ хуулийг баталснаар. Мөн яг уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн ихээр өртөж байгаа малчин өрхүүд болон яг хөдөө аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт, ногоон санхүүжилтийг нэмэгдүүлэх, гадна дотнын төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх боломжийг нээж өгч байгаа. Сая гишүүн бас хэллээ. Засгийн газрын хооронд 4 улстай хэлэлцээр байгуулсан байгаа. Тэгээд тэр хэлэлцээрийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэнээр.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулъя. Бидний хийсэн судалгаагаар өнгөрсөн 10 жилийн хугацаанд манай улсад ногоон санхүүжилтийн хэлбэрээр 1,5 тэрбум долларын хөрөнгө оруулалтаар гаднын хөрөнгө оруулалт орж ирсэн гэсэн судалгаа байгаа. Тэгэхээр өөр бусад улсуудын тодорхой уур амьсгалын өөрчлөлтийн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлснээр энэ санхүүжилт 2-оос дээш хувиар өсдөг гэдэг тооцоо судалгаа гарсан байгаа. Тэгэхээр бидний төсөөлж байгаагаар, төлөвлөж тооцоолж байгаагаар бол ирэх 10 жилд өнгөрсөн 10 жилийн 1,5 тэрбум долларын ногоон санхүүжилтийг бол 2-оос дээш дахинаар өсгөх боломж бүрдэж байгаа гэж үзэж болно.

Ж.Бат-Эрдэнэ: Байгаль орчны сайд хариулъя. Сандаг-Очир.

Ц.Сандаг-Очир: Эрдэнэболд гишүүнийхээ асуултад бас нэмэлтээр тайлбар өгье. Уур амьсгалын өөрчлөлтийн анхдагч хууль батлагдсанаар ямар эерэг үр дүн гарах вэ гэж. Энэ хууль гарснаар Монгол Улс, иргэн, хуулийн этгээдүүд ямар хүлэмжийн хийн ялгарлыг гаргаж байгаа юм бэ гэдгээ бид нар хэмждэг болно.

Бүртгэдэг болно. Баталгаажуулдаг болно. Тайлагнадаг болно. Ингэснээр бид нар дэлхийн зах зээл дээр карбон ногоон зах зээл дээр ногоон санхүүжилтийг татах тэр хууль, эрх зүйн орчин бүрдэнэ. Ингэснээр бид нар эргээд байгалийн өгөгдлөө ашиглаад, ногоон зах зээл дээр хөрөнгө оруулалт татах, дахиад эдийн засгийн шинэ салбарын зах зээл бий болох тийм бололцоо боломжууд бас эрх зүйн орчин бүрдэж байгаагаараа онцлогтой гэдгийг бас хэлье. Ганцхан минутаг хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Сайн байна. Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Сандаг-Очир сайд бас туршлагатай болохоороо л хариулж байна л даа. Яг энэ саяын зүйлүүдийг л тодорхой асуугаад байгаа байхгүй юу. Дэлхий дахин бол яг энэ ногоон зүйл рүү явдаг байж байгаад АНУ энэ Трампын бодлого эд нар чинь бол бараг эсрэгээрээ яваад байгаа. Тэгээд миний түрүүний асуусан асуулт байгаа. Энийг Тэмүүлэн гишүүн маш сайн мэдэж байгаа байх. Манай Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал бас шинэчлэн боловсруулагдаад яваад байгаа ийм сурагтай л байгаад байгаа юм. Ойлгосноор бол Засгийн газар луу өгчихсөн юм байна гэж ойлгосон. Тэгээд тэнд байгаа яг тэр 6 үзэл баримтлал дотроо яг энэ уур амьсгалтай холбоотой асуудал нь бол уламжлалт байдлаасаа арай өөр түвшинд явж байгаа юм байна гэсэн би ойлголт авсан. Яагаад гэхээр энэ нийтэд ил гараагүй байгаа учраас. Гэхдээ яг энэ гарч байгаа хуулиуд маань тэр судалгаатай нь хэр зэрэг уялдаж байгаа вэ. Тэрийгээ уялдуулсан уу л гэдэг асуултыг асуугаад байгаа юм. Бас нэмэлт тодруулахаар та энэ дээр нэг хариултаа өгөөч.

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ. Болормаа гишүүн.

Э.Болормаа: Энийг ажлын хэсгийн түвшинд бас бид ярилцсан. Ер нь бол Парисын хэлэлцээр бол 2015 онд батлагдсан. Тухайн үед бол Америк манлайлж байсан бол өнөөдөр бас зарим улс орнууд тэр дундаа АНУ бол Парисын хэлэлцээрээс гарсан ийм нөхцөл байдал үүссэн байгаа. Гэхдээ энэ бол шинжлэх ухааныг үгүйсгэхгүй байгаа. Мэдээж улс төрийн шийдвэрүүд олон улсын хэмжээнд геополитикийн шийдвэрүүд байгаа ч гэсэн шинжлэх ухааны нөлөөллийг бол бид үгүйсгэж чадахгүй. Тухайн эдгээр том гүрнүүдийн хувьд бол хамгийн их хүлэмжийн хийн ялгаруулагч улс орнууд. Яг энэ үүсээд байгаа уур амьсгалын өөрчлөлтийг бий болгож байгаа хүлэмжийн хийг дийлэнхийг нь ялгаруулж байгаа улс орнууд. Манайх буюу Монгол Улс дэлхийн энэ агаар мандлын хүлэмжийн хийн ялгарлын 0,1 хувь ч хүрэхгүй. Тэгэхээр бидний энд авч хэрэгжүүлж байгаа бодлого бол бид Монгол Улсдаа ногоон санхүүжилтийг татах, мөн энэ уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эндээ шинжлэх ухааны үндэслэлтэй хариу арга хэмжээнүүдийг авах гэсэн ийм үзэл баримтлалыг бол бариад явж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Батын Батбаатар гишүүн алга байна. Пүрэвжавын Сайнзориг гишүүн алга байна. Хассуурийн Ганхуяг гишүүн алга байна. Мэндбаярын Мандхай гишүүн.

М.Мандхай: Энэ хууль өөрөө маш чухал хууль юм. Ялангуяа Монгол Улсын хувьд бол цөлжилт нэмэгдэж байгаа, уур амьсгалын дулаарал бусад улс орнуудтай харьцуулахад маш өндөр ийм функттэй явж байгаа. Тийм учраас энэ хуулийг бол үзэл баримтлалын хувьд дэмжиж байгаа. Тэгээд хэдэн тодорхой асуулт асууя.

Жишээлбэл би сэргээгдэх эрчим хүчийг барилаа гэж бодъё. Ингээд карбон кредитээ тодорхойлж үнэлэхийн тулд маш их хэмжээний суурь судалгаа, шаардлагатай тэр хэмжих үзүүлэлтэд нь тоног төхөөрөмж, тоноглолууд гээд надаас зардал гарна. Тэгээд карбон кредитээ үнэлүүллээ. Жишээлбэл, Япон улс гэхэд доод тал нь 10 мянган тонныг бууруулах ийм шаардлага тавьж байгаа. Тэгсэн тохиолдолд карбон кредитэд чинь мөнгө өгье гэхчээ байгаа юм. Тэгэхээр энэ уур амьсгалын тухай хууль дээр татварын зохицуулалт ер нь маш хангалтгүй туссан харагдаад байна. Тэгэхээр энийг яаж уях юм бэ. Одоо жишээлбэл би карбон кредитээ аваад, над дээр орлого бүртгэгдэхээр бусад орлого гээд ороод ирчихнэ. Тэрэн дээр би татвар авах гээд байгаа байхгүй юу. Над дээр. Жишээлбэл тоноглол, тоног төхөөрөмжийг би карбон кредитийг тооцуулахын тулд оруулж ирэхээр НӨАТ надаас суутган тооцох гээд байна. Энийг ингээд хөнгөлөх ямар механизм байгаа юм бэ.

2 дугаарт бусад орлого гээд карбон кредитээс орлого ороод ирэхээр татварын тэр ногоон санхүүжилт гэдгээрээ хөнгөлөлт үзүүлэх механизм нь юу байгаа юм бэ. Энийг тодорхой асууя.

2 дугаарт энэ уур амьсгалыг тэсвэртэй байлгахын тулд хөдөө аж ахуйтай уямаар байна. Сая Хөдөө аж ахуйн тухай хууль батлагдсан. Гэтэл энэ нүүрс хүчлийн хийг үйлдвэрлээд байгаа 1 гол салбар чинь хөдөө аж ахуйн салбар байгаад байгаа юм. Тэгэхээр энэ хөдөө аж ахуйн салбартай маш сайн уяж оруулахгүй бол эргээд малчид, хоршоологч нь нийт ялгарлын 51,97 хувийг эзэлж байна гээд энэ нь өөрөө малчин өрхийг буруутгаж байгаа юм шиг ийм тоо харагдаад байгаа юм. Тэгэхээр сая хөдөө, орон нутгаар явж байгаа юм. Малчид яаж карбон кредитээ тооцох юм бэ. Ямар ажлуудыг хийж энэ зах зээлд чинь бизнес эрхэлж оролцох юм бэ. Тэгээд олсон орлогоо яаж хуваарилах юм бэ. Хаашаа энэ мөнгө нь орох юм бэ. Энэ бүх асуудлууд чинь тодорхойгүй байгаа учраас энийг хөдөө аж ахуйдаа маш сайн уях хэрэгтэй. Хөдөө аж ахуйн тухай хууль дээр тогтвортой хөдөө аж ахуй гэдэг бүхэл бүтэн зарчим, бодлогыг тусгачихсан байгаа. Тэгэхээр энэ дээр бас уялдуулж энэ хуулийг илүү үр дүнтэй, яг амьдрал дээр бодит хэрэгжихүйц зүгээр тийм зарчим, бодлого төдий биш, маш хэмжигдэхүйц, хэрэгжихүйц ийм хууль байгаасай гэдэг үүднээс би тодорхой асуулт асуулаа. Тэгээд хариултаа авчхаад тодруулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Хариулъя. Болормаа гишүүн.

Э.Болормаа: Мандхай гишүүний асуултад хариулъя. Бид уур амьсгалын өөрчлөлт гэж ярихад ер нь бол хамгийн гол хэд хэдэн салбарууд байдгын сая 2 чухлыг нь бол Мандхай гишүүн хөндлөө. Сэргээгдэх эрчим хүч, тэгээд ер нь бол хөдөө аж ахуйн салбар бол ялгаруулагч гэж гардаг. Дэлхийн зарим улс орнууд бол хүлэмжийн хийн ялгарлаа бууруулах албан журмын тийм өөрсдөө тааз тогтоосон байгаа. Энэ хуулиар ямар нэгэн тааз тогтоогоогүй. Тэгэхээр ямар нэгэн албан журмын байгууллагууд, аж ахуйн нэгжүүд, иргэд хүлэмжийн хийн ялгарлаа тооцоод, тэдээр бууруул гэдэг таазыг бол тогтоож өгөөгүй. Эсрэгээрээ карбон зах зээл нэвтрэхийг нээж байна гэдэг нь магадгүй Япон улс ч юм уу, Солонгос улсад тэдгээр улсуудад тэдэн хувиар бууруулна гээд зорилт тавиад, тэрийгээ бүр хуулиар дүрэм журам болгоод гаргаад ирсэн бол тэр бууруулалтыг нь Монгол Улсад хийгээд, түүгээрээ бид нар Ногоон санхүүжилт татах боломжтой гэж байгаа юм.

Таны хэлсэн санаа зовнил бол яг Засгийн газрын оруулж ирсэн хуулийн төсөл дээр ямар нэгэн татварын онцгойлсон бодлого бол орж ирээгүй байгаа. Ажлын хэсгийн зүгээс бас салбарын сайдаар ажиллаж байсан Одонтуяа сайд маань, Батбаатар сайд маань гээд нэлээд мэдлэг мэдээлэлтэй хүмүүс бид нар энэ дээр ярилцаад, Лувсанжамц гишүүний оруулж ирсэн зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэн байгаа. Тэр маань юу вэ гэхээр ногоон санхүүжилт гэдгийг бид анх удаа томьёолж, энэ хуульд оруулж ирж байгаа. Тэгээд татварын дэмжлэгийг ч гэсэн энэ дотор оруулна гээд. Тэгэхээр үүнийг баталсны дараа энэ хуулийн хэрэгжилтийн хүрээнд Засгийн газраас нөгөө яг татвартай холбоотой асуудлыг заавал төсөвтөө дагуулаад орж ирэх ёстой гэж Төсвийн байнгын хорооноос хэлсэн учир бид энэ хуульдаа бол оруулж ирэх боломж гараагүй юм. Гэхдээ цаашид орж ирэх үүд хаалгыг нь нээх ногоон санхүүжилтийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг болно гэдгийг бол томьёолж оруулж ирсэн байгаа.

2 дахь асуудал яг малчид яаж энэ карбон зах зээлд оролцох юм бэ гэж маш олон хүмүүс бас энийг асууж байгаа. Тэгээд бид бас буруу хүлээлт өгмөөргүй байна. Маргааш энэ хууль батлагдаад малчид өөрсдөө шууд хүлэмжийн хий бууруулах магадгүй мод тарих төсөл ч юм уу хийгээд, энэнээсээ шууд мөнгө олох боломж гарч ирнэ гэж хэлэх нь хэтэрхий хялбараар бодсон болно. Яг таны хэлснээр энийгээ хэмжих төхөөрөмж гээд нэлээд бас процесстой байдаг олон улсын зах зээлийн шаарддаг стандарт журам нь аягүй өндөр учир хамгийн бодитой хурдан боломж нь юу вэ гэхээр төсөл хэрэгжүүлэгч нар малчидтай хамтран магадгүй хоршоо юм уу, нөхөрлөлтэй хамтраад, энэ газар нутаг дээр бүгдээрээ ийм байгаль орчинд ээлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах төслийг хэрэгжүүлээд, бид орлогоо ингэж хуваана гэдэг энэ шаардлагыг ч гэсэн үүн дотор оруулсан байгаа. Иргэдийн оролцоог хангах. Тэгж малчид шууд эерэг санхүүгийн нөлөө авч болох ийм боломжтой байгаа юм шүү.

Ж.Бат-Эрдэнэ: Мандхай гишүүн тодруулъя.

М.Мандхай: Тэгэхээр Карбон кредит чинь өөрөө ингээд шинэ нэр томьёо. Шинэ ийм хэрэгслүүр учраас мэдээж яг энэ чиглэлээр томоохон аж ахуйн нэгжүүд бол ойлгоод, аль хэдийн бас тодорхой хэмжээний нүүрсхүчлийн хий, энэ ялгарлыг бууруулах төслүүдийг хэрэгжүүлээд, олон улстай холбогдоод карбон кредитийг тооцуулах түвшинд яриад эхэлчихсэн байгаа. Гэтэл манай нөгөө хууль гарчхаад төр нь өөрөө бодлогоороо дэмжих зохицуулалт нь орохгүй бол дахиад энэ хууль хэрэгжихгүй болчих юм. Тэгэхээр одоо яг бизнесүүд асууж байгаа юм. Бид нар яах юм бэ бид нарыг татвараар дэмжээч ээ ногоон санхүүжилт оруулаад ирлээ. Карбон кредитийг тооцуулахад хамгийн их хөрөнгө суурь хөрөнгө зарцуулж байна. Тэгэхээр энийг дэмжихгүй бол энэ хууль өөрөө хэрэгжихгүй ийм эрсдэлтэй байгаа юм гэдгийг хэлж байгаа. Тэгэхээр энэ хууль батлагдаад л ирэх юм бол өөрөө юмнууд нь маш тодорхой, хэрэгжихүйц. Тэгээд .../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Болормаа гишүүн.

Э.Болормаа: Мандхай гишүүнтэй санал нэг байна. Яг энийг бодитой хэрэгжүүлэхийн тулд бид бас аж ахуйн нэгжүүдэд ийм эерэг, байгаль орчинд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулсан дасан зохицох шинж чанартай төслүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ёстой гэж бодож байна. Энэ дээр Засгийн газар үргэлжлүүлээд бас бодлогын арга хэмжээнүүдийг авах байх. Яг энэ асуудал дээр

бол Монгол Улсын Ерөнхий сайд энэ хуулийг бас өөрөө өргөн барихаар бэлтгэж байсан. Энэ дээр бас салбарын сайд Сандаг-Очир сайд нэлээн манлайлалтай, энийг дагаж орж ирэх Засгийн газрын бодлогууд байх болов уу гэж бодож байна.

Тэгээд бид харин ажлын хэсгийн хүрээнд юуг санаачилсан бэ гэхээр үүнийг дагах Их Хурлын тогтоол, “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” буюу Засгийн газарт өгсөн чиглэлүүд байгаа. Энэ дунд яг хэрэгжүүлэх хүрээнд хууль тогтоомжуудын төслийг боловсруулж оруулж ирээч гэсэн ийм чиглэл байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: 1 гишүүн асуулт асуусны дараа санал хураалт явагдана. Тийм болохоор гишүүдийг танхимд урьж байна. Бүлгийн дарга нар гишүүдээ уриарай.

Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууна.

Л.Соронзонболд: Энэ маш чухал. Монгол Улсад бас шинэ зах зээл бий болгож байгаа ийм хуулийн төсөл орж ирсэн. Энийг бол маш сайн дэмжиж байгаа. Яг энэ чиглэлээр бол бас яг Монголд бол бас харьцангуй энэ санхүүгийн байгууллагууд, ялангуяа арилжааны банкнууд бас нэлээн ахиц дэвшил гаргаж ажиллаж байгаа юм болов уу гэж боддог. Хэд хэдэн сэргээгдэх эрчим хүчний чиглэлийн компаниуд, дээрээс нь Барилга, хот байгуулалтын яам бас бест гэрэгэ барилгын сүүлийн ногоон стандартыг тогтоогоод явж байгаа. Ийм хэд хэдэн юмнууд бол байна. Зүгээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас асуух гээд байгаа нь болохоор бол энэ хуулийн төслөөр бол яг энэ уур амьсгалын нөлөөнд хамгийн их автаж байгаа салбар, бүлгээ тодорхойлно гээд байгаа шүү дээ. Энэ дээр эхний ээлжид яг тодорхойлчихсон тийм салбар, бүлэг байгаа юу.

Тэгээд энэ карбон кредитийн шинэ зах зээл бий болсонтой холбоотойгоор аль аль салбарын хооронд хамгийн их шилжүүлэг хийгдэх юм бэ. Энэ талаар ойролцоо тооцоолол байна уу гээд асуух гээд байна.

2 дугаар асуулт Монгол Улсад COP-17 гээд олон улсын цөлжилттэй тэмцэх ийм хурал болох гэж байна. Энэ хурлаас өмнө бол бид энэ хуулийн төслөө батлуулж чадвал бас бид нарт том амжилт. Нөгөө талдаа яг энэ COP-17 тэр цөлжилттэй тэмцэх олон улсын хурлаас бидний хүлээж байгаа үр дүн юу юм бэ. Энэ хуулийн төсөл дээр тусгагдсан байгаа ямар зүйл заалтаар бид нар COP-17 дээр үр дүн гаргана гэж харж байгаа вэ гэ ийм асуулт байна.

Дараагийн асуулт болохоор бол Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар орж ирсэн байгаа. Тэгээд энэ дээр харахаар яг уур амьсгалын барилга байгууламж, үйл ажиллагаанаас нь ялгарч байгаа хүлэмжийн хийн хэмжээг тогтоодог болно гээд. Энийгээ болохоор энэ хууль батлагдсан өдрөөс эхэлж мөрдөнө гэж байгаа юм. Яах вэ зүгээр мэдээж яамд хоорондоо мэдээлэл солилцсон байдаг байх. Зүгээр Барилга, хот байгуулалтын яам жишээлбэл яг энэ шинээр олгож байгаа барилгын зөвшөөрөл, баригдаж байгаа барилгууд, ялангуяа төрийн санхүүжилтээр баригдаж байгаа барилгуудаа энэ асуудлыг ингээд тогтоодог болох гээд байна шүү дээ. Энэ бэлтгэл ажил хэр хангагдсан байдаг юм бэ гэсэн ийм 3 асуулт асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Асуултад хариулъя. Ажлын хэсгийнхэн хариулъя. 4 дүгээр индэр.

Ш.Батбаяр: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам Батбаяр. Гишүүний асуултад хариулъя. Хуульд хамгийн их хамрагдаж байгаа бүлэг бол ган зудад хамгийн их өртөж байгаа малчид, тариаланчдын бүлэг бол хамгийн их өртөж байгаа. Тэгээд малчид тариаланчид бол төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч, ногоон санхүүжүүлэгч нартай болон орон нутгийн удирдлагуудтай гуравласан гэрээ байгуулж, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлээд, түүндээ оролцоод тодорхой хэмжээний орлогыг тэр төслийн ашгаас хүртэх боломж бүрдэж байгаа.

Мөн 2 дугаарт өртөж байгаа салбар бол эрчим хүчний салбар байгаа. Сая таны хэлсэнчлэн ногоон эрчим хүчний хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломж байгаа. Түрүүн хэлсэнчлэн энэ хуулийн эрх зүйн орчин тодорхой болсноор тоглоомын дүрмээ тодорхой болгосноор манай улсад гарч ирэх ногоон санхүүжилт нэмэгдэх юм. Энэ хүрээгээр бол эрчим хүчний төслүүд Монгол Улсад ихээр нэмэгдэх боломж бүрдэж байгаа гэж үзэж байгаа.

2 дахь нь СОР-17 бол хамгийн их уялдаж байгаа хууль байгаа. Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль нь зөвхөн Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх гэхээс СОР-17 болон Цөлжилттэй тэмцэх тухай конвенцын хэрэгжилттэй нягт уялдаж байгаа. 1 дүгээрт бол дасан зохицох бодлого дээр бол манайх ган, зуд, усны хомсдол, газрын доройтлыг бууруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бий болгож байгаа гэсэн үг. Энэ түрүүн хэлсэнчлэн дасан зохицох төлөвлөгөө болон үндэсний тодорхойлсон зорилтуудаа хэрэгжүүлэх боломж бүрдэж байгаа. Эко системд суурилсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, ой болон бэлчээр, хөрс, нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх, газрын доройтлыг бууруулах зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, зохицуулах бодлогын уялдаа холбоог хангаж өгч байгаа. Карбон зах зээл тодорхой болж байгаа. Бэлчээр, ой, газрын нөхөн сэргээлтийн төслүүдийг карбон зах зээлтэй холбох боломжийг энэ хууль гарснаар бүрдүүлж байгаа. Уур амьсгалын санхүүжилтийг бас нэмэгдүүлэх боломж бүрдэж байгаа. Цөлжилт газрын доройтолтой тэмцэх төсөл хөтөлбөрт олон улсын санхүүжилтийг татах эрх зүйн орчин бүрдэж байгаа. Тэгэхээр бид 8 сарын 17-оос 25-нд зохион байгуулагдах Цөлжилттэй тэмцэх НҮБ-ын конвенцын талуудын 17 дугаар бага хурлын үеэр санаачлан гаргаж байгаа 3 тэргүүлэх санаачилгынхаа хүрээнд энэ хууль хэрэгжүүлэх орчныг нь бүрдүүлж байгаа, суурь хууль болж байгаа гэж үзэж байгаа.

Товчхондоо бол Монгол Улсын тэргүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэх үндсэн хууль, эрх зүйн орчин бүрдчихэж байгаа юм. Тэгэхээр мөн НҮБ-ын суурь 3 конвенц болох Цөлжилттэй тэмцэх уур амьсгалын конвенц, Биологи хамгийн олон янз байдлын энэ 3 конвенцын хүрээнд хийж хэрэгжүүлэх ажлуудыг санхүүжүүлэх, санхүүжилтийг зөвхөн улсын төсөвт найдах биш, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, мөн хувийн хэвшлийн оролцоог хангахад бол томоохон хувь нэмэр, эрх зүйн орчныг тодорхой болгосон хууль болж байгаа гэж үзэж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. Сэддорж гишүүн.

Р.Сэддорж: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Энэ хуулийг дэмжиж байгаа. Тэгэхээр энэ уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их өртөж байгаа бүс нутаг бол

Монгол Улсын газар нутаг, тэр дундаа говийн бүс нутаг. Монгол Улсыг өнөө цаг үед тэжээж байгаа алт, зэс, нүүрсний уурхайнууд говийн бүс нутагт их байна. Одоо нээгдчихсэн байгаа. Говийн ард түмэн бол энэ уурхайнуудыг хөөж туугаагүй нээлгэж, энэ Монгол Улсынхаа төлөө Монгол Улсын төрийн минь сүлд өршөөг гэж нээлгэсэн, одоо ч дэмжсээр байгаа. Энэ нь уул уурхайн сөрөг нөлөөлөл бол маш ихтэй байгаа. Хамгийн их тоостой, хамгийн их бэлчээр нь хашигдсан, шахагдсан, уул уурхайд шахагдсан ийм бүс нутаг, ийм аймгууд бол энэ говийн аймгууд байна. Тэгээд энэ хууль гарснаараа энэ гүний усыг хэрэглэж байгаа, гүний усыг нүүрс угаахдаа хэрэглэж байгаа, зэс угаахдаа хэрэглэж байгаа, баяжуулах үйлдвэртээ хэрэглэж байгаа энэ уурхайнуудыг гадаргын усыг ашиглахад түлхэц болох маягаар ямар заалт оруулж болох вэ. Ийм заалт байна уу. Тэгэхээр уур амьсгалын өөрчлөлтөд өртүүлж байгаа гол зүйл бол гадаргын гүний усыг нь сороод ашиглаад байгаад байгаа юм. Тэгээд сүүлийн үеийн энэ цөлжилтийн судалгаагаар цөлжилт бол маш их эрчимжиж байна. Гар худгууд бол бараг байхгүй боллоо. 200 метр өрөмдөөд ус гарахгүй болсон. Тэр гар худгууд бол хуучин тэр айл, тэр хавийн айлууд бүгдийг нь усаар хангадаг байсан ийм худгууд ширгэчихсэн байна. Тэгэхээр энэ гадаргын усыг авчрах, энэ 2 том говь руу ус татах төслийг дэмжихэд энэ хуульд нөлөөлөх тийм заалт байна уу. Уур амьсгалын өөрчлөлт ч ерөөсөө л энэ усан дээр л байгаа. Тэгээд гүний усыг хойч үедээ үлдээе. Гадаргын усыг 2, 3 хувийг нь энэ уул уурхайн төслүүд дээрээ хэрэглэе гээд бид сүүлийн бараг 20-иод жил ярьж байна. Одоо энэ парламент энэ дээр онцгой анхаарах ийм парламент. Тэгэхээр энэ уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль гэдэг бол гүний усыг хамгаалах, гадаргын усыг ашиглах дээр бол онцгой заалтууд байх ёстой. Тэгээд энэ дээр ямар зүйлүүд байна вэ гэдэг дээр хариулт авъя.

Ж.Бат-Эрдэнэ: Болормаа гишүүн.

Э.Болормаа: Сэддорж гишүүний асуултад хариулъя. Энэ хуулиар 2 ойлголт гарч ирж байгаа нь ногоон санхүүжилт, уур амьсгалын санхүүжилт гэж 2 ойлголт гарч ирж байгаа. Яг одоогоор бол Эдийн засаг, хөгжлийн яаманд Ногоон санхүүжилтийн хэлтэс гэж байгаа боловч яг үүний чиг үүрэг нь бол ямар нэгэн хуулиар зохицуулагдаагүй байгаа. Тэгэхээр яг устай холбоотой төслүүд бол ногоон санхүүжилт, энэ хөрөнгө оруулалтыг татах төслүүд гэж үзэж болно. Тэгэхээр энэ маань юу гэж томъёологдсон байгаа вэ гэхээр байгаль орчны тогтвортой хөгжлийн хүрээнд байгаль орчинд эерэг үр нөлөө үзүүлэх, доройтлыг бууруулах, нөөцийн үр ашигтай хэрэглээг дэмжихэд чиглэсэн тодорхой шалгуур үзүүлэлтэд нийцсэн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг гэж байгаа юм. Үүнийг дагуулаад Эдийн засаг, хөгжлийн яам болон Сангийн яам хамтраад ногоон таксономи гэж зүйлийг бий болгож байгаа юм.

Түрүүн Соронзонболд гишүүн хэлж байсан. Банк, санхүүгийн байгууллагууд бол энэ байгаль орчны төслүүдийн зээл хөтөлбөрүүдийг бол шалгуур үзүүлэлтийг маш тодорхой болгочихсон. Харин бид улсын төсвийн хөрөнгө оруулалтын, төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг энийгээ тодорхойлоогүй байдаг. Тэгэхээр бид нар ногоон таксономын дагуу магадгүй яг саяын таны хэлсэнчлэн говийн бүсэд ийм эерэг үр дагавартай усны төслийг бол энэ ногоон таксономоороо ингэж давуу байдал олгоно. Бид улсын төсвөө ч гэсэн үүгээр цаашдаа хянадаг болно. Энэ ногоон санхүүжилт гэж тооцогдох учир ийм эерэг үр дагавруудыг оруулна гэж ийм боломжийг нээж өгч байгаа гэсэн үг. Үүнээс гадна яг уур амьсгалын санхүүжилт дотроо бид нар хүлэмжийн хийг сааруулах гэж ярьж байгаа. Энэ дотор хүлэмжийн

хийг шингээх гэдэг ч гэсэн нэг хэсэг төслүүд байдаг. Энэ маань юу вэ гэхээр ой, бэлчээр, ургамлын бүрхэвч, хөрс, ус болон бусад эко системийг ашиглах эсвэл геологийн, физикийн технологийн аргаар хүлэмжийн хийгээ агаар мандлаас урт хугацаанд тогтвортой шингээх. Тэгэхээр магадгүй усны төсөл дундаа хүлэмжийн хийг шингээх, цаашаа сааруулах ийм шинж чанартай төслүүдэд ч гэсэн карбон зах зээлээр дамжуулаад санхүүжилт босгох боломжтой болно гэсэн үг.

Ж.Бат-Эрдэнэ: Тодруулъя. Сэддорж гишүүн.

Р.Сэддорж: Баярлалаа. Ямар ч байсан заалтууд байгаа юм байна. Тэгээд энэ гүний усыг хэрэглэж байгаа уурхайнууд, уул уурхайн төслүүд гадаргын усыг авчрахад хувь нэмэр оруулна гэсэн ийм заалт оруулж болох уу. Мэдээж улс орондоо татвараа тушаагаад, ингээд гүний усаа хэрэглэж байна. Тэгэхээр гадаргын усыг ирээдүйд авчрах гээд байна. ТЭЗҮ нь бэлэн болчхонгуут хөрөнгө оруулалтаа босгоно. Тэрэнд яг 1 сая куб метр ус хэрэглэсэн бол 1 сая куб метр ирээдүйд говь руу ирэх усыг санхүүжүүлэхэд тэр төсөлд оролцоно гэсэн ийм заалт оруулах боломж, бололцоо байгаа юу.

Дээрээс нь энэ уул уурхайн төслүүд дээр тэр унаган байгалийг сүйтгэж, тэр унаган амьдралыг өөрчилж байгаа учраас 1 уул уурхайн төсөл, 1 хөдөө аж ахуй, мал аж ахуйн төслийг .../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Хариулах уу. Болормаа гишүүн хариулъя.

Э.Болормаа: Яг энэ устай холбоотой асуудал, үүнтэй холбоотой заалтыг Мөнхбаясгалан гишүүн Байнгын хорооны хурал дээр бас энэ асуудлыг хөндсөн байгаа. Тэгээд бид юу гэж үзсэн бэ гэхээр Усны тухай хуульд бас нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгын асуудал яригдаж байгаа учир тэнд орох нь зүйтэй байх. Энэ өөрөө уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой. Тэгээд цаашид байгаль орчны тухай хууль болон Агаарын тухай хуультай уялдсан ийм хуулийн төсөл учир энэ хуулийн төсөлд орохоос илүүтэйгээр Усны тухай хуулиар зохицуулагдах нь зүйтэй гэж үзсэн байгаа. Тэгээд өнөөдөр бид бас эцсийн хэлэлцүүлэг явж байгаа учир саналын томьёоллуудын санал хураалт явагдах байх.

Харин үүнээс гадна бас бид ажлын хэсэг дээр энийг ярихад байгаль орчны нөлөөллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хаврын чуулганаар бид батлахад бас энэ дээр нэлээн сайн сайн заалтууд орсон байгаа. Энэ давхцалтай байна гэж ажлын хэсгийн зүгээс үзсэн.

Ж.Бат-Эрдэнэ: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо санал хураалтууд явагдана. 17 цаг өнгөрсөн байна. Гишүүдийг танхимд цуглахыг хүсэж байна. Гишүүдээ уриарай. Гишүүдээ урьж байна. Гишүүдийг суутал дараагийн асуудал руу оръё.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтуяа танилцуулна. Одонтуяа гишүүнийг урьж байна.

С.Одонтуяа: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Уур амьсгалын өөрчлөлтийн тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2026 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулах үед “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах талаар зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй холбогдуулан ажлын хэсгээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсэгт заасныг баримтлан уг тогтоолын төслийг боловсруулсан болно.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа дээрх тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Шүрэнчулууны Батбаяр Байгаль орчин, уур амьсгал, өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Цэрэндоржийн Уранчимэг Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн яамны Тусгай хамгаалалтын газар нутгийн бодлогын газрын дарга, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Макро бодлогын эдийн засгийн бодлогын газрын дарга, Саруулын Пүрэвсүрэн Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга, Харнүдэгийн Мөнхзул Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга, Цэндээхүүгийн Мөнхбат Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Тусгай хамгаалалтын газрын нутгийн бодлогын газрын ахлах шинжээч, Алтангэрэлийн Нарангаравуу Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, Баатарын Номун НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлж буй Нүүрстөрөгчийн зах зээлийн бэлэн байдлыг бэхжүүлэх төслийн хуулийн зөвлөх гэж байна.

Та бүхэнд урьд өмнө бас танилцуулсан Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24, 21.25, 21.31-д заасан чуулганы хуралдаанд оролцож байгаа Засгийн газрын гишүүд, ажлын хэсгийн бүрэлдэхүүн үнэн зөв мэдээлэл өгөх үүрэгтэй гэдгийг та бүхэнд танилцуулъя.

Ингээд Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Пүрэвжавын Сайнзориг гишүүн нэр өгсөн байна. Сайнзориг гишүүн асуулт асуухгүй юм байна. Ингээд санал хураалттай. Байнгын хорооны гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Санал хураалтыг нэгдсэн байдлаар явуулна.

Гишүүд санал хураалт явуулахад бэлэн үү. Гишүүдийг чуулганы танхимд урьж байна. Гишүүдийг дуудаарай.

С.Бямбацогт: Гишүүд чуулганд хүрэлцэн ирнэ үү. Санал хураалтуудаа явуулъя. Хуралдаан зохион байгуулах газар, бүлгүүдийн ажлын алба, гишүүдийн зөвлөх, туслахууд гишүүдээ чуулган танхим руу явуулна уу. Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлтгэнэ үү. Ирц бүртгэлийн санал хураалт. Санал хураалт. Татгалзсан гарч байгаа 41 гишүүн байна. Энэ 41 гишүүнийг чуулганы танхимдаа хүрэлцэн ирэхийг урья. Танхимд одоогоор 65 гишүүн байна.

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Гишүүд хурууны хээг уншуулж, санал хураалтдаа бэлдсэн байна. Санал хураалт явуулъя.

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 99 гишүүн орсноос 64 гишүүн буюу 64,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн 5 хуулийн төсөл байгаа.

1.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 99 гишүүн оролцсоноос 63 гишүүн буюу 63 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 99 гишүүн орсноос 68 гишүүн буюу 68 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 99 гишүүнээс 70 гишүүн буюу 70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 99-өөс 67 буюу 67 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 99-өөс 69 буюу 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

17.36 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Төрийн өмчит компанийн бүтээмж, засаглалыг сайжруулах тухай хуулийн төслийн санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Зарчмын зөрүүтэй 25 санал байгаа.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгасан санал:

1.Төслийн нэрийн “бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах” гэснийг “засаглалын” гэж, 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “хяналт, ил тод байдал, засаглалыг сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэхтэй” гэснийг “засаглалыг сайжруулах, хяналтыг хэрэгжүүлэх, ил тод байдлыг хангахтай” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо санал хураалт. 99-өөс 72 буюу 72 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 2.1 дэх хэсгийн “бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах” гэснийг “засаглалын” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. 99-өөс 73 буюу 73 хувийн саналаар санал дэмжигдлээ.

33.Дээрх 1, 2 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан энэ хууль болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийн “бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах” гэснийг “засаглалын” гэж тухай бүрд өөрчлөх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. 99-өөс 73 буюу 73 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай “Тайлбар” хэсэг нэмэх:

“Тайлбар:- Энэ хуульд заасан “үр ашигтай байх” гэж арилжааны зорилго бүхий төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьд оруулсан капиталын өгөөжийг капиталын жигнэсэн дундаж өртгөөс өндөр түвшинд байхаар үйл ажиллагаа явуулж, компанийн урт хугацааны үнэ цэнийг нэмэгдүүлэхийг ойлгоно. Нийтийн үйлчилгээний төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьд нийтийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай, тасралтгүй, боломжит бага зардлаар үзүүлэхийг ойлгоно.

Тайлбар:- Энэ хуульд заасан “зах зээлд шударга өрсөлдөх, аливаа хэлбэрээр давуу эрх эдлэхгүй байх” гэж хуульд зааснаас бусад тохиолдолд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхгүй, төрийн болон орон нутгийн өмчийг зах зээлийн үнэ, нөхцөлөөс доогуур ашиглахгүй, зөвшөөрөл, эрх олгох болон төрийн худалдан авах ажиллагаанд давуу эрх эдлэхгүй, дампуурал, төлбөрийн чадваргүйдлийн нийтлэг журмаас үндэслэлгүй чөлөөлөгдөхгүй байхыг ойлгоно. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. 99-өөс 69 буюу 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 6 дугаар зүйлийн гарчгийн “, хэлбэр” гэснийг хасаж, 6.1,2, 6.2,2 дахь хэсгийн “34-өөс” гэснийг “гуравны нэгээс” гэж тус тус өөрчилж, 6.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.3.Төрийн болон орон нутгийн өмчит компанийг үйл ажиллагааны зорилго, чиг үүргээс нь хамааруулан арилжааны, эсхүл нийтийн үйлчилгээ гэж ангилах бөгөөд энэ талаар тухайн компанийн дүрэмд тусгана.” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. 99-өөс 69 хувийн 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.1.Төрийн өмчит компанийг дараах үндэслэлээр үүсгэн байгуулж болно.

8.1.1.хувийн хэвшил дангаараа гүйцэтгэх боломжгүй, санхүүгийн үр ашиггүй нөхцөл нийтийн үйлчилгээний үүргийг хэрэгжүүлэх;

8.1.2.үндэсний эдийн засгийн ашиг сонирхлыг хангах зорилгоор төрийн нийтийн өмчид хамаарах байгалийн баялгийг ашиглах;

8.1.3.зүй ёсны монопол үйл ажиллагаа эрхлэх;

8.1.4.үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой батлан хамгаалах, хил хамгаалах, харилцаа холбоо, хууль сахиулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг дэмжих, холбогдох аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх;

8.1.5.хуульд тусгайлан заасан бол.” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. 99-өөс 68 буюу 68 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 16 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

16.1.Төрийн болон орон нутгийн өмчит компани нь Компанийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйлд заасан ногдол ашгийн бодлоготой байх бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ батална.

16.2.Ногдол ашгийн бодлогод тухайн компанийн үйл ажиллагааны зорилго, хөрөнгө оруулалтын бүтэц, мөнгөн урсгалын онцлогоос хамааруулан дараах хэлбэрийн аль нэг, эсхүл хосолсон хэлбэрийг тусгана:

16.2.1.аудитлагдсан санхүүгийн тайланд туссан татвар төлсний дараах цэвэр ашгийн тодорхой хувиар;

16.2.2.жил бүр хөрөнгө оруулагчид тогтвортой хуваарилахаар урьдчилан тогтоосон ногдол ашгийн зорилтот хэмжээ болон түүнд тооцох өсөлтийн хувиар;

16.2.3.аудитлагдсан санхүүгийн тайланд туссан хувь нийлүүлсэн хөрөнгө, чөлөөт мөнгөн урсгал, хүү, татвар, элэгдэл, хорогдлын өмнөх ашиг, эсхүл хүү, татварын өмнөх ашиг зэрэг санхүү үзүүлэлтээр урьдчилан тогтоосон хувь хэмжээгээр;

16.2.4.бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлтөөс шалтгаалж урьдчилан тооцоолоогүй орлого бий болсон тохиолдолд түүний урьдчилан тогтоосон тодорхой хувиар.

16.3.Төрийн болон орон нутгийн өмчит компани, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компанийн ногдол ашгийн бодлогод дараах зарчим, шаардлагыг тусгана.

16.3.1.ногдол ашгийг аудитлагдсан санхүүгийн тайланг үндэслэн тогтоох;

16.3.2.компанийн батлагдсан бизнес болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, их засварын хэрэгцээ, нөөц сан бүрдүүлэх шаардлага, санхүүгийн тогтвортой байдлыг харгалзан үзэх;

16.3.3.нийтийн үйлчилгээний үүрэг хүлээсэн бол тухайн үүргийн санхүүжилт, нөхөн төлбөр, татаас, тарифын зохицуулалт, зориулалтын хөрөнгийг ногдол ашиг тооцох сууринаас тусад нь авч үзэх;

16.3.4.компанийн урт хугацааны үнэ цэн, хэвийн үйл ажиллагааг дордуулахгүй байх;

16.3.5.бусад хувьцаа эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх.

16.4.Арилжааны зорилготой төрийн болон орон нутгийн өмчийн компани, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компани нь ногдол ашгийн бодлогод заасны дагуу ногдол ашиг хуваарилах үүрэгтэй.

16.5.Энэ хуулийн 16.4-т заасан компанийн тухайд тухайн жилд хуваарилах ногдол ашгийн зорилтот хувь хэмжээ, ногдол ашиг тооцох хэлбэрийг Засгийн газар, орон нутгийн өмчит компанийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал жил бүрийн төсвийн төсөл боловсруулах үе шатанд компанийн ангилал, салбарын

онцлог, хөрөнгө оруулалтын хэрэгцээ, өр төлбөрийн хэмжээ, мөнгөн урсгал, өөрийн хөрөнгийн өгөөж, нөөц сангийн шаардлагыг харгалзан тогтооно.

16.6.Энэ хуулийн 16.5-д заасан зорилтот хувь хэмжээ нь арилжааны зорилготой компанийн хувьд хуваарилж болох цэвэр ашгийн 30 хувиас доошгүй байх зарчмыг баримтална. Харин компанийн санхүүгийн байдал, хөрөнгө оруулалтын хэрэгцээ, өр төлбөрийн хэмжээ, эсхүл энэ хуулийн 16.8-д заасан үндэслэл байгаа бол уг хувь хэмжээг бууруулж болно.

16.7.Нийтийн үйлчилгээний төрийн болон орон нутгийн өмчит компанид энэ хуулийн 16.6-д заасан доод хувь хэмжээ хамаарахгүй. Компани нь цэвэр ашигтай ажилласан тохиолдолд төлбөрийн чадвар, мөнгөн урсгал, нийтийн үйлчилгээний үүргийн санхүүжилт, үйлчилгээний хүртээмж, чанар, тасралтгүй байдлыг харгалзан ногдол ашиг хуваарилж болно.

16.8.Дараах үндэслэл байгаа бол энэ хуулийн 16.5, 16.6-д заасан зорилтот буюу доод хувь хэмжээнээс бага хэмжээгээр ногдол ашиг хуваарилж болно:

16.8.1.компанийн хэвийн үйл ажиллагааг хангах хүрээнд цэвэр ашгаас дахин хөрөнгө оруулалт хийх зайлшгүй шаардлага үүссэн;

16.8.2.компанийн ногдол ашгийн бодлогод тусгасны дагуу хуримтлагдсан алдагдлыг нөхөх шаардлага үүссэн;

16.8.3.эрх бүхий байгууллагаас тогтоосон өөрийн хөрөнгийн хүрэлцээний шалгуур үзүүлэлтийг хангуулж, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах шаардлага үүссэн.

16.9.Энэ хуулийн 16.8-д заасан үндэслэлээр ногдол ашгийг зорилтот хувь хэмжээнээс бага тогтоох саналыг төлөөлөн удирдах зөвлөл гаргана. Саналд дараах бичиг баримтыг хавсаргана:

16.9.1.аудитлагдсан санхүүгийн тайлан;

16.9.2.төлбөрийн чадварын болон мөнгөн урсгалын дүгнэлт;

16.9.3.зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалтын тооцоолол.

16.10.Энэ хуулийн 16.9-д заасан саналыг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч хянаж, зөвшөөрөх, өөрчлөх, эсхүл татгалзах тухай үндэслэл бүхий шийдвэр гаргана.” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт. 99-өөс 72 буюу 72 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн 23 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 23.4 дэх хэсэг нэмэх:

“23.4.Төлөөлөн удирдах зөвлөлгүй төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьд түүний бүрэн эрхийг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч хэрэгжүүлнэ.” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. 99-өөс 69 буюу 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалтын “авлигын,” гэсний дараа “нийтийн албаны ашиг сонирхлын,” гэж нэмж, 24.1.2 дахь заалтын “тухайн салбарт

5-аас доошгүй жил удирдах албан тушаалд” гэснийг “төрийн өмчит компанийн хувьд удирдах албан тушаалд таваас доошгүй, орон нутгийн өмчит компанийн хувьд удирдах албан тушаалд хоёроос доошгүй жил” гэж, “хууль” гэснийг “эрх зүй” гэж өөрчилж, 24.1.6.а. заалтын “өөрөө” гэснийг “дангаараа” гэж өөрчилж, “дангаараа болон” гэснийг хасах;” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. 99-өөс 70 буюу 70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.4, 24.5, 24.6 дахь хэсгийг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулах:

“24.4.Арилжааны зорилго бүхий төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлүүлэх зөвлөл нь сондгой тооны таваас ес хүртэлх гишүүнтэй байна.

24.5.Энэ хуулийн 24.4-т заасан төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний төрийн болон орон нутгийн төлөөллийн нэг гишүүн нь хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээс санал болгож, томилогдсон этгээд байна.

24.6.Энэ хуулийн 24.4-т заасан төлөөлөн удирдах зөвлөл нь 5 гишүүнтэй бол хоёроос, 7 гишүүнтэй бол гурваас, 9 гишүүнтэй бол дөрвөөс доошгүй нь хараат бус гишүүн байна. Хараат бус гишүүнийг Компанийн тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулна.” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. 99-өөс 71 буюу 71 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн “нийтийн зориулалттай дэд бүтэц,” гэснийг хасаж, “таваас илүүгүй сондгой тооны” гэснийг “таван” гэж, “хоёр хүртэлх гишүүн нь төрийн захиргааны албан хаагч, хоёроос доошгүй нь мэргэжлийн хараат бус гишүүн байж болно” гэснийг “хоёроос доошгүй нь хараат бус гишүүн байна” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. 99-өөс 70 буюу 70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.8 дахь хэсэгт доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24.8.Энэ хуулийн 24.5-д зааснаас бусад төрийн болон орон нутгийн төлөөллийн гишүүдийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилох бөгөөд төрийн захиргааны албан хаагч нэрээ дэвшүүлж, сонгон шалгаруулалтад оролцож болно.” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. 99-өөс 67 буюу 67 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсэгт доор дурдсан өөрчлөн найруулах:

“29.6.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний санал өгөх, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч доор дурдсанаас бусад тохиолдолд оролцож, удирдамж, чиглэл өгөхийг хориглоно:

29.6.1.ногдол ашгийн бодлого батлах, хэрэгжүүлэх;

29.6.2.төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогыг хэрэгжүүлэх.” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. 99-өөс 71 буюу 71 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Дээрх 13 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 29 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 29.7, 29.8, 29.9 дэх хэсэг нэмэх:

“29.7.Төрийн болон орон нутгийн өмчийн төлөөлөл нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ компани ашиг сонирхол, хуульд заасан үүрэг, хариуцлагыг тэргүүн ээлжид баримтлах бөгөөд энэ хуулийн 29.6-д заасан удирдамж, чиглэлийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн баримтлах эсэхийг бие даан шийдвэрлэнэ.

29.8.Төрийн болон орон нутгийн өмчийн төлөөлөл нь энэ хуулийн 29.6-д заасан удирдамж, чиглэлийг баримталсан, эсхүл баримтлаагүй нь түүнийг Компанийн тухай хууль болон бусад хуульд заасан үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

29.9.Энэ хуулийн 29.6-д заасан удирдамж, чиглэлийг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч бүртгэж хадгална.” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. 99-өөс 70 буюу 70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Төслийн 36 дугаар зүйлийн 36.1.1, 36.1.2 дахь заалтын “3” гэснийг “2” гэж, 36.1.3 дахь заалтын “өргөдөл” гэснийг “хүсэлт” гэж, 36.1.13 дахь заалтын “3 жил дараалан хангалтгүй” гэснийг “2 жил дараалан өөрчлөлттэй” гэж тус тус өөрчилж, 36.1.4 дэх заалтын “ноцтой” гэсний өмнө “эсхүл” гэж нэмж, 36.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36.5.Энэ хуулийн 36.1.1-д заасан тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчит нийтийн үйлчилгээний компани, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод төрийн эзэмшлийн хувьцаа эзэмших эрхийг хэрэгжүүлэгч болон төслийн санхүүжилттэй компанид хамаарахгүй.” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. 99-өөс 70 буюу 70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Төслийн 37 дугаар зүйлийн 37.4, 37.5, 37.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“37.4.Төрийн болон орон нутгийн өмчийн компани жил бүрийн санхүүгийн тайлангаа баталгаажуулах, хараат бус мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж гаргуулах зорилгоор санхүүгийн тайлангийн аудит хийлгэнэ.

37.5.Төрийн аудитын байгууллага тайлант жилийн улсын хөгжлийн бодлого, тухайн жилийн санхүүгийн төлөв байдал, урьдчилсан судалгаа, эрсдэлийн үнэлгээг хийж, өмнөх оны гүйцэтгэсэн аудитын дүн, хүний нөөц, төсөв, санхүү бусад хүчин зүйлд үндэслэн санхүүгийн тайлангийн аудит хийх төрийн болон орон нутгийн өмчийн компанийг сонгон гүйцэтгэнэ.

37.6.Төрийн аудитын байгууллагаас энэ хуулийн 37.5-д зааснаас бусад төрийн болон орон нутгийн өмч компанийн санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдэд тавигдах тусгай шаардлагыг Засгийн газарт хүргүүлнэ.” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. 99-өөс 69 буюу 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Дээрх 16 дахь заалт дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 37 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 37.7, 37.8 дахь хэсэг нэмэх:

“37.7.Энэ хуулийн 37.6-д заасан хөндлөнгийн аудит хийх хуулийн этгээдийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журмын дагуу аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээс төлөөлөн удирдах зөвлөл сонгон шалгаруулна.

37.8.Энэ хуулийн 37.1-д заасан өмчлөлийн бодлогод нийцүүлэн тухайн жилд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын хуулийн этгээдээр санхүүгийн аудит хийлгэх төрийн өмчит компанийн жагсаалт болон аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулах этгээдийг Засгийн газар тогтооно.” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. 99-өөс 71 буюу 71 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Төслийн 41 дүгээр зүйлийн 41.3 дахь хэсгийг хасаж, 41.4 дэх хэсгийн “03 дугаар сарын 01-ний” гэснийг “04 дүгээр сарын 15-ны өдөр” гэж өөрчлөх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. 99-өөс 65 буюу 65 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.Төслийн 44 дүгээр зүйлийн дугаарыг 43 болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“43 дугаар зүйл.Энгийн хувьцаа нэмж гаргах, арилжих

43.1.Төрийн болон орон нутгийн өмчит компани нь энэ хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлэн энгийн хувьцаа нэмж гаргаж, дараах хэлбэрээр үнэт цаасны зах зээлд санал болгож хөрөнгө оруулалт татаж болно:

43.1.1.хуульд заасны дагуу нийтэд санал болгох, эсхүл хаалттай хүрээнд санал болгох;

43.1.2.хуульд заасны дагуу үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад давхар бүртгүүлэн санал болгох;

43.1.3.хуульд заасан бусад хэлбэрээр дотоодын болон гадаадын үнэт цаасны зах зээлд санал болгох.

43.2.Энэ хуулийн 43.1-д заасан шийдвэрийг төрийн өмчийн компанийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчит компанийн хувьд тухайн шатын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гаргана. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн хувьд Компанийн тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

43.3.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн энгийн хувьцааг нийтэд санал болгох ажиллагааг дараах зорилгоор хэрэгжүүлнэ:

43.3.1.компанийн үйлдвэрлэл, үйл ажиллагааг өргөжүүлэх, техник технологийн шинэчлэл хийх, өрсөлдөх чадвар, санхүүгийн чадавх, тогтвортой байдлыг дээшлүүлэх;

43.3.2.компанийн засаглал, ил тод байдал, хяналтыг сайжруулах, олон нийтийн оролцоог хангах;

43.3.3.Монгол Улсын иргэн, Үндэсний баялгийн сан, Тэтгэврийн сан болон хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх;

43.3.4.газрын хэвлийн баялгийн өгөөжийг Монгол Улсын иргэн бүрд хүртээмжтэй, ил тод, зах зээлийн зарчмаар хүргэх;

43.3.5.төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогыг хэрэгжүүлэх.

43.4.Энэ хуулийн 43.3.1-43.3.5-д заасан зорилго болон 43.6.2-т заасан зарчмыг хангах хүрээнд төрийн болон орон нутгийн өмчит компанийн энгийн хувьцааг нийтэд санал болгохдоо хөрөнгө оруулагчийн төрлийг дараах байдлаар дангаар болон хослуулан тогтоож болно:

43.4.1.Монгол Улсын иргэн;

43.4.2.мэргэжлийн хөрөнгө оруулагч;

43.4.3.стратегийн хөрөнгө оруулагч;

43.4.4.бусад хөрөнгө оруулагч.

43.5.Энэ хуулийн 43.4-д заасны дагуу хөрөнгө оруулагчдын төрөл, захиалгын доод болон дээд хэмжээ, хуваарилалтын аргачлал, төвлөрлөөс сэргийлэх арга хэмжээ болон шаардлагатай тохиолдолд нэг этгээдийн эзэмших дээд хэмжээг төрийн өмчит өмчийн компанийн хувьд Засгийн газар, Орон нутгийн өмчийн компанийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал мэргэжлийн оролцогчийн санал, дүгнэлтийг үндэслэн тогтооно. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн хувьд мэргэжлийн оролцогчдын санал, дүгнэлтийг үндэслэн Компанийн тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

43.6.Төрийн өмчит компанийн энгийн хувьцааг нийтэд санал болгоход дараах зарчмыг баримтална:

43.6.1.шударга, ил тод оролцох боломж олгох;

43.6.2.дангаар болон холбогдох этгээдэд хувьцаа эзэмшигчийн хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх;

43.6.3.хувьцааны үнэ, үнэлгээ, эрсдэл, ногдол ашиг, саналын эрх, хязгаарлалт, захиалгын нөхцөлийг нийтэд хүртээмжтэй мэдээлэх;

43.6.4.захиалга давсан тохиолдолд хувьцааг урьдчилан зарласан журмын дагуу хуваарилах;

43.6.5.Монгол Улсын иргэний хувьцааг богино хугацаанд төвлөрүүлэн худалдан авах, дамжуулан худалдах, зах зээлийн урвуулан ашиглах эрсдэлээс сэргийлэх зохицуулалт хийх;

43.6.6.Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан бусад энгийн хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хуульд өөрөөр заавал хангах.

43.7.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааг дараах хэлбэрээр арилжиж худалдаж болно:

43.7.1.үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьд төрийн болон орон нутгийн эзэмшлийн энгийн хувьцааг хоёрдогч зах зээл дээр арилжих;

43.7.2.дуудлага худалдаа, уралдаант шалгаруулалт, хэлэлцээрийн аргаар стратегийн хөрөнгө авс худалдах;

43.7.3.өөр төрлийн үнэт цаас, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр солих;

43.7.4.хуульд заасан бусад.

43.8.Энэ хуулийн 43.7-д заасны дагуу төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцааг арилжих, худалдах шийдвэрийг Засгийн газар, орон нутгийн өмчит компанийн орон нутгийн эзэмшлийн хувьцааг арилжих, худалдах шийдвэрийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хувьцаа эзэмшигчийн хувиар гаргана.

43.9.Энэ хуулийн 8.1.2-т заасан төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцааг худалдах, арилжих шийдвэрийг Улсын Их Хурал гаргана.

43.10.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмжийг нэмэгдүүлэх, ур чадвартай ажлыг тогтвортой ажиллуулах, дотоод хяналтыг сайжруулах зорилгоор Компанийн тухай хуульд заасны дагуу компанийн ажилтнууд опцион эзэмших хөтөлбөр хэрэгжүүлж болно.

43.11.Энэ хуулийн 43.10-д заасан хөтөлбөрийн нөхцөл, эзэмшлийн дээд хэмжээ, шилжүүлэх хязгаарлалт, хэрэгжүүлэх хугацаа, шалгуур үзүүлэлтийг төлөөлөн удирдах зөвлөлийн саналын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурал Засгийн газрын зөвшөөрлийг үндэслэн батална.” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. 99-өөс 70 буюу 70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

20.Төслийн 51 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 51.3, 51.4, 51.5 дахь хэсэг нэмэх:

“51.3.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийг энэ хуулийн 8.3-т заасан үндэслэлд нийцүүлэн нийцүүлэх арга хэмжээг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгуулна.

51.4.Энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан зохицуулалтыг 2028 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл хугацаанд үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

51.5.Энэ хуулийн хүчин төгөлдөр болохоос өмнө үүсгэн байгуулагдсан уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн өмчит компанид энэ хуулийн 8.3-т заасан зөвшөөрөл хамаарахгүй.” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. 99-өөс 70 буюу 70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу хураалгасан санал:

1.Төслийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.3.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн дүрэмд Компанийн тухай хуулийн 16.2-т зааснаас гадна компанийн үйл ажиллагаа, зорилго, хүрэх үр дүн, хувьцаа эзэмшигч, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн талаарх мэдээлэл, нийтийн үйлчилгээний үүргийн бодлогыг тодорхой тусгана.” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. 99-өөс 68 буюу 68 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсгийг хасах. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. 99-өөс 65 буюу 65 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 15 дугаар зүйлийн 15.5, 15.6 дахь хэсгийг хасах. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. 99-өөс 64 буюу 64 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32.4.Компанийн гүйцэтгэх удирдлагын хуульд заасан шаардлагыг хангасан хараат бус, мэргэжлийн багаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. 99-өөс 65 буюу 65 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 37 дугаар зүйлийн 37.4, 37.5, 37.6 дахь хэсгийг өөрчлөн найруулах санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед дэмжигдсэн Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах саналыг хүчингүй болгох. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. 99-өөс 67 буюу 67 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

17.59 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Төрийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуультай холбогдуулан боловсруулсан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл байгаа.

Байнгын хороонд гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Санал хураалт явуулъя. Байнгын хорооноос Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 99 гишүүн орсноос 69 гишүүн буюу 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлээ.

18.01 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

“Газар зүйн нэрийн жагсаалт батлах тухай тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалтдаа бэлтгэсэн үү гишүүд ээ. Санал хураалт. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 99-өөс 65 буюу 65 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Тогтоолын төслийг баталсан. Улсын Их Хурлын гишүүд ажлын хэсэгт талархал илэрхийлье.

Монгол Улсад байгаа газар, усны нэрийг Монголоор нэрлэдэг энэ тогтоол батлагдлаа. Гишүүддээ баяр хүргэе.

18.02 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Бизнесийн эрх чөлөө /Эдийн засгийн эрх чөлөө/-ний тухай хуулиудыг нэгтгэж хэлэлцүүлсэн байгаа.

Зарчмын зөрүүтэй 189 санал байгаа. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Засгийн газар Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль гээд өргөн барьчихсан байж байгаад, татаж аваад, буцааж өргөн барихдаа Бизнесийн эрх чөлөө болгоод ороод ирсэн. Манай Цогтгэрэл, Жаргалан, Очирбат нарын гишүүд Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль гэж оруулж ирсэн. Тэгээд ярьж байгаад Эдийн засгийн эрх чөлөөний хууль болгосонтой холбогдуулаад маш олон хуулиуд дээр бизнесийн эрх чөлөө гэсэн үгийг эдийн засгийн эрх чөлөө болгож өөрчилж байгаатай холбоотой олон санал гарсан шүү. Гишүүд бас зөв ойлгоорой.

Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийн нэгтгэсэн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.БИЗНЕСИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ болон ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН нэгтгэсэн төслийн нэрийг **“ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ”** гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батбаатар, Зулпхар, Мөнхсоёл, Одбаяр, Пүрэвдаваа, Пунсалмаа, Сайнзориг, Уянгахишиг, Үүрийнтуяа, Цэнгүүн, Энхтүвшин /цаашид “ажлын хэсэг” гэх/. Санал хураалт. Санал хураалтад 99 гишүүн орсноос 67 гишүүн буюу 67 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1, 1.2 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан өмчлөгчийн эрхийг хамгаалах, бизнесийн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх эрх, эдийн засгийн эрх чөлөөг баталгаажуулах, шударга өрсөлдөөн, бизнесийн орчны тогтвортой байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 69 гишүүн буюу 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Нэгтгэсэн төслийн 2, 3 дугаар зүйлийг нэгтгэн 2 дугаар зүйл болгон доор дурдсан өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Эдийн засгийн эрх чөлөөний хууль тогтоомж

2.1.Эдийн засгийн эрх чөлөөний хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 63 буюу 63 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 64 буюу 64 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Нэгтгэсэн төслийн 5 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 64 буюу 64 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Нэгтгэсэн төслийн 6 дугаар зүйлийг 3 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Эдийн засгийн эрх чөлөөг хангах талаар баримтлах зарчим

3.1.Эдийн засгийн эрх чөлөөг хангахад дараах зарчмыг баримтална:

3.1.1.хуулиар хориглосноос бусад бизнесийн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх;

3.1.2.бизнесийн үйл ажиллагаанд хийх хязгаарлалтад зорилгхүрэхэд тохирсон, боломжит хамгийн бага түвшинд байх;

3.1.3.төрийн зохицуулалт нь тогтвортой, урьдчилан таамаглах боломжтой байх;

3.1.4.шударгаар олж авсан өмчлөх эрхийг хамгаалах;

3.1.5.бизнесийн үйл ажиллагаанд хамаарах мэдээллийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, боловсруулж, ашиглах, хуульд зааснаас бусад тохиолдолд задруулахгүй байх;

3.1.6.хөдөлмөр, оюуны бүтээл, хөрөнгө оруулалтын үр шим, хууль, ёсны дагуу олсон орлогоо чөлөөтэй эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг баталгаажуулах;

3.1.7.хуулийн хүрээнд гэрээг чөлөөтэй байгуулах, түүний агуулгыг бие даан тодорхойлох эрхийг хангах;

3.1.8.хөдөлмөрлөх эрхийг бүрэн хангах, зохистой хөдөлмөрийг дэмжих;

3.1.9.ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний бодлого, зохицуулалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлттэй уялдуулах;

3.1.10.шударга өрсөлдөөнийг үндэслэлгүйгээр хязгаарлахгүй байх, өмчийн хэлбэр харгалзахгүй шударгаар өрсөлдөх боломжийг хангах;

3.1.11.хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчит компани байгуулахгүй байх;

3.1.12.төрийн үйлчилгээ цахим, ил тод, түргэн шуурхай, тэгш, хүртээмжтэй байх, бизнес эрхлэгчээс нэг мэдээллийг нэг удаа авах нөхцөлийг бүрдүүлэх;

3.1.13.нийтийн мэдээллийг хуульд заасны дагуу нээлттэй өгөгдөл болгож ашиглах боломжийг нэмэгдүүлэх;

3.1.14.бизнесийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээнд суурилсан, давхардалгүй, ил тод, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөвлөн туслахад чиглэсэн хяналт шалгалтыг тэргүүн ээлжид хэрэгжүүлэх;

3.1.15.хуульд зааснаас бусад тохиолдолд үнэ тогтоох үйл ажиллагаанд төр алив аливаа хэлбэрээр оролцохгүй байх.

3.2.Эдийн засгийн харилцааг зохицуулсан хууль тогтоомжийг боловсруулан батлахдаа энэ хуулийн 3.1-д заасан эдийн засгийн эрх чөлөөний зарчмыг баримтална.” Санал гаргасан ажлын хэсэг санал хураалт. 99-өөс 66 буюу 66 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Нэгтгэсэн төсөлд доор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл.Эдийн засгийн эрх чөлөөг хангах төрийн бодлого, зохицуулалт

4.1.Төрийн байгууллага, албан тушаалтан бизнесийн үйл ажиллагаанд хийх төрийн зохицуулалтыг боловсруулахдаа бизнес эрхлэгчид үзүүлэх ачаалал, шударга өрсөлдөөний хязгаарлалт, хөрөнгө оруулалтын орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлж, бизнес эрхлэгч, мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн байгууллага, олон нийтийн оролцоог хангана.

4.2.Өмчлөх эрхийг хязгаарлах шийдвэр, үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу хууль, хуулиар эрх олгосон байх шаардлагыг хангасан байна.

4.3.Төрөөс үнэ тогтоох, нийлүүлэлтийг хязгаарлах шийдвэр гаргахдаа энэ хуулийн 3.1.2-т заасныг баримтлах бөгөөд аливаа хязгаарлалтыг зөвхөн хугацаатай тогтооно.

4.4.Тухайн жилийн төсвийн тухай хууль болон түүнийг дагаж боловсруулсан хууль тогтоомжоос бусад хууль тогтоомж нь бизнес эрхлэгчийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, зардлыг нэмэгдүүлэх бол хууль тогтоомжийн дагаж мөрдөж эхлэх хугацаа нь батлагдсанаас хойш 6-аас доошгүй сарын хугацаатай байна.

4.5.Бизнесийн үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль тогтоомж, захиргааны шийдвэрийн үр дагаварт жил тутам шинжилгээ хийж шаардлагагүй, давхардсан, үр ашиггүй зохицуулалтыг багасгана.

4.6.Бизнес эрхлэгчийн ашиг, орлого хөрөнгөд ноогдуулах татварыг хуулиар тогтооно.

4.7.Төр нь бизнесийн үйл ажиллагаанаас үүссэн маргааныг эвлэрүүлэн зуучлал, арбитрын болон бусад шүүхийн бус журмаар шуурхай, шударга, хараат бусаар шийдвэрлэх боломжийг дэмжинэ.

4.8.Төрийн аливаа сонгон шалгаруулах үйл ажиллагаа, төсвийн болон төсвийн бус хөрөнгийн захиран зарцуулалт, худалдан авалт нь бизнес эрхлэгчийн зах зээлд чөлөөтэй, шударга өрсөлдөх боломжийг хангасан байна.

4.9.Мэргэжил эзэмших, дээд болон мэргэжлийн боловсрол, сургалт, ажиллах хүчний шилжилт хөдөлгөөнийг хөдөлмөрийн зах зээл, эдийн засгийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн зохицуулна.

4.10.Төсвийн сахилга батыг сахиж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагуудыг хангаж ажиллана.

4.11.Төр бизнес эрхлэгчийн зөвшөөрөлтэй эрхэлж байгаа үйл ажиллагааг хэвийн, саадгүй явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 66 буюу 66 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Нэгтгэсэн төслийн 7 дугаар зүйлийг 8 дугаар зүйл болгон доор дурдсан өөрчлөн найруулах:

“8 дугаар зүйл.Төрийн бодлого, үйл ажиллагаанд хориглох зүйл

8.1.Эдийн засгийн эрх чөлөөг хангах төрийн бодлого, үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:

8.1.1.үндэсний аюулгүй байдал, хүний үндсэн эрх, эрх чөлөө, хүн амын эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах зорилгоор нийтийн ашиг сонирхол, шударга өрсөлдөөнийг хамгаалахаас бусад тохиолдолд эдийн засгийн эрх чөлөөг хязгаарласан, хориглосон хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, дүрэм, журам, норм, стандартын баримт бичиг батлан гаргах;

8.1.2.бизнес эрхлэгчийн ажил хэргийн нэр хүндэд халдах, үндэслэлгүй хуурамч мэдээлэл түгээх;

8.1.3.бизнес эрхлэгчийн нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд албадан оролцуулах;

8.1.4.хуульд зааснаас бусад тохиолдолд зарим бизнес эрхлэгчид давуу эрх олгосон захиргааны хэм хэмжээний акт, дүрэм, журам батлах, үйл ажиллагаа явуулах, эс үйлдэхүй гаргах;

8.1.5.энэ хуульд заасан зарчмыг зөрчиж эдийн засгийн эрх чөлөөг хязгаарласан хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт батлах, эс үйлдэхүй гаргах;

8.1.6.бизнесийн үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөх, оролцох, үндэслэлгүй хяналт шалгалт хийх, өмч хөрөнгийг нь хууль бусаар хураан авах, дайчлах;

8.1.7.бизнес эрхлэгчид төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хууль, захиргааны хэм хэмжээний актад зааснаас бусад баримт бичиг, түүний бүрдлийг шаардах;

8.1.8.бизнес эрхлэгчийн үйл ажиллагаанд хуульд заагаагүй хяналт шалгалт хийх, хяналт шалгалтын тогтоосон хугацааг хэтрүүлэх.

8.2.Хувийн өмчийг нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хураах, дайчлан авах төрийн шийдвэр нь зөвхөн зах зээлийн бодит үнэлгээнд үндэслэсэн нөхөх олговор бүрэн төлөгдсөн тохиолдолд хэрэгжинэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Маш чухал санал хураалт байна шүү. 99-өөс 65 буюу 65 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Нэгтгэсэн төслийн 2 дугаар бүлгийн нэрийг **“ХОЁРДУГААР БҮЛЭГ” “ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА”** гэж өөрчилж, төслийн 4 дүгээр зүйлийн өмнө шилжүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 99-өөс 63 буюу 63 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Нэгтгэсэн төслийн 8 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 64 буюу 64 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Нэгтгэсэн төслийн 3 дугаар бүлгийн нэрийг **“ГУРАВДУГААР БҮЛЭГ” “ХАРИУЦЛАГА, ИЛ ТОД БАЙДАЛ, ХЯНАЛТ”** гэж өөрчилж, төслийн 5 дугаар зүйлийн өмнө шилжүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 64 буюу 64 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Нэгтгэсэн төслийн 9 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 62 буюу 62 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Нэгтгэсэн төслийн 10 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 59 буюу 59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Нэгтгэсэн төслийн 11 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 61 буюу 61 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Нэгтгэсэн төслийн 12 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 62 буюу 62 хувиар санал дэмжигдлээ.

16.Нэгтгэсэн төслийн 13 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 63 буюу 63 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Нэгтгэсэн төслийн 14 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 64 буюу 64 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Нэгтгэсэн төслийн 15 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 65 буюу 65 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.Нэгтгэсэн төслийн 16 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 62 буюу 62 хувийн саналаар санал дэмжигдлээ.

20.Нэгтгэсэн төслийн **“ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ” “ХАРИУЦЛАГА, ШҮҮХИЙН ХАМГААЛАЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ, ХЯНАЛТ”** гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 63 буюу 63 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21.Нэгтгэсэн төслийн 17 дугаар зүйлийг 5 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Хариуцлага.

5.1.Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэр, үйл ажиллагаа, үйлдэл, эс үйлдэхүйгээс бизнес эрхлэгчид учирсан хохирлыг төрөөс хуульд заасны дагуу нөхөн төлнө.

5.2.Энэ хуулийг зөрчсөн төрийн байгууллага, албан тушаалтан, хүн, хуулийн этгээд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.” Санал гаргасан Ажлын хэсэг. 99-өөс 64 буюу 64 хувийн саналаар санал дэмжигдлээ.

22.Нэгтгэсэн төслийн 18 дугаар зүйлийг 7 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7 дугаар зүйл.Гомдол гаргах эрх

7.1.Аж ахуй эрхлэгч төрийн хууль бус шийдвэр, үйл ажиллагаанд гомдол гаргах эрхтэй бөгөөд төрийн байгууллага гомдлыг хуульд заасан хугацаанд шуурхай шийдвэрлэх, эрхийг сэргээх, нөхөн төлбөрийг барагдуулах үүрэгтэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Чухал заалт байна шүү. 99-өөс 66 буюу 66 хувийн саналаар санал дэмжигдлээ.

23 дугаар санал хураалт дээр ажлын хэсгийн ахлагч Энхтүвшин гишүүний микрофон өгье. Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Энэ дээр 1 санал байгаа юм. Энэ зүйлийг ажлын хэсэг дээрээ боловсруулж байх явцад эшлэл татсан байгаа. Энэ заалт нь өөрчлөгдсөн. Энэ зүйлийн 6.4.4 дэх заалтын энэ хуулийн 3.1.12-т заасны дагуу гэснийг хасаж, санал хураалгах ийм саналтай байна. Энэ зүйл заалт нь өөрчлөгдчихсөн гүйцээн боловсруулах чиглэл авъя.

С.Бямбацогт: Гүйцээн боловсрох чиглэл өглөө. 23 дугаар санал дээр ажлын хэсэг, Байнгын хороонд.

24.Нэгтгэсэн төслийн 20 дугаар зүйлийг хасах. Санал хураалт. 99-өөс 64 буюу 64 хувийн саналаар санал дэмжигдлээ.

25.Нэгтгэсэн төслийн **“ТАВДУГААР БҮЛЭГ” “БУСАД”** гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 62 буюу 62 хувийн саналаар санал дэмжигдлээ.

26.Нэгтгэсэн төслийн 21 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс. 58 буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

27.Нэгтгэсэн төслийн **“ЗУРГАДУГААР БҮЛЭГ” “БУСАД ЗҮЙЛ”** гэснийг **“ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ” “БУСАД”** гэж өөрчилж, төслийн 9 дүгээр зүйлийн өмнө шилжүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 63 буюу 63-ын саналаар санал дэмжигдлээ.

28.Нэгтгэсэн төслийн 22 дугаар зүйлийг 9 дүгээр зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

9.1.Энэ хуулийг зөрчсөн төрийн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

9.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 66 буюу 66 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ажлын хэсгийн ахлагч Энхтүвшин гишүүнд микрофон өгье.

Д.Энхтүвшин: Би нэг юм тэмдэглүүлэх гэсэн юм. Өчигдөр Байнгын хорооны хуралдаан дээр хуулийн хүчин төгөлдөр мөрдөж эхлэх хугацааг тодорхой болгож, санал хураалгах байсан ч уг хуулийг ердийн горимоор мөрдөх нь зүйтэй гэж үзээд зарчмын зөрүүтэй саналаа татсан байгаа. Тэгээд энэ талаар хуралдааны тэмдэглэлд тусгуулах хүсэлтэй байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Гүйцээн боловсруулах гэсэн үү. Ажлын хэсгийн ахлагчийн хэлсэн саналыг протоколд тэмдэглэлээ.

Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Нэг.Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал:

Нэг.Авто замын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 4 дүгээр зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 67 буюу 67 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Авто тээврийн тухай хуульд өөрчлөлт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 2 дугаар зүйлийн 15 дугаар зүйлийн 15.9 дэх хэсэг, 15.9.6 дахь заалтын “Олон улс,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 66 буюу 66 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн “хассугай” гэсний өмнө “, мөн зүйлийн 15.9.7 дахь заалтын “, татварын өргүй байх” гэснийг тус тус” гэж нэмэх. Санал гарсан ажлын хэсэг. 99-өөс 66 буюу 66 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 6 дугаар зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 63 буюу 63 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гурав.Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 2 дугаар зүйлийн “18 дугаар” гэсний өмнө “7 дугаар зүйлийн 7.1.10 дахь заалтын дугаарыг “7.1.11” гэж,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 99-өөс 65 буюу 65 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 7.2 дахь хэсгийн “эрх бүхий” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 62 буюу 62 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 63 буюу 63 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дөрөв.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “2024-2028 онд 90 хувиар, 2029-2031 онд” гэснийг “2024-2034 онд 90 хувиар, 2035-2040 онд” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 62 буюу 62 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн “дагаж мөрдөнө.” гэсний дараа “Энэ хуулийн 22 дугаар зүйлийн 22.5.17 дахь заалтыг 2041 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл дагаж мөрдөнө.” гэсэн өгүүлбэр нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 62 буюу 62 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн бизнесийн гэснийг эдийн засгийн гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 59 буюу 59-ийн саналаар санал дэмжигдлээ.

Тав.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 32 дугаар зүйлийн “дэвшилтэт технологи” гэсний өмнө “газар тариалан,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 60 буюу 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 57 буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зургаа.Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 29¹-дүгээр зүйлийн 29¹.18 дахь хэсгийн “зөвшөөрлийн гэрчилгээг” гэснийг “зөвшөөрлийг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 62 буюу 62 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “25.6 дахь” гэсний өмнө “25 дугаар зүйлийн” гэж нэмж, мөн зүйлийн “8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “амьтныг сэргээн нутагшуулах” гэсний дараа “, өсгөн үржүүлэх” гэж,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 59 буюу 59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 6 дугаар зүйлийн “хэсэг, 36 дугаар зүйлийн 36.4 дэх” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 59 буюу 59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 7 дугаар зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 58 буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Долоо.Арбитрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийг хууль санаачилагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 58 буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найм.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 26.9.4 дэх заалтын “архивын” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 58 буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “26.3.4 дэх заалтын “аюулын” гэснийг “аюулгүй байдлын” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. 99-өөс 59 буюу 59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.2.5.тамхины хамаарлаас гарах эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

5.2.6.тамхины хэрэглээ болон тамхины хяналтын талаар хүн амд чиглэсэн сургалт, сурталчилгаа, эрүүл мэндийн боловсролын үйл ажиллагааг зохион байгуулах.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 100-аас 68 буюу 68 саналаар санал дэмжигдлээ.

9.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5 дугаар зүйлийн 5.3.1 дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 100-аас 64 буюу 64 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5 дугаар зүйлийн 5.3.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.3.2.бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын орчин дахь тамхины хяналтыг боловсролын салбарын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээд хэрэгжүүлэх.” Санал хураалт. 100-аас 64 буюу 64 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5 дугаар зүйлийн 5.3.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.3.3.мэргэжлийн байгууллагын судалгаанд үндэслэн бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын орчин дахь тамхидалтыг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авах,” Санал хураалт. 100-аас 63 буюу 63 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалтын “бүх шатын боловсролын” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 17 дугаар зүйлд заасан боловсролын байгууллага болон бүх түвшний боловсролын сургалтын” гэж өөрчлөх. Санал хураалт 100-аас 64 буюу 64-ийн саналаар санал дэмжигдлээ.

13.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5 дугаар зүйлийн 5.4 дэх заалтын “үр дүнтэй” гэснийг хасах. Санал хураалт. 100-аас 65 буюу 65-ын саналаар санал дэмжигдлээ.

14.Төслийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалтын 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсгийн “хүнс, хөдөө аж ахуйн” гэснийг “хүнсний” гэж, мөн зүйлийн 5.5,3, 5.6.2 дахь заалтын “заасныг хэрэгжүүлэх” гэснийг “заасан зарчмыг баримтлах” гэж тус тус өөрчлөх. Санал хураалт. 100-аас 64 буюу 64 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Төслийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалтын 6 дугаар зүйлийн 6.7.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.7.2.энэ хуулийн 3.1.1.а-д заасан янжуур тамхи болон түүнтэй адилтгах бусад тамхи, 3.1.1.б-д заасан тамхийг нэг хайрцагт 20 ширхгээс цөөн тоогоор, эсхүл дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхийг 200 граммаас багаар савлах, энэ хуулийн 3.1.1.в-д заасан электрон тамхины шингэний хэмжээг 10 миллилитрээс ихээр савлах, тамхины шингэнийг дахин цэнэглэх боломжтой байх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 100-аас 57 буюу 57 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Төслийн 7 дугаар зүйлийн “2026 оны 01 дүгээр сарын 01-ний” гэснийг “2027 оны 01 дүгээр сарын 01-ний” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 100-аас 61 буюу 61 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Төсөлд зүйл, хэсэг, заалт хасах, нэмэх саналтай уялдуулан холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, төслийн үг хэллэг, дэс дараалал, нэр томьёог жигдлэх засварыг хийх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 100-аас 65 буюу 65 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах. Санал хураалт. 100-аас 64 буюу 64-ийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6 дугаар зүйлийн 6.7.16 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.7.16.электрон никотин дамжуулах системд тамхи болон гаанаас өөр төрлийн үнэр, амт оруулах бодис, бэлдмэл нэмсэн байх;” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энхнасан. Санал хураалт. Ногоон шүү дээ. 100-аас 60 буюу 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6.7.16 дахь заалтыг бүхэлд нь хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нарантуяа-Нара. Санал хураалт. 100-аас 60 буюу 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6.7.16 дахь заалтад дараах агуулгыг нэмэх:

“Тамхин бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд орц найрлагад хэрэглэхийг хориглосон бодисыг холбогдох техникийн зохицуулалтад шаардал зохицуулалтын шаардлагаа тодорхойлно;” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батбаатар. Санал хураалт 100-аас 61 буюу 61 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6.7.17 дахь заалтад доор дурдсан агуулгатай өгүүлбэр нэмэх:

“2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болон түүнээс хойш төрсөн Монгол Улсын иргэнд тамхи, тамхин бүтээгдэхүүн, никотин агуулсан болон никотин хүргэх зориулалттай бүтээгдэхүүнийг худалдахыг хориглоно. Энэ хэсэгт заасан этгээдэд тамхи, тамхин бүтээгдэхүүн, никотин агуулсан болон никотин хүргэх зориулалттай бүтээгдэхүүн худалдсан, нийлүүлсэн, үнэ төлбөргүй олгосон этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мөнхсайхан.

Мөнхсайхан гишүүн санал гаргасан юм уу. Мөнхсайхан гишүүнд үг өгье.

Т.Мөнхсайхан: Энэ их чухал санал байгаа шүү. Гэхдээ энэ 2010 оноос өмнө төрсөн буюу нас биед хүрсэн ямар нэгэн байдлаар тамхи, тамхин бүтээгдэхүүн хэрэглэж байгаа хүмүүст ямар ч хамааралгүй, холбоогүй заалт. Харин 2010 оноос хойш төрсөн буюу өөрөөр хэлбэл өнөөдөр 16 наснаас хойш бага настай, шинээр төрж байгаа хүүхдүүдийг насан туршид нь тамхи, тамхин бүтээгдэхүүн борлуулахгүй байх ийм заалт юм байгаа юм.

Энэ заалтыг бусад өндөр хөгжилтэй, улс орныхоо хүмүүсийн эрүүл мэндэд, эрүүл байхад нь анхаардаг өвчлөлөөс нь сэргийлдэг улсууд ийм заалтуудыг хийгээд эхэлчихсэн байгаа. Англи, Мальдив зэрэг улсууд бол ийм заалтууд оруулаад эхэлчихсэн. Тэгэхээр манай улсад өвчлөлийн нөгөө зүрх судас, хавдрын өвчлөлийн чинь гол шалтгаан нь тамхидалт байгаад байгаа. Тэгэхээр хойч бидний ирээдүй болсон үр хүүхдүүд, ач зээ нараа энэ тамхи хэзээ ч хэрэглэхгүй байх , эрүүл ирээдүйг бүтээхэд маш их чухал заалт байгаа шүү. Тэгээд Байнгын хорооны дэмжээгүй энэ саналыг та бүхэн дэмжихгүй байж төхөөрөмждөө хүрэхгүй байж энэ саналыг босгож өгөхийг та бүхнээсээ хүсье.

С.Бямбацогт: Саналаа тайлбарлаж, үг хэллээ. Санал хураалт. Санал хураалтад 100 гишүүн орсноос 28 гишүүн зөвшөөрч, 28 хувийн саналаар дэмжигдсэнгүй энэ санал.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 7².3 дахь хэсгийг бүхэлд нь хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг. Анхааралтай байгаарай гишүүд ээ. Санал хураалт. Санал хураалтад 100 гишүүн оролцсоноос 56 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6.Төслийн 3 дугаар зүйлийн нэг дэх заалтын 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтыг бүхэлд 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтыг бүхэлд нь доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.1.“Тамхин болон никотин агуулсан бүтээгдэхүүн” гэж тамхины навч, тамхинаас гарган авсан никотин, нийлэг никотин эсхүл никотин агуулсан бусад бодисыг ашиглан хүний биед никотин хүргэх, эсхүл тамхи хэрэглэхтэй адил зориулалтаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг:

3.1.1.а.“утаат тамхи” гэж үйлдвэрийн болон гар аргаар ороож бэлтгэсэн, татах зориулалттай янжуур, навчин тамхи, дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхийг;

3.1.1.б.“халаадаг тамхи” гэж цахилгаан халаагч болон бусад арга, хэрэгслээр асаахгүйгээр сорж татах зориулалттай бүх төрлийн халаадаг тамхи;

3.1.1.в.“электрон никотин дамжуулах систем” гэж никотин, никотин давс, амт, үнэр оруулагч болон бусад химийн бодис агуулсан, эсхүл агуулаагүй шингэнийг цахилгаан хэрэгслээр ууршуулан татах, эсхүл түүнтэй адилтгах аргаар хэрэглэх зориулалттай электрон никотин дамжуулах системийг.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энхнасан. Санал хураалт. 100 гишүүнээс 57 буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 3.1.1 дэх заалтыг бүхэлд нь доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.1.“тамхин бүтээгдэхүүн” /цаашид “тамхи” гэх/ гэж тамхины навч, ургамлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн түүхий эд болгон үйлдвэрлэсэн болон нийлэг аргаар гаргаж авсан никотин, түүний уламжлал дагавар бодис, бохь, химийн бодис агуулсан, амт, үнэр оруулагч нэмсэн, эсхүл нэмээгүй, татах, үнэрлэх, сорох, зажлах, аманд уусгах, биед наах, эсхүл бусад аргаар, дагалдах хэрэгсэл бүхий төхөөрөмжийг ашиглаж болон ашиглахгүйгээр хэрэглэх зориулалттай, хууль тогтоомжид заасны дагуу эмийн бүртгэлд бүртгэгдсэн тамхинаас гаргах эмээс бусад дараах бүтээгдэхүүнийг:

3.1.1.а.тамхины түүхий эд, задгай тамхи, татаж хэрэглэх зориулалттай навчин, дүнсэн, шүүлтүүртэй, шүүлтүүргүй янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи;

3.1.1.б.цахилгаан халаагч болон бусад арга, хэрэгслээр асаахгүйгээр сорж татах зориулалттай бүх төрлийн халаадаг тамхи;

3.1.1.в.никотин, никотин давс, амт, үнэр оруулагч болон бусад химийн бодис агуулсан, эсхүл агуулаагүй шингэнийг цахилгаан хэрэгслээр ууршуулан татах, эсхүл түүнтэй адилтгах аргаар хэрэглэх зориулалттай электрон тамхи.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нарантуяа-Нара. Санал хураалт. 100-аас 63 буюу 63 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

8.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.11."тамхи татах зөвшөөрөгдсөн цэг" гэж энэ хуулийн 3.1.1.а-д заасан бүтээгдэхүүн хэрэглэх цэг болон энэ хуулийн 3.1.1.б болон 3.1.1.в-д заасан бүтээгдэхүүнийг хэрэглэх цэгээс бүрдэх бөгөөд эдгээрийг тусад нь, эсхүл хооронд нь тусгаарлан зохион байгуулсан, тамхи хэрэглэх зориулалтаар тусгайлан бэлтгэсэн талбай, агааржуулалтын тоног төхөөрөмжөөр тоноглогдсон өрөөг.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 100-аас 58 буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 100-аас 48 буюу 48 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

11.Төслийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалтын 5 дугаар зүйлийн 5.8.4 дэх заалтын “барилга байгууламж” гэсний дараа “тус бүр” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 100-аас 61 буюу 61 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

10.Төслийн 3 дугаар зүйлийн 3.5 дахь заалтын 5 дугаар зүйлийн 5.5.1 дэх заалтыг хасах. Санал хураалт. 100-аас 60 буюу 60 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

12.Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалтын 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.4.1.зурагт анхааруулга нь тамхи, тамхин бүтээгдэхүүний техникийн зохицуулалтад нийцсэн байх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 100-аас 56 буюу 56 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

13.Төслийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалтын 6 дугаар зүйлийн 6.7.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.7.2.энэ хуулийн 3.1.1.а, 3.1.1.б-д заасан тамхийг нэг хайрцагт 20 ширхгээс цөөн тоогоор, эсхүл дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхийг 200 граммаас багаар савлах, энэ хуулийн 3.1.1.в-д заасан электрон никотин дамжуулах системийн шингэний хэмжээг 10 миллилитрээс ихээр савлах, шингэн дэх никотины агууламж 30 миллиграмм/миллилитрээс их байх;” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энхнасан. Санал хураалт. 100-аас 56 буюу 56 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

14.Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалтын 6.4.1.дэх заалтыг доор дурдсанаас өөрчлөн найруулах:

“6.4.1.тамхин бүтээгдэхүүний хэрэглэгчийн савлагаа (хайрцаг)-ны нүүрэн талын доод хэсгийн үндсэн гадаргуугийн дор хаяж 70 хувийг, мөн ар талын

доод хэсгийн үндсэн гадаргуугийн дор хаяж 70 хувийг эзэлсэн, тамхин бүтээгдэхүүн хэрэглэхээс үүдэлтэй өвчлөлийн үр дагаврыг дүрслэсэн зураг болон эрүүл мэндийн анхааруулга бүхий бичвэр байрлуулсан байх ёстой. Тамхин бүтээгдэхүүний савлагаан дээрх анхааруулгын бичвэр, дүрслэлийг байрлуулах шаардлагыг холбогдох техникийн зохицуулалтаар тодорхойлно.” Санал гаргасан Батбаатар. 100-аас 61 буюу 61 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

15.Төслийн 5 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энхнасан. 100-аас 56 буюу 56 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

16.Төслийн 7 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Энэхүү хууль 202_ оны сарын-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилнэ. Харин 6.4.1, 6.7.16. дэх заалт нь энэхүү хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 24 сарын дараа хэрэгжинэ.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батбаатар. 100-аас 61 буюу 61 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

Нэг.Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал:

1.Төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 100-аас 65 буюу 65 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал:

1.Төслийг хууль санаачлагчид нь буцаах Санал гаргасан ажлын хэсэг. 100-аас 62 буюу 62 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гурав.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Онцгой албан татварын тухай хууль доор дурдсан агуулгатай хэсэг заалт нэмсүгэй.

1/5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 8, 9 дэх заалт:

8.Электрон тамхины шингэн 1мл,

9.Аманд уусгах, зажлах зориулалттай тамхи 1грамм.

2/6.1².энэ хуулийн 4.1.2-т заасан барааны тогтоосон биет нэгжид дараах хэмжээгээр онцгой албан татвар ногдуулна:

д/д	Онцгой албан татвар ногдуулах барааны нэр, төрөл	Биет хэмжээ	Ногдуулах онцгой албан татварын хэмжээ /төгрөгөөр/					
			2026 он	2027 он	2028 он	2029 он	2030 он	2031 он
1	Татаж хэрэглэх зориулалттай навчин, сигар, янжуур тамхи, тэдгээртэй адилтгах бусад тамхи	20 ширхэг	836	2,000	3,500	5,000	6,000	8,000
2	Халаадаг тамхи	20 ширхэг	836	1500	2625	3750	4875	6000
3	Дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхи, усан хоолойгоор татах зориулалттай тамхи	200 грамм	626	1500	2625	3750	4875	6000
4	Электрон тамхины шингэн	1 миллилитр	0	750	1312.5	1875	2437.5	3000
5	Аманд уусах, зажлах зориулалттай тамхи	1 грамм	0	125	220	315	410	500

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 100-аас 62 буюу 62 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “, халаадаг, шүүлтүүртэй, шүүлтүүргүй янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи” гэснийг “болон янжуур тамхи, тэдгээртэй адилтгах бусад тамхи, халаадаг тамхи” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 100-аас 58 буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсан өөрчлөн найруулах:

“1/5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг:

д/д	Онцгой албан татвар ногдуулах барааны нэр, төрөл	Онцгой албан татвар ногдуулах биет нэгж
1	Бүх төрлийн тамхины шингэн	10 миллилитр
2	Татаж хэрэглэх зориулалттай навчин, шүүлтүүртэй, шүүлтүүргүй янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи	100 ширхэг
3	Халаадаг тамхин бүтээгдэхүүн	100 ширхэг
4	Ууталсан никотин	1 килограмм

2/6.1.энэ хуулийн 4.1.2-т заасан барааны тогтоосон биет нэгжид дараах хэмжээгээр онцгой албан татвар ноогдуулна:

д/д	Онцгой албан татвар ногдуулах барааны нэр, төрөл	Биет нэгж	Ногдуулах онцгой албан татварын хэмжээ /төгрөгөөр/					
			одоо	2026 он	2027 он	2028 он	2029 он	2030 он
1	Татаж хэрэглэх зориулалттай навчин, шүүлтүүртэй, шүүлтүүргүй янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи	100 ширхэг	4,180	6,270	6,897	7,587	8,345	9,180
2	Халаадаг тамхин бүтээгдэхүүнийг тусад нь оруулах саналтай байна: Халаадаг тамхин бүтээгдэхүүн	100 ширхэг	0	3,135	3,449	3,793	4,173	4,590
3	Дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхи	200 грамм	626	939	1,033	1,136	1,250	1,375
4	Бүх төрлийн тамхины шингэн	10 миллилитр	0	3,135	3,449	3,793	4,173	4,590
5	Электрон тамхи төхөөрөмжийн хамт	10 миллилитр	0	3,135	3,449	3,793	4,173	4,590
6	Ууталсан никотинд	1 килограмм		20,900	29,275	35,125	42,150	46,365

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн нар Энхнасан, Нарантуяа-Нара. Санал хураалт. 100-аас 60 буюу 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Онцгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн хүснэгтийн 2 дахь мөрийн “Янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи” гэснийг “Татаж хэрэглэх зориулалттай навчин шүүлтүүртэй, шүүлтүүргүй янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи” гэж, “20 ширхэг” гэснийг “100 ширхэг”, мөн хэсэг дэх хүснэгтийн 3 дахь мөрийн “1 килограмм” гэснийг “200 грамм” гэж тус тус өөрчилсүгэй.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энхнасан, Нарантуяа-Нара. 100-аас 58 буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дөрөв.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал:

1.Төслийн 2 дугаар зүйлийн 6.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтын “хоёр зуун” гэснийг “гурван зуун” гэж, мөн заалтын “хоёр мянган” гэснийг “гурван мянган” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. 100-аас 58 буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тав.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй санал:

1.Төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. 100-аас 60 буюу 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зургаа.“Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээ тогтоох тухай тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Чинбүрэн гишүүн, ажлын хэсгийн ахлагчид микрофон өгье.

Ж.Чинбүрэн: Энэ дээр гүйцээн боловсруулах чиглэл авчихъя.

С.Бямбацогт: Гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

2.Төслийн 2 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал хураалтыг цуцаллаа. Чинбүрэн гишүүн, ажлын хэсгийн ахлагч.

Ж.Чинбүрэн: Дөнгөж сая бид энэний өмнө ярьсан онцгой албан татварыг өөрчлөхтэй холбоотой Евроазийн юутай холбоотой бид гүйцээн боловсруулах юм. Нөгөө хууль маань яаж гарах вэ гэдэгтэй уялдуулж энийг бас гүйцээн боловсруулахгүй бол зөрчилдөх аюул байгаа. Тийм учраас энийг гүйцээн боловсруулах чиглэл авчихъя дарга аа.

С.Бямбацогт: Төслийн 2-ыг бас гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй санал:

1.Төслийн 1 дэх заалтыг бүхэлд нь доор дурдсан өөрчлөн найруулах:

“1.“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтын 24, 85, 96 дугаар бүлэгт доор дурдсан агуулгатай 24.04, 85.43, 96.14 дүгээр зүйл тус тус нэмсүгэй.

24.01.Түүхий тамхи, тамхины хаягдал. 30

24.02.Тамхи эсвэл тамхи орлуулагч агуулсан сигар /cheroots/, үзүүрийг нь тайрсан сигар болон нарийн ороосон сигар /сигарилл/ болон янжуур. 0

24.03.Боловсруулсан бусад тамхи болон тамхи орлуулагч, “нэгэн төрлийн болгосон” буюу “сэлбэгдсэн” тамхи, тамхины ханд болон охь. 0

24.04.Тамхи, дахин боловсруулсан тамхи, никотин агуулсан эсвэл тамхи, никотин орлуулагч агуулсан, асаахгүйгээр сорж татах зориулалттай бүтээгдэхүүн; хүний биед никотин өгөх зориулалттай, никотин агуулсан бусад бүтээгдэхүүн.5

2404.11.Тамхи эсвэл дахин боловсруулсан тамхи агуулсан. 5

2404.11.10.Цахилгаан халаагч хэрэгслээр татах тамхи. 5

2404.12.Никотин агуулсан бусад: 5

-нэг удаагийн электрон тамхи

-цэнэглэгч шингэн

2404.91.амаар хэрэглэх зориулалттай. 5” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нарантуяа-Нара. Санал хураалт 100-аас. 58 буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дэх заалтын хүснэгтийн 85 дугаар бүлгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

85	85.43	8543.40.00	Электрон тамхи болон татах хэрэгсэл, эд анги:	
			- Электрон тамхиний хэрэгсэл шингэний хамт	30
			- Бусад.	30
		8543.90.00	Дагалдах хэрэгсэл, эд анги	30

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг. Санал хураалт. 100-аас. 59 буюу 59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Долоо.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.2026 оны ... дугаар сарын ...-ны өдрийн Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд:

1.1.Тамхины хяналтын тухай хуулиар стандарт, хэм хэмжээний акт батлах эрх олгосон Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллагууд, Стандартчиллын төв байгууллага тус хуульд нийцүүлэн холбогдох дүрэм, журам, стандарт, загварыг Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө шинэчлэн баталж, мөрдүүлнэ.

1.2.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд заасан тамхин бүтээгдэхүүн, түүний орц найрлагыг таних, шалгах зориулалтын лабораторийн тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

1.3.Тамхины хамаарлаас гаргах эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах төлөвлөгөөг Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө боловсруулж, эмчилгээ үйлчилгээг хэвийн явуулах, хуулийн хэрэгжилтийг хангана.

1.4.Тамхи үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн талаарх Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд заасан мэдээллийн нэгдсэн санг бий болгох, уг мэдээллийн санг холбогдох бусад мэдээллийн сантай мэдээлэл солилцдог байх чиглэлд төрийн байгууллагууд хамтран ажиллана.

1.5.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө мөн хуулиар тамхин бүтээгдэхүүнд тооцсон шинэ төрлийн тамхийг Тамхины хяналтын тухай хуулиар хориглосон байдлаар сурталчилсан зар сурталчилгааг хуульд нийцүүлэх арга хэмжээ авах, тамхи үйлдвэрлэх, импортлох, худалдаалахад зүй ёсны монопол болон давамгай байдалтай аж ахуй эрхлэгч байгаа эсэхийг тогтооно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 100-аас 54 буюу 54 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 2, 3 дугаар зүйлийг хасах. Санал хураалт. Санал 100-аас 55 буюу 55 хувийн саналаар дэмжигдсэн байна.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа. Санал хураалт явуулж дууссан.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

20.51 цаг.

Дараагийн асуудал. хоёрхон санал хураалт байгаа шүү гишүүд ээ. Дараад нь өнөөдөр хэлэлцэх асуудлаа дуусгана. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. ¥

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль байгаа.

Зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэн гишүүд үг хэлсэн. Зарчмын зөрүүтэй 6 санал байна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Гишүүд санал хураалтдаа бэлтгэсэн үү.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгасан санал:

1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтыг, 4.1.3 дахь заалтыг “нэг ижил” гэснийг, 4.1.5 дахь заалтын “, болон сайн дурын санаачилгыг хэрэгжүүлэх” гэснийг, 4.1.12 дахь заалтын “Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн дагуу” гэснийг, 4.1.13 дахь заалтыг, 4.1.15 дахь заалтын “зорилгоор ашигладаг” гэснийг, 4.1.16 дахь заалтыг, 4.1.21 дэх заалтын “замаар уур амьсгалын өөрчлөлтийг сөрөг нөлөөллийг

бууруулах бодлого,” гэснийг, 4.1.25, 4.1.27 дахь заалтыг, 4.1.30 дахь заалтын “Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн хүрээнд” гэснийг, мөн заалтын “тохируулга хийж” гэснийг тус тус хасаж, 4.1.3 дахь заалтын “шингээлт эсхүл” гэснийг “шингээх үйл ажиллагаанаас үүссэн” гэж, 4.1.4 дэх заалтын “тогтвортой” гэснийг “арга хэмжээ” гэж, 4.1.6 дахь заалтын “зах зээлийн тогтолцоо” гэснийг “зах зээлийг” гэж, 4.1.14 дэх заалтын “шингээсэн” гэснийг “Хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлсэн” гэж, 4.1.15 дахь заалтын “шаардлагаас” гэснийг “үүргээс” гэж, 4.1.28 дахь заалтын “нэмэр” гэснийг “нэмрийн зорилт” гэж тус тус өөрчилж, 4.1.6 дахь заалтын “худалдах” гэсний дараа “арилжих, дүйцүүлэх” гэж, 4.1.20 дахь заалтын “үйлдвэрлэл” гэсний дараа “үйлчилгээ” гэж, 4.1.28 дахь заалтын “зохицох” гэсний дараа “даван туулах” гэж, 4.1.30 дахь заалтын “нэмж” гэсний дараа “, эсхүл хасаж” гэж, 4.1.32 дахь заалтын “бусад хийг” гэсний өмнө “олон улсын гэрээ, стандартаар хүлэмжийн хий” гэж хүлээн зөвшөөрөгдсөн” гэж, 4.1.33 дахь заалтын “ой, ” гэснийг гэсний дараа “бэлчээр,” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо. Санал хураалт. Булгантуяа гишүүнийг дэмжсэнд авъя. 60.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 4.1.7, 4.1.8, 4.1.10, 4.1.11, 4.1.18, 4.1.19, 4.1.22, 4.1.24, 4.1.26, 4.1.31, 4.1.36, 4.1.37, 4.1.38, 4.1.39 дэх заалтыг доор дурдуулсан өөрчлөн найруулах:

“4.1.12.“даван туулах” гэж уур амьсгалын өөрчлөлт, аюултын үзэгдэл тулгарахад байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тогтолцоо, үндсэн чиг үүрэг, өвөрмөц чанар, бүтцээ хадгалан хариу үйлдэл үзүүлэх, сэргээн зохион байгуулагдах, дасан зохицох чадавхыг;

4.1.7.“карбон кредит” гэж эзэмших, ашиглах, захиран зарцуулах боломжтойгоор баталгаажсан, бүртгэгдсэн карбон нэгжийг;

4.1.8.“карбон нэгж” гэж сааруулалтын үр дүнг нэг тонн хүчилтөрөгчийн давхар ислийн тэнцэлд дүйцэх байдлаар илэрхийлсэн тооцоолол нэгжийг;

4.1.10.“ногоон таксономи” гэж байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн зорилтод хувь нэмэр оруулах эдийн засгийн үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтыг тодорхойлсон нэгдсэн шалгуур, ангиллыг;

4.1.11.“олон талт карбон зах зээл” гэж олон улсын гэрээ, шийдвэрийн хүрээнд төвлөрсөн зохицуулалтаар хэрэгжих, олон улсад хийж шилжүүлэн тооцох, сааруулалтын үр дүнг бий болгох, бүртгэх, шилжүүлэх, худалдах, арилжих, дүйцүүлэх, ашиглах үйл ажиллагааг зохицуулсан зах зээлийг;

4.1.18.“уур амьсгалын өөрчлөлт” гэж байгалийн хүчин зүйл, хүний үйл ажиллагааны улмаас дэлхийн агаар мандлын хийн бүрэлдэхүүн өөрчлөгдсөнөөс үүдэн уур амьсгалд урт хугацаанд гарч буй өөрчлөлтийг;

4.1.19.“уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртөмхий хүн амын бүлэг” гэж уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөлд өртөх эрсдэлтэй, нийгэм, эдийн засаг, эрүүл мэнд, газар зүйн байршлын улмаас түүнд дасан зохицох, даван туулах чадавх хязгаарлагдмал хүн амын бүлгийг;

4.1.22. “уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөл” гэж уур амьсгалын өөрчлөлтийн улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчин, нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаанд нөлөөл үзүүлэх сөрөг өөрчлөлтийг;

4.1.24. “уур амьсгалын санхүүжилт гэж” уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн олон улсын, үндэсний болон орон нутгийн түвшинд төр, хувийн хэвшил, бусад эх үүсвэрээс бүрдсэн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг;

4.1.26. “үндэсний карбон зах зээл” гэж үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хангах хүрээнд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ялгарлаас урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны үр дүнд үүссэн карбон кредитийг бүртгэх, шилжүүлэх, худалдах, арилжих, дүйцүүлэх, ашиглах замаар зохицуулсан зах зээлийг;

4.1.31. “хоёр талт карбон зах зээл” гэж улс хоорондын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжих олон улсад шилжүүлэн тооцох сааруулалтын үр дүнг бий болгох, бүртгэх, шилжүүлэх, худалдах, арилжих, дүйцүүлэх ашиглах үйл ажиллагааг зохицуулсан зах зээлийг;

4.1.36. “хүлэмжийн хий ялгарлаас урьдчилан сэргийлэх” гэж тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх тохиолдолд үүсэх байсан хүлэмжийн хий ялгарлаас зайлсхийх чиглэсэн үйл ажиллагаа;

4.1.37. “хүлэмжийн хий ялгарлыг бууруулах” гэж хүлэмжийн хий ялгарлын хэмжээг багасгахад чиглэсэн үйл ажиллагааг;

4.1.38. “хүлэмжийн хий ялгарлын тэнцэл” гэж тайлант хугацаанд үүссэн хүлэмжийн хийн нийт ялгаралтаас бууруулалт, урьдчилан сэргийлсэн ялгарал болон шингээлтийг хасан гарах цэвэр дүнг;

4.1.39. “хэмжилт, тайлагнал, баталгаажуулалт” гэж хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны үр дүнг баталсан аргачлалын дагуу хэмжих, үр дүнг тайлагнах, тайлагнасан мэдээллийг хөндлөнгийн итгэмжлэгдсэн этгээдэд шалгуулан баталгаажих үйл ажиллагааг; Санал гаргасан Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо. Санал хураалт. 100-аас 59 буюу 59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.1.5 дахь заалтын “хөтөлбөрийг тодорхойлсон” гэснийг “хөтөлбөрт зориулсан” гэж, 7.1.9 дэх заалтын “санхүүжилтийн орлогын урсгалыг” гэснийг “санхүүжилтийг” гэж, 7.1.10 дахь заалтын “үйл ажиллагааг удирдах, зохицуулах” гэснийг “ажиллагааны” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 7.1.3 дахь заалтын “энэ хуульд заасан асуудлаар” гэснийг, 7.1.8 дахь заалтын “хүлэмжийн хий ялгарлын бууралт, шингээлтийн үр дүнг тооцох, баталгаажуулах, тайлагналтай холбоотой” гэснийг, 7.1.9 дэх заалтын “ногоон болон уур амьсгалын санхүүжилтийн орлогын урсгал, үр ашиг, зарцуулалтыг бүртгэх, хянах, тайлагнах, цаашдын төлөвлөлтийг хангах, олон улсын тайлагнал болон ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбоотой” гэснийг, 7.1.10 дахь заалтын “энэ хуулийн 4.1.27-д заасан” гэснийг, 7.1.11 дэх заалтын “бүрэн эрх” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн

7.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 7.1,1, 7.1.2 дахь заалт заалт болгох:

“7.1.1.уур амьсгалын өөрчлөлтийн төлөвлөлт, хэрэгжилтийн салбар хоорондын уялдааг хангах зорилгоор Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний үндэсний хороог байгуулж, ажиллуулах;

7.1.2.Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний хорооны санал, зөвлөмжийг үндэслэн Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөгөөг батлах;” Санал гаргасан Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо. Санал хураалт. 100-аас 59 буюу 59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.7 дахь заалтын “уур амьсгалын” гэсний дараа “өөрчлөлтийн” гэж нэмж, мөн зүйлийн 11.1 дэх хэсгийн “байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүргийн хүрээнд” гэснийг “ус цаг уур, орчны шинжилгээний асуудал эрхэлсэн” гэж, 11.1.2 дахь заалтын “нэмэр” гэснийг “нэмрийн зорилт” гэж, мөн заалтын “хариуцан зохих байгууллагад” гэснийг “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулахаар” гэж, 11.1.3 дахь заалтын “удирдах” гэснийг “удирдлага, зохион байгуулалтыг хангах” гэж тус тус өөрчилж, 11.1.6 дахь заалтын “Парисын хэлэлцээрийн шаардлагад нийцүүлэн” гэснийг, 11.1.10 дахь заалтын “бүрэн эрх” гэснийг тус тус хасаж, 11.1.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.9.сааруулалтын үр дүнгийн урт хугацааны хадгалалт алдагдах, хэтрүүлэн тооцож шилжүүлэх, байгалийн болон бусад хүчин зүйлээс шалтгаалан буцаан алдагдах эрсдэлийг бууруулах зорилгоор төсөл, хөтөлбөрөөс үүссэн баталгаажсан сааруулалтын үр дүнгийн тодорхой хувийг эрсдэлийн санд нөөцлөн, энэ хуулийн 7.1.7-д заасан журмын дагуу буцаан олгох, удирдлага хяналтыг хэрэгжүүлэх;” Санал гаргасан Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо. Санал хураалт. 100-аас 61 буюу 61 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Төслийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх тохиолдолд холбогдох хуульд заасан хүлэмжийн хийн бууруулах арга хэмжээг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгана.” гэснийг хасах. Санал гаргасан Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо. Санал хураалт. 100-аас 61 буюу 61 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6.Төслийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 16.1, 16.4, 16.6 дахь хэсгийг дор дороос өөрчлөн найруулах:

“16.1.Үндэсний зохицуулагч байгууллага энэ хуулийн 12.1, 12.2-т заасан үнэлгээний үр дүнд үндэслэн Үндэсний дасан зохицох төлөвлөгөөг Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтод нийцүүлэн тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулна.

16.4.Холбогдох төрийн захиргааны төв байгууллага, аймаг нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 4.1.19, 4.1.20-д заасан уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртөмтгий салбар, хүн амын бүлгийн дасан зохицох, даван туулах

чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

16.6.Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг, ойлголтыг бүх шатны боловсролын түвшинд эзэмшүүлэх, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, хандлага, оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.” Санал гаргасан Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо. Санал хураалт. Санал хураалтад 100 гишүүн оролцож, 60 гишүүн буюу 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахад Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүллээ.

21.01 цаг.

Дараагийн асуудалдаа орёё.

Уур амьсгалын өөрчлөлтийн хуулийг дагаж “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Санал хураалт явуулъя. Байнгын хорооноос “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр батлах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя 100 гишүүн орсноос 60 гишүүн буюу 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалтыг Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах санал хураалттай хамтатган явуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүллээ.

21.03 цаг.

Дараагийн асуудалдаа орёё.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулна.

Өнөөдөр хэлэлцэх асуудлаа дуусгана шүү гишүүд ээ.

Төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Болдын Жавхлан танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Одоо Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэлэлцэх эсэх, дараа нь бусад асуудлын хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн томилох, чөлөөлөх асуудал байгаа шүү. Энэ 3 асуудлаар өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусна.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 сарын 26-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, дараах санал, дүгнэлтийг танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурлын даргын 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 275 дугаар захирамжаар Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг миний бие ахалж, Улсын Их Хурлын гишүүд Батбаяр, Батболд, Батнайрамдал Наранбаатар, Туваан, Ундраа, Уянга, Мөнхсоёл, Үүрийнтуяа, Эрдэнэбүрэн нарын бүрэлдэхүүнтэйгээр байгууллаа.

Ажлын хэсэг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлтэй холбоотойгоор ашигт малтмалын хайгуул, ашиглалт, баяжуулалтын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, зөвшөөрөл олголт, ил тод байдал, орон нутгийн оролцоо, байгаль орчны хамгаалалт, татвар, төлбөрийн тогтолцоог илүү тодорхой болгох, иргэн, аж ахуйн нэгжид илүү ойлгомжтой, тогтвортой эрх зүйн орчин, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт, орон нутагт ногдох үр өгөөж, төсвийн орлого, хариуцлагатай уул уурхайг бүрдүүлэх зэрэг 50 зарчмын зөрүүтэй санал бэлтгэлээ.

Хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн болон Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар, Цэнгүүн, Бадамсүрэн, Мөнхбаясгалан, Батнайрамдал, Жавхлан нарын гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг нэг бүрчлэн хэлэлцэн санал хураалт явуулж, зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийн хамт та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрөөтэй саналын томъёоллуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Жавхлан гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Гонгорын Дамдинням Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Буриадын Дашпүрэв Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Гүнчинсүрэнгийн Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга, Хүрэлбаатарын Санчигдорж Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Геологийн бодлогын газрын дарга, Пүрэвжавын Баянбаатар Ашигт малтмал, газрын тосны газрын дарга, Намсрайн Мөнхбилиг Үндэсний геологийн дарга, Мөнхсайханы Энхтулга Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн дарга.

Ажлын хэсэгт хууль сануулъя. Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандах ёстой. Улсын Их Хурлын гишүүдийн асуусан асуултад үнэн зөв, бүрэн гүйцэт хариулт өгөх ёстой. Хариулахаас татгалзах, худлаа хариулт өгөх, чуулганы хуралдаанд ирж оролцохгүй бол бас холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцдог болохыг сануулъя.

Улсын Их Хурлын гишүүд байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Энэ хуультай холбоотойгоор Оюутолгойн асуудал нэлээн яригдаж, хөндөгдөж байгаа. Тэгэхээр өнгөрсөн 11 сард болсон Оюутолгойн түр хорооны хурал дээр би ер нь бол энэ Оюутолгой мөнгө хүүлэлт явуулаад байна гэж үзээд, софер дээр нэмэх нь 3 хувь буюу 6,5 хувиас дээшгүй хүүтэй мөнгө гаднаас авах ёстой гэдэг ийм зарчмын зөрүүтэй санал гаргасан. Харамсалтай нь дэмжигдээгүй.

Тэгээд софер гэдэг нь бол олон улсын банкнуудын хоорон дахь хүүгийн хүүг тооцдог ийм үзүүлэлт байгаа. Тэгэхэр энэ дээр софер бол өнөөдрийн байдлаар 3,5 хувь байгаа. Энэ дээр 3 хувь гэхээр 6,5 гэсэн үг л дээ. Тэгэхээр дээрээс нь энэ Рио Тинто компани өөрөө 3А зэрэглэлтэй, дэлхийн зах зээл дээрээс 4,5 хувийн хүүтэй бонд босгодог ийм компани. Гэтэл энэ зээлийгээ бүр 11,2 хувиар ингээд зээлээд явж байна гэдэг бол мөнгө хүүлэлт хийж байна гэсэн үг. Тийм учраас энэ 6,5 хувийн дээд талын хүүтэй байх ёстой гэдэг ийм шаардлагыг би тавиад байгаа юм. Тийм учраас Засгийн газар бол энэ энэ асуудал дээр бол нэлээн хатуу байр суурьтай энэ хэлэлцээр дээр ажиллах ёстой шүү гэж 1 дүгээрт хэлж байгаа юм.

2 дугаарт нь бол энэ ер нь өнгөрсөн 10 мянган жилийн туршид хүн төрөлхтний хэрэглэсэн зэсийн хэрэглээг ирэх 25 жилийн дотор хэрэглэнэ гэж байгаа юм. Ирэх 25 жилийн дотор. Тэгээд манай Монгол Улс урдаа Чили, Австрали, Перу, ОХУ гээд 4 улс урдаа оруулж байгаа. Нөөцөөрөө 4, 5-д ордог. Дээрээс нь манай судлагдаагүй маш их талбайнууд байдаг. Тэгэхээр энэ Монгол бол гайхалтай боломжоор дүүрэн орон байхгүй юу даа. Тэгээд бид нар Оюутолгойн ордыг гэрээ байгуулж байхад үед зэсийн үнэ 5 мянган доллар байсан. Өнөөдөр бараг ингээд удахгүй 15 мянган доллар болно. Ийм сайхан боломжуудыг байж байхад энэ Оюутолгойн цаад Рио Тинто компани ард түмний бас хүсээд байгаа энэ зүйл дээр бас тодорхой нэг байр суурьтай байх ёстой гэдэг ийм зарчмыг хэлээд байгаа юм.

Тэгээд эд баялгаа гаргаад байдаг, өрөнд ороод байдаг. Энэ чинь юу гэсэн үг юм бэ. Энэ чинь бас болохгүй шүү дээ. Хүмүүсийн шаардаад байгаа зөв байхгүй юу. Тэгээд өнөөдрийн энэ эрх баригч МАН-ыг энэ 2028 онд хугацаа нь дуусчихвал ард нь АН гарч ирээд, энэ 5 хувь дээрээ байгаад, бүх юмыг бахь байдгаараа байна гэвэл тэрүүн шиг эндүүрэл байхгүй шүү. Ийм юм байхгүй. Ер нь бол тодорхой хэмжээгээр энэ Засгийн газарт би үүгээр тодорхой шаардлага тавьж байна. Өөрөөр хэлбэл энэ гишүүд сөрөг хүчин ийм зүйлийг шаардаад байна. Тийм учраас энэ мөнгө хүүлэлтээ зогсоо.

Дээрээс нь бас энэ өсөн нэмэгдэх АМНАТ юм уу, энэ Цөмийн энергийн хууль дээр хэрэглэж байсан тэр нөхцөл байдлуудыг хэрэгжүүлэх боломжууд юу байна. Энэ зүйлүүдийг хийх ёстой. Тэгээд ер нь бол 7 жилээр ч билүү нөгөө гэрээгээ эргэн хардаг тэр чагт түгжээг мултлаад авчихсан байж байгаа. Тийм учраас энэ Засгийн газар тодорхой хэмжээгээр энэ хэлэлцээр дээр амжилт гаргаж чадахгүй бол бид нар бас Их Хурлын гишүүд тодорхой тодорхой тогтоолын төслүүдийг, хуулиудыг өргөн бариад явах ийм боломжтой шүү гэж хэлье.

Засгийн газар дээрээс нь Рио Тинто, Оюутолгойд бас яг энэ хэлэлцээр дээрээ анхаарал тавьж, тэр ард түмний хүсээд байгаа тэр зүйлүүд дээр бас тэр очих ингэснээр, ингэснээр .../минут дуусав/

С.Бямбацогт: Үг хэлчихсэн үү, асуулт уу. Дамдинням сайд хариулъя.

Пүрэвдорж даргын асуултад хариулъя. Бүгдээрээ нэг зүйлийг ойлгох хэрэгтэй байна. Рио Тинтогийн хувьд бол бид Ардын нам, Ардчилсан нам, ХҮН нам, Үндэсний эвсэл биш. Бид бүгдээрээ Монголчууд, бид нэг баг. Энэ хүмүүстэй бол манай Засгийн газар яг таны хэлж байгаатай ижилхэн зарчмын байр суурьтай байгаа. Зээлийн хүү өндөр байна. Монгол Улс хүлээн зөвшөөрч чадахгүй гэдэг байр суурийг хатуу илэрхийлж байгаа. Менежментийн төлбөр өндөр байна. Монгол Улс хүлээн зөвшөөрч чадахгүй гэдэг байр суурийг хатуу илэрхийлээд, эхний үр дүнгээ гаргаж чадсан. Зээлийн хүүтэй холбоотой хэлэлцээрийг Сангийн сайд ахлаад ингээд ажиллаж байна. Ойрын үед үр дүн гарах байх гэж хүлээж байна. Менежментийн төлбөртэй холбоотой хэлэлцээрийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд би ахалж байсан. Үр дүнд хүрсэн. Одоо албажуулах ажил нь явагдаж байна. Ногдол ашгаа наашлуулах хэрэгтэй. Олборлолтын үйл ажиллагаа яваад байх тусам Монгол Улс өрөнд ороод, өгөөжөө авч чадахгүй байгаа байдлыг Монгол Улсын Засгийн газар ч хүлээн зөвшөөрөхгүй байгаа. Зэсийн үнэ өндөр байгаа дээр бид 3 эх үүсвэрээр орлогоо авдаг. АМНАТ, татвар, хураамжаараа ингээд аваад явдаг. Ногдол ашгаар аваад явдаг.

Тэгэхээр бид энэ дээр ард иргэд болон Улсын Их Хурлын гишүүдтэйгээ ижилхэн байр суурьтай байгаа гэдгийг танд хэлье. Бид бас хатуу шахалттай байгаа. Бас бидний Их Хурлын хэлэлцүүлгийг тэр хүмүүс хараад сууж байгаа байлгүй. Бас манай Их Хурлын гишүүд юу бодож байгааг бас харж авах хэрэгтэй. Санал нэг байна.

С.Бямбацогт: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Д.Энхтүвшин: Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдуулж байгаа энэ Зөвшөөрлийн тухай хуулиар асуулт байна. Энэ хууль дээр 3 зүйл байгаа юм.

1 дүгээрт нь болохоор баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрөл, маркшейдерийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шинээр нэмж байна. Тэгэхээр Зөвшөөрлийн тухай хуулиар шинээр нэмэгдэж байгаа энэ зөвшөөрлүүд дээр нийтийн сонсгол хийгдэх ёстой. Тэгээд энэ сонсгол хийгдсэнээр шинээр хийж байгаа бүх зөвшөөрлүүд дээр сонсгол хийчхээд, Зөвшөөрлийн зөвлөлөөр орж энийг нэмэх эсэхийг шийднэ. Тэгэхээр сая бас Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль, Бизнес эрх чөлөөний тухай хуулийг дагалдуулж байгаа Зөвшөөрлийн тухай хууль дээр шинээр нэмэгдэж байгаа бүх зөвшөөрлүүдийг Зөвшөөрлийн зөвлөл өнгөрсөн хугацаанд хуралдаагүй учраас бүгдийг нь оруулаагүй хассан байгаа. Тэгэхээр энэ шинээр 2 зөвшөөрөл орж ирж байна л даа. Тэгэхээр энэ дээр шинээр нэмэгдэж байгаа зөвшөөрөлд тавигддаг шаардлага буюу нийтийн сонсголыг хэзээ, хаана, яаж хийж энэ Зөвшөөрлийн зөвлөл хэзээ энэ зөвшөөрөл өгсөн бэ. Энийг яагаад асууж байна гэхээр энэ баяжуулагчдын холбоо, энэ уул уурхайн бүтээгдэхүүн баяжуулагчид энэ аж ахуйн нэгжүүдийн холбоо эд нар болохоор энэ зөвшөөрөлтэй холбоотой асуудал дээр эсрэг байр суурьтай байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр хэлэлцүүлэг, нийтийн сонсгол хийгдээгүй л сонсогдоод байгаа юм. Тэгэхээр энэ талаар мэдээлэл өгөөч.

2 дугаарт нь энэ хуулийн 2 дугаар зүйл дээр болохоор 2 болон 3 дугаар зүйл хоёулаа адилхан. 1 нь болохоор боловсролын байгууллага цөмийн энергитэй холбоотой 4 зөвшөөрөл өгдөг байсныг нь Цөмийн энергийн комисс руу шилжүүлж байгаа энэ заалт, мөн Түгээмэл тархацтай ашигт малтмалыг тусгай зөвшөөрөлд байсныг нь энгийн зөвшөөрөл рүү шилжүүлсэн шилжүүлэлтүүдийг сая Бизнесийн хуулийг дагаж өргөн барьсан Зөвшөөрлийн тухай хууль дээр яг энэ өөрчлөлтүүдийг ингээд оруулчихсан байгаа. Тэгэхээр энэ давхардаж байгаа учраас энэ дээр хууль санаачлагч юм уу, ажлын хэсэг дээр гүйцээн боловсруулагч чиглэл авдаг юм уу, энийгээ эсвэл буцаадаг юм уу. Яг иймэрхүү асуудал шийдэл гаргахгүй бол энэ давхардал үүсэх гээд байна. Яг зүйл заалтыг энэ 2 болон 3 дугаар зүйл дээр түрүүн хэлэлцээд дэмжчихсэн зүйл, заалт ингээд явж байна. Энэ дээр тайлбар саналуудыг сонсьё.

С.Бямбацогт: Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Энэ Улсын Их Хуралд хууль өргөн барихад Хууль тогтоомжийн тухай хуулиараа бүрдлийг Улсын Их Хурлын Тамгын газар бүрэн хянаж байж хүлээж авдаг. Тэгэхээр бүрдлийн хувьд ямар нэг зүйл дутуу байгаа бол хүлээж авдаггүй. Тэгээд бүрдэл хангагдчихсан. 2 дугаарт Засгийн газраар бас бид хэлэлцүүлэхэд бас бүрдэл хангадаг. Тэгээд энэ бүх юм болсон. Зөвшөөрлийн зөвлөлөөр орох ёстой юмнууд нь орсон.

Баяжуулалтын тусгай зөвшөөрөл яагаад хэрэгтэй байгаад байгаа вэ гэхээр хэд хэдэн асуудал үүсчхээд байгаа юм. Хамгийн наад захын жишээ. Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр дээр баригдчихсан байгаа 3 баяжуулах үйлдвэр ямар хуулийн зохицуулалтаар явах нь тодорхойгүй байгаа. Бид нар тэнчээнээс бүртгэлээ явуулж чаддаггүй, хяналтаа явуулж чаддаггүй. АМНАТ-өө бүрэн тооцож чаддаггүй. Жоншны баяжуулах үйлдвэрүүд гээд бас байна. Энэ үйлдвэрүүдийг хянахгүй бол

химийн хэрэглээ, химийн бодисын хэрэглээ, хүний аюулгүй байдал гээд энэ өөрийн орд газаргүй баяжуулалтын үйлдвэрүүдийн хувьд үнэхээр зохицуулалт байхаас өөр аргагүй болчхоод байгаа юм. Арга бар бараа л оруулж ирж байгаа юм. Түүнээс хорьж хянах гээд байгаадаа асуудал алга. Дээрээс нь хэрхэн дэмжих юм, яаж зохион байгуулах юм. Үүсмэл ордын зохион байгуулалтыг хэрхэн зохион байгуулж бид нар ингэж хийх юм. Түүхий эдийн гарал үүсэл нь тодорхойгүй 650 мянган тонн бүтээгдэхүүн хилээр гарчихсан. Юу нь мэдэгдэхгүй, хаанаас гарсан нь мэдэгдэхгүй. Энэ чинь нэг ийм хуулийн хийдэл яваад байгаа байхгүй юу. Тийм учраас энэ баяжуулах үйлдвэрүүд дээр зохицуулж, дэмжиж, удирдаж явахад эрх зүйн орчингүй болчхоод байна. Сайн дураараа нэг үйлдвэр очиж бариад, хаа хамаагүй гэрээ хийгээд, ингээд янз бүрийн чөлөө зөвшөөрөлгүй, хяналтгүй, ямар нэг ийм химийн бодис хэрэглээд, тэгээд хилээр гарахаараа бүртгэл нь болж өгөхгүй ийм л байгаад байгаа юм. Тэгэхээр байгалийн баялаг дээр угаасаа Зөвшөөрлийн тухай хуулиараа ашигт малтмалын салбарт бүхий л үйл ажиллагаанд зөвшөөрөл авна гэдэг ийм бүр тусгай зохицуулалттай. Байгалийн баялаг дээр бол. Зөвшөөрлийн тухай хуулиар.

2 дугаар асуудал энэ маркшейдерийн зөвшөөрлийн тухай асуудал байгаа юм. Маркшейдерийн зөвшөөрөл дээр гидрогеологичид маркшейдерийн хэмжилт хийгээд ингээд завааруулаад байдаг асуудал бий болчхоод байгаа юм. Энэ мэргэжлийнхнийх нь хүсэлт юм байгаа юм. Тэгэхээр энэ хуулийн төслөөр маркшейдерийн тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байсныг ярилцаж байгаад бид яг маркшейдер хүн дээр нь өгье гэж, мэргэжилтэн дээр нь өгдөг болъё гэдэг өөрчлөлт бол найруулахаар орж ирэхээр ингээд явж байгаа. Тэгэхгүй бол бас маркшейдер гэдэг мэргэжлийг ингээд хөндлөнгөөс тайлбарлахад зүгээр энгийн хэлээр хэлбэл тэр уулын цулын сийрэгжилт, хэр хэмжээний уулын цул байгаа юм, хэр хэмжээний шороо байгаа юм гэдгийг нь хэдэн тонн, хэр хэмжээтэй байгаа юм гэдгийг нь хэмждэг ийм асуудал байдаг. Энэ дээр бас хулгай ч яригддаг. Тэгэхээр энийг бас хянахаас өөр арга байхгүй. Зөвшөөрлийн хууль дээр дахин сануулъя. Байгалийн баялаг дээр бол хяналт байх ёстой гэдэг.../минут дуусав/

С.Бямбацогт: Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

Д.Энхтүвшин: Нийтийн эрх ашгийн төлөө зөвшөөрлүүд байх нь асуудалгүй. Гэхдээ гол нь нөгөө оролцогч талуудын шаардлагуудаа хангаад, энэ хэлэлцүүлгээ хийгээд, нэг талаас саяын Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль ч гэсэн хязгаарлалтууд байж болно. Гэхдээ тэрийгээ оролцогч талуудтайгаа хэлэлцдэг, зайлшгүй шаардлагатайг нь сонсдог тэгж байж энэ зөвшөөрлүүдийг олгодог болъё гээд сая бас хуулийн төслийн үзэл баримтлал дээр гарсан. Тэгээд одоогийн мөрдөгдөж байгаа Зөвшөөрлийн тухай хуулиар Нийтийн сонсгол хийх ёстой гээд. Тэгэхээр би Нийтийн сонсгол яг хэзээ хийсэн бэ гэдгийг яамнаас өмнөх сайд нар, өмнө л хийсэн болж таараад байна. 2023 оны 10, 11 сард энэ Засгийн газарт энэ Зөвшөөрлийн зөвлөл хуралдаж, хэд хэдэн юунуудыг зөвшөөрсөн гэж харж байна. Тэгэхээр яг тэр шаардлага өгөхөд сонсголоо хэзээ хийсэн. Яг энэ 2 зөвшөөрөл дээр. Тэгээд дээр нь нэмэгдүүлээд тэр нөгөө гүйцээн боловсруулах чиглэлтэй холбоотой зүйлийг болж байна уу.../минут дуусав/

С.Бямбацогт: Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Зөвшөөрлийн зөвлөлөөр бид 2023 онд оруулж зөвшөөрөл авсан. Ашигт малтмалын тухай хууль 13 жилийн өмнөөс хойш бэлтгэгдэж явж

байгаа. Зөвшөөрлийн тухай хуульд байгалийн баялгийг ашиглахад тусгай зөвшөөрөл олгоно гээд бүр яг байгалийн баялагт нь зориулаад бүр ингээд тусгайлаад заагаад өгчихсөн байгаа. Яагаад гэвэл Үндсэн хуулийн 6.2-т байгалийн баялаг бол бүх ард түмний өмч гэж үзэж байгаа учраас заавал оруулна гэдэг оролцогч талуудын саналыг авсан, Зөвшөөрлийн зөвлөлийн зөвшөөрлөө авсан ийм л юм орж ирчихсэн байгаа.

С.Бямбацогт: Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

Д.Энхтүвшин: Саян асуудлуудыг ойлгож байна. Нийтийн сонсгол хийх ёстой энэ шаардлагаараа. Зөвшөөрлийн зөвлөл тэрийг үндэслэж, зөвшөөрөл өгөх ёстой. Тэр нийтийн сонсголыг хэзээ, хаана, яаж хийсэн юм бэ л гэж асуугаад байна. Яам нь хариулахгүй бол Дамдинням сайдаас өмнө энэ чинь 2023 оны асуудал учраас яамныхан хариулаач.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. Индран 4 дүгээр микрофон.

Г.Намчинсүрэн: Энхтүвшин гишүүний асуултад тайлбар өгье. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газар Намчинсүрэн. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн асуудлаар бид Зөвшөөрлийн зөвлөлд 2023 оны 10 дугаар сарын 26, 11 дүгээр сарын 17-ны өдрүүдэд энэ зөвшөөрлүүдийг олгох асуудлууд буюу 4 зөвшөөрлийг олгох асуудлыг танилцуулсан байгаа. Тухайлах юм бол, Ашигт малтмал баяжуулах, ашигт малтмал, уул уурхайн технологийн аудит хийх, маркшейдерийн үйл ажил эрхлэх зөвшөөрлүүдийг нэмснийг дэмжүүлсэн байгаа. Энэ Зөвшөөрлийн зөвлөлд орохдоо бид нар Нийтийн сонсгол хийсэн танилцуулгуудаа Зөвшөөрлийн зөвлөлд танилцуулж, холбогдох шийдвэрүүдийг гаргуулсан байгаа. Сонсгол хийсэн өдрийг нь би танд эргээд тодруулаад өгчихье.

С.Бямбацогт: Тэр сонсгол хийсэн өдрийг, хэзээ хийснээ одоо тодруулаад хэлчхээрэй. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуултаа асууя.

Х.Баасанжаргал: Хуулийн төсөлтэй танилцаад хэд хэдэн асуулт гарч байна. Ялангуяа хүний эрхийн үүднээс нь энэ хуулийг харж байна. Хуульд орж байгаа нэмэлт, өөрчлөлтийг харж байна. Хэд хэдэн заалтууд нь анхаарал татаад, жоохон санаа зовоож байна. 64¹ заалт, 42¹ заалт гээд.

Тэгэхээр энэ дээр байгаа иргэдийн оролцоо болон иргэдийн яг бодит үр дүнтэй шийдвэр гаргах үйл явцад үр дүнтэй оролцох оролцоог хэрхэн хангаж байгаа механизмаа та бүхэн бодсон юм уу. Ямар механизм бодоод энэ дээр ингэж бичсэн бэ. Ялангуяа хууль бус халдлага гэдэг үгтэй чинь илүү холбож асуугаад байна. Хууль бус халдлага гэж яг юуг хэлэх юм. Энэ иргэдийн тайван замаар үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, тайван замаар жагсаал цуглаан хийх, эсэргүүцлээ илэрхийлэх энэ эрхээс энэ хууль бус халдлага гээд байгаа чинь яаж ялгагдах юм. Ийм тодорхойгүй, маш ерөнхий юуг л бол юуг хамааруулж болох энэ нэр томьёо чинь хууль хүчний байгууллага буюу эрх эзэмшигч талд маш том давуу талыг ямар ч байдлаар мушгин гуйвуулж тайлбарлах, иргэдийнхээ эсрэг авах ийм арга хэмжээ болж буй ийм нөхцөл байдал оржээ. Тэгэхээр энэ заалтуудаа 1 дүгээрт тайлбарлаж өгөөч ээ.

2 дугаарт Монгол Улс НҮБ-ын бизнес ба хүний эрхийн удирдах зарчмыг хэрэгжүүлэхээр амлалт аваад, тэгээд манай улс бас энэ хүрээндээ төлөвлөгөөгөө баталсан байдаг юм. Бизнес ба хүний эрхийн үндэсний төлөвлөгөө, үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөгөө баталсан. Тэгээд энэ төлөвлөгөөнд ерөөсөө л яг энэ өнөөдөр үүсээд байгаа асуудлыг шийдэх маш тодорхой гарц гаргалгааг уг нь бол олоод биччихсэн байгаа. Гэтэл яг ингээд Ашигт малтмалын хууль, түүнтэй холбоотой орж ирж байгаа хуулиудыг харахаар иргэд, уул уурхайн компани 2-ыг хооронд нь сэргэлдүүлж буй өнөөгийн нөхцөл байдлаа ерөөсөө засахгүй, эсрэгээрээ дандаа иргэдийнхээ эсрэг хязгаарлалтуудыг л улам нэмээд, улам чангалж орж ирээд байна л гэж би үзээд байгаа гэсэн үг байхгүй юу.

Хэрвээ би буруу бодож байвал үндэслэл бүхий тайлбар өгөөрэй. Хуулийн яг тэдийн тэд дээр иргэдийн оролцоог хангаагүй бол ийм заалт байгаа. Иргэдэд ийм хариу өгөх ёстой. Иргэдийн яг бодит оролцоог ингэж хангах юм. Иргэд буцаагаад эрх нь зөрчигдөж байна гэвэл эрх бүхий байгууллага, шүүхэд, шүүхээс өмнөх шатад энэ асуудлаа хандаад шийдвэрлүүлэх гээд энэ чинь өөрөө иргэдийн оролцооны эрх гэдэг чинь бүтэн том механизм байхгүй юу. Тэгэхээр энэ механизмаараа бүтнээр нь та хэд өөрсдөө надад яг энэ дэлгэц дээр олон нийт үзэж байгаа дээр тайлбарлаад өгөөрэй гэж хүсэж байна.

Тэгээд та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа Монголд үүсээд байгаа олон уул уурхайн жишээнүүдийг та бүхэн мэднэ. Бүгдээрээ Бро Гоулд, Оюутолгой, Тавантолгой, Ноён уул, Хөшөөт гээд. Яг энэ кэйсүүд дээр эргээд яг энэ хуулийн төслийг ингээд наагаад бодохоор дандаа иргэдийнхээ эсрэг л харагдаад байна л даа. Тэгэхээр энэ дээрээ маш тодорхой тайлбар хэлэхийг хүсье.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. Индрийн 4 дүгээр микрофон.

Г.Намчинсүрэн: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газар Намчинсүрэн. Ашигт малтмалын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл дээр 42¹ гээд зүйл оруулж ирж байгаа. Тухайлах юм бол хайгуул, ашиглалт, баяжуулалтын үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олон нийтэд үйл ажиллагааныхаа талаарх мэдээллийг нээлттэй байлгаж, тогтмол мэдээлэл тайлагнах гэдэг. Мөн иргэн, төрийн бус байгууллага, геологи, уул уурхайн үйл ажиллагаанд дараах хэлбэрээр оролцоно гээд үндсэндээ 5 зүйл заалтыг шигтгэж өгсөн байгаа. Одоогоор Ашигт малтмалын хуульд байгаагаар бол иргэд, олон нийтийн оролцоо бол сул байгаа. Тантай бол санал нэг байна. Бид нар энэ дээр нэмээд үйл ажиллагаагаа аж ахуйн нэгжүүд нь нээлттэй ил тод байлга. Мөн иргэд нь энэ талаарх эрх ашиг нь зөрчигдөж байгаа бол мэдээлэх эрх үүргүүдийг нь энэ хуульд тусгаж өгсөн.

Нөгөөтээгүүр бид нар бас сая таны асууж байгаа энэ юутай холбоотой Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг оруулж ирсэн. Бид нарын геологи, уул уурхай, газрын тосны эрэл хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд хууль бусаар халдаж, тоног төхөөрөмжийг эвдсэн, үйлдвэрлэлийн яг үйл ажиллагааг санаатайгаар тасалдуулсан, зам уурхайн гарц хаасан, цахилгаан хангамж, усан хангамжийн зориудаар тасалсан бол хүнийг 300 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 3000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэдэг зохицуулалтыг оруулж ирсэн. Энэ хуулийг өргөн барихтай холбоотойгоор хүний эрх хөндөгдөж байгаа гэдэг утгаараа бид нар Улсын дээд

шүүх, Прокурорын газар, Хүний эрхийн Үндэсний Комиссоос бол холбогдох санал, дүгнэлтийг авч, хуулийн төсөлд зөвшөөрлийг нь аваад Их Хуралд өргөн барьсан байгаа.

С.Бямбацогт: Энхбатын Болормаа гишүүн. Баасанжаргал гишүүн тодруулж асууя.

Х.Баасанжаргал: Би уг нь өөрсдөд чинь, та бүхэнд боломж олгоод байна л даа. Яг хууль бус халдлага гэдгээ хууль ёсны тайван замаар, жагсаал цуглаанаас яаж ялгах юм бэ гэдгийг тайлбарлаад өг. Тайван замаар жагсаал цуглаан хийх эрх бол хүн бүрийн үндсэн эрхийн асуудал байгаа шүү дээ. Энийгээ хууль бус халдлагаасаа яаж ялгах юм гээд байна.

Сая та бас яг хэлчихлээ. Зөрчлийн хууль дээр хариуцлага тооцохоор оруулж ирсэн. Иргэн талдаа бид нар улам чангараад байгаа байхгүй юу. Иргэн талдаа. Эргээд нөгөө талдаа иргэддээ мэдээлэл, та нар мэдээлэх эрхийг нь тавьчихсан гээд байгаа юм. Гэтэл яг ингээд харахаар ямар мэдээллийг ямар хугацаанд, ямар хэлбэрээр нийтлэхээ ерөөсөө хууль дээрээ бичээгүй. Ус ашиглалтын талаар мэдээлэл байх юм уу. Ашиглаж байгаа химийн бодисынх нь талаар мэдээлэл байх юм уу. Хог хаягдлынх нь талаар мэдээлэл байх юм уу. Аюултай хог хаягдлынх нь талаар мэдээлэл байх юм уу. Нөхөн сэргээлтийн талаар мэдээлэл байх юм уу. Энийг яг ямар хугацаанд, хэн иргэдэд яаж мэдээлэх юм гэдэг юм чинь ерөөсөө тодорхой байхгүй байгаа байхгүй юу. Тэгээд энийгээ та нар мэдээлэх эрхтэй гээд заачихсан учраас болно гээд ингээд ийм ерөнхий байдлаар яваад байгаа байхгүй юу.

С.Бямбацогт: Хариулъя. Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

Г.Намчинсүрэн: Бид нар 64² дээр бол үйл ажиллагаанд хууль бусаар халдах гээд дээрээс нь тоног төхөөрөмжийг эвдэх, тээвэрлэлтийн үйл ажиллагааг санаатайгаар тасалдуулах, уурхайн гарцыг хаах, цахилгаан усан хангамжийг зориудаар таслахыг гэдэг тодорхойлолтыг оруулж ирсэн байгаа. Нөгөөтээгүүр энэ үйл ажиллагаатай холбоотойгоор бид бүхэн холбогдох хууль тогтоомжид нь нийцүүлээд, бас танд түрүүн хэлснийхээ дагуу л тайлбар өгч чадахаар байна. Бид нар 3 байгууллагаас нь бол санал, зөвшөөрлөө аваад, Их Хуралд хуулийн төслөө өргөн барьсан байгаа.

С.Бямбацогт: Тодруулъя. Баасанжаргал гишүүн. Хариулт нь хангалтгүй болохоор л гишүүд дахин дахин асуугаад байгаа шүү дээ. Та бүхэн гишүүдийн асуултад бүрэн гүйцэд, товч тодорхой хариулт өгчхөж бай л даа. Тэгээд дутуу хариулаад ингээд дахин дахин асуулгаад байх юм. Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Миний асуулт маш тодорхой шүү дээ. Иргэн талдаа хуулиа бид нар чангалаад байна. Энэ дунд нь үүрэг хүлээж байгаа төр өөрөө ямар үүрэг хүлээх юм. Иргэдийг ямар мэдээллээр яаж хангах юм. Иргэд эрхээ яаж хамгаалах юм бэ гэдэг заалт чинь байхгүй байна. Наад хууль бус халдлага, тоног төхөөрөмж эвдэх, таслал тавиад гээд бүгдийг нь тус тусад нь үйлдэл болгоод зүйлчилчихсэн байгаа байхгүй юу. Хамгийн том уут чинь наад хууль бус үйлдэл гэдэг чинь аягүй том уут үүсгэхээд байна. Хэнийг ч тэрэнд хамруулаад хэнд ч хариуцлага тооцох ийм боломжийг та нар бий болгочоод байна шүү дээ. Олон улсын уул уурхайн

компаниудад тавьдаг өчнөөн олон шаардлагууд байгаа шүү дээ. Тэр шаардлага руу ойртуулахын төлөө ерөөсөө та нар ажиллахгүй байгаа байхгүй юу. Иргэдээ л чангалаад байн. Та нар тэгэх юм бол та нарыг тэгнэ, та нар ингэх юм бол та нарыг ингэж хорино, та нарыг ингэж торгоно гээд. Уул уурхай нөгөө талдаа иргэн, уул уурхайн компани 2-ыг хооронд нь ойлголцуулах бүрэн мэдээлэлтэй зөвшилцөх ямар механизм энэ дотор оруулж ирээд байгаа юм бэ гэдгийг асуугаад байгаа байхгүй юу. Тэгээд дандаа хооронд нь алалцуулдаг..../минут дуусав/

С.Бямбацогт: Ажлын хэсэг Болдын Уянга гишүүн хариулъя.

Б.Уянга: Баасанжаргал гишүүнтэй энэ дундын механизмыг сайжруулах тал дээр хангалттай энэ Ашигт малтмалын хууль сайжирч орж ирээгүй гэдэгтэй бол санал нэг байгаа. Тэгэхдээ нэмэлт, өөрчлөлт учраас бас нөгөө 50 хүртэлх хувь гэдэгтээ баригдсан байх. Зөрчлийн тухай хууль дээр та нөгөө хууль бус гэдэг үгийг асуусан. Зөрчлийн тухай хуулийн 7.10, 7.11 нь болохоороо тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хууль зөрчвөл яах юм. 7.12 нь болохоороо иргэн талтай таны хэлж байгаа. Энэ 3 зүйлд бүгдэд нь хууль бус гэдэг үгнүүд нь хэд хэдэн заалтаараа байгаа. Тэгэхээр энэ Зөрчлийн тухай хууль дээр байгаа энэ хууль бус гэж томъёологдсон өгүүлбэрээр нь Ашигт малтмалын тухай хуульд нь бичигдээд л орж ирж байгаа асуудал. Ерөөсөө шинээр хууль бус гэж бичигдээд, эндээ ямар нэгэн юмыг хайрцаглах гэж байгаа асуудал бол биш юм. Тэгэхээр Зөрчлийн тухай хууль хаа нэгтээ хэрвээ засгаас ч юм уу өргөн баригдах тохиолдолд бас саяын хэлсэн таны зүйлүүдийг харж байгаад, яаж механизмыг нь сайжруулах ёстой юм гэдэг дээр нь бол ажиллаж болох байх.

Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хууль дээр бас засвар.../минут дуусав/

С.Бямбацогт: Энхбатын Болормаа гишүүн асуултаа асууя.

Э.Болормаа: Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн ажлын хэсэг өчигдөр өглөө хуралдаад, өчигдөр өдийд шөнөжингөө Байнгын хороо энийг хэлэлцээд, өнөөдөр яараад ингээд чуулганд орж ирж байна. Ийм чухал хуулийг, уул уурхайн асуудлыг, эрх зүйн зохицуулалтыг бий болгож байгаа ийм чухал хуулийг ингэж яарч хэлэлцүүлж болохгүй. Энэ дундаас хараад үзэх юм бол маш ноцтой зүйлсүүд энэ дунд явж байна. Юуны өмнө олон нийтэд ил тод болоод, олон нийт шүүмжилж байгаа АМНАТ-ийн суудал.

Байгалийн баялгийн үр өгөөжийн дийлэнх нь иргэдэд очно гэсэн, хүртэнэ гэсэн. Гэтэл зэсийн АМНАТ-өө бууруулж байна. Ажлын хэсэг тэрийг 3 жилээр хойшлуулъя гэж байна. 3 жилээр ч гэсэн хойшлуулаад бууруулж яах гэж байгаа юм. Дэлхийд зэсийн үнэ түүхэн дээд хэмжээндээ орж ирээд, энэ АМНАТ-өөр бид нар үндэсний баялгийн сангаа арвижуулна шүү дээ. Яагаад энэ АМНАТ-өө бууруулах гээд байгаа юм.

Үргэлжлүүлээд харахаар одоо энэ гэрээгээр эрлийн судалгааны талбай гэдэг зүйлийг өгдөг болно гэж байна. ТХГН-ийн тухай хуульд өөрчлөлт оруулаад, орон нутгийн тусгай хэрэгцээт газар гэдгийг тоодоггүй болгоод, 150 мянган га хүртэлх газрыг гэрээгээр эрлийн хайгуул гэдэг юмаар өгөөд, тэрний 20 хүртэлх хувийг нөгөө зардал гаргасан компанидаа ямар нэгэн сонгон шалгаруулалтгүйгээр хайгуулын

тусгай зөвшөөрөл өгөх гэж байна. Ямар нэгэн сонгон шалгаруулалтгүйгээр ийм шинэ зохицуулалт оруулж ирж байгаа.

Үргэлжлүүлээд энэ 64 дүгээр зүйл тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд халдахыг хориглох. Орон нутгийн иргэд үйл ажиллагааг эсэргүүцээд аргаа бараад энэ шалгалт хийгээч ээ, энэ чинь хууль зөрчөөд байна шүү дээ гэхэд яам нь тоохгүй, газар дээр нь очихгүй, аргаа бараад жагсаж тэмцэхэд хуулийн хариуцлага хүлээлгэнэ гэж байгаа юм. Ингээд бүр Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулж ирэх. Ямар аймаар харгис юм бэ. Тэр хүмүүсийг сонсьё гэж бодохгүй байна уу. Бүгд захиалгаар, мөнгөөр жагсаж цуглаж, үзэл бодлоо илэрхийлдэг гэж бодоод байгаа юм уу. Яагаад ингээд өөрсөд шигээ сэтгээд байгаа юм.

Үргэлжлүүлээд Улсын Их Хурлын дарга аа, та энийг бас онцлоод анхаараад өгөөрэй. Улсын Их Хурлын дэд дарга Пүрэвдорж мөн адил. Газрын ховрын төслийг оруулж ирэхийн тулд нууцаар Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуулиас газрын ховрын элемент агуулсан бодисыг гэдгийг хасаж байгаа юм. Газрын ховор элемент гэдгийг тус тус хассугай. Ингээд жижигхэн энэ дунд нь Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.2 гэсэн дотор газрын ховор элементээс бусад гэж оруулна уу гэж байгаа. Цацрагт идэвх, ашигт малтмал гэдгээс хасах. Одоо бүр шинжлэх ухааны эсрэг юм манай Монголд хийдэг болж байна. Дэлхийд газрын ховор элемент энэ 17 элемент нь уран, торигийн цацраг идэвхт бодисуудтай хамт байх магадлал их байдаг гээд дэлхий энийг судлаад, шинжлэх ухааны мэдээлэл гараад байхад, манайх энийгээ хасах юм гэнэ. Тэгээд энийг эсэргүүцсэн иргэдээ очоод үргэлжлүүлээд торгоод байх юм гэнэ. Яаж бид нар наадмын өмнө ийм юм хэлэлцэж байгаа юм бэ. Энийг дарга аа, би нэмээд 2 минутаа авчихъя...../минут дуусав/

С.Бямбацогт: Болормаа гишүүнд 1 минут.

Э.Болормаа: Энийг маш энгийнээр бол эдийн засгийн оюутнууд үзэж байвал энэ рент сикийн гэдэг рент илэрхийллийн бүр классик жишээ. Яаж үр өгөөжөө нэмэгдүүлэх, бялуугаа томруулах гэж ярихын оронд цөөн хэд нь лобби хийж шийдвэр гаргагчид нөлөөлж, өөрийнхөө бялууны зүсмийг томруулах гэж оролддог. Компаниуд орон нутгийнхаа иргэдтэй учраа олж чадахгүй байна. Тийм учраас учраа олох гэж яаж энийг бид нар ойлголцох вэ гэж тэнд ажил хийхийн оронд энэ хэдэн нөхдүүдийг лоббидож байгаад, хуулиа өөрчилчихье. Эсэргүүцээд байх юм бол бүгдээрээ торгочихье. Сонгон шалгаруулалтгүйгээр сайхан хайгуул нэртэй эрэл хийж байгаа гэж байгаад тэрний 20 хувийг нь хайгуулын газар өгчихье. Тэр шинжлэх ухаан энэ тэр хамаагүй, эд нар цацрагт идэвх гээд байгаа юм чинь газрын ховрыг цацрагт идэвх биш гээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2 удаагийн зарлиг байгаа шүү. Газрын ховор элементийн асуудлыг..../минут дуусав/

С.Бямбацогт: Дамдинням сайд хариулъя. Тодорхой мэдээлэл өгөх ёстой.

Г.Дамдинням: Буруу, зөрүү ойлгох юм байгаа байх. Зэсийн АМНАТ-ийг бууруулах тухай асуудал бол 3 жилээр хойшлуулъя гэдэг МАН-ын бүлэг дээр бас гишүүдийн ярьсан саналуудыг хүлээж аваад ингээд бид хойшлуулж байгаа. 2029 оны 01 дүгээр сарын 01-ээс мөрдөж эхэлье гээд хойшлуулж байгаа. Яагаад вэ гэвэл

бид одоо 5 хувийн АМНАТ төлдөг Оюутолгой гэдэг төсөлд хөрөнгө оруулсан Рио Тинто гэдэг ганцхан хөрөнгө оруулагчаас хамааралтай байдалд орчхоод байгаа. Ганц улсын үйлдвэр уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр нь 21,6 хувийн АМНАТ төлж байгаа. Зэсийн АМНАТ өндөр байх нь яг одоогийн байдлаар Рио Тинтод асар ашигтай. Харин ч ашигтай шүү. Өөр хэнийг ч оруулж ирэхгүй. Өөр хэн ч орж ирэхгүй. Ингээд орж ирэхгүй учраас ганцхан хөрөнгө оруулагчаас хамааралтай, улсын төсөвт жилдээ 1,6 их наяд төгрөгийн орлого оруулдаг энэ төслийг бид нар зогсоож байгаад хэлэлцээр хийх чадваргүй ийм л байгаа юм. Хөдлөхөд бэлэн болоод хөрөнгө оруулалт хүлээж байгаа 20 төслөө хөдөлгөө. Олон зэсийн төсөлтэй болж байгаад болохгүй байгааг нь шахаж байгаад, болж байгааг нь явуулж байгаад хэлэлцээрээ улс орон шиг нүүр бардам хийчихдэг болъё гэж л оруулж ирсэн ийм л бодлого. Энэ бол улс орон хийдэг бодлого. Нүүрснээс хамааралтай эдийн засгаа зэсээс гэдэг 2 дахь хөдөлгүүртэй болгоё гэж оруулж ирсэн ийм бодлого. Тэгээд улс төр нь ингээд үл ойлгогдох байдал руу мушгидаад байгаа учраас бид 2029 оны 01 дүгээр сарын 01 болгоод, 3 жилээр хойшлуулчихсан. Энд хардлага сэрдлэг нь төвөг, яг ний нуугүй хэлэхэд больё л гэж байгаа юм. Хойшлуулчихъя.

2 дугаарт эрлийн ажил дээр эрлийн ажил гэдэг бол геологи хайгуулын ажил биш. 150 мянган га талбай гэдэг бол одоо ч хууль дээр байгаа талбай. Одоо ч байгаа талбай. Эрлийн ажил гэдэг бол капиталист байна уу, коммунист байна уу, ардчилсан байна уу, ямар ч улс орон хөрсөө судлаад, геологийн ажил хийх газраа бүгдийг нь мэдээд, үер ус, онцгой байдал, хотжилт, зам харилцаа, дэд бүтэц, хөдөө аж ахуй, мал аж ахуй, газар тариаландаа аль газраа ашиглах уу, үгүй вэ гэдгээ судалдаг судалгаа байхгүй юу. Эрлийн ажил гэдэг бол эндээсээ энэ рүүгээ улсын төсвөөс хөрөнгө гаргадаг. Манай улс харамсалтай нь эндээ хангалттай мөнгө гаргаж чадахгүй байгаа учраас дараагийн Оюутолгой, Тавантолгойгоо олж чадахгүй байгаа юм. Тогтоож чадахгүй байгаа юм. Тийм учраас энэнд бид мөнгө гаргах ёстой юм. Энийгээ хувийн хэвшлээр хамтарч хийдэг Канад, Казакстан, ОХУ зэрэг энэ уул уурхайн салбарт тэргүүлж байгаа улс орнуудын туршлагыг л ашиглаж хамтарч хийе гэсэн ийм л зорилгоор явж байгаа.

Цөмийн энергийн хуультай холбоотой асуудлыг Мөнхбилэг дарга хариулаад өгчих. Тэгвэл бас тодорхой болох байх. Энд бол нууцаар явсан юм байхгүй. Бүгд .../минут дуусав/

С.Бямбацогт: Тэр газрын ховортой холбоотой асуудлаа нэмээд хариулчих. Тэгээд дараад нь Болормаа гишүүн дахиж тодруулъя. 4 дүгээр микрофон.

Н.Мөнхбилэг: Болормаа гишүүний асуусан асуултад хариулъя. Ажлын хэсгийн гишүүн, Үндэсний геологийн албаны дарга Мөнхбилэг. Энэ гишүүний ярьж байгаа 2 цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах гэж байгаа заалт нь бол цөмийн бодис, цөмийн эх үүсвэр материал гэдэгтэй холбоотой заалт. Газрын ховор элементэд тооцогддог 17 элемент өөрөө ямар нэгэн задрал, идэвхжил байхгүй өөрөө ямар нэгэн цөмийн урвалд ордоггүй. Энэ бол хагас задралд орж энерги, эрчим хүч ялгаруулдаггүй. Энэ нь бол зүгээр л ашигт малтмалын төрлөөрөө газрын ховор гэдэгт ордог ийм бүлэг элементүүд байгаа.

Зүгээр энд магадгүй Цөмийн энергийн тухай хууль тухайн үед орохдоо хэрэглээг нь үндэслээд ийшээ оруулчихсан байж магадгүй. Юунд хэрэглэдэг вэ гэхээр зэрэг тодорхой төрлийн элементүүд нь цөмийн реактор.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариултаа гүйцээгээд хариулчихъя. Тодорхой хариулна шүү. Иргэдийн бас эргэлзээ дагуулсан, бухимдал төрүүлсэн асуудлууд дээр та бүхэн маш тодорхой мэдээлэл өгчхөж байна л даа. 4 дүгээр микрофон.

Н.Мөнхбилэг: Тодорхой хэлэхэд газрын ховор элементэд ордог 17 төрлийн элемент нь ямар нэгэн цацраг идэвхт шинж байхгүй элементүүд.

С.Бямбацогт: Болормаа гишүүн тодруулж асууя.

Э.Болормаа: Хариулсан юм чинь тодруулаад асууя. АМНАТ дээр 3 жил хойшлуулах гэж байгаа бол нэгмөсөн энэ заалтаа тэгвэл 2 жилийн дараа оруулаад ир л дээ. Бүлэг дээр 3 жил гэж ерөөсөө огт яриагүй шүү дээ. АМНАТ-ийг хөндөхгүй байна гэсэн шүү дээ. Хойшлуулъя биш, бүлэг дээр хөндөхгүй байна гэсэн.

Цацрагт идэвх дээр би Цөмийн энергийн комиссын ажлын албаны даргын бичгийг та бүхэнд танилцуулъя. Газрын ховор элемент боловсруулах технологи нь их хэмжээний хаягдал үүсгэхээр байна. Энэ дотор цацраг идэвхт хаягдал багагүй хэмжээгээр гарах бөгөөд төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгжийн хувьд цацрагт идэвхт хаягдлын менежментийн талаар үндсэн баримт бичгүүдэд ямар ч асуудал тусгаагүй. Энэ тал дээр тодорхой ойлголтгүй байсан. Газрын ховрын элементийн ордын хүдэрт цацрагт идэвхт байгалийн элементүүд, тэр дундаа уран, тори, кали тодорхой хэмжээнд агуулагддаг..../минут дуусав/

С.Бямбацогт: Хариулъя. Цөмийн энергийн комисс чинь ингээд цацраг идэвхт бодис дагуулдаг гээд бичиг хийгээд өгчихсөн байна. Та бүхэн байдаггүй гээд яриад байх юм. Хэн хариулах вэ. Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

Н.Мөнхбилэг: Гишүүний тодруулгад хариулъя. Үндэсний геологийн албаны дарга Мөнхбилэг. Хэрвээ хүдэрт агуулагддаг цацраг идэвхт бодис хаягдалд байдаг гэх юм бол ганцхан газрын ховор ч биш фосфорид, нүүрс болон хайлуур, жонш гэх мэтчилэн бусад металл ашигт малтмалын хүдэрт мөн энэ шинж хэрэглэгдэнэ. Байдаг цацраг идэвхт шинж. Тэгэхээр эдгээр ашигт малтмал бол хэрвээ хүдэртэй хаягдалдаа агуулдаг гэвэл бас мөн энэ хууль руу дагалдаад орох шаардлагатай л болно гэсэн үг.

С.Бямбацогт: Тэгэхээр яг энэ дээр иргэдийн эргэлзээг тайлах хэрэгтэй. Цөмийн энергийн комисс нь цацраг идэвхт бодис агуулдаг гээд бичиг хийгээд өгчихсөн. Үндэсний геологийн албаны дарга нь цацраг идэвхт бодист агуулдаггүй. Ер нь тэгж ярих юм бол хайлуур жонш, бусад юманд, нүүрсэнд хүртэл цацраг идэвхт бодис байдаг гээд байна. Энэ бодитой мэдээллийг албан ёсоор Аж үйлдвэр, уул уурхайн яам Болормаа гишүүнд, Улсын Их Хуралд өг. Бид нар энийг чинь олон нийт бас мэдээлж, танилцуулъя. Хаана үнэн байна. Хаана худлаа байна гэдэг бодитой мэдээлэл бид өгч байх ёстой. Тэгээд иргэдийг буруу мэдээллээр, худлаа мэдээллээр төөрөгдүүлж болохгүй. Улсын Их Хуралд ирүүлсэн, Болормаа гишүүнд ирүүлсэн албан бичиг хэрвээ худлаа байх юм бол тэр хүн хариуцлагаа хүлээх ёстой. Хэрэв Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд Үндэсний геологийн албаны дарга Мөнхбилэг доктор худлаа хариулт өгсөн бол та хариуцлага хүлээх ёстой. Ийм байдлаар үнэн 1 л байх ёстой. Зөв нь 1 л байх ёстой. Энийг гаргах ёстой шүү. Энэ дээр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Улсын Их Хурлын Тамгын газар анхааралдаа

авч, энийг албан ёсоор бодитой мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэе. Энийг үүрэг болголоо шүү.

Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуултаа асууя.

М.Бадамсүрэн: Энэ эрэл хайгуулыг нэмнэ л гээд байх юм. Энэ өмнөх социализмын үед хайсан, олсон энэ Эрдэнэт овоо, Оюутолгой, тэгээд энэ Тавантолгой гээд энэ ордоороо л өнөөдөр үндсэндээ үйл ажиллагаа явуулж байгаа шүү дээ. Эдийн засгийн үр ашигтай стратегийн энэ ордуудаа л ашиглах нь зөв шүү дээ. Бусад орон чинь энэ жижиг, эдийн засгийн үр ашиг багатай байгаль орчинд сөрөг нөлөөтэй ордуудаа бол ашиглахгүй байгаа шүү дээ бид. Тэгээд ингээд дэлхий эсрэг явах гээд байх юм. Тэгээд одоо энэ чинь шавхагддаг баялаг. Угаасаа нөхөн сэргээгддэггүй баялаг. Энэ түүхий эдийн үнэ цэн буурна гэж хэзээ ч байхгүй. Зэсийн үнэ өнөөдрөөс 10 жилийн өмнө хэд байлаа, өнөөдөр хэд байгаа юм. Шавхагддаг баялаг байхгүй юу. Тэгэхээр энийг үнэ цэнтэй томоохон үр ашигтай ордуудыг л ашиглах тухай бид нар ярих ёстой. Энэ сая Болормаа гишүүний асуултаас нэлээн ноцтой юм явагдаад байгаа юм уу даа гэж мэдээлэл авлаа. 150 мянган га судалгаа эрлийн ажилд өгнө гээд. Энэ чинь 50км, 30км нутаг шүү дээ хааш хаашаа. Тэрнээс 20 хувь нь гэхээр ингээд 10км, 30км тийм газрыг зүгээр сонгон шалгаруулалтгүй өгөх юм байна шүү дээ. Одоо байгаа иргэд, орон нутаг энэ хайгуулын үйл ажиллагааны хоорондох зохицуулалт, орон нутагт хуваарилагдах өгөөж, харилцан ашигтай байх, алтыг нь аваад авдрыг нь хаядаггүй байх энэ тогтолцоогоо бид нар бүрдүүлж чадаагүй байж байж энэ бол цаашаа явна гэхэд бол хүнд юм байна гэж сая Болормаа гишүүний асуултаас бол мэдэрлээ. Тэгэхээр энэ нь ер нь яагаад ингэж тооцсон юм бэ.

2 дугаарт ТХГН-ийн тухай хуулиар энэ чинь яагаад ТХГН гэж авдаг вэ гэхээр экологийн тэнцвэр алдагдахаас сэргийлж энэ газрыг авдаг. Өөрөөр хэлбэл зарим газрыг ашиглаж байхад зарим ашиглагдаагүй газар нь өөрөө экологийн тэнцвэр хангадаг. Энэ олон улсын зарчим. Монгол Улсын алсын хараа бодлогод тусчихсан. Тэгэхээр яагаад бид нар эсрэг яваад байгаа юм бэ гэдгийг л би асууж байгаа юм. ТХГН байж байг л дээ. Тэр ганцхан хүн амьдрахад зориулагдаагүй шүү дээ. Энэ дэлхийн бөмбөрцөг, энэ амьтан, мал, энэ цэцэг ургамал, ой мод, ус энэ зүйл нь тэгээд хэсэг газраа байг л дээ. Ирээдүй үед маань үлдэг л дээ. Бид нар ганцхан амьдраад дуусахгүй шүү дээ. Тэгэхээр ТХГН-ийн тухай хуулийг хөндөж хэрхэвч болохгүй. Энэ бол ерөөсөө маш хатуу их эзэн Чингис хааны сургаал гэж хэлж болно. Тусгай хамгаалалттай газар нутаг 20 хувь байгаа шүү дээ. Ой мод чинь 10 байсан. Одоо 6, 7 хувь болчихсон. Ядаад мод тарья гэж. Тэгээд энэ эх дэлхийнхээ эсрэг бол ийм юм байж болохгүй. Өмнө байгаа том ордуудаа ашиглах нь зөв.

2 дах асуулт нь энэ АМНАТ-тай холбоотой Эрдэнэт овоо өөр тогтоолоо л гэнэ. Оюутолгой дээр өөр тогтоолоо л гэнэ. Тэгээд энийгээ энэ яг оновчтой тайлбарлаж өгөөч. Мэргэжлийн үүднээс мэддэг энэ Үүрийнтуяа гишүүн, Дамдинням сайд, тэгээд энэ холбогдох агентлагийн дарга гээд. Тэгэхгүй бол энэ их ойлгомжгүй байна. Ер нь АМНАТ гэдэг бол өөрөө бидний эцэг өвгөдөөс үлдээсэн баялаг ирээдүй үедээ ашиглах баялгийн өгөөжөөс ард түмэндээ үндэсний баялгийн сангаар дамжуулж хүргэх зорилготой гол ийм бид нарын авч байгаа төлбөр шүү дээ. Ашиг олох эсэхээс үл хамаараад борлуулалтаас нь авч байгаа. Тэгээд энийг асууя.

Дараагийнх нь энэ дээр тодорхой хариулт авъя. Баасанжаргал гишүүний ярианаас, мэргэжлийн хуульч хүний ярианаас анхаарал татахаар асуудлууд байна. Энэ ардчилсан нийгэмд иргэд чинь үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй. Энийг харин зөв зүйтэй ард иргэд юу хүсээд байна гэдгийг зөв тодорхойлж тэдэнд.../минут дуусав/

С.Бямбацогт: Дамдинням сайд хариулъя. Ажлын хэсэг.

Г.Дамдинням: Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Эрэл хайгуулыг нэмэхгүй эрлийн ажи, хайгуулын ажил гэдэг бол маш их цаг хугацаа шаардаж хийгддэг ажил. Та сая зөв хэллээ. Эрдэнэт, Тавантолгой, Оюутолгой гээд энэ 1990 оноос өмнөх эрэл судалгааны ажлын үр дүнгээр өнөөдрийн бид нар амьдраад байгаа юм. 30 жилийн дараа бид нарын хүүхдүүд орд газраа ашиглах вэ гэдгийг одоогоос эрж хайж тогтоогоод явдаг. Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр дээр өнгөрсөн жил эцсийн өрмийг нь тавиад, энэ жил бид Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд нөөцийг нь хүлээж авсан Оюутын ордыг 50 жил эрэл хайгуулын судалгааг нь хийж байж баталгаажуулсан. Том орд болохын тулд. Тэгэхээр ирээдүйн хүүхдүүдийнхээ тухай бодох тухай л асуудлыг бид ярьж байгаа шүү дээ.

Ташрамд нэг зүйлийг хэлье. Хүн төрөлхтөн хоёрхон төрлийн эх үүсвэртэй зүйлийг л хэрэглэж байгаа. 1 бол ухсан байгаа, 1 бол ургуулсан байгаа. Тэгэхээр аль болох зохистойгоор ухаж хэрэглэх тухай асуудлыг ярьж байгааг бас дэмжиж байгаа, ойлгож байна. Орон нутгийн өгөөжийг Бадамсүрэн гишүүн таны маш их ярьдаг асуудал. Бид орон нутагт очих АМНАТ-ийн хэмжээг төслөөр оруулж ирсэн ажлын хэсэг маань 20 хувь болгосон байна. Ер нь орон нутагт энэ очдог АМНАТ-ийн хуваарилалт бага байснаас болж маш их хэмжээний зөрчил ард иргэд, аж ахуйн нэгжүүдийн дунд гардаг байсан юм. Тэгээд энийг бид өсгөж хэдэн мянган жил нутаглаж байсан эцэг өвгөдийнхөө нутгийг улс орныхоо эдийн засгийг ойлгоод ухуулаад зөвшөөрсөн ч тэр сумд нь сургууль, цэцэрлэг, эмнэлэг, гэрэл, тог, зам байхгүй ард иргэд уурлах нь зөв. Тийм учраас яг тэр хэсэгт нь арай түлхүү олгоё. Хариуцлагатай уул уурхайтай хамтарч ажиллаж чадаж байгаа аймаг сумд нь АМНАТ-ийн хуваарилалтыг илүү нэмж олгоё гэдэг ийм зохицуулалтыг оруулж ирж байгаа юм. Эндээс бас уул уурхайн төслүүд, ард иргэд 2-ын хооронд гардаг зөрчлүүд буурна гэсэн хүлээлттэй байгаа. Тусгай хамгаалалттай газар нутаг дээр бид эрлийн ажил хийе гэж байгаа юм. Би түрүүн хэллээ шүү дээ. Энд зөвхөн ашигт малтмалын ажил хийгдэхгүй. Хөрсний судалгаа тэр чигтээ хийгдэнэ. Антропологийн судалгаа тэр чигтээ хийгдэнэ. Хот төлөвлөлт, аялал жуулчлал, ер нь бүх салбарт л хэрэгтэй эрлийн ажил хийгддэг.

Тэр түрүүн ярьж байгаа тэр 150 мянган га талбай гэдэг бол одоогийн хууль дээр ч байгаа. 25 мянгаас 150 мянган га талбайг лицензээр олгож болно гэсэн зохицуулалт одоогийн хууль дээр байгаа. Одоогийн хуулиас өөрчилсөн ямар ч өөрчлөлт байхгүй. Одоогийн хууль мөрдөгдөөд удаж байна. 10 хэдэн жил болж байна. Энэ хайгуулын тусгай зөвшөөрөл авах гэж байгаа аж ахуйн нэгжүүдээр эрлийн ажлаа хийлгэж авна гэдэг бол улс мөнгө хэмнэж байгаа хэрэг. Тэр эрэл судалгааны ажлаа хийхэд бид хувийн хэвшлийнхний нөөцийг ашиглах ийм боломжийг авах гэж оролдож байгаа хэрэг. Хариултаа гүйцээчихвэл дарга аа минут өгвөл.

С.Бямбацогт: Хариултаа гүйцээе. Дамдинням сайд 1 минут.

Г.Дамдинням: Тэгээд Оюутолгой, Эрдэнэт 2 дээр ийм юм. Манай улсын нийт зэсийн АМНАТ бол 21,6 хувь, Оюутолгойг 17 жилийн өмнө 2009 онд Тогтвортой байдлын гэрээ хийгээд Ашигт малтмалын хуулиар биш Хөрөнгө оруулалтын тухай хуулиар Улсын Их Хурал дээр оруулж ирээд АМНАТ-ийг нь 5 хувиар тогтоогоод, урт хугацааны гэрээ байгуулчихсан юм. Энэ Хөрөнгө оруулалтын гэрээ гэдэг гэрээнээс болоод одоо баахан асуудлууд явж байгаа. Одоо бусад бүх уурхайнууд дээр 21,6 хувийн АМНАТ ногдоно. Улсын хэмжээнд идэвхтэй 350 гаруй уурхай ажиллаж байна. Улсын хэмжээнд ажиллаж байгаа энэ 350 гаруй уурхайн өгөөжөөр өнөөдрийн Монгол орны эдийн засаг явж байгаа. Тэгэхээр бас дан томыг нь гээд байвал эрэл судалгаа хийх ёстой болно. Жижгийг нь боль гэвэл тийм л юм руу явчих гээд байна л даа бид нар.

С.Бямбацогт: Үүрийнтуяа гишүүн тэр АМНАТ дээр тодорхой тайлбар хариулт өгөөдхөөч. Ажлын хэсгийн гишүүн.

Д.Үүрийнтуяа: Оюутолгой, Эрдэнэт гэдэг 2 зэсийн орд компани л АМНАТ төлж байгаа. Оюутолгой 5 хувь, Эрдэнэт хуулиараа 20 хувь, 5 дээр өсөн нэмэгдэх 15, гүйцэтгэлээр хууль бус 2 хувиа нэмээд 22 хувь төлж байгаа. Энэ 22 хувийг өнөөдөр өөрчлөхгүй бол АМНАТ-ийг Эрдэнэт болоод шинээр орох зэсийн ордууд л төлнө. Яг энэ нөхцөл байдалд Эрдэнэтээс өөр ийм АМНАТ төлөх газар байхгүй. Дэлхийн хаана ч байхгүй АМНАТ-ийг төлдөг. Би яагаад Амнатыг бууруулах ёстой вэ гэдэг дээр 2 үндэслэлийг тооцоотой хэлье гэсэн юм. Их Хурлын дарга энд бас хариулах боломж олгоно уу гэж хүсэж байна. Хугацаа нэмээд өгчих.

1 дүгээрт АМНАТ-ийг бууруулснаар бид нар уул уурхайн нөөцөө үр ашигтай ашиглах боломж бүрдэнэ. Хаягдал багатай ашиглах боломж бүрдэнэ. Өнөөдөр Эрдэнэт үйлдвэрийн 1 тонн зэсийн баяжмал үйлдвэрлэх нэгжийн өөрийн өртөг нь 6,6 сая төгрөг байгаа. Энэ нь 20 хувийн АМНАТ-тайгаар гэсэн үг. Хэрвээ энэ амнатыг 5 хувь нэмэх нь 5 хувь, өсөн нэмэгдэх хамгийн дээд тал нь 10 хувь болголоо гэхэд нэгжийн өртөг 1 сая төгрөгөөр буурна. Ингэснээрээ өнөөдөр захын агуулга буурч 0,15-0,12 болсноороо Эрдэнэт үйлдвэрийн ашиглах боломжтой эдийн засгийн үр өгөөжтэй ордын нөөцийн хэмжээ 400 сая тонноор нэмэгдэнэ. 400 сая тонн гэдэг бол өнөөдрийн хүчин чадлаар 10 жил ашиглах нөөц. Насжилт 10 жилээр нэмэгдэнэ. 400 сая тонн гэдэг бол өнөөдрийн хүчин чадлаар, өнөөдрийн үнээр үнэлэхэд 50 их наяд төгрөгийн борлуулалтын орлого. 50 их наядаас жил тутам улс орон нутгийн төсөвт 2 их наядыг төлөх хэмжээний ийм нөөц. АМНАТ буурснаар энэ нөөцийг ашиглах боломж бидэнд нээгдэнэ. Хэрвээ АМНАТ энэ хэвээрээ байх юм бол энийг ашиглах боломж Эрдэнэт үйлдвэрт байхгүй. .../минут дуусав/

С.Бямбацогт: Бадамсүрэн гишүүн тодруулж асууя.

М.Бадамсүрэн: Тэгэхээр хууль санаачлагчийн зүгээс Тусгай хамгаалаттай газар нутгийн тухай хууль дээр геологийн судалгаа хийх гэдэг энэ зүйлээ больж, энэ Тусгай хамгаалаттай газар нутгийн тухай хууль дагалдуулж бариснаа татах хэрэгтэй. Энэ бол болохгүй асуудал шүү. Энэ бол экологийн тэнцвэр хангадаг асуудал гэдгийг л маш сайн ойлгох хэрэгтэй. Бид чинь далайгаа л алслагдмал, дээрээс дээс уур амьсгалтай, аль ч шатад татаж авч болно.

2-т нь ер нь иргэдийн буруу бол байхгүй шүү дээ. Төрийн байгууллагуудын олж илрүүлээгүй зөрчлийг иргэд, иргэний нийгмийн байгууллагууд илрүүлж байгаа шүү

дээ. Тийм учраас бид хүндэтгэлтэй хандах хэрэгтэй. Харин энийг иргэдээ ингэж үзэл бодлоо ардчилсан нийгэмд илэрхийлсний төлөө өндөр хариуцлага тооцно гэвэл энэ асар их эсэргүүцэлтэй тулгарна шүү. Бид бол ардчилсан нийгэмд амьдарч байгаа. Харин яагаад ингээд эсэргүүцээд байна гэдгийг зөв олж тогтоож холбогдох .../минут дуусав/

С.Бямбацогт: Дамдинням сайд нэмж хариулъя.

Г.Дамдинням: Тийм яах вэ, уул уурхай болон ер нь аливаа бизнес бол 3 талын оролцогч талын хамтын ажиллагаагаар хэрэгждэг. Иргэн байна, аж ахуйн нэгж байна, төр байна. Энэ 3 тэнцүү оролцоотой байж байж ямарваа нэг үйл ажиллагаа явдаг ардчилсан нийгэмд. Дан ганц иргэд гэж явбал аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж чадахгүй, төр нь тэнд оролцох боломжгүй болчихдог. Дан ганц төр гэвэл дарангуйлал болдог. Дан ганц компани гэвэл иргэдийнхээ эрх ашгийг хэт хохироодог. Тэгэхээр одоогийн байгаа хууль маань хууль ёсоор аж ахуйн нэгжүүд ажлаа явуулахад ирээд техникийг нь эвдчихнэ. Хашааг нь цөм өшиглөж орно. Тэгээд уул уурхайн аюултай бүс рүү нэвтрээд орчихно. Замыг нь хаана, гэрэл цахилгааныг нь тасална. Энэ чинь хууль бус үйлдэл шүү дээ. Тэгэхээр эд нарыгаа зүгээр хууль номын дагуу тэмцэх боломж нь нээлттэй. Тийм ажлаа хийгээч ээ л гэж байгаа юм.

Эрэлтэй холбоотой ажил дээр тусгай хамгаалалттай газар ямар ч хайгуул, олборлолтын үйл ажиллагаа хийх боломжгүй. Хориотой байгаа. Эрлийн ажил, хийнэ судалгааны ажил хийнэ гэсэн үг. Өөр юм хийхгүй.

С.Бямбацогт: Бадамсүрэн гишүүн тодруулъя.

М.Бадамсүрэн: Үгүй ээ, тэгвэл тэгээд судалгаа хийж яах юм. Тэнд угаасаа л ашигт малтмал хайхгүй, олборлохгүй бол судалгаа хийж яах юм. Тэр чинь онгон дагшнаараа экологийн тэнцвэр хангаад байж байг л дээ. Энд ганцхан хүн амьдардаггүй гэдгийг би хэлээд байгаа шүү дээ. Эх дэлхий гэдэг чинь амьтан, ургамал, цэцэг навч энэ болохгүй шүү. Энэ Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд эрэл судалгаа хийх энэ зүйлээ татаж авах нь зөв.

2 дахь нь энэ иргэдийн хувьд үнэхээр хууль зөрчсөн бол тэгээд хууль хяналтын байгууллага шийднэ шүү дээ. Тэгэхээр заавал ингэж нэг ийм айдсаар юм шиг иргэдийг ингэвэл тэгнэ, тэгвэл ингэнэ гэж энэ хууль хүчний байгууллагаар далайлах хэрэг байгаа юм уу. Энэ л их тийм буруу зүйл рүү л хөтөлнө дөө. Энийг их сайн бодох хэрэгтэй. Энэ их ноцтой үр дагавар авчирна шүү. Энийг сайн бодоорой.

С.Бямбацогт: Үг хэлчихлээ дээ. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн алга байна. Равжихын Эрдэнэбүрэн гишүүн алга байна. Гомбын Ганбаатар гишүүн байна. Асуултаа асууя.

Г.Ганбаатар: Тэрнээс өмнө байсан шүү дээ. Шөнийн мэнд. Ер нь энэ аливаа хуулийг шинэ санаачлах ч байна уу, шинэчлэн найруулах ч байна уу, нэмэлт, өөрчлөлт орох ч байна уу, тухайн салбарт ямар асуудал байгаа вэ, хүндрэл бэрхшээлийг л шийдэх гэж орж ирж байгаа гэж боддог шүү дээ би энэ хуулийг.

Би энэ Ашигт малтмалын тухай хуулийн амин сүнс нь уг нь АМНАТ байсан юм болов уу гэж харсан юм. Одоо 3 жилээр оролдохгүй болж байгаа юм байна. Тэгээд асуудлыг нь шийдэхгүй, хүндрэл бэрхшээлийг нь шийдэхгүй юм бол энэ хуульд өөр ямар гол өөрчлөлт байгаа юм.

Дээрээс нь АМНАТ дотроо тэр давхар АМНАТ-ийн тухай асуудал байгаа юм. Манай энэ боловсруулах үйлдвэр экспортлогч нар хүндрэл учруулаад байгаа юм. Манай улс шиг ийм хүдэр, баяжмал, бүтээгдэхүүний үе шат бүрд нь ийм АМНАТ авдаг улс ер нь дэлхий дээр хэд байна. АМНАТ-ийг Сангийн яам нь хариуцаж байна уу. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нь хариуцаад байна уу.

Дээрээс нь бид нар энэ АМНАТ-ийг жишиг үнээр тогтоосноос хойш хэдэн их наядын өр үүсээд байна вэ. Сангийн яам, Татварын ерөнхий газрынхнаас хүн байгаа юу. Улсын төсөв, орон нутгийн төсөв энэ үндэсний баялгийн санд мөнгө орохгүй, өр нэмэгдсээр л байгаа хэлбэр шүү дээ энэ чинь.

Дараагийн гол асуулт бол энэ хуулийн бас 42 дугаар зүйл байна. Энэ орон нутгийн оролцооны талаар ер нь сая ч бас яриад байна. Тэр сонгон шалгаруулалттай холбоотой. Сонгон шалгаруулалт гээд л нэг том талбай гэнэт эндээс ингээд олгочихдог. Орон нутгийн засаг захиргаа нь ч мэддэггүй, иргэд нь ч мэддэггүй. Яах вэ, энэ өмнөх хуульд нь ч байсан. Энэ яг хэвээрээ л орж ирж байна л даа. Тэгээд гэнэт иргэд, орон нутгийн захиргааны хооронд үл ойлголцол үүсдэг. Тэгээд явж явж тэр сумын дарга нар муу нэртэй болдог. Гэнэт газар олгосон юм шиг. Бэлчээр хумсалсан юм шиг. Энэ асуудлаа яаж зохицуулах юм бэ гэдэг 2 дахь асуулт байна. Энэ асуулт дээр хариултаа авчихаад, дараа нь тодруулъя.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч Болдын Жавхлан хариулъя. Дараа нь ажлын хэсэг бэлдэж байгаарай.

Б.Жавхлан: Ганбаатар гишүүний асуултад мэдээлэл өгье. Давхар АМНАТ гэдэг ийм тодорхойлолт ер нь хаана ч байхгүй. Тэгэхээр АМНАТ-ийн хураалтыг Сангийн яам хариуцна. АМНАТ-ийн тодорхойлолтыг мэдээж чиглэлийн яам нь өөрсдөө хариуцна. Тэгэхээр АМНАТ гэдгийг эцсийн бүтээгдэхүүн хүртэл АМНАТ авч байгаа юм. Тэгэхээр одоо олборлоод, баяжуулаад, бүх шатанд нь эцсийн бүтээгдэхүүн хаана хүртэл явагдах нь тэр хүртэл өмнөхийг нь цэвэрлээд, цэвэрлээд ингээд явдаг. Тэрийг давхар гэж яриад байдаг юм. Тэрнээс давхардуулж Амнат авдаг тийм юм ерөөсөө байхгүй. Энэ бол өөрөө АМНАТ-ийн яг боловсруулалтын шат бүрэн ингээд өөр өөр үйлдвэр, өөр өөр зөвшөөрөлтэй ийм шат шатанд явдаг учраас өмнөхийг нь цэвэрлээд, дараагийнх нь боловсруулалтын шатад авдаг. Харин алийг ямар түвшинд хүдрийг, баяжмалыг ямар түвшинд эцсийн бүтээгдэхүүн бэ гэдгийг тодорхойлох нь бол Уул уурхайн яамны өөрийнх нь бодлого. Зэс дээр, төмөр дээр, жонш дээр, нүүрсэн дээр аль шатандаа хүртэл боловсруулалт хийснийг эцсийн бүтээгдэхүүн гэж үздэгийг яам нь өөрөө тодорхойлоод, Засгийн газарт оруулаад ингээд Засгийн газрын тогтоолоор энийг баталдаг юм. Тэр гараад ирсэн тогтоолын дагуу АМНАТ хураалтыг Сангийн яам хариуцаж ингэж явдаг. 2022 онд жишиг үнэ рүү шилжсэн юм. Өмнө нь бол гэрээний үнээр явдаг байсан юм. Жишиг үнэ рүү явснаар өр гэхээсээ илүүтэй бараг 20-30 хувь илүү АМНАТ ордог болсон. АМНАТ илүү ордог болсон төсөвт. Өөрөөр хэлбэл Үндэсний баялгийн сан тэр хэмжээгээр нэмэгдсэн гэсэн үг. Тэгэхээр энэ жишиг үнэ рүү шилжсэн бол их тийм

дэвшилтэт зүйл болсон. Бусад тэр орон нутагтай холбоотой, хуулийн үзэл баримтлалтай холбоотой зүйлийг ажлын хэсгээс хариулсан нь дээр байх.

С.Бямбацогт: Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Энэ хуульд тэр АМНАТ-ийн дэвшил бол уг нь байсан юм. Тэгээд одоо ингээд улс төржөөд болсонгүй. Ер нь бол ил тод болгож байгаа, талуудыг хариуцлагатай болгож байгаа ийм олон давуу тал бас уурхайн хаалтыг бас нэлээн чангаруулж байгаа, нөхөн сэргээлтийг чангаруулж байгаа энэ хуулиар. Эрлийн талбайг нэмэгдүүлж байгаа, судалгааны ажлыг төр, хувь хамтарч хийх зохицуулалтыг хийсэн. Олон сайн давуу талтай ийм хууль оруулж ирж байгаа юм. Нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд бид зөвхөн АМНАТ-өөс бусад олон зохицуулалтууд бий. Эд нар маань ингээд явж байна. Аймаг, орон нутгаас бол Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйл дээр заавал зөвшөөрөл авдаг хуулиараа Аймаг, нийслэлийн Засаг дарга хуульд заасан үндэслэлээр татгалзах ч эрхтэй байдаг. Тэгэхээр бид бол Засгийн газрын тогтоолоор энэ хайгуулын талбайг тогтоодог. Тэгээд 2018, 2023 онуудад санал авсан. Одоо бас санал аваад л явж байгаа. Аймаг, орон нутгийн саналыг заавал авдаг юм шүү дээ Ганбаатар гишүүн ээ, хуулиараа.

С.Бямбацогт: Ганбаатар гишүүн тодруулж асууя. Гомбын Ганбаатар.

Г.Ганбаатар: Үгүй ээ, яах вэ аймаг, орон нутгийн гэхээсээ илүү тухайн уул уурхай явагдах гэж байгаа, хайгуул хийх гэж байгаа баг сумын иргэдийн зөрчлийн тухай би яриад байна л даа. Тэгээд л явж явж сонгон шалгаруулалт гээд ирдэг. Сумын иргэд нь ч мэддэггүй. Нэг нөхөр нь сонгон шалгаруулалтаар авсан талбай гээд л ороод ирдэг. Ахиад дээрээс нь тэр орон нутаг удирдаж байгаа сумынх нь дарга, багийнх нь даргад их хүндрэл учруулаад байдаг байхгүй юу. Энэ талаар би яриад байгаа. Орон нутгийн иргэдийн оролцооны 2 дахь асуудал нь би танд 2026 оны 05 дугаар сарын 11-нд Дорноговь аймгийн сумдаар явж ирснийхээ дараа энэ хууль дээр бас тухайн сумдад иргэдийн уулзалт дээр гарч байсан саналуудыг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд орсон саналуудыг би танд албан бичгээр хүргүүлсэн. Энэ оны 5 дугаар сарын 11-ний 3/5257 дугаартай бичиг очсон байх. Энэ саналын талаар ялангуяа Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд нутгийн захиргааны байгууллагатай хамтарч ажиллах, тэр нутгийн захиргааны байгууллага гэдгийг яг юу гэж ойлгох тухай .../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд асуучих уу. Асуултаа гүйцээчихье, дуусгачихъя.

Г.Ганбаатар: Ашигт малтмалын тухай хуулийн 43.1 дээр ажиллах хүчний талаар нийт тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь нийт ажилчдын 10 хувиас хэтрэхгүй гадаадын ажилтантай байх, 5 хувиас доошгүй нь орон нутгийн иргэд байх заалт 43.2 гээд. Яагаад гэвэл тусгай зөвшөөрөл эзэмшигч нь 43.1 дэх заалтыг зөрчвөл торгуультай гээд заасан. Гэвч тусгай зөвшөөрөл эзэмшигч нь туслан гүйцэтгэгч компаниа ажиллуулаад, хуулийн цоорхой ашиглан завших байдалтай байгаа тухай гээд орон нутаг дээр ажиллаж байхад иргэдээс гарсан саналуудыг би танд маш тодорхой хүргэсэн. Одоо болтол энэ хариугаа аваагүй байгаа. Энэ хуулийн саналууд дээр ямар заалтууд орсон бэ гэж.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. Индрийн 4 дүгээр микрофон. Дашпүрэв.

Б.Дашпүрэв: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт нь түрүүний хэлсэн дээр бас тодруулаад нэмээд хэлэхэд сумын иргэдийн Хурал болон аймгийн иргэдийн нийтийн Хурлаас саналыг нь 45 хоногийн хугацаанд хуульд нийцүүлэн саналыг хүлээж авч, сонгон шалгаруулалтын талбайд оруулж байгаа. Мөн аймагт, аймаг, нийслэлийн төрийн захиргааны байгууллагыг яаж явуулах вэ гэдэг дээр бид бүхэн бол томъёоллыг өөрчилж оруулж ирж байгаа. Энэ нь сум, дүүрэг, нийслэлийн Засаг дарга хамтран санал гаргаж, гэрээ байгуулж ажиллана гэдэг ийм заалтаар оруулж ирж байгаа гэдгийг хэлье.

Мөн түрүүн Энхтүвшин гишүүний асуултад бас дутуу хариулагдсан дээр нэмээд хэлэхэд 16 удаагийн хэлэлцүүлэг хийж, 1400 саналаар 2023 оны 03 сарын 9-ний өдөр Зөвшөөрлийн зөвлөлийн хэлэлцүүлгийг хийж, 2023 оны 10 сарын 26, 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаар .../минут дуусав/

С.Бямбацогт: Зөвшөөрлөө авсан юм байна. Тийм ээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудаар санал хураалт явуулах ёстой. Өнөөдөр чуулганы танхимд санал хураалтын ирц хангалтгүй байна. Санал хураалтыг хойшлууллаа.

22.09 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэхийг хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Ренчинбямбын Сэддорж танилцуулна. Индэр дээрээс танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Р.Сэддорж: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судалсны үндсэн дээр Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтын дагуу энэхүү үзэл баримтлалыг боловсрууллаа.

1.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор Алсын хараа 2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлагдаж, Хүний хөгжил төвтэй хөгжлийн бодлого хэрэгжиж эхэлсэн. Уг бодлогын үргэлжлэл болох 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт боловсролд бүх хүүхэд, залуучуудыг тэгш хамруулах зарчмыг баримталж, ялгаатай хэрэгцээтэй хүүхэд, залуучуудыг хамруулсан, тэдний гэр бүл, орон нутгийн онцлог байдалд нийцсэн тохируулгат орчин, дэд бүтэцтэй хувилбартай гэрийн сургалттай боловсролын үйлчилгээг бүх түвшинд бий болгох зорилтыг дэвшүүлсэн.

Улс орны хөгжил дэвшлийн урт хугацааны эдгээр зорилтыг хангахад тулгуур болох боловсролын салбарын эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжүүлж буй хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь энэхүү төслийг боловсруулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

Монгол Улс хүн амын бүтцийн хувьд 37,1 хувийг хүүхэд, залуучууд эзэлдэг харьцангуй залуу иргэдтэй улс орон юм. Тийм ч учраас хүүхдийн сурах эрх, хүүхэд хамгааллын асуудалд бодлогын түвшинд анхаарч, хууль, эрх зүйн орчныг тогтмол шинэчилж ирсэн хэдий ч бодлого, хөтөлбөр, хууль тогтоомж боловсруулан хэрэгжүүлэхдээ, хүүхдийн хөгжих, оролцох эрхийг бүрэн ойлгож хэрэгжүүлдэггүй, хүүхдийг хамгаалах субъект гэж харах хандлага давамгайлж байна гэж судлаачид дүгнэдэг.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах нэг үндсэн шалтгаан нь манай орны онцлог хэв шинж болсон уламжлалт бэлчээрийн мал аж ахуйтай холбоотой байгаа юм. Малчдын үйл ажиллагааны хүрээнд тулгарч байгаа бэрхшээл, хүндрэл, нөхцөл байдал, шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг судалгааны явцад авч үзэхэд малчин өрхийн хүүхдийн сургалтын асуудал чухлаар тавигдаж байна.

Одоогийн нөхцөлд дээрх хуулийн зохицуулалтаар малчин өрхийн хүүхэд 6 наснаас сургуульд суралцах нь тэдний хувьд, ялангуяа малчдын амьдралд хүндрэл бэрхшээл үүсгэж, 1 гэр бүл 2 талд тухайлбал, эхнэр нь сургуульд орсон 6 настнаа харж, сумын төв, аймгийн төвд удаан хугацаагаар сууж, бусадтай гэр бүлсэх, нөхөр нь уулын мухарт ганцаараа байх, архи дарс уух, архинд орох, улмаар гэр бүл салж, сарних тохиолдол гарч, амьдрал ахуйгаа зольж байгаа сөрөг үр дагавар гарч байна. Энэ асуудлыг цэгцлэх, шийдвэрлэх арга зам бол тэдний хүсэлтийн дагуу тухайн онд 6 нас хүрэх малчин өрхийн хүүхдийн 1, 2 дугаар ангийн сургалтыг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлтээр Боловсролын ерөнхий хуулийн 26.1.11-д заасан журмыг баримтлан гэрээр, зайн болон хувилбарт сургалтад хамруулах явдал юм.

Цаашид дэлхийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан хүүхдийн сурах эрхийг хүндэтгэж, сургалтын олон хэлбэрийг бий болгох болгон хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага үүсээд байна. Эх оронч үзэлтэй, амьдрах ухаанд суралцсан, авьяас чадвараа нээн хөгжүүлсэн, эрхээ хамгаалж чаддаг хөгжсөн Монгол хүүхдийг төлөвшүүлэхэд төрийн бодлого, дэмжлэг чухал юм. Тиймээс эх орны ирээдүй хойч, хүүхэд, багачуудын хөгжил, оролцоог дэмжих хууль, эрх зүйн орчин, сургалтын тогтолцоог олон улсын сайн туршлагад тулгуурлан боловсронгуй болгох, хууль, эрх зүйн үндэслэл, практик шаардлага бий болжээ.

2.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр дараах асуудлыг зохицуулахаар тусгана. Үүнд:

Малчин өрхийн тухайн онд 6 нас хүрсэн хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд элсүүлэн малчин эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлтэд үндэслэн 1, 2 дугаар ангийн сургалтад гэрээр зайн болон хувилбарт

сургалтаар хамруулж болно. Зайн болон цахим хэлбэрээр хувилбарт сургалтад хамрагдсан малчин өрхийн 8 настай хүүхдийг 3 дугаар ангиас эхлэн танхимаар сургалтад үргэлжлүүлэн сургана.

Малчин өрхийн хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд элсүүлэн сургах сургалтыг энэ хэлбэрээр зохион байгуулах журмыг Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах.

3.Хуулийн төсөл батлагдсаны дараах үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн

Хуулийн төсөл батлагдсанаар дараах үр дагавар гарна. Малчин өрхийн хүүхдийн боловсрол эзэмших зорилго, хүүхэд сурах, боловсрол эзэмших арга хэлбэр тодорхой болж, боловсролын хөгжлийн чиг хандлагад нийцсэн арга хэмжээ болн. Боловсролын салбарын эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэн хүний хөгжлийн үзүүлэлтийг нэмэгдүүлэх, хөгжлийн бодлогоо бүх түвшинд хэрэгжүүлэх чадвартай иргэдийн оролцоог хангасан тогтвортой засаглал төлөвших үндсийг бүрдүүлэх суурь нөхцөл болно.

Хүний хөгжлийн үндсэн хэмжүүр нь хүний хөгжил байх гол зарчмыг үндэс болгон хуулийн төслийг боловсруулах ба иргэн бүр боловсрол эзэмшиж амьжиргаандаа хүрэлцэхүйц орлоготой болох боломжийг бүрдүүлж, ядуурал, ажилгүйдлийг бууруулах, дундаж орлоготой өрхийн тоог нэмэгдүүлж, хүн амын амьжиргааны түвшнийг дээшлүүлэх, мэдлэгт суурилсан нийгэм, ур чадвартай, зөв хандлагатай монгол хүнийг төлөвшүүлэх зорилгод нийцнэ.

4.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцэж байгаа бөгөөд тухайн хуулийг дагалдан түүнийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл боловсруулах болно.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Сэддорж гишүүнд баярлалаа. Төслүүдийн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мягмардашийн Сарнай танилцуулна. Таныг индэрт урьж байна.

М.Сарнай: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж нарын 36 гишүүнээс 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг

хэлэлцэх эсэх асуудлыг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Хууль санаачлагч нь малчин өрхийн хүүхдийн боловсрол эзэмших эрхийг бодит нөхцөл хэрэгцээнд нь нийцүүлэн хангах, сургалтыг хувилбарт зайн болон цахим хэлбэрээр явуулах, хүүхдийн сурах боломжийг өргөжүүлэх, боловсролын хүртээмж, тэгш байдлыг сайжруулах шаардлагатай гэж үзэн хуулийн төслийг боловсруулсан байна.

Дээрх хуулийн төслийг иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын D-Paliament.mn цахим сайтад байршуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун тус чиглэлээр өмнө нь хэрэгжиж байсан сайн туршлага байгаа эсэх, төсөлтэй холбоотойгоор Засгийн газрын байр суурь боловсролын салбарын бодлого, үйл ажиллагааны хэрэгжилттэй хэрхэн уялдаж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл хуулийн төсөл батлагдсанаар хэзээнээс хэрэгжиж эхлэхээр төлөвлөж байгаа, төсөлд малтай өрхийн иргэд хамаарах эсхүл зөвхөн малчин өрхийн хүүхдэд үйлчлэхээр зохицуулсан эсэх талаар, зайн болон явуулын сургалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөц, техник, санхүүгийн боломж хүрэлцээтэй эсэх, хэрэгжилтийн явцад үүсэж болзошгүй хүндрэл эрсдэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг 1, 2 дугаар ангийг зайн хэлбэрээр суралцуулснаас үүдэн суурь мэдлэг болох унших, бичих, сэтгэн бодох, нийгэмших чадварын хоцрогдол үүсэх эрсдэлийг хэрхэн тооцсон, мөн уг эрсдэлийг бууруулах эцэг эхэд дэмжлэг үзүүлэх ямар арга хэмжээ төлөвлөж байгаа талаар асуулт асууж, хариулт авсан бол Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун төсөлд тусгасан зохицуулалтууд Боловсролын ерөнхий хуулийн зарим зохицуулалттай давхцаж байгаа талаар, энэхүү сургалтын хэлбэр нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх хэрэгцээтэй талаар, зайн болон явуулын сургалтын хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийн сурлагын үр дүн, хүртээмж, үр нөлөөг үнэлсэн судалгаа байдаг эсэх, малчин өрхийн эцэг эхчүүд хүүхдэдээ хичээл заах боломж чадавхын талаар судалгаа хийх, мөн тэдгээрт зориулсан гарын авлага, дэмжлэгийг бүрдүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл хөдөө орон нутагт интернэт сүлжээний хүртээмж хангалтгүй байдгаас зайн сургалтыг хэрэгжүүлэхэд үүсэх хүндрэл эрсдэлийг анхаарах талаар санал хэлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11-д заасны дагуу сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт мэдүүлсэн хуулийн төслийн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг

хэлэлцэх эсэх талаар Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Сарнай гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Батсүхийн Бадамжав Боловсролын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Лхагвасүрэнгийн Ганбат Боловсролын яамны Ерөнхий боловсролын газрын дарга, Арьяагийн Цолмон Боловсролын яамны Ерөнхий боловсролын бодлогын газрын ахлах шинжээч.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төсөл үзэл баримтлалтай холбогдуулж урьдчилан ирүүлсэн нэсрийн дагуу асуулт асууна. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэболд: Гал морин жилийн гал хөх морин сарын цагаан морин өдрийн 22 цаг 22 минут. Өнөөдөр өдөр сайн хуралдаж байна. Энэ хууль их бас сонирхолтой. Ер нь ноднин намар манай Сэддорж гишүүн бас яг энэ сэдвийг бас байнга ярьж байсан л даа. Тэгээд энэ асуудлын цаана бас нийгмийн амьдрал, хүн ам зүйн бодлого, хүүхдийн боловсрох эрх, аюулгүй байдал, гэр бүлийн тогтвортой байдал гээд маш олон сэдвүүд бол байгаа.

Би бас Дархан, Сэлэнгэ, Төв аймгаас сонгогдсон. Манай төвийн бүсэд энэ жил 72.334 хүүхэд сурч байгаагаас яг 1, 2 дугаар ангид 10-аад мянган хүүхэд сурч байгаа. Тэр арваад мянган хүүхдийн дийлэнхийнх нь бас нөхцөл байдал бол яг энэ асуудалтай уялддаг. Ерөнхийдөө бол 3, 4 асуудал гардаг.

1 дүгээрт нь яг энэ боловсролын чанарын асуудал буюу 1 багш хэдэн хүүхэдтэй харьцах вэ.

2 дугаарт бол ихэнх манай сургуулиуд 50-аас дээш жилийн насжилттай болчихсон. Байрны асуудал, халуун, хүйтний асуудал.

3 дугаарт хүүхдийн сургууль, сургуулийн аюулгүй орчны асуудал гээд эдгээр асуудлууд ордог. Үүнтэй уялдаад нийгэм, хүн ам зүйн бодлоготой холбоотой шууд зүйл нь энэ 6 настай хүүхдийн асуудал байгаа. Тэгэхээр хүний эрхийн бас манай Баасанжаргал гишүүн дэд хороон даргаар ажиллаж байгаа. Хүний эрхийн Үндэсний комиссоос гаргасан судалгаагаар манай Хунан гишүүн хэлж байсан. Хот суурин газар байгаа хүүхэд, дээрээс нь энэ сум, орон нутагт байгаа хүүхдүүдийн боловсролын гарааны тэгш байдал буюу хүртээмж бас их ялгаатай байгаад байна гэдэг асуудал явагдаж байгаа. Энэ дээр нэмэгдээд Сэддорж гишүүний санаачилж байгаа хуульд 8 нас хүртэл нь цахимаар хичээл авах боломжийг нь нээж өгөөд, ингээд 8 настайгаасаа 3 дугаар ангиасаа буюу 8 настайгаасаа орно гэсэн энэ зохицуулалтыг хэлж байгаа.

Тэгэхээр энэ дээр би Боловсролын яамнаас яг мэргэжлийн хүмүүсээс нь асуулт асууя.

Монгол орон бол нэлээн онцлогтой. Хүн ам зүйн хувьд цөөхөн ч гэсэн өргөн уудам нутаг дэвсгэрт оршин тогтнож байгаа ийм улсын хувьд бас энэ онцлог нь шинжлэх ухааны хувьд бөгөөд яг практикийн хувьд хэр зэрэг ач холбогдолтой вэ. Энэ хууль яг энэ зохицуулалтаараа батлагдсан тохиолдолд ямар ямар нийгэм, хүн ам зүйн эерэг үр дүн гарах вэ. Ингэхдээ ямар нэгэн байдлаар 6 настай хүүхдээс хойно буюу төв суурин газруудын хүүхдүүдээс 2 жилийн дараа танхимын сургалтад хамрагдлаа гэхэд тэдгээр хүүхдүүдэд ямар нэгэн хоцрогдол гарах эрсдэл бодитоор байх уу, үгүй юу гэдэг дээр хариулт авмаар байна. Ингээд хариултаас шалтгаалаад тодруулга авъя.

С.Бямбацогт: Хууль санаачлагч хариулах уу. Хэн хариулах вэ. Яамнаас асуусан. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон. Ганбат дарга хариулъя.

Л.Ганбат: Бүгдээрэнд нь оройн мэнд хүргэе. Гишүүний асуултад хариулъя. Ерөнхийдөө Сэддорж нарын гишүүдийн санаачилсан малчны хүүхдийн боловсролын асуудалтай холбогдолтой хуулийн өөрчлөлтийг бол зарчмын хувьд агуулгын хувьд бол Боловсролын яам боломжтой гэж бол дэмжиж байгаа.

Гэхдээ энэ дээр 1 зүйлийг тодотгох хэрэгтэй. Бид нар бол яг энэ хуулийн төсөл дээр заасанчлан зайн болон гэрийн сургалтыг гэдэг зарчмаар явж байгаа. Энэ дээр бол Боловсролын яамны өмнөх ковидын 2 жилийн зайн сургалтын үеэр гарч байсан үр дүн, сүүлд ПИСА судалгааны үр дүнгээр гарч байсан зэрэг үр дүнгүүдийг ингээд хараад үзэх юм бол зөвхөн дан ганц зайн сургалтаар, цахим сургалтаар явагдах боломжгүй юм. Энэ нь бас магадгүй хоцрогдлыг бас илүү бодитоор үүсгэх нөхцөл бүрдэнэ. Ер нь бол цаашдаа яг үүний хамгийн зөв хэлбэр бол гэр бүлд суурилсан сургалт, багшийн дэмжлэгтэй зайны сургалт, улирлын онцлогтой танхимын сургалтын хосолсон хэлбэрээр ингэж явагдах юм бол энэ бас олон улсынхаа жишигт бас нийцэж байна. Нөгөө талаасаа бодит байдал дээр малчны хүүхдүүдийг сургалтын хоцролтын чанарын асуудалд бас оруулахгүйгээр хэрэгжүүлэх ийм үндсэн боломжтой юм гэдэг байдал дээр бол төлөвлөж харж байгаа. Энэ дагуу бас бэлтгэл ажлуудыг тооцоо судалгаануудыг агуулгын өөрчлөлтүүдийн юмнуудыг гаргаж, энэ намраас зарим нэг газрууд, аймаг дээр бас туршилт байдлаар хэрэгжүүлэх гэсэн ийм төлөвлөгөөтэй бол явж байна.

С.Бямбацогт: Эрдэнэболд гишүүн тодруулъя.

С.Эрдэнэболд: Тэгэхээр яг гол асуудал нь бол яг энэ хууль батлагдлаа гэхэд эдийн засгийн ямар зайлшгүй хөрөнгө оруулалтууд ямар хугацаанд хийх шаардлагатай вэ. 1 дүгээрт.

2 дугаарт энийг хэвшүүлж хэрэгжүүлэхэд хэчнээн жил шаардлагатай вэ.

3 дугаарт бол эцэг эхийн бас үүрэг оролцоо нэмэгдэж байна. Яг малчин өрхүүд, эцэг эхчүүдэд тийм бодит боломж, тийм чадавхжих хугацаа нь ямар хугацаагаар хэмжигдэж байгаа вэ. Ер нь зүгээр ийм практик туршлага хэр зэрэг байдаг вэ. Зүгээр яах вэ Монголын онцлогтой гэдгээр нь хийлээ гэхэд энд ер нь та ямар хугацаа шаардагдана гэж үзэж байгаа вэ. Жишээлбэл бид нар ингээд Монгол хэлний хуулийг 2015 онд батлаад, 2025 оны 01 сарын 01-ээс хэрэгжүүлж эхэлсэн гэж байгаа боловч хангалттай энэ бол үр дүнгээ өгөхгүй байгаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр та мэргэжлийн байгууллагын зүгээс хариулт өгөөч. Саяын 3 асуултад.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. 4 дүгээр микрофон.

Л.Ганбат: Гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Ерөнхийдөө статистик тоон мэдээллээс харах юм бол ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа нийт 819.907 суралцагч байгаа. Энэ дотроос бол 130.111 нь бол малчдын хүүхдүүд суралцаж байна гэдэг, малчин өрхийн хүүхдүүд суралцаж байна гэдэг статистик. Энэ дотроосоо 1 дүгээр ангид малчин өрхийн хүүхэд суралцаж байгаа 11.200 гэсэн тоо байж байгаа. Тэгэхээр бид нар бол мэдээж энэ заалт батлагдлаа гэж бодоход бол эдгээр тооны бүх хүүхдийг бол нэгэн зэрэг бүгдийг нь хамруулна гэсэн ойлголт байхгүй. Эцэг эхийн хүсэлт дээрээс үндэслэнэ гэж байгаа. Гол заалт нь. Тэгэхээр ер нь бол хэрэгжих хугацааг энэ намраас бид нар дор хаяж 1-2 жилийн хугацаанд туршилтын байдлаар хэрэгжүүлж, бүх тохируулсан нэмэлт тохируулга, хөтөлбөр юу байдаг юм, сургалтын арга зүй, бүх асуудал дээр тохируулга туршилт үндсэн дээрээс хийж байж 2028 он гэхэд 3 дахь жил дээрээсээ үндсэндээ хүсэлт гаргасан малчин иргэдийн малчин өрхийн хүүхэд бүр дээр ... /минут дуусав/

С.Бямбацогт: Сэддорж гишүүн, хууль санаачлагч хариулъя.

Р.Сэддорж: Эрдэнэболд гишүүний асуултад нэмж хариулъя. Манайх бол энэ 12 жилийн сургалтын системд шилжээд, 20-иод жил болж байгаа юм байна. Энэ 20-иод жилийн хугацаанд бол хүндрэл бэрхшээл Монгол Улсын 330 сум, 21 аймагт гарсан. Тэгээд энэ 6, 7 настай хүүхдүүд байранд, дотуур байр байгаад ч байранд ганцаараа суух ийм боломжгүй. Ээжийнхээ өврөөс гараагүй хүүхдийг Монголчууд ганцааранг нь хэзээ ч явуулахгүй. Ийм учраас 6, 7 настай хүүхдээ дагаад айл гэр 2 тусдаа амьдраад, ингээд сая дурдсан олон асуудлууд үүсэж байгаа. Тийм учраас энэ хууль бол зөвхөн сонголтоор аав ээж нь хүсвэл боломжтой айл байна, боломжгүй айл байна, сумын төв дээрх айл байна, сумын төвд ойрхон айл байна, хол айл байна. Гэр бүл нь өнөр өтгөн айл байна..../минут дуусав/

С.Бямбацогт: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуултаа асууя.

Х.Баасанжаргал: Би одоо Боловсролын яам ийм хариулт өгөөд зогсож байгаад бол яг үнэндээ бүр сая бол ёстой чихэндээ итгэсэнгүй шүү. Энэ 3, 4 заалттай хуулийн төсөл байгаа шүү дээ. Энэ дээр ямар ч тэр бэлтгэлтэй холбоотой та нарын хэлээд байгаа тэр олон хувилбартай холбоотой ямар ч заалт байхгүй байгаа шүү дээ. Бид нар Ковид 19-ийн цар тахлаас авсан сургамжаа ийм хурдан мартчихаж байгаа юм уу. Хүүхдүүд хэчнээн их сургалтын хоцрогдолд орлоо. Ялангуяа бага ангийн хүүхдүүд унших, бичих, хамгийн гол нь нийгэмших. Хүүхдүүд өдөр болгон анги дээрээ очно, хүүхдүүдтэй харилцана, багштайгаа харилцана, найз нөхөдтэй болно. Энэ хэрэгцээг нь та нар юугаар хангах гэж байгаа юм. Яаж хангах гэж байгаа юм. Зөвхөн эцэг эхийн хүсэлтээр энэ асуудлыг шийддэг юм гэнэ. Уучлаарай. Боломжтой, боломжгүй айлыг нь та нар яаж мэдэх юм. Ийм гоомой ийм хуулийн төсөл оруулж ирж байхад нь бүхэл бүтэн Боловсролын яам та нар чинь хаашаа юм бэ. Нөгөө ПИСА-ийн үнэлгээнийхээ дүнгүүдээ бүгдээрээ ингээд мартчихдаг юм уу. Ийм харамсалтай ийм зүйл яриад сууж байна гэж юу гэсэн үг юм бэ.

Түрүүн Эрдэнэболд гишүүн хэлсэн. Хүний эрхийн Үндэсний Комиссоос дүгнэлт гарсан гээд. Хот, хөдөөгийн хүүхдийн боловсролын ялгаа асар их байна гээд. Энийг улам гүнзгийрүүлэх гэж байна шүү дээ. Малчны хүүхдүүд гэрээсээ сурдаг.

Интернэттэй, интернэтгүй, утас, зурагт янз бүрийн байдлыг зарим тохиолдолд тоггүй. Та нар бүгдээрээ хөдөө орон нутгаас сонгогдсон гишүүд нөхцөл байдал ямар байдгийг бүгдээрээ мэднэ шүү дээ. Тэгээд эхнэр, нөхөр 2-ыг хамт байлгахын тулд хүүхдийг та нар золиосолж байгаа юм уу. Өөр арга зөндөө арга байгаа шүү дээ. Тэр дотуур байрыг нь сайжруулах тухай та нар яагаад ярихгүй байгаа юм. Дотуур байрны үйлчилгээг нь сайжруулах тухай яагаад ерөөсөө бодохгүй байгаа юм. Тэнд хүүхдийг асран хамгаалах үйлчилгээ байх ёстой гээд иргэний нийгмийн байгууллагууд сүүлийн 5, 6 жил бүх судалгааг нь хийгээд, бүх танилцуулга мэдээллүүдийг нь бэлдээд, сүүлдээ Азийн хөгжлийн банк энэ жилээс эхлээд 5 дотуур байранд загвар 5 дотуур байр гаргаж үзэх гэж байна. Тэгээд зөвхөн томчууд өөрсдийнхөө эрх ашгийн үүднээс та нар энд ингэж хандаж болох юм уу. Хүүхдүүдийн боловсролын хоцрогдлыг та нар яаж нөхөх юм. Ковидынхоо хоцрогдлыг нөхсөн юм уу Боловсролын яам. Нөхөж чадаагүй байгаа биз дээ. Тэгээд үүний төлөөсийг хэн төлөх юм. Тэгээд сүүлдээ малчны хүүхдүүд зайнаас сурсан хэзээ нийгэмшихийн, бага ангийн боловсролын маш олон ур чадвар энэ хүүхдүүдэд дутагдана шүү дээ. Би ч гэсэн адилхан өнөөдөр орон нутгаар явсан. Орон нутгийн малчид харин хамгийн их үүнийг чинь эсэргүүцэж байгаа шүү. Булган аймгийн Дашинчилэн сум, Баяннуур .../минут дуусав/

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Ажлын хэсэг хариулах уу. Сэддорж дарга хариулах юм уу. Яам хариулъя. Тэр эрсдэлийг яаж бууруулах юм гэж байна. Бас санаа зовниж асууж байна.

Л.Ганбат: Гишүүний асуултад хариулъя. Энэ бол мэдээж маш чухал асуудал. Мэдээж хоцрогдлын асуудлыг нөхөх тухай бас өмнөх үүссэн асуудлууд дээр ахиж нэмж гарч болзошгүй бас ийм асуудлууд үүсэж байгаа. Тэгэхдээ хамгийн гол нь одоогийн бид нарын Боловсролын яаман дээр энэ загварыг эцэслэн бас гаргаж, яг тэгнэ гэж шийдсэн тодорхой юм бол байхгүй байна. Судалгааныхаа түвшинд бүх юм явагдаж байна. Энэ дээр нэмэлтээр ингээд л бүр дэлгэрэнгүй тайлбарлах юм бол магадгүй малчин өрхийн хүсэлт дээр нь тулгуурлана гэдэг гол үндсэн концепц байж байгаа юм. Эцэг эхийг нь чадавхжуулна гэдэг бас 1 асуудал байж байгаа юм. Явцын ахицын үнэлгээг байнгын тогтмол хийнэ. Хэрвээ хүүхдийн хоцролтын асуудал бодитойгоор нүүрлэх юм бол тэрийг танхимын сургалтад шилжүүлэх арга хэмжээ авна ч гэдэг юм уу ингээд тодорхой энэ асуудлыг зохицуулсан нэмэлт журам, хөтөлбөр гаргаад, тэр дээрээ холбогдох бүх журмууд, зохицуулалтууд нь хийгдээд явах байх гэж бодож байна.

С.Бямбацогт: Баасанжаргал гишүүн ээ, Боловсролын яам, Засгийн газар хууль санаачлаагүй. Хууль санаачлагч хариулах ёстой. Тэгээд хөөрхий Боловсролын яамныхныг загнаад байх юм байхгүй. Тэр зөвшөөрсөн үндэслэлээ л ярих ёстой. Яг үзэл баримтлалаа бол хууль санаачлагч хариулах ёстой. Сэддорж гишүүн хариулъя.

Р.Сэддорж: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Хот, хөдөөгийн ялгаварлал их гарна гэж байна. Монгол бол дэлхий дээр хамгийн агуу түүхтэй улс гүрэн. Дэлхий Монголыг сонирхож, Монголын төлөө Монголыг яг энэ унаган төрхөөрөө байгаасай гэж хүсэж байгаа юм. Ийм учраас бид Монгол хүнийг бэлдэх ёстой. 1 дүгээрт гэр бүл элэг бүтэн, бүрэн бүтэн байх ёстой. Энэ гэр бүлийн аюулгүй байдал хамгийн чухал. Та бүхэн хөдөө Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн бүтэн

байдлыг харж хамгаалж байгаа байгаль орчин, өв соёлтой нь харж хамгаалж байгаа энэ олон мянган малчдыг төр анхаарах ёстой. Энэ анхаарлын нэг нь бол энэ хууль.

С.Бямбацогт: Бейсен гишүүн асуултаа асууя. Баасанжаргал гишүүн тодруулъя.

Х.Баасанжаргал: Би эрсдэлүүдийг 1, 1-ээр нь дурдъя.

1 дүгээрт 1-2 дугаар ангийн хүүхдүүд хамгийн их ковид 19-өөс хохирсон хүүхдүүд гэдэг нь олон улсын судалгаагаар нотлогдсон. Нэг эрсдэл.

2.Хүүхэд зөвхөн хичээл биш нийгэмших эрхээ алдана. Нийгэмших бүх боломж чадавхуудаа суурь боломжуудаа алдана.

3.Малчин хүүхдийн боловсролын ялгаа улам гүнзгийрнэ. Энийг бид нар бүр албан ёсны тогтолцоо болгоод хуульчлах гэж байна. Ялгаатай байхыг.

4.Цахим сургалтад бүх айл өрхүүд цахим сургалтад хамрагдах боломжгүй байгааг та нар бүгдээрээ сайн мэдэж байгаа. Боломжтой, боломжгүй гээд энэ бүх зүйлийг та нар яаж нөхөх юм.

5.Хүүхэд хяналтгүй орчинд орно. Зөвхөн эцэг эхээс гадна боловсролын байгууллага чинь багш чинь тэр хүүхдийг сурч байна уу, ямарваа нэгэн хүчирхийлэлд өртөж байна уу, зүй бус хөдөлмөрт орж байна уу гэдгийг бас .../минут дуусав/

С.Бямбацогт: Асуултаа гүйцээж асууя. Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Хүүхдийн хүчирхийлэл, хүүхдийн үл хайхрах гээд олон хүүхдийн хүчирхийллийн хэлбэрүүд байгаа. Энэ бүх юмнаас хамгаалдаг маш том байгууллага бол боловсролын байгууллага.

7.Ерөөсөө ямар тохиолдолд зайнаас ургадаг юм бэ гэвэл энэ бол богино хугацаанд,түр хугацаанд авдаг арга хэмжээ. Дэлхийн олон улсын байгууллагууд НҮБ ковидтой холбоотой маш олон зөвлөмжүүдийг улс орнуудад өгсөн шүү дээ. Тэгээд энэ түр арга хэмжээг бид нар байнгын арга хэмжээ болгох гээд байх юм. Би яагаад Боловсролын яам бухимдаад байна вэ гэвэл бүхэл бүтэн мэргэжлийн байгууллага нь болно гээд энэ дотор ингээд орж ирээд, тайлбарлаад суугаад байдаг. Тэгсэн хэр нь өөр олон хувилбарууд байж болно гээд. Хуулийн төсөлд нь тийм заалт байхгүй байгаа шүү дээ. Би бол Сэддорж гишүүнийг Их Хурлын гишүүний хувьд ийм хэрэгцээ шаардлага байна гээд хуулийн төсөл санаачилж байна. Гэхдээ мэргэжлийн байгууллага нь энэ дээр мэргэжлийн чиглүүлэг зөвлөмжүүд ажиллах хэрэгтэй шүү дээ. Тэгээд 3 заалттай хуулийн төсөл барьчхаад өнөөдөр орж ирээд, тэгээд тэрийг нь болно гээд ингээд дэмжээд, тэгээд 1 2 жил .../минут дуусав/

С.Бямбацогт: Сэддорж гишүүн хариулъя.

Р.Сэддорж: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Нийгэмших гэдэг асуудал байна. Нийгэмших гэдэг бол магадгүй тэр малчин айлын хүүхэд бол хамгийн сайн Монголоо мэддэг нийгэмших боломжтой ийм хүүхэд орж ирнэ. Анги

дотор Монгол ёс заншлаа мэддэг, үндэснийхээ соёлыг мэддэг хүүхэд бол илүү нэр хүндтэй байна. Малчин хүүхдийн боловсролын ялгаа гэж байна. Байгаль экологийн, хүний ёсны Монгол ёс заншлаараа тэр хүн бол илүү боловсролтой хүн 3 дугаар ангидаа орж ирнэ. Цахим нөхцөл байдлыг бол малчин хүн өөрөө шийднэ, багийн дарга нь анхаарна, сумын дарга нь анхаарна, аймгийн дарга нь анхаарна, сургуулийн захирал нь анхаарна, ангийн багш нь бол байнга анхаарна. Ангийн багш нь бол шууд өдөр тутамдаа анхаараад явчихн.

С.Бямбацогт: Бейсен гишүүн асуултаа асууя. Буланы Бейсен гишүүн.

Б.Бейсен: Энэ хуулийн төслийг дэмжиж байгаа юм. Маш сонирхолтой бөгөөд шаардлагатай хуулийн төсөл байгаа. Яагаад гэвэл 6 настай хүүхдийг сургуульд оруулж, дотуур байранд байлгаж байна, хамаатан садандаа гэрт нь тавьж байна. Зарим нь хөдөөгөөс орж ирчхээд байр хөлсөлж байна. Байртай нь байрандаа байж байна гэх мэт. 1 айлын 6, 7 настай, 6, 8, 9 настай 3 хүүхэд байхад 1 юунд байж байна. Тэгэхээр энэ хүүхдүүдийн хувцаслалт, хооллолтын асуудал, гэрээ санах асуудал жоохон хүүхэд юм. Тэгээд энэ дээр бас анхаараад цахим сургалт гээд хууль санаачилсан байна л даа. Тэгэхээр энэ дээр 1 анхаармаар асуудал байна. Энэ улсын хэмжээнд хэрвээ 6, 7 настай хүүхэд цахим сургалтад хамруулбал улсын хэмжээнд хэчнээн хүүхэд хамрагдахаар байна. 1 дүгээрт.

2 дугаарт, сургалтын төлөвлөгөө байх ёстой. Жшээлбэл тэгээд цахим гэхээр чинь гар утсаар хангах юм уу, iPad-аар хангах юм уу, компьютероор хангах юм уу гэтэл хөдөөд тэр нь тог нь байна уу. Гол нь малчин өрхүүд 4, 5 хүүхэдтэй гэхэд 1, 2-ыг нь малчин болгоод, 3-ыг нь сургаж байгаа шүү дээ. Бүгдийг нь бас сургаж чадахгүй. Бүгдийг нь сургаад хот руу орчхож байгаа айлууд ч байж байна. Тэгэхээр энэ залуу малчин бэлтгэх асуудал байж байна. Цахим сургалтаар малчин болох хүүхдээ цаашдаа ер нь хэлний хичээлд тоо бодож чадах, түүхийн хичээлд нөгөө талаар мал аж ахуйн сургалтын программ гэж байна уу. Энэ төлөвлөгөөнд ер нь яаж тусгаж байна. Тэгэхгүй бол энэ дээр бас нэлээн асуудал гарчих вий гээд байна. Энэ талаар асууя. Дараа нь тодруулъя.

С.Бямбацогт: Сэддорж гишүүн хариулъя. Хууль санаачлагч.

Р.Сэддорж: Бейсен гишүүний асуултад хариулъя. Энэ бол дан ганц цахим сургалт гэж үзэхгүй байгаа. Боловсролын яам бол хөтөлбөрөө нарийн гаргана. Ингээд энэ намраас эхлээд Боловсролын сайдын хэлснээр энэ намраас эхлээд туршилт явагдана. Энэ хууль маань намар батлагдах байх. Энэ хавар арай амжихгүй байх. Тэгэхээр энд бол явуулын багш очно. Ангийн багш нь хариуцна, хайхарна. 9 сарын 1-ээс эхлээд л 6 настай хүүхдийг миний зүгээр ойлгож байгаагаар бол 6 настай хүүхдийг бол 9 сарын 1-ээс эхлээд л гэрт гэртээ байхад нь малчин хүүхдүүдээ ангийн багш нь бүртгээд авчихна. Анги нь бол жишээ нь чөлөөт цаг, дадлага тойрон аялал маягаар тэр хүүхдүүддээ очно. Тэр хүүхэд нь байнга бас аав, ээж нь сум, аймгийн төв рүү очиход бас тэр ангидаа очно, хүүхдүүдтэйгээ ойрхон байна. Харилцан дадлага хийнэ, туршлага солилцоно. Явуулын номын сан, явуулын хичээлийн байр эд нар бас явахад боломжтой. Тэгээд манай аймаг, сумдуудад чинь бол тэтгэвэрт гарсан маш олон бага ангийн багш нар байгаа. Маш туршлагатай хүмүүс байгаа. Тэд нарыгаа тодорхой хэмжээнд урамшуулаад ингээд явуулах боломжтой. Ер нь 1 сумд бол 6 хүүхэд л байна лээ дээ. 6-10 хүүхэд л байна лээ. 1 дүгээр ангид орж байгаа. Энэ 10 хүүхдийг бол сумын дарга, багийн дарга,

сургуулийн захирал, тэр ангийн багш бол бөөцийлнө шүү дээ. Тэгээд хамгийн чухал хүмүүс бол аав ээж, эмээ өвөө нар. Энэ хүмүүс хүүхдүүдээ боловсролгүй болгоё гэж хэн ч бодохгүй. Хамгийн чухал юм бол гэр бүл. Гэр бүл аюулгүй байх ёстой. Гэр бүл бүрэн бүтэн байх ёстой. Мэдээж хүүхдээ маш сайн сургана. Эндээс бол ирээдүйн Монгол Улсын удирдах хүмүүс ч төрөхийг үгүйсгэхгүй. Одоо Монгол Улсын Боловсролын сайд бол ярьж байна шүү дээ. Хэл зүгшрүүлэх хөтөлбөр гаргахгүй бол Монголоороо ярьдаг хүүхэд төв суурин газруудад цөөхөн болж байна шүү гэж ярьж байна. Тэгээд бид бол хэтэрхий туйлширч, хүүхдүүдээ унаган хэлнээс нь салгаж байгаа асуудал байгаа юм. Энэ хүүхдүүд бол тэрний хажууд унаган хэл дээрээ, унаган соёлоо үүрээд ингээд 3 дугаар ангидаа бие даах чадвартай болоод ороод ирэх ийм хүүхдүүд юм. Энэ бол Монголын ирээдүй. Монгол Улс бол өөр, дэлхий нийтээс өөр. Монголчууд 12 жил сурах бараг шаардлагагүй, дэлхийн хамгийн оюуны потенциалтай хүмүүс. Бид хуучин 3 сард сурдаг байсан 35 үсгийг 12 жилд орсноос хойш бүтэн 1 жил үздэг болсон байна шүү дээ. Тэгээд энэ бол дэндүү удаан хөтөлбөр байхгүй юу.

С.Бямбацогт: Бейсен гишүүн тодруулъя.

Б.Бейсен: Тэгэхээр бас 1 асуудал байна. 1 дүгээр ангид 1 сумд 2 1 дүгээр ангийн хүүхэд байлаа гэхэд тэр ангийн багш нь тэр хүүхдийг бүртгэж аваад, тэгээд эргэж байх юм уу. Аль эсвэл сургалтын ямар хэлбэрийг ашиглах юм. Жишээлбэл 5 дахь, хагас сайн өдөр эргэж очих байх. Бүтэн сайн өдөр ч юм уу. Нөгөө тэтгэвэрт гарсан багш нар тэр болгон очихгүй. Тэгэхээр чинь тэрийг 1 дүгээр ангийн цахимд сурч байна гээд нөгөө 1 дүгээр ангийн багш нь бүртгэж авах асуудал юу болох бол. Тэр ер нь дараа нь орж ирэхээр чинь сурлагын хоцрогдол байх юм уу. Тэр талын асуудал дээр сургалтын материал энэ тэр дээр онцгой анхаарах тал дээр юу баримталж байна.

С.Бямбацогт: Сэддорж гишүүн хариулъя.

Р.Сэддорж: Бейсен гишүүний асуултад хариулъя. Энэ мэдээж эцэг эхтэйгээ хамт сургах тийм сурах бичиг хийх шаардлагатай. Одоогийн сурах бичгүүд бол гэр бүл бүгдээрээ хийчихээр тийм сурах бичиг ер нь бас байна уу, үгүй юу мэдэхгүй байна. АНУ-д 3 сая 400 мянган хүүхэд гэрээсээ сурч байна. Монгол Улсаас Канадын их сургуульд 12 жил эндээсээ сурч байна. Одоо их сургуульд Монголд суугаа тэр Канадын фермер гэр бүл бүх хүүхдээ 12 жил эндээс сургаад, тэгээд их сургуульдаа маш өндөр оноо аваад явсан байна. Монголын манай Боловсролын яамны 1 сайхан юм нь энэ гэрээсээ сурч байгаа хүүхдүүдийг бас сертификат олгодог юм байна. Гэрээсээ Монголын хамгийн шилдэг 1, 2 дугаар ангийн багш нараар хүүхдүүдээ хичээлээ заалгаж байгаа ч хүмүүс байна. Тэгээд энэ бол харьцангуй ойлголт. Боловсрол ч гэсэн өөрөө харьцангуй ойлголт.

С.Бямбацогт: Уянгахишиг гишүүн нэмж хариулъя.

Г.Уянгахишиг: Энэ хуулийн төслийг 40 хэдэн гишүүн ерөнхийдөө хамтарч санаачилсан байгаа. Тэгээд үүнтэй холбоотойгоор бас түрүүн Баасанжаргал гишүүн асууж байсан. Тэр дээр бас нэмэлт тайлбар өгчихье гэж бодож байна. Энэ дээр бол Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг бас хамт өргөн мэдүүлсэн байгаа. Тэгэхээр энэ дагаж мөрдөх журмын тухай хуулиар яаж байгаа вэ

гэхээр тухайн хууль дээр угаасаа Боловсролын яам энэ хөтөлбөрийг гаргах ёстой буюу Боловсролын ерөнхий хуулийн 8.2-т заасан хувилбарт хөтөлбөр гэж байгаа. Энийг Боловсролын ерөнхий хуулийн 26.1.11-д заасны дагуу Боловсролын яам тухайн журмыг батлах ёстой. Тэгэхээр энэ журмыг батлах, энэ журамдаа холбогдох өөрчлөлтийг тусгах, мөн түүнчлэн хөтөлбөрийг тодорхой болгох, үүгээрээ бол 2027 оны 9 сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөнө..../минут дуусав/

С.Бямбацогт: Ганбат гишүүн асуултаа асууя. Ганбат гишүүн.

Д.Ганбат: Энэ талаар ер нь Монголын төр засаг бол нэлээн анхаармаар байгаа байхгүй юу. Тийм ч учраас манай Сэддорж гишүүн энэ хуулийг санаачлаад, энэ асуудлыг шийдэхийн төлөө явж байна л даа. Харин тэр Боловсролын яамнаас хэлж байгаа ганц нэг үг нь сонин санагдчихлаа. Тэр туршилт гэнэ үү. Хүүхдүүдээр туршиж болохгүй шүү дээ. Ер нь энэ МАН сүүлийн 10 жилд ингээд засаглаж байгаа юм. Тэгээд энэ боловсролоор бол малчдаар бол тоглоод дууслаа л даа. Боловсролын байдал бол туйлын хүнд байна. Энэ чинь юу билээ, хэдхэн жилийн өмнө хэчнээн ч олон сайд сольж байв даа. Засаглаж байхдаа. Тэгээд боловсролоор бол монголчууд ер нь гайгүй байдаг байсан. Ганц нэг хүүхдүүдийг л гэхээс биш энэ нэлэнхийдээ бол тэр ПИСА-ийн шалгалтыг нь харж байхад бол 2 ангиар хоцорсон байна гэж байна лээ шүү дээ. Тэгээд энэ боловсролын хоцрогдол, боловсролын ядуурал гэдэг бол аягүй хэцүү л дээ. Тэгээд 50 хувь нь ядуурсан энэ тэр гээд л, 33 хувь нь нэн ядуу гээд л байгаа байхгүй юу.

Тэгээд дээр нь боловсролын хувьд ингэж 10 жил МАН авлига, хулгайд идэгдээд ингэж явж байх хоорондоо тийшээ зориулж болох тэр их мөнгийг бол үрчихсэн байгаа л даа. Тэгэхээр энэ эх эцгүүдийг бас журам гарна..../минут дуусав/

С.Бямбацогт: Ганбат гишүүнд 1 минут. Асуултаа дуусгая.

Д.Ганбат: Эх эцгүүдэд шаардлага тавигдах уу. Гэртээ нөгөө сургаж барих, тэр 6, 7 настай хүүхдүүдийг. 1 сум дээр чинь 7, 8 хүүхэд л байдаг гэнэ л дээ. Тэр сумын дотуур байр энэ тэр бол үнэндээ хүнд шүү дээ. Аль 1 эх эцэг нь байхаас өөр аргагүй тийм байдалтай байдаг. Үнэхээр байлгана гэж бодох юм бол тэрний нөхцөлийг бол маш их сайжруулмаар юм шиг байгаа юм. Мөнгөө бол тийш нь зориулмаар юм шиг байгаа юм. Тэгээд манайхан учир утгагүй их шинэчлэлүүдийг хийдэг. Тэр уйгаржин үсэгт шилжиж байна. Больж байна гээд л. Тэр ковидоос зайны сургалт хийж байна гээд ингээд явсан. Америкт бол 3 сая 500 хүүхэд сураад болдог энэ тэр гээд энэ бол бас их сайн жишиг л дээ. Үнэхээр ажиллаж чаддаг бол.../минут дуусав/

С.Бямбацогт: Уянгахишиг гишүүн хариулъя. Хууль санаачлагч.

Г.Уянгахишиг: Тэгэхээр ер нь яг бид нар мэдээж хүүхдийн эрх ярилгүй яах вэ. Гэхдээ тэнд бас хүүхдийн эрх зөрчигдөөд байгаа гэдгийг бид нар бас сайн ойлгох ёстой. Өөрөөр хэлэх юм бол энэ бол зөвхөн 6, 7 настай хүүхдийн тухай яригдаж байгаа. Тухайн 6, 7 настай хүүхэд эцэг эхтэйгээ байх боломжгүй, дотуур байранд байх яг адилхан чанар хүртээмжтэй боловсрол эзэмших эрх нь хангагдаж байгаа юу гэвэл хөдөө, орон нутагт бол энэ байдал байхгүй байна. Тэгэхээр бид нар хувилбарт сургалт буюу хэрхэн тэр хүүхдүүдийг эцэг эхтэйгээ хамт байлгаад, түүн дээр нь сургалтын байгууллагууд хэрхэн хамтарч ажиллах боломжтой юм. Ямар хөтөлбөрөөр сургах ёстой юм. Хэрхэн нийгэмшүүлэх юм, багш нь ямар оролцоотой

байх юм, эцэг эх ямар оролцоотой байх юм гэх мэтээр энэ боломжит хувилбаруудыг бид нар гаргаж ирж бодох ёстой. Тэгэхээр энэ хуулийн төсөл бол энэний эхлэл гэж харж байгаа. Энэ хуулийн төсөл дээр зүгээр 5, 6 заалттай юм шиг харагдаж байгаа боловчиг дотор нь яг хөтөлбөрөө батлах, түүн дээр хяналт тавих, журмаа батлах, бэлтгэл ажлаа хангах гээд энэ бүх зохицуулалтуудыг бол тусгаж өгсөн байгаа. Мэдээж яг хэлэлцэх эсэх хэлэлцэгдээд дэмжигдсэний дараа энэ дээр баяжуулах гэдэг юм уу бас хараагүй үү, анхаараагүй зүйлс байвал энийг өөрчлөх, ямар нэгэн байдлаар энэ хувилбарт хөтөлбөрийг явуулах боломжийг бид нар бий болгох тал дээр бас Боловсролын яамтайгаа гишүүд ажиллах боломжтой юм гэж хараад байгаа юм.

Өөрөөр хэлэх юм бол бид нар багийн бага сургууль гэж байна. Сумын сургууль байна. Тэгэхээр багийн бага сургуулиуд дээр магадгүй юу гэдэг юм хоёр 7 хоногтоо 1 удаа ирэх ёстой ч гэдэг юм уу, эсвэл сардаа 1 удаа ирэх ёстой ч гэдэг юм уу, багш тухайн айлуудаар явж нөхцөл байдал буюу тухайн сурагч сурах боломжтой байгаа эсэхийг эхлээд шалгаж байж тэр эрхийг нь нээж өгөх. Яагаад гэвэл энэ сонголтод болохоос биш бүгдийг нь тийм болгочхож байгаа биш. Тэгэхээр энэ өөрөө тухайн хүүхдийн эрхийг хамгаалаад, чанартай хүртээмжтэй боловсролыг эзэмшихэд нь яаж боломжит байдлаар илүү таатай нөхцөл байдлыг бий болгож болох нь вэ гэдгийг Боловсролын яам бас хамтарч хэрэгжүүлэх ёстой гэж харж байгаа юм.

Мөн үүнтэй холбоотойгоор бид нар 1 юмыг аягүй сайн бодох хэрэгтэй болсон нь 12 жилийн сургалтад шилжсэнээрээ уг нь бол 1, 2 дугаар ангийн хүүхдийг зөвхөн нийгэмшүүлэх, зөвхөн сууж сургах, зөвхөн гар хурууг эвсэлтэй болгох тухай яригдаж байсан байтал одоо нөгөө 10 жилийн академик сургалт чинь 12 жилийн академик сургалт болчихсон. 6 настай хүүхдийг яагаад заавал тэнд бичиг бичүүлж, 35 үсгийг бичиж сургах гээд байгаа юм. Тэр жижигхэн гаранд чинь хэцүү байгаа шүү дээ. Тэгэхээр бид нар энэ хөтөлбөрөө ч гэсэн эргэж харах ёстой. 6, 7 настай хүүхэд заавал бид нарын 10 жилийн 8, 9 настай хүүхдийн сурдаг байсан хөтөлбөрөөр сурах албатай биш байхгүй юу. Тэгэхээр эднийгээ ч гэсэн бид нар бас харах ёстой. Ингэж байж тухайн орон нутгийнхаа онцлогийг улс үндэстнийхээ онцлогийг бас бид нар эргэж харах хэрэгтэй байна.

С.Бямбацогт: Сэддорж гишүүн нэмж хариулъя.

Р.Сэддорж: Нэмж хариулъя. Ганбат гишүүний асуултад. Энэ намуудын мөрийн хөтөлбөрт байгаа. Тэгээд сонгуулиар бол яг энэ асуудлыг малчид, хилчдэд ярьдаг. Энэ хууль ингээд цаашаа дэмжигдээд явбал гишүүдээс бас санал гарч байгаа. 36 гишүүн дэмжиж, гарын үсэг зурсан. Хилийн застав дээр байгаа хүүхдүүд орох юм байна. Яг энэ зовлон адилхан байгаа. Мөн дээрээс нь тариаланчид орох юм байна. Өчигдөр бол хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдээ сургахад маш хэцүү байдаг. Тэгээд энэ чинь 1, 2 дугаар ангид бол тоглонгоо сургах ёстой. Тэр хүүхдүүдийг ширээ сандал дээр тэгж удаан суулгах ёсгүй. Энэ дэлхийн хандлага бол тоглонгоо сургах ёстой. Мөн сургалтыг бол Улсын Багшийн Их сургуулийн оюутнууд дадлага хийх ёстой..../минут дуусав/

С.Бямбацогт: Гишүүд асуулт асуу, хариулт өгч дууслаа. Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай гишүүд үгээ хэлнэ. Урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу Мэндбаярын

Мандхай гишүүн алга байна. Мөнхтуяа гишүүн алга байна. Батжаргал гишүүн алга байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Би энэ хуулийн төслийг эсэргүүцэхийн тулд эсэргүүцэж байгаа юм биш. 4 гол зарчмыг баримтлал болгож, энэхүү хуулийн төслийг эсэргүүцэж байгаа.

1 дүгээрт хүүхдийн эрх, 2 дугаарт Монголын түүхэн бодлого боловсролд баримталж ирсэн, 3 дугаарт Ковид 19-ийн сургамж, 4 дүгээрт хэрэгжих боломжтой нөөц боломж гэсэн энэ 4 зарчим дээр тулгуурлаад энэ төслийг Улсын Их Хурлын гишүүдийг дэмжихгүй байхыг уриалж байна. Энэ хуулийн төслийн хамгийн гол асуудал нь малчин өрхийн хүүхдүүдийн боловсрол эзэмших аргыг өөрчилж байна. Үүний цаана хүүхдийн эрхийг ямар аргаар хамгаалах вэ гэдэг асуултад огт хариулж чадсангүй.

Монгол Улс бараг 100 жилийн турш малчдын хүүхдүүдийг сургуульд ойртуулахын төлөө дотуур байрны тогтолцоог байгуулсан. Та нар бүгдээрээ ихэнх нь дотуур байранд өсөж, суралцаж, өдийд энэ танхимд орж ирж сууж байгаа байх. Харин өнөөдөр бид эсрэгээрээ хүүхдүүдийг сургуулиас холдуулах бодлогыг хуульчилж байна. Бид Ковид 19-ийн үеэр маш үнэтэй сургамж авсан. Үүнийхээ үнэ цэнийг одоо болтол бид нар төлж дуусаагүй байгаа. Өшөө ч төлнө. Танхимын сургалтыг гэрийн болон цахим сургалтаар орлуулах боломжгүй гэдгийг бид бүгд өөрсдөө биеэрээ мэдэрсэн. Би яг тэр үед өөрөө 1 дүгээр ангийн 2 хүүхэдтэй байсан. Би бас өөрөө биеэрээ мэдэрсэн. Та нарыг мэдэрсэн байх гэж найдаж байна. Гэртээ хүүхдээ харсан болов уу гэж найдаж байна. Хамгийн их хоцрогдолд орсон нь бага ангийн хүүхдүүд байсан. Өнөөдөр ч төр тэр алдагдлыг нөхөхийн төлөө ажиллаж байгаа. Маш их хөрөнгө, хүч, нөөц зарцуулж байгаа.

Мөн багш нар очиж сургана гэж та бүхэн тайлбарлаж байна. Гэхдээ хууль бол сайхан хүсэл дээр биш бодит хэрэгцээндээ тулгуурлах ёстой. Бодит боломж дээрээ тулгуурлах ёстой. Өмнөговь аймагт яг тэтгэвэрт гарсан хэдэн багш байдаг юм. Хэд нь яг хүүхдүүдийн гэрт очоод хичээл заах боломжтой байдаг юм. Тоогоо хэлээрэй. Ямар төсвөөр, ямар хяналтаар, ядаж ямар унааны зардлаар айл бүр дээр багш нар очих юм. Өнөөдөр багшийн хүрэлцээ ямар байгааг та надаар хэлүүлэлгүй мэдэж байгаа.

Монгол ахуйгаа мэддэг болно гэдгийг бас нэг үндэслэл болгож байна. Гэхдээ хүүхэд Монгол ахуйгаа өвлөхийн зэрэгцээ чанартай боловсрол эзэмших хэрэгтэй. Энэ 2-ыг эсрэгцүүлэх ямар ч боломжгүй. Ямар ч логикгүй. Өнөөдөр дотуур байранд суралцсан хүүхдүүд бүгдээрээ Монгол ахуйгаа эзэмшээгүй гэсэн логик дүгнэлт таны үндэслэлээс гарах гээд байна. Энэ үнэн юм уу. Эцэст нь зарчмын нэг асуулт тавья.

Хэрвээ энэ сургалтын хэлбэр үнэхээр илүү сайн юм бол Улаанбаатар хотод, хот, суурин газар хэрэгжих боломжтой юу. Гэтэл хотод хотын эцэг эхчүүд хүүхдээ зайнаас явуулахыг хэр дэмжих бол. Хотынхонд энэ нь өөрөө сөрөг нөлөөтэй юм бол хөдөөгийнхөнд энэ яагаад боломж байх ёстой гэж. Энийг бас бид нар бодож үзэх ёстой. Та хариулах байх гэж найдаж байна.

Хүүхдийн эрхийн үүднээс шийдэл нь хүүхдийг сургуулиас холдуулах биш харин сургуулийг хүүхдэд ойртуулах бодлого байх ёстой. Бид нар дотуур байраа

сайжруулах ёстой. Дотуур байрны үйлчилгээг цоо шинээр загварчлах ёстой. Бага ангийн хүүхдүүдийг суралцах, ээж аавтайгаа байх, уулзах тэр боломжийг, тэр үүргийг бид нар хуульчлах ёстой. Илүү дотуур байрыг бид нар боловсролын тогтолцоо гэж хүлээн зөвшөөрч харах ёстой, ийм хуулийн төслийг санаачлах ёстой. Өнөөдрийн хуулийн төсөл бол хамгийн залхуу хуулийн төсөл. Төр өөрийнхөө үүргийг эцэг эхэд нь шилжүүлсэн, эцэг эхийг хүүхдүүддээ зайнаас сургаад аваад ирээрэй гэж байгаа ерөөсөө л төрийн залхуу бүх үүргээ шилжүүлж байгаа ийм залхуу .../минут дуусав/

С.Бямбацогт: Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалтыг маргааш явуулна.

23.00 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох тухай Улсын Их Хурлын саналыг танилцуулъя.

Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуулийн цэц 9 гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн 3-ыг Улсын Их Хурал, 3-ыг Ерөнхийлөгч, 3-ыг Улсын дээд шүүхээс санал болгосноор Улсын Их Хурал 6 жилийн хугацаагаар томилно.” гэж, 2 дахь хэсэгт “Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, Монгол Улсын 40 нас хүрсэн иргэнийг томилно.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнд Жамьянхорлоогийн Сүхбаатарыг нэр дэвшүүлэхээр Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшигч Жамьянхорлоогийн Сүхбаатар нь 1975 онд одоогийн Дархан-Уул аймгийн Дархан сум буюу Дархан хотод төрсөн. Ам бүл 2. Нэр дэвшигч Ж.Сүхбаатар нь 1993 онд Дархан хотын ерөнхий боловсролын 3 дугаар дунд сургуул, 1997 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр, 1999 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг Хууль зүйн ухааны магистрын зэрэгтэй төгсөж, АНУ, Швед, Казахстан зэрэг улсад мэргэжлийн болон бус сургалтад хамрагдсан байна.

Нийтийн эрх зүйн буюу захиргааны эрх зүй, Сонгуулийн эрх зүйгээр мэргэшсэн, судалгаа хийдэг докторант юм.

Нэр дэвшигчийн ажлын туршлагын хувьд 1997-2005 онд Улаанбаатар Эрдэм дээд сургуульд захиргааны эрх зүйн багш, ахлах багш, 1997-1999 онд Улсын Их Хурлын гишүүний орон тооны ажилтан, 1999-2001 онд Улсын Их Хурал дахь Монгол Ардын Хувьсгалт намын бүлгийн ажлын албанд Хуулийн бодлогын зөвлөх, 2001-2006 онд Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, нарийн бичгийн дарга, 2006-2008 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга, 2008-2012 онд Улсын

Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, 2012- 2013 онд Монгол Ардын намын Удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга, 2016 онд Монгол Ардын Хувьсгалт намын Ерөнхий нарийн бичгийн дарга, 2019-2020 онд Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх, 2020-2024 онд Улсын Их Хурлын гишүүн, 2020-2022 онд Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга, 2022-2023 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга, 2025 оны 12 дугаар сараас 2026 оны 04 дүгээр сар хүртэл Улсын Их Хурлын даргын Хууль зүйн бодлогын зөвлөх, 2026 оны 04 дүгээр сараас Ерөнхий сайдын Хууль зүйн бодлогын зөвлөхөөр тус тус ажиллаж байна.

Нэр дэвшигч Сүхбаатар нь төрийн албанд 20 гаруй жил ажилласан бөгөөд төрийн улс төрийн, захиргааны, тусгай албанд удирдах болон өндөр албан тушаалд удаа дараа сонгогдох буюу томилогдон ажилласан. Төрийн удирдах ажлын өргөн мэдлэг туршлагатай байна.

Ж.Сүхбаатарын хууль зүйн болон улс төрийн мэргэшсэн байдал, төрийн ажил, эрх зүйн онол, практикийн өндөр мэдлэг, бэлтгэгдсэн байдал, туршлагыг үндэслэн Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэрийг нь дэвшүүлж байна.

Дараагийн нэр дэвшигчийг танилцуулъя. Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуулийн цэц 9 гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн 3-ыг Улсын Их Хурал, 3-ыг Ерөнхийлөгч, 3-ыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал 6 жилийн хугацаагаар томилно.” гэж, 2 дахь хэсэгт “Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр хууль зүйн, улс төрийн өндөр мэргэшилтэй Монгол Улсын 40 нас хүрсэн иргэнийг томилно.” гэж тус тус заасан.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнд Ганбатын Эрдэнэбатыг нэр дэвшүүлэхээр Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшигч Ганбатын Эрдэнэбат нь 1972 онд Улаанбаатар хотод төрсөн, 54 настай, эхнэр, 2 хүүхдийн хамт амьдардаг. Нэр дэвшигч Г.Эрдэнэбат нь 1990 онд ерөнхий боловсролын 31 дүгээр дунд сургууль, 1994 онд Цагдаагийн дээд сургуулийн эрх зүйч мэргэжлээр, 1997 онд Батлан хамгаалахын их сургуулийг Хууль зүйн магистр зэрэгтэй төгсөж, 1998-2000 онд ОХУ-ын Уралын Хуулийн академид эрүүгийн эрх зүй, криминологийн чиглэлээр аспирантурт суралцжээ.

Нэр дэвшигчийн ажлын туршлагын хувьд 1994-1995 онд Хилийн цэргийн ангид офицер, 1996-1998 онд БХИС-д багш, 1998-2000 онд Хил хамгаалах ерөнхий газарт хуулийн зөвлөх, 2000-2005 онд МУИС-ийн Хууль зүйн сургуульд багш, 2005-2009 онд МУИС-ийн Хууль зүйн сургуульд Сургалтын албаны дарга, 2009-2010 онд Ерөнхийлөгчийн Тамгын газарт хуулийн асуудал хариуцсан туслах, 2010-2013 онд Монгол УЕПГ-т хэлтсийн дарга, 2013-2019 онд Монгол УЕП-ын орлогч, 2019-2022 онд Монголын криминалогчдын холбооны ерөнхийлөгч, 2021-2023 онд Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн ажлын албанд ахлах референт, 2024-2025 онд Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтан, 2026 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс Улсын Их Хурлын Тамгын газрын дэд даргаар ажиллаж байна.

Г.Эрдэнэбатын хууль зүй, улс төрийн мэргэшсэн байдал, төрийн алба болон эрдэм шинжилгээ, судалгаа, боловсролын байгууллагад ажилласан болон эрх зүйн онол практикийн өндөр мэдлэг, бэлтгэгдсэн байдал, туршлагыг үндэслэн Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэрийг нь дэвшүүлж байна.

Нэр дэвшигчдийн талаар гаргасан Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд танилцуулна. Индэрт урьж байна.

Л.Соронзонболд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Жамьянхорлоогийн Сүхбаатар, Ганбатын Эрдэнэбат нарыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар нэр дэвшүүлсэн.

Хууль зүйн байнгын хороо Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар санал болгосон нэр дэвшигчийн талаарх асуудлыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 104 дүгээр зүйлд заасны дагуу 2026 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар нэр дэвшигчдээс Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг, Нарантуяа-Нара, Тулга, Баасанжаргал нар асуулт асууж, хариулт авч, Улсын Их Хурлын гишүүн Нарантуяа-Нара, Алтангэрэл, Тэмүүжин, Баасанжаргал, Номинчимэг, Цогтбаатар нар үг хэлсэн бөгөөд Жамьянхорлоогийн Сүхбаатар, Ганбатын Эрдэнэбат нарыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулах саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Гунгаагийн Баясгаланг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай болон Жамьянхорлоогийн Сүхбаатар, Ганбатын Эрдэнэбат нарыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар санал болгосон нэр дэвшигчийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Соронзонболд гишүүнд баярлалаа. Чуулганы нэгдсэн хуралдааны танхимд нэр дэвшигч Жамьянхорлоогийн Сүхбаатар, Ганбатын Эрдэнэбат нар хүрэлцэн ирсэн байна.

Нэр дэвшүүлсэн байгууллага болон нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Энхтүвшин гишүүнээр тасаллаа. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуултаа асууя. Асуулт асууж, үг хэлж болно.

С.Эрдэнэболд: Ганбатын Эрдэнэбат, Жамьянхорлоогийн Сүхбаатар гээд 2 хүн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд гишүүнээр нэр дэвшиж байна. Хоёулаа улс төрийн болон хууль зүйн амьдрал дундуур явсан. 70-аад оны ийм төлөөллүүд. Хоёуланд нь ижил зүйл байгаа. Бас хуулийн хонгилоор явсан, хэлмэгдсэн. Энийг бол бас шууд би хэлмээр байна. Улс төрийн шалтгаанаар өөрсдийнхөө эрхийг хасуулж, нэр төр, алдар хүндээрээ хохирч явсан хүмүүс. Энэ үүднээсээ цэцийн гишүүн боллоо гэхэд хүний эрхийг хамгийн сайн хамгаалах, эрх нь зөрчигдсөн тохиолдолд, эрхээ хасуулсан тохиолдолд Үндсэн хуулийг давсан улс төржилт, хуульт ёсыг давсан хар пи ар хүний амьдралыг яаж орвонгоор нь эргүүлж болдог вэ гэдгийн бас бодит золиос болсон хүмүүс.

Яагаад би ингэж хэлж байна гэхлээр энэ 2 хүнийг бас тодорхой хугацаанд мэдэж байгаа. Ямар асуудлаас болоод, ямар улс төржилтөөс болоод ямар золиос болсныг нь бас мэдэж байгаа учраас онцолж та 2-т бас амжилт хүсэж, бас хариуцлагыг чинь сануулж, хэд хэдэн асуултууд асуух гэж байгаа юм.

Цэц гэдэг бидний шударга ёсны хамгийн дээд оргил ийм институц. Тэнд хувь хүн гэхээс илүүтэйгээр Монгол Улс дахь хуулийн засаглал тэр хуулийн засаглалын оройн дээд болсон Монгол Улсын Үндсэн хууль халдашгүй дархан байх, түүний хэм хэмжээ, зохицуулалт ардчиллын амьд баталгаа болж байх тэр бүрдлийг хангаж байдаг. Тэгэхээр өнгөрсөн хугацаанд та 2 аль аль нь улс төрийн намтай холбоотой ажлууд хийж байсан. Гэхдээ одоо үүнээс хойш, түүнээс цааш ямар нэгэн нам, хамаарал, танил тал, бүх хаалгууд хаагдаж, зөвхөн Монгол Улсын язгуур ашиг сонирхлын өнцгөөс Монгол Улсын эрх чөлөөт бүрэн эрхт ардчилсан Үндсэн хуульд тэр тогтолцооны өмнөөс та 2 харах ийм цаг тоолол эхэлнэ.

Тийм учраас өнгөрсөн хугацаанд болсон, туулсан амьдрал та нарт ямар эрмэлзлийг, ямар зориг, хүсэл тэмүүллийг өгч байгаа вэ. Ямар итгэл үнэмшлээр Монгол Улсын Үндсэн хуулийн манаанд та нар зогсох гэж байгаа вэ. Албан тэмдэглэлд энэ хүсэл зориг энэ эрмэлзлээ бас илэрхийлээч. Олон нийт янз бүрээр харж байж болно. Гэхдээ та нарын эрмэлзлийг энэ протоколд тэмдэглэгдэж асуумаар.../минут дуусав/

С.Бямбацогт: Нэр дэвшигч хариулъя. Жамьянхорлоогийн Сүхбаатар. Индэрийн 4 дүгээр микрофон. Дараа нь Эрдэнэбат нэр дэвшигч бэлдэж байгаарай.

Ж.Сүхбаатар: Баярлалаа. Эрхэм гишүүдийн оройн мэндийг хүргэе. Эрдэнэболд гишүүний асуулт хувь хүний итгэл үнэмшил, улс төрийн хүсэл зориг, ямар санаа бодлоор Үндсэн хуулийн цэцэд нэр дэвшиж байна вэ. Улс төрийн намын хамааралтай бас тодорхой цаг үед явсан, улс төрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байсан хүмүүс гэдгийг онцолж хэлж байна. Тийм ээ. Тэгээд үнэхээр ардчилсан нийгмийн тогтолцоонд бол бидний аливаа юм ил тод, нээлттэй байх ёстой. Янз бүрийн асуудлууд үүсэж болно. Тэгэхээр бүх юм нээлттэй, гол нь ил тод, нууж хаах юмгүй явах ёстой. Тэгээд миний улс төрийн намд туулсан амьдрал та бас надад би энэ танхимд бас сууж, хууль тогтоож, бас өнөөгийн парламентын эрх зүйн үндсийг тавихад ч гэсэн нөхдийн хамт оролцож байсан хүний хувьд хэлэхэд бас нэр

төрийн хэрэг байж байна. Миний амьдралын бас нэг чухал мөч юм. Таны асуулт бол.

Тэгэхээр энэ дээр улс төрийн намд байхдаа бол Монголын улс төрийн тогтолцоог эрүүлжүүлье л гэж би ажилласан. Тийм учраас нам дотроо тэмцсэн, олон хуулийн өөрчлөлт дээр ажилласан, намаа орхиж явсан. Үзэл баримтлал, үзэл санаандаа үнэнч байсан. Би намд үнэнч байгаагүй. Монгол Улсын төрийг бэхжүүлэх үйлсэд үнэнч байсан. Амьдрал үйл хэргээрээ тэгж явсан. Цэцэд яаж байгаа нь бол үнэхээр бас хүнд цаг, 126-тай энэ парламентыг бүрэлдүүлж би өргөн бүрэлдэхүүнтэй 5 улс төрийн хүчний бүрэлдэхүүнтэй ийм парламентыг харах юм сан гэж 2018, 2019 оноос эхэлж ярьж байсан хүн. Тэгээд энэ маань ингээд биелж 80 хувь нь шинэ хүмүүс бүрдэж байна.

Тэгэхээр миний хувьд бол ингээд эцэс төгсгөлгүй тэмцэл. Саяын энэ нуулгүй хэлэхэд бол хуульчийн мэргэжлээрээ ажиллая гэсэн ч улс төрч хүний тавилан бол дандаа өөрөө шийддэггүй. Тэгээд Засгийн газарт орж ажилласан. Өөр салбар дээр ажилласан. Мэдээж туршлага, сургамж, ухаарал, Монголоо илүү ойлгох, Улаанбаатараа илүү ойлгох талаасаа бол хувь хүний хувьд сайхан байлаа. Гэхдээ амаргүй замыг туулсан. Хүн гэдэг амьтан бол тодорхой цаг хугацаанд амьдардаг, тодорхой энергитэй, хүсэл бодол нь бас тодорхой зүйлээр хязгаарлагддаг. Тийм учраас ийм боломж ингээд таарсан. Зүгээр энэ бол хүмүүс итгээд мэдээж улс төрч хүн чинь дандаа алга ташилт дээр явахгүй. Мэдээж хэцүү зүйл дээр явдаг. Тэгэхээр цэц дээрээ орж ажиллана гэдэг бол миний карьерын хувьд бол хуульчийнхаа хувьд нэр төртэй бас энэ чиглэлээрээ дуртай юмандаа загас нууртаа жаргалтай гэдэг шиг улс төрийнхөө ертөнцөөс шууд намтай хамааралтай элдэв хардлага сэрдлэгээс харьцангуй гайгүй. Тэгэхдээ мэдээж топ хэмжээний том хэмжээний маргаан шийдэх энэ газар очиж ажиллах нь бол эрдэм номын үйлс талаасаа ч бас тэгэхдээ харьцангуй бас өөрийгөө залуу гэж бодож байна. Бас суралцахад бол оройтдоггүй. Тэгэхээр энийгээ бас олон жил орхичихсон байсан нь энийгээ хийе. Үндсэн хуулийн эрх зүйг хөгжүүлье. Үндсэн хуулийн шүүхээ институц талаас нь өөд татаж, таны хэлдгээр хүний эрхийн чиглэл дээр итгэлцлийг бий болгох талаасаа ажил хийх боломж нь надад хувь хүний хувьд бас олдож байгаа боломж юм гэж ингэж харж байгаа. Хувийн компанид очоод би захирал хийж чадахгүй. Өөр газар очоод ажиллахад хэцүү. Тэгээд ер нь бол энэ нөхцөл байдал чинь хэцүү шүү дээ. Тэгэхээр улс төрч хүн бол хэцүү дотроос аль нэг хэцүүг сонгодог. Миний хувьд бол ухаарсан, сурсан, ойлгосон зүйлүүд бол ямар ч байсан Монголын төрийн гол юмыг баталгаажуулдаг юм бол Үндсэн хуулийн шүүх, Цэц бол Монгол Улсын төр, ард түмэн, газар нутаг, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хамгийн эцсийн углуургаараа ингээд хамгаалж суудаг газар. Тэгэхээр олон жилийн шинэчлэл, парламентын шинэчлэл, сонгуулийн шинэчлэл бүх юм маань бол Үндсэн хуулийн төлөө байсан. Үндсэн хуулийг тодорхой хэмжээнд засан сайжруулахын төлөө байсан учраас одоо тэрнийхээ газар очиж ажиллавал хувь хүнийхээ хувьд итгэл үнэмшлийн хувьд туулсан тэр зам, мэдээж амьдрал гэдэг бол өөрөө дандаа тийм нартай сайхан өдрүүд байдаггүй. Галтай, мөстэй, шуургатай өдрүүд байдаг. Тэгээд тодорхой хэмжээнд бас туулж өнгөрүүлсэн хүний хувьд энэ бас Үндсэн хуулийн эрх зүйтэй ойр ажиллаж, захиргааны эрх зүй бол бусад оронд Үндсэн хуулийн эрх зүйн хэсэгт багтдаг. Британи эд нарт бол. Тэгэхээр Үндсэн хуулийн эрх зүйн үр..../минут дуусав/

С.Бямбацогт: Эрдэнэбат нэр дэвшигч хариулъя.

Г.Эрдэнэбат: Баярлалаа. Үндсэндээ 32 жил хууль зүйн салбарт ажиллаж, эрүүгийн эрх зүй, тэгээд сүүлийн жилүүдэд бодлого боловсруулах, тодорхойлох, энэ чиглэлээр туршлагажиж, ажиллаж ирлээ. 2 зүйлийг ялангуяа өнөөдрийн энэ шийдвэр гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор би хувьдаа бас өөртөө итгэл үнэмшил болгосноо хэлье.

Хамгийн эхлээд ойлгож авсан зүйл маань бол бидний өнөөдрийг хүртэл тогтоох гэж оролдож, тогтоож байгаа шударга ёс гэдэг бол 1 удаа байшин шиг бариад орхичихдог зүйл ерөөсөө биш юм байна. Шударга ёс гэдэг бол үйл явц юм байна. Энийг байнга хамгаалж, байнга арчилж, тордож, байнга түүний төлөө ажиллаж байхгүй бол 1 л удаа сайхан шударга хууль гаргачихлаа. Сайхан шударга шийдвэр гаргачихлаа. Асуудлыг шударгаар шийдлээ гээд бодоод орхиход тэр зүйл маш амархан алдрах эрсдэлтэй байдаг юм байна. Тийм учраас ямарваа нэгэн юмыг хийгээд орхиж зогсож ерөөсөө болохгүй. Хэрвээ үнэхээр л энэ салбарт энэ мэргэжилтэй ажиллаж л байгаа бол тэр өөрийнхөө итгэл үнэмшил болгосон шударга ёс гэдэг юмыг хамгаалж тордож байхын төлөө явах ёстой гэдгийг ойлгож авсан.

Дараагийн ээлжид яг үүнтэйгээ холбоотойгоор ямар ч асуудлыг 100 хувийн итгэлтэйгээр харж болохгүй юм билээ. Байнга хэн нэгэнд итгэсэн ч ямар нэгэн үйл явцыг боллоо гэж бодсон ч гэсэн шалгаж хянаж, нягталж байх ёстой юм билээ. Өнөөдрийг хүртэл бидний гаргасан бодлого, хууль, шийдвэр, явуулсан үйл ажиллагаа цаг хугацааны эрхээр нөхцөл байдал өөрчлөгдөхөд эсвэл түүний араас олон шинэ зүйл тодорч гарч ирэхэд бид ямагт түүнийг эргэж харж, нягталж, гаргасан шийдвэр зөв үү гэж эргээд өөрийнхөө ч, бусдын ч шийдвэрийг харж, нягталж, эргэлзэж байх ёстой юм байна лээ. Тийм ч учраас энэ дэлхийн улс орнууд хяналтын олон бие биеийгээ харилцан тэнцвэржүүлж хянадаг тогтолцоо бий болгосон. Энэний нэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэц. Энэ салбарт ажилласан, сурч мэдсэн амьдралаас сурсан зүйл дээрээ тулгуурлаад энэ итгэсэн ч шалгадаг энэ ажлыг үргэлжлүүлж хийх ёстой гэж бодсон учраас би энэ ажил хэргийн саналыг маш хүндэтгэлтэйгээр хүлээж авсан.

С.Бямбацогт: Эрдэнэболд гишүүн тодруулж асууя.

С.Эрдэнэболд: Тэгээд мэдээж саяын Эрдэнэбат нэр дэвшигчийн хэлсэнчлэн энэ шударга ёс гэдэг чинь байнга тордож, хамгаалж байхгүй алдрах ийм эрсдэлүүд бас сүүлийн жилүүдэд ихээр бий болж байгаа. Ялангуяа Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийг хиргүй тунгалаг шийдвэр гаргадаг, хамгийн баталгаатай, бидний дээд, хуулийн итгэл үнэмшил бүхий институц гэж боддог. Гэхдээ Цэцэд ажиллаж байгаа хүмүүс бас олон нийтийн дунд иргэдийн төрд итгэх итгэл, шүүхэд итгэх итгэлийг унагаасан, уландаа гишгэсэн үйл явдлуудад удаа дараа холбогдсон. Зарим 1 нь Цэцээс улс төрийн байгууллага руу шилжсэн ч гэдэг юм уу ийм асуудлууд гарсан. Цэц ямар нэгэн байдлаар увайгүй, ёс суртахуунгүй, ёс зүйгүй хүмүүс тэнчээ дураар авирлаж байдаг газар бол огтоос биш гэдгийг бас нотлох ийм эрхэм үүргийг та бүхэн хүлээх гэж байгаа шүү. Тийм учраас та бүхэнд амжилт хүсье.

С.Бямбацогт: Үг хэллээ. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Д.Энхтүвшин: Монгол Улсын тусгаар тогтнолын гол баталгаа бол Үндсэн хууль. Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа нь бол Үндсэн хуулийн цэц байгаа. Тэгэхээр Үндсэн хуулийн цэц болон Цэцийн гишүүдэд тавьдаг Үндсэн хууль дээр заасан гол шаардлага бол аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна гэж. Үндсэн хуулийн цэцийн гишүүдийн тангараг дээр ч гэсэн тал үл харах, хараат бус байна гэсэн. Тэгэхээр яах вэ, бодит байдал дээр бол Улсын Их Хурлаас томилогдож байгаа цэцийн гишүүдийг бас улс төрийн намууд жишээлбэл оролцож, зөвшилцөж тавьж байгаа. Нэр дэвшигчийн хувьд бол нэг нь МАН-аас, 1 нь АН-аас санал болгож, ингээд томилогдож байгаа юм. Тэгэхээр санал орж ирж байгаа юм. Тэгэхээр энэ мөн чанар нь өөрөө яг энэ баталгаа болж байгаа Үндсэн хуулийн заалтыгаа бас зөрчих ийм магадлал өндөртэй эрсдэлүүд бас байдаг. Тэгээд өнгөрсөн хугацаанд ч гэсэн харахад тодорхой хэмжээнд ингээд томилогдсон байгууллагадаа ч юм уу, улс төрийн нөлөөллүүд нь бас байнга тодорхой хэмжээнд ингээд харагддаг жишээнүүд олон байсан. Тэгэхээр 2 нэр дэвшигчээс яг энэ санал болгосон гэх юм уу, энэ улс төрийн намуудын нөлөөллөөс бие даасан хараат байх, тал үл харж байх энэ зарчмыг юу гэж харж, яг ингээд нөлөөлөөд санал болгоод жишээлбэл ингээд ороод ирдэг. Тэгэхдээ яг буцаад энэ байдал нь Цэцийн гишүүдийн үйл ажиллагаанд яаж нөлөөлөх юм. Тэгээд хувь хүнийхээ хувьд бол яг энэ байдлыг хангаж чадах болов уу гэдэг талаар хариулт өгөөч. Баярлалаа.

С.Бямбацогт: Сүхбаатар нэр дэвшигч хариулъя.

Ж.Сүхбаатар: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Тэгэхээрээ өчигдөр Байнгын хороон дээр Баасанжаргал гишүүн сануулж байсан. Энэ процедураа хэр шударга гэж үзэж байгаа вэ гэж. Тэгэхээр Монгол Улсын Их Хурал буюу парламент бол Үндсэн хуулийнхаа хүрээнд л явах ёстой байдаг. Засгийн газар, шүүх бол Үндсэн хууль болон бусад хуулиасаа гажихгүй байх ёстой. Тэгэхээр өнгөрсөн парламент дээр Бямбацогт гишүүн Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг санаачлаад, би аж ажлын хэсгийг нь ахлаад батлуулсан дотор бол төрийн ийм албан тушаалтнуудыг бүгдийг нь сонсголоор, нийтэд танилцуулаад, ингээд явдаг болгосон юм. Тэгээд яг сая 3 сарын өмнө байна уу, цэцийн гишүүний томилгооны сонсголыг бол хүчингүй болгосон л доо. Тэгэхээр өмнө нь яаж явж ирж байсан бэ гэхээр Улсын Их Хурлын удирдлагын зүгээс энэ цэцийн гишүүний томилгоог ингээд судалж байгаад оруулж ирээд шийддэг хурдан процессыг уг нь бол би ажлын хэсгийн ахлагч байхдаа энэ Их Хурлын дарга Бямбацогт нар энийг бол процессжуулаад, ингээд шийдчихсэн байсан асуудал. Тэгээд одоо энэ асуудал хүчингүй болчихоор зэрэг сая АН-ын бүлэг миний ойлгож байгаагаар ингээд шаардлага тавьсан учраас энэ асуудлыг урьд нь явж ирсэн жишгийнхээ дагуу парламент улс төрийн болон хууль зүйн өндөр мэргэшилтэй тэр 2 намын зонхилгоч энэ парламентыг бүрдүүлж байгаа 2 намын бүлэг парламент дээрээ зөвшилцлийн хүрээнд, улс төрийн соёлынхоо хүрээнд ингээд ийм хүмүүс байж болох юм гээд оруулж ирж байгаа. Мэдээж энэ дээр олон янзын санал бодол гарна. Ер нь хувь хүний хараат бус, биеэ даасан байдал гэдэг бол хүний характертай л холбоотой. Зүгээр хууль зүйн хувьд ярих юм бол эдийн засгийн баталгаа, нийгмийн баталгаа, хууль зүйн хамгаалалт нь ямар юм гээд ингээд бид яриад явдаг. Зүгээр таны шууд ойлгомжтой асуудлаар хүрэх юм бол хүн ер нь ямар ухамсар, сэтгэлгээ, боловсрол, үнэт зүйлтэй байна гэдэг асуудал түүхэнд яаж үлдэх вэ, нэрээ хүн хичээх ёстой шүү дээ. Тэгээд бүгд л хичээдэг. Шүүмжлэлд өртдөг. Гэхдээ мэдээж улс төрийн явж байгаа хүмүүсийн хувьд хардлага сэрдлэг дагуулах нь бол хиймэл дагуул шиг л

явдаг. Тэгэхээр таны саяын хэлж байгаа дээр бол ер нь хүний хувьд туулсан туршлага, баримталж байгаа зан, тэр зарчим энэ бүх юм бол хүний тэр характер, тэр юмаараа, үйлдлээрээ л харагддаг шүү дээ. Түүнээс сайн хүн гэж бодоод, одоо хүмүүс чинь тэгдэг шүү дээ. Чи их сайн байна гэж байна. Тэгээд дараа нь асуудал болоход чи их муу хүн байжээ л гэдэг. Тэгэхээр энэ болгоныг танд хэлэхэд энэ бол зүгээр хууль тогтоогчид томилж байгаа үед бол хууль тогтоогч болгоны ард түмний мандат авсан хүмүүсийн үнэлгээ, итгэл үнэмшил, тооцоололтой холбоотой. Зүгээр хувь хүн та ямар баталгаа өгөх юм бэ гэхээр хүмүүс бүгд л амаараа би чадна, би хийнэ, хичээнэ, зүтгэнэ гэдэг. Тэгээд миний хувьд Үндсэн хуульд захирагдах тэр гол юм бол хуульдаа байгаа. Цэцийн тухай хуульд байна, Цэцийн маргаан шийдвэрлэх журмууд нь байж байна. Үндсэн хуульдаа хүн чинь хэд хэдэн удаа тангараг өргөчихсөн. Тэгэхээр тангарагтаа үнэнч байна гэдэг нь л хамгийн гол хоосон биш хэлэх юм бол хүний амьдралд 1 удаа дандаа андгай тангараг өргөдөггүй. Би төрд алба хааж байхдаа хэд хэдэн удаа энэ танхимд бол Үндсэн хуульд болон Монгол Улсын Их Хуралд бол тангараг өргөж байсан. Тэгэхээр тангарагтаа үнэнч байх нь намын чинь юм уу бусад нөлөөллөөс илүү байх ёстой. Тэгэхээр тэрэндээ л хүн чинь үнэнч үлдэхийг хичээдэг. Тэгээд насны хязгаар яагаад хүнд тавьдаг юм гэхээр зэрэг мэдээж улс төрч хүн тодорхой эгзэгтэй цаг үеүдэд хамгийн түрүүн гол эрхэмлэх юм нь үнэт зүйл нь шүү дээ. Тэгээд хүн нэрээ хичээнэ гэдэг чинь тэр үнэт зүйлээ л хичээх гэж байгаа болохоос биш өөрийнхөө нэрийг бодож байгаа юм байхгүй.

Тэгэхдээ заримдаа үнэт зүйлийнхээ төлөө бас өөрийгөө зориулах, золиослох шаардлагатай болдог. Галыг авах шаардлагатай болдог. Тэрний цаана энэ Монгол төрийн зовлон, жаргалын цаана, тайлбарлаж хэлэхэд тухайн үедээ боломжгүй олон зүйлүүд болоод өнгөрдөг. Гол нь цаг хугацаа тайлдаг. Түүнээс бол бүх юм дардан сайхан явдаггүй учраас хараат бусбиеэ даасан байна гэдэг бол тэр хүний улс төрийн карьерынх нь төгсгөлийн хэсгээрээ хүн өөрөө дүгнэдэг, бусдаар дүгнүүлдэг, өнөөдөртөө адлуулж байсан ч маргааш магтуулах, сайшаалгах улс төрчид бол энэ удаа олон улс төрчдийг бас харж байсан. Тийм учраас таны би асуултад хэлэх юм бол хараат бус, бие дааж чадсан уу гэвэл тэгэхээр хүн болгоны тухай хүнийг харж байгаа өнцгөөс л хамаарах байх. Би бол хувьдаа өөрийнхөө замаар .../минут дуусав/

С.Бямбацогт: Эрдэнэбат нэр дэвшигч хариулъя.

Г.Эрдэнэбат: Баярлалаа. Манай хуулийн салбарт нэг үзэгдэл байдаг. Ямарваа нэг Монгол хүн асуудалд орохоороо тухайн асуудлыг шийдэх гэж байгаа хуулийн хүний ах дүү, хамаатан садан, найз нөхөд, аймаг орон нутгийн ингээд хүн хайж эхэлдэг. Тэгээд угшил хогшилгүй хэн байх вэ гэдэг шиг ямарваа нэгэн хүн ер нь ажил хэргийг явуулах үед хамааруулъя, хараат болгоё гэвэл заавал юм олддог. Улс төрийн үйл ажиллагаа явуулж, улс төрийн үйл ажиллагаанд оролцож аль нэг намаас санал болгосон гээд зөвхөн түүгээр ч биш, ер нь хэн хүн хариуцлагатай ажил хийж байгаа хүнд нөлөөлөх гэвэл нөлөөлөх суваг, гарц, орц заавал байдаг. Гэхдээ энийг хүмүүс яаж даван туулдаг вэ гэхээр хариуцсан ажлаа итгэл үнэмшлээрээ хийх, мэргэжлийн ёс зүйгээ ухамсарлах энэ байдлаар л давдаг гэж би боддог.

Өмнөх ажлуудаа хийж байхад нөлөөлөх гэж оролдох, ямар нэгэн байдлаар надад татгалзаж болохгүй, миний татгалзаж болохгүй гэж хэлэхүйц хүнийг олоод гуйлгах, нөлөөлөх, ятгуулах оролдлогууд гарч л байдаг. Гэхдээ энэ бүхнийг тэр энэ орчлон хорвоо дээр байгаа, ажил үүргээ хараат бусаар хийж чадсан гэж үнэлэгддэг

тооцогддог бүх хүмүүс тухайн ажилдаа эзэн байж, өөрөө тухайн үедээ урдах ажлаа тэр хуулиар хүлээлгэсэн үүргээ биелүүлэх замаар л даван туулдаг.

Тийм учраас урьд урьдын энэ жишиг, урьд урьдын олж мэдсэн, ухаарсан сурснаараа заавал ямар нэгэн юмнаас хамаараад, энэ намайг томилсон шүү дээ, энэ хүний ачаар ийм болсон шүү дээ гэж бодохгүйгээр одоо би энэ ажлыг хариуцаж байгаагийнхаа хувьд ард үлдэх нэр, ард үлдэх үнэлгээ ямар байх вэ гэдгээ бодоод хийчхэж болох байх гэж бодож байгаа. Баярлалаа.

С.Бямбацогт: Энхтүвшин гишүүн тодруулъя.

Д.Энхтүвшин: Баярлалаа. 2 нэр дэвшигчээс 1 асуулт байна. Үндсэн хуулийн цэц болон Үндсэн хуулийн цэцэд аргаан хянан шийдвэрлэх тухай хууль гээд 2 гол хууль байгаа. Тэгээд энэ 2 хуулиуд дээр 2 нэр дэвшигчийн хувьд сайжруулах, шинэчлэх ямар зүйлүүд байна гэж та хэд харж байгаа вэ. Энэ талаар бас санал бодлоо хуваалцаач.

С.Бямбацогт: Сүхбаатар нэр дэвшигч.

Ж.Сүхбаатар: Би Улсын Их Хурлын гишүүн байхдаа бол яг цэцийн асуудал дээр мэдээж олон итгэмжилсэн төлөөлөгчөөр оролцож, бас цэцийн дүгнэлтүүдийг сонсож суудаг байсан. Тэгэхээр тухайн үед бол их олон л юм бодогддог байсан. Одоо зүгээр цэцийн тухай хууль бол 1992 онд гарсан. Цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль бол 1997 онд гарсан. Бид нар бол зарим өөрчлөлтүүдийг бол хийж яваа. Ер нь сүүлийн жилүүдэд бол манай Цэцийн гишүүд нэлээн тийм онолын шинжтэй багш нар, бас нэлээн эрдэмтэд бас орж ирсэн. Дүгнэлтүүдээ их нарийн бичдэг болж, юм бол нэлээн хөгжиж байгаа. Тэгэхдээ одоо ингээд харахаар саяын ингээд тодорхой кэйсүүд дээр харахаар гадна талдаа юу байна вэ гэхээр бид нар нийгэмд тэр Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагаа ил тод нээлттэй байх тэр сувгийг сайжруулах асуудал тэр яг юундаа байна вэ, дотор нь ажиллаж үзээгүй бол мэдэхгүй шүү дээ. Зүгээр гаднаас харахад энэ дутмаг байгаа харагдаж байна.

2 дугаарт тодорхой хэмжээнд ингээд Улсын Их Хурлын үе үеийн гишүүд .../минут дуусав/

С.Бямбацогт: Минутаа баримжаалж хариултаа өгмөөр байна шүү. Эрдэнэбат нэр дэвшигч.

Г.Эрдэнэбат: Өмнөх нэр дэвшигчтэйгээ ижил зүйлийг давтахгүй байх үүднээс шууд үргэлжлүүлэхэд Үндсэн хуулийн эрх зүйн салбарын хөгжил үнэхээр хуулийн шинэчлэл дээрээ нэлээд хоцрогдсон. Харин институт нь энэ байдлыг нөхөж, даван туулах гэж маш их амжилттай оролдлогууд хийж байгаа гэж боддог. Гэхдээ мэдээж дутагдалтай зүйлүүд байгаа байх. Миний хувьд цэвэр өөрийн салбарын судлаачийн өнцгөөс харахад энэ уг нь дэлхийн улсуудад Үндсэн хуулийн эрүүгийн эрх зүй гэдэг ойлголт байдаг. Энэ Үндсэн хуулиар хамгаалсан эрүүгийн эрх зүйн үнэт зүйлс. Ер нь Үндсэн хуулиар хамгаалсан үнэт зүйлсийг эрүүгийн эрх зүйгээр хамгаалдаг. Тэр үнэт зүйлсийн хамгаалалт зөв хуульчлагдаж уу. Тэгээд түүнийг Үндсэн хуулийнхаа үзэл баримтлалын дагуу Эрүүгийн хууль тогтоомжид жишээлбэл тусгаж уу гээд ингээд ярихаар .../минут дуусав/

С.Бямбацогт: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуултаа асууя.

Х.Баасанжаргал: Би нөгөө өчигдөр асуултдаа бүрэн хариулт авч чадаагүй. 1 асуулт үлдчихсэн байгаа. Та 2 маань мэдэж байгаа байх. Байнгын хороогоор орж ирэх хүртэл та 2-ын туулсан зам хэр шударга байна гэж бодож байна вэ. Өөрсдөө биеэрээ туулж байгаа хүмүүс. Үүнийг засах ёстой гэдэг дүгнэлт хийсэн үү. Хэрвээ засах ёстой бол ямар өөрчлөлт засвар хийх ёстой гэж харж байгаа вэ. Энэ асуултдаа хариулт авъя.

2 дугаарт бид нар аль ч шатны ямар ч шүүхийн шийдвэрт бид нар итгэх итгэлээ хуульчид бид алдах ёсгүй. Та бүхэн итгэж байгаа юу. Тэгээд бүгд бид нар өршөөнгүйгээр бүгд бодож байгаа. Бүгд мэдээж та 2-ыг хувь хүний чинь хувьд итгэдэг, мэддэг учраас цаана нь юу болсон юм, улс төрийн ямар нөхцөл байдал байдаг юм, байсан юм гэдгийг бас энэ танхимд байгаа олон хүмүүс мэдэж байгаа учраас бас энэ бүхнийг чинь ойлгож байгаа. Гэхдээ нийгэм бид нарыг эргээд дахиад хуульчдаас асууна, дахиад надаас асууна. Би олон сэтгүүлчдэд би шүүхийн шийдвэрт итгэдэг учраас би шүүхийн шийдвэрийг шүүж энд ярихгүй гэж олон сэтгүүлчдээс би татгалздаг. Энэ төрлийн асуултад. Одоо дахиад яг энэ асуултад бид нар хариулах хэрэгтэй болчихлоо. Та бүхэн өөрсдөө бас энэ хариултыг өгөөсэй гэж хүсэж байна.

С.Бямбацогт: Нэр дэвшигч хариулъя. Сүхбаатар нэр дэвшигч. Минут гарч байгаа дэлгэц дээр. Тэрийг харж байгаад баримжаагаа аваарай.

Ж.Сүхбаатар: Баярлалаа. Тэгэхээр тэр Байнгын хороо хүртэл процесс хэр шударга болсон бэ гэдэг дээр би өөрөө дүгнэмээргүй байгаа. Гэхдээ би таны хэлдгээр хууль тогтоогч байхдаа би энэ асуудлыг засаад шийдчихсэн байхгүй юу. Тэгээд нөгөө 3 сарын өмнө энэ эрх зүйн байдал өөрчлөгдчихсөн учраас одоо тэр хуулийн зохицуулалт байхгүй учраас парламент өмнө нь явж ирсэн жишгээрээ явсан учраас олон удаа ингээд явж байсан. Тэгэхээр би парламентын тэр өмнөх үйл ажиллагаануудыг үгүйсгэх боломжгүй байгаа юм.

Тэр дараагийн асуудал бол би шүүхийн шийдвэрт итгэх, итгэхгүй нь хамаа байхгүй. Монгол Улсын Үндсэн хуульд шүүхийн шийдвэр захирагдахыг л зааж байгаа юм. Тэгэхээр би сэтгэл дундуур байна уу, баярлана уу, баярлахгүйгээс хамаараад албан ёсны үйл ажиллагаагаа явуулж байгаа Үндсэн хуулийн дагуу бусад хууль шүүхийн болон процессын хуулиудын дагуу явуулж байгаа шүүхийн үйл ажиллагаанд бол би захирагдахаас өөр аргагүй. Тэгээд дуртай ч бай дургүй, сэтгэл дундуур байж, заримдаа гутарсан ч гэсэн тэгээд л хууль бол хууль, шүүх бол шүүх. Тэрийг засна гэдэг бол тусдаа асуудал. Тусдаа сэдэв. Баярлалаа.

С.Бямбацогт: Эрдэнэбат нэр дэвшигч хариулъя.

Г.Эрдэнэбат: Нийтийн албан тушаалтан хариуцлагатай албан тушаалд томилогдох хүмүүст сонсголын дэг хуульчилсан боловч харамсалтай нь Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээр энийг Үндсэн хууль зөрчсөн гэж үзээд, хүчингүй болгосон. Ингээд өнөөдөр уламжилж тогтсон ёс, Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуульд тогтоосон зохицуулалт, хэм хэмжээний хүрээнд өнөөдрийн энэ үйл явц

явагдаж байгаа учраас би үүнийг шударга, шударга биш гэж бас хэлж чадахгүй. Энэ хуулийн дагуу л явж байна л гэж би харж байгаа.

Шүүхийн шийдвэртэй холбоотой асуудал дээр харин нэг зүйлийг бид хэлэх ёстой. Шүүх өөрөө итгэл дээр оршдог. Шүүх итгэл дээр оршдог учраас шүүх дахь засаглалыг төлөөлж ажиллаж байгаа хүмүүс шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нураасан үг хэлэх эрхгүй. Тийм учраас ямар нэгэн шүүхийн шийдвэр гарсныг шүүх буруу шийдсэн гэж ярих бол ялангуяа хуульч хүний амнаас бол гараад хэрэггүй юм байгаа юм. Яах вэ, сая хэлж байна. Тийм үнэн гомдох, сэтгэл дундуур байх бол миний хувийн л асуудал. Тэрнээс биш энэ шийдвэр гарсныг нь бид нар ялангуяа төлөөлөөд шүүх буруу шийдсэн. Бүр тэгж ярих юм бол хууль нь буруу ч гэж ярих нь өөрөө хуульч хүний хувьд ёс зүйгүй хэрэг гэж үздэг.

С.Бямбацогт: Аюушийн Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: Худал хурдан ч үнэнд гүйцэгддэг гээд сүүлийн үед хүмүүс их хэлж, бичиж, постлох ийм дуртай үг. Гэхдээ үнэн гэдэг юм чинь маш залхуу, маш удаан, маш хойрго. Ирэх гэсээр байтал худал үүргээ гүйцэтгэчихсэн байдаг. Тэгээд та 2 дээр бол өнөөдөр бид нар худал гүтгэлэг гэдгийг чинь мэдээд, дэмжээд үг хэлээд байна шүү дээ. Нийгэмд та 2 алга ташилтаар угтаж орж ирж байгаа 2 нэр дэвшигч биш гэдгийг бас сүүлийн 2 өдрийн энэ сошиал хандлагаар бас харж байгаа байлгүй дээ. Тэгээд би энүүгээр юу хэлэх гээд байна вэ гэхээр хуучин улс төрч, ялаа 2-ыг сониноор ална гэж бүр 1990-ээд онд ярьдаг байсан шүү дээ. Тэгээд одоо бол бүр дэлгэрчихсэн. Энэ танхим дотор бүгдээрээ худалч, хулгайч, бас алуурчин, нүүрчин юу юу ч байгаа юм бэ дээ. Ер нь нэр цэвэр амьтан байхгүй. Энэ бол тэгээд ер нь маш их харамсалтай л асуудал байгаад байгаа юм.

Зүгээр би та 2-оос дахиад нөгөө хүсэх юм нь юу байна вэ гэхээр хэрэвзээ хэн нэгэн хууль бус юм нэхээд байвал бардам ажлаа өгөөд, тэгээд яваарай. Битгий тэр ажилтайгаа зууралдаж, тэр хүний ч юм уу, институцийн ч юм уу, юу ч байдаг юм үгэнд нь орж, тэгээд бүх насан туршдаа харамсаж суугаарай гэж хүсье дээ.

Би энэ 1 минут 30 секундийг ашиглаж, Улсын Их Хурлын дарга аа, 1 сэтгэл зовоогоод байгаа асуудал үлдчихлээ. Тамхины хууль дээр 2010 оноос хойш, 2010 оны 01 сарын 01-ээс хойш төрсөн хүнд насан туршид нь тамхи борлуулахгүй байх ийм асуудлыг Мөнхсайхан гишүүн дэвшүүлээд, Нийгмийн бодлогын байнгын хороон дээр бид нар унагаасан юм. Тэгээд энэ сая чуулган дээр босчихлоо л доо. Тэгээд гишүүд маань энийг бас ойлгож яачхав уу, ойлгосонгүй юу. Энэ зүгээр нөгөө Үндсэн хуулийн зөрчил дараа нь бас үүсчих вий гэдгээс би болгоомжилж байна. Тэгэхээр нөгөө нийгмийн бодлогын байнгын хорооноос өмнө хууль зүйн дүгнэлт гаргах боложтой болов уу, үгүй болов уу. 2010 онд төрсөн гэдгээр нь бид нар яах вэ, одоо хүүхэд гэж бодоод байна. Гэхдээ одоо бол 21 наснаас өмнө бид нар хүүхдэд архи, тамхи борлуулахгүй байгаа. 22 насанд хүрчхээд юугаа хийнэ вэ, ёстой жинхэнэ тухайн насанд хүрсэн хүний сонголт биз дээ. Тэгээд насанд хүрсэн хүний сонголтыг бид нар өнөөдөр үгүй хийгээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ бол өөрөө бас боломгүй л юм шиг надад санагдаад байх юм. Би бол насанд хүрсэн хүн өөрөө тамхиа татна уу, үгүй юу өөрийнх нь сонголт. Гэтэл бид нар өнөөдөр энийг хориглоод байгаа нь насаар нь ялгаварласан хүний эрхэд халдсан ийм зохицуулалт болчихож байгаа юм биш үү. Тэгээд нөгөө хууль маань явчихдаг, эргээд нөгөө цэцэд очдог, унадаг хайран хууль болох вий дээ..../минут дуусав/

С.Бямбацогт: Үнэхээр Үндсэн хууль зөрчсөн хууль Их Хурал батлах юм бол яг тухайн хуулийг бүхэлд нь биш, тухайн заалттай холбогдож цэцэд дүгнэлт гаргана. Маргаан үүсэх байх. Үндсэн хууль зөрчсөн байна уу, зөрчөөгүй байна уу гэдэг дээр 2 дугаар хэлэлцүүлэг дээр манай Тамгын газар анхааралдаа аваадхаарай. Энэ хүний эрхийг бас тэгж хэт хавтгайруулж, хязгаарлаж байгаа, сонголт хийх эрхийг нь хязгаарлаж байгаа Үндсэн хууль зөрчсөн асуудал, хүний үндсэн эрхийн маргааны асуудал болчих вий гэдэг дээр Тамгын газар анхааралдаа аваад, шаардлагатай бол анхны хэлэлцүүлэг хийчихсэн. Эцсийн хэлэлцүүлэг дээр 2/3-оор босох боломж байгаа. Энэ дээр бас Тамгын газар анхааралдаа аваад, ажлын хэсэгтээ тодорхой шийдэл гаргаадхаарай гээд бас чиглэл өгөөдөхье. Үг хэллээ.

Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Д.Ганбат: 2 нэр дэвшигчийг бол мэднэ тодорхой хэмжээнд. Энэ боломжийн нэр дэвшигчид оруулж ирж байна гэж ойлгож байна. Энэ Үндсэн хуулийг чинь нөгөө юу билээ алганд багтсан Монгол Улс, ард түмэнтэй байгуулсан гэрээ, Үндсэн хуулийн дээр юу ч байхгүй хөх тэнгэр энэ тэр гээд л янз янзаар л яриад байдаг л даа. Энэ улс орныг тэгээд яг Үндсэн хуулийн үзэл санааны дагуу хөгжүүлж чадаж байна гэж үзэж байна уу. Та 2 маань юу гэж бодож байна.

Үндсэн хуулийн их суудлын шийдвэр гардаг. Гармагц цаг хүчин төгөлдөр болоод биелэгдэж байх ёстой. Заримдаа Үндсэн хуулийн цэц дээр бараг хууль тогтоох гээд ч байх шиг харагдах юм. Тухайлбал би энэ тэр төмөр замын царигийн талаар гаргасан тогтоолыг өөрчилснийг хэлэх гээд байна л даа. Олон улсын стандарт буюу нарийн төмөр замаар ингээд байна гэсэн юмыг өргөн төмөр зам болгоод л өөрчилж байсан. Тэр нь тэгээд биелэгдээд л яваад, тэрний үр дүнд эдийн засгийн үр ашиг их л хүнд л байгаа. Зардал чирэгдэл нэмэгдэж байгаа. Экспорт саарч байгаа. Тэгээд 2 зам нийлэх, нийлэхгүй янз янзын юм болчихсон. Өндөршил тэр юмаараа зөрчихсөн ийм үр дагавар байсан.

Нөгөөдөх нь Үндсэн хуулийн зөрчихсөн гээд шийдвэр гаргаж байгаа байхгүй юу. Тэгээд энэ шийдвэрүүд нь биелэгдэхгүй яваад ч байгаа юм шиг. Тэгээд үүний үр дагавар нь ямар байх вэ. Ингээд цэцийг юу гэж харах вэ. Тэгээд цэцийн шийдвэр нь биелэгддэггүй тийм улс орныг яаж харах юм бэ. Үүний үр дагавар ямар байх вэ гэдгийг та 2 юу гэж бодож байна вэ гэсэн ийм асуултууд байна.

С.Бямбацогт: Сүхбаатар нэр дэвшигч хариулъя.

Ж.Сүхбаатар: Эрхэм гишүүн Ганбатын асуултад хариулъя. Тэгэхээр Үндсэн хуулийн дагуу хөгжүүлж чадаж байна уу гээд та нэг бодлын их энгийн юм шиг мөртөө бас философилог асуулт асуучих шиг боллоо. Мэдээж Үндсэн хууль бол Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр юм уу, хөгжлийн хөтөлбөр бол биш. Гэхдээ таны саяын хэлдгээр Үндсэн хуулийн эхний хэсэг дээр Монголын ард түмний эрхэм зорилгыг тодорхойлсон байгаа. Туйлын хүслэн идеал. Тэр нь бол Монголын ард түмэн бид бол төрт ёс, түүхэн уламжлалаа гээд хүмүүнлэг ардчилсан иргэний нийгмийг цогцлуулан хөгжүүлнэ гэж байна. Энэ бол мэдээж эрх зүйт төр, ардчилсан нийгэм. Тэгэхээр ардчилсан нийгэм бол алдаагаа нуудаггүй, сүүдрээ нуудаггүй гэдэг. Алдаж эндэж явж, түүнийгээ засаж залруулах тийм онцгой механизм гэж үздэг. Тийм учраас Үндсэн хууль өөрөө өөрийнхөө алдааг засаж залруулах тэр төрийн эрх мэдэл хуваарилалтын механизм, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах

механизм, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын баталгаа болсон заалтууд гэдэг юм уу энэ механизмуудаараа бол энийг ардчилал, эрх зүйт төр, хүний эрх, эрх чөлөө, төрийн эрх мэдлийг харилцан хяналт тэнцэлтэй хувааж байгаа. Энэ бүгдийн үр дүнд хүний эрх, эрх чөлөө хангагдаад ирэнгүүт хүний эрх хэдий чинээ бодитойгоор амьдралд хангагдаж байна. Тэр хэмжээгээр бодит хөгжил дэвшил ирдэг гэж үздэг. Тэгэхээр энэ утгаараа бол бид нар алдаж, онож байгаа ч гэсэн ардчилал Монголд хэр хөгжиж байна вэ гэдэгтэй бараг энэ Үндсэн хуулийн дагуу хөгжүүлж чадаж байна уу гэдэг харагдана. Алдаа, оноо бол байгаа. Гэхдээ засаж залруулах гээд ингээд л зүтгэж яваа. Тэгээд тодорхой цаг хугацаанд хүмүүс үнэлээд явдаг.

Заримдаа Үндсэн хуулийн цэц зориуд хууль тогтоож байх шиг байна гэж. Тэгэхээр яах вэ, онолын хувьд Үндсэн хуулийн шүүх зарим талаар гаргасан шийдвэрээрээ хууль тогтоогчийн хийдлийг, хууль тогтоогчийн хийгээгүй зүйл, хийж чадаагүй байгаа зүйлүүдийг засаж залруулах замаар зарим тохиолдолд бол хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлээд байна гэж бол үзэх явдал бол байдаг. Зарим оронд ч хэрэг дээрээ хууль тогтоодог гэж үздэг.

Тэгэхээр энэ дээр хууль тогтоогч өөрөө дандаа болгоомжтой хандаж байх ёстой. Яагаад гэвэл Үндсэн хуулийн шийдвэр өөрөө дандаа Үндсэн хуулийг дагаж гардаг гэдгээрээ давуу хүчин чадалтай байдаг. Парламент бол Үндсэн хууль болон бусад хуульдаа захирагддаг. Тэгэхээр Үндсэн хуулийн цэц хууль тогтоогоод байна гэж үзэж байгаа бол хууль тогтоогчид бас механизм нь өөрт нь байдаг, хууль тогтоодог энэ асуудлыг ярьдаг, хэлдэг. Тэгэхээр энэ асуудал дээр бол тэрийг нэлээн дүн дүн шинжилгээ хийх асуудлууд байх гэж бодож байна. Тэрийг нь бол эрдэмтэд мэргэд, улс төрчид өөрсдөө хууль тогтоогчид ярьж байгаад энэ нь зөв үү, буруу юу. Зарим тохиолдолд бол үнэхээр парламент бол улс төрийн хүчнүүдийн харилцан баланс тухайн үеийн тохиролцоо, шийдэл дээр гардаг явдал бол их байдаг. Тэгэхээр алдаа дутагдал байхгүй гэж бас хэлж болдоггүй. Тэрийг нь цэц бас засаж залруулах явдал бол гардгийг бас та сайн мэдэж байгаа байх.

Үндсэн хууль зөрчсөн гээд дүгнэлт гараад, үр дагаврын асуудлыг бол хуулиар ерөнхийдөө зарчмыг нь Үндсэн хууль дээр заачихсан. Мөн Цэцийн хууль тогтоомж дээр бол ер нь Үндсэн хуулийн тодорхой зөрчсөн гэсэн шийдвэр бол гармагцаа эцсийн шийдвэр гарангуут хүчингүй болчхож байгаа. Үр дагавар нь тодорхой болчхож байгаа. Түүнээс үүдэн гарч байгаа үр дагавар, бусад хохирол арилгах, бусад үр дагаврыг арилгах асуудлыг бол хууль тогтоомжийн дагуу тухайн шийдвэрийг гаргасан эрх бүхий байгууллага, албан тушаалтан өөрөө хариуцан арилгах үүрэгтэй. Жишээлбэл Улсын Их Хурлын тухайд гаргасан шийдвэрийг Улсын Их Хурлын шийдвэр хүчингүй болоод бусад үр дагаврыг Улсын Их Хурал өөрөө тэр үр дагаврыг хариуцан арилгах үүрэг хүлээж байдаг. Тэр үүргээ биелүүлэхгүй байгаа нь өөрөө тухайн институц албан тушаалтны үүрэг хариуцлага болдог.

Тэгээд ч Монгол Улсын Үндсэн хууль мэдэгтүн, сахигтун гэж заасан байгаа. Тэгэхээр бидний хамгийн чухал юм бол Үндсэн хуулийн хүрээнээс гарах, гарахгүй байх асуудал бол Үндсэн хуульд суралцахуй гэдэг Үндсэн хуульдаа суралцах, Үндсэн хууль дээдлэх ёсыг түгээн дэлгэрүүлэх тэр асуудлын хүрээнд бол бид сайн ойлгох юм бол энийг сахиж чадна. Тэгээд эргээд төгсгөлд нь хэлэхэд Үндсэн хуулийн дагуу байж гэмээ нь л төрийн эрх мэдлийн институцүүд даврахгүй, дур зоргоороо албан тушаалтнууд аашлахгүй, иргэд өөрийнхөө эрхийг бусдаас, төрөөс хамгаалж хамгаалж чадна. Тэр утгаараа бол манай Үндсэн хууль ардчилал бол

зохих хэмжээнд үүргээ бол гүйцэтгэж байгаа. Мэдээж алдаа дутагдал..../минут дуусав/

С.Бямбацогт: Эрдэнэбат нэр дэвшигч хариулъя.

Г.Эрдэнэбат: Баярлалаа. Та үнэхээр их чухал асуулт асуусан учраас би их баяртайгаар хариулъя. Эрх зүй үнэхээр нийгмийг хөгжүүлдэг. Хөгжлийн эрх зүйн парадигм гэх ойлголт ч байдаг. Бид өнөөдөр 1990-ээд оны үеийнхээсээ хавьгүй олон төрлийн ажил хэргийн, амьдралын харилцаатай болсон. Бид саяхныг болтол нэрийг нь ч зөв дуудаж чаддаггүй байсан олон төрлийн гэрээг хийж, арилжаа наймаагаа хийж байна. Нийгмээ хөгжүүлж байна. Барилга, байшин барьж, бүтээн байгуулалт хийж байна. Асуудлуудыг шийдэж байна. Нөгөө талаас нь харах юм бол урьд нь огт дуулдаагүй байсан олон төрлийн гэмт хэрэг хүртэл гарч байна. Энэ Монголын нийгэм хөгжөөд байгаагийн шинж шүү дээ. Ингээд харах юм бол энэ Монголын нийгэм үнэхээр хууль тогтоох үйл ажиллагааны тусламжтайгаар хөгжиж байгаа. Хууль тогтоох үйл ажиллагааны тусламжтайгаар хөгжиж байгаа энэ хүрээнд яг таны хэлсэн Үндсэн хуулийн үзэл санаа өөрөө энийг хөгжүүлж байгаа суурь нь. Тийм учраас бол бид нар Үндсэн хууль дээрээ тунхагласан тэр суурийг ашиглаж, тэр үзэл санааг ашиглаж, чөлөөт нийгмийн тогтолцоог бий болгосон, эдийн засгийн харилцаагаа тэтгэж байгаа олон төрлийн бизнесийн үйл ажиллагааг дэмжиж тэтгэж байгаа. Ийм учраас Монголын нийгэм Үндсэн хуулийнхаа тусламжтайгаар тэгээд энэ хугацаанд гарсан олон 10, 100 хуулиуд, тэр хуулиудын дагуу хүмүүсийн хийж байгаа ажил хэргийн тусламжтайгаар Монгол Улс хөгжиж байгаа. Энэ хөгжилд Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагаа саад тээг болж байна уу, эсвэл буруу замаар явахад нь хяналт тавьж алдаа гарахаас нь сэргийлж чадаж байна уу гэвэл би өнгөрсөн 30 жилийн ололт амжилт, алдаа бүх юм нь мэдээж хэрэг Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагаатай холбоотой. Тэгэхээр юу гэсэн үг вэ гэхээр дэмжсэн нь ч байна, мөн алдсан ч байж магадгүй.

Тийм учраас Үндсэн хуулийн цэц үйл ажиллагаа явуулаад, ер нь Монгол Улс Үндсэн хуулийнхаа дагуу хөгжиж байгаа юу гэвэл би хөгжиж байгаа гэж итгэлтэй хариулна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэр хэр хэмжээнээсээ хэтрээд, хууль тогтоох үйл ажиллагааны шинжтэй болоод байна уу, үгүй юу гэдгийг харин ёстой анхааралдаа аваад, хэрвээ энэ ажлыг хариуцах юм бол би энэ талаар нэлээн нухацтай бодох ёстой гэж бодож байна.

Өнөөдөр энэ ажлыг би ямар нэгэн байдлаар дүгнэж ийм байдлаар Үндсэн хуулийн цэцийн шийдвэр буруу гарсан юм. Ийм байдлаар цэцийн үйл ажиллагаа хууль тогтоох эрх мэдэл рүү халдсан юм гэж хэлэх ямар нэгэн эрх мэдэл ер нь эрх алга.

Цэцийн шийдвэрийн биелэлт нь ямар байдаг вэ, үр дагавар нь ямар байдаг вэ гэвэл энэ өөрөө туйлын тодорхой зүйл. Цэцийн шийдвэр биелэгддэг.

С.Бямбацогт: Ганбат гишүүн нэмж асууя.

Д.Ганбат: Шүүх, шүүгчийн нэр хүнд хуулиар хамгаалагдсан байдаг. Үндсэн хуулийн цэц ч гэсэн. Одоо та бүхнийг хонгилоор чирсэн гээд л хэвлэл мэдээлэл энэ

юмаар олон давталттайгаар нэр хүндэд чинь халдаж байна л даа. Ийм үед иргэний хувьд та нар өөрсдөө шүүхэд хандаж бариад цагаатгаад ч юм уу. Тийм биш гэдгээ нотлуулаад явах л ёстой байх л даа. Цэцийн гишүүн болчихсоныхоо дараа бол Цэцийн нэр хүнд болоод явчих байх. Энийг юу гэж ойлгож, яаж энийг цэгцлэх ёстой юм бэ. Энэ тал дээр та нарын байр суурийг сонсьё.

С.Бямбацогт: Сүхбаатар нэр дэвшигч 1 минутад хариулна.

Ж.Сүхбаатар: Би Ганбат гишүүний асуултад хариулахад маш товчхон улс төрч хүн бол тэсэж тэвчих ёстой гэдэг. Нийтийн өндөр албан тушаалтай хүн бол гүтгэлэг, доромжлол гутаалтаас бусад тохиолдолд бол тэсэж тэвчих ёстой гэж үздэг. Мэдээж бид нар сүүлийн үед гүтгэлэг, гутаах доромжлох тухай их ярьж байна. Үнэн байсан ч гэсэн манайхан үнэн юм мэдээлж болно гэж үздэг. Гэтэл гутаах гэдгээр орж, тэр нь хувь хүний нэр төр, халдашгүй байдал, хамгаалагдсан байдаг. Тэгэхээр нийтийн өндөр албан тушаалтнуудын тухайд бусдын ярьдаг үзэл бол ер нь аль болохоор тэр шүүмжлэлээс ангид байж болохгүй учраас тэсэж тэвчээд л нэгэнт сонгосон зам учраас гээд явах ёстой. Мэдээж өөрөө гэр бүлтэй эргэн тойрон олон хүнтэй учраас зарим тохиолдолд иргэний хууль тогтоомжоор өөрийнхөө нэр төрийг гутаагдсан, доромжлогдсон тэр нэр төрөө сэргээлгэх тэр асуудал бол байж болно. Ер нь бол аль болохоор ардчилсан нийгмийнхээ зарчимд хүндэтгэлтэй л хандах ёстой. Манай тэгэхдээ шинэ Иргэний хуулийг гаргах, гэрээний харилцааг/минут дуусав/

С.Бямбацогт: Эрдэнэбат нэр дэвшигч хариулъя.

Г.Эрдэнэбат: Мэдээж хэрэг хувь хүний нэр төр гэдэг хувь хүндээ эрхэм зүйл. Гэхдээ өнөөдөр байгаа хууль, эрх зүйн орчны хайчин дунд таны хэлсэнчлэн нэр төрөө сэргээх, цэвэрлэх энэ боломж төрийн нууц, ажил хэргийн хэрэг бүртгэлд мөрдөн байцаалтын үйл ажиллагаанд саад болохгүй байх гэсэн энэ олон төрлийн эрх ашгийн хайчин дунд боломжгүй явсаар өдгөө хүрлээ. Тэгээд энийг би өнөөдөр, гомдоллоод, ганцхан өөрийн нэр төр, эрх ашиг хохирсон мэтээр ярих бол ямар ч утгагүй гэж бодож байгаа. Мэдээж хэрэг цаг хугацаа, нөхцөл байдал бүх зүйлийг өөрчлөх байх. Энэ үед үнэн тодорно. Түрүүн Ариунзаяа гишүүн хэлсэнчлэн үнэн хэзээ нэгэн цагт гүйцэж ирнэ гэж итгэж байгаа.

С.Бямбацогт: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр 2 нэр дэвшигч бол 1 нь буюу Сүхбаатар нэр дэвшигч бол захиргааны эрх зүйгээр, Эрдэнэбат нэр дэвшигч бол эрүүгийн эрх зүйгээр бас Монголдоо танигдсан ийм хуульч нар Үндсэн хуулийн цэцэд очиж байна. Тэгэхээр аливаа албан тушаалтнууд 1 бол захиргааны асуудал гаргаж, Үндсэн хуулийн цэц дээр хүний эрх зөрчсөн гэж. Дээрээс нь эрүүгийн асуудал гаргасан гэж албан тушаалтнуудыг Үндсэн хуулийн цэц дээр бас тодорхой хэмжээгээр шийдвэрлэдэг ийм газар. Тийм учраас захиргааны болон эрх эрүүгийн эрх зүйгээр мэргэшсэн 2 нэр дэвшигч илүү Үндсэн хуулийн цэц дээр нарийн судалгаатай, дээрээс нь мэдлэгтэйгээр асуудалд орно гэж итгэж байна.

Асуулт бол алга байна. Тэгэхээр ер нь бол Үндсэн хуулийн цэц дээр миний 1 хууль очсон юм. Би 2019 оноос хойш энэ хуурамч шатахуунтай тэмцэж байгаа. 2019 онд хууль өргөн бариад, 2 жилийн туршид тэмцэж байж, энэ хуулийг 2021 онд батлуулсан. Тэгээд. 2023 онд гэнэтхэн Үндсэн хуулийн цэц өөрт нь ямар ч

хамааралгүй, хуурамч шатахууны асуудал Үндсэн хуулийн цэцэд ямар хамаарал байх вэ дээ. Тэнд очиж хэлэлцэгдсэн. Тэгээд дунд суудлаараа энэ хууль Үндсэн хууль зөрчсөн байна гэдэг ийм дүгнэлт гаргасан. Тэнд ер нь бол эндээс ингээд харж байхад бол Үндсэн хуулийн цэцэд хугацаа нь дуусаж байгаа нөхдүүд бол юу ч хамаагүй хийгээд буудаг л юм шиг би анзаарсан л даа. Тэгээд Үндсэн хуулийн цэцээр Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэлт гаргаад хэргийг нь Их Хурлын гишүүд увайгүйгээр хүлээж авч, тэр хууль маань хүчингүй болсон 2023 онд. Энэ олон олон гишүүд тэр Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг дэмжиж, ард түмнийхээ эсрэг ийм шийдвэр гаргасан юм л даа. Тэгээд дахиад би 2024 онд дахиж өргөн барьсан байгаа. Шинэ парламент бий болсонтой холбоотойгоор. Тэгэхээр ер нь энэ дээр бол ийм өөрт нь ямар ч хамааралгүй ийм асуудлаар цэц дүгнэлт гаргадаг ийм увайгүй зүйл бий болсон, байж байсан гэдгийг бас хэлэх нь зүйтэй.

Тэгэхээр энэ дээр би 1 хүнийг бас тодорхой бас дэмжиж хэлмээр байгаа юм..../минут дуусав/

С.Бямбацогт: 1 минут сунгая.

Б.Пүрэвдорж: Өөрөөр хэлбэл энэ хуурамч шатахууны эсрэг хууль дээр бол энэ ард түмнийхээ талд байсан Баясгалан Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг бас тодорхойлж хэлмээр байна. Яг л энэ ард түмнийхээ төлөө яг энэ Үндсэн хуулийнхаа цэцийн хийх ёстой тэр ажлыг Үндсэн хуулийн бус ийм зүйлийг хэлэлцэхэд ард түмнийхээ талд байсанд нь их баяртай байгаа. Дээрээс нь ер нь олон жил төрд ажилласан, хуулийн салбарт ажилласан, төрийн бас өндөр албан тушаалтай ийм хүн очоод, энэ Үндсэн хуулийн цэцэд ажиллахаар бас яг энэ гаргаж байгаа шийдвэр нь гаргаж байгаа тэр бодлого, яриа нь бол илүү зөв тууштай байдаг юм байна гэдэг нь харагдсан. Би уг нь бол Баясгалан Цэцийн гишүүнийг хугацааг нь сунгачхаасай гэж үнэхээр бодож байсан. Харамсалтай нь эрх баригч нар өөр хүмүүс оруулж ирж байх шиг байна.

Тэгээд та 2-т яг .../минут дуусав/

С.Бямбацогт: Сүүлийн 1 минут.

Б.Пүрэвдорж: Яг л Үндсэн хуульд ямар л үг, үсэг байна, агуулга байна, тэр бүх зүйлийг бүгдийг нь ягштал биелүүлж, энэ хүний үндсэн эрхийг хамгаалах тал дээр байнга байж, Монгол Улсынхаа тусгаар тогтнол, ард түмнийхээ амгалан тайван амьдрах тэр бүх зүйл дээр хатуу бат байж, дээрээс нь энэ албан тушаалтнуудын хүний эрхийг зөрчиж байгаа энэ зөрчил дээр хатуу байхыг бас хүсье.

С.Бямбацогт: Үг хэллээ. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшигчийг хэлэлцэх асуудал дуусаж байна. Маргааш санал хураалтыг явуулна. Санал хураалтыг өнөөдөр явуулах боломжгүй гэж хойшлууллаа. Маргааш өглөө 10 цагаас санал хураалт явна.

Ингээд өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууслаа. Чуулганы нэгдсэн хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ их баярлалаа. Тамгын газрын ажилтнууддаа, удирдлагууддаа, Байнгын хороодын зөвлөхүүд, бас хуулийн

төсөл эх барьж байгаа зөвлөхүүддээ их баярлалаа. Тэгээд нэлээн ачаалалтай ажиллаж байгаа шүү.

Ингээд чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Идэвхтэй оролцсон гишүүддээ их баярлалаа. Тэгээд эцсийн мөч хүртэл хамтдаа байсанд. Тамгын газрынхаа ажилтнууддаа их баярлалаа.

24.00 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ